



Загалмайсан

ЭЦЭГ

Марио Пьюзо

ЗАГАЛМАЙЛСАН ЭЦЭГ

www.kiebooks.com

АЛИВАА БЭЛ ХӨРӨНГӨ ХЭТЭРХИЙ ИХ БОЛ ГЭМТ ХЭРГЭЭС ЭХ СУРВАЛЖТАЙ.

О.БАЛЬЗАК

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Америго Бонасера төрсөн охиныг нь зэрлэгээр тамлаж, дээр нь бас бузарлахыг оролдсон танхай этгээдүүдийг шүүн тасалж, зохих цээрлэл үзүүлэхийг хүлээгээд Нью-Йорк хотын эрүүгийн шүүхийн гуравдугаар тасагт зогсож байлаа.

Ихэмсэг бардам шүүгч хэрэгтний сандал дээр суух хоёр залууг өөрийн биеэр залхаах гэсэн юм шиг хар жанч нөмрөгийнхөө ханцуйг шамлах нь нэн сүртэй харагдана. Түүний дүнсгэр царайд үзэн ядах дээрэнгүй байдал царцсан хэдий ч цаанаа нэг л хуурамч өнгө цухалзаад байгааг Америго Бонасера оюунаараа биш ч дотоод сэтгэлээрээ мэдрээд байв.

- Та нар ёстой адгийн шаар шиг авирласан гэж шүүгчийн ширүүн зандрахад: «Яг тийм, яах аргагүй үнэн. Нээрээ л адгуус малнууд» гэж Америго Бонасера дотроо бодно. Гялалзтал тосолсон үсээ сүүлийн үеийн загвараар засуулсан тэр залуус савандаж угаасан гөлчгөр нүүрэндээ гэмшсэн дүр эсгэн уруу царайлж толгой гудайх ажээ.

- Та хоёр хээрийн зэрлэг араатан шиг авир гаргасан, гэвч тэр хөөрхий бүсгүйн нэр төрийг гутааж амжаагүй нь аз чинь болж. Хэрэв тиймгүйсэн бол би та нарыг хорь хорин жилээр хорих байсан юм гэснээ хэсэг дуугүй болж, сүртэй гэгч нь зангидсан хөмсөг дороосоо үнэгэн зальтай харцыг Америго Бонасерагийн хувхай цайж шарласан нүүрэнд нэг түрхээд авснаа зүй ёсны уур хилэнгээ барьж ядах мэт мөрөө хавчиж духаа улам үрчийлгээд: Гэвч та хоёрын хиргүй тунгалаг, гэнэн залуу нас, буянтай эцэг эхийн чинь нэр төрийг бодоод, бас дээр нь маргашгүй мэргэн хуулиа баримтлаад би та нарыг тус бүр гурван жил тэнсэн харгалзах ялаар шийтгэж байна хэмээн үгээ төгсгөв.

Бонасера оршуулгын товчоонд дөчин жил ажиллаж, мэргэжлийнхээ дагуу нүүр царайны хувирлаа захирч сурсан тулдаа л оргилоод ирсэн их уур хилэн хорсол зэвүүцлээ хүчлэн дарж чадлаа.

Ид цэцэглэж яваа насандаа байгаа булбарай хөөрхөн охиных нь эрүү хугараад эмнэлгээс гараа ч үгүй хэвтэж байхад энэ малнуудыг суллаад тавьж байдаг?! Тэгэхлээр сая түүний өмнө жүжиг тоглосон юм байна. Тэртээ буланд нүүр дүүрэн инээмсэглэсэн эцэг эхчүүд нь хайртай нуган үрсийнхээ дэргэд баярлан овооролдоно. Ийм баяртай юм болж байхад малилзтал инээхээс ч өөр яах билээ.

Харамсал гашуудал Бонасерагийн хоолой өөд хахуун цоргиж, шүдээ тас зуусан аманд нь гашуун шүлс дүүрээд ирсэнд тэрбээр цагаан даавуун алчуур энгэрийн халааснаасаа суга татан авч амаа дарав. Түүний гэнэ чигээрээ эгнүүлсэн сандлын чөлөөнд зогсож байх зуур эрээ цээрээ алдсан нөгөө хоёр увайгүй залуу доогтойхон жуумалзсаар дэргэдүүр нь өнгөрөхөд Бонасера юу ч дуугарсангүй. Зөвхөн цардмал алчуураараа амаа улам хүчтэй дарлаа. Залуусын араас дагасан эцэг эх нь америкийн уугуул хүмүүс бололтой. Хоёр авгай, хоёр эр Бонасератай үе тэнгийн улс харагдана. Тэд түүн рүү аягүйрхэн харсан боловч нүдэнд нь нуудгай баяр хөөр, өдсөн давсан байдал илэрхий.

Америкт амь зуусан энэ бүх он жилүүдийн турш Бонасера хууль ёс, дэг журамд итгэж,

түүнийхээ хүчээр л өдий хүрч, ийм зэргийн амжилт олжээ. Тийм ч учраас үнэн голоосоо үзэн ядаж, хорссондоо ухаан балартах шахаж байв. Гүйж гараад буу авчраад хоёр новшийг нам буудчихмаар болж ирэв. Энэ хүсэл нь тэсэхийн аргагүй болоод ар дагзаар нь хатгуулж байсан хэдий ч тэрээр: Биднийг энд доромжиллоо хэмээн юу ч ойлгохоо байсан эхнэртээ тайлбарлаад хэсэг дуугүй зогссоноо бүрмөсөн шийдэв бололтой:

үнэн шударга шүүхийг хүсэж эрхэм Корлеонед очих хэрэгтэй гэж хэлэхдээ ямар их гарз гарахыг бодсон ч үгүй.

Лос-Анжелес хот. Зочид буудлын гяланцаг болсон тансаг чамин өрөөнд Жонни Фонтейн виски архи ам руугаа юүлэн суух нь ёстой л эхнэртээ араараа тавиулсан эр гэлтэй. Тэр улаан бүрээстэй буйдан дээр налайж виски шилээр нь хөнтрөн гашуун амтыг нь дарахын тулд болор хувинд дүүргэсэн мөстэй ус руу нүүрээ шаана. үүрийн дөрвөн цаг болж, архиндаа мансуурсан түүний толгойд завхай эхнэрээ эргэж ирдэг л юм бол яаж залхаах тухай бодол зэрэглээтэх ажээ. Эргэж ирвэл л тэр шүү дээ. Түүрүүчийнхээ авгайд утасдаж охидоо асуувал мөн зүгээрсэн, гэвч нэгэнт хожимдож. Ялангуяа ажил хэрэг нь бүтэлгүйтээд ирснээс хойш тэр найз нартайгаа утсаар ярих хүсэлгүй болсон байв. Түүнийг үүрээр дөрвөн цагт утасдахад тэд бөөн баяр хөөр болж бах нь ханаж байсан цаг үе улиран өнгөрчээ. Жонни Фонтейныг ид мандаж эхлэх үеэр Америкийн киноны сор болсон одууд түүнд тохиолдсон гай зовлонг өөрсдийн юм шиг хуваалцаж явсан бол одоо тэд түүнийг тоохоо больжээ. Инээдтэй ч юм шиг.

Түүнийг лонхноосоо дахин балгах зуур хаалганы цоожинд түлхүүр эргэх дуулав. Сийлсэн юм шиг нарийхан танхилхан биетэй, хөөрхөн царайтай, нил цэцгийн өнгөтэй талимаарсан нүдтэй эхнэр нь өмнө нь ирж зогстол Жонни лонхоо амнаасаа салгасангүй. Хорвоо ертөнцийн сая сая эрчүүд Марго Эштоны цэвэрхэн царайд шохоорхон дурлаж, түүнийг дэлгэцнээс харахын тулд мөнгө төлдөг юмсанж:

- Хаагуур тэнэж яваад ирэв?

- Зүгээр л, ганц хүнтэй энгэр зөрүүлж яваад ирлээ хэмээн Марго хэнэггүй хариулахдаа нөхрийгөө их согтуу байна гэж бодсон нь эндүүрчээ. Жонни сэтгүүлийн ширээ даван үсэрч гараад түүний ар хүзүүн дээрээс палаажтай нь базаж авсан боловч энэхүү зурсан юм шиг хөөрхөн царай нүүрэнд нь тулаад ирэхээр хорсол занал нь хоромхон зуур замхарч хамаг бие нь шалчийчхав. Эхнэр нь доогтой жуумалзан мушилзав. Гэвч Жонниг нударгаа далайхыг хараад бас л буруу тооцоолсноо ойлгоод:

- Нүүр рүү л бүү цохиорой, Жонни! Би чинь кинонд зураг авахуулж байгаа шүү гэж чарлав.

Зангидсан нударга яг аюулхайд нь таарч эхнэр нь тэрий хадан унахад Жонни дээрээс нь дарж аваад мөр, гар, ташаа, сүвээ, хажуу хавирга гээд юу тааралдсанаа балбаж гарав. Тэрээр дээр үед гудамжны танхай жаал байхдаа «тамын гал зуух» гэгдэх Нью-Йоркийн борчуулын хороололд нусгай жаалуудыг дэлсдэг байсан шигээ шүд хугалах хамар цөмлөх зэргээр бэртээж гэмтээхгүй ч гэсэн их өвдтөл нь эхнэрээ нүдлээ.

Гэлээ ч тэр эхнэрээ хамаг тэнхээгээрээ цохиж чадахгүй байсан тул Марго түүнийг илэрхий тохуурхан, хоргой палаажны хормойгоо бүсэлхийнээс нь дээш сөхөгдтөл шалан дээр тэрийж

хэвгчихээд хорыг нь малтан хөхөрч:

- За алив Жонни, над дээр хүрээд ир. Чамд юу хэрэгтэйг чи өөрөө мэднэ шүү дээ.

Гоо сайхан хуягныхаа цаана халдашгүй дархан цаазтай энэ мондийг алсан ч багадна гэж бодоод Жонни Фонтейн бослоо. Марго уруугаа харснаа туялзан үсэрч босоод догонцон дэвхэрч жаахан хүүхэд шиг:

- Өвдөөгүй дээ, өвдөөгүй дээ хэмээн маяглаж байснаа дорхноо төлөв болж, дур булаам нүдэндээ уйтгар гуниг хураан: - Дүүрчихсэн тэнэг амьтан, жаахан хүүхэд шиг гэдэс гүзээ цөмлөчих шахлаа байна. Чааваас гэж, Жонни минь, чи арчаагүй чигээрээ л насыг барах байх даа. Хөнжил дотор ч гэсэн чи нусгай жаалаас дээрдэх юмгүй. Хүмүүс үнэхээр чиний урьд дуулж байсан шиг сайхан аашилдаг гэж бодно уу? Ээ хөөрхий ч амьтан бол доо! За Жонни минь, баяртай гээд унтлагынхаа өрөөнд орж хаалга түгжив.

Жонни басуулж доромжлуулсандаа гомдож цөхрөнгөө бараад суулаа. Гэвч Нью-Йоркийн ядуусын хороололд өссөн нь талаар өнгөрсөнгүй. Голливудын балар ширэнгэнд амь тээж гарсан хуучин зан чанарынхаа хүчинд тэр босов. Нисэх онгоцны буудал орохоор хөлсний тэрэг утсаар дуудлаа. Одоо түүнийг ганцхан хүн л аварч чадна. Нью-Йорк руу нисэж, эдүгээ агаар шиг дутагдаж буй хүч чадал, оюун ухаан, итгэл найдварыг өгч чадах цорын ганц хүн болох загалмай зүүлгэсэн эцэг, эрхэм Корлеоне руу очих хэрэгтэй.

Италийн сэвсгэр талх шигээ улаа бутарсан хацартай тагдгар бөөрөнхий биетэй, дээр нь бас цул гурил болсон талхчин Назорин өөрийн эхнэр, охин Катарина, талхны газрынх нь ажилтан Энцо гурвыг ууртай ширүүн харцаар тойруулан харлаа. Энцо ханцуйн дээрээ «ОЦ» гэсэн ногоон үсэгтэй даавуу уясан олзны цэргийн дүрэмт хувцсаа өмсөж амжсан боловч харин одоо Амбаны арал дээр болох оройн тоонд хожимдохоосоо айн дороо холхино. Америк эздийн газарт ажиллуулахаар ам үгэнд итгэмжлэгдэн торгоогдож байдаг тэрээр италиас олзлогдсон мянга мянган цэргийн нэгэн адил энд, америкт ажиллах аятайхан хөнгөлөлтөөс салчих вий хэмээн хэзээ ямагт айн чичрэх учраас одоогийн тоглогдож буй энэ гэнэн жүжиглэл түүний хувьд ноцтой хэрэг байв.

- Миний гэр бүлийн нэр төрийг гутаах гээ юу, чи? хэмээн Назорин түүнийг зандарч: -Охинд минь дурсгалын бэлэг үлдээж байгаа нь энэ үү? Дайн дуусаж байгаа болохоор цаашид яахыг таахад түвэггүй. Чи Америкаас хөөгдөөд Сицили дэхь тосгондоо очиж бөөсөө тоолно биз, тийм үү? гэлээ.

Богинохон хөлтэй загзгар Энцо гараараа зүрхэн тушаа даран уйлах шахаж:

- Эзэнтэн минь. Ариун хутагт эхийн нэр барьж тангараглая. Би та нарын тусыг усаар хариулах гээгүй. Би охиныг чинь байдгаараа хүндэтгэдэг, үнэн голоосоо хайрладаг. Тэгээд ч надтай суулгаач гэж мэхийн гуйж байна. Би ийм юм гуйх эрхгүй нь үнэн, гэвч, хэрэв намайг Итали уруу явуулчихвал эргэж ирж ч чадахгүй. Катаринатай гэрлэх ч өнгөрнө хэмээх нь бас ч нэгийг бодсон бололтой.

Назоринигийн эхнэр Филомена олон юм ярьж цаг үрэхийг бодсонгүй шууд л бүдүүн хар

хүндээ хандаж:

- Битгий тэнэглээд бай! Юу хийвэл зохихыг чи сайн мэдэж байгаа. Энцог хааш нь ч явуулж болохгүй. Харин Лонг-Айланд уруу хамаатныдаа аваачиж хэсэг зуур нуувал хавьгүй дээр!

Гэрлэх нас нь хэтэрч яваа, тагдгар бүдүүн Катарина цорхиртлоо уйлна. Гоо сайхнаараа гайхуулж чадахгүй энэ хүүхэн Энцо шиг ийм сайхан нөхөр дахиж хаанаас олох юм бэ? Өөр хэн түүний бие эрхтнийг ингэж хайрлаж энхрийлж илэн таалах билээ?!

Би Итали руу явчихна шүү, харж л байгаарай! Энцог энд үлдээхгүй юм, бол би дагаад оргоно доо хэмээн тэр эцэг рүүгээ үсчинэ.

Назорин залирхаг нүднийхээ булангаар түүнийг хараад Миний охин ч ёстой сайхан моньди юм даа> гэж бодлоо. Халуунаар нь авчирсан талх сагсанд хийхээр Энцо түүний араар шурган зүтгэхэд охин нь мань эрийг түнтгэр тонтгор болгоноороо лангуунд шахан наалдахыг оролдож байхыг Назорин нэг бус удаа харсан юмсанж. Одоохон шийдвэртэй арга хэмжээ авахгүй бол энэ залуу ч гэсэн өөр нэг тийшээ шургахаар зүтгэж мэднэ. Энцог Америкийн иргэн болгож энд нь үлдээх хэрэгтэй. Энэ хэргийг бүтээж чадах ганц хүн бол загалмайланс эцэг, эрхэм Корлеоне мөн.

1915 оны наймдугаар сарын сүүлчийн бямба гаригт Констанция Корлеонегийн хуримд хүрэлцэн ирэх алтан үсэгтэй урилгыг энэ гурваас гадна өөр олон хүн хүлээн авсан байв. Тэр хүүхний эцэг ноён Вито Корлеоне эдүгээ Лонг-Айланд дахь нүсэр том тансаг харшид хангалуун амьдардаг хэдий ч эртний анд найз, айл хөршүүдээ ер мартдаггүй ажээ. Чухам энэ харшид л зочид цугларч, хөгжөөн цэнгээн бүтэн өдөр үргэлжилж хожим дурсан ярих олон дурсамжтай тарна. Японтой хийсэн дайн дөнгөж дуусаад, галын шугам руу явсан хөвгүүдийнхээ хойноос сэтгэл түгших зовлон хүмүүсийн энэ баяр баясгаланг гутааж харлуулахаа нэгэнт больсон цаг байв. Харин хурим найр бол хүмүүст хөөр баяслаа дураар нь тавих хамгийн аятайхан шалтаг шүү дээ!

Ингээд тэр бямба гаригийн өглөө болж, эрхэм Корлеонегийн найз нөхөд нь түүний гэр бүлийн найр цэнгээнд хүрэлцэн ирж хүндэтгэл илэрхийлэхээр Нью-Йорк хотоос цувж гарлаа. Хуримын бэлэг болгон зочин бүрийн халаасалж ирсэн дүүрэн мөнгөтэй дугтуй, түүн дотор хийсэн нэрийн хуудас нь бэлэг барьсан хүний хэн гэгч болох, мөн эрхэм Корлеонег хэр зэрэг хүндэтгэхийг зүй ёсоор илтгэх бөлгөө.

Эрхэм Вито Корлеоне дээр хэн ч гэсэн тусламж гуйн ирж болдог, ирсэн нэг ч хүн гуяа ганзагалаад хоосон буцсан удаа ер үгүй. Тэр хоосон амлалт өгдөггүй, бас өөрөөс нь илүү хүчирхэг юм хорвоо дээр байдаг, гар хөл боолт баглаатай, хөдөлж, болохгүй, яах ч аргагүй байна гэх мэтчилэнгийн худал шалтаг заадаггүй, шууд л тусалдаг байв. Тэгэхдээ тэр заавал таны найзын тоонд багтах албагүй, танд шанд нь өгөх хөрөнгө мөнгө байгаа эсэх нь ч хамаагүй. Гагцхүү та, та л өөрөө түүний найз гэдгээ мэдэгдэх шаардлагатай. Чухам ингэвэл л аврал эрж ирсэн хүн ямар ч ядуу дорой байсан эрхэм Корлеоне түүний гаслан зовлонг өөрийнх шигээ үзэн, түүнд тохиолдсон гай тотгорыг арилгахаар ямар ч саад бэрхшээлийг даван зүтгэдэг юмсанж. Шанд нь юу авах вэ? үерхэл, нөхөрлөл, «эрхэм» гэх хүндэтгэл, хааяа «Загалмайланс эцэг» гэж дотночлох л шив дээ. Өөр юу билээ? Заяах вэ, Христосын

мэндэлсний өдөр ширээгээ чимэхэд нь зориулан зориуд бэлдэж ирүүлсэн амтаг боовтой сагс эсвэл гэртээ дарсан лонх дарс байж болох л юм. Гэхдээ шан хөлсний журмаар биш, зөвхөн хүндэтгэл үзүүлэх хэлбэрээр шүү дээ. Тэгээд бас та түүнд насан туршдаа өртэй болохоор дуртай цагтаа чадах зүйлийг нь хариу шаардах эрхтэйг заавал батлан андгайлах нь мэдээж хэрэг.

Одоо, төрсөн охиныхоо хуримын энэ чухал өдөр эрхэм Вито Корлеоне Лонг-Айленд дахь гоёмсог харшийнхаа үүдэнд зогсоод зочдоо угтаж байлаа. Тэдний дийлэнх нь Корлеонегийн ач буянаар сайн сайхан яваа тул гэр бүлийн энэ баяр дээр түүнийг эрээлхэж бараалхалгүй зүгээр л «Загалмайлсан эцэг минь» гэж дуудна. Энд баарын худалдагч, үйлчлэгч хүртэл бүгд өөрийн хүмүүс тул зөвхөн дотнын анд найз нар нь цайллагын хоол унд бэлдэж, цэцэрлэгээ гэрлэн чимэглэлээр гоёсон байна. Зочин нь баян чинээлэг, ядуу хоосон, эрхтэн дархтан, эсвэл даруухан албан тушаалтан байна уу, ер хамаагүй. Эрхэм Корлеоне хүн болгоныг баяр хөөртэй угтах нь түүний төрөлхийн өвөрмөц зан билээ. Зочид нь ч гэсэн өмссөн хувцас нь түүний нүүр царайд хэрхэн зохисныг нэгэн дуугаар гайхан шагшиж элдвээр магтацгаахыг хараад учрыг сайн мэдэхгүй хүн бол эрхэм Корлеоне өөрөө гэрлэж байна гэж андуурмаар ажээ.

Корлеонегийн гурван хүүгийн хоёр нь түүний хажууд зогсож байлаа. Хамгийн том хүү, Сантиног эцгээс бусад нь бүгд л Сонни юм уу «хүү минь» гэж дуудах бөгөөд хижээл насны италичууд нь түүнийг сонжсон байртай харж, харин залуучууд нь бахархан ширтэнэ. Итали гаралтай америк хүн гэхэд тэрээр бараг зургаан тохой өндөр, бухан бяруу шиг чийрэг, ханхар биетэй, малгай шиг овойсон тас хар үстэй, нас бие гүйцсэн Купидоны царайтай аж. Хэт мэдрэмтгий, нумалсан уруул бяцхан хонхорхойтой тэвхгэр эрүүг нь харсан хэнд ч нүгэлтэй бодол аяндаа төрнө. Үнэхээр ч байгалиас Соннид янаг амрагийн хүч чадал харамгүй заяаж, хөөрхий эхнэр нь түүнтэй дэр нийлүүлэхээс яаж айдгийг гагцхүү бурханд тэрсэлсэн хүнд яргалал тамлал ямар санагддагтай л зүйрлүүштэй. Түүний орж гарч явсан янхны газрын хашир догь хүүхнүүд хүртэл түүнтэй унтсаныхаа маргааш өглөө ямбийтлаа эдлүүлсний төлөө нэмэлт хөлс нэхсэн хэмээн шивэр авир гэлцдэг болой.

Өнөөдөр ч гэсэн энэхүү хурим найр, ид цэнгээний үеэр залуухан охид хүүхнүүд эрээ цээргүй сонжсон, урин дуудсан харцыг Сонни руу алсаас чулуудна. Гэвч энэ өдөр тэдний оролдлого яагаад ч бүтэхгүй байв. Учир нь тэрбээр нэгэн хүүхнийг онцлон харж ойртон дөхсөөр байсан юм. Төрсөн дүүгийнх нь ганц найз Люси Манчини өнөөдөр Соннигийн анхаарлыг татаад байлаа. Тэр хүүхэн одоо ягаан палааж өмсөж, тас хар үсээ цэцгэн титмээр даруулаад, хуримын ширээний ард, бэргэний хажууд сууна. Тэрээр хуримын өмнөх долоо хоногийн туршид Соннитой сээтгэнэж, гэрлэх ёслолын үеэр тахилын ширээний өмнө зогсож байхдаа түүний гарыг чангаар атгаад авчээ. Хадамд гараагүй нэг ч хүүхэн үүнээс илүү эр хүнд аальгүйтэж зүрхлэх байсан гэж үү. Сонни агуу их эцэгтэйгээ хэзээ ч эн зэрэгцэж чадахгүй нь хүүхэнд ямар ч хамаагүй, гагцхүү тэр залуу амьдралдаа ч, хайр дурлалдаа ч зоригтой, хүчтэй байдаг нь л хүүхэнд чухал санагдана. Хэзээ ч хашир санаалж, буурь заадаг эцгийгээ бодвол Сонни овилгогүй зан гаргаж, санаанд оромгүй зүйл хийх нь олонтаа учир хэдийгээр баруун гарын туслах нь боловч түүнийг Загалмайлсан эцгийг орлоно гэдэгт олон хүн эргэлзэнэ.

Их эцгийн хоёрдахь хүү зүгээр л Фредо буюу Фред гэж дууддаг Фредерико бол аль ч итали хүний хүсэн хүлээж, заяагаач гэж бурхнаас гуйдаг тийм хүүхэд байлаа. Эцгийнхээ хүсэл

зоригийг биелүүлэхэд ямагт бэлхэн, хүндэтгэн хайрлаж, үнэнчээр харилцдаг тэр хүү гучин нас хүртэлээ эцгийнхээ гэрт амьдарсаар бөлгөө. Намхан загзгар биетэй тэр залуу бас л гэрийнхэн шигээ Купидонтой адил төстэй боловч буржгар үстэй дугуй царай нь тийм ч дур булаам бус, мөн л мэдрэмтгий нумалсан уруул нь харгис хэрцгий шинжтэй. Фредо үг цөөнтэй, ширүүн зантай боловч эцгийнхээ түшиг тулгуур нь болдог бөгөөд хэзээ ч түүнтэй маргадаггүй, элдэв хэрүүл шуугиан, хэрэг түвэгт орооцолдож санааг нь зовоодоггүй нэгэн. Гэхдээ сүргийн толгойлогчид шаардлагатай байдаг хүчтэй араатны байлдан дагуулах чадвар түүнд үгүй учраас Их Эцгийн ажил хэргийг түүнийг залгамжилна гэдэгт мөн л хэн ч үл итгэнэ.

Эрхэм Корлеонегийн гуравдахь хүү Майкл эцэг, ах нарынхаа хамт зочдыг угтсангүй, цэцэрлэгийн хамгийн цаад булангийн ширээнд суух боловч тэнд ч гэсэн хавь ойрын хүмүүсийн сониуч харцнаас тэрээр мултарч эс чадна.

Майкл бол төгс хүчит эцгийнхээ хүслийг биелүүлэхээс татгалзсан цорын ганц хүн бөгөөд гэр бүлийнхнийхээ дүр төрхийг ч дуурайсангүй. Майклын үс нь буржгар биш шулуун, ер нь багадаа гадаад байдлаараа хүүхэн хүн шиг санагдаж эрхэм Вито Корлеоне түүнийг жинхэнэ эр хүн болдог л байгаа даа хэмээн санаа зовж байтал арван долоон нас хүрмэгц эцгийнхээ энэ эргэлзээг арилгажээ. Цэцэрлэгийн алс бөглүү буланд, захын ширээний ард очиж сууснаараа отгон хүү нь гэрийнхнээсээ хол хөндий байдгаа харуулсан аж. Түүнтэй найз хүүхэн нь хамт суух агаад тэрхүү цэвэр америк хүүхний тухай бүгд сонссон боловч хэн ч олж хараагүй юмсанж. Мэдээж, Майкл боловсон зан гаргаж түүнийг гэрийнхэндээ болон бусад зочдод танилцуулсан боловч тэдэнд гойд сэтгэгдэл төрүүлсэнгүй. Дэндүү туранхай биетэй, дэндүү цайвар царайтай, эмэгтэй хүнд ахадсан гэмээр ухаантай, хүмүүстэй дэндүү чөлөөтэй харилцах тэр хүүхний Кэй Адамс гэдэг нэр нь хүртэл итали хүний чихэнд хүнийрхүү харь сонсогдоно. Адамсынхан хоёр зуун жилийн өмнө америкт ирж суурьшсан улс, энэ бол их дэлгэрсэн түгээмэл овог нэр хэмээн түүнийг хэлэхэд нөгөөдүүл нь мөрөө хавчихаас цаашгүй байцгаах аж.

Их Эцэг отгон хүүгээ ер анхаарахгүй байгааг бүгд анзаарчээ. Дайнаас өмнө Майкл эцгийнхээ хайртай хүү нь байсан болохоор Вито Корлеоне эцсийн эцэст түүнд л ажлаа үлдээх нь зүй ёсны мэт санагдаж байсан үе бий. Тэр тусмаа Майкл эцэг шигээ тайван, буурьтай хөдөлж, орчны хүмүүсийн хүндэтгэлийг хүлээж чаддаг байв.

Гэтэл дайн эхэлж, Майкл Корлеоне эцэгтэйгээ зөрсөөр байгаад сайн дураар фронт руу явжээ. Эрхэм Вито төрсөн хүүгээ харь орны ашиг сонирхлын төлөө тулалдуулж, тэнэсэн сумны золиос болгохыг ер хүсээгүй учир эмч нарыг их мөнгөөр худалдан авч бүх юмыг аргалжээ. Гэвч хорин нэгэн нас хүрээд байсан Майкл хүү нь шийдвэрээ өөрчилсөнгүй. Тэнгисийн явган цэрэгт бүртгүүлж, цэргийн алба хаахаар далайн цаад руу оджээ. Тэндээ тэрээр ахмад цолтой болж одон медалиар шагнуулсан учир 1944 онд «Лайф» сонинд зурагтайгаа нийтлэгджээ. Түүнийг нь эрхэм Корлеонед нэг найз нь (гэрийнхнээс хэн нь ч ингэж зүрхлээгүй) үзүүлэхэд ер тоосон шинжгүй:

-Хүний найран дээр ингэж ч хэнхэглэх гэж дээ, хэмээн бувтнасан гэдэг.

Дөчин таван онд шархадсаных нь дараа Майклыг цэргээс халж, энэ бүхнийг эцэг нь зохион

байгуулсан гэж тэрбээр зүүдлээ ч үгүй, өнгөрч билээ. Гэвч Майкл гэртээ гурван долоо хоноод эцэг эхийнхээ хүсэн хүлээсэн найдварыг дахин хөсөрдүүлж, хэнтэй ч үл зөвшилцөн Нью-Хемпшир муж улсын Дармутын их сургуульд оржээ. Төрсөн гэртээ тогтдоггүй тэр залуу гагцхүү дүүгийнхээ хуримд л гэж энд ирснээс гадна бас юм үзэж нүд тайлсан ирээдүйн эхнэрээ танилцуулах гэсэн аж.

Одоо Майкл Корлеоне зарим зочдынхоо элдэв хөгийн паянг ярьж, Кей Адамсыгаа зугаацуулж суулаа. Кей түүний яриаг үнэн голоосоо сонирхон, ийш тийшээ харж байснаа дарстай торх тойрсон хэдэн хүн нэг л юм хүлээсэн байртай зогсож байхыг олж үзлээ.

Тэд нь Америго Бонасера, талхчин Назорин, Энтони Компиола, Люка Брази нар байхыг Майкл таньж, тэр дөрөв тийм ч их баярласан шинжгүй байгааг Кей гярхай нүдээр ажиж мэджээ. Майкл сэтгэл хангалуун жуумалзав.

- Нээрээ эд чинь юм гуйхаар ирж. Аавтай аминчилж уулзах боломж хүлээгээд байна.

Үнэхээр ч сайхь дөрөв эрхэм Корлеонег нүд салгалгүй ажиглана.

Гэрийн эзэн зочдод баяр хүргэсэн хэвээр зогсож байтал цэцэрлэгт гудамжны цаад үзүүрт хар «Седан Шевроле» ирж зогсоод, урд нь суусан хоёр эр шууд дэвтэр гарган тэнд байсан машины дугаарыг бичиж авав.

Сонни эцэг рүүгээ эргэж харлаа.

- Эд цагдаа нар боллолтой.

Эрхэм Корлеоне мөрөө хавчина.

- Гудамж миний мэдлийнх биш. Яавал яаг.

Соннигийн уур нь буцалж царай нь барайгаад ирэв.

- Шаарнууд чинь, бүр галзуурах нь ээ!

Тэрээр шатаар бууж, «Седан-Шевроле» тийш дөхөж очоод жолоочийн цонхоор шагайваас цаадах нь биеийн байцаалтаа тэр дороо үзүүллээ. Сонни юу ч хэлсэнгүй, цааш эргэн машины арын хаалга руу сархийтэл нулимж орхив. Жолооч дургүй нь хүрээд гараад ирэх болов уу гэтэл ер хөдлөх шинжгүй.

Сонни эргэж ирээд:

- Эд нар FBI-ныхон байна. Муу новшнууд - хэмээн эцэгтээ мэдэгдвэл цаадах нь урьдаас мэдэж байсан бололтой ер гайхсангүй. Тэрээр өөрсдийн машинаар биш таксигаар ирээрэй гэж ойр дотнын анд найз, хамгийн эрхэм зочиддоо захисан байсан юмсан. Хүүгийнх нь зэрлэг авир Их Эцэгт таалагдаагүй хэдий ч цагдаа нарын ирэхийг мэдээгүй байсан гэх сэтгэгдэл төрүүлсэнд харин ч сайн юм болов.

Үгүй ээ, эрхэм Корлеоне уурласангүй. Энэ нийгмийн эрхтэн дархтан эгзэг таарвал хэзээ ч дарлан доромжлоход бэлэн болохоор гагцхүү цаг нь ирэхээр тэдэнтэй тооцоо хийнэ гэж горьдоод л суугаад байхаас өөр аргагүй гэсэн үнэн мөнийг тэр аль эртнээс ойлгож авчээ. Энэ энгийн зарчмынхаа ачаар ч эрхэм Корлеоне юу ч болж байсан үл тоомсорлож сайхан санаалан явж. ойрын хүмүүсийгээ бишрүүлж чаддаг бөлгөө.

Байшингийн цаад цэцэрлэгт хөгжим дуугарч бүгд цугларсан болохоор эрхэм Корлеоне цагдаа нарын тухай бодлоо таягдан хаяад наргианаа эхлэхээр зочид руугаа явлаа.

Асар уудам цэцэрлэгт хэдэн зуун хүн бужигнаж, зарим нь цэцэг навчаар чимсэн модон тавцан дээр бүжиглэж, бусад нь өмнө зүгийнхний халуун ногоотой зүсэн зүйлийн хоол, зууш, архи дарс дүүрэн өрсөн урт урт ширээний ард тухалжээ. Бэр Конни Корлеоне хуримынхаа ганган хувцастайгаа тусгай зассан ширээнээ сүйт хархүү, найз хүүхнүүд, бэргэн нарын хамт сууна. Сүйт хархүү нь дургүй байсан хэдий ч Конни эцгийгээ баярлуулахын тулд л хуримаа хуучны итали ёсны дагуу хийхийг зөвшөөрсөн байна. Хадам эцэгтээ тийм ч их таалагдаагүй Карло Онцили эцгээ дууриасан бор царайтай, хойт зүгийн эхийнх шигээ цайвар үстэй? цэнхэр нүдтэй эрлийз залуу байв. Түүний эцэг эх Невадад амьдардаг, харин тэр өөрөө хууль зөрчсөн хэрэг явдлынхаа улмаас тус муж улсыг орхиж явахад хүрсэн аж. Нью-Йоркод ирээд тэрээр Сонни Корлеонетой танилцаж, түүгээр дамжуулан Коннитой учирсан юм байж. Мэдээжээр, эрхэм Корлеоне түүний тухай Невадаас асуун магадалж, буу алдсан хэрэгт холбогдсоныг нь олж мэджээ. Энэ хэргийг цагдаагийн газраас авч, энэ залууг шил шиг цэвэршүүлэхэд юухан байхав?! Үүний хажуугаар найз нар нь Невадаас ирэхдээ хуулиар зөвшөөрсөн тоглоомын газрын тухай мэдээ олж ирсэн нь Их эцгийн сонирхлын ихэд татаж, тэр тухай одоо хүртэл бодсоор яваа бөлгөө. Суусан газраасаа шороо атгаж алт болгодогт Вито Корлеонегийн сүр хүч нь орших авай.

Конни Корлеоне тийм хөөрхөн гэхээргүй, хөгшрөөд ирэхээрээ уур уцаартай, үглээ болж мэдэхээр боловч өнөөдөр хуримынхаа цагаан өмсгөлтэй болоод ч тэр үү, танигдахааргүй болтлоо өөрчлөгджээ. Тэр хүүхэн гараа ширээн доогуур нөхрийнхөө өвдөг дээр тавьж, түүнийгээ хайрын нүдээр ширтэн харж ханахгүй сууна. Карло Рицци залуудаа элсэн цөлд хэдэн жил биеийн хүчний ажил хийсэн тул булчин шөрмөс нь хуримын хувцасных нь дороос зангирч харагдана. Одоо Карло эхнэрийнхээ бишрэн шүтсэн харцан дор буянаа эдэлж, түүнд байн байн архи хундагалан үйлчлэх нь ямар нэгэн жүжигт сүйт хархүүгийн дүр амилуулж байна гэлтэй. Харин хуримлаж буй бүсгүйн баруун сугандаа зүүсэн торгон уутанд бэлэгний зузаан дугтуй хэрхэн орж хуримтлагдахыг тэрээр үнээн голоосоо шохоорхон харж суулаа. Тэнд хэд байгаа бол? Арван мянга уу? Хорь хүрсэн болов уу? Энэ чинь зөвхөн эхлэл гэж бодоод Карло Рицци сэтгэл хангалуун инээмсэглэв. Охинтой нь гэрлэснээр Карло үнэхээр хүчирхэг гэр бүлд багтан орсон тул одоо хүссэн хүсээгүй ч түүний төлөө санаа тавих л болно.

Үсийг нь тугал долоочихсон өмхий хүрэн шиг залуу зочдын дунд зогсоод бэр хүүхний торгон уутыг бас л шохоорхон харах ажээ.

Паоло Гатто үнэн хэрэг дээрээ түүнийг хулгайлах гэсэнгүй, зүгээр л хийх юмаа олж ядахдаа яаж авч болохыг төсөөлөн биеэ зугаацуулах бөгөөд энэ бодол нь танкийг гар резинээр харваж сөнөөх гэсэн томоогүй жаалын хүсэлтэй адилхан гэдгийг сайн ойлгож байлаа.

Паоло өөрийн дарга Питер Клеменцаг олж харвал хижээл насны тарган тэр эр залуухан охидыг бүдүүн гэдсэндээ чанга тэврэн бүжгийн тавцан дээгүүр хуй салхи лугаа адил эргэлдэнэ. Клеменца асар том, лагс биетэй хэдий ч тун эвлэгхэн бүжиглэх тул үзэгч олон нэгэн зэрэг алга нижгэнүүлэн таашааж, нас тогтсон эмэгтэйчүүд хүртэл бүжиглэхих санаатай урагшаа чихэлдэн, сайхь эрийн хормой хотоос чангаацгаана. Залуучууд тэднийг хүндэтгэн зай гаргаж, мандолин хөгжмийн эрчимтэй айзмаар алга ташиж эхэллээ.

Эцсийн эцэст Клеменца тэнхээ тасарч дөнгөж амжин тавьж өгсөн сандал дээр лагхийн унахад Паоло Гатто тэрхэн зуур хүйтэн дарстай аяга барьж, өөрийнхөө алчуураар даргынхаа духны хөлсийг арчиж өгөв. Клеменца эрэг дээр хаягдсан халим загас шиг түнхэлзэн амьсгаадсаар дарсаа хэдхэн балгаж дуусаад Паолод талархал илэрхийлэхийн оронд:

Үүгээр эргэлдэхийн хэрэг юун. Ажлаа бод. Элдэв бусын юм гарсан эсэхийг нь шалга! хэмээн зандарчээ.

Паоло нэг ч үг дуугарсангүй, зочдын дунд орж алга боллоо. Хөгжимчид хоолойгоо норгохоор түр завсарлахад зочин залуусын нэг Нино Валенти эзэнгүй орхисон мандолиныг шүүрэн авч хайр дурлалын тухай шалиг дуу уянгалуулж гарав. Залуудаа цэвэрхэн байсан үүний царай байнга архидсаны улмаас хавдаж бөлцийн одоо ч гэсэн нилээд хөлчүү харагдана. Нино Валенти нүдээ эргэлдүүлж битүү утгатай үгс аялахад хүүхнүүд бахдан шуугилдаж, эрчүүд нь шад бүрийн сүүлчийн хоёр мөрийг нийтээр түрэн уухайлах ажээ.

Төлөв ёсыг эрхэмлэх Вито Корлеоне угийн завхай зайдан явдалд дургүй учир (бүдүүн эхнэр нь бусдын адил хөл хөөрцөг болж байсан хэдий ч) дипломат зан гарган гэртээ явж орлоо. Сонни энэ далимаар залуу хосын ширээнд очиж Люси Манчинигийн хажууд суув. Соннигийн эхнэр нь энэ үеэр гал зууханд хуримын бялуу хийхээр бөгтгөнөж байсан тул айх юмгүй гэж боджээ. Мань эр хүүхний чихэнд хэдэн үг шивнэж цаадах нь босоод гадаалахад Сонни ёсыг бодож жаахан хүлээснээ зарим зочидтой хэд гурван үг солилцсоор араас нь дагав.

Коннигийн хамгийн дотнын найз тэр бүсгүй америкийн коллежид гурван жил суралцахдаа их юм үзсэн хүүхний ааш аягийг бүрэн эзэмшжээ. Хуримд бэлтгэх хугацаанд өөртөө сээтэн хаях бололцоо Соннид бүрэн олгож, хоёулаа бэргэн болж гэрлэх ёслолд хамт оролцох учир үүнийгээ ичгүүртэй юм ч гэж бодсонгүй авай. Одоо тэрээр урт ягаан палаажныхаа хормойг дарсаар байшинд ормогц төлөв ариун бүсгүйн хуурамч инээмсэглэлийг нүүрнээсээ арчин хаяад халуун усны өрөөнд гүйхээрээ оров. Хэдэн минутын дараа түүнийг гарч ирэхэд Сонни аль хэдийнээ хүлээгээд зогсож байлаа.

Эрхэм Корлеонегийн ажлын өрөөний цонхоор Томас Хейген хурим найрын наргианыг харж зогсоно. Түүний арын хана дүүрэн өлгөсөн тавиурт хууль цаазын ном пиг өрөөстэй. Хейген Корлеонегийн гэр бүлийн өмгөөлөгч, тэдний бүлгийн зөвлөгч болохоор хамгийн хүндтэй, чухал байр эзэлдэг нэгэн. Вито Корлеоне тэр хоёр энэ өрөөнд суугаад олон ч ээдрээтэй асуудлын зангилааг тайлсан, түүнийг сайн мэддэг учир Их Эцгийг босоод гэр лүүгээ алхахаар нь жинхэнэ ажлаа хийх цаг болсныг төвөггүй ойлгожээ. Хейген эрхэм Корлеонег дагуулан харах зуур Сонни, Люси Манчини хоёрын шивнэлдэж, ар араасаа босч явахыг ажиглаж амжсан тул сэтгэл таагүй ярвайн тэр хоёрын талаар Их Эцэгт нь цухуйлгах эсэх

талаар эргэцүүлэн бодоод хэлэхгүй байх нь дээр гэж шийдлээ. Тэрээр өнөөдөр Загалмайлсан Эцэгтэй уулзах хүсэлт гаргасан хүмүүсийн жагсаалтыг ширээн дээрээс дөнгөж автал эрхэм Корлеоне орж ирсэнд жагсаалтаа сарвайв.

- Бонасераг хамгийн сүүлд уулзуулаарай - хэмээн тэрээр хэсэг бодсоноо үгүүлсэнд Хейген цэцэрлэгт гарч, дарстай торхны дэргэд хүлээж ядан зогссон хүмүүсийн дотроос талхчин Назориниг занган дуудлаа.

Эрхэм Корлеоне, Назорини хоёр Италид хамт тоглож өссөн учир түүнийг элэгсэг дотноор угтав. Тэдний үерхэл он жилүүдийн шалгуурыг амжилттай давж, талхчин эр жил болгоны христосын мэндэлсэн өдрөөр зах нь шүднээ шаржигнасан аварга том талх ирүүлэхээс гадна улаан өндөгний баяр, гэр бүлийн тэмдэглэлт өдрөөр олон давхар асар том бялуу бэлэглэж, түүнийхээ хэмжээгээр багын найздаа хайр хүндэтгэлээ илэрхийлнэ. Ган гачигтай, хур бороотой ямар ч жил Назорин найзынхаа үүсгэж байгуулсан хүнсний ажилтан нарын үйлдвэрчний эвлэлд татвараа алдалгүй төлдөг бөгөөд түүний гарыг ер хардаггүй, харин дайны үеийн шуугианаар хар зах дээрээс хямдхан олж авсан элсэн чихрийн талоноос нь л ганц удаа гуйсан юмсанж. Тийм болохоор талхчин олон жил үерхсэн найзаасаа юм гуйх бүрэн эрхтэй, эрхэм Корлеоне түүнд ямар ч тус хүргэхэд дуртай байлаа.

Тэрбээр найзыгаа «Ди Нобион» навчин тамхи, алтан шаргал «Стрега» буйлуулмал архиар дайж, «гуйх гэдэг гутамшиг гуйлгах гэдэг гайхамшиг» болохыг сайн мэдэх хүний хувьд урам хайрлан мөрийг нь аяархан алгадав.

Талхчин өөрийн охин, Энцо хоёрын тухай ярилаа. Сайн ухааж бодвол, олзлогдсон тэр залуу эцсийн эцэст Америкийн ашиг тусын тулд, ялалтын төлөө энд ажиллаж байна. Гэтэл одоо, дайн дууссан хойно түүнийг Итали руу нь буцааж, хөөрхий тэр сицили залуу, Назоринигийн охин хоёрын ариун нандин дурлалыг унтраах гэж байгаа тул ээнэгшин дассан хөөрхий хоёрын хамаг найдвар ганцхан Загалмайлсан эцэг, эрхэм Корлеоне л байна!

Их Эцэг Назориниг нөхөрсгөөр тэвэрсэн хэвээрээ өрөөн дотуур нааш цааш аажуухан алхаж, түүнийг сайн ойлгож, дэмжиж буйн тэмдэг болгон байн байн толгой дохиж явснаа талхчинг яриагаа дуусгамагц түүн рүү инээмсэглэн харж:

- Ингэтлээ санаагаа бүү зовоо, найз минь - гээд ямар дэс дараагаар, юу хийвэл зохихыг тодорхой тайлбарлаж өглөө. Эхлээд тойргоос сонгогдсон конгрессын гишүүнд өргөдөл өгч, тэр нь Энцог АНУ-ын иргэн болох тухай хуулийн төслийг конгресст оруулна. Дараа нь зохих хүмүүст хоёр мянгаад доллар атгуулчихвал конгресс энэ төслийг баталчихна. Энэ бүхнийг Корлеоне өөрөө аргална. Үүнийг зөвшөөрч байгаа биз?

Ийм тус хүргэнэ чинээ бодоогүй явсан Назорини дуртайяа зөвшөөрлөө. Тэр тусмаа өөрт нь ямар ч хохиролгүйгээр конгрессын тусгай шийдвэр гаргуулна гэдэг тоглоом биш гэж бодохоос л талхчин эр сэтгэл хөөрсөндөө золтой л уйлчихсангүй.

Эрхэм Корлеоне түүнийг үүдэнд хүргэж өгөөд, бичиг баримтыг нь янзалж бүтээгээд өгөх хүн явуулахаа амлаж, тэд тэврэлдэн салах ёс хийгээд Назорини цэцэрлэг рүү буужээ.

Хейген үл мэдэг инээмсэглэн:

- Назорини ердөө л хоёр мянгаар хүргэнтэй ч, зуухны дэргэд бөгтгөнөх туслахтай ч болдог байна шүү. Энэ асуудлыг хэнд даалгах вэ? - гэвэл эрхэм Корлеоне бодол болон духаа атируулав.

- Сицилээс сонгогдсон конгрессын гишүүнийг оролцуулсан дор бол зэрэгцээ тойргийн еврейд даалгасан нь дээр байх. Харин Назоринигийн гэрийн хаягийг өөрчилчхөөрэй. Одоо дайн дууссан болохоор иймэрхүү хэрэг олшрох нь чирэгдэл учруулахгүй, үнэ хөлсийг нь хадаачихгүйн тулд Вашингтонд хүн нэмж ажиллуулах хэрэгтэй.

Хейген тэмдэглэлийн дэвгэртэй: «Конгрессын гишүүн Лютекотой уулзаж болохгүй, Фишертэй тохиролцох» хэмээн бичиж авлаа.

Дараа нь Энтони Компиола орж ирсэн бөгөөд Вито Корлеоне түүний эцэгтэй дээхэн үед төмөр замын агуулахад хамт ажиллаж байжээ. Тэрээр тусгай зуухтай зуушны газар шинээр нээх гээд таван зуун долларын хэрэгтэй ирсэн юмсанж. Энэ ердийн л хэрэг байсан тул Энтони яагаад банкны зээлээс татгалзсаныг ч сонсолгүй Их Эцэг толгой дохин халааснаасаа мөнгө гаргатай арай хүрсэнгүйд жаахан ярвайгаад Хейгенд хандав.

- Нэг дэх өдөр хүртэл зуун доллар зээлүүлээч, Том!

Энтони эрс эсэргүүцэн дөрвөн зуун доллар болно, хүрнэ гэсээр байтал тэр тоосонгүй, хүссэн мөнгийг нь атгуулав.

- Энэ хуримаас болоод бэлэн мөнгө дуусчхаж...

Их Эцэг өглөгч зангаа гайхуулж харуулах энэ чадварыг Хейген дотроо бахдан харж зогслоо. Өөрт нь тус болох гээд Загалмайлан эцэг өөрөө хүнээс мөнгө зээлж байгааг Энтони Компиола үнэлэхгүй байж яахан чадах билээ?! Эрхэм Корлеонегийн хөрөнгө сая саяар яригдах боловч ерөөл бусдад тус болох гээд өөртөө төвөг удах саятан тийм ч олон олдохгүй болов уу?

Вито Корлеоне дараачийн хүн хэн бэ гэсэн янзтай Хейген өөд харлаа.

- Люка Брази жагсаалтанд ороогүй, гэхдээ уулзахыг тун их хүсээд байна. Амьтан ах дүүгийн дэргэд танд баяр хүргэх эвгүйг ойлгоод биечлэн уулзах гэнэ.

Их Эцэг анх удаа дургүйцлээ илэрхийлэв.

- Заавал уулзах хэрэгтэй юу?

Хейген хайнгадуухан мөрөө хавчлаа.

- Та өөрөө л мэд. Ийм урилга авна гэж ер бодоогүй явсан болохоор хариу талархал илэрхийлэх гэснийг л би хэлж чадах байна.

Их Эцэг тэр Люка Бразиг хүлээн авахаа мэдэгдэн гар дохив.

Кей Адамс хуран цугларсан зочдын дотроос Люка Бразиг онцлон харж арьс маханд нь шингэсэн мэт зэрлэг догшин төрхийг нь гайхан, хэн гэгч болохыг Майклаас асуужээ. Ер нь Майкл эхнэр болох хүнээ энд дагуулж ирэхдээ эцгийгээ ямар, хүн гэдгийг аль болох цочиртол эмзэглэлгүйгээр, аажуухан ойлгуулах далд бодолтой байсан амой. Одоохондоо Кей ирээдүйн хадмаа ажлаа л бүтээж байвал ямар ч арга хэрэглэхээс сийхгүй жирийн бизнесмен хэмээн бодож яваа бололтой. Майкл түүнд үнэн мөнийг тойруу замаар ойлгуулахыг хичээн: Дорнод муж улсуудын гэмт хэрэгтэнгүүдийн дотор Люка Бразигаас илүү аюултай хүн олдохгүй, тэрээр хэний ч оролцоо дэмжлэггүй гав ганцаараа хүний амь хороох ажил эрхэлдэг тул хууль хамгаалах байгууллагад бараг баригдахгүй зайлдаг увидастайг тайлбарлав.

- Энэ бүхэн үнэн худлыг би сайн мэдэхгүй. Ямар ч л гэсэн тэр эр миний эцэгтэй зарим талаар найзалдаг юм.

Дөнгөж одоо л Кей зарим нэгэн зүйлийг гадарлаж эхлэв бололтой, итгэж ядсан эргэлзэнгүй дуугаар асуусан нь:

- Аав чинь ийм хүнээр. ажил хийлгэдэг гэж чи арай хэлэх гээгүй биз дээ?

«Аа, солиг гэж! Нуугаад ч яах юм билээ!» хэмээн Майкл дотроо хараагаад бүгдийг илэн далангүй хэлж, асуудлыг нэг тийш болгохоор шийдлээ.

- Арван таван жилийн өмнө өрсөлдөгч этгээдүүд нь эцгийн минь чидун жимсний тос гадаадаас оруулж борлуулах ажлыг булааж авах санаатай хөнөөхийг оролдож, аав азаар амьд үлдсэн. Тэгэхэд л Люка Брази тэдэнтэй халз үзэлцэж, хагас сарын дотор зургаан хүн цааш харуулснаар алдар цуутай чидун жимсний дайныг эцэс төгсгөл болгосон гэж би сонссон.

Майкл тун хөгжөөнтэй шог юм хэлчихсэн мэт наг наг хөхөрсөн боловч Кей давхийн цочлоо.

- Дээрэмчид эцгийг чинь үнэхээр буудсан юм уу?

- Арван таван жилийн өмнө тэр шүү дээ. Харин түүнээс хойш нам жим л байна гэх зуураа Майкл Кейд арай ч дэндүү цочмог дуулгачив уу даа хэмээн бодов.

- Чи зүгээр л намайг хөндийрнө гэж бодохдоо тоглоом хийж байна аа даа? Тун уран догь санаа, хэлэх ч юм алга - гээд Кей түүний тохойгоороо ёвроод авлаа.

Майкл инээмсэглэсэн хэвээр...

- Ямар ч гэсэн нэг завандаа сайн бодоод үз.

- Тэр чинь нээрээ зургаан хүн алчихсан юм уу?

- Сонинд л тэгж бичсэн байсан, гэхдээ үүнийг нотлох аргагүй. Энэ этгээд урьд өмнө олон хүнд хэлээд байхааргүй, нилээн бантан хутгаж явсан гэж би боддог юм. Энэ тухай аав надад яриагүй, гэхдээ Том Хейген хүнд хэлдэггүй ч бүгдийг мэдэж байгаа. Би Люка Бразигийн

тухай хэзээ бүгдийг мэддэг болох юм бэ гэж нэг удаа Хейгенээс асуусан чинь «Зуун жилийн дараа» гэсэн шүү. Ер нь Бразигийн түүх намтар өөрийнх нь нүүр царай шигээ муухай байх л даа

Үнэхээр Люка Бразигаас чөтгөр шулам ч гэсэн хирдхийж зугтаамаар билээ. Зүгээр түүнийг харахад л аюулын харанга дэлдэх шиг болдог аж. Ямар ч гэрэл гэгээгүй үхээнц бор нүд, түүхий махны өнгөтэй нимгэн уруултай бух нохойнх шиг өргөн нүүртэй, намхан тагдгар тэр эр ёстой л айдсын киноны гол баатар гэлтэй.

Хүн алж талахаараа нэр цууд гарсан тэр эр Загалмайлан эцэгт ямар үнэнчээр зүтгэдэг талаар үлгэр домог шиг юм ярих нь бий. Люка Брази нь эрхэм Корлеонегийн намын хүчин чадлын тулгуур гурван чулууны нэг нь болжээ. Люка шиг хүнийг дахиад олоход хэцүү бололцоогүй ч байж болох юм. Тэрбээр цагдаагийн газраас ч, бурхнаас ч, чөтгөр шуламсаас ч, олон нийтийн санал бодлоос ч айдаггүй, харин газар дээр ганц айж, хүндэтгэж, хайрлаж явах хүнээ өөрийн сайн дураар сонгон авсан нь Загалмайлан эцэг байлаа. Хүн болгонд айдас жихүүдэс төрүүлсэн Люка Брази өөрөө эрхэм Корлеонег харахаараа хүндэтгэсэн эрхэмлэсэндээ болоод хөшиж орхих бөлгөө. Энэ удаад ч гэсэн Их Эцэг баярласан талархсанаа ээрэн түгдрэн байж илэрхийлээд, анхны зээ нь хүү байхыг ерөөж, залуу хосод зориулсан дугтуйтай мөнгөө сарвайн барилаа.

Эрхэм Корлеонегийн зан ааш хэрхэн өөрчлөгдсөнийг Хейген ажиглаж амжжээ. Тэрбээр Люкатай харилцахдаа үлэмж гавьяа байгуулсан харьяат албатаа хүлээн авч буй хаан шиг байсан бөгөөд үг, хөдөлгөөн нэг бүрээрээ хэрхэн үнэлж байгаагаа харуулах боловч харин эрээ цээргүй, дотночлох янз ер алга. Залуу хосод өгөх бэлгийг өөрт нь өгсөнд эрхэм Корлеонегт гайхсангүй, бүгдийг сайн ойлгож байв.

Энэ дугтуй дотор бусдынхаас хамаагүй их мөнгө байгаа нь илэрхий. Люка Брази олон цаг толгой гашилгаж, бусад зочид нь хэдийг өгөх, өөрөө хэдийг илүү өгвөл хайр хүндэтгэл, үнэнч зүтгэлээ Их Эцэгт ойлгуулах тухай сайтар тунгаан бодсон нь эргэлзээгүй. Тийм ч учраас Люка эл дугтуйгаа залуу хосод биш. Загалмайлан эцгийн гарт нь өгөхийг эрмэлзэж, эрхэм Корлеонег ч түүний ийнхүү жаахан дураараа аашилсныг нь уучлахаар барахгүй, уран гоё сүржин үгээр хариу талархал илэрхийлжээ. Люка Бразигийн догшин царайны зэрлэг багны цаанаас сэтгэл ханасан инээмсэглэлийн сүүмгэр дүрс хэрхэн тодрохыг Хейген сонирхон харж зогссоноо шилэн хаалга онгойлгож өгвөөс Люка Брази Их Эцгийн гарыг үнсээд гарч одлоо. Угийн хашир. холын бодолтой хүний хувьд Загалмайлан эцгийн зөвлөх энэ аймаар хүнтэй инээмсэглэн салах ёс хийж, цаадах нь ч гэсэн хаалга хаахдаа эрзээнэн уруулаараа жуумалзмар аядав.

Эрхэм Корлеонег ганцхан Люка Бразигийн дэргэд л сэтгэл тавгүй байдаг тул түүний гарсан хойно л сая нэг юм дотор нь уужирчээ. Тэсрэх бодистой адил болгоомжтой харилцахгүй бол тун болдоггүй энэ зэрлэг догшин их хүчийг гүйцэд номхруулсан гэж хэзээ ч бүрэн итгэхийн аргагүй. Гэхдээ хэрэгцээ тохиолдвол тэсрэх бодисын хүчийг ч гэсэн удирдан залж болдог доо...

- Одоо ганц Бонасера үлдээ юу?

Том толгой дохисонд эрхэм Корлеоне бодолхийлснээ хөмсөг зангидав.

Түүнийг оруулахаасаа өмнө Сантиног дууд. Жаахан ч гэсэн юм сурч аваг.

Хейген Сонниг эрээд цэцэрлэгийг бүтэн тойрох замдаа Бонасерад жаахан хүлээ гэж хэлснээ Майкл Корлеоне дээр очиж Сонниг сурагласан чинь тэрээр толгой сэгсэрчээ. «Түрүүнээс хойш Сонни тэр хүүхэнтэй зууралдсаар байна гэж үү? Энэ л дутаж ээ. Энд Соннигийн эхнэр, тэр дэрвэгнүүр хүүхний ч хамаатан садан байгаа болохоор шуугиан дэгдэж магадгүй...» хэмээн бодоод Хейген хагас цагийн өмнө Соннигийн далд орсон хаалга тийш яаран алхлаа.

Томын араас харж байсан Кей:

- Энэ хэн бэ? Чи миний ах гэж надад танилцуулсан. Гэтэл овог нь танайхаас өөр, тэгээд бас итали хүнтэй төсгүй юм - хэмээн Майклаас лавлав.

- Том арван хоёр настайгаасаа хойш манайд байгаа. Эцэг эхээсээ өнчирч, нүдний халдварт өвчин тусаад гудамжинд тэнэж явахад нь Сонни тааралдаж нэг орой дагуулаад ирж билээ. Тэр өдөртөө манайд хоноод орох оронгүй тул эхнэр автлаа манайд үлдчихсэн юм.

- Ямар сонин юм бэ? Гэр дүүрэн хүүхэдтэй байж, хүний хүүхэд үрчилж авдаг, танай эцэг чинь тун сайхан сэтгэлтэй хүн юм аа даа! - хэмээн Кей хөөрөн дуу алдлаа.

Итали гэр бүлийн хувьд дөрвөн хүүхэдтэй байх нь жирийн үзэгдэл болохыг тайлбарлаж нуршсангүй, ганцхан л зүйлийг тодруулав.

- Томыг үрчилж аваагүй, зүгээр л манайд байсан юм. ,

- Яагаад?

- Үрчилж авсан бол Том овгоо солиход хүрч, энэ нь эцэг эхээ хүндэтгээгүй хэрэг болно гэж аав үзсэн хэрэг.

- Өө, тийм үү? —гэхээс өөр юм Кей хэлж чадсангүй.

Тэр хоёрыг харсаар байтал Том Сонниг дагуулан Их Эцгийн ажлын өрөөний шилэн хаалгаар орох зуураа Америго Бонасераг урин дохьсонд цаадах нь араас нь яаран дагав.

- Эд нар очиж ийм өдөр ажил төрлийн хэргээр аав дээр чинь орж яаж зүрхэлнэ вэ? - хэмээн Кей эгдүүцсэнд Майкл:

- Эд чинь ёс заншлаа сайн мэддэг улс. Ямар ч сицили хүн охиныхоо хуримын өдөр хэн нэгний гуйсан зүйлийг татгалзаж чадахгүй. Ийм боломжийг алдах тэнэг хүн олдох уу даа? гээд тачигнатал хөхөрчээ...

...Люси Манчини ягаан палаажныхаа хормойг өргөн, шатаар гүйхээрээ гарч, уусан архиндаа минчийн улайсан Соннигийн царайг хараад айхгүй ч гэсэн аягүй болжээ. Гэвч тэр өөрөө өнгөрсөн долоо хоногийн турш түүнийг элдвээр өдөж урин дуудсан хойно доо одоо яая

гэхэв?! үүнээс өмнө Люси хоёр ч хүнтэй энгэр зөрүүлж үзсэн боловч дур хүслийг нь хангаж чадсангүй. Сүүлчийн нууц амраг нь түүнийг ханаж цадахаа мэдэхгүй хоосон торх шиг амьтан гэж хүртэл зэмлэсэн болохоор коллежоо төгстөл янаг амрагийн болзооноос зайлсхийх болсон байна.

Гэвч энэхүү Сонни Корлеонегийн эр хүний хүчин чадал, хөнжлийн урлагийн талаар энэ зун үлгэр домог шиг юм сонсоод сэтгэл нь их хөдөлжээ. Нэгэн удаа Коннигийн хуримд бэлдэн эрхэм Корлеонегийн гал зууханд ногоо цэвэрлэж байхдаа Соннитиногийн эхнэр Сандрагийн сэтгэлээ уудлахыг сонссон аж. Гэнэн цайлган Сандра Соннигийн өвөрт орно гэхээс толгойтой үс нь өрвийх тул найз бүсгүйтэй болох тоолонд нь сүмд очиж буян үйлдэх болсноо ярихад бусад хүүхнүүд жуумалзан инээж, харин Люсигийн дур хүсэл нь оргилоод явчихжээ.

Эдүгээ, Сонни руу яарахдаа хамаг цус нь хөөрөн тэсч ядсаар шатны оройд харайн гарч, түүний дагуулж орсон унтлагын өрөөний хаалга хаагдмагц бүх бие нь сулран өвдөг нь нугарах шахлаа. Удсан ч үгүй тамхины бохиор хачир нэмсэн Соннигийн уруул тэмтэрсээр яваад түүний уруулыг хаман авав.

Тэдний хавьталт санаанд ч ороогүй жаргалыг авчирч өдрийн бодол, шөнийн зүүдэнд ч багтаагүйгээр цэнгэлийн далайд умбасан тул Люси байж ядахдаа бараг л чарлан уйлах дөхжээ. Тэрээр юутай ч зүйрлэшгүй таатай шаналгааг анх удаа амсуулж, дур хуялыг нь бүрэн тайлсан Соннид хязгааргүй талархах ажээ.

Энэ бүхний эцэст Люсигийн хамаг бие тавиран хөдлөх ч тэнхэлгүй амьтан Сонниг түшин нилээд удаан зогстол хаалга болгоомжтой тогшив. Сонни хүн оруулахгүйн тулд хаалга налан хувцас хунараа янзлах хооронд Люси салганасан гараараа палаажныхаа хормойг буулгахад хоёр нүд нь оч гэрэлтэн гялалзаж харагдана.

- Сонни, чи энд байна уу? - гэх Хейгений намуухан дуу сонсогдсонд Сонни санаа амран Люси өөд харж инээмсэглэв.

- Тийм ээ, Том оо. Юу болоо вэ?

- Их Эцэг чамайг одоохон хүрээд ир гэсэн.

Түүний хөлийн чимээ хонгилоор холдсон хойно Сонни Люсиг тэвэрч үнсээд хаалгаар шурган гарлаа.

Люси үсээ самнаж, хувцсаа янзлаад цэцэрлэгт гарч очоод Коннигийн дэргэд суутал цаадах нь илт гомдсон байртай:

- Люси чи хаачив аа? Архи уучихсан юм уу даа? Дахин бүү алга болоорой, за юу?

Люси дув дуугүй хундагаа сарвайж, Коннигийн нөхөр учрыг ойлгон жуумалзангаа өтгөн хүрэн дарс хальтал нь аягалав. Дагжтлаа чичирч суусан Люси хундагатайгаа нэгмөсөн хөнтөрч орхилоо. Одоо түүний хувьд хорвоо дээр Сонни Корлеонегээс өөр хүн хэрэггүй болсон тул түүнийг хайсан боловч хаа ч алга. Тэрбээр Люси бэр хүүхний чих рүү тонгойн:

- Хоёр гурван цагийн дараа чи өөрөө амсаж мэднэ ээ, гайгүй - хэмээн шивнэвэл Конни аальгүйтэн инээвхийлэв.

Люси сурагч охин шиг ширээн дээр гар зөрүүлэн суух нь хуримлаж буй найз бүсгүйнхээ хамаг эрдэнэсийг хулгайлсан мэт харагдах ажгуу...

Америго Бонасера Томын араас дагаж ороход Их Эцэг мангар том ширээний ард сууж, Сонни цонхны дэргэд цэцэрлэг рүү харан зогсоно. Энэ өглөөнөөс хойш эрхэм Корлеоне анх удаагаа хүйтэн царайлж, зочноо тэвэрч угтсан ч үгүй, гар барьж уулзсан ч үгүй. Чин үнэнээр хэлэхэд энэ авчин эрийн эхнэр нь Вито Корлеонегийн авгайн найз нь байгаагүй бол түүнийг урих нь юу л бол. Тэгээд ч Америгог эрхэм Корлеоне тийм ч их таалдаг бус.

Бонасера үгээ цэнэн байж, нэлээд холоос яриагаа эхлэв.

- Танай эхнэрийн загалмай зүүлгэж өгсөн охин минь энэ хурим дээр ирээгүйг уучлаарай. Одоо хүртэл эмнэлэгт байгаа нь түүний буруу биш шүү дээ - гээд тэрээр эрхэм Корлеонетой ганцаараа уулзах хүслээ илэрхийлэн Сонни, Том Хейген хоёр уруу зовингуйрсан нүдээр харсан боловч Загалмайлан эцэг түүнийг ер өрөвдсөнгүй.

- Танай охинд тохиолдсон гай зовлонгийн тухай би сонссон, чадах л бол тус хүргэхэд бэлэн байна. Ямар ч гэсэн эхнэр маань түүнд загалмай зүүж өгсөн болохоор бидэнд үзүүлсэн хүндэтгэлийг мартаж учиргүйсэн. Энэ хахир үгээрээ эрхэм Корлеоне өөрийг нь хэзээ ч Загалмайлан эцэг гэж дууддаггүй эл авчинг далдуур зэмлэсэн өнгө аяс илэрхий.

Дотор нь палхийн үхээнц царайлан Бонасера үүнийг анзаарах сөхөөгүй шууд л:

- Би тантай дангаараа ярилцаж болохсон болов уу? гэвэл эрхэм Корлеоне толгой сэгсэрчээ.

- Аль алийг нь баруун гараа гэж үздэг энэ хоёр хүнд би амь насаа итгэж даатгасан болохоор хөөж доромжлохыг хүсэхгүй, чадах ч үгүй.

Авчин эр нүдээ түр аниад, таалал төгссөн хүмүүсийн садан төрлийг албан өрөөндөө тайтгаруулдаг жигдхэн, гунигтай хоолойгоор ярьж гарав.

Би охиноо Америкт өсгөж хүмүүжүүлсэн, өөрөө ч энд хүний зэрэгтэй болсон тул америк маягийн амьдралыг хүндэтгэдэг. Би өөрийн хүсэл зоригийг охиндоо тулгаагүй боловч гэр бүлийнхээ нэр төрийг эрхэмлэх үзлээр хүмүүжүүлсэн. Тэр өөрөө найзаа сонгож аваад тэр нь итали биш залуу байсан ч би арга буюу эвлэрсэн. Тэд гадуур зугаалж, кино ший үзээд оройтохоос гадна надтай уулзуулж танилцуулаагүй ч гэсэн би тэдний хэрэгт оролцохыг хүсээгүй. Энд л би буруутсанаа хожим ойлгосон. Хоёр сарын өмнө тэр залуу нэг найзынхаа хамт охиныг минь зугаалахаар дагуулж яваад архиар шахаж, сүүлд нь хүчиндэхээр завджээ.

Охин минь эсэргүүцээд болж өгсөнгүйд тэр хоёр зодож бэртээжээ. Эмнэлэг дээр очиж уулзахад түүний нүд харагдахаа болиод, хамрын яс нь цөмөрч, эрүү нь хугарсан байлаа. Тэрээр өвчин шаналгаа ч үл тоон цорхиртол уйлж: «Аав аа, яалаа гэж энэ вэ? Ямар учраас намайг ингэв ээ?» хэмээн үглэж билээ. Би ч тэссэнгүй дагаад нулимс бөмбөрүүлэв. Намайг яагаад уйлсан бэ гэж гайхаж байна уу? Тэрээр хоёр нүдний минь баяр баясгалан, эелдэг, ааштай, халамжтай, гэнэн итгэмтгий охинсон. Харин одоо хэнд ч итгэхээ болиод үүрд эрэмдэг боллоо доо.

Бонасерагийн царай минчийн хүрэгтээд арай л гэж биеэ барьж буй бололтой.

- Би хуульд заасны дагуу цагдаагийн газарт мэдэгдэж, тэр хоёрыг баривчлан шүүхэд шилжүүлсэн боловч шүүх тэдний гэм бурууг, хүлээн зөвшөөрсөн хэрнээ ердөө л гурван жилийн тэнсэн ял өгөөд, тэр хоёр намайг улаан цайм доромжилсоор шүүх хурлын танхимаас шууд гараад явчихсан. Тэгээд л би эхнэртээ: «Шударга ёс гэж байдаг л бол эрхэм Корлеоне дээр очих хэрэгтэй» гэж хэлсэн дээ.

Их Эцэг энэ хүнд учирсан гай зовлонг нь хүндэтгэн тэргүүнээ өндийлгөлгүй сонсож байснаа харин ам нээхэд нь хөндий хүйтэн аяс илэрхий.

- Та над дээр шууд ирэхгүй, яагаад цагдаагийн газар очсон юм бэ.

Бонасера дуудахтай үгүйтэй шивнэн:

- Үүний төлөө би яах ёстой вэ? Миний гуйсныг биелүүлээд л өгвөл би яахаас ч буцахгүй - гэх нь үнэхээр цөхрөнгөө барсан шинжтэй.

- Та чухам юу гуйсан юм бэ?

Бонасера ахиад л Хейген, Сонни хоёрыг хяламхийн толгой сэгсэрсэнд Их Эцэг суудлаасаа өндийлгүй урагш тонгойж, авсчин ч гэсэн бөхийн үсэрхэг чихэнд нь уруулаа наав.

Загалмайлан эцэг нүглээ наманчлах чин сэтгэлийн үг сонсон суугаа лам шиг хэнэггүй царайлан нэлээд удаан сонсож байснаа Бонасераг яриагаа дуусгасан хойно түүнийг цоо ширтсэн боловч түүний царай жаахан улайснаас биш харц буруулсангүй.

- Ингэж таарахгүй. Та бололцоогүй юм хүсээд байна.

- Би гар татахгүй. Хөлсөнд нь хэдийг ч төлсөн би бэлэн гэх Бонасерагийн дуу тод дуулдсанд Хейген давхийн цочиж, түрүүнээс хойш элгээ тэврэн цонхоор харж зогссон Сонни анх удаа эргэн харахдаа ёжтой зэвүүн инээмсэглэв.

Эрхэм Корлеоне ширээний араас өндийхөд нүүр царай нь ер өөрчлөгдөөгүй боловч мөс шиг хүйтэн хоолой нь төмөр хавирах шиг хахир сонсогдлоо.

Бид танилцаад олон жил болж байгаа боловч та одоо хүртэл юм гуйж, эсвэл зөвлөгөө авч явсангүй. Эхнэр маань охинд чинь загалмай зүүж өгсөн хэдий ч сүүлийн удаа би хэдийд танайхаар орж аяга цай ууснаа санахгүй байна. Шуудхан хэлэхэд та миний үерхэлийг үл

тоомсорлосон. Эсвэл надад өртэй хоцрохоос айсан хэрэг үү?

- Өөрийн толгой дээр лай хураахаас айсандаа л тэр.

- Үгүй ээ, хэргийн учир үүнд биш. Та Америкийг хуурай газрын диваажинд тооцож, хэрэг ажил урагштай, хэдэн мөнгө халаасанд орж л байвал амар жимэр суугаад байж болох амгалан газар гэж бодсон учир найдвартай анд найз нартай болохыг хүсээгүй. Цагдаагийн газар, шүүх, хуулиар эрх ашгаа хамгаалуулсан хүнд найз нар байгаад ч яах юм билээ. Вито Корлеоне ч ямар хэрэг байх вэ? За яахав, надад эвгүй л байсан. Гэвч үерхэл, сайн харилцааг минь үнэлдэггүй хүнтэй би хүчээр зууралдаад байдаггүй хүн. - Их Эцэг сайхь эр рүү доогтой жуумалзаж харав. - Гэтэл одоо та зөрчигдсөн эрх ашгаа хамгаалуулахаар над дээр ирж. Тэгэхдээ бас зохих ёсоор хүндэтгэл үзүүлэхийн оронд хэдэрлэж байдаг. Та надтай үерхэж найзлая гэсэнгүй. Харин ч миний охины хуримын өдөр хүн алж өгөөч хэмээн гуйж ирэхдээ бас болоогүй, «Хөлсөнд нь хэдийг ч төлөхөд би бэлэн» гэдэг байна шүү! үгүй ээ, би гомдоогүй. Гэвч ингэж доромжлуулахаар би ямар гэм хийсэн юм бэ?

Бонасера айн зовж, шаналж гүйцээд арга ядахдаа:

- Америк намайг алга тосон угтсан болохоор би шударга иргэн нь байхыг хичээсэн. Охиноо ч гэсэн Америкт үнэнч байлгахыг хүссэн хэмээн хашгиран алдваас Их Эцэг халуунаар дэмжсэн хүн болж алгаа халуу оргитол ташиж гарлаа.

- Тун гайхамшигтай мэргэн үг байна. Тийм л юм бол санаа зовох юу байхав? Шүүх хурал болж, шударга ёс ялан дийлсэн юм чинь та эмнэлэг дээр очиж цэцэг чихрээр охиноо тайтгаруулан, харин ч гайгүй өнгөрчээ гэсэн бодлоор «сэтгэлээ зогоох л үлджээ. Тэр хоёр нас залуу, цус шингэн улс, жаахан хөлчүүрхээд л тэр биз. Тэгээд ч бас нэг нь улс төрийн нэрт зүтгэлтний хүү. Үгүй ээ, Америго та хэзээ ямагт үнэнч явсан болохоор түүгээрээ л дуусах хэрэгтэй. Учир иймд өшөө хонзонгийн тухай солиотой бодлоо тас март. Америкт ингэдэггүй юм. Алаг эрээн хорвоо дээр аль бүдрэхийг тэр гэх вэ? Намайг уучлаарай, надад хэлснээ мартсан нь дээр!

Их Эцгийн энэ ёжтой, хорон үгэнд арай хийн барьж тогтоох уур хилэн илт цухалдах тул хөөрхий авсчин хамаг бие нь салганан хүйтэн хөлс нь цувах хэдий ч бас л бууж өгөхгүй санаатай аж.

- Үнэн шударгаар шүүн таслахыг би танаас хүсч ирсэн билээ.

- Та нэгэнт хожимджээ. Шударга ёс сахиулах ажиллагаа шүүх хурал дээр болоод өнгөрсөн.

Бонасера бас л өөрийнхөөрөө зүтгэн толгой сэгсрэв.

- Надад биш тэр хүүхдүүдэд л талтай шүүх хурал болсон.

Ийм ялгаа яах аргагүй зөв гэдгийг эрхэм Корлеоне хүлээн зөвшөөрлөө.

- Чи тэгээд юу хүсээ вэ?

- Цусыг цусаар, амийг амиар...

- Охин чинь амьд үлдсэн атал чи арай ихийг хүсч байна.

- За яахав, тэгвэл тэр хоёр яг миний охин шиг зовж тарчлаг хэмээн Бонасера дуртай дургүй зөвшөөрөв.

Их Эцэг өөр юу хэлэхийг нь хүлээгээд байсан тул Бонасера эр зоригийнхоо эцсийг шавхан, цөхрөнгөө барсан дуугаар:

- Би хичнээнийг төлөх вэ? гэж орхилоо.

Эрхэм Корлеоне үг ч дуугарсангүй, яриа дууссаны тэмдэг болгон цааш харсан авч Бонасера ***** гадас мэт... ер хөдөлж өгсөнгүйд Их Эцэг анд найз нартаа удаан уурлаж чаддаггүй хүн болж санаа алдан эргэж харвал хөөрхий авсчин эцсийн замд нь үдэж сурсан талийгаач нараасаа ч долоон дор хувхай цайчихсан зогсож байсанд дуу нь арай зөөлрөв.

- Хамгийн түрүүнд над дээр ирж тусламж гуйхаасаа та яагаад айсан юм бэ? Түүний оронд та шүүх дээр очиж хоёр гурван сараар хүлээгээд л, тэртэй тэргүй хэрэг бүтэхгүйг урьдаас мэддэг өмгөөлөгчид мөнгө төлөхөөр үл барам, шалиг эм шиг худалч шүүгчээр хэргээ шийдүүлж байх ч гэж дээ. Бас тэгээд энэ бүх хугацаанд та хөрөнгө чинээ, хөлс төлөх чадварыг тань мэдэх гэсэндээ тавагтай хоол уруу чинь өнгөлзөн, цоожны нүхээр шагайдаг банк дээр очиж зээл горьдон гар тосоор өдийг хүрсэн бус уу? Гэтэл анх түрүүлэн над дээр л ирж уулзсан бол түрийвчтэй мөнгөө дуртайяа дэлгээд барихсан. Шударга ёсыг би сахиулсан бол тэр хоёр шаар өдийд тамын ёроолд унадаггүй юмаа гэхэд, гашуун нулимсаа урсгаж байхсан. Түүгээр ч үл барам, өштөн дайсан гэж байдаг бол миний гарт аль хэдийнээ өртөөд, таныг хармагц дагжин чичирч явахсан.

Бонасера толгой унжуулан үхээнц дуугаар үгүүлрүүн:

- Таны болзлыг хүлээн авъя. Та миний анд болооч!

- За тийм болог. Хэрэв хэрэгцээ гарвал, хэзээ нэгэн цагт шаардлага гарвал шүү, надад хариу тус хүргээрэй. Харин одоо миний шударга цээрлэл тэр хоёр залуугийн толгой дээр бууна. Үүнийг охинд чинь загалмай зүүлгэсэн миний эхнэрийн бэлэг гэж бод.

Баярлаж талархсанаа үглэсээр Бонасераг хаалга хаасан хойно эрхэм Корлеоне зөвлөхдөө захирамж өглөө.

Том оо, энэ ажлыг Клеменцод даалгаад, арай цус үзээд улайрчихааргүй найдвартай залуус явуул гэж хэлээрэй. Бидний тухай энэ мулгуу авсчин юу ч гэж бодож байлаа гэсэн, лав л алуурчид биш юм даг.

Ууган хүү нь энэ завсар цонхоор хуримын цэнгээнийг харсан хэвээр зогсохыг ажсан Их Эцэг дотроо: «Сантино миний арга барилаас сурч туршлага суухыг хүсэхгүй байна. Тэгэхлээр энэ хэзээ ч нам толгойлж, Их Эцэг болж чадахгүй. Эцсийн эцэст хорвоо дээр хэн ч мөнх бус

учраас одоохон, нэн даруй өөр хүнийг эрж олох хэрэгтэй» хэмээн бодож бөлгөө.

Цонхны цаана гэнэт баярлан хашгиралдах чимээ сонсогдож, Сонни нөгөө хоёроосоо түрүүлэн үүд рүү харайлгах зуураа:

- Жонни хүрээд ирж! Ямар ч гэсэн түүнийг энэ хуриманд ирнэ гэж би эс хэллүү?» - гээд гарч одсонд Хейген ч гэсэн цонхоор харлаа.

- Нээрээ таны загалмайлсан хүү байна. Дуудах уу?

- Хэрэггүй, эхлээд зочидтой уулзаг. Тэр сайн хүү, өөрөө над дээр ирнэ гээд Их Эцэг инээмсэглэхэд Том Хейгенд жаахан хардах сэтгэл төрөв.

- Хоёр жил үзэгдээгүй юмсан. Нэг л юм болоод таны тусламж хэрэг болж дээ!

- Загалмай зүүлгэсэн эцэгтээ ирэхгүй өөр хэн дээр очих юм бэ?

Конни Корлеоне цэцэрлэг рүү орж яваа Жонни Фонтейныг бусдаас түрүүлэн олж харсан учир хуримлаж суугаа сүйт хүүхний намба төрхөө ч умартан; «Жонни!» хэмээн чарлаад өөдөөс нь хоёр гараа алдлан харайлгажээ.

Жонни түүнийг чанга тэврэн үнсч, солгой гараараа түүнийг тэвэрсэн хэвээрээ бусад зочидтой ээлж дараагаар гар барьж мэндлэв. Түүнийг тойрон бүчсэн бүх хүмүүс вест-сайдын гудамжинд хамт тоглож өссөн хуучны найз нар нь байлаа. Конни түүний гараас чирсээр нөхөртэйгөө аваачиж танилцуулсанд цайвар үстэй хүргэн хүү өнөөдрийн гол хүн биш болж халхлагдсандаа гоморхсон юм уу тун инээдтэй харагдсан учир голливудын киноны од хүн уяруулах хамаг урлаг чадвараа дайчлан байж тэр залуугийн гарыг чанга атган, эрүүл энх сайн сайхныг хүсэн ерөөхөөс өөр аргагүй болжээ.

Эстрадын модон тавцан дээрээс танил дуу сонсогдлоо.

- Жонни, хоёулаа нэг ая баривал яасан юм бэ?

Жонни эргэн хартал Нино Валенти инээмсэглэн зогсож байсанд даруй тайзан дээр үсрэн гарч Ниног тэвэрч авав. Дээхэн үед хагацаж салшгүй хоёр найз хамтдаа дуулж, хамтдаа хүүхнүүдтэй зугаалж явсан бөгөөд харин хожим нь Жонни радиогоор дуулж, дараа нь кинонд тоглохоор голливуд яваад, Нино эндээ үлдсэн юмсанж. Эхэндээ тэрбээр Нинод утасдан, эсэн бусын юм ярьдаг, тэр ч бүү хэл тэндхийн клубт түүний концертыг тоглуулахаар амласан боловч энэ нь хоосон ярианаас хэтэрсэнгүй. Харин одоо Ниногийн танил инээмсэглэл, жаахан хөлчүү сэргэлэн цовоо царайг нь хараад найздаа урьдын адил хайртайгаа мэдэрчээ.

Нино мандолины утсан дээгүүр хуруу гүйлгэн, Жонни мөрөн дээр нь гараа тавьж:

- Бэр хүүхэнд зориулья гээд хоёр хөлөө ээлжлэн товшсоор хайр дурлалын тухай сицили дууны шалиг үгсийг уянгалуулж гарлаа.

Нино найзынхаа дуулах үгийг хэнд ч ойлгомжтой хөдөлгөөнөөр давган дагах тул бэр хүүхэн

царай улайж ичингүйрэвч бөөн баяр хөөр болов. Зочид нь ч гэсэн шад бүрийн сүүлчийн хоёр мөрийг нийтээр түрэн хөлөө дэвсэлж хөхрөлдөн баясаж байснаа Жонни нэг дуу дуусган хоолой засаад өөр дуу эхэлтэл алга нижгэнүүлэн ташна.

Хуран цугларсан хүмүүс бүгд түүгээр бахархах ажээ. Жонни тэдний л адил эгэл нэгэн атлаа нэртэй дуучин, киноны од болон алдраа мандуулж, хамгийн гоо үзэсгэлэнт хүүхнүүдийн шүтээн болжээ. Гэсэн хэдий боловч загалмайласан эцэгтээ хүндэтгэл үзүүлэн, охиных нь хуриманд оролцохоор гурван мянган бээрийн зай туулж, Нино Валенти мэтийн эртний найз нартайгаа хөгжилдөн байгаа нь биеэ тоогоогүйн илрэл биш гэж үү? Тэр нэгэн цагт Жонни Ниногийн хамт дуугаа дуулж явсныг бүгд санах боловч гагцхүү Жонни л тавин сая бүсгүйчүүдийн зүрх сэтгэлийг эзэмдэх юм гэж хэн бодлоо?!

Жонни дуугаа дуулсаар тайзнаас үсрэн бууж, бэр хүүхнийг өргөн буцаж гараад дундаа тавьснаа Нино тэр хоёр залуу зандан цагтаа наадаж явсанчлан сэлмээр тулалдах мэт хоолойгоороо халз өрсөлдөж гарав. Тэр хоёр дууны бадгийг ээлжлэн аялсаар Жонни алдарт хоолойгоо Ниногийн дуунд даруулж, түүнийг эцсийн шад дуусахад ялагдлаа хүлээх мэт таг чимээгүй болов. Тайзан дээрх гурвыг эелдгээр тэврэлдэх хооронд үзэгчид хөөрөн хашгирч, шалгаа хорстол ташин өөр дуу дуулахыг шаардана.

Энэ бүх хугацаанд хажуу хаалган дээр зогссон Вито Корлеоне л бүх юм тийм ч бүтэмжтэй биш байгааг ганцаараа ажиглаад хэнийг ч гомдоохгүйг хичээн эелдэг дуугаар үгүүлрүүн:

- Загалмай зүүлгэсэн хүү минь тийм холоос хүрэлцэн ирж биднийгээ гийгүүлж байхад та нарын хэн нь ч хоолой норгох юм өгөхөө санасангүй юу?

Тэрхэн зуур олон хүн Жоннид аягатай дарс сарвайж, тэрбээр бүгдээс нь балгаж талархаад эрхэм Корлеоне тийш яарлаа. Жонни түүний хацарт нүүрээ наан нэг юм шивнэсэнд цаадах нь гэр рүүгээ дагуулан одов.

Ажлын өрөөнд ороход нь Том Хейген гар алдлан угтлаа.

- Сонин юу байна, Том? гэх Жоннигийн дуунд хүний сэтгэл булаах гол увидас нь болсон эелдэг дотно өнгө ер сонсогдсонгүй. Жоннигийн ийм хайнга хөндий харилцаанд Хейген жаахан эгдүүцсэн боловч Их Эцгийн зөвлөгчийн хувьд янз бүрийн хүмүүстэй сайдах, муудах нь ердийн үзэгдэл тул нэг ч их гомдсонгүй.

Жонни Фонтейн загалмайласан эцэгтээ хандан ийн үгүүлэв:

- Хуримын урилга авмагц, та нарын уурласан уурлаагүй очих хэрэгтэй гэж шийдсэн дээ. Эхнэрээсээ салснаас хойш би таван удаа утасдсан чинь Том дандаа л таныг завгүй юм уу эзгүй гээд булзааруулаад айхаар нь миний тухай сонсохыг ч хүсэхгүй байгааг тань ойлгосон.

Эрхэм Корлеоне алтан шаргал «Стрега» архи хундагалав

- «Хуучнаа дурссан хүний хохь нь болдог» гэж нэг үг бий. Одоо бүгдийг мартсаан, Жонни. Харин одоо мөнгөтэй ч, алдар цуутай ч болсон чамд би хэрэг болох эсэхээ л сайн мэдэхгүй

байна.

Жонни хоолой зүсэм хатуу архи нэгмөсөн хөнтөрч орхиод хоосон хундагаа дахин сарвайлаа.

- Загалмайлсан эцэг минь, та юу ярина вэ? Юун хөрөнгө, юун нэр алдар вэ? Би улам бүр дордсоор л явна. Тэр нэг завхай эмээс болж эхнэр хүүхдээ орхих хэрэггүй гэж та яах аргагүй зөв хэлж байжээ. Таны уурласан чинь ч дэмий юм биш байж.

Их Эцэг мөрөө хавчин

Чи миний загалмай зүүлгэсэн хүү болохоор би санаа зовсондоо л тэр шүү дээ.

Жонни сандарч өрөөн дотуур холхин гарлаа.

- Би тэр муу хүүхнээс болж ёстой солиорох дөхлөө. Голливудын хамгийн сод од нь үнэн боловч яаж аашилдаг гэж санана, хэлэх ч муу үг олдохгүй юм. Нүүр засалч сэтгэлд нь таартал гоёж гоодоод өгвөл өвөрт нь орж хэвтээд, оператор оновчтой газраас зургийг нь авчихвал өрөө рүү нь дагаад гүйхэд бэлэн, ер нь буруу дуулахгүй бол үгүй гэдэггүй хүүхэн. Түүний энгэрээ нээж өгөх нь миний бутархай мөнгө халааснаасаа гаргахаас ч амархан шүү. Тэр янхны дэргэд чөтгөр шулам л тогтох байх.

Эрхэм Корлеоне түүний үгийг шууд таслав.

- Гэрийнхэн чинь сайн уу?

- Би тэдний талаар чадлаараа л санаа тавих юм. Би гэрлэлтээ цуцлуулснаас хойш эхнэр хүүхдэдээ шүүхээр тогтоосноос илүү мөнгө төлж, долоо хоногт нэг, заримдаа хэд хэд очиж байгаа. Тэднийг санана гэж жигтэйхэн. Гэтэл Марго шоолоод яагаад хардаад байгааг минь ойлгохгүй, намайг дуулдаг дуу, итали маягийн хуялынхаа хамт хоцрогдсон гэж дөвчигнөхөөр нь сая наашаа гарахаасаа өмнө нүүрнээс нь бусад газар хөх няц болтол нүдчихээд ирсэн. Тэр ер тоосон шинжгүй, инээж хөхрөөд л байх юм хэмээн Жонни санаа алдаад янжуур асаалаа.

- Загалмайлсан эцэг минь. Амьдрал минь ингээд л ямар ч утга учиргүй болчихсон шиг санагдаад байна.

Эрхэм Корлеоне шууд л улаан нүүрэн дээр нь:

- Энэ талаар чамд хэн ч тусалж чадахгүй гээд хэсэг чимээгүй байснаа: - Хоолой чинь яачихаа вэ? гэтэл олныг бишрүүлсэн Жонни Фонтейны гаднах гялаан, сүржин төрх дорхноо гандан шалчийлаа.

- Хоолой өвдөөд би одоо дуулж чадахаа больсоон. Эмч нар анагааж чадахгүй гэнэ.

Хейген, Вито Корлеоне хоёр Жонни өөд анхааралтай ширтэх нь дэмий юман дээр сандарч тэвдэх хүн ч бишсэн дээ гэх янзтай.

- Миний тоглосон хоёр кино асар их орлоготой байж, би овоо нэрд гарсан. Гэтэл студийн

эзэн бид хоёр анхнаасаа таарамж муутай байсан болохоор өс санахдаа хоолойны минь өвчинг далимдуулаад гудамжинд хөөж гаргасан.

- Та хоёр юу булаацалдсан улс вэ?

- Зүүний хүчний цуглаан дээр дуудсан минь түүнд таалагдаагүй, та ч гэсэн намайг загнадаг байгаагүй юу даа, загалмайлсан эцэг минь! Жек Вольц намайг бүр коммунист гэсэн, гэхдээ түүнд хэн ч итгээгүй л дээ. Дээр нь бас би түүний санаархаж байсан хүүхнийг аваад явчихсан. Нэг л шөнө тэр хүүхэн өөрөө гүйгээд ирсэн юм чинь би яах билээ? Гай газар дороос гэдэг биз дээ? Одоо тэр муу Марго хүртэл намайг гэрээс хөөгөөд болох биш. Жинни, хүүхдүүд минь сунаж мөргөсөөр очихоос нааш намайг хүлээж авахгүй. Мууд муу нэмэр, муухайд улцан нэмэр гэгчээр би дуулж чадахаа больчихлоо. Загалмайлсан эцэг минь, би одоо яах вэ яавал таарах билээ?

Эрхэм Корлеоне түүнийг өчүүхэн ч өрөвдсөн янзгүй зэвүүрхсэн хүйтэн харцаар ширвээд авлаа.

- Юуны өмнө эр хүн шиг байж үз! Жинхэнэ эр хүн шиг шүү! - гэж Их Эцэг араатан шиг архираад, зэрлэгээр энхрийлэн толгойтой үсийг нь базаж татаад: - өршөөлт тэнгэр минь! өчнөөн жил миний хажууд байчхаад өөдгүй хулчгар хэвээрээ үлддэг, чи яасан унхиагүй амьтан бэ? Нулимс дуслуулж, тусламж гуйхаас өөр юм мэдэхгүй голливудын хувцасны гол, энэ лойчихсон эр хаанаас гараад ирэв ээ? Эмс охидоос ч долоон дор: «Одоо яах вэ? Яавал таарах билээ?» гэнэ шүү хэмээн огт санамсаргүй байтал Жонниг яг адилхан дууриан элэглэсэнд Хейген, Жонни хоёр тэсч чадсангүй, инээд алдчихав.

Эрхэм Корлеоне бах нь ханан дуугаа хурааж, загалмай зүүлгэсэн хайртай хүүгээ ширтэн минут хэртэй суухдаа, хэрэв ингэж загнуулсан бол төрсөн хөвгүүд нь яах байсныг эргэцүүлэн бодлоо. Сантино гомдож өширхөөд, дараа нь тэгэхээс тэгэх гэж дөвчигнөх хүн. Майкл бол зэвүүн хүйтнээр жуумалзаад гэртээ ирэлгүй хэдэн жил ч болж мэднэ. Харин Фредо л үнэхээр айж, туулай шиг дагжин чичрэн байх даа. Ай - хөө, загалмайлсан эцгийнхээ үгийг зөв ойлгоод сэтгэл сэргэн үнэн голоосоо хөхөрч суудаг энэ Жонни ямар сайн хүү вэ?

- Эзнийхээ хүүхнийг эргүүлж сээтэгнэчихээд одоо болохоор өөхөн дээр өнхрүүлсэнгүй, гэж түүнд гомдоллох чинь дутаа юу? Ёстой гайхмаар юм! өөрөө завхай хүүхнээс болж эхнэр, хүүхдээ хаяж өнчрүүлсэн мөртлөө араар тавиулсан эр хүн ад үзлээ гэж уйлагнах хэрэг байна уу? Бас кинонд тоглодог л юм гээд хүүхнийхээ нүүр лүү цохиж зүрхлэхгүй байж дооглож инээсэнд нь дургүйлхэж явдаг чам шиг маанаг эрийн үйл нь хүртэл хазайхаас ч өөр яах билээ?

Их Эцэг нэг амьсгаа аваад:

- Одоо чи миний зөвлөгөөг дагана биз дээ? - гэвэл Жонни Фонтейн мөрөө хавчив.

- Загалмайлсан эцэг минь ээ, одоо би Жиннитэй дахин суух нь өнгөрсөн шүү дээ! Би хөзөр тоглож, найз нартайгаа архидаж наргидгаас гадна хүүхнүүд өөрсдөө гүйж ирээд наалдчихдаг юм чинь би яаж түүний тавьсан шаардлагыг хүлээж авах юм бэ? Тийм нүгэл үйлдчихээд

Жинни дээр очихдоо яаж гэмшдэг гэж санана. Дахиад би тэгж тамаа цайх хүсэл ч алга, чадал ч алга.

Хэдийгээр биеэ барьж чаддаг ч гэсэн эрхэм Корлеонегийн тэсвэр тэвчээр барагдаж буй төлөвтэй.

- Хэн чамайг дахин гэрлэ гэж албадаа вэ? Өөрөө л мэдэхгүй юу? Хүүхдээ асран тэтгэж байгаа чинь сайн хэрэг. Үр хүүхдүүддээ жинхэнэ эцэг нь болж чадаагүй бол эр хүн биш л дээ. Гэвч нэгэнт л ийм юм болсон бол хүүхдийнхээ эхэд өөрийгөө ойлгуулан атгандаа хийж чадах хэрэгтэй. Тэдэнтэй чи яагаад нэг гэрт байж, өөрийн дураар амьдарч болдоггүй билээ?

- Яалаа гэж дээ, эцэг минь. Хуучны итали эхнэрүүд одоо хаанаас олдов гэж? Жинни үүнтэй яасан ч эвлэрэхгүй.

- Чи өөрөө нусгай жаал шиг хулчгар болоод л тэр. Нэг авгайд хэмжээнээс хэтэрсэн мөнгө төлөөд нөгөөхийг нь болохоор кинонд тоглодог юм гээд нүүр рүү нь дэлсэхээс айгаад байхаар чинь тэд чамайг дарангуйлан захирахгүй яах юм бэ? Гэтэл эмэгтэй хүний үс нь урт ч, ухаан богино гэдэг биз дээ! Хойт насандаа тэд диваажинд очиж, бид тамд унах ч байж магадгүй. Тэглээ гээд өөрчлөгдөх юмгүй, бид л тэднийг захирах ёстой. Ер нь би энэ хэдэн жилийн турш чамайг хараа салгалгүй ажлаа. Чи үлгэр жишээ сайн хүү байсан, намайг үнэхээр хүндэлдэг чинь үнэн. Гэвч бусад андынхаа хувьд чи нэг ойртож, нэг хөндийрөөд тун туйлбаргүй, ханддаг. Инээдмийн дүрд тоглодог байсан нэг итали залууг чи санаж байна уу? Яагаад ч юм, тэрээр нэг л удаа бүдрэхэд нь чи амжилтын туйлдаа хүрч явсан болоод шууд л холбоогоо тасалсан. Багын найз Нино чинь байна. Аз нь дутсандаа гутраад тэрээр архи их уудаг ч гэсэн хэнд ч гомдол мэдүүлдэггүй, чамайг нэг ч муулдаггүй. Ачааны машинаар элс хайрга зөөгөөд, хажуугаар нь бас хэд гурван юм олох санаатай дуу дуулаад л явж байна. Тэр сайн дуулдаг юм чинь чи түүнд тусалж чадахгүй гэж үү? Ганц сайн найз чинь шүү дээ?!

Жонни Фонтейн тэвчээр заан хүлцэнгүй зан гаргана.

- Тэр муугүй дуулдаг боловч авьяасаар дульхан, загалмайлсан эцэг минь. Шоу тоглолтод тэнцэхгүй шүү дээ.

Эрхэм Корлеоне нүдээ бараг далд ортол зовхио буулган духаа үрчийлгэх нь их л дургүйцсэний шинж болов уу.

- Чи ч гэсэн барахгүй л болоод байгаа юм биш үү, хүү минь? Эсвэл чамд ч гэсэн авьяас дутаад байна уу? Чи ер нь Нинотой нэг машин дээр хамт ажиллавал яасан юм бэ?

Жонни үг дуугарсангүйд Их Эцэг цааш үргэлжлүүлэн ийн үгүүлрүүн:

- Анд найз нар юунаас ч эрхэм, үерхэл ямар ч авьяасаас чухал, үүнийг юутай ч зүйрлэх аргагүй шүү. Тэд гэр бүлийн гишүүдтэй л адилхан дотно хүмүүс гэдгийг хэзээ ч бүү март. Чи анд найз нараараа бат хүрээлүүлж чадсан бол өнөөдөр тусламж гуйгаад над дээр гүйж ирэхгүйсэн. За одоо чухам яагаад дуулж чадахгүй болсноо хүн ойлгохоор тайлбарлаад аль. Чи дөнгөж сая, энэ цэцэрлэгт тун дажгүй, Ниногоос нэг ч их дутахааргүй дуулсан шүү дээ.

Өмдөндөө шээс алдчихмаар энэ хорон үгийг сонсоод Хейген: Жонни хоёулаа жуумалзан инээмсэглэж, энэ удаад Жонни өөрөө тэвчээр гарган тайлбарлах хэрэгтэй болов.

- Миний хоолой муудаад, хоёр гурван дуу дуулчихвал хэдэн цагаар, аягүй бол хэдэн өдрөөр таг болчих юм. Дасгал сургууль, дуу бичлэгээ дуусгаж чадалгүй хоолой сөөгөөд нэг л биш,

- Аа мэд, тэгвэл эхнэр хүүхнүүдтэй эв түнжин тасраад, бас хажуугаар нь хоолой чинь болохоо байгаа шив? За тэр Голливудын монцгор эрхэмтэй яагаад таарахаа байснаа ярь даа. Хаана, яагаад чамайг ажиллуулахгүй гээд байгаа юм бэ?

Загалмайлсан эцэг энэ хүртэл тоглоом тохуу хийж байснаа одоо л ажил хэргийн асуудалдаа шилжиж байгаа нь энэ.

- Тэр чинь кино үйлдвэрийн эзэн, цэрэг дайныг киногоор сурталчлах асуудал хариуцсан ерөнхийлөгчийн зөвлөх, үнэхээр том хүн шүү. Энэ жил хамгийн их шуугиан дэгдээсэн романаар кино хийх эрхийг тэрбээр ердөө сарын өмнө худалдаж авсан. Тэр номыг олон дахин хэвлээд, хэвлээд олдохгүй байгаа юм. Гол баатар нь яг л надаас үлгэр авсан мэт, надад жүжиглэх ч хэрэг алга, байдгаараа л байхад хангалттай. Бараг дуулахын ч хэрэггүй. Тэгвэл Академийн шагналыг авч ч юу магад. Энэ дүрд намайг яг тохирно, тэгвэл би дахиад сэхээд ирнэ гэдгийг бүгд мэдсээр атал тэр адгийн новш Вольц хонзон санаад намайг тоглуулахгүй байна. Би бүр хамгийн бага хөлсөөр, бараг үнэгүй шахуу тоглоё гэж гуйсан чинь ер хөдөлдөггүй шүү. Хэрэв намайг үйлдвэр дээр ирж, олны өмнө хошногыг нь үнсвэл бодож байгаад харж үзэж болох л юм гэх ухааны цуу үг тараасан байна билээ.

Дороо суурьтай дотроо бодолтой хүмүүс ажил хэргийн чанартай саад бэрхшээлийг даван туулах арга хэзээ ч олдог тул эрхэм Корлеоне эл уянгын төгсгөлийг таслан зогсоож, Жоннигийн дал мөрийг аяархан алгадаад авлаа.

- Чи ч бүр санаагаар унаж гүйцээ шив дээ. Бүгд чамаас нүүрээ буруулж, хэнд ч хэрэггүй амьтан болжээ гэж чи бодсон, үнэн биз? Архи хэт ууж, арьс яс болтлоо тураад, нойр хоолноос гарсан уу? За одоо чи сайн сонсоод, миний үгэнд ор. Хүн шиг цадталаа хоол идэн, ханатлаа унтаж тэнхэртлээ манайд нэг сар бай.

Миний хажууд байж ахуй амьдралын асуудлаар туршлага суувал тэр шагшин шуугиад байгаа Голливудад чинь ч хэрэг болох юм билүү, хэн мэдлээ. Харин ямарваа дуу хуур, архи дарс, эмс хүүхнийг ор тас мартаж хэрэгтэй. Сарын дараа Голливуддаа буцаад очиход тэр сэхүүн зантай монцгор чинь чиний хийх ажлыг өгнө. Тэгж тохирох уу?

Их Эцгийн ам, ажил хоёр хэзээ ч зөрдөггүйг Жонни Фонтейн андахгүй хэдий ч санаа зовон эргэлзсэн байртай.

- Тэр шаар чинь Эдгар Гуверын сайн найз болохоор таны үгийг сонсох ч үгүй байхаа даа.

- Тэр ажил хэрэгч хүн. Би түүнд татгалзаж чадахааргүй зүйлийг санал болгоно.

- Тэгээд ч нэгэнт хожимдсон. Бүх хүмүүстэй гэрээ хийж гарын үсэг зураад, долоо хоногийн

дараа зургаа авч эхэлнэ. Яаж ч оролдоод бүтэхгүй дээ, шал дэмий..

- Чи явж зочид дээр оч. Найз нар чинь хүлээж ядан байгаа. Би бүгдийг аргална гээд эрхэм Корлеоне түүнийг хаалга уруу аяархан түлхжээ.

Хейген ширээнд сууж, дэвтэр дээрээ юм тэмдэглэн, харин эрхэм Корлеоне хүзүүгээ шилгээн хүндээр санаа алдав.

- Өөр юу байна?

- Солоцогийн хүсэлтийг дахиж хойшлуулах аргагүй боллоо. Энэ долоо хоногт та түүнийг хүлээж авах хэрэгтэй байна.

- Хурим болоод өнгөрсөн хойно хэзээ ч яахав дээ...

Үүнийг сонсоод Хейген хоёр дүгнэлт хийжээ. Хамгийн гол нь Виргилия Солоцод татгалзсан хариу өгөх юм байна. Хоёрдугаарт эрхэм Корлеоне охиныхоо хуримыг өнгөртөл хариу өгөлгүй хойшлуулсан болохоор түүний саналыг татгалзсанаас гай учрах нь гарцаагүй.

- Хүмүүсийнхээ хагасыг энд байлга гэж Клеменцод хэлэх үү? - хэмээн Хейген болгоомжтой лавлавал Их Эцэг дургүйцэн ярвайлаа.

- Яах юм бэ? Хурим хүртэл хариу өгөлгүй цааргалсны учир гэвэл, тийм тэмдэглэлт өдрийн баяр цэнгэлийг хол ойрын, ил далдын өчүүхэн зүйлээр ч гутаан сүүдэрлэх ёсгүй билээ. Түүнээс гадна би түүний ирж ярих зүйлийг урьдчилан мэдэх гэсэн юм. Тэрээр тун гутамшигтай, бузар булай зүйл бидэнд санал болгох гэж байгаа нь одоо тодорхой болсон.

- Тэгвэл та татгалзах юм биз дээ? Гэвч энэ асуудлыг гэр бүлийн зөвлөгөөн дээр бүгдээрээ хамтарч хэлэлцээд хариу өгөх нь зүйтэй гэж би үзэж байна.

- Аа мөн, чи тэгж үзэж байна уу? За яахав, чамайг Калифорниос буцаж ирсний дараа хэлэлцье л дээ. Чи маргааш тийшээ нисч, тэр кино үйлдвэрийн эзэнтэй уулзаад Жоннигийн асуудлыг шийдээд ир. Чамайг Калифорниос ирсний дараа хүлээн авна гэж Солоцод дамжуулаарай. Өөр юу байна?

- Зөвлөх асан Аббанданогийн бие хариугүй гэнэ. Очилгүй горьгүй байх. Бас Сенатч утасдсан. Өөрийн биеэр ирж чадаагүйдээ уучлалт гуйгаад, таныг ойлгоно гэж байна билээ. Танай байшингийн өмнүүр эргэлдээд машины дугаар бичиж аваад байсан Холбооны Мөрдөх Товчооны хоёр сайн эрийг хэлсэн байх. Итгэлтэй хүнээрээ бэлэг сэлтээ ирүүлсэн шүү.

Их эцэг толгой дохин зөвшөөрөв. Тэр өөрөө сенатчийг ирээд хэрэггүй гэж зөвлөснөө энд хэлэхийн хэрэг юун?

- Дориун бэлэг үү?

Хейгений герман-ирландын холимог төрхтэй царайд нь яг итали хун шиг дээд зэргээр магтан сайшаах байдал тодрох нь хажуугаас харахад хачин гайхалтай ажгуу.

- Асар их үнэтэй хуучны мөнгөн эдлэл. Хэрэв манай залууст өгч заруулбал лав л мянга хүрнэ. Тийм ховор эдийг олох гэж сенатч нилээн гүйсэн нь гарцаагүй. Тиймэрхүү зиндааны хүмүүсийн хувьд үнэ хөлс нь хамаагүй, олохоор хөөцөлдсөн хичээл зүтгэл нь л бидэнд чухал биз дээ?

Сенатч шиг хүн ийм бэлэг өгнө гэдэг тоглоом бусаар анхаарал тавьсан хэрэг тул эрхэм Корлеоне түүний үгийг үлэмж таатай сонсов. Сенатч бол Люка Бразигийн нэгэн адил Их Эцэг Корлеонегийн сүр хүчний тулгын гурван чулууны нэг нь бөгөөд мөн л Люкагийн нэгэн адил саяын ирүүлсэн бэлгээрээ гуйвшгүй үнэнч болохоо нотолж чаджээ.

Жонниг цэцэрлэгт дөнгөж хөл тавимагц л Кей Адамс дор нь таниад гайхахын ихээр гайхаж Майклаас асуусан нь:

- Танай гэрийнхэн Жонни Фонтейнтэй танил юм уу? Чи урьд нь яагаад надад хэлээгүй юм бэ? Одоо ч би чамтай заавал сууна аа, чи эргэлзэх хэрэггүй!

- Чамайг хүсвэл, би түүнтэй танилцуулаад өгөх үү?

- Одоо ч юу хийхэв дээ. Харин би цагтаа гурван жил түүнд дурлан, концерт тоглох болгонд нь Нью-Йоркод ирж, хоолойгоо сөөтөл орилж чарлаж байгаад буцдагсан. Мөн ч сайхан дуулдаг байж билээ.

- Жаахан хүлээ, чамайг заавал танилцуулна аа!

Жонни хоёрдахь дуугаа дуулж дуусаад эрхэм Корлеонегийн араас байшингийн хаалгаар далд орсон хойно Кей егөөтэй нь аргагүй Майклыг тохуурхан хэлсэн нь:

- Жонни Фонтейны зиндааны хүн эцгээс чинь юм гуйхаар ирсэн гэж л чи миний толгойг бүү эргүүлээрэй

- Жонни түүний загалмай зүүлгэсэн хүү нь юм. Хэрэв миний эцэг байгаагүй бол тэр хэзээ ч ийм зиндааны од болж чадахгүйсэн.

Кей Адамс үнэхээр бахдан баярлаж:

- Хүүе ээ, би лав дахиад л хачин гайхалтай түүх сонсох нь ээ дээ, янз нь гэвээс Майкл толгой сэгсэрлээ.

- Энэ түүхийг чамд ярих эрх надад байхгүй.

- Чи надад итгэж болно.

Тэгээд л Майкл элдэв тайлбар, хошин шог үг хэрэглэлгүйгээр ердөө л болсон явдлыг дуртай дургүй ярьж өгчээ.

Найман жилийн өмнө Жонни нэгэн нэр цуутай жааз хамтлагийн бүрэлдэхүүнд ер бусын амжилттай дуулж, радио сонсогчдын анхаарлыг татах амттай өгөөж болсон байна. Гэвч мэнгэ нь голлоход, хамтлагийн удирдагч Лесс Галли хэмээх зартай нэгэн эр Жонниг таван жил хөлс хүчийг нь гарах гэрээгээр хүлж боогоод авчээ. Ер нь шинэ залуу жүжигчдийг гол төлөв ингэж мөлждөг л дөө. Ингээд Галли Жонни Фонтейныг түр хөлсөөр өгч дуулуулаад олсон мөнгийг нь өөрөө завших бүрэн эрхтэй болсон аж. Тэр үед эрхэм Корлеоне бас ч халуун хөөргөн сэтгэлтэй явснаас гадна нэгэнт Жонни загалмай зүүлгэсэн хүү нь учраас түүний ашиг сонирхлыг хамгаалах явдлыг өөрийн нэр төрийн хэрэг хэмээн үзээд Галлитай биеэрээ уулзаж, гэрээгээ цуцлавал хорин мянган доллар өгөхөө амласан байна. Гэтэл Галли Жоннигийн олсон орлогын хагасыг өөртөө үлдээсэн нөхцөлд л гэрээ цуцлахаа зөвшөөрч, энэ нь, Их Эцгийн хөх инээд нь хүрч, амласан шан харамжаа хоёр дахин багасгажээ. Сэтгэл зүрхээ өгсөн эстрадтай нь холбоогүй ажил хэргийн талаар мэдлэг, туршлагаар дульхан хамтлагийн удирдагч ингэж шан харамжийн хэмжээ хорогдсоны учрыг зөв ойлгох ямар ч чадваргүй байж, Их Эцгийн саналыг хэрэгсэж үзсэнгүй.

Маргааш өдөр нь эрхэм Корлеоне өөрийн зөвлөх байсан Женко Аббандандо, Люка Брази хоёрын хамт Галлигийн ирэхэд гэрийн эзнээс өөр хүн байсангүй. Арван мянган долларын баталгаатай чек авсан цагаас эхлэн Жонни Фонтейны уран бүтээлийн үйл ажиллагаанд үл оролцохоо амласан бичигт гарын үсэг зурахыг эрхэм Корлеоне Лесса Галлигаас шаарджээ. Эрхэм Корлеоне олон таван үг нуршсан ч үгүй, Лесса Галлигийн духанд гар буу тулгаад, нэг минутын дараа тэр бичиг дээр нэг бол хамтлагийн удирдагчийн гарын үсэг байна, эсвэл түүний уураг тархи асгарсан байх болно гэсэн тул Галли арга буюу зөвшөөрчээ.

Дараа нь үйл явдал түүхийн хуудсанд тэмдэглэхээр сонирхолтой өрнөж, Жонни Фонтейн, түүний дуу хоёр Америк даяар жинхэнэ шуугиан дэгдээсэн байна. Түүний тоглосон хөгжимт инээдмийн хоёр кино голливудын үйлдвэрт урьд үзэгдээгүй их орлого оруулж, түүний дуутай пянз сая саяар борлогдох болов. Дараа нь тэр хар багаасаа үерхэж дассан авгайгаасаа салж, үр хүүхдээ орхин голливудын киноны оддын дотроос хамгийн хөөрхөн, цайвар үст жүжигчинтэй гэрлэсэн байна. Тун ч удалгүй шинэ эхнэр нь ичгүүр сонжуургүй биеэ худалддаг болохыг олж мэдээд тэр эр архинд орж мөрийтэй тоглоом хөөцөлдөн, хүүхэн эргүүлэх нь газар авсан учраас хоолой нь: муудаж, пянз нь гүйхээ больсон аж. Киноны үйлдвэр түүнтэй гэрээ байгуулахаас татгалзсан учир тэрбээр загалмай зүүлгэсэн эцэг дээрээ эргэж ирэхээс өөр яах вэ?!

Кей нэг хэсэг гүн бодолд дарагдав.

- Чиний ярьсан бүхнээс үзэхэд аав чинь үнэхээр тусч цайлган сэтгэлтэй хүн бололтой. Өрөөл бусдын төлөө ийм их юм хийгээд буян болж байхад чамд атаархах сэтгэл төрдөггүй юм уу? Гэхдээ, үнэнийг хэлэхэд, хуульд заагаагүй арга хэрэглэдэг нь л тиймхэн юм даа.

Майкл хүндээр санаа алдлаа.

- Хажуунаас харахад тийм ч байж магадгүй, гэхдээ би чамд нэг юм хэлье. Дэлхийн туйл

судлаачид тодорхой хэмжээний газар яваад хүнсний нөөц үлдээгээд аяллаа цааш үргэлжлүүлдэг заншилтай нь хэзээ нэгэн цагт хэрэг болж магадгүй гэсэндээ тэр шүү дээ. Аавын буяны үйлс яг ийм л шинжтэй. Түүний одоо тус болсон хүний хувьд хэзээ нэгэн цагт хариу барих ээлж заавал ирнэ.

Хуримын бялууг ширээн дээр гарган тавьж, түүнийг магтан гайхаж, хувааж идэх гэж бужигнасаар байтал бүрэнхий боллоо. Назорин өөрийн гараар урлан бүтээсэн тэр амтат бялууг чихэртэй тос дун хэлбэрээр дусааж чимсэн бөгөөд бэр хүүхэн шаргал үстэй нөхрийнхөө хамт хуримын аянд мордохын өмнө түүнээс хоёр гурван хэрчим идээд амжжээ. Их Эцэг зочдоо хурдан шалмаг боловч ёс төртэй үдэж мордуулах зуураа FBI-ын тагнуулуудын хар машин алга байгааг анзаарсан байна.

Ингээд тэдний гадаа урт хар «кадиллак» ганцаараа үлдэж, Фредди жолооны ард суусан харагдана. Их Эцэг лагс биетэй, нас ахисан гэхэд гайхмаар шалмаг намалзан алхсаар очиж урд талд нь суулаа. Арын суудалд Сонни. Майкл, -Жонни Фонтейн гурав тухалсан харагдана.

- Хүүхэн чинь өөрөө аргалаад хот орчих байгаа? гэж Их Эцэг мөрөн дээгүүрээ Майклаас асуусанд тэрээр толгой дохив.

- Том хүргүүлнэ гэсэн.

«Хейген хамаг юмыг амжуулах юм даа» хэмээн эрхэм Корлеоне сэтгэл хангалуун бодлоо. Бензин шатахуун талоноор олгосон хэвээр тул Манхаттан ордог Тойрдог зам эл хуль. Хөдлөөд цаг ч болоогүй байхад тэд Франц эмнэлгийн байдаг гудамж эргэж, энэ хооронд Сонни урагшаа тонгойн:

- Та Жоннид тохиолдсон эвгүй явдлыг аргалах юм гэж дууллаа. Би Голливуд очиж туславал яасан юм гэж асуувал эрхэм Корлеоне товчхон хариулав.

- Том өнөө шөнө тийшээ ниснэ. Тусламж хэрэггүй. Ялихгүй ажил.

Сонни нэг нэг хөхөрч

- Жонни таныг яаж ч чадахгүй гэсэн болохоор би тус болж юу магад гэж бодсон юм л даа хэмээвэл Загалмайлан эцэг Жонни Фонтейн өөд эргэн харлаа.

- Чи юунд эргэлзээ вэ? Би ганц удаа ч болов хэлсэн амандаа хүрээгүй тохиолдол байна уу? Хэдийнээс намайг хоосон үгтэй хүнд тооцох болоо вэ?

- Загалмайлан эцэг минь ээ, тэр үйлдвэрийн эзэн чинь үнэхээр танил тал ихтэй, том хүн. Мөнгө ч нэмэргүй болохоор таныг яаж аргалах гээд байгааг би ер ойлгохгүй юм.

Их Эцэг тун хөгжилтэй дуугаар:

- Чи тэр дүрд тоглоно гэж би чамд хэлээд байна шүү. Хүүе Майкл аа, бид Жонниг

хөөдчихгүй биз дээ? - хэмээн хошигновол Майкл эцгийнхээ үгэнд өчүүхэн төдий ч эргэлздэггүй тул зөвхөн толгой сэгсрэв.

Бүгд эмнэлгийн зүг явах зуур Их Эцэг хүүгийнхээ гараас барьж:

Их сургуулиа дүүргээд хүрээд ир. Би чамайг нэг ажилд товлосон, чи харамсахгүй байх- гэвэл Майкл юу ч дуугарсангүйд эрхэм Корлеонегийн уур нь хүрээд явчхав.

- Чиний бодлыг мэдэхгүй гэж санаа юу? Ямар ч муу юм би чамаар хийлгэхгүй. Тун өвөрмөц онцгой ажил байгаа юм. Одоохондоо энэ сонгосон замаараа эр хүний жаргал эдлээд явж л бай. Харин сургуулиа төгсөөд хүний хүү шиг аав дээрээ хүрээд ирээрэй...

...Их Эцгийн зөвлөхөөр олон жил ажиллахдаа Женко Аббандандо үхлээс зугтаан урт зам туулсан боловч одоо өвчин эмгэгт баригдан турж эцээд эмнэлгийн энэ орон дээр эцэслэнэ гэдгээ сайн мэдэж байлаа.

Эрхэм Корлеоне түүний сэтгэлийг засах санаатай:

- За бушуухан хөл дээрээ босоод орхи. Тэгээд хоёулаа Итали, төрсөн тосгондоо очиж, өвөг дээдсийнхээ үеэс уламжилсан тоглоомоор шавайгаа ханатал наадъя хэмээн хөгжилтэй дуугарвал хадан гэр нь ойртсон хөөрхий өвгөн толгой сэгсэрч Их Эцгийн ханцуйгаас зуурч ойртуулаад тасалдангуй шивнэсэн нь:

- Загалмайлсан эцэг минь, намайг үхлээс аварч үзээч. Араг ясны минь гадуур байсан мах өөх, булчин шөрмөс бүгд хатаж гүйцээд, үхлийн өт хорхой уураг тархийг минь идэж байна. Загалмайлсан эцэг минь, амь авар. Хүүхэд ахуйдаа Корлеонед хамт тоглож өссөн байж, тамын ёроолд унах цаг минь ирээд байхад та намайг орхих юм гэж үү?

- Хуучин анд минь, энэ чинь надад ч хүч хүрэхгүй даваа шүү. Бүхнийг чаддаг, дийлдэг байсан бол би чамд бурхан тэнгэрээс ч нигүүлсэнгүй хандахсан. Гэхдээ чи үхлээс бүү эмээ, тамд очихоос битгий ай. Өглөө, орой болгон сүмд чиний хойтохыг уншиж, эхнэр хүүхэд чинь ч мөргөл үйлдэх болно. Нүглийг чинь наманчилсан, өршөөл хайрлахыг гуйсан мөргөл залбирал тал бүрээс нь нисэн очиж байхад бурхан чамайг юунд цээрлүүлэх юм бэ?

Хоногийн тоо нь дууссан өвгөний арьс яс болсон царай зальжин болж, хатаж үрчийсэн уруул дээгүүр нь зэвүүн инээмсэглэл бүжиглэнэ.

- Аа, та түүнтэй тохиролцсон юм уу?

- Чи бурханд тэрслэхээ боль. Хүлцэн тэвч гэх хүйтэн ширүүн хариу сонсоод Аббандандо тэнхэл алдан дэрээ налав Сувилагч орж ирээд дадсан зангаараа бүгдийг хөөж туун Их Эцэг боссон боловч өвчтөн өвгөн түүнийг зуураад авлаа.

- Загалмайлсан эцэг минь, та үлдээч. Таныг хажууд минь сууж байгааг нөгөө гайхал харвал хулчийгаад намайг орхиод явчхаж ч юу магад. Эсвэл намайг өмөөрч ямар нэг юм хийвэл болохгүй юу? Та хоёр чинь бараг л төрөл садан шүү дээ. Бусдыг бүхэл насаараа хуурч

залилсан шигээ та бид хоёр тэр Гайхлыг аргалж дөнгөхгүй юм уу? Загалмайлсан эцэг минь, намайгаа бүү орхиоч!

Их Эцэг гар занган бүгдийг гаргаж, Женко Аббандандогийн хатангир гарыг илэн тайтгаруулж, үнэхээр хүн төрөлхтний хамгийн хорон зальт, өшөөт дайсан тэр Гайхлын савраас Женкогийн амийг аварч чадах юм шиг амарлиулан тайвшруулах үгс эелдгээр хэлж суулаа.

Конни Корлеонегийн хувьд хуримын шөнө зохих ёсоороо өнгөрчээ. Карло Рицци эр нөхрийн үүрэгт ажлаа сурамгай дадамгай гүйцэлдүүлсэн нь бэлэгний хорь гаруй мянган доллар пиндийтэл нь чихсэн эхнэрийнхээ уутыг шохоорхох хүсэл багагүй тус дэм болсон янзтай аж. Гэтэл харин залуу эхнэр эл уутыг онгон биенээсээ илүү харамласан учир залуу эр түүнийг салгаж авахын тулд Коннигийн нүдийг булуу болтол дэлсэхэд хүрсэн байна.

Люси Манчини гэртээ ирээд Соннигийн утасдаж, болзоо тогтоохыг хүлээж хүлээж, тэссэнгүй өөрөө утасдсан чинь эмэгтэй хүн хариулахаар нь утсаа тавьчав. Соннитой нуугдан байж буянаа эдэлсэн тэр гайтай хагас цагийн дотор тэр хоёрын тухай элдвээр ярилцаж, Сонни шинэ амрагтай болж, төрсөн дүүгийнхээ найз бүсгүйг «эдэлсэн» тухай дам үгс ам дамжин тархсаныг Люси яахан мэдэх билээ?!

Кей Адамсыг зочид буудалд нь хүргэж өгөхөөр Клеменца, Поли Гатто хоёр Нью-Йорк уруу авч явжээ. Хүүхэн зам зуураа хэн хэнтэй нь элдвийг хүүрнэхдээ тэд Майклыг үнэн голоосоо хүндэтгэн хайрлаж ярихыг ажаад үлэмж гайхав. Майкл ямар учраас өөрийгөө төрсөн эцгийнхээ ертөнцөд харь хөндлөнгийн хүн гэж түүнд ойлгуулах гэсэн юм бол оо? Гэтэл энэ Клеменца амьсгаадсан нарийхан дуугаар ярихдаа, Их Эцэг хүүхдүүд дотроосоо ганцхан Майклыг онцолж түүнд л Корлеонегийн намын ажил хэргийг найдаж үлдээхээр товлосон гээд байдаг.

- Тэр нь тэгээд ямар ажил юм бэ дээ? - хэмээн Кей гэмгүй царайлан асуучихсан чинь Поли Гатто түүн рүү хоромхон зуур хяламхийгээд залуураа огцом мушгиж, харин Клеменца бас л үл мэдээч болон арын суудлаас хэнэггүй дуугаар ийн үгүүлрүүн:

- Майкл танд хэлээгүй юм уу? Ноэнтон Корлеоне бол Италиас чидун жимсний тос Америкт ханган нийлүүлдэг хамгийн том наймаачин шүү дээ. Одоо дайн дуусч, ажил ундраад ирэхээр Майкл шиг толгойтой хүн маш их хэрэг болно.

Зочид буудалд очсон хойноо Клеменца бүсгүйг заавал оруулж өгөх гэхээр нь Кей эсэргүүцэн дургүйлхсэн боловч сайхь эр ботгоо голсон ингийг ч уяраам ялдам дуугаар:

- Эзэн таныг бүр үүдэнд чинь бүрэн бүтэн хүргэж өг гэсэн. Би тийм үүрэгтэй - хэмээн хүүхнийг цахилгаан шатанд суулгаж өгөөд жижүүр дээр очив.

- Энэ хүүхэн ямар нэрээр бүртгүүлсэн бэ.

Жижүүр Клеменцаг мөс шиг хүйтэн нүдээр ширвэсэнд тэрбээр гартаа хуйлан бөөрөнхийлсөн ногоон дэвсгэрт шидлээ. Жижүүр эр түүнийг нь овжин барьж аваад нэн даруй хариулсан нь:

- Эрхэм Корлеоне эхнэрийн хамт

Машинд суусан хойноо Поли Гатто:

- Дажгүй хүүхэн байх чинь вэ? гэвэл Клеменца унтууцан:

- Чи маргааш өглөө намайг эртхэн аваарай. Чи бид хоёрт Хейген яаралтай даалгавар өгсөн шүү гэжээ.

Том Хейген яарсаар байсан хэрнээ зөвхөн ням гаригийн орой эхнэртэйгээ салах ёс хийгээд нисэх онгоцны буудал руу явжээ. Тун хэцүүхэн тэр өдрийг Том Хейген өөртөө үлэмж ашигтай, үнэхээр хийморьтой өнгөрөөсөн аж. Үүрийн таван жингээр Женко Аббандандо амьсгал хурааж, эрхэм Корлеоне эмнэлэг дээрээс буцаж ирээд өөрийн гарын зөвлөхөөр Хейгенийг томилсноо албан ёсоор мэдэгдсэн байна. Ийнхүү Хейген энэ мөчөөс эхлэн баяжиж бэлжихээс гадна хэчнээн их эрх мэдэлтэй болсон талаар ярихын ч хэрэггүй.

Ингэснээрээ Их Эцэг бүгдийн эрхэмлэн хүндэтгэдэг хуучны ёс заншлыг зөрчжээ. Бүүр эрт дээр үеэс эхлэн зөвхөн цэвэр цусны сицили эрийг гарын зөвлөхөөр томилдог уламжлалтай байсан бөгөөд Хейген Их эцгийн гэрт өсөж хүмүүжсэн нь үүнд ямар ч хамаагүй, ганцхан удам угсаа л шийдэх асуудал байлаа. Зөвхөн ам алдахгүй, өөрөөр хэлбэл биеэ хаацайлах хуулийг эхийн сүүний хамт амсаж мэдэрсэн сицили нутгийн уугуул эрд л аливаа их эцгийн эзэнт улсын гол зангилаа байр эзэлдэг гарын зөвлөхийн албан тушаалыг итгэн найдах ёстой байв.

Корлеонегийн гэр бүлийн эзэнт улсыг Их Эцэг толгойлж, эл намын бүх үйл ажиллагааг удирдан чиглүүлэх бөгөөд түүний тушаал зааврыг гардан гүйцэтгэдэг хүмүүсээс Их Эцгийг тусгаарлах завсрын гурван жийрэг давхарга бий болохоор ямар ч ул мөр хөөгөөд эзэнт улсын ноён оргилд хүрч чадахгүй. Гэхдээ зөвхөн гарын зөвлөх урван тэрслээгүй цорын ганц нөхцөлд л тэр шүү дээ! Тэр ням гаригт ч гэсэн эрхэм Корлеоне Том Хейгенийг ганцааранг нь дуудаад, Америго Бонасерагийн охиныг зэрэмдэглэсэн хоёр нусгай бандийг хэрхэх талаар дэлгэрэнгүй захирамж өгч, Хейген бас л Клеменцад хөндлөнгийн гэрчгүй, хоёулхнаа байхдаа энэ зааврыг уламжлан, тэр нь Поли Гаттод тушаал гүйцэтгэхийг даалгасан байна. Энэ бүхний эцэст Поли Гатто хэрэгтэй хүмүүсээ сонгон авч хий гэснийг ёсоор биелүүлэхээс өөр яах вэ. Ийм даалгавар яагаад өгсөн, анх хэн өгснийг Поли Гатто ч түүний залуу ч мэдэх боломжгүй. Хэрэв энэ гинжин хэлхээний бүх гогцоо найдвар алдсан тохиолдолд л энэ хэрэгт Их Эцэг хамаатайг тогтоож болно.. Ийм юм амьдрал дээр хэзээ ч тохиолдож байгаагүй, тохиолдлоо ч гэсэн урьдчилан сэргийлэх арга бас бий бөгөөд ердөө л дээрээсээ хоёрдахь гогцоо буюу зангилаа байр эзэлдэг зөвлөх алга болох учиртай.

Зарим төрлийн ажил хэрэгт гарын зөвлөх Их Эцгийн нэрийн өмнөөс арай ил тод оролцох

боловч бас л түүний нэрийг цухалзуулахгүй байхыг аль болохоор хичээх үүрэгтэй. Яг л ийм хэргээр одоо Хейген Калифорни уруу нисч яваа бөгөөд үүнийг яаж амжуулахаас цаашид гарын зөвлөхийн албан тушаалд байх хувь заяа нь үлэмж хэмжээгээр шалтгаална гэдгийг тэр сайн ойлгож байлаа.

Ажил хэргийн талаас нь авч үзвэл, Жонни Фонтейн шинэ кинонд мөрөөдөл болсон дүрдээ тоглоно уу, байна уу, тун өчүүхэн асуудал. Харин Хейгений баасан гаригт товлосон Виргилия Солоцотой хийх уулзалт үүнээс хавьгүй чухал ач холбогдолтой боловч Их Эцгийн хувьд хоёулаа чанар тэнцүү асуудал гэдгийг Хейген андахгүй бөгөөд сайн зөвлөх бол үүнийг л ойлгон мэдэж байх ёстой.

Онгоц даржигнан чичирхийлж, тэртэй тэргүй сэтгэл бухимдан хөдөлсөн Хейгенд нөлөөлөөд амар заяа үзүүлсэнгүйд тэрээр тайвшрахын тулд үйлчлэгчээс хундага мартини дарс гуйж уув. Наашаа нисэхийн өмнө тэрбээр кино найруулагч Жек Вольцын тухай Их Эцэг Жонни хоёроор мэдэх бүхнийг нь хэлүүлэн авчээ. Жоннигийн ярьснаас ургуулан бодвол. Хейген яаж ч ятгаад тэр найруулагчийг атгандаа оруулж чадахгүй бололтой. Гэвч Их Эцэг Жоннид амласнаа заавал биелүүлнэ гэдэгт гарын зөвлөх хормын төдий ч үл эргэлзэх тул ямар нэг аргаар Вольцтой холбоо тогтоож, хэлэлцээр хийх л болж дээ!

Хейген сандлын түшлэгийг арагшлуулж налаад оюун бодлоо төвлөрүүлэхийг хичээлээ. За байз, Жек Вольцын тухай юу олж мэдсэн билээ гэвэл, тэрээр

Голливудын хамгийн нэртэй гурван найруулагчийн нэг, өөрийн кино үйлдвэртэй, хэдэн арван шилдэг жүжигчинтэй гэрээ контракт байгуулсан, мөн Америкийн Нэгдсэн Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх цэргийн мэдээллийн Зөвлөлдөх зөвлөлийн гишүүний хувьд киноны хэлтсийг удирддаг, өөрөөр хэлбэл, дайныг алдаршуулан сурталчилсан кино хийдэг юм байна. Бас Цагаан Ордны хүлээн авалтад очиж, Голливуд дахь албан тасалгаандаа Эдгар Гуверийг урьж уулзаж явсан хүн гэдэг Хэдий сүржин сонсогдовч хэрэг дээрээ үнэн л байдаг байгаа даа?! Зөвхөн албаны л харилцаанаас цаашгүй биз, нохой долоо! Вольц биеэ өргөмжлөн ихэмсэглэх өвчтэй, хэчнээн дайсантай болж байгаагаа ч үл тоомсорлон эрх мэдлээ дур зоргоороо ашиглах донтойгоос гадна хамгийн гол нь хэт харгис үзлийг баримтлан сурталчлах учир улс төрийн зүтгэлтнүүдийн дунд өөрөө бол ямар ч нэр нөлөөгүй хүн.

Энэ Жек Вольцтой тохиролцоно гэж санасны гарз гэж бодоод тэрбээр бичгийн саваа онгойлгон албан ажлаа бичиж тэмдэглэх гэсэн боловч туйлдталаа ядарсан тул чадсангүй, үйлчлэгчээс дахин нэг хундага мартини авч уугаад өөрийнхөө тухай гүн бодолд дарагдав. Яагаад энэ замыг сонгож авсан нь хамаагүй, хамгийн гол нь зөв замаар яваа учир юунд ч харамсах юм алга, харин ч түүнд аз таарсан. Тэр ажилдаа ч, аж амьдралдаа ч цог хийморьтой яваа, эрийн цээнд хүрсэн хүний л амсаж болох жаргалыг үлдээлгүй эдэлж яваа нэгэн болжээ.

Гучин таван нас хүрч яваа Том Хейген өндөр нуруутай, туранхай биетэй, богинохон тайруулсан халимагтай, ер нь гаднаас нь харахад хүнээс гойд ялгарах юм юу ч үгүй. Тэрбээр хуульчийн боловсрол эзэмшиж, диплом аваад гурван жил мэргэжлээрээ ажилласан боловч харин одоогийн хийж байгаа ажил нь Корлеонегийн намын ил бизнес болох чинар модны тос гадаадаас оруулах ажиллагаатай бараг хамаагүй гэж болно.

...Том арван нэгтэйдээ үе тэнгийн хүү Сонни Корлеонетой үерхжээ. Хейгений эх нь хараагүй болж яг энэ үеэр нас барснаас болоод угийн балгачих дуртай байсан эцэг нь бүр архинд орлоо. Тэрбээр амьдралдаа үнэнч шударга явсан ажилсаг, сайн мужаан байсан авч архинаас болоод гэр бүлээ баллаж, эцэст нь нь өөрийн биеийг хөнөөсөн байна. Ийнхүү Том Хейген өнчирч.

гудамжаар тэнэж тааралдсан газраа хоног төөрүүлж, охин дүүг нь харь элэгтэй хүмүүст хүмүүжүүлэхээр өгсөн байна. Тэгээд ч бас Хейгенний нүд идээлж эхлээд эхээс нь халдсан байж магадгүй, тэгвэл бидэнд ч халдана хэмээн хавь ойрынхон шивэр авир гэлцэн дөлж тойрох болжээ. Сонни Корлеоне арван нэгэн насныхаа гэнэн хонгор сэтгэлийн угаас найзаа өрөвдөн гэртээ дагуулж ирээд, эндээ байлгана гэж тулган шаардсан аж. Том Хейгенийг усанд оруулж, унтахынх нь өмнө улаан лоолийн тосорхог өтгөн сүмстэй халуун спагеттигаар цадтал нь дайлсан бөгөөд түүний амтыг одоо хүртэл мартаагүй яваа бөлгөө.

Эрхэм Корлеоне элдэв юм шалгаасангүй, олон таван үг хэлсэнгүй, тэгэх л ёстой юм шиг тэр тэнүүлч хүүг гэртээ үлдээж, өөрийн биеэр эмчид дагуулан очиж нүдийг нь эдгээв. Тэрээр Хейгенийг коллежид өгч, дараа нь их сургуулийн хууль зүйн факультетад оруулжээ. Эрхэм Корлеоне өргөмөл хүүтэйгээ эцгийн ёсоор биш асран хамгаалагч шиг нь харилцаж, хэзээ ч энхрий ялдам зан гаргаж байгаагүй атлаа өөрийн хүсэл бодлоо тулгадаггүй, түүний үгэнд илүү ордог байсан нь гайхалтай. Тухайлбал. тэр залуу нэгэн удаа эрхэм Корлеонегийн:

- Цүнх барьсан нэг хуульч автомат тулгасан зуун маанагаас хавьгүй ихийг дээрэмдэнэ - гэж хэлэхийг сонсоод л хуулийн ангид орсон юмсанж.

Гэтэл Сонни, Фредди хоёр дунд сургуулиа төгсөөд эрхэм Корлеонегийн дургүйцсээр байтал эцгийнхээ мөрөөр явахаар шийдэж, ганцхан Майкл л их сургуульд орсон боловч Жибэнтэй дайн зарласны маргааш нь тэнгисийн явган цэрэгт сайн дураараа элсчээ.

Хейген өмгөөлөгчийн диплом аваад эцэг эх нь Нью Жерси муж улсад ирж суурьшсан нэг залуу бүсгүйтэй гэр бүл болжээ. Эхнэр нь бас л их сургууль төгссөн нь тийм хүрээний хүүхний хувьд тун ховор тохиолдол байлаа. Хуримаа, мэдээжээр, эрхэм Корлеонегийнд хийсний дараа Их Эцэг Хейгений аливаа ажлыг дэмжиж, өмгөөлөгчийн контор нээж, үйлчлүүлэгчдийг олж өгөх юм уу, үгүй бол үл хөдлөх хөрөнгө худалдаалах газартай болгоход бэлэн байгаагаа илэрхийлсэн боловч Хейген толгойгоо хүндэтгэлтэйгээ гудайлган үгүүлсэн нь:

- Би танайд ажиллах гэсэн юмсан.

Их Эцэг гайхсан боловч сэтгэл ханамжтай байгаа нь илт.

- Чи миний ямар ажил эрхэлдгийг мэдэх үү?

Хейген тийм гэж толгой дохисон боловч Их

Эцгийн хүч чадал ямар ихийг хараахан мэдээгүй, тэр ч бүү хэл Женко Аббандандо өвдөж, гарын зөвлөхийн үүрэгт ажлыг авах хүртлээ бүтэн арван жилийн турш сайн мэдэхгүй явжээ.

Гэсэн хэдий боловч тэгэхэд зөвшөөрөн толгой дохиод Их Эцгийн цоо ширтсэн харцыг дааж өнгөрүүлсэн аж.

- Би яг л таны хүүхдүүд шиг танайд ажилламаар байна.

өөрөөр хэлбэл Хейген Их Эцгийн эрхэм дээд мэдлийг үг дуугүй зөвшөөрч, чин сэтгэлээсээ үнэнч зүтгэхээ илэрхийлсэнд эрхэм Корлеоне түүнийг тэднийд ирснээс хойш анх удаа эцгийн ёсоор энхрийлэн тэврээд үүний дараа л төрсөн хүү шигээ харилцах болсон бөлгөө. Гэхдээ л:

- Том оо, чи эцэг эхээ үргэлж санаж яваарай - гэж үе үе дурсдаг аж.

Хейген яаж мартаж чадах билээ?... Нэгэн аймаар зүүд түүнийг шаналгаад олон жил болж буй бөгөөд тэрээр эх шигээ сохорч урдах замаа модоор тогшин тэнэж, араас нь бас л сохорсон хүүхдүүд нь гутлаа чирэн дагаж гуйлга гуйна. Ийм зүүднээсээ цочин сэрж ухасхийн -босох эхний мөчид л эрхэм Корлеонегийн дүр нүдэнд нь үзэгдээд жаахан тайвширдаг байлаа.

Хейгенийг эхний хоёр гурван жилдээ зөвхөн Корлеонегийн гэр бүлийн ажил хэргээр биш бас өөр хүмүүсийг хувиараа хүлээн авч үйлчилж бай гэж Их Эцэг шаарджээ. Хожим нь ийм замаар хуримтлуулсан туршлага нь тун их хэрэг болж, хамгийн гол нь энэ хугацаанд Их Эцгийн ажиллах эсэх талаар Хейгений эцсийн эргэлзээ арилжээ. Дараа нь тэрбээр Их Эцгийн танил олонтой эрүүгийн хэрэг өмгөөлөх нэрт пүүсэнд хоёр жил ажиллаж их юм сурч авчээ Хейген эрүүгийн эрх зүйн бузгай мэдлэг чадвартайг бүгд хүлээн зөвшөөрч, зургаан жилийн дараа эрхэм Корлеонегийнд ирж ажилласнаас хойш түүний ажилд алдаа эндэгдэл ер гарсангүй.

Гарын зөвлөхийн үүрэгт ажлыг Хейгенд хариуцуулснаас хойш Сицилийн бусад томоохон бүлэглэлүүд Корлеонегийн намыг: «Ирланд золбингууд» хэмээн үл тоомсорлон дуудах болжээ. Энэ нь Хейгенд инээдтэй санагдсан хэдий ч бас хэзээ нэгэн цагт Их Эцгийг орлож, гэр бүлийн концертыг толгойлох ямар ч найдлага байхгүй гэсэн уг байв. Гэвч энэ нь ямар хамаатай юм бэ? Хэрэв ингэвэл ивээн тэтгэгч эрхэм Корлеоне, түүний төрөл төрөгсдийн тусыг усаар хариулсан тоогүй хэрэг болох тул тэрээр хэзээ ч ийм санаа өвөрлөж яваагүй бөлгөө.

Онгоц Лос-Анжелест буух үеэр харанхуй хэвээрээ байлаа. Хейген зочид буудалд ирж усан шүршүүрт ороод сахлаа хусч, цонхны дэргэд очоод үүр хаяарахыг харж баахан зогссоноо өрөөндөө өглөөний зоог. шинэ сонин авчруулан, Жек Вольцтой уулзах арван цагийг хүлээв. Ийнхүү уулзахаар санаандгүй амархан тохиролцжээ.

Урьд өдөр нь Хейген үлэмж нэр нөлөөтэй киноны ажилтан нарын үйлдвэрчний эвлэлийн Билл Гоффод утасдаж, маргааш Жек Вольцтой уулзуулж өгөхийг гуйгаад, хэрэв Хейген уулзалт ярианы үр дүнд сэтгэл дундуур үлдвэл кино үйлдвэр дээр нь ажил хаялт зарлаж болзошгүйг битүүхэн цухуйлгаад орхихыг хүссэн нь эрхэм Корлеонегийн зааврыг дагасан хэрэг байлаа. Өглөө арван цагт уулзахаар тохирсон гэж Гофф нэг цагийн дараа утастжээ.

Ажил хаялтын тухай битүү дохиог Вольц ойлгосон хэдий ч нэг их тоосонгүй бололтой гэнэ.

- Элдэв асуудал гарвал би Их Эцэгтэй өөртэй нь ярина - гэж Гофф нэмж хэлсэнд Хейген өөдөөс нь:

- Иймээ тиймээ юм болвол тэр өөрөө тантай ярих болно - хэмээн түс тас хариулсан аж.

Гофф ингэж Их Эцгийн хүсэлтийг дуртай хүлээн авсанд Хейген ер гайхсангүй. Нарийндаа хүрвэл Их Эцгийн харьяалах нутаг нь Нью-Йорк боловч Корлеоне ид хүчээ авч байх үедээ үйлдвэрчний эвлэлийн удирдагч нарт ихээхэн тусламж үзүүлсэн болохоор тэдний ихэнх нь одоо хүртэл түүнд өртэй яваа юм.

Харин арван цагт уулзах гэсэн нь базаахгүй хэрэг дээ. Тэгэхлээр түүний нэр уулзах хүмүүсийн жагсаалтын эхэнд орж, Вольц түүнийг зиндаан доогуурт тооцон ердийн хоолонд урихгүй гэсэн үг. Тэгэхлээр Гофф түүнийг олигтой сүрдүүлсэнгүй, лав өөрөө түүнээс хээл хахууль авдаг биз. Их Эцэг өөрийнхөө нэрийг хэт далдалдаг нь заримдаа Корлеонегийн намын ажил хэрэгт муугаар нөлөөлөх юм гэж Хейген дотроо бодлоо.

Хейгений таамаг зөв болж, Вольц түүнийг үүднийхээ өрөөнд хагас цаг гаруй хүлээлгэв. Одоо яая гэх вэ. Тун хээнцэр тохилог хүлээлгийн өрөөнд Хейгений урьд өмнө үзээгүй хөөрхөн охин өөдөөс нь хараад ягаан бүрээстэй буйдан дээр сууна. Том хүн шиг даруухан хувцасласан, арван хоёроос хэтрээгүй насны тэр охин санаанд багтамгүй алтан шаргал үстэй, тэнгисийн ус шиг гүн цэнхэр томоос том нүдтэй, бөөрөлзгөнө шиг час улаан уруултай ажээ. Эх нь бололтой нэг авгай хажууд нь сууж, охиноо харамлан хүйтэн цэвдэг харц Хейген тийш байн байн чулуудаад байхаар нь босч очоод тас алгадаад авмаар санагдан тэсэхүйеэ бэрх. Түрэмгий ээжийнхээ хараан дор зовлонгоо эдлэх тавилантай охин юм даа, хөөрхий гэж Хейген дотроо харуусав.

Тэгж байтал тун хээнцэр хувцасласан, дунд зэргийн насны бүдүүн хүүхэн гарч ирээд өрөө хонгил сүлжсээр найруулагчийн өрөө рүү дагуулж очив. Тавилга тоноглол нь ч гэсэн, ажлаа хийгээд сууж байгаа хүмүүсийн гадаад байдал нь ч гэсэн харахад нүдэнд дулаахан боловч Хейген дотроо дооглон инээмсэглэв. Киноны од болохоор сээхэлзэн энд шургалсан эдгээр овжин хүмүүсийн ихэнх нь эл л байсан байрандаа үлдэж, зарим нэг нь амжилт олохгүйгээ мэдээд зэлүүд буйд нутагтаа эргэж очих нь дамжиггүй.

Жек Вольц ханхар том цээжтэй, гол шиг өндөр нуруутай, хийц сайтай костюмынх нь дороос мэдэгдэхтэй үгүйтэй гэдэс суусан нэгэн. Хейген түүний намтар түүхийг сайн мэднэ. Тэрбээр арван настай байхдаа Ист-Сайдад пивоны хоосон торх өнхрүүлж, гудамжинд ганзаганы наймаа хийж байжээ. Хорин нас хүрээд оёдлын газрын ажилчин хүүхнүүдийн шүүсийг шахахад эцэгтээ туслан, гучин настайдаа өрнө зүг мордож, хувийн кинотеатр нээгээд, дөчин наймтайдаа Голливудын эрхтэн дархтаны дунд толгой цохих болжээ. Тэрээр залуугийнх шигээ бүдүүлэг авиртай боловч угийн хүүхэмсэг болохоор атганд нь орсон залуухан жүжигчин бүсгүйчүүдийг үлдээдэггүй, ёстой л номхон хонин сүрэгт орсон чоно л гэлтэй явлаа. Тавь хүрээд харин ч томоожин англи гаралтай бойдагаараа боловсон ёс, хэллэг заалгаж, эхнэрээ нас нөгчсөний дараа дэлхийд алдартай боловч ажилдаа дур сонирхолгүй нэгэн жүжигчинтэй гэр бүл болжээ. Одоо тэр жар гарч, ерөнхийлөгчийн дэргэдэх Зөвлөлдөх

Зөвлөлийн Гишүүн болоод кино урлагийг дэмжих нэрийн санг үндэслэсэн байна. Охин нь английн лордтой сууж, хүү нь италийн гүнжтэй ханилсан ажээ.

Сонин сурвалжлагч нарын тал засан Америк даяар нэг тарааснаар бол, сүүлийн үед тэрбээр хувийн морин заводдоо хамаг дур хүслээ зориулж, зөвхөн өнгөрсөн жил гэхэд л арван сая доллар зарцуулжээ. Бас саяхан зургаан зуун мянган долларын урьд өмнө дуулдаагүй их, үнээр Хартум гэдэг английн алдартай азарга худалдан авч, дахиад хэзээ ч уралдахгүй, зөвхөн өөрийн нь адуун сүргийн үүлдэр сайжруулах болно гэж бөөн шуугиан дэгдээсэн байна.

Вольц жигд борлосон, гөлчийтөл хуссан нүүрэндээ инээмсэглэсэн дүр эсгэн ярвайгаад. Хейгенийг их л найр тавьсан байртай ёсорхуу угтав. Хамгийн дөнгүүр, шилдэг гоо зүйчид яаж ч оролдоод уулыг цас, эрийг нас гэгчээр нүүр нь элдсэн савхи зүйсэн мэт үрчлээтжээ. Гэвч энэ хорвоог хуруу зангах төдийгөөр захирна гэх бардам сэтгэлдээ хөтлөгдөн эрхэм Корлеоне шиг хурдан шаламгай хөдлөх аж.

Хейген шууд л ажил хэрэгтээ орж, өөрийн түнш, дотнын найз Жонни Фонтейны даалгавраар ирснээ мэдэгдээд, тэр тун их нэр нөлөөтэй хүн тул ирэх долоо хоногт зураг авч эхлэх гэж байгаа шинэ кинонд түүнийг тоглуулж найр тавьбал хожим түүний тусламж дэмжлэг, хариу талархалд найдаж болно гэдгийг хэллээ.

Вольцын ширмэл нүүрэнд юу ч өөрчлөгдсөнгүй:

- Найз чинь надад ямар тус хүргэх гэж байгаа юм бэ дээ хэмээн үл тоомсорлосон өнгөөр дуугарсан боловч Хейген тэр хайнга аясыг нь чихнийхээ хажуугаар өнгөрүүлэв.

- Танайд үйлдвэрчний эвлэлийн шугамаар эвгүй тохиолдол болох төлөвтэй байгаа. Миний найз түүнийг чинь зохицуулж аргалах бүрэн баталгаа өгч байна. Тэгээд бас танай үйлдвэрт их мөнгө оруулдаг нэг киноны од чинь мансууруулах бодис хэрэглэдэг, саяхан марихуанаасаа давраад героинд шилжсэн. Тэр жүжигчин дахиад героин хэрэглэхгүйг найз минь батлан даах байна. Цаашдаа ямар ч бэрхшээл учирсан надад утасдахад л хангалттай, би бүгдийг аргална.

Жек Вольц сагсуу хүүхдийн хөөргөн яриа сонсох мэт чагнаж байснаа Ист-Сайдад ярилцдаг шулуухан аясаар:

- Надьг сүрдүүлэх гээ юу? - гэсэн боловч Хейген ер тоосон шинжгүй:

- Үгүй шүү, нөхөрсөг туслалцаа л авах гэж ирсэн юм. Бас та юугаар ч хохирохгүй гэдгийг ойлгуулах бодолтой.

Хоромхон зуур Вольцын царай зэрлэг догшин баг болон хувирч, будаж шунхадсан өтгөн хөмсөг нь оч үсрүүлсэн хилэнт нүдэн дээгүүр нь хуньж атираад, ширээн дээгүүр Хейген тийш тонгойв.

- Салаан завсраар гоожсон зальт минь, аан гэж бай. Хэн ч билээ, тэр толгойлогчдоо товч бөгөөд тодорхой дамжуул. Мафийн дээрэмчид үүд хаалгыг минь өдөр болгон балбаж байсан ч хамаа алга, Жонни Фонтейн хэзээ ч тэр кинонд тоглохгүй. Харин танд нэг зүйлийг зөвлөө.

Жон Эдгар Гувер гэж нэг хүн байдгийг дуулсан биз? Миний дотнын найз юм шүү дээ. Надыг айлгах оролдлого хийлээ гэж түүнд дуулгах л юм бол хөөрхий та нар чандруу болно шүү.

Хейген түүнийг голсон байртай тэвчээр заан сонсож суув. Ийм тэнэг аашилдаг хүн хэдэн зуун саяар ярих хөрөнгө нааш цааш нь болгодог пүүсийг толгойлж байгаа юм гэж үү? Их Эцэг хөрөнгөө оруулах шинэ ажил эрэн хайж байгаа юм чинь энэ талаар бодож үзэх хэрэгтэй. Ийм маанагууд киноны асуудлыг удирдан зохион байгуулж байгаа юм бол энэ чинь л яг тохирох ажил юм биш үү? Хейген хэлэлцээр хийх урлагт Их Эцгээс өөрөөс нь суралцсан тул хараал зүхлийг ер тоосонгүй. Хэзээ ч уурлалгүй, айлган сүрдүүлэлгүй, тайван сонсож, цаад хүндээ эрүүл ухаанаар тунгаан бодох бололцоо олгож бай гэж Их Эцэг сурган зөвлөдөг бөлгөө. Ямар ч доромжлолыг, заналхийллийг үл анхааран хүлцэнгүй, амгалан байх нь л гол урлаг бөгөөд нэгэн удаа Хейгений дэргэд Их Эцэг найман цагийн турш ихэмсэг зан шүгэлсэн нэг дээрэмчний хараал ширээлийг сонсож сууснаа ширээ тойрон налайсан бусад хүмүүст хандаж:

- За за, энэ хүн тайван ярьж, учраа олохыг ер хүсэхгүй байна, больё - гээд босч үүд рүү алхжээ.

Сайхь дээрэмчин үнхэлцэг хагартлаа айж, Их Эцгийн хойноос гүйж очоод буцааж авчирсан аж. Яриа хэлэлцээр эвтэй найртай тарсан боловч хоёр сарын дараа тэр дээрэмчинг үсээ засуулж суухад нь буудаж алсан гэдэг.

Хейген ч гэсэн ердийн, намуун дуугаар бүр эхнээс нь эхэлж:

- Та энэ нэрийн хуудсыг минь үзэж болгооно уу. Би өмгөөлөгч хүн. Яалаа гэж толгой дээрээ лай хураах вэ? Би танд занаж сүрдүүлэх ганц үг хэлсэн гэж үү? Жонни Фонтейн л тэр кинонд тоглож байвал таны ямар ч болзлыг хүлээн авахад бэлэн байгаага л хэлсэн дэг. Таны ашиг сонирхолд ч нийцэх эл өчүүхэн тусын чинь төлөө хангалттай юм амласан биш үү? Жонни л буруу дуулаагүй бол, түүнийг энэ дүрд яг таарах хүн гэж та өөрөө хэлсэн биз дээ? Тэгээгүй бол бид яалаа гэж тан дээр ирэх билээ? Түүгээр ч үл барам, хэрэв та хөрөнгө мөнгөний талаар зовоод байгаа бол миний найз тэр киног бүхэлд нь ч санхүүжүүлж чадна. Харин та миний үгийг зөв л ойлгож үзээрэй. Үгүй бол үгүй л биз, хэн ч таныг албадахгүй, тэгэх ч гээгүй. Бас нэг зүйлийг зүрхлэн нэмж хэлэхэд, манай толгойлогч эрхэм Гувер та хоёрын үерхдэгийг мэддэг, их ч хүндэлдэг билээ.

Вольц нугасны том өдөнд суулгасан улаан үзгээр цаас сараачиж сууснаа мөнгөний тухай сонсмогц толгой өлийн анхааралтай сонсож эхлэв.

- Төсөвт зааснаар бол эл кино бүтээхэд таван сая доллар шаардагдана. Хейген ийм их тоонд гайхсан хүн болж исгэрээд авснаа, тун тоомсоргүй дуугаар:

- Манай толгойлогчид ямар ч эхлэлийг нь бүрэн дэмжих олон найз бий - гэлээ.

Одоо л Вольц түүнийг үнэхээр тоож үзэв бололтой, нэрийн хуудсыг нь гүйлгэн харав.

- Таны тухай урьд ер сонссонгүй. Нью-Йоркдоо томоохонд тооцогдох ихэнх өмгөөлөгчийг би

танина. Харин та хаанаас гараад ирсэн юм бэ?

- Би нэгэн буурьтай пүүсийг төлөөлж яваа хүн. Түүний ажлаас өөр асуудлаар оролддоггүй. За, за таны цагийг үрэхээ больё - хэмээн Хейген хөндий дуугараад босч гар сунгасанд Вольцыг гар атгахаар нь хаалга тийш хэд алхсанаа эргэж харлаа.

- Та гол төлөв сүрхий том хүн болж харагдах гэсэн шалихгүй улстай уулзаж учирч явсан юм шиг байна. Харин би бол шал өөр хүн шүү. Та миний тухай хэн нэгийг маань таних хүнээс асууж лавлавал яасан юм бэ? Шинэ юм сэдвэл зочид буудал руу угасдаарай. Та итгэхгүй байж магадгүй, гэхдээ л таны түнш эрхэм Гуверийг ч бууж өгөхөөр юмыг хийж дөнгөх хүн шүү - гэхэд нь Вольц сая л ухаж ойлгов бололтой нүдээ онийлгохыг Хейген ажиглаж амжлаа. Энэдээ л гэж хэлэхэд би таны киног их таалдаг хүн. Энэ буянт үйлээ үргэлжлүүлэхэд чинь хэн ч саад хийхгүй байх гэж найдна. Эх орон чинь танд баярлалаа л гэж хэлэх болно.

Орой болж байтал найруулагчийн нарийн бичгийн дарга угасдаад, барагцаалбал нэг цагийн дараа машин очиж, хотын дүүрэг дэх Вольцийнд, үдшийн зоогонд аваачина - гэж хэллээ. Гурван цаг орчим явах хэдий ч хөргөгч дотор архи дарс, хөнгөн зууш бий гэнэ. Вольц харихдаа онгоцоор нисдэгийг Хейген сайн мэднэ. Харин яагаад хамт нисье гэж урьсангүй вэ?

Нарийн бичгийн дарга ялдам дуугаар цааш үргэлжлүүлэн:

- Таныг юм хумаа аваад гараарай, өглөө нисэх буудал шууд хүргэж өгнө гэж эрхэм Вольц хэлүүлсэн шүү - хэмээв.

- За, ойлголоо.

Бас л хачин юм. Түүний өглөөгүүр Нью-Йорк руу нисэх гэж байгааг Вольц яаж мэдэв ээ? Тэр хэсэг зуур бодолд дарагдав. Вольц түүний араас хувийн мөрдөгч тавьсан юм байх даа. Тэгвэл Вольц түүнийг Их Эцгийн нэрийн өмнөөс хэлэлцээр хийж явааг мэдээд, түүний тухай зарим нэгэн ойлголт авсан байж таарна. Тэгэхлээр эл асуудалд суурьтай хандаж, ажил бүтээж ч юу магад хэмээн Хейген бодно. Вольц өглөөнийхөө харагдсанаас илүү ухаантай ч хүн байж магадгүй шүү дээ.

Жек Вольцын эдлэн газар киноны тайз засал шиг үзэсгэлэн төгөлдөр харагдана. Боол эзэмшигч газрын эзний ордон шиг том байшин, асар уудам цэцэрлэг, цаана нь үржил шимтэй хар хөрст газраар дурайсан морин тойруулгын зам, агтны жүчээ, сүрэг адуу ч элбэг сэлгүүцэхээр бэлчээртэй ажээ. Бут сөөгөн хашаа, цэцгийн мандал, зүлэг ногоог моод хөөцөлддөг кино жүжигчний халимаг шиг арчилж торджээ.

Вольц сэрүүцүүлэх сэнс тавьж шиллэсэн тагт дээр Хейгенийг гэрийн хувцастай угтав. Хөх торгон цамц, эмч шиг шав шар өмднийх нь тод өнгө ширмэл царайтай нь харшин тун содон солонгорох ажгуу. Тэрбээр цар дээрээс хоёр өндөр шилэн аягатай мартини дарс авч нэгийг нь Хейгенд сарвайв. Вольц өглөөнийхөөсөө хамаагүй найрсаг зан гаргаж, Хейгенийг мөрөөр нь тэвэрч авлаа.

- Үдшийн зоог болтол жаахан зав байна. Миний морьдыг очиж үзье. Би таны тухай асууж сурагласан. Том оо, та Корлеонегийн зөвлөх гэдгээ эртхэн хэлэхгүй, тун тоогүй юм болжээ. Би анх Жоннигийн хөлсөлж авсан дунд зэргийн нэгэн зальтайхан эр намайг айлган сүрдүүлэхээр дөвчигнөж байна гэж бодсон юм. Харин намайг сүрдүүлэх гэвэл ч барахгүй л дээ. За за, ийм дэмий юм ярьж сэтгэлдээ сэв суулгахаа больё. Ажил хэргийн талаар дараа ярьсан ч хожимдох юмгүй.

Хамгийн хачирхалтай нь Вольц үнэхээр зочломтгой эзэн ажээ. Тэрбээр шинэ санаа сэдэж, Америкийн бүх морин заводыг давж ойчих гэж байгаа тухай дэлгэрэнгүй ярьж сонирхуулав. Бүхэлд нь галд тэсвэртэй эдээр барьсан агтны жүчээг бүртийх ч хоггүй, үнэхээр цэвэр цэмцгэр байлгаж, хувийн мөрдөгч нарын тусгай бүлгээр хамгаалуулдаг юм байна. Дараа нь тэрээр: «Хартум гэсэн хүнд хүрэл пайз хадсан саравчинд дагуулан очлоо.

Морь мал огт мэдэхгүй Хейген хүртэл тэр саравчинд байгаа азарга ямар сайхан амьтан болохыг хараад л мэдэв. Гагцхүү духандаа сартай, давирхай шиг тас хар зүстэй, хонин бор нүдтэй Хартумын тарган хондлой нь хээгүй торго шиг гялалзах ажгуу.

- Хорвоод хосгүй ажнай даа. Ноднин жил Англиас зургаан зуун мянгаар авсан юм. Оросын хаад ч гэсэн ганц моринд ийм их үнэ өгч байгаагүй, итгэж үзээрэй. Гэхдээ үүнийг би уралдуулахгүй, зөвхөн үүлдэр сайжруулахад л хэрэглэж, Америкт урьд өмнө үзэгдэж харагдаагүй ажнай хурдан хөлгүүдтэй болно доо. Би тавь хүрсэн хойноо анх морь унаж сурсан гэхэд овоо дажгүй унадаг юм шүү. Эмэг эхийг минь оросын хасаг эр оролдож, надад Хасагийн цус байгаа ч юм билүү, хэн мэдлээ гээд Вольц азарганы цавийг маажин эрхлүүлснээ: - Энэ мөн мундаг эдтэй амьтан шүү. Надад ийм юм заяадаг ч болоосой - хэмээн атаархангуй дуугарав...

Тэд байшинд буцаж ирлээ. үдшийн зоог дээр гурван зарц бойдаагийн хяналтын дор үйлчилж, алтан утсаар гоёж шагласан бүтээлэгтэй ширээн дээр мөнгөн тавгаар хоол зууш зөөж тавих боловч амт нь Хейгенд тааруухан санагджээ. Вольц ганцаараа амьдардаг болохоор хоол унданд нэг их анхаарал тавьдаггүй юм болов уу даа. Хейген хүлээгээд ажил хэргээ ярихгүй сууснаа. Вольц тэр хоёр гаваны бүдүүн навчин янжуур асаасан хойно сая ам нээлээ.

- Та тэгээд, Жоннид тэр дүрийг өгөх гэж байна уу, үгүй юу?

- Чадахгүй. Хүсэл байлаа ч гэсэн Жонниг энэ кинонд тоглуулах ямар ч бололцоо байхгүй, Оролцох бүх хүмүүстэй гэрээ байгуулж, гарын үсэг зурчихсан, дараачийн долоо хоногт зураг авалт эхэлнэ. Одоо би ч гэсэн ямар нэг юм өөрчилж чадахгүй.

Хейгений тэсвэр алдарч байгаа бололтой:

- Ноёнтон Вольц, хэнд ч захирагдах албагүй хүнтэй ажил хэрэг ярихад иймэрхүү төрлийн санаа бодлыг тоохгүй өнгөрч болдог нэг давуу талтай. Хүссэн бүхнээ хийх эрх мэдэл танд бий. Миний түнш амласнаа биелүүлж чадна гэж та итгэхгүй байна уу? - гэвэл Вольц хөндий хүйтэн хариу үгүүлрүүн:

- Үйлдвэрчний эвлэлийнхний зүгээс надад эвгүй юм тохиолдож болох л юм. Гофф над уруу

утасдсан л даа. Тэгэхдээ жил бүр надаас зуун мянган доллартой дугтуй авч өвөртөлдөггүй юм шиг яаж дээрэнгүй ярьсан гэж бодно, муу новш! Бас тэр нэг эр хүний шинжгүй жүжигчин шүү юмыг та нар героиноос салгаж чадна гэж бодъё. Харин энэ бүхэнд би сэтгэл их зовохгүй байна. Би өөрөө ч гэсэн киногоо санхүүжүүлж дөнгөнө. Хамгийн гол нь би тэр шаар Фонтейныг үзэн яддагт л байгаа юм. Энэ бол миний татгалзахаас өөр аргагүй цорын ганц хүсэлт гэдгийг та эзэндээ дамжуулаарай. Өөр ямар ч хүсэлтийг нь би дуртай биелүүлнэ.

Тэгвэл энэ муу өгөр толгой ямар чөтгөрөө хийж намайг ийш нь чирсэн юм бол гэж Хейген бодлоо. Найруулагч лав л нэг зүйлийг сэдсэн бололтой.

- Та энэ асуудлын талаар арай ташаа ойлголт авсан болов уу гэж айх юм. Ноён Корлеоне Жонни Фонтейны загалмай зүүлгэсэн эцэг нь тул сүм хийдийн ивээн соёрхсон дотнын харилцаатай байдаг - хэмээн Хейгений учирлахад Вольц ердөө л хүндэтгэн толгой гилжийлгэсэнд тэрээр цааш үргэлжлүүлэв. - Алдаж онодог алаг эрээн хорвоо дээр амь зуух тун бэрх тул хоёрдахь эцэг, өөрөөр хэлбэл загалмайлан эцэггүй бол баларч гүйцнэ гэж италичууд ярьдаг. Гэтэл Жоннигийн төрсөн эцэг нь нас барчихсан болохоор ноёнтон Корлеоне өөрийн хариуцлагаа онц гүнзгий ухамсарлаж байгаа билээ. Харин ноёнтон Корлеоне нэг удаа татгалзсан хүнтэй дахиж уулздаггүй, хэтэрхий ёсорхуу хүн тул өөр тусламж гуйх талаар ярихын ч хэрэггүй.

Вольц яг л дэлбэртлээ уурлах тохиромжтой мөчийг хүлээгээд сууж байсан гэлтэй дүрсхийв.

- Би таныг маш сайн ойлголоо. Уран хөхөө шиг уяхан донгодоод, үнэн чанартаа айлган сүрдүүлдэг мафийн л арга зам байна. Илэн далангүй ярилцъя. Жонни Фонтейн яг л энэ дүрд зориулагдаж төрсөн боловч хэзээ ч тоглож чадахгүй. Тэр энэ дүрд л тоглох юм бол дэлгэцийн агуу их оддын тоонд орох нь гарцаагүй үнэн. Ганцхан энэ дүрийг авч л чадахгүй. Яагаад гэвэл үймээн самууны дуу хоолой болсон тэр булай амьтныг би үзэн яддаг, удахгүй кино урлагаас хөөж, хөсөр шидэх гэж байгаа юм. Хамгийн гол нь тэрээр миний ганц горьдлого тавьж байсан, өсөх ирээдүйтэй нэг жүжигчинг хөнөөж дууссан. Би хэдэн зуун мянган доллароор тэр хүүхэнд дуу хөгжим бүжиг, жүжгийн урлаг заалган таван жил сургаж, киноны од болгох санаатай байсан юм. Бүр ч ний нуугүй хэлэхэд, хэргийн гол нь зөвхөн мөнгө хөрөнгөнд байгаа юм биш. Тэрээр гоц хөөрхнөөс гадна үүлэн борооны ажилд түүнээс гаргуу хүүхнийг би үзээгүй. Гэтэл би гэдэг чинь хорвоо дэлхийгээр хэрэн тэнэхдээ олныг үзсэн толгой шүү. Гэтэл итали оперын дур булаах увидастай, нялуун дуутай Жонни хүрч ирээд түүнийг аваад талийдаг байна. Тэр хүүхэн бүхнийг түүгээр сольж, намайг хүн болгоны элэг доог болгосон. Эрхэм Хейген миний зиндааны хүн бүгдийн доог тохуу болох нь энэ насны гутамшиг учир би Фонтейнээс хариугаа заавал авах учиртай.

Чухам одоо л Хейген үнэхээр гайхаж хоцорчээ. Ийм хөрөнгө бэлтэй, тохитой томоотой, нас тогтсон хүн үнэндээ ноцтой хэрэг шийдвэрлэж байхад тийм үл ялих, хөгийн юмаар хөөцөлдөнө гэж ер байх уу? Корлеонегийн хүрээлэлд, Хейгений ертөнцөд эмэгтэй хүний гоо сайхан, энгэр зөрүүлэх чадвар ажил хэргийн асуудалд ямар ч хамааралгүй, гагцхүү гэрлэх буюу гэр бүлийн нэр төр хамгаалахаас бусад тохиолдолд тухайн хүний хувийн хэрэг гэж үздэг бөлгөө. Хейген эцсийн удаа оролдоод үзэхээр шийдэв.

- Ноёнтон Вольц, таны зөв л дөө. Гэхдээ таны энэ гомдол тийм их ноцтой юм уу даа? Миний

бодлоор, мөн чанартаа шалихгүй энэ гуйлт түншийн минь хувьд ямар чухал ач холбогдолтойг та нэг л гүйцэд сайн ухахгүй байх шиг байна. Ноёнтон Корлеоне Жонниг өлгийтэй байхад нь тэвэрч загалмай зүүлгэсэн хүн. Жоннигийн аав нас барахаар эцгийн нь үүргийг ноёнтон Корлеоне өөртөө хүлээсэн. Ер нь түүний ач тусын хариуд талархаж, хүндэтгэлээ илэрхийлэх гэсэн маш олон хүн Загалмайлан эцгээ гэж өргөмжилдгийг болгоож үзээрэй. Ноёнтон Корлеоне анд найз нартаа гай зовлон учирсан үед хэзээ ч орхиж байгаагүй юм шүү.

- За боллоо, яриа дууслаа. Шальдар бульдар банди нар л надад болзлоо тулгах нь дутаад байж гэнэ. Харин би л бусдаас өөрийн хүссэнийг шаардах ёстойсон. Би зөвхөн харилцуур авахад л хонгор минь та төмөр торны цаана жиргэж сууна гэж мэдээрэй. Танай тэр тонуулчин чинь их оролдох гэвэл намайг нөгөөх эстрадын дуучин шиг нь хулчгар эр биш гэдгийг тун удахгүй мэдрэх болно. Тийм ээ тийм, би тэр паянг сонссон. Танай ноёнтон Корлеонег чинь үнсэн товрог болгож орхино шүү. Үүний тулд би Цагаан ордон дахь бүх танил талаа ашиглахаас ч сийхгүй шүү.

Ээ маанаг, ёстой мулгуу амьтан юм аа! Ийм хүн яаж байгаад ерөнхийлөгчийн зөвлөх, дэлхийд хамгийн томд тооцогдох кино үйлдвэрийн эзэн болчихдог байна аа? Үнэхээр Их Эцэг кино бизнест хөрөнгө оруулбал зүгээр юм биш үү? Тэгээд ч болоогүй энэ тэнэг чинь далд утга гээчийг ер мэдэхгүй, үг болгоныг шууд дуудлагаар нь үсэгчилж ойлгоод байх гайхал юм...

- Амттай хоолоор дайлсан явдалд талархлаа илэрхийлэхийг зөвшөөрнө үү. Та намайг нисэх буудалд хүргүүлэн тус болохгүй юу? Би энд хономооргүй байна. Ноёнтон Корлеоне таагүй мэдээг шууд дуулахыг илүүд үздэг юм - гээд Хейген Вольц өөд хүйтнээр харж зэвүүн инээмсэглэжээ.

Хейген тольдуураар гэрэлтүүлсэн өндөр баганануудын дэргэд машин хүлээгээд зогсож байхдаа орцны үүдэн дэх урт хар лимузинд хоёр эмэгтэй суухыг харсан нь өглөө Вольцын хүлээх өрөөнд байсан ээж, арван хоёр настай алтан шаргал үстэй охин хоёр ажээ. Харин одоо тэр охины сэвгүй хөөрхөн уруул нь бамбайтлаа хавдаад, ямар ч хэлбэр галбиргүй бөөн улаан юм болж, гүн цэнхэр хоёр нүдэнд нь булингар суугаад урт турьхан хөл нь дөнгөж төрсөн янзаганых шиг өвдгөөрөө нугарах алдан салганана. Эх нь түүнийг түшин машины арын суудалд суулгах зуураа чихэнд нь нэг юм шивнэн захирамжлах ажээ. Дараа нь Хейген тийш хулгайгаар хяламхийхэд махчин шувууных шиг нүдэнд нь ялж дийлсний баяр бахдал дүүрэн гэрэлтэнэ. Хормын дараа тэр авгай ч гэсэн машинд оржээ.

Үүнээс л болоод намайг Лос Анжелес уруу онгоцоор нисээч гээгүй юм байна» гэж Хейген дотроо боллоо. Вольц үдшийн зоогны өмнө жаахан амарч, энэ жаал охиныг янзлах зав гаргахын тулд ээж, охин хоёрыг авч ниссэн байх нь. Жонни ийм амьтдын дунд байх гэж юунд нь дурлаа юм бол оо? Одоо яая гэхэв, түүнд, за даа энэ Вольцод ч гэсэн амжилт хүсээд л хараад сууж байхаас өөр арга алга даа...

Поли Гатто ялангуяа нударга хэрэглэх ажлыг яаруу сандруу эхлэх тун дургүй хүн. Хэрэв нэг л алдаа гаргавал хор уршиг тарьж мэдэх ялангуяа өнөөдрийнх шиг ажлыг, ажлыг ч гэж дээ, хоёр

нусгай жаал хашраах хэргийг урьдаас төлөвлөн тооцоолж дассан билээ. Тэрээр пиво шимэнгээ баарын лангууны дэргэд охидуудтай хэлэлцээ хийж буй нөгөө хоёр залуугийн ажил хэр урагштай байгааг нүдний булангаар сэм ажиглана.

Жерри Вагнер, Кевин Мунан гэгч эл хоёр жулдырай бандийн товчхон түүх намтрыг Поли Гатто нэгд нэгэнгүй мэдэж авчээ. Тэднийг амралт нь дуусаад коллеждоо эргэж ирэхээс өмнө нэн даруй хашрааж өгөх ёстойг Клеменца түүнд дуулгасан аж. Энэ ажлыг заавал Нью-Йоркод хийдэг нь ямар учиртай юм бэ? Энэ Клеменца даалгавраа өгөөд л яаж хийхийг нь өөрсдөө мэд гээд орхичихгүй, дандаа л алхах гишгэх бүрийг зааж сургах санаатай, нохой долоо. Одоо энэ хоёр шувуухай тэр залуустай зууралдаад араас нь дагавал бас нэг үдэш дэмий өнгөрлөө гэсэн үг.

Яг энэ үеэр охидын нэг нь:

-Чи солиороо юу? Чамтай, тэгээд бас машинд уу даа? Нөгөө нэг хөөрхий охин шиг эмнэлэгт хэвгэх хэрэг гарах биз?. Больёо, чи минь! - хэмээн хор малтсан маадгар өнгөөр тас тас хөхрөх дуулав.

Поли Гаттод чухам энэ л хэрэгтэй байсан учраас пивоо дуустал уугаад гадагш гарлаа. Шөнийн нэг цаг болж, өөр ганцхан баар гэрэлтэй бусад зуушны газар, мухлагууд бүгд хаалттай, орчны байдал яг захиалгаар юм шиг байв. Цагдаагийн эргүүлийн машиныг Клеменца өөрөө дааж авсан болохоор радиогоор дохио өгөхөөс нааш хөдлөхгүй, хөдлөлөө ч гэсэн хэргийн газар уруу яст мэлхий шиг мөлхөх болно.

Поли «Шевроле»-гийн хаалга налах зуураа, мангар том биетэй хэдий ч арын суудал дээр харагдахтай үгүйтэй суусан хоёр эрд:

- Гараад ирмэгц нь бариад аваарай гэлээ.

Клеменца түүнд цагдаагийн газрын архиваас авсан хоёр гэрэл зураг өгч аль бааранд энэ хоёр залууг орой болгон ирж хүүхэн эргүүлдгийг зааж өгчээ. Поли гар хөлийн үзүүрт гүйдэг залуугаасаа арай биерхэг хоёрыг нь сонгон авч, хэнийг ямар хэмжээнд хашраах, нэг үгээр хэлэхэд толгой тархи, ар дагз уруу нь цохиж хэтрүүлчхэлгүй, гэхдээ нэг их нэрэлхэлгүй болгож тавих учиртайг тайлбарлаж өгчээ.

- Аа тийм нэг зүйлийг анхаар. Энэ хоёр хүү эмнэлэгт сар хэвтэхгүй бол. Та хоёр бахь байснаараа л жолоо мушгина гэж мэдээрэй - хэмээн Гатто сануулав.

Сайхь эрс машинаас гарлаа. Урьд өмнө тэр хоёр боксчин байсан боловч захын нэг муу спортын клубээс цааш ахилгүй, бүтэлгүйтэж явахад нь Сонни тус болж, овоо мөнгө олох бололцоо олгожээ. Одоо тэд тун дажгүй амьжиргаанд залгасан тул сайн санааг нь мартаагүй гэдгээ харуулахыг чармайх нь зүйн хэрэг буй заа.

Жерри Вагнер, Кевин Мунан хоёр баарнаас гарч ирэхдээ яг л Полигийн бодож байсанчлан, хүүхэнд доромжлуулсандаа уур нь хүрч, уушги нь сагсайчихсан байжээ. Поли Гатто машиныхаа хаалгыг хайнга түшин зогсож байснаа түсхийтэл инээд алдаад:

- Хөөе нусгай жаал минь, тэр охин чамайг сайн чадав аа? - хэмээн егөөдөв.

Дотор нь багтарч явсан залуус дуртай нь аргагүй давхиж ирлээ. Намхан нуруутай, өмхий хүрэн шиг шалчгар эрд, тэр тусмаа өөрөө өдөөд байгаа бол, уураа гаргах юутай таатай. Тэд ийн бодоод Гатто тийш гүйхээрээ дайрсан боловч яг хүрдэгийн даваан дээр араас нь нөгөө хоёр эр гарыг нь мушгин бариад авав. Поли тусгай захиалгаар хийж, богино төмөр шүд суулгасан зодуур баруун гартаа сурмаг шаламгай углаад, долоо хоногт гурван удаа биеийн тамирын зааланд очиж бэлтгэл сургууль хийдэг тул Вагнер гэдэг нусгайнх нь намалдгийг яг онож цөм цохисонд дорхноо шолбойгоод ирлээ. Энэ ажилбар ердөө л тавхан хормоос илүүгүй хугацаанд л болж өнгөрчээ.

Одоо Кевин Мунаны ээлж ирлээ. Түүнийг хашгирч гуугалж эхэлтэл боксчин болох гээд бүтэлгүйтсэн эрсийн нэг нь хүнд гараараа илээд авах шиг болтол цаадах нь сулбайгаад явчхав. Сайхь эр нөгөө гараараа Мунаны хоолойг тас базаад дуу гарах нь бүү хэл, амьсгаа авахад ч бэрх болгожээ.

Поли Гаттог машиндаа шурган орж асаах зуур, нөгөө хоёр аймаар хичээнгүйлэн хөдөлж, цохих тоолонд нь амьд махан бие урагдаж язрах эвгүй чимээ сонсогдоно. Гатто Мунаны нүүрийг гүйлгэн харвал танигдахын аргагүй болжээ. Нөгөө хоёр эр Мунаныг зам дээр гулдайсан хэвээр нь орхиод Вагнерыг барьж авлаа. Яг энэ үеэр Вагнер арай гэж хөл дээрээ босоод тусламж гуйн хашгирсанд баараас нэг хүн гуйн гарч ирсэн тул яаравчлах хэрэгтэй болов. Хоёр яргачны нэг нь Вагнерыг цохиж унагаад, нөгөө нь гарыг нь арагш мушгин нуруу уруу нь өшиглөөд авлаа. Нэг юм түсхийх шиг болж, хачин муухай орилох чимээнээр хавь ойрын бүх цонх нээгдэн хоёр эр тун шалмаг хөдөлж эхлэв. Нэг нь хоёр гараараа Вагнерын толгойг бахь шиг хавчин газраас өргөж нөгөө нь үл хөдлөх гулдайсан бие рүү нь мангар нударгаараа балбаж байх үеэр баараас бөөн хүмүүс гарч ирсэн авч хэн нь ч тэр хоёрт саад хийхийг оролдсонгүй.

- Одоо боллоо, бушуу зугтаая - хэмээн Поли Гаттигийн хашгирсанд мангар эрс машинд үсрэн ормогц Поли ухасхийн хурдлав. Хэн нэг нь хожим ямар машин байсныг дүрслэн хэлж, хэн нэг нь машины дугаарыг мэдэгдлээ ч гэсэн үүгээр л энэ хэрэг дарагдана. Дугаарыг Калифорниос ирсэн машинаас хулгайлж авсан бөгөөд харин хар «Шевроле» машин Нью Йоркод дор хаяхад зуун мянга байгаа юм чинь санаа зовох юун.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Хейген өөрийн өмгөөлөх контортоо очихоор пүрэв гаригийн өглөө эртлэн хот уруу гарчээ. Тэрбээр хожимдсон цагаа нөхөж, тав дахь өдөр Виргилия Солоцотой уулзахад бэлдэн ажил хэргийн бичиг цаасаа үзэж янзлах гэсэн аж. Энэ уулзалт маш чухал ач холбогдолтой байсан тул Солоцогийн тавих гэж буй ажил хэргийн санал хүсэлтийг хэлэлцэж, тухтай ярилцахад нэг бүтэн үдэш зориулахыг тэрээр Их Эцгээс хүссэн байна. Тийм ээ, бүх анхаарлаа Их Эцэгтэй урьдчилан зөвлөлдөхөд төвлөрүүлэхийн тулд аар саар зүйл ч саад хийхгүй байхын тулд бүх ажлаа яв цав цэгцлэх хэрэгтэй дээ.

Мягмар гаригийн үдэш орой болсон хойно Калифорниос буцаж ирээд Вольцтой хийсэн хэлэлцээр юугаар дууссан тухай Хейгенийг дэлгэрэнгүй ярихад Их Эцэг гайхсан дүр ер үзүүлсэнгүй. Тэрбээр гагцхүү өчүүхэн зүйлийг ч орхилгүй бүгдийг дэлгэрэнгүй ярь гэж Хейгенээс шаардаад, хөөрхий охин, түүний эх хоёрын тухай дуулмагц зэвүүцэн ярвайж, амандаа аяархан хараал тавив. Эл ярианы эцэст эрхэм Корлеоне Хейгенд ганцхан асуулт тавьсан аж.

- Энэ хүнд бас бэрх чанар бий юу?

Асуултын гол утгыг олох гээд Хейген хэсэг зуур чимээгүй суув. Энэ олон жил хажууд нь байхдаа ухаж мэдсэнээр, Их эцгийн баримталдаг үзэл санаа нь ихэнх хүмүүсийнхээс тэс ондоо, хэлсэн үг нь хүртэл шал өөр утгатай байдаг билээ. Вольцод эрс шийдэмгий зан, хатан зориг бий юу? Мэдээжээр байгаа. Гэхдээ Их Эцэг энэ тухай асуугаагүй нь лавтай. Аюул заналыг сөрөн зогсох эр зориг тэр найруулагчид бий юу? Түүний мэргэн дуулдаг жүжигчин мансууруулах бодис хэрэглэдэг нь илэрч шуугиан дэгдээд, үйлдвэр дээр нь ажил хаялт зарлахад хүнд ноцтой хохирлоос үл шантрах зүрх бий юу? Бас л байгаа биз. Гэвч Их Эцэг үүнийг ч бас асуугаагүй. Эцэст нь Хейген Их Эцгийн үгийн утгыг зөв ухаж: Жек Вольц зарчмаа баримталж, өс хонзон санаад, нэр төрөө хамгаалахын тулд байгаа бүхнээрээ дэнчин тавих сэтгэлийн тэнхээтэй хүн үү гэж асуусныг нь ойлгожээ.

Их Эцгийн өөдөөс наргиан наадмаар хариулж тэр болгон зүрхэлдэггүй боловч Хейген энэ удаад тэссэнгүй инээмсэглэж:

- Та түүнийг сицили эр мөн үү гэсэн юм уу? - гээд Их Эцэг түүний хошин үгийн далд утгыг ойлгон зохих ёсоор үнэлсний тэмдэг болгон сэтгэл хангалуун толгой дохихыг хараад, - үгүй, ер тийм эр биш - хэмээв.

Тэгээд л гүйцээ. Их Эцэг их ч удаан бодсонгүй, маргааш нь гэхэд л үдийн хоолны дараа Хейгенийг дуудаад зохих захирамж өгчээ. Хейген ажлын цаг хүртэл багшдаа магтуулсан сурагч шиг бөөн баяр хөөртэй байж, Их Эцэг асуудлыг зөв шийдсэн гэдэгт өчүүхэн төдий ч эргэлзсэнгүй. Маргааш өглөө л Вольц утасдаад шинэ киноны гол дүрд Жонни Фонтейн тоглох болсныг дуулгах ёстой.

Утас дуугарсан боловч энэ удаад Вольц биш, нөгөөх Америго Бонасера ярьж баярлаж талархсандаа хэлэх үгээ олж ядан, насан туршдаа эрхэм Корлеонегийн анд явахаа андгайлан,

ач тусыг нь хариулахын тулд амиа өгөхөөс ч буцахгүй гэдгээ илэрхийлжээ. Хейген эл бүхнийг Загалмайлсан эцэгт дамжуулахаар ам гарав.

«Дейли Ньюс» сонин нэвширтлээ зодуулсан Жерри Вагнер, Кевин Мунан хоёрын гэрэл зурагт гол нүүрээ ч харамласангүй. Хашир туршлагатай гэрэл зурагчин чадлаа гаргасан учир засмал зам дээр овойн хэвтээ бөөн маханд хүний гэх юм бараг үлдээгүй харагдана. Зөвхөн сохор азаар л хоёр хүү амьтай голтой үлдсэн бөгөөд харин эмнэлэгт хэр удаан хэвтэж, хэчнээн удаа мэс засал хийлгэхийг зөвхөн бурхан тэнгэр л таалах хэрэг гэж тэр сонины тайлбарт бичсэн байв. Ажил хэргээ овоо мэддэг бололтой тэр Поли Гаттод ямар нэг урамшил үзүүл гэж Клеменцад хэлэхээ мартчихгүйн тулд Хейген дэвтэртээ тэмдэглэж авлаа.

Ажил нь овоо урагштай явж Хейген гурван цаг бичиг цаастай ноцолдохдоо Их Эцгийн мэдлийн барилгын пүүс, чидун жимсний тос гадаадаас ханган нийлүүлэх компани, үл хөдлөх хөрөнгө наймаалах компанийн нягтлан бодох тайлан тооцоог нэгтгэн дүгнэв. Одоо хүртэл алдсан ч юмгүй хожсон ч юмгүй байсан боловч нэгэнт дайн дууссан болохоор энэ гурван компанийн аль аль нь орлого хөрөнгийн ширгэшгүй ундарга болох ёстой. Хейген Жонни Фонтейны тухай асуудлыг бараг мартаж дөхөж байтал нарийн бичгийн дарга нь Калифорниос утасдаж байгааг дуулгалаа. Юу болох бол гэж жаахан эвгүйрхсээр утсаа авч:

- Хейген сонсож байна - гэвэл харилцуурт хахаж цацах Вольцын дуунд байж ядталаа хорсон занх, үзэн ядах өнгө дүүрэн бялхалзаад танигдахын аргагүй ажээ.

- Өмхий муу новш минь, та нарыг шоронгийн хадаас болгохын тулд халаасаа хоослохоос ч буцахгүй гэж мэдээрэй. Би тэр Жонни Фонтейныг чинь насан туршид нь зэрэмдэг болгоно. Италийн муу шээс хүний сүг минь чи сонсож байна уу?

- Би уг нь герман-ирландын эрлийз юм шүү дээ гэж Хейген эелдэгхэн дуугарсанд Вольц хэсэг зуур чимээгүй байж байснаа харилцуураа шидчихлээ. Вольц эрхэм Корлеонег ганц үгээр ч дурсаагүй тул Хейген таатай жуумалзав. Сургамжилж хэлсэн үг нь элсэнд асгасан ус шиг сураггүй алга болоогүй нь яамай даа.

Жек Вольц ганцаараа унтаж дасжээ. Түүний орон дээр арван хүн элбэгхэн багтахаар, унтлагын өрөө нь цэнгээнт бүжгийн зураг ч авч болохоор уужим боловч тэрбээр эхнэрээ нас барснаас хойш арван жилийн турш ганцаараа унтаж байгаа билээ. Энэ нь түүнд эмэгтэй хүн хэрэггүй боллоо гэсэн үг биш л дээ. Хэдийгээр тэр нас тогтсон, бас ч эр чадал нь бүрмөсөн буурчхаагүй боловч гагцхүү цэл залуугаараа, бараг балчир шахуу охид л түүний сэрлийг хөдөлгөж, дур хүсэл хүч чадал нь хоёр цагийн жаргалд л хүрэлцэх төдий болжээ.

Энэ пүрэв гаригт тэрээр яагаад ч юм өглөө эрт сэрчихжээ. үүр Дөнгөж хаяарч байсан боловч асар уужим унтлагын өрөөнд бүрэнхий хэвээр. Хэмжээгүй том орных нь хөлд морины толгой шиг хэлбэртэй нэг юм бүртэлзэж үзэгдсэнд нойрноосоо гүйцэд сэрээгүй Вольц тохойлдон өндийснөө сайн харахын тулд гэрлээ асаалаа.

Тэр зүйлийг олж хараад Вольц гэнэтийн аюулт өвчинд нэрвэгдсэн хун шиг нам цохиулав.

Цээж рүү нь хүнд лантуугаар буулгаад авах адил санагдан зүрх нь нэг хэсэг зогссоноо дараа нь галзууран цохилж, тэрбээр шууд л тансаг сайхан хивсэн дээр бөөлжиж орхилоо.

Орны хөлд цус нөждөө хутгалдсан, тас хар үстэй алдарт азарга Хартумын толгойг бэхэлсэн байж! Судас шөрмөс нь цагаан утас лугаа адил санжганан унжиж, амнаас нь хөөс сахран, шаргал туяатай алим шиг том нүдэнд нь булингартай цус хурж гөлийсөн нь ялзарсан жимс шиг ёозгүй харагдана. Вольцын толгойтой үс нь өрвийн үхтлээ айсандаа хүний бус хоолойгоор зарц нараа дуудаж, тэр эрчиндээ Хейгенд утасдаж мэддэг бүх хараалаа дуусгасан юмсанж. Түүний ийнхүү галзуурсан мэт дөвчигнөж гарахаар нь бойдаа сандраад түүний хувийн эмч, туслах найруулагч хоёрыг дуудсан боловч тэднийг ирэхэд Вольц биеэ барьж амжсан байлаа.

Вольц үнэхээр цочирдон балмагджээ. Зургаан зуун мянган доллароор худалдаж авсан ийм сайхан ажнай хүлгийн толгойг авчих зүрхтэй чинь хүн үү, араатан уу, хэн байх вэ? Ямар ч урьдчилан сануулга үгүйг энэ туйлшралаас зайлсхийж хэл амаа ололцохыг оролдсон ч юмгүй, аливаа бүх үнэт зүйлсийг бүрэн тоомсорлохгүй байгаа хүн чинь өөрийн хүсэл зоригоос ангид хууль, өөрөөсөө бусад бурхныг үл хэрэгсдэг байж таарна. Тэгээд бас ямар ч харуул хамгаалалт саад болж чадахааргүй тийм хүч чадалтай, овжин зальтай хүн байх нь. Яагаад гэвэл ажнайд эхлээд нойрны эм өгч, дараа нь толгойг нь сүхээр яарч тэвдэлгүй цавчиж авсан болохыг тэр үеэр олж тогтоосон байлаа. Шөнийн манаач нар юу ч сонсоогүйгээ андгайлан тангараглах боловч тэднийг хахуульдсан хэмээн үзээд Вольц ер итгэсэнгүй, сайн тамлаад өгвөл хэн мөнгө атгуулсныг хэлэхгүй хаачхав гэж шийдсэн юмсанж.

Вольц тийм ч тэнэг биш, гэхдээ дээд зэргээр биедээ эрэмшсэн хүн байсан тул эрхэм Корлеонегээс хүчээр илүү гэж ихээхэн эндүүрсэн бөгөөд үүнийг нь ойлгуулахын тулд нотолгоо баримт хэрэгтэй болсон аж. Харин энэ удаад тэрээр хэдий их баян чинээлэг, АНУ-ын Ерөнхийлөгчтэй уулзаж учирдаг, FBI-ын даргын дотнын найз ч гэсэн, ердөө л Италиас чидун жимсний тос оруулж нийлүүлдэг нэг хэр тааруухан эр түүний амь насыг хөнөөчхөж дөнгөх нь байна гэдгийг тун зөв ухаж авчээ. Жонни Фонтейнд таалагдсан ролийг нь өгсөнгүй гээд л түүнийг цааш нь харуулчих гэж байна. Энэ тун санаанд багташгүй хэрэг. Ийм бузар юм хийх эрх хэнд ч байх ёсгүй! Хүмүүс ингэж дураараа дургиж, дунд чөмгөөрөө жиргэх болсон бол замбуулин дээр нэг л юм зөрчигдөн, тэс өөрчлөгджээ. Ингээд ирэхлээр чи халаасандаа байгаа мөнгө, харьяандаа байгаа үйлдвэр, бурхнаас заяасан эрх мэдлээ өөрийн хүссэнээр ашиглаж эзэмших аргагүй гэсэн үг. Коммунизмоос долоон дор энэ аюулт халдварыг хэрхэвч тарааж болохгүй.

Эмч нь түүнд тайвшруулах эм өгсний ачаар Вольц биеэ барьж, уур цухлаа даран, сийрэг сэтгэх чадвартай боллоо. Дэлхий даяар нэр алдар нь цуурайтсан, зургаан зуун мянгын үнэтэй ажнай сайхан хүлгийг нь тэр Корлеоне юман чинээ тоолгүй хөнөөсөнд л Вольц бүхнээс илүү балмагджээ. Зургаан зуун мянга шүү. Гэтэл энэ бол зөвхөн эхлэл нь гэж бодмогц тэрбээр нуруугаар нь хүйт оргиод явчихлаа. Тэр өөрөө махран зүтгэж явж бий болгосон аж амьдралаа эргэцүүлэн бодов. Тэрээр одоо хэмжээгүй бэл хөрөнгөтэй, хорвоогийн ямар ч хөөрхөн хүүхнийг хуруугаараа даллаж, гэрээ контракт амлаад л эрхэндээ оруулах увидастай, хаан ван, хатад авхай нар түүнийг хүндэтгэн хүлээн авалт хийдэг, ер нь л хөрөнгө мөнгө, эрх мэдлийн хүчээр хүний амсаж эдэлж болох жаргал цэнгэл бүгд байхад нэгэн ялихгүй адармаа зангаас

болоод ийм амьдралаараа дэнчин тавих гэдэг ёстой солиорсон хэрэг биз ээ. Ээ чааваас, тэр муу Корлеонег бариад авдаг ч болоосой! ...Уг нь адуу мал алсан хүнийг хуулиар яаж шийтгэдэг юм бол?

Тэрээр галзуурсан мэт тачигнатал хөхөрч, эмч зарц нар нь түүнийг айж цочсон нүдээр ширтэв. Дараа нь түүний толгойд огт өөр бодол харван орж ирлээ.

Үл бүтэх нэг увайгүй эр ичгүүр сонжуургүй аашилснаас л болоод Калифорни даяар шившгээ тарих аюул түүнд тулгараад байна. Үүнээс гадна нөгөө гайхлууд түүнийг зүгээр ч нэг алчихгүй, урьдахаасаа илүү ухаан зарсан аюултай, аймаар залхаал нөөцөлж үлдсэн юм биш байгаа гэсэн бодол бүхнийг шийдвэрлэв.

Вольц тушаал лүндэн ээлж дараагаар буулган шадар хүмүүсээ бүгдийг хөдөлгөж эхэллээ. Эмч зарц нарыг үхтэл нь айлган сүрдүүлж байгаад амаа хамхиж явах андгай тангараг гаргуулж авсны хажуугаар алдарт ажнай хурдан Хартумыг Европоос авчирч явах замдаа хорт өвчнөөс хамгаалж чадсангүй алдчихлаа гэж сонин хэвлэлийнхэнд мэдэгдсэн аж.

Зургаан цагийн дараа гэхэд л шинэ киноны ерөнхий найруулагч Жонни Фонтейнд утасдаж, даваа гаригаас ажилдаа ор гэсэн байна.

Тэр орой Хейген маргаашийн Виргилия Солоцотой хийх онц чухал уулзалтад бэлтгэхээр эрхэм Корлеонегийн өрөөнд орж ирэхэд Их Эцэг ууган хүүгээ бас дуудуулсан байв. Сонни Корлеонегийн нүүр царай нь зэвхийрч эцэж цонхийгоод виски архинаас залхуутай нь аргагүй балган тавин суухыг хараад нөгөөх бэрийнхээ найз дээр очсоор л байгаа юм байна, ядаж байхад бас л надад төвөг удах нь гэж Хейген бодлоо.

- Та шаардлагатай бүх юмыг мэдэж чадав уу? - хэмээн эрхэм Корлеонегийн асуусанд Хейген хавгастай бичиг цаасаа гаргав. Түүнд нь хожим гай тарих юм юу ч үгүй, зөвхөн өөрөө л гаргах өөрт нь л ойлгогдох тэмдэглэл байх аж.

- Солоццо манайхаас дор хаяхад сая доллар зээлэн хууль шүүхээс хаацайлуулах хүсэлт тавихаар ирнэ. Үүний хариуд бид ажилд нь хувь хамжиж оролцоно. Харин ямар хэмжээгээр гэдэг нь тодорхойгүй байна. Солоццо энэ хэрэгт бас л хувь оролцож байгаа Тагтальегийн намыг төлөөлж яваа хүн. Би мансууруулах бодис наймаалах тухай яриад байна. Солоццо Түрэгт намуу цэцэг тарьдаг хүмүүсийг таньдаг, тэндээс түүнийг Сицилд аваачихад амархан. Сицилд тэр намуу цэцэгнээс героин хийдэг нь тийм ч их аюултай зүйл биш бололтой. Хамгийн төвөгтэй нь мансууруулах бодисыг нааш нь оруулж борлуулах явдал, тэгээд ч бас Солоццод гарааны бэл мөнгө багавтар байгаа. Сая доллар гэдэг чинь ямар гудамжинд хэвтэж байдаг эд биш.

Эрхэм Корлеоне ажил хэргийн ярианд сул дэл, уянгын үгс хэрэглэхийг тэвчиж чаддаггүй тул дургүйцэн ярвайхыг хараад Том Хейген яаран сандран цааш үргэлжлүүлсэн нь:

- Солоцод Түрэг гэж хоч өгсөн. Яагаад гэвэл нэгдүгээрт, олон жил Түрэгт амьдарч, эхнэр. хүүхэдтэй болсон гэж ярилцдаг. Хоёрдугаарт: сав л хийвэл хутга гаргадаг, гэхдээ ажил хэргийн ашиг сонирхлын үүднээс үнэхээр болохгүй бол тэр шүү дээ. Уг нь их ухаантай, хэнд ч бууж өгөхгүй хүн. Бас их юм үзсэн, хоёр ч удаа аавын хаалга татаж үзсэн. Италийн ч, Нэгдсэн улсын ч засаглал түүний мансууруулах бодис наймаалдгийг сайн мэднэ Иймээ тиймээ юм болвол янз нь бидэнд ашигтай байж болох юм. Ийм намтар түүхтэй, тэгээд ч түүнийг толгойлогч гэж үзэх тул Солоццо хэзээ ч шүүх дээр гэрчилж мэдүүлэхгүй. Энд, Америкт бас эхнэртэй, гурван хүүхэдтэй болохоор тэднийгээ сайн сайхан аж төрж байгааг мэдвэл хэдэн ч жил шоронд суухдаа бусдыг илчилж барьж өгөхгүй хүн дээ.

Эрхэм Корлеоне навчин янжуураа баагиулан:

- Сантино, чи юу гэж бодож байна? - гэлээ.

Хейген Соннигийн юу гэж хэлэхийг сайн мэдэж

байв. Сонни гар хөлийн үзүүрт гүйж залхаад, одоо энэ Солоцогийн санал болгох гэж байгаа шиг томоохон ажлыг бие даан эрхлэхийг хүсч байгаа нь лав.

- Цагаан нунтаг чинь их мөнгө, гэхдээ хорин жилээр ч шоронд орчхож болохуйц аюултай ажил. Харин яг ажиллагаанд нь биечлэн оролцолгүй, зөвхөн санхүүжүүлэн хамгаалах үүрэг хүлээвэл муугүй санаа биш үү?

Хейген түүн рүү таашаан харлаа. Илэрхий давуу талыг нь онцолж дурдана гэдэг түүний хувьд хамгийн зөв арга.

Эрхэм Корлеоне дахиад л навчин янжуураа баагиулав.

- Чиний санал ямар байна, Том оо?

Эрхэм Корлеоне Солоцогийн саналд татгалзсан хариу өгөх гэж байгааг Хейген ойлгоод илэн далангүй ярихаар шийдсэн юмсанж. Хамгийн гайтай нь гэвэл, эрхэм Корлеоне бүгдийг урьдчилан тооцоолж чадаагүй ховорхон тохиолдлын нэг нь энэ байлаа.

- За, Том минь, яриад байгаарай. Цэвэр цусны сицили зөвлөх хүртэл тэр болгон эзэнтэйгээ санал нийлдэггүй шүү дээ - хэмээн эрхэм Корлеоне түүнийг зоригжуулсанд бүгд инээлдлээ.

- Нэгэнт шалтгаан тодорхой болохоор энэ саналыг га зөвшөөрөх нь зүйтэй болов уу. Хамгийн гол нь мансууруулах бодис бусад ямар ч юмнаас илүү орлоготой. Хэрэв бид татгалзвал Тагтальягийн намаас өгсүүлээд бусад нь дорхноо шүүрээд авна. Тэд ийм их орлого олох юм чинь улс төрийн хүрээ, цагдаагийн газарт нөлөө ихтэй болж, улмаар бидэнтэй өрсөлдөн, одоо бидний мэдэлд байгаа зүйл рүү ч халдан дайрах болно. Дэлхийн улс төрийн бодлого ч гэсэн яг

адил, нэг гүрэн зэвсэгтэй болбол нөгөөх нь бас л

?зэвсэглэлээр хөөцөлддөг шүү дээ. Хэрэв бусад нам бүлгүүд санхүүгийн хувьд хүчирхэгжвэл

бидэнд аюул занал учруулна. Бид мөрийтэй тоглоомын газар, үйлдвэрчний эвлэлүүдийг гартаа барьж байна. Энэ бол манай гол хуч боловч хамгийн ирээдүйтэй нь мансууруулах бодисын наймаа лавтай мөн. Энэ хэрэгт хувь нийлүүлэн оролцох хэрэгтэй, тэгэхгүй бол одоо байгаа бүхнээ алдаж болзошгүй гэж бодож байна. Одоохондоо үгүй юмаа гэхэд арван жилийн дараа гарцаагүй алдана.

Энэ үгс эрхэм Корлеонед нэгийг бодуулав бололтой янжуураа баагиулангаа:

- Энэ чинь тун чухал мэдээ байна. Тэр бурханд тэрсэлсэн эртэй хэзээ уулзах билээ? - гээд санаа алдан бослоо

- Маргааш өглөө арван цагт - гэхдээ Хейген Их Эцгийг зориглон шийдэж магадгүй хэмээн горьдлого тасраагүй байв.

- Та хоёр тэр уулзалт дээр байлцана шүү гээд эрхэм Корлеоне хүүгийнхээ тохойноос атгав. - Сантино чи бүр нүднээс гарчхаж, ядахдаа өнөөдөр сайн унтаж амраарай. Залуу нас мөнх биш, биеэ бодоорой.

Эцэг хүний энэ халамжид урамшсан Сонни Хейгений зүрхлээгүй зүйлийг зориг гарган асуулаа.

- Аав аа, та ямар хариу өгөх гэж байна вэ?

- Ямар ч нарийн ширийн зүйл, тоо тооцоог мэдээгүй байж би одоо юу хэлэх вэ? Түүнээс гадна би та хоёрын саналыг сайн тунгааж бодох хэрэгтэй байна. Ер нь би яаруу түүхий шийдвэр гаргадаг хүн биш шүү дээ.

Түрэг хэмээх Солоццо ихэмсэг зантай намхан загзгар биетэй, бор арьстай, муухай харцтай хар нүдтэй, шувтан мурий хамартай, үнэхээр ч түрэг хүнтэй төстэй харагдана.

Сонни Корлеоне түүнийг хаалган дээр угтан авч, Хейген Их Эцэг хоёрын хүлээж буй ажлын өрөөнд дагуулж орлоо. Люка Бразиг л тооцохгүй бол үүнээс илүү аюултай амьтантай амьдралдаа учраагүй юм байна гэж Хейген дотроо бодож зогсжээ.

Бүгд эелдгээр гар барин мэндлэх зуур, хэрэв энэ мөчид бат бэх чанар бий юу гэж Их Эцэг асуувал бий хэмээн хариулах юм байна гэж Хейген бас бодож амжлаа. Эрхэм Корлеонед хүртэл ийм их итгэл, хүч чадал мэдрэгдэхгүй мэт санагдана. Тэр тусмаа Их Эцэг өнөөдөр урьдын адил гялалзуур биш, хэтэрхий энгийн ааш гарган мэндлэх нь хүртэл яг л жирийн тариачин шиг аж.

Солоццо гол зүйлээ шууд л ярьж гарав. Мансууруулах бодис борлуулах энэ ажлыг сайн зохион байгуулсан. Түрэг улс дахь намуу цэцгийн талбайн эзэд жил бүр тодорхой хэмжээний түүхий эд ханган нийлүүлж, Францад морфи үйлдвэрлэнэ. Сицилд героин үйлдвэрлэх ажлыг найдвартай зохион байгуулсан. Бараагаа Франц, Сицилд оруулах ямар ч аюулгүй, харин

мансууруулах бодис Нэгдсэн улсад оруулахад орлогын таван хувийг алдана. Холбооны Мөрдөх Товчоог

хахуульдаж чадахгүйг бид хоёр андахгүй мэднэ. Гэвч гол нь үлдэх орлого асар их, аюул бараг үгүй.

- Та чухам над дээр яагаад ирсэн юм бэ? Намайг яахаараа ингэж их хүндлэв? - хэмээн эрхэм Корлеоне эелдгээр асуувал Солоццогийн нүүр царай ер хувирсангүй.

- Надад хоёр сая доллар бэлнээр хэрэгтэй. Бас чухал албан тушаалын нэр нөлөөтэй найз нар олонтой хүн үүнээс ч илүү хэрэгтэй байна. Заримдаа манай хүмүүсээс ганц хоёр нь баригддаг. Үүнээс зайлах аргагүй. Гэвч тэдний намтар түүхэнд өө сэв юу ч үгүй юм чинь шүүхэд очлоо ч гэсэн зөөлөн ял сонсох учиртай. Би баригдаж баларсан хүмүүсээ нэг хоёр жилээс илүү суулгамааргүй байна Тэгвэл л тэд амаа хамхиад байж чадна. Харин арав хорин жил хорих ял сонсчихвол тэдний ямар балаг тарихыг хэн мэдэх вэ? Уулын мод урттай богинотой гэдэг шүү дээ. Далан булчирхайгаа тоочоод хэрэгтэй хүмүүсийн маань ч толгой цусдах хүн байхыг үгүй гэх газаргүй. Хууль шүүхээр хамгаалуулна гэдэг бидний хувьд тэргүүн чухал ач холбогдолтой. Эрхэм Корлеоне таны атгандаа оруулсан шүүгчийн тоо гутал тослогчийн халаасан дахь бутархай мөнгөнөөс ч олон гэж сонссон юм байна.

Эрхэм Корлеоне энэ магтаалын үгийг тоосонгүй.

- Миний намын хувь ямар байх юм бэ?

Солоццогийн нүд нь гялалзан:

- Тавин хувь - гээд хэсэг чимээгүй байснаа: - Эхний жилд гурав юм уу, дөрвөн сая. Цаашдаа танд оногдох хувь чинь улам өсөх болно хэмээн зулгуу хоолойгоор үгүүлсэнд эрхэм Корлеоне эв эеэ их л хичээж буй бололтой.

- Таныг буурьтай хүн гэж дуулсан болоод л тантай уулзахыг зөвшөөрсөн юм. Би таны саналаас татгалзахаас өөр аргагүй. Гэхдээ яагаад гэдгээ тайлбарлахыг хүсч байна. Танай энэ ажил асар их орлоготой ч гэсэн их осолтой болохоор би пүүс компаниа баллачхаж мэднэ. Чухал албан тушаалтай олон найз надад бий нь үнэн, гэвч тэд над намайг мөрийтэй тоглоомын оронд мансууруулах бодистой зууралдсаныг минь мэдвэл сайнаар лав хэлэхгүй. Тэд мөрийтэй тоглоомыг архидалт шиг зүгээр л нэг эвгүй явдал, харин мансууруулах бодисыг аюултай хэрэг гэж үздэг юм. Үгүй, үгүй, та эсэргүүцээд нэмэргүй. Тэд л тэгж үзэж байгаа, би биш шүү дээ. Хэн яаж мөнгө олох нь надад хамаагүй асуудал. Таны асуудал хэтэрхий аюултай л гэдгийг би хэлэх гэсэн юм. Арван жилийн турш манайхан нам тайван аж төрж байгаа болохоор ашиг хонжооноос болоод тэдэнд аюул учруулах эрх надад байхгүй.

Солоццо Хейген, Сонни хоёр тийш хоромхон зуур хяламхийгээд авахаар нь түүний дургүйлхэж буйг бүгд мэдэж авлаа.

- Та хоёр сая долларынхоо төлөө санаа зовоод байгаа юм уу ?

Эрхэм Корлеоне хүйтнээр инээвхийлэн:

- Үгүй - хэмээн огцом дуугарсанд Солоццо дахин нэг оролдоод үзэхээр шийджээ.

Таттальягийн нам ч гэсэн таны капиталын бүрэн бүтэн байдлыг батлан даана.

Яг энэ үед Сонни тун бүдүүлэг алдаа гаргав.

—Өөрөөр хэлбэл Таттальягийн нам манай капиталыг хамгаалаад, үүнийхээ төлөө хувь процент нэхэхгүй гэсэн үг үү?

Эрхэм Корлеоне мөс шиг хүйтэн, хилэнт нүдээр хүүгээ тас ширвэж, Сонни гэнэт айн цочирдож, ямар ч учрыг нь ололгүй хөшиж орхихыг хараад Хейгений дотор палхийгээд явчхав. Корлеонегийн намын эгнээн дэх сул газрыг олж мэдсэндээ сэтгэл нь сэргэсэн Солоццогийн нүд нь дахин гялалзаад ирлээ. Эрхэм Корлеоне дахин ам нээхэд уулзалт дууссан нь дууны өнгөнөөс тодорхой боллоо.

- Одоогийн залуучууд юм болгоныг чамлаж, бас ямар ч хүмүүжилгүй, ахмад настнаас түрүүлэн дуугараад л, хэрэгтэй хэрэггүй юманд хошуу дүрээд л. Гэвч хүүхдүүддээ хэтэрхий хайртай болохоор эрхлүүлчихсэнийг минь харж байгаа биз дээ. За тэгэхлээр, эрхэм Солоццо, миний «үгүй» гэдэг бол эцсийн хариу шүү. Гэсэн хэдий боловч өөрийн зүгээс танд их амжилт хүсье. Бид чинь бие биедээ саад хийлгүйгээр ажил хэргээ эрхлээд явж болно биз дээ? Танд арга буюу татгалзах болсондоо би тун их харамсаж байна.

Солоццо мэхийн ёсолж, эрхэм Корлеонетой гар барьсны дараа Хейген түүнийг машин хүртэл үдэж өгөхдөө нүүр царайд нь юу ч өөрчлөгдөөгүйг ажиглажээ.

Хейгенийг буцаад ирэхэд эрхэм Корлеоне түүнээс:

- Энэ хүний тухай чи юу бодож байна? гэж асуухаар нь тэрээр их л биеэ барьж:

- Энэ сицили хун юм - гэжээ.

Эрхэм Корлеоне бодлогошрон толгой дохиод хүү тийшээ эргэн харлаа.

- Сантино минь, юу бодож сэдсэнээ харь элэгтэй хунд хэзээ ч бүү үзүүлж бай. Чи тэр хүүхэнтэйгээ хэт зууралдсанаас болоод толгой чинь муу ажилладаг болсон шиг байна. Одоо үүнийгээ эцэслэж, ажил хэргээ бодож үз. За за, явж үз.

Аавынхаа ингэж зэмлэхэд Сонни эхэндээ жаахан гайхсанаа удалгүй уур нь шатаад явчхыг Хейген ажиглажээ. Түүний шинэ нуудгайн тухай Их эцэг мэдэлгүй өнгөрнө гэж Сонни найдсан хэрэг үү? Дөнгөж сая ямар ноцтой алдаа гаргаснаа ойлгоогүй гэж үү? Үнэхээр тийм бол Хейген эрхэм Сантино Корлеонегийн гарын зөвлөх болно гэж ер дурлахгүйсэн...

Эрхэм Корлеоне Соннигийн гарахыг хүлээж байгаад ширэн бүрээстэй буйданд тухалж, Хейген түүнд гоньдын архи хундагалж өгөв. Их Эцэг түүний нүдийг эгцлэн ширтлээ.

- Люка Бразиг над дээр дуудаад орхи.

Гурван сар өнгөрчээ. Хейген эртхэн гарч, эхнэр хүүхдэдээ христосын мэндэлсний баярын бэлэг авах санаатай ажлаа яаран дуусгаж байтал нь хотын ажлын өрөөнийх нь утас хангинав. Жонни Фонтейны аз жаргал нь цээжинд багтаж ядан бялхаж, киноны зураг авалт дуусч анхны үзлэгээр бүгд шагшин магтаад сүйд болсон гэнэ. Тэрээр энэ баяраар эрхэм Корлеонед хачин гоё бэлэг явуулсан, өөрөө аваачиж өгмөөр санагдавч кино бүрэн дуусаагүй тул хаяад явж болохгүй байна гэнэ. Хейген тэсч ядан сонсоно. Жонни Фонтейны хунд таалагдах авьяас Хейгенд ер нөлөөлдөггүй боловч бас л сониуч зан нь хөдлөөд болдоггүй.

- Ямар бэлэг юм бэ?

- Би хэлэхгүй, урьдаас мэдчихвэл ямар олигтой бэлэг болох вэ?

Хейгений сонирхол тэр дороо буурч, эхний боломж гармагц л эелдэг зан гарган яриагаа дуусгалаа.

Утас дахин хангинаж, Хейген хамаг бичиг цаасаа хамж далд хийгээд явахаар шийдсэн боловч тэссэнгүй харилцуур авбал Майкл Корлеоне байсанд дургүйцсэн сэтгэл нь дорхноо замхарчээ. Тэр хэзээ ямагт Майклд сайн явсан болоод тэр биз.

- Том оо, маргааш Кей бид хоёр хот орно. Баярын өмнө аавтай нэг чухал юм яримаар байна. Аав маргааш орой гэртээ байх болов уу?

- Бүү санаа зов, байлгүй хаачхав. Христосын мэндэлсний баяраар заавал гэртээ байна. Өөр хэлэх юм юу байна?

Майклыг үг алдуулах гэдэг эрхэм Корлеонегээс юм дуулахаас ч амаргүй.

- Юм алга аа. Баяраар бүгд цуглана биз дээ?

- Тийм ээ.

Майкл харилцуураа тавьчихлаа. Илүү дутуу үг дуугардаггүй хачин хүн шүү. Хейген жаахан саатаад үдшийн хоолон дээр очно гэдгийг эхнэртээ хэл хэмээн нарийн бичгийн даргадаа тушаагаад гадагшаа гарч дэлгүүрийн зүг яаран алхаж явтал нэг хүн зам хөндөлдсөн нь Солоццо байсанд Хейген үнэхээр их гайхлаа.

- Та битгий ай, хоёр гурван үг солих хэрэг байна - хэмээн Солоццо намуухан үгүүлээд гараас нь барьтал замын хажууд зогсож байсан машины хаалга цэлийтэл нээгдэв. Хейген хараахан сэтгэл түгшиж амжаагүй боловч зэвүү нь хүрч гараа угз татан аваад:

- Би яарч явна - гэтэл ард нь хоёр хүн ирж зогсмогц түүний хоёр хөл нь гэнэт сульдаад явчихлаа.

- Машинд суу. Хэрэв би чамайг алах гэсэн бол аль хэдийн тонилгочих байсан. Надад итгээрэй.

Очиж очиж Солоццод итгэх гэж үү хэмээн Хейген бодсон боловч дув дуугүй машинд орж суулаа.

...Майкл Корлеоне Хейгенд худлаа хэлсэн байжээ. Тэрбээр аль хэдийн Нью Йоркод ирчхээд Хейгений ажлын газраас хоёрхон алхмын зайд орших «Пенсильвани» зочид буудлаас утасдсан аж. Түүнийг харилцуураа тавихад Кей Адамс янжуураа унтраагаад:

- Чи мөн сүрхий залдаг хүн юм аа Майк! - гэлээ.

- Хайрт минь, чамайг бодсондоо л тэгсэн юм. Бидний ирснийг манайхан мэдчихвэл тийшээ очихоос өөр аргагүй. Тэгвэл зоогийн газар хоол идэх, театрт очих ч өнгөрнө. Хамт унтахын тухай ярихын ч хэрэггүй. Албан ёсоор гэрлээгүй, тэр тусмаа аавынд энэ яасан ч бүтэхгүй хэрэг.

Тэрбээр Кейг чанга тэврэн, зөөлөн уруулыг нь шимэн үнсэж, жаргалынхаа дээдийг амсав. Номхон далайд, тэр золигийн арал дээр бөөн хог новш, цус нөжин дотор алба хааж байхдаа яг л ийм Кей Адамс шиг хөөрхөн, булбарай цагаан арьстай хүүхнийг л хүсэн мөрөөдөж явсан билээ. Тэр хоёр энэ Христосын мэндэлсний баяраар, нэг их чимээ шуугиан дэгдээлгүй, зөвхөн хоёр найзыгаа бэргэнээр уриад л бүртгүүлэхээр шийдсэн аж. Гэхдээ Майкл ямар ч гэсэн эцэгтээ дуулгахыг хүссэн бөгөөд юу ч нуулгүй бүгдийг хэлэхэд дуртай байдаг тул нэг ч их дургүйлхэхгүй байх гэж найджээ. Харин Кей эцэг эхээ зөвшөөрнө гэдэгт сүрхий эргэлзэж байв.

- Намайг жирэмсэн болж гэх биз - хэмээн Кей санаа алдахад нь Майкл ч гэсэн гунигтай инээмсэглэв.

- Манайхныг тэгж хэлэхгүй гэж бодоо юу?

Харин гэр бүлийнхэнтэйгээ тангараг тасрах дээр тулах тухай тэр хоёрын хэн хэн нь үг цухуйлгасангүй. Майкл гэртэй тэргүй тэднээс хөндийрсөн нь үнэн хэдий ч тэр хоёрын сэтгэл түгшсээр л... . Сургуулиа төгстөл тэр хоёр зөвхөн амралтын өдрөөр уулзаж, . зуны амралтаа хамт өнгөрүүлээд байхад болохгүй нь юу билээ?!

Театрт «Карусель» гэдэг жүжиг үзээд гарч явахдаа Кей Майклд эрхлэн наалдаж:

- Гэрлэснийхээ дараа намайг чи зодож нүдчихээд, сая юу гэж дууллаа даа. «од эрхсийг хулгайлаад ч болов чамдаа бэлэглэнэ» гэх үү? - хэмээсэнд Майкл хүд хүд инээж:

- Яалаа гэж дээ?! Хөөе. хоёулаа буудалд очихоосоо өмнө хоол идэх үү - гэсэн боловч Кей дургүйлхээд байхаар нь өрөөндөө хоол авчруулахаар шийджээ.

Буудлын үүдний танхимд ороод Майкл Кейг мужлаг уруу түлхэж:

- Сонин аваад ир, би түлхүүрээ авч байя - гэв.

Дайны дараа зочид буудалд үйлчлэгч нар хүрэлцэхгүй байсан тул Майкл нилээн удаан зогсож байж түлхүүрээ аваад эргэн хартал Кей мужлагийн дэргэд сонин бариад уйлчихсан зогсож байв.

- Хүүе, Майк аа одоо яана аа?!

Тэрээр Кейгийн гараас сонин шүүрэн авгал шууд нэгэн гэрэл зураг нүдэнд нь туслаа. Эцгийнх нь толгой цус нөжиндөө хутгалдан засмал замын голд хэвтэж, хажууд нь ах Фредди нь цорхиртлоо уйлж суух ажээ. Майклын дотор нь харанхуйлж, тэр айсан ч үгүй, гашуудсан ч үгүй, зөвхөн уур хилэн нь буцлан оргилоод ирэв. Майкл Кейд хандан:

- Өрөөндөө орж бай - гэсэн боловч хүүхэн өөрөө явж чадсангүй, тэр хоёр дээшээ хамт гарлаа. Майкл ором дээр суугаад сонинг дэлгэвэл том үсгээр өрсөн гарчигнууд тод харагдана

Вито Корлеонег бууджээ. Дээрэмчдийн толгойлогч бололтой хүн хүнд шархадсан байна. Эмч нар цагдаагийн хүчтэй хамгаалалтын дор хагалбар хийж байна. Цус урсгасан хядаан гарч болзошгүй. Гэнэт Майклын өвдөг нь чичрээд эхлэв.

- Аав амьд байна. Тэр новшнууд алж чадаагүй нь яамай.

Тэрээр зургийн тайлбарыг уншиж үзвэл таван цагт аавыг нь буудсан байв. Тэгэхлээр Кей тэр хоёрыг орондоо эрхэлж, үдшийн хоол идэж, театрт жүжиг үзэж суух хооронд эцэг нь үхлийн ирмэг дээр байжээ. Майкл хамаг бие нь гэнэт янгинасан мэт шүдээ тачигнатал хавирлаа.

- Эмнэлэг дээр очих уу? - Кейгийн асуухад Майкл толгой сэгсрэв.

- Эхлээд би гэр рүүгээ утасдъя. Ёстой шийдчихсэн хүмүүс аав уруу буудсан болохоор түүний амьд байгааг мэдээд юу ч хийж мэднэ. Тэд яахаас ч буцахгүй улс шүү.

Тэдний гэрийн хоёр утас хоёулаа яриад ер болж өгсөнгүй, бүр хориод минут эрэгдэж байж Майкл арай гэж залгатал Сонни харилцуур авлаа.

- Байна уу?

- Сонни, би байна.

- Еэ ашгүй дээ, бид чиний төлөө их айлаа шүү. Чи хаана байна аа? Бид танай тэр хотхон уруу чинь хүн явуулсан.

- Аав яаж байна? Сүрхий шархдаа юу? - хэмээн Майкл юуны түрүүнд лавлав.

- Маш хүнд, тав дахин буудсан. Гэхдээ аав дажгүй шүү гэхэд түүний дуунд бахархах өнгө сонсогдов. Эмч нар амьд гарна гэсэн. Хөөе Майк аа, би одоо зав тун муу, удаан ярьж чадахгүй

нь. Чи хаана байна?

- Нью Йоркод. Намайг ирнэ гэж Том хэлээгүй юм уу?

- Тэд Томыг бариад авсан. Чиний төлөө яагаад санаа зовсныг одоо ойлгов уу? Энд түүний эхнэр нь ирчхээд байна. Тэр одоохондоо мэдэхгүй, цагдаагийн газар ч бас адил. Тэр малууд юу хийж байгаагаар сайн мэдэж байсан. Олон таван юм ярилгүй, бушуухан наашаа хүрээд ир, ойлгов уу?

- Ойлголоо. Хэн ингэснийг нь чи мэдэж байна уу?

- Мэдэлгүй яах вэ? За яахав, Люка Брази хүрээд ирэг. Тэгвэл ч тэдэнд үзүүлээд өгнө өө, гайгүй.

- Цагийн дараа хөлсний тэргээр очно оо - гээд Майкл утсаа тавилаа.

Энэ мэдээтэй сонин худалдаад гурван цаг гаруй болж байна. Люка юу ч мэдээгүй хэрэг үү? Ер нь Люка Брази хаашаа алга болчхов оо? Энэ тухай Хейген одоо бодож суулаа. Энэ асуулт Сонни Корлеонегийн ч сэтгэлийг зовоож байв.

Тавд арван таван минут дутуу байхад эрхэм Корлеоне чидун жимсний тос гадаадаас нийлүүлэх компанийн эрхлэгчийн өгсөн тооцооны баримтуудыг үзэж дуусчээ. Тэрээр пиджакаа өмсөөд, сонин уншиж суусан Фреддигийн зулай дээр хуруугаараа аяархан тоншив.

- Би бэлэн боллоо, харьцгаая. Гатто машинаа энд аваад ирэг.

- Би өөрөө аваад ирье. Пола дахиад ханиад хүрчихсэн гэж утасдсан - хэмээн Фредди амандаа бувгналаа.

- Энэ сард гуравдахаа ханиад хүрч байна. Бие сайнтай жолооч эрж олох хэрэг гарах нь, Томд хэлээрэй.

Фред эцгийнхээ үгийг үл зөвшөөрөн:

- Үгүй, Пола дажгүй. Хэн ч гэсэн өвдөж болно биз дээ. Зогсоол дээрээс машин авчирч ядаад байх юу байгаа юм бэ? - гээд гарав.

Эрхэм Корлеоне хүүгээ Есдүгээр гудамж хөндлөн гарч машины зогсоол очихыг цонхоор харж зогссоноо, Хейгенд утасдсан чинь ажлынх нь өрөөнд хэн ч алга. Гэр рүүгээ утасдвал бас л хэн ч харилцуур авсангүй. Харамсалтай. Дахиад цонхоор хартал машин орцны өмнө ирчихсэн, Фредди хоёр гараа элгэндээ зөрүүлэн машины хамар налаад баярын өмнөхөн дэлгүүрийн үүдээр бужигнасан олныг харж зогсоно. Их Эцэг пиджакаа товчилж, компанийн эрхлэгч пальтог нь авч өгсөнд «баярлалаа» гэгчхээд шатаар буув.

Өвлийн үдэш эрт бүрэнхий болж, олон морины хүчтэй «бьюик»-ийг түшин гөлөрч зогссон

Фредди аавыгаа гарч ирэхийг хараад жолооны ард орж суулаа. Эрхэм Корлеоне машины хаалга нэг онгойлгосноо болиод, гудамжны буланд байдаг жимсний зах руу явжээ. Тэрбээр өвөл ногоон лангуун дээр нүд булаам овоолсон амтат жүрж, тоор жимс харах дуртай тул саяхнаас ийшээ дандаа ирдэг болсон байна. Мухлагийн эзэн найр тавин угтаж, харин эрхэм Корлеоне жимсэнд гар хүрсэнгүй, зөвхөн хуруугаараа заан шилж аваад мөнгөө төлж машин тийшээ эргэтэл хоёр хүн булан тойроод гараад иржээ. Эрхэм Корлеоне одоо юу болохыг эгшин зуур ойлголоо.

Сайхь эрс хар пальтотой, хунд танигдахгүйн тулд хар бүрхээ духдуулж дарсан байв. Харин тэр хоёр Их Эцгийг ингэх юм гэж ер санасангүй. Тэрбээр цаасанд боодолтой жимсээ тэр дороо шидчихээд, тийм нүсэр, лагс биетэй хүн гэхэд санаанд ормооргүй хурдан шалмаг харайлган машиндаа ойртох зуураа:

- Фредо Фредо! - хэмээн хашгирлаа.

Зөвхөн ингэсэн хойно л нөгөө хоёр автоматаа угз татан авч гал нээв. Эхний сум Их Эцгийн нуруунд тусч, хоёр далных нь хооронд алхаар дэлсээд авах шиг болсон авч, хүчээ шавхан харайлаа. Гэвч дараагийн хоёр сум өгзгийг нь онож, тэрээр замын голд тэрийн унахад сайхь дээрэмчид хөл дор нь хөглөрөх жимсэн дээгүүр үсэрч дүүлсээр түүнийг бүрмөсөн дуусгах санаатай ойртож ирэв. Яг энэ үеэр Эцгийнхээ хашгирснаас хойш таван хором болоод л Фредерико Корлеоне машинаас ухасхийн гарч таарсан тул хоёр эр яарсандаа хоёрхон удаа нэмж буудсан байна. Нэг сум гарт нь, нөгөө нь баруун гуянд нь шигдэж, хэдийгээр яс дайраагүй, аминд аюулгүй боловч цус их алдсан тул Их Эцэг ухаан алджээ.

Аав нь бага байхад нь дуудаж байсан нэрээр нь хашгирахыг Фредди сонстол хоёр удаа буудах дуулджээ. Тэрбээр машинаас ухасхийн гараад, автомат бугаа гаргахаа ч мартаад хөшиж орхив. Хоёр зандалчин түүнийг дор нь нам шүршчих байсан боловч бас л сандарч мэгдээд буудсангүй, булан тойроод алга болжээ. Энэ завсар гудамжинд байсан хүмүүс орцонд нуугдан, хэн нэг нь газарт навтасхийн унаж, зарим нэг нь айн хуйлраад зөвхөн Фредди л цус нөжиндөө хутгалдсан аавынхаа дэргэд ганцаараа хоцров.

Фредди бугаа гаргасан ч үгүй, дух уруугаа сүхдүүлсэн юм шиг мэлрэн, хар нуур шиг нэлийх цусан дундаа гулдайсан ааваа гөлийн, саа өвчинд дайруулсан мэт мэлрэн зогссоор л... Тал бүрээс хүмүүс уван цуван гарч, хөл үймээн эхлээд Фреддиг гулсан доошлохыг харсан нэг нь явган хүний зам дээр чирч аваачин суулгав. Эрхэм Корлеонег тойрон бүчсэн хүмүүс эхний цагдаагийн машин дохио хангинуулсаар давхиж ирэхэд л сая зам тавьж өглөө. Араас нь «Дейли Ньюс» сонины радио төхөөрөмжтэй машин ирж, гэрэл зурагчин үсрэн бугаад цус нь тогтоогүй хэвээрээ л байгаа Их Эцгийн зургийг дарж гарав. «Түргэн тусламж» ирсэн хойно тэр гэрэл зурагчин цорхиртлоо уйлсаар суугаа Фредди Корлеонед хамаг анхаарлаа шилжүүллээ. Тэр залуу чулуу шиг болхидуу нүүр, зузаан уруул, махлаг хамар дээгүүрээ нус нулимсаа нялгдан уйлж байхыг хажуунаас нь харахад жаахан инээдтэй ч юм шиг, өрөвдөлтэй ч юм шиг. Цагдаагийн машинууд дараа дараагаар нэмэгдэн ирж, хурсан олны дотор энгийн хувцастай туршуулууд хэрэн хөлхөлдөх болов. Нэг мөрдөгч Фреддигийн өмнө явган суугаад элдэв юм шалгаах боловч Фреддид сэхээ авах тэнхэл алга боллоотой. Мөрдөгч энгэрийнх нь халаасанд гараа хийж түрийвчийг нь аваад жолооны эрхийн үнэмлэхийг нь үзмэгц цаад нэгэндээ шүгэлдэн бууг нь хурааж, ямар ч таних тэмдэггүй машинд суулган

хөдлөхөд араас нь «Дейли Ньюс» сонины машин дагалдан гэрэл зурагчин нь юм болгоны, хүн бүрийн зургийг дарсаар хоцорчээ.

Эцгийнх нь амь насанд халдсаны дараа хагас цагийн дотор Сонни Корлеоне уруу дөрвөн удаа утасдсан байна. Эхний удаад Корлеонегийн гэр бүлээс давхар цалин авдаг мөрдөгч Филипс утасджээ. Тэр эр хэргийн талаар түрүүлж ирсэн цагдаагийн машинд сууж явсан юмсанж.

- Та миний дууг таньж байна уу?

- Танилгүй дээ - хэмээн яг зүүрмэглэж байхад нь эхнэр нь дуудсан Сонни нойрмог дуугарвал Филипс нэг амьсгаагаар дуржигнуулж гарлаа.

- Арван таван минутын өмнө аавыг чинь ажил дээрээсээ гарч явахад нь ул таних хүмүүс бууджээ. Хүнд шархадсан ч амьд үлдсэн, Франц эмнэлэгт аваачсан. Таны дүү Фредди одоо Челсид, цагдаагийн хэсэг дээр байгаа. Тэндээс харихаар нь эмч дуудаж үзүүлээрэй. Ноёнтон Корлеоне ухаан орвол мэдүүлэг өгч юу магад, би эмнэлэг рүү явлаа. Танд бүгдийг мэдээлж байя.

Соннигийн эхнэр Сандра нөхрийнх нь нүд нь гөлийн цийлийж, нүүрэнд нь цус хураад ирэхийг хармагц:

- Яав аа? - хэмээн шивнэсэн боловч Сонни тээршээн чимээгүй гэж дохиод гараараа харилцуур таглан цааш эргэв.

- Амьд байгаа нь үнэн үү?

- Үнээн, үнэн. Цус их алдсан боловч харин ч санаснаас гайгүй өнгөрсөн.

- Их баярлалаа. Таны зүтгэлийг бид үнэлнэ. Маргааш өглөө найман цагт гэртээ байгаарай. Манай нэг хүн мянган доллар аваачиж өгнө.

Сонни хоёр гараараа ширээ тулан утсан дээрээ тонгойн сэтгэлийн их хүч гаргаж, байж байсан байрандаа үлдлээ. Хамгийн гол сул тал нь уурлахаараа биеэ барьж чаддаггүй болохоо тэр өөрөө сайн мэдэх бөгөөд уурын мунхгаар хамаагүй юм хийвэл яг балрах тохиол болсныг ойлголоо. Юуны өмнө Том Хейгентэй холбоо барих хэрэгтэй гэж бодоод гар сунгатал утас дахин дуугарав «Дейли Ньюс» сонины сурвалжлагчийн нэрийг сонсмогц Сонни харилцуураа шидчихээд хэдэн хормын дараа Хейгений гэрт залгавал ашгүй эхнэр нь авлаа.

- Том гэртээ харьсан уу?

- Үгүй, хориод минутын дараа ирэх биз. Би хоолоо хийчхээд хүлээж сууна.

- Нааш нь ярь гэж хэлээрэй.

Сонни байдлыг эрүүл саруул ухаанаар цэгнэн, эцэг нь бол яах байсныг төсөөлөх гэж оролдов.

Энэ Солоццогийн хийсэн ажил гэдэг нь анхнаасаа тодорхой байсан боловч ардаа хүчтэй дэмжлэггүй бол Их Эцэг рүү халдаж зүрхлэхгүй нь мэдээж. Энэ бодлоо мухарлаж амжаагүй байтал нь утас дахин хангинаж, бараг эелдэг ч гэмээр зөөлөн дуу сонсогдлоо.

- Сантино Корлеоне юу?

- Тийм байна.

- Том Хейген энд байгаа. Гурван цагийн дараа очоод тэрээр манай саналыг дамжуулна. Гай тотгор нэмж дуудах гээгүй бол чи одоохондоо яарах хэрэггүй. Болсон юм болсноороо л өнгөрөг. Харин болчимгүй зан бүү гаргаарай! Ер нь чи нас залуу, цус шингэн, түргэн ууртай хүн шүү, биеэ бариарай гэх нь даажигнасан өнгө илт. Лав Солоццо өөрөө утасдсан биз. Гэвч яг нотлох аргагүй! учир Сонни зориуд үхээнц дуугаар хариу үгүүлрүүн:

- За за, хүлээхээс яах вэ?

Солоццог харилцуураа тавихад Сонни нүсэр том алтан цагаа харж, хэдийд ярьснаа ширээний цагаан хулдаас дээр тэмдэглэж авлаа.

- Юу болоо вэ, Сонни? - гэх эхнэрийнхээ дуунаар тэрбээр гал зуухны мухар сандалд лагхийн сууж дуугаа ер өөрчлөлгүй:

- Аавыг бууджээ гэв

Түүний нүүрэн дээр айдас тодрохыг ажаад Сонни эхнэрээ зандарлаа.

- Тэр амьд байгаа, бүү уйл. Өөр юу ч болохгүй, тайван бай.

Хейгений тухай эхнэртээ хэлж санааг нь улам зовоохоос түдгэлзэн байтал утас дөрөвдөх удаагаа хангинаж амьсгаа нь давхарласан Клеменцагийн дуу шуухитнах сонсогдов.

- Эцгийнхээ тухай сонсов уу?

- Сонссон, гэхдээ тэр амьд байгаа.

- Еэ тэнгэр минь, ёстой бурхны л аврал даа - гэснээ Клеменца тэрхэн дороо сэхээ авав бололтой: - Чи лавтай мэдэж байна уу? Түүнийг шууд л гудамжинд таалал төгссөн гэж би сонслоо гэв.

- Үгүй, амьд байгаа - гэх зуураа Сонни түүний үг бүрийг хичээнгүйлэн чагналаа. Тэрбээр үнэн голоосоо сэтгэл түгшсэн юм шиг боловч уг нь албан үүргийнхээ дагуу сайн жүжигчин байх ёстой хүн шүү дээ!

- Сонни, одоо чи бүхнийг гартаа авах учиртай. Яах талаар заавар өг!

- Поли Гаттог аваад наашаа хүрээд ир.

- Тэгээд л тэр үү? Эмнэлэг рүү, бас танайх уруу хүмүүсээ явуулах юм биш үү?

- Үгүй, Поли Гаттог дагуулаад энд хүрээд ир.

Клеменца юмны зах сэжүүрийг гадарлаж эхлэв бололтой хэсэг чимээгүй болохоор нь Сонни аль болох ердийн дуугаар:

- Ер нь тэр Поли хаана юу хийгээд яваа юм бэ? Хаашаа алга болчихдог билээ, чөтгөр алгадмар чинь? хэмээв.

Харилцуур дахь амьсгаадсан исгэчээ нэг хэсэгтээ нам болж, Клеменца тэр дороо хариулсангүй.

- Салхинд цохиулаад гэртээ үлдсэн. Энэ өвөлжингөө л үе үе өвдсөн шүү.

Соннигийн дотор нь сэрдхийгээд явчихлаа.

- Сүүлийн саруудад хэдэн удаа ажилдаа ирээгүй вэ?

- Лав л гурав, дөрвөн удаа юм даг. Би тухай бүрд нь орны хүн явуулъя гэхэд Фредди дандаа л «хэрэггүй» хэмээн өнгөрөөсөн. Чи өөрөө ч мэднэ дээ, сүүлийн арван жил зүв зүгээр байсан юм чинь санаа зовох шалтгаан ч байгаагүй л дээ.

- За тэгвэл аан гэж бай. Замаараа заавал Полиг аваад аавынд хүрээд ир. Эрүүл өвчтэй нь хамаагүй, түүнгүй бол нүдэнд бүү үзэгд, ойлгов уу? - гээд Сонни хариу хүлээлгүй харилцуураа шидчихэв.

Чимээгүйхэн мэгшин уйлсаар суугаа эхнэрээ тэрээр нэг муухай харснаа гэнэт сөөнгөтсөн хоолойгоор:

- Манайхан асуувал аавын хувийн утсаар надтай ярь гэж хэлээрэй. Гаднын хүн асуувал чи юу ч мэдэхгүй шүү. Хэрэв Томын гэргий утасдвал түүнийг ажил гараад түр саатсан гэж хэлээрэй - хэмээгээд гадагшаа гарлаа.

Балчир есийн жавар хувцас нэвт салхилж, хав харанхуй болсон хэдий ч хагас дугуй цэцэрлэгийн гудамж дахь найман байшин бүгд эрхэм Корлеонегийн мэдлийнх тул Сонни юунаас айх билээ?! Эхний хоёр байшинд Корлеонегийн итгэлтэй хүмүүс гэр бүлийн хамт амьдардаг, доод давхарт нь бас л үнэнч ганц бие хүмүүс суудаг. Бусад зургаан байшингийн нэгд нь Том Хейген, нөгөөд нь Сонни, гурав дахь хамгийн жижиг даруухан байшинд Загалмайлан эцэг өөрөө суух бөлгөө. Эрхэм Корлеоне сүүлийн гурван байшинг нэгэнт албаа хаасан боловч хэрэгцээтэй үед эхний

дуудлагаар л давхиж ирэх найз нартаа үнэ төлбөргүй хэрэглүүлдэг тул гаднаас нь харахад ямар ч гэмгүй мэт энэ түшиц газар үнэн хэрэгтээ жинхэнэ хэрэм мэт бат найдвартай цайз байлаа. Байшин болгон дээр хүчтэй тольдуур зоосон болохоор эргэн тойрон гэрэл гэгээтэй, нуугдаж отохын ямар ч аргагүй.

Сонни замын нөгөө талд гараад өөрийн түлхүүрээр аавынхаа байшингийн хаалга онгойлгож оров.

- Ээжээ, та хаана байна?

Эх нь гал тогооны өрөөнөөс гарч ирэхэд шарсан чинжүүний үнэр ханхийв. Сонни нэг ч үг хэлэх зав өгөлгүй ээжийнхээ гараас барьж шууд сандал дээр суулгалаа.

- Сая над руу утасдсан.. Та харин санаа бүү зовоорой. Аав шархдаад эмнэлэгт байгаа гэнэ. Одоохон машин ирнэ, хувцаслаад түүн дээр оч. За юу, ээжээ?

Ээж нь түүнийг эгцлэн ширтсэнээ;

- Түүнийг буудаа юу? - гэж италиар асуув.

Сонни толгой дохисонд эх нь бурхан тэнгэртээ залбирч буй бололтой, хормын төдий толгой гилжийлгэснээ гал зуухны өрөөндөө буцаж орлоо. Сонни араас нь дагаж, ээжийнхээ хэрхэн хийн пийшин унтраан, дутуу шарсан чинжүүтэй хайруул авч тавиад унтлагынхаа өрөө рүү шатаар өгсөхийг харж зогссоноо мухрын том өрөөний зүг алхав. Тэрбээр эцгийнхээ ажлын тасалгаанд орж ширээний шургуулганаас телефон утас гаргаж ирсэн нь буруу хаягаар, өөр хүний нэр дээр бүртгүүлсэн эрхэм Корлеонегийн хувийн утас ажээ. Сонни юуны өмнө Люка Брази уруу утасдсан боловч хариу алга байсанд Их Эцэгт хязгааргүй үнэнч, хоёр дахь итгэмжлэгдсэн төлөөлөгч Тессиотой ярихаар Бруклин руу утасдлаа. Сонни түүнд юу болсныг дуулгаад хамгаас найдвартай тавин хүн шилэн авч, заримыг нь эмнэлэг хамгаалуулахаар, үлдсэнийг нааш нь, Лонг Бич рүү ирүүл гэж тушаав.

- Клеменца бас жагсаалаас гараа юу? - хэмээн Тессио сонирхлоо.

- Би одоохондоо Клеменцагийн хүмүүсийг ашигламааргүй байна.

Тессио энэ үгний далд утгыг дор нь ойлгон хэсэг чимээгүй болов.

- Чи намайг уучлаарай, Сонни. Гэвч би эцэг шиг чинь гэж бодоод нэг юм хэлмээр байна. Битгий л түргэдээрэй. Клеменца урвасан гэдэгт би итгэхгүй байна.

- За, их баярлалаа. Би ч гэсэн итгэлгүй л байна. Гэвч юуны өмнө болгоомжтой байх нь чухал, тийм биз?

- Аа, бас Майк маань Ганноверт, их сургуульд байгаа шүү дээ. Бостонд байгаа манай хүмүүсээс тийш нь явуулаад түүнийг энд авчруулаач. Чимээ шуугиан дарагдтал бидэнтэй байсан нь дээр. Би түүнд утасдаад хэлчихье.

- За за, би ажлаа амжуулчхаад, одоохон очлоо. Чи миний залуусыг таних уу?

- Харвал таних байлгүй гээд Сонни харилцуураа тавилаа.

Тэрээр хананд суулгасан төмөр шүүгээнээс цэнхэр ширэн хавгастай жижигхэн дэвтэр

гаргаж, «Рей Фаррел, 5000 доллар Христосын мэндэлсэн өдөр» гэсэн тэмдэглэлтэй хуудас олж, хажууд нь бичсэн дугаарыг эрэгдэв.

- Фаррел уу?

- Би байна.

- Сантино Корлеоне байна. Танаас хүсэх яаралтай ажил гарлаа. Хоёр утас шалгаад өгөөч. Сүүлийн гурван сард тэр утсаар, мөн тэр утсанд хэн хаанаас ярьсныг мэдэх гэсэн юм - гээд Сонни Клеменца, Полли Гатто хоёрын гэрийн утсыг хэлж өгчээ. - Энэ маш чухал. Хэрэв та өнөөдөртөө багтаж мэдээд өгвөл Христосын мэндэлсний өдрөөр илүү сайхан баярлах аян шалтаг гарах байх шүү.

Одоо сайн тунгааж бодох л хэрэгтэй. Юуны өмнө Люка Бразид дахиад утасдах нь чухал. Тэрээр дахиад л хариу өгөхгүй байгаа нь хачирхалтай байсан боловч тайвшрахыг хичээлээ. Уг нь Люка дуулсан даруйдаа л давхиж ирэх хүнсэн дээ. Нэг цагийн дараа гэхэд л энд хүн амьтан бужигнаад, тайван суух ч зав олдохгүй. Ямар аюултай хэрэг мандсаныг Сонни сая л бүрэн гүйцэд ухаарав. Арван жил болоход анх удаагаа Корлеонегийн нам, түүний бүрэн эрхэнд ийнхүү халдсан хэрэг бөгөөд хэрэв Солоццогийн цаана нь Нью Йоркийн хамгийн том бүлэрхэг омгуудын ядахдаа нэг нь байгаагүй бол ийм юм хийж зүрхлэхгүй нь мэдээж. Бодоод үзэхэд Тагтальягийнх л болов уу. «Нэг бол үхтлээ тэмцэлдэнэ, нэг бол Солоццогийн болзлыг хүлээн зөвшөөрч, нэгмөсөн бууж өгнө, өөр аргагүй» гэж бодоод тэрбээр шүд зуулаа. Хорон санаат Солоццо бүгдийг тооцоолсон боловч азын тэнгэр нь харьсан юм байлгүй, Загалмайлсан эцэг амьд үлдсэн болохоор одоо дайтахаас яах вэ? Люка Брази гэж нэг хүн байгаагаас гадна Корлеонегийн намын хүч чадлыг бодоод үзвэл энэ дайтал юугаар дуусах нь тодорхой. Ер нь энэ Люка Брази яачихсан юм бол оо?

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Хейгенийг машин дотор оруулж, хоёр хүний хооронд суулгатал нэг нь малгайг нь нүд рүү дарсан тул тэрбээр юу ч харахаа болив.

Нэг ч их удсангүй, хагас цаг хэртэй яваад машинаас гарахад хав харанхуй тул Хейген чухам хаана ирснээ мэдсэнгүй. Түүнийг нэг байранд оруулж, сандал дээр суулгаад Солоццо өөдөөс нь харж тухлав.

- Чи битгий ай, Корлеонегийн намд уураг тархины хүрээлэн гэдгийг чинь бид мэднэ. Өөрийнхөндөө ч, манайханд ч тус болохыг би танаас хүсч байна. Танай эзэн чинь нөгөө ертөнцөд очсон. Яг ажлаасаа гарч явахад нь гудамжинд бодийг нь хөтөлсөн.

Хейген дув дуугүй сонсоод гэнэт ямар их гашуудаж байгаагаа өөрөө мэдрээд үнэн гайхлаа. Их Эцгийг яаж байгаа бол гэхээс харамсах зовох хоёр зэрэгцээд Хейгений дотор нилээд давчдав.

- Энэ тухай дуулсан даруйдаа л би чам дээр очсон юм. Соннитой бид үгээ ололцож болно биз дээ. Энэ ажил ямар орлоготойг чи өөрөө сайн мэдэж байгаа. Их Эцэг үнэхээр амьдралаас хоцорсноо өөрөө ч мэдэхгүй байна. Нэгэнт таалал төгссөн хүний хойноос олон юм яриад юу хийх вэ? Би яриа хэлцлээ дахин эхлэхэд бэлэн байна, ганцхан чи л Сонниг зөвшөөрүүл.

- Энэ ёстой бүтэхгүй. Сонни амьсгаа хураатлаа өс хонзонгоо авахаар тэмцэнэ.

Солоццо түүний үгийг тас дайрлаа.

- Анх цочирдоод л тэгж байгаа юм. Учир байдлыг нь сайн ойлгуулах л хэрэгтэй. Тагталья болон түүний хүмүүс намайг дэмжиж байгаа. Нэгэнт дайтах хэрэг гарвал хүний амь үй олноор эрсдэх тул Нью Йоркийн бусад нам, бүлэглэл юу ч хийхээс буцахгүй. Харин Сонни бид хоёр ярьж тохирвол Америкт байгаа нэг ч синдикат энэ хэрэгт оролцохгүй - гээд Хейген бас л чив чимээгүй суугаад байсан тул Солоццо цааш үргэлжлүүлсэн нь: Их Эцэг үнэхээр дордож. Тэгээгүй бол яалаа гэж гэнэдэх билээ. Чамайг гарын зөвлөхөөр сонгосон болоод л бусад нам бүлэглэл түүнд итгэхээ больсон. Чи сицили эр биш, ядахдаа итали хүн биш шүү дээ. Хэрэв илэрхий тулалдаад унавал хэн хэн нь, би ч гэсэн тохирно. Корлеонегийн улс төрийн зүтгэлтнүүдтэй тогтоосон холбоо нь надад мөнгөнөөс чухал. Цус асгаруулсан ширүүн тэмцэл дэгдээхгүйн тулд чи Соннитой, бас бусад итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй ярилцаж үз.

Хейген янжуураа асаах гэтэл гар нь салгалаад байсанд цаадуул нь архи хундагалж өгөв.

- За яахав, би оролдоод л үзье. Сонниг ятгах гэдэг хэцүү дээ. Харин Люка Бразиг бол Сонни ч тогтоож чадахгүй шүү, түүнээс их болгоомжилж яваарай.

- Люкаг бол би өөрөө хариуцна. Чи харин Сонни, Их Эцгийн бусад хөвгүүдийг л аргал. Өнөөдөр манай залуус Фреддиг ч гэсэн тонилгочихож чадах байсан боловч би хориглосон юм. Амьд үлдсэн нь аз гэж хэлээрэй.

Өөрийг нь алах юм уу, эсвэл барьцаанд байлгах гээгүйг Хейген дөнгөж сая ойлгож, дотор нь онгойхын зэрэгцээ бас ичих ч шиг болов.

Одоо яах вэ? Хэрэв Солоццогийн хэлснийг дамжуулахгүй бол түүнийг дор нь устгана. Гэхдээ татгалзаад яах юм бэ? Тэрээр Солоццогийн тавьсан саналыг яг хэлснээр нь л очоод дуулгачихвал болоо юм биш үү? Энэ бол аль ч зөвлөхийн үүрэг биз дээ? Хэрэв сайн тунгааж бодоод үзвэл Солоццогийн үгэнд үнэний хувь бий нь ч бий. Татталья, Корлеоне хоёрын хоорондын дайсагналыг ямар ч үнээр хамаагүй зогсоох хэрэгтэй. Яая гэхэв, Корлеонегийн намынхан Их Эцгийг эцсийн замд нь үдээд дараа нь хэлцэл хийнэ л биз. Цаг нь ирэхээр Солоццотой тооцоо бодож болохгүй нь юу билээ?

Хейген толгой өндийтөл Солоццо түүний бодлыг таасан мэт ёжтой жуумалзаж суув. Гэтэл Люка Бразиг яасан юм бол оо гэж бодохоос Хейгений дотор палхийв. Яагаад Солоццо ингэж доогтой инээмсэглээд суугаад байна вэ? Люка эдэнд урвачихсан юм биш биз? Солоццогийн очиж уулздаг өдөр эрхэм Корлеоне Люкаг дуудсанаас хойш яасныг бүү мэд. Гэхдээ энэ нь гол биш. Эндээс л яаж ийж байгаад мултарч, Корлеонегийн баг бэх цайз Лонг Бичд очоодох юмсан.

- Би чадах бүхнээ л хийе. Ийм юм болсон хойно эрхэм Корлеоне ч гэсэн биднийг зөв гэх байсан биз - хэмээн Хейгений үгүүлсэнд Солоццо бах нь ханасан байртай толгой дохилоо.

- За, сайн байна. Цус асгаруулсан тулаанд би ер дургүй. Би ажил хэрэг ч хүн, цус гэдэг чинь ямар ус биш дээ.

Утас дуугарч, Хейгений ард суусан нэг хүн харилцуур авч чагнаснаа:

- За за, хэлье - гээд босч Солоццогийн чихэнд нэг юм шивнэтэл Түрэгийн царай зэвхий дааж нүдэнд нь уур хилэнгийн оч бадраад ирэв. Солоццо нэг юм эргэцүүлэх мэт Хейгенийг цоо ширтсэнд «Нэг л юм болж одоо намайг явуулах нь өнгөрлөө. Дахиад л би үхлийн ирмэг дээр очлоо» гэж бодмогц түүний нуруугаар хүйт оргив.

- Егзөр өвгөн амьд гэнэ. Түүний сицили арьсыг таван сумаар нүхэлчхээд байхад гол нь тасардаггүй байна шүү хэмээн Солоццо хувь тавилангаа хүлцэн дагах мэт үгүүлээд мөрөө хавчив.

- Миний ч чиний ч аз харьжээ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Майкл Корлеоне Лонг Бич дэх эцгийнхээ байшинд очиход цэцэрлэгт гудамжны нарийхан орцыг хүнд төмөр гинжээр хөндлөн хааж, найман тольдуур бүгдийг асаан хагас тойргийн дагуу арав гаруй машин тавьсан харагдана.

Төмөр гинж дээр сандайлан юм ярьж суусан үл таних хоёр эрийн нэг нь.

- Юун хүн бэ? - гэж бруклин аялгаар асуусанд Майкл нэрээ хэллээ. Эхний байшингаас нэг хүн гарч ирээд:

- Их Эцгийн хүү байна гэв. Майкл түүний араас даган байшин тийш очвол хаалганы дэргэд бас хоёр хүн угтан ирж үзээд оруулав.

Тэр байшинд Майклын үл таних хүмүүс пиг дүүрэн, зочдын өрөөний буйдан дээр Том Хейгений гэргий Тереза ямар ч хөдөлгөөнгүй, тамхи татаж суух ажээ. Буйдангийн нөгөө буланд тухлан налайсан Клеменцагийн нүүрнээс юу ч олж мэдэх аргагүй боловч духаар нь хөлс бурзайж, хуруундаа хавчсан навчин янжуураа нортол нь зажилсан харагдана.

Клеменца ойртон ирж өрөвдсөн янзтай Майклын гарыг сэгсэрч:

- Чиний ээж эмнэлэгт, аавын чинь дэргэд байгаа. Бүх юм зүгээр болно, санаа бүү зов гэж үглэв. Поли Гатто бас л амар мэндийг нь мэдэхээр ирсэнд Майкл түүнийг сонирхон ширтэв. Поли эцгийн нь бие хамгаалагч гэдгийг Майкл мэдэх боловч өнөөдөр ханиад хүрсэн гээд ажилдаа ирээгүйг нь түүнд хэн ч хэлсэнгүй. Харин бие хамгаалагчийн сэтгэл түгшүүртэй, царай баргар байхыг нь л ажиглаж амжжээ. Тэрбээр Гаттог өсөх ирээдүйтэй сайн залуу, хэлсэн юмыг дор нь ойлгодог гэж дуулсан юмсанж... өрөө тасалгаагаар хөлхөлдөх энэ олон хүмүүсийг Майкл ер танихгүй, лав л Клеменцагийн хүмүүс биш. Майкл энэ бүхнийг шүтэлцүүлэн бодож үзээд Клеменца, Гатто хоёр сэжиглэгдэж буйг ойлголоо. Поли халдлагын үеэр яг байсан гэж бодоод Майкл түүний өмхий хүрэн шиг царайг ширтэн:

- Фредди яасан бэ, гайгүй юу? - хэмээн асуусанд Клеменца өмнөөс нь хариулав.

- Түүнд тарна хийчихсэн, одоо унтаж байгаа.

Майкл Хейгений эхнэр хоёр бие биендээ хэзээнээс сайн байсан тул түүн дээр очоод хацрыг нь үнсэнгээ:

- Томын талаар санаа бүү зовоорой. Чи Соннитой уулзсан уу? гэж шивнэсэнд тэрээр хэсэг зуур хацарт нь наалдсанаа толгой сэгсэрлээ. Америк эмэгтэй гэхээсээ итали бүсгүйтэй илүү төстэй энэ хөөрхөн хүүхэн үнэхээр балмагдан цочирджээ. Майкл түүний гараас барин буйдангаас босгож эцгийнхээ өрөөнд дагуулж орлоо.

Сонни шар дэвтэр, харандаа бариад ширээнээ сууж, дэргэд нь итгэмжлэгдсэн төлөөлөгч Тессиогоос өөр хүн алга. Майкл түүнийг таниад хэний хүмүүс ордны хамгаалалтад гарсныг

дор нь ойлгов. Тессии бас л дэвтэр харандаа барьсан харагдана.

Сонни тэднийг орж ормогц ширээний араас босч, Хейгений авгайг тэвэрч найр тавилаа.

- Тереза, чи бүү ай. Томыг яах ч үгүй. Тэд зөвхөн Томоор өөрсдийн саналыг л дамжуулах гэсэн юм байна. Тэр чинь манай ажил хэрэгт оролцдоггүй, зөвхөн өмгөөлөгч юм чинь аюулгүй биз.

Сонни Терезаг орхиод огт санаандгүй байтал Майклыг тэвэрч хацар дээр нь шовхийлгээд авсанд хачин их гайхаж ахыгаа түлхэж орхиод жуумалзав.

- Бүх л насаар минь зодож нүддэг байсан атлаа одоо үнсэж үнхлээд юу болчхоо вэ?

Тэр хоёр багадаа дандаа л зодолддог байсан тул Сонни ч гэсэн мөрөө хавчин инээмсэглэлээ.

- Чи аан гээч, би чамайг Ганноверт байхгүй болохоор чинь их санаа зовлоо. Чамд иймээ тиймээ юм болсон бол ээжид юу гэж хэлэх вэ?

- Ээж яаж байна?

- Дажгүй, ээж бид хоёр их юм үзсэн улс. Харин чи л тэгэхэд балчир байсан болоод юу ч мэдээгүй өнгөрсөн. Чиний том болсон хойно бид амар тайван амьдрах болсон юм даа. Ээж, аав дээр байгаа. Эмч нар амьд гарна гэсэн.

- Бид ч гэсэн очих юм биш үү? Сонни толгой сэгсрэв.

- Энэ хэргийн шуугиан намжтал би гэрээс гарах эрхгүй.

Утас дуугарч Сонниг сэтгэл түгшин харилцуур чагнах зуур Майкл санаандгүй мэт ширээнд дөхөн шар дэвтэр лүү шагайвал хамгийн эхэнд Солоццо, Филипп Татталья, Жон Татталья нарын нэрс бичээстэй байлаа. Тэгэхлээр тэрээр яг Сонни, Тессии хоёр нэн тэргүүнд тонилговол зохих хүмүүсийн нэрсийн жагсаалт гаргаж байхад нь ороод ирсэн байж.

Сонни харилцуураа тавиад Тереза, Майкл хоёр тийш эргэв.

- Та хоёр зочдын өрөөнд хүлээж байхгүй юу? Тессии бид хоёр нэг юм дуусгах хэрэгтэй байна.

Хейгений эхнэр нүд дүүрэн нулимс гүйлгэнүүлж, хамаг бие нь салганан:

- Томын тухай утасдаагүй биз? - гэж асуувал Сонни түүний мөрөөр тэвэрч хаалга уруу дөхүүллээ.

- Түүнийг яах ч үгүй гэж ам өгье. Чи тэнд хүлээж бай. Ямар нэг юм мэдвэл тэр дор нь чамд дуулгана.

Тэрээр Терезаг гаргаж хаалга хаагаад ширэн бүрээстэй том буйдан сандалд очиж суусан Майклыг анхааралтай харснаа ширээнд ойртож очив.

- Майкл, сайхан мэдээрэй. Энд үлдлээ гээд чи олигтой юм олж сонсохгүй шүү.

- Би хэрэг болж магадгүй биш үү?

- Өө, тэр ёстой ярихгүй. Чамайг энэ хэрэгт оролцуулчихвал аав намайг хэзээ ч өршөөхгүй хэмээн Сонни татгалзсанд Майкл үсрэн бослоо.

- Хөөе, дүлий годил минь, тэр чинь миний төрсөн эцэг шүү! Би түүнд туслах ёстой. Заавал буудах албагүй, өөр юмаар тус хийж болно биз дээ. Тэгээд ч ер нь намайг жаахан хүүхэд шиг бодлогоо больж үз! Би дайнд явж, өөрөө ч шархдаж, ерөөлийг ч алж хядаж байсныг минь мартаа юу? Чи надыг ухаан алдаад уначихна гэж бодоогүй биз?

- Одоо намайг «гараа ергө» гэх нь шив дээ? За за үлд, утасны хажууд сууж бай - хэмээн Сонни жуумалзаад Тессио уруу эргэв. - Дөнгөж сая бидэнд хэрэгтэй нэг зүйлийг мэдээллээ. Хэн нэг нь тэднийг эцэг дээр дагуулж очсон байна. Клеменца ч юм уу, Поли Гатто ч байж магадгүй, тэр яг өнөөдөр өвдлөө гээд ажилдаа очоогүй нь хачирхалтай биш үү? Би хэн гэдгийг сайн мэдэж байна. Гэвч чи боловсролтой хүн, уураг тархиа яаж ажиллуулахыг чинь харья. Биднийг хэн Солоццод худалдсан бэ, хэлээд орхиоч?

Майкл дахин сууж сандлын түшлэг налан тухлаад мэдсэн, сонссон бүхнээ тунгаан бодов. Корлеонегийн эзэнт улсад Клеменца итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гол зангилаа албан тушаалд ажилладаг, Их Эцэг түүнийг саятан болоход нь тусалж хорь гаруй жил дотнын найз нь явсан. Их Эцгээс урвалаа гээд Клеменца юу хожих вэ? Мөнгө үү? Тэр маш баян, гэвч хүн ямар ханаж цадахаа мэдэх биш дээ. Эрх мэдэл үү? Тааруухан халамжиллаа гэж бодоод тооцоо хийх гээ юм болов уу? Гарын зөвлөхөөр Хейгенийг томилсонтой эвлэрч чадахгүй яваа хэрэг үү? Эсвэл Солоццог дийлнэ гэж бодсон уу? үгүй, Клеменца яасан ч урвагч байж таарахгүй. Яг энэхэн эгшинд Клеменцаг үхүүлэхийг үл хүсэх учраас ингэж бодож байгаагаа Майкл ойлголоо. Сайхь бүдүүн эр түүнийг жаахан байхад нь бэлэг авчирч, гадуур дагуулан зугаалдаг байж билээ. Үгүй ээ, Клеменца яасан ч биш. Гэвч Солоццо яг л түүн шиг хүнийг Корлеонегийн отгоос урвуулах гэсэн байж магадгүй л юм.

Харин Поли Гатто бол одоохондоо баяжиж амжаагүй, нэр сайтай албан тушаал ахиж яваа боловч хүссэндээ хүртэл нь их хугацаа хэрэгтэй. Тэр нас залуу тул илүү эрх мэдлийн төлөө улайран хөөцөлдөх нь мэдээж. Тийм ээ, Поли л урвасан болов уу даа... Гэвч Поли тэр хоёр хамт нэг ангид сурч байснаа дурсаж санаад Поли биш байгаасай гэж бодон толгой сэгсрэв.

- Аль нь ч биш.

Сонни энэ асуултын хариуг сайн мэдэж байгаа болохоор л тэр ингэж хэлжээ. Хэрэв Майкл эцсийн шийдвэр гаргах бол Поли Гаттог л гэм буруутайг хүлээн зөвшөөрөх байсан тул Сонни бүгдийг ойлгон инээмсэглэлээ.

- Чи тайвширч үз. Клеменца яагаа ч үгүй. Поли л урвасан.

Тессиогийн дотор нь уужраад явчхыг Майкл ажиглав. Тэрээр өөрөө бас итгэмжлэгдсэн төлөөлөгч тул зэвсэг нэгт анд болох Клеменцагийн төлөө их санаа зовж байсан аж. Тэгээд ч

хамгийн дээд тушаалынхаас л урван тэрслээгүй бол нэг ч их балаг тарихгүй биз гэж бодоод Тессио:

- Маргаашнаас залуусаа гэр гэрт нь хариулах уу? - гэвэл Сонни зөвшөөрсөнгүй.

- Нөгөөдөр л явуул. Тэр болтол Полигийн тухай хэн ч мэдэхгүй байсан нь дээр. Харин одоо уучлаарай, дүүтэй аминчилж ярих юм байна. Зочдын өрөөнд хүлээж бай, за юу? Жагсаалтаа дараа дуусгая. Харри чи Клеменцад үзүүлээд саналыг нь асуучхаарай.

- Ойлголоо - гээд Тессио өрөөнөөс гарч одов.

- Энэ Поли гэдгийг яаж та мэдээ вэ? - хэмээн Майкл ахаасаа лавлан асуулаа.

Телефоны компанид байдаг манай хүн Поли, Клеменца хоёрын яриаг шалгасан юм. Энэ сард Поли гурван удаа өвдөж, яг энэ өдрүүд эцгийн ажлын газрын эсрэг байдаг автомат утсаар түүнтэй ярьсан байна. Өнөөдөр ч гэсэн адил. Поли ажил дээрээ байна уу, эсвэл өөр хүн орлож байна уу гэдгийг мэдэх гэсэн байх. Эсвэл өөр ч шалтгаанаар утасдсан байж магадгүй. Гэхдээ энэ одоо чухал биш. Бурхны авралаар Поли л байсан нь яамай. Клеменцагүйгээр бид хэцүүдэх байсан шүү.

- Тэгвэл дайтах уу - хэмээн Майкл эргэлзэнгүй асуусанд Сонни түүний зүг ширүүн харц чулуудав.

- Том л хүрээд ирэг... Тийм ээ, эцэг л татгалзаад саад хийхгүй бол дайтах л болно.

- Түүний шийдээ хэлтэл хүлээвэл яасан юм бэ?

- Чи чинь яаж тэр олон медаль авсан юм бэ? Залуу минь бидэн рүү буу шагайчихсан, одоо дайтахаас өөр ямар ч арга алга. Харин тэд Томыг явуулахгүй л болов уу гэж айх юм.

- Яагаад? гэж Майклын гайхсанд Сонни тун их тэвчээр гарган тайлбарлав.

- Аавыг таалал төгссөн гэж бодоод тэд Томыг авч явсан. Бас надтай хэл үгээ ололцоно хэмээн найдаад Томоор зуучлуулан өөрсдийнхөө саналыг дамжуулах гэсэн хэрэг л дээ. Гэтэл одоо аавыг амьд үлдсэнийг тэд мэдээд намайг зөвшөөрөхгүйг ойлгосон болохоор Том хэрэггүй болсон. Түүнийг нэг бол явуулна, нэг бол цааш харуулчихна. Яахыг Солоццо л шийдэх хэрэг. Тоглоом наадам хийгээгүй гэдгээ харуулж айлгах гэсэндээ алчхаж ч магадгүй дээ.

- Чамтай хэлэлцэн тохирч болно гэж Солоццо тийм их итгэн найдсаны учир юу вэ?

Соннигийн царай гэнэт минчийн барайгаад мөддөө дуугарч чадсангүй.

- Хоёр сарын өмнө Солоццо манайд ирж, мансууруулах бодис наймаалах ажилд хувь оролцохыг санал болгоход аав татгалзсан. Харин би тэр ярианы үеэр хэрэггүй юм дуугарчхаад тийм ч дургүй биш байгаагаа Солоццод ханд авахуулчихсан юм. Гэр бүлийн отгийн доторх санал зөрөлдөөнийг хэнд ч мэдүүлж үл болохыг аав яс маханд минь шингэтэл ойлгуулсаар байтал би үнэхээр тэнэгтсэн. Тэгээд л аавыг нухчихвал намайг түншлэнэ гэж Солоццо

шийдсэн хэрэг. Аавын үгүй бол манай гэр бүлийн хүч хоёр дахин суларна. Тэгээд л би намыг толгойлж, ажил хэргээ гартаа барьж байхын тулд үхэн хатан үзэлцэж, нэгэнт мансууруулагчийн наймаа ирээдүйтэй юм хойно бид хэлэлцэн тохирох л байсан. Солоццо хувийн өшөө хонзонгоор биш, ажил хэрэгч хүн болохоороо л аавыг буудах тушаал өгсөн л дөө. Би ч тэсэн ашиг сонирхлоо бодоод л түүнтэй нийлэх байсан. Нью Йоркийн бусад нам, бүлэглэл энэ тохиолдолд зөвхөн цусан өшөө авахаар Солоццог тонилгох бололцоо надад өгөхгүй л дээ. Түүний ард Таттальягийн нам байгаа шүү дээ.

- Хэрэв тэд аавыг нам буудчихсан бол яах байсан бэ?

- Тэгсэн тэгээгүй би Солоццог ална. Миний эсрэг Нью Йоркийн Таван нам бүгд боссон ч хамаа алга, намайг юу ч хорьж зогсоохгүй. Хамт үхсэн ч ялгаагүй, би Таттальягийнхнийг бүгдийг нь хүйс тэмтэрнэ.

- Аав бол өөрөөр хандах байсан даа - гэж Майклыг аяархан дуугарвал Сонни ундууцан гараа савлав.

- Аавын зиндаанд хүрэхгүй гэдгээ мэдэж байна. Ганцхан л юм чамд хэлэхэд нүүр тулан үзэлцэхэд надаас дээр хүн олдохгүй гэдгийг аав ч батална. Солоццо ч, Тессо, Клеменца хоёр ч түүнийг мэдэж байгаа. Намайг арван естэй байхад манай нам олон бүлэглэлтэй дайтаж, би эцэгтээ их түшиг тулгуур болж байсан тул анх хүний амь хөнөөж, эргэж буцах замаа хаасан. Тийм болохоор би одоо юунаас ч айхгүй. Тэгээд ч энэ тоглоомын бүх хөзөр бидний гарт байна. Ганцхан Люкатай л холбоо бариадах юмсан, харла гэж!

- Тэр ганцаараа бүхэл бүтэн армитай тэнцэх хүн. Би түүнийг Таттальягийн гурвал уруу явуулаад, Виргилия Солоццог өөртөө үлдээнэ.

Зочдын өрөөнд эмэгтэй хүн чарлах дуулдаж, аа солиг гэж, энэ чинь Томын гэргий байна хэмээн Майкл бодоод үүд рүү ухасхийлээ. Буйдангийн дэргэд хүмүүс овоорч, Том Хейген ичингүйрсэн янзтай Терезаг тэвэрсэн харагдана. Түүний нүднээс нулимс дуслахыг Майкл хараад, нөхрөө амьд орж ирсэнд баярлаад хашгирсныг ойлголоо. Том Хейген эхнэрийнхээ гарыг зайлуулж буйдан дээр суулгаад Майкл уруу харж уруулын үзүүрээр инээмсэглэсэн болж:

- Чамтай уулзсандаа их баяртай байна. Нээрээ шүү гээд нүднээсээ гинжин хэлхээ унагасаар суугаа Терезаг харсан ч үгүй, ажлын өрөөнд оров. «Энэ хүн аавын хажууд өдий олон жил болсон нь талаар өнгөрсөнгүй, Сонни бид хоёр шиг их юм түүнээс сураа шив» хэмээн Майкл бахархан боджээ.

ТАВДУГААР БҮЛЭГ

Сонни, Майкл, Том Хейген, Клеменца, Тессио нар өглөөний дөрвөн цагийн алдад эрхэм Корлеонегийн ажлын өрөөнд цугларчээ. Хейген авгайгаа арай гэж аргадан гэр лүү нь явуулж, харин Поли Гатто Тессиогийн хүмүүсийн бүрэн хараа хяналтад байгаагаа ер мэдсэнгүй, зочдын өрөөнд хүлээсэн хэвээрээ л...

Том Хейген нөгөө хэддээ Солоцогийн тавьсан болзлыг үгчлэн дамжуулаад Их Эцгийн амьд байгааг мэдмэгц Солоццо хэрхэн түүнийг алахаар завдсаныг яриад жуумалзлаа.

- Би дээд Шүүх дээр очлоо ч гэсэн тэр новшийн Түрэгийн өмнө өнөөдөр донгодсон шиг уран цэцэн ярьж чадахгүйсэн. Их Эцэг амьд байлаа ч гэсэн би та нарыг зөвшөөрүүлж чадна гэж заллаа шүү дээ. Бас Сонни чамайг амархан хуурч дөнгөнө гээд чамтай хамт сургуульд байснаа дурсаж, чи Сонни уучлаарай, манай намыг толгойлохоос дургүйлхэхгүй хүн гэж хүртэл донгоссон шүү. Бурхан намайг өршөөг!

Тэрээр аврал эрсэн нүдээр Сонниг харж гунигтай инээвхийлсэнд цаадах нь бүхнийг ойлгож буйн тэмдэг болгон толгой дохив.

Майкл утасны хажуугийн буйдан дээр тэр хоёрыг харж суулаа. Хейгенийг орж ирэхэд Сонни гүйж очоод тэврэхээр нь Том Хейген ахад нь өөрөөс нь хамаагүй ойр дотно байдаг юм байна хэмээн хардах харамлах сэтгэл төрж билээ.

- За одоо ажилдаа орж, юу хийхээ төлөвлөх ёстой байна. Уг нь Тессио бид хоёр зарим зүйлийг товлосон юмсан. Тессио, наад жагсаалтаа Клеменцад өгөөдхөөч! - хэмээн Сонни албаны байдалтай дуугарав.

- Хэрэв бид шийдвэр гаргах юм бол Фреддиг дуудах хэрэгтэй - гэж Майклын зөрсөнд Сонни царай барайлган хариу үгүүлрүүн:

- Фредди сэтгэлийн хүнд хямралд орсон болохоор бүрэн тайван байлгах хэрэгтэй гэж эмч хэлсэн. Түүнгүйгээр л шийдэхээс. Тэрбээр аавыг бурхантай зүйрлэн биширдэг байсан юм чинь нүдэн дээр нь аавыг шархдуулахад их цочирдож, бас гутарсан биз. Майкл бид хоёр бол ч өөр л дөө.

Хейген тэр хоёрын ярианд яаран оролцлоо.

- За за, Фреддиг тайван байлга, бүү оролд. Хөөе Сонни, энэ бүх хэрэг явдал нэг тийш болтол чи гудамжинд бүү үзэгд, энд чамд аюулгүй. Солоцог дугуу үнэлж болохгүй, өөрийнхөө ажилд гаргуу хүн шүү. Эмнэлгийг хамгаалж байгаа юу? Сонни толгой дохив.

- Цагдаагийн газар эмнэлгийн үүдэнд харуул гаргасан, манай залуус ааваас нүд салгахгүй байгаа. За Том, жагсаалт чамд ямар санагдав даа?

Хейген нэрсийг уншихдаа магнай үрчийлгэн баргар царайлна.

- Сонни, чи сэтгэлийн хөдөлгөөндөө хэт хөтлөгджээ. Чөтгөр ав гэж, Загалмайлсан эцэг бол ажил хэрэгч байдлаар хандахсан. Хамгийн гол нь одоо Солоццо, түүнийг л тонилгочихвол бүх юмны учир олно гэдгийг ойлгооч. Энэ Тагтальягийнхнаар чи яах гээ вэ?

Сонни итгэмжлэгдсэн төлөөлөгч нар өөд харсанд Тессио мөрөө хавчив.

- Тийм ээ, энэ ч амаргүй дээ.

Клеменца зөвшөөрснөө мэдэгдэн чив чимээгүй байхаар нь Сонни түүнд хандан:

- Маргаангүй ганц ойлгомжтой юм нь гэвэл Полиг үгүй хийх хэрэгтэй байна. Эхнийх нь тэр болог тарган бүдүүн эр дуугүй л толгой дохилоо.

- Люка яасан бэ? Миний бодоход, Солоццо түүнээс нэг ч их айхгүй байгаа тул би Люкагийн төлөө үнэхээр санаа зовоод байна. Хэрэв Люка урвасан бол ч бидний хэрэг базаахгүй талаараа эргэнэ дээ. Түүний үнэнч хэвээрээ эсэхийг л юуны өмнө олж тогтоох хэрэгтэй. Түүнтэй хэн холбоо барьсан бэ? - хэмээн Хейгений асуусанд Сонни түрүүлэн ам нээв.

- Хэн ч чадаагүй. Би түүн рүү бүхэл оройжингоо утасдсан.

- Майк аа, арван таван минут болоод л утасдаад бай, заавал хариу авах ёстой шүү - хэмээн Хейгений захисанд Сонни тэсч ядан түүнд үгүүлрүүн:

- Хөөе Том оо, чи зөвлөх хүн, одоо нэг зөвлөөд өгөөч. Бид ер нь яах ёстой болж байна?

- Аав чинь ажил хэргээ дахин толгойлох хүртэл Солоццотой хэлэлцээр хийх хэрэгтэй. Тун болохоо байвал зөвшөөрсөн дүр үзүүлэхэд яадаг юм бэ? Их Эцэг эдгэрч ирээд бүх юмны учрыг чимээгүйхэн олж, зөвөөр шийднэ биз.

Сонни дүрсхийн уурлаж:

- Чинийхээр бол, би Солоццог дийлэхгүй юм биз дээ? - гэсэнд Том Хейген түүний нүд рүү эгцлэн ,ширтлээ.

- Корлеонегийн нам хүчтэй болохоор чи дийлэх нь дийлнэ. Чамд Клеменца, Тессио хоёр байна. Хэрэв дайтах дээр тулбал энэ хоёр мянгаар нь ч болсон хүн цуглуулж чадна. Гэвч энэ тохиолдолд Дорнод эрэг даяар алаан хядаан дэгдэж, бусад нам эвслүүд ганцхан Корлеонегийн намыг л буруутгаж, бид олон дайсантай болно. Аав чинь өөрөөр ажиллахыг сургадагсан.

- Хэрэв аав амьд гарч чадахгүй бол яах вэ, зөвлөх өө?,

- Би чиний зөвшөөрөхгүйг мэдэж байна, Сонни. Гэхдээ аав чинь нас барчихвал чи Солоццогийн саналыг хүлээн авч, мансууруулагч наймаалсан нь дээр. Аавын чинь танил тал, түүний өөрийнх нь нөлөөгүй бол Корлеонегийн намын хүч хоёр дахин суларна. Их Эцэг байхгүй ,болбол Нью Йоркийн бусад намууд ядахдаа олон жилийн хүйс тэмтрэх дайнаас зайлсхийх тул Солоццо, Тагталья хоёрыг дэмжих болно. Хэрэв үнэхээр аав чинь нас бардаг л

юм бол чи зөвшөөрөөрэй. Тэгээд харан, байж бодъё.

Сонни уурласандаа хувхай цайж:

- Чиний эцэг рүү буудаагүй болохоор чамд ингэж хэлэх амархан биз - гэсэнд Хейген омог бардам дуугаар тэр дор нь хариу үгүүлрүүн:

- Би Майк та хоёр шиг л түүний хүү, илүү дотно ч байж магадгүй. Би чамтай зөвлөхийн хувиар ярилаа. Хэрэв чи миний хувийн бодлыг сонирхож байгаа бол, би тэднийг бүгдийг нь өөрийн гараар багалзуурдаж алахсан.

Сонни ичингүйрсэн янзтай толгой унжуулав.

- Уучлаарай, Том, өөрийн мэдэлгүй дуугарчихлаа.

Үгүй ээ, үнэн хэрэг дээрээ бол өөрийн эрхгүй дуу гарчихсан юм биш, төрсөн үр гэдэг чинь мах цусны тасархай, яах арга байхгүй. Сонни царай даран бодолд дарагдан бусад нь сэтгэл тавгүйрхэн дуугүй хүлээцгээж байтал тэрбээр гүнзгий санаа алдаад тайван хэлсэн нь:

- За яахав, аавын ирэхийг хүлээе дээ. Гэхдээ Том чи ч гэсэн аз туршаад яах вэ, эндээ бай. Майк чи ч ялгаагүй болгоомжлоорой. Гэхдээ Солоццо манайхныг бүгдийг хүйс тэмтэрч арай ч зүрхлэхгүй байх. Тэгвэл бүгдээрээ түүний эсрэг босох болно. Гэсэн хэдий боловч Майк мэдээтэй байгаарай. Тессио хүмүүсээ бэлэн байлгаж, хотод юу болж байгааг сайн хянуулж бай. Клеменца чи Гаттог зүйл дуусгамагц, Тессиогийн хүмүүсийн оронд эмнэлэгт, мөн нааш нь залуусаа ирүүлээрэй. Тессио ,юмыг яаж мэдэхэв, одоохондоо хүмүүсээ эмнэлэг дээр байлгаж бай. Том, чи ердөө л маргааш өглөөнөөс эхлэн утсаар юм уу, зуучлагчаар дамжуулан Солоццо, Татталья хоёртой хэлэлцээ хийж эхлэх хэрэгтэй. Майк аа, маргааш Клеменцагийн хүмүүсээс хоёрыг аваад Люкагийн д очиж хүлээж байгаад уулз, эсвэл хаашаа алга болсныг нь мэдэж ир. Хэрэв тэр, энд юу болсныг дуулсан л бол өдийд Солоццог багалзуурдах хариугүй дөхөж явах учиртай. Тэр золигийн Түрэг түүнд уул шиг алт амласан байсан ч, Люкаг урвасан гэдэгт би хэзээ ч итгэхгүй.

- Майкийг оролцуулаад хэрэг байна уу даа? - хэмээн Хейгенийг эргэлзэнгүй асуусанд Сонни зөвшөөрөв.

- Чиний зөв ч юм уу даа. Майк аа, чи утсан дээр бай, энэ нь надад илүү чухал.

Майкад нэг л эвгүй, ичгүүртэй ч юм шиг байсан тул юм дуугарсангүй. Тессио, Клеменца хоёр түүнийг үл тоомсорлодгоо мэдэгдэхгүйг хичээн хэнэггүй царайлна. Майк харилцуур авч Люка Брази уруу залгаад тасалдсан дууг чагнан суусаар...

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Питер Клеменца тун тавгүй нойрсож, өглөө эртлэн босоод өөрөө хоолоо бэлтгэжээ. Усны хуучин халаад нөмөрч, улаан эсгий улавч өмссөн сайхь эр гэр дотуураа холхин, одоо хийх ёстой ажлаа тунгаан бодно. Поли Гаттог нэн даруй устгах хэрэгтэй гэж Сонни өчигдөр тодорхой захирамж өгсөн юм чинь өнөөдөр л хийх болж дээ.

Клеменцагийн сэтгэл тавгүйрхсэний учир нь түүний гарын хүн урвасанд байгаа юм биш ээ. Энэ нь Клеменцад ямар ч хор хүргэхгүй. Эцсийн эцэст Полигийн тухай бүх юмыг бүгд мэднэ. Тэрээр сицили гэр бүлд төрж, Корлеонегийн хүүхдүүдийн дэргэд шахуу өсөн хүмүүжиж, шалгалт сорилтыг амжилттай давж, ажилд тэнцэхээ харуулсан. Поли «хүн устгах» даалгавар биелүүлсэн тул Корлеонегийн нам түүнд дориун цалин пүнлүү тогтоож, ист сайдын мөрийтэй тоглоомын газар, үйлдвэрчний эвлэлээс орох орлогын тодорхой хувийг өгөх болсон ажээ. Поли Гатто Корлеонегийн намын дотор тогтоосон хатуу дүрэм журмыг зөрчин гадуур дээрэм хийж аз туршдаг болов уу гэж Клеменца хий хардан сэрдэх боловч сүрхий эр юм даа хэмээн бодоод өнгөрөхөөс цаашгүй. Тушаалыг ийнхүү үл тоомсорлох нь овжин зан, эр зоригийн шинж гэж үздэг байлаа. Залуу хүнд халаасны мөнгө ахиухан хэрэгтэй учир энэ бүхэн хаана ч байдаг л зүйл. Харин Поли Гаттог урвах юм гэж хэн бодлоо?!

Үгүй ээ, өнөө өглөө Клеменца огт өөр юманд сэтгэл түгшинэ. Поли Гаттог устгах бол ердийн, өдөр тутмын л хийдэг ажил, харин бие хамгаалагчийг хэнээр орлуулах вэ? Гар хөлийн үзүүрт явдаг жирийн хүний хувьд энэ нь албан тушаал их ахиж байгаа хэрэг боловч эл асуудалд буурьтай хандаж, унхиагүй, болхи эрийг биш, хэрэв баригдвал амаа хамхиад, сицилийн нууц хадгалах журмыг үхэн сахиж чадах тийм найдвартай сэргэлэн хүнийг сонгож олох хэрэгтэй. Шинэ ажлынх нь хөлсөнд хэдийг өгөх вэ гэдэг бас нэг асуулт байна. Хэрэг явдал гарахад бие хамгаалагч л бусдаас урьд галын шугам дээр очдог. Гар хөлийн үзүүрт явдаг олигтой хүмүүст ахиухан хөлс төлж байх талаар Клеменца Их Эцэгт бишгүй л ярьсан боловч тэрээр дуугүй явсаар өдий хүрчээ. Поли мөнгөөр гачигдах нь арай гайгүй бол хорон зальт Түрэгийн урхинд орохгүй байсан ч юм билүү, хэн мэдлээ?!

Эцсийн эцэст Клеменца Рокко Лампоне дээр тогтлоо. Корлеонегийн намд ажиллаад удаагүй боловч Рокко бусдаасаа ялгарч, тушаал ахиж амжжээ. Тэрбээр Африкт байлдаж шархдаад 1943 онд халагдсан, тэр үедээ сүрхий доголдог байсан боловч залуу хүмүүсийн хэрэгцээ их тул Клеменца түүнийг авчээ. Лампоне ер нь дороо суурьтай, дотроо бодолтой тул Клеменца түүнийг их үнэлнэ. Багахан хугацаагаар суух буюу ахиухан торгууль төлөөд аргалж болох газар дөвчигнөж байж ноцтой хохирол амсах хэрэггүй, энэ бол сүүлд авах шан хөлснийх нь дэргэд юу ч биш гэдгийг Лампоне сайн ойлгодог байлаа. Тэр бас жаахан сүрдүүлэх нь хэтрүүлэхээс дээр гэдгийг ойлгодгоос гадна илүү дутуу шуугиан тарьдаггүй нь хамгийн сайн тал нь байв.

Клеменца, боловсон хүчнийг шилж сонгох бэрх асуудал шийдсэн захиргааны шударга түшмэл шиг сэтгэл нь хөнгөрөөд явчихлаа. За тэгэхлээр, өөрийн туслахаар Рокко Лампонег авах хэрэгтэй юм байна. Клеменца зөвхөн нас залуу, туршлагагүй Роккод анхны «хүн амины хэрэгт» нь туслахыг хүссэндээ ч биш, Поли Гаттотой хувийн тооцоо бодох гэсэндээ эл

даалгаварт өөрөө оролцохоор шийдсэн байна. Поли бол яг өөрийнх нь халамжилдаг хүн бөгөөд Клеменца өөр олон илүү найдвартай, нэр хүндтэй хүмүүсийн толгой дээгүүр алгасуулан Полиг,бие хамгаалагч болгон, анхны «хүн амины хэргээ» амжилттай гүйцэлдүүлэхэд нь тусалж, аль болохоор тушаал ахиулахыг эрмэлзэж явжээ. Тийм учраас Поли гагцхүү Корлеонегийн намаас төдийгүй, өөрийн халамжлагч Питер Клеменцагаас урвасан хэрэг. Тэгэхлээр, тусыг усаар хариулсан хүнийг заавал шийтгэх хэрэгтэй.

Бусдыг урьдаас бодож боловсруулсан байв. Гурван цагт Поли Гатто өөрийн машинаар ирж Клеменцаг авна. Тэрбээр утас уруу очиж, Рокко Лампонегийн дугаарыг эрэгдээд нэрээ ч хэлсэнгүй, зүгээр л:

- Хоёр цагаас хожимдолгүй манайд ирээрэй. Ажил гараад байна - гэвэл цаадах нь:

- За, за - хэмээн товчхон хариулав.

Клеменца эрхэм Корлеонегийн гэрт байсан итгэмжлэгдсэн төлөөлөгч Тессиогийн хүмүүсийг соль гэж өөрийн залууст хэлчихсэн болохоор хийх ажил нэгээр багассан хэрэг. Түүний залуус шаламгай хөдөлдөг тул өөрсдөө бүгдийг амжуулж дөнгөнө.

Харин одоохондоо «кадиллак»-аа угаадаг юм билүү? Машинаа угааж арчих зуур элдэв юм тунгаан бодож эргэцүүлэхэд сайхан байдаг сандаа гэж бодоод Клеменца эцэг нь Италид байхдаа хэдэн илжгээ сойзоор угааж цэвэрлэх дуртай байсныг дурсан санав.

Клеменца угийн бээрэг тул дулаахан гараашдаа машинтайгаа ноцолдож байхдаа: «Поли үхэр огодой шиг өчүүхэн төдий аюул ослыг холоос мэдэрдэг тул тун хянуур байхгүй бол горьгүй. Юуны өмнө яагаад Рокко хамт явааг үнэмшилтэйгээр тайлбарлах хэрэгтэй. Хоёрдугаарт, хаашаа яах гэж яваагаа мөн л Полид итгүүлж чадахаар зохиож ярих нь чухал» хэмээн бодлоо.

Гэхдээ Поли нэгэнт занганд орчихсон болохоор нэг их ёсорхолгүй цааш харуулчхаж болно. Зөвхөн Клеменца цэвэрхэн ажиллах дуртай болоод л өөртөө ийм өндөр шаардлага тавьсан хэрэг. Тэгээд ч, нэгэнт үхэх сэхэх тухай яригдаж байхад өчүүхэн төдий ч аюул байвал зайлуулахыг л хичээх хэрэгтэй. Юмыг яаж мэдэх вэ?!

Клеменца цэлмэг тэнгэрийн өнгөтэй «кадиллак»-аа угаан зүлгэх зуур өөрийн тоглох дүр, үйл хөдлөл, яриагаа дотроо ахин дахин сургуулилна. Эхлээд Поли ямар нэгэн буруу ажил хийсэн юм шиг тун ширүүн уулзах хэрэгтэй. Тэгвэл араатных шиг сонор мэдрэмжтэй, айхавгар хардаж сэрддэг Поли Гаттог балмагдуулан төөрөлдүүлж, ядахдаа итгэл алдруулах болно. Гэхдээ бас хэрээс хэтрүүлж болохгүй. Хайнга атлаа жаахан сэтгэл түгшиж уцаарласан толгойлогчийн дүр үзүүлж болох л юм... Одоо Лампоне байна. Рокко ард нь суух юм чинь түүнтэй хамт явна гэхээр гэнэт Полид сэжиг төрвөл яана? Лампоне ард нь сууж байхад жолоо барина гэдэг эсэргүүцэл үзүүлэх бололцоогоо алдана гэсэн үг. Клеменца «кадиллак» машинаа гялалзтал зүлгэсээр л байлаа. Энэ асуудалд тун их заль гаргахгүй бол горьгүй. Өөр нэг хүн авдаг юм билүү? ,Аа, хэрэггүй байх. Цаашдаа асуудал хүндрээд хам хэрэгтний нэг нь Клеменцагийн эсрэг мэдүүлэг өгөх хэрэгцээ гарах ч юм билүү?! Хэрэв гэрч нэг байвал мэдүүлэг нь тэнцэнэ. Харин гэрч хоёулаа болвол түүний мэдүүлэг ганцаардаад дийлдэж мэдэх юм. Үгүй ээ, яг л бодсоноороо хийх нь зөв юм байна.

Зөвхөн хүүрийг нь үгүй хийж, хэргээ нууцалж болохгүй нь л тоогүй. (Гол төлөв тэнгис юм уу, эсвэл тэдний намын журмын найз нарын эзэмшилд байдаг Нью Жерсийн намагт хүүр далд хийдэг, үгүй бол өөр нарийн аргаар устгадаг ажээ. Гэвч урван тэрслэх санаа өвөрлөж яваа бусад хүмүүст сургамж болох, бас Корлеонегийн намд нусаа гоожуулсан маанаг юмнууд байх ёсгүй гэдгийг дайснууддаа мэдүүлэхийн тулд энэ удаад ял цээрлэлийг ил тод хийх ёстой. Солоццо өөрийнхөө мэдээлэгчийг ямар амархан илрүүлснийг мэдмэгц бараг л зүрх нь зогсчих байлгүй. Корлеонегийн намынхан их Эцгийг буудуулж гэнэдээд элэг доог болсныхоо хариуг ядахдаа хагасчилж ч болсон авах ёстой юм байгаа биз дээ. «Кадиллак» машинаа том төмөр өндөг шиг гялалзан харагдтал нь зүлгэсэн хэрнээ Клеменца олигтой тайлбар бодож олсонгүй, үе үе гүн санаа алдаж байтал гэнэт яагаад Рокко Лампоне авч явах ёстой, тэгэхдээ дуу чимээ гаргахгүй байх хэрэгтэй гэх зэрэг бүх асуудлыг нэгэн зэрэг тайлбарлах маш энгийн, хэнд ч зүй ёсны санагдах сайхан санаа толгойд нь харван орж ирлээ.

Тэд хэрэв намынхан «дэвсгэр дээр хэвтэхэд» хүрвэл толгой хоргодох байр эрж яваа гэж Полид хэлнэ. Гэр бүлийн синдикатуудын хоорондын дайн ширүүсээд ирэхээр өрсөлдөгч талууд ямар нэгэн орон байр хөлслөн авч тэнд бүгд хоргодон, «цэргүүд» нь шалаар зулсан дэвсгэр дээр унтдаг байв. Энэ нь төрөл төрөгсдөө хамгаалах гэсэндээ биш, хэн, хэндээ халтай болохоор алаан хядаанд оролцоогүй эмэгтэйчүүд, хүүхдүүдэд хэн ч, хэзээ ч халдаж байгаагүй, зүгээр л эрүүл ухаанаар бодож үзээд дайсны хараанаас холхон байх, бас цагдаагийн газрынханд тэдний хэрэгт хөндлөнгөөс оролцох солиотой бодол төрвөл нууц байранд байх гэсэндээ л тэр юм. Гол төлөв хамгийн найдвартай итгэмжлэгдсэн төлөөлөгч байр хөлслөн, дэвсгэр хүргэж аваачдаг бөгөөд тэр хоргодох байрнаасаа хэрэгцээтэй тохиолдолд хот уруу сэм гарч дайралт хийдэг байжээ. Клеменцад л хамгийн түрүүнд ийм даалгавар өгөх байсан бөгөөд тэр байраа тоноглож тохижуулахад туслалцуулахаар Гатто, Лампоне хоёрыг авч яваа нь ч зүйн хэрэг. «Түүнээс гадна шунал ихтэй Поли ийм үнэтэй мэдээ хүргэж очоод Солоццогоос хэчнээн юм салгаж авах бол хэмээн шүлс нь гоожоод хардаж сэрдэх нь арай гайгүй болно» гэж бодоод Клеменца доогтой нь аргагүй жуумалзав.

Рокко Лампоне нилээн эрт ирж, Клеменца түүнд юу хийхийг тодорхой тайлбарлаж өгсөнд тэрээр эхлээд их гайхсанаа, намынханд тус хүргэх бололцоо олгож буйг ойлгомогц талархсан нүдээр итгэмжлэгдсэн төлөөлөгчийг ширтлээ. Энэ нь үлэмж дэвшиж буйн тэмдэг тул Клеменцад гялайснаа илэрхийлсэнд тэрээр зөв хүнээ сонгож авчээ гэж урамшин Лампонегийн мөрийг найрсгаар алгадав.

- Маргаашаас эхлээд чамд зөвхөн талхны мөнгө төдийгүй, бас ахиухан юм унах болно. Энэ тухай дараа ярья. Манай намд одоо илүү чухал ажил зөндөө байгааг чи өөрөө мэдэж байгаа шүү дээ. Лампоне мэдээжээр хүлээж байлгүй яах вэ, шан хөлс баталгаатайд ер эргэлзэхгүй байна гэх ухааны юм батлан үгүүлэв. Клеменца гараашдаа орж төмөр шүүгээнээс гар буу гаргаж Лампоне өглөө.

- Май, энэ бууг таньж мэдэх ямар ч аргагүй. Дараа нь машин дотор Полигийн хажууд хаячихна биз. Энэ хэргээ дуусгаад чи эхнэр хүүхдээ авч Флорид уруу яваарай. Зардлаа өөрөө даа, дараа нь чамд нөхөж өгнө. Хэрэг болвол хаанаас олохыг би мэдэж байхын тулд Майами Бич дэх «Корлеоне» зочид буудалд байрласан нь дээр биз.

Клеменцагийн эхнэр хаалга тогшиж, Поли Гатто өөрийнхөө машинаар ирснийг мэдэгдсэнд

тэр хоёр гараашаас гарч, Гаттогийн хажууд лагхийн суугаад цагаа харснаа Полиг хожимдож ирсэн юм шиг амандаа зэмлэнгүй бувтнав. Арын суудалд нь Лампоне орж суухад учрыг нь олох гэсэндээ Полигийн шөвгөр царай чимээ чагнасан туулай шиг сэрэмжилсэн янзаар хэсэг хөшсөнөө ярвайж:

- Рокко, хажуу тийшээ болооч. Ийм мангар амьтан байж яг толь таглаад суучих юм - гэвэл Лампоне энэ үгэнд ер гайхсангүй яаран зайлж Клеменцагийн ард суулаа.

Клеменца Гаттод хандан хорсож уурласан янзтай үгүүлрүүн:

- Сонни мэдрэл муутай юм шиг үхтлээ айгаад бүгэхээр шийдэж, Вест Сайдад байр ол гэсэн. Рокко та хоёр хоол хүнс, дэвсгэр гудас базааж, түүнийг тушаал буулгасан цагт бүгдийг бэлэн болгоорой. Поли чи олигтой газар мэдэхгүй биз?

Яг л итгэмжлэгдсэн төлөөлөгчийн бодсоноор Поли мэхэнд хууртаж, энэ мэдээг Солоцод хэдээр худалдахаа тооцоолон аюул хөнөөлийн тухай бодохоо ч мартчихжээ. Харин Лампоне дүрдээ сайн тоглож, ер юу ч болоогүй юм шиг цонхоор шагайн исгэрч суусанд Клеменца оновчтой сонголт хийлээ гэж өөртөө дахин баяр хүргэв.

Гатто мөрөө хавчин:

- Бодох хэрэгтэй гэсэнд Клеменца уцаарласан дүр үзүүлэн амандаа бөвтнөв.

- Бодох нь бод, харин бушуу хөдлөөч. Би маргааш биш, өнөөдөр л Нью Йорк орох ёстой.

Тэд дув дуугүй явсаар өвлийн эртэч бүрэнхий нөмөрч байхад хотод ирж, Клеменца Вашингтон Хейтс дүүрэг рүү эргэхийг тушаав. Тэд нилээн хэдэн сууц үзсэний дараа Клеменца Артур авеню хүрч, нөгөө хоёроо машиндаа суугаад хүлээж бай гэлээ. Тэрээр өөрөө Вера Мариогийн зоогийн газар орж, тугалын мах, салат зэрэг хөнгөн хоол захиалан, зарим нэг танилтайгаа хэд гурван үг солиод нэг цагийн дараа гарч ирэв.

- Золиг байх гэж, Соннид яаралтай ажил. гараад Лонг Бичд буцаад ир гэнэ. Бас дэвсгэр олдоогүй юм байх. Рокко, чи чинь энд суудаг байх аа? Чамайг дөхүүлээд өгөх үү? хэмээн Клеменца асуусанд Рокко тайван дуугаар хариу үгүүлрүүн:

- Би машинаа танай гэрийн гадаа орхичихсон. Гэтэл авгай маргааш өглөө машин хэрэгтэй гэсэн юмсан.

- Тэгвэл яая гэхэв, хамт л явахаас даа! Тэд буцаад дув дуугүй явсаар хотын захад гараад Клеменца гэнэт:

- Поли зогсоодхооч. Би морь хараад ирье гэв.

Поли лагс биетэй итгэмжлэгдсэн төлөөлөгчөө олон удаа зөөсөн, давсаг султайг нь андахгүй тул ер гайхсангүй, намаг тийш очдог шороон замаар эргэлээ. Клеменца замын хажуугийн бутан дунд бие засчхаад эргэж ирэхдээ ийш тийш харвал эргэн тойрон эл хуль, түнэр харанхуй байсанд:

- За одоо! - гэж товчхон дуугарав. Машин дотор буу тасхийж, Поли Гатто урагшаа ухасхийн залуур цээжээрээ налснаа суудал уруугаа гулсаж, Клеменца цусанд будагдчихгүйн тулд бушуухан хойш боллоо. Рокко Лампоне машинаас гарч гар буугаа намагт чулуудчихаад тэрүүхэн хавьд нуусан өөр машины зүг яаран одов. Лампоне жолоочийн суудал доогуур тэмтрэн түлхүүр авч машинаа асаагаад Клеменцаг гэрт нь хүргэсний дараа өөрөө Нью Йорк уруу ондоо замаар буцаж гэртээ харьжээ.

ДОЛООДУГААР БҮЛЭГ

Эрхэм Корлеонег бууддагийн өмнөх өдрийн орой түүний хамгийн хүчтэй, хамгийн аюултай, хамгийн, үнэнч шадар туслах нь дайсантай тулалдахаар бэлтгэж байв. Эрхэм Корлеонегийн өөрийнх нь тушаалаар Люка Брази Солоцогийн талынхантай холбоо тогтоож, Таттальягийн намын мэдэлд байдаг шөнийн цэнгээний газруудаар хэсч явсаар, тэндэхийн хамгийн шилдэгт тооцогдох нэг хүүхэнтэй танилцжээ. Люка түүнтэй орондоо хэвтэх зуур Корлеонегийн намынхан намайг огт үнэлдэггүй, хавчиж гадуурхдаг гэж гомдоллоно. Долоо хоногийн дараа гэхэд л шөнийн клубийн эзэн Бруно Татталья, түүнтэй мэндлэн, аахар. шаахар юм ярих болов. Бруно бол Таттальягийн отгон хүү бөгөөд түүний л мэдэхийн тэдний намын санхүүгийн гол эх үүсвэрт огт хамаагүй боловч Нью Йоркийн янхны газрын олон хүүхнүүд Бруногийн шөнийн клубийн урт хөлт «бүжигчдийн» алдарт цэцэрлэгт дадлага хийсэн бөлгөө.

Анхны уулзалтаар сүйдтэй ч юм болсонгүй, Бруно «журам сахиулагч бол гэж Люкад санал болгоод сар хэртэй ятган элдвээр саймширхав. Люка Брази хуял тачаалдаа мансуурсан хижээл эр болж, Бруно Татталья өрсөлдөгчөөсөө үнэтэй сайн ажилтныг нь өөртөө татаж авах гэсэн ажил хэрэгч хүний дүрд тоглож нэг хэсэг жүжиглэсэн аж. Нэгэн удаа ярилцаж суугаад Люка ятгалгад нь авгаж буй дүр үзүүлээ.

- Гэхдээ нэг болзол байна. Загалмайлсан эцгийн эсрэг би хэзээ ч, юу ч хийхгүй шүү. Би эрхэм Корлеонег хүндэлдэг, гэхдээ ажил хэрэгтээ бол намайг биш, төрсөн хүүхдүүдээ илүүд үзнэ гэдгийг сайн ойлгож байна.

Бруно Татталья залуу хүн болохоороо Люка Брази, эрхэм Корлеоне зэрэг хуучны үзэл баримталдаг хүмүүст тэр ч бүү хэл төрсөн эцэгтээ дээрэлхүү хандаж, тэднийг үл тоомсорлох байдлаа хэрээс хэтэрсэн хүндэтгэлийн цаана нууж явдаг нэгэн ажээ. Харин одоо тэрээр:

- Аав минь таныг Корлеонегийн эсрэг яв гэхгүй. Тэгээд ч яах юм билээ? Хуучны юм ул болж, одоо бүгд л эв эеэ хичээх болсон. Зүгээр л танд ажил хэрэгтэй байгаа бол би аавдаа хэльеү л гэсэн юм. Уг нь тан шиг хүн манайд хэзээд хэрэг болно. Бид буурьтай ажил эрхэлдэг, түүнийгээ амжилттай явуулахын тулд бас л буурьтай хүмүүсийг ажиллуулах шаардлагатай болдог юм. Хэрэв та зөвшөөрвөл бидэнд хэл өгөөрэй - гэсэнд Люка мөрөө хавчив.

- Уг нь ч надад тэнд тийм ч муугүй байгаа юм л даа.

Тэгээд л тэр хоёр салж явжээ.

Люка Бразигийн гол зорилго нь мансууруулах бодисын орлоготой арилжааны тухай олж мэдээд бие даан оролцох хүсэлтэй байгаа мэт сэтгэгдэл Таттальяд төрүүлэх явдал байлаа. Хэрэв энэ нь бүтвэл Солоцогийн бодож сэдсэнээс зарим хагасыг ч болов олж мэдэх аз таарч, ялангуяа Түрэг эрхэм Корлеонетой өрсөлдөх эсэхийг тодруулж чадах ч байж магадгүй юмсанж. Ингэснээр хоёр сар өнгөрч, Солоццо ялагдлаа тайван хүлээсэн юм шиг байгааг Люка эрхэм Корлеонед илтгэсэнд Их Эцэг яг л энэ хэвээрээ, гэхдээ хэт жүжиглэлгүй ажиллахыг тушаажээ.

Эрхэм Корлеонегийн амь насанд халдахын өмнөхөн Люкаг шөнийн клубт дөнгөж ортол Бруно Татталья ширээнд нь ирж суув.

- Нэг танил маань тантай ярих юмсан гэнэ.

- Нааш нь аваад ир. Чиний танил л юм бол ярьж болохгүй нь юу билээ?!

- Үгүй ээ, тэр хоёулхнаа уулзах гэнэ.

- Юун хүн юм бэ?

- Яахав дээ, нэг таньдаг л хүн - хэмээн Бруно Татталья булзааруулж: - Танд нэг зүйлийг санал болгох гэнэ. Өнөөдөр оройхон уулзвал ямар вэ? - гэв.

- За яахав, хэзээ хаана уулзах вэ?

- Клуб өглөөний дөрвөн цагт хаана. Үйлчилгээний танхим цэвэрлэх хооронд энд уулзвал зөвшөөрөх үү?

Үүр цайтал унтдаггүйг минь мэддэг болоод л ийм цагт болзож дээ хэмээн Люка дотроо бодлоо.

- За за, дөрвөн цагт ороод гаръя.

Люка клубээс гарч, таксигаар Аравдугаар авеню дэх гэртээ харьжээ. Тэгэхлээр, хорон залыг үнэг нүхнээсээ сүүлээ цухуйлгах гэж дээ?! Хэрэв энэ яриа амжилттай дуусч, Солоццо бодол санаагаа илчилбэл, эрхэм Корлеонед Христосын мэндэлсний баярын муугүй бэлэг болж тун ч магадгүй юм шүү.

Люка гэртээ ирээд орон дороосоо жижигхэн авдар татаж хүнд төмөр гархин хуяг гарган цамцан дотуураа өмсөв. Эрхэм Корлеонед утасдаж, шинэ мэдээ дуулгах гэснээ болилоо. Их Эцэг ер нь өөрөө утсаар ярьдаггүйгээс гадна эл даалгаврыг өөрийн биеэр өгсөн болохоор Хейген ч, Сонни ч мэдэхгүй. Тэгэхлээр энэ тухай аль болох цөөн хүн дуулбал л зүгээр юм байна.

Люка дандаа зэвсэгтэй явдаг байлаа. Тэрбээр арван мянган доллар төлж байж буу авч явах эрхтэй болсон бөгөөд хэдийгээр их үнэтэй олдсон боловч цагдаад нэгжүүлэх дээр тулбал тэр бичиг нь Люкаг шоронгоос аврах байв. Люкагийн зиндааны хүний үйл ажиллагаанаас Корлеонегийн эзэнт улсад ихээхэн юм шалтгаалах тул ийм эрхтэй ч байлгүй яах вэ?!

Өнөөдөр Солоццогийн хувь заяаг нэгмөсөн шийдчих бололцоо гарах тохиолдолд хэнийхийг нь танихын аргагүй автоматаа авч явмаар санагдсан боловч сайн муу талыг цэгнэж үзээд өнөөдөртөө зөвхөн Солоццогийн саналыг сонсож, эрхэм Корлеонед дуулгаад л боллоо гэж шийдэв.

Шөнө дөл болгоод Люка клуб рүү явах замдаа архи дарс амссан ч үгүй, дөчин наймдугаар гудамж дахь Патсигийн ресторанд тайван сууж хоол идээд мөн л яаралгүй цааш явлаа.

Дөрвөн цаг болгоод клубт орвол хаалгач нь алга, хувцасны өлгүүрийн хүүхэн ч яваад өгчээ. Түүнийг Бруно Татталья угтан авч хов ноосон баар уруу дагуулан очвоос түүний хажуугаар арчаад цэвэрлэчихсэн ширээнүүд эгнэн ярайж, яг дунд нь шар модоор шахаж шалласан бүжгийн талбай үнэт эрдэнэсийн чулуу шиг гялалзаад, цаад бүрэнхийд нь хөгжимчдийн тавцан бүүдийж, голд нь тавьсан микрофон нарийхан шилбэтэй цэцэг шиг харагдах ажгуу.

Люка баарын сандалд сууж, Бруно Татталья лангууны цаагуур орсон боловч Люка архи уухаас татгалзаж, тамхиа асаангаа Түрэг алга байгаа тул өөр хүн ирэх юм болов уу хэмээн бодож суутал Солоццо бүдэг гэрэлтэй танхимын гүнээс хий үзэгдэл мэт гэнэт урган гарч ирэв.

Солоццо түүнтэй тар барьж хажууд нь сандайлахад Бруно Татталья өмнө нь шилэн аягатай дарс тавьж, Түрэг толгой дохин талархлаа.

- Та миний хэн болохыг мэдэх үү?

Люка толгой дохиод ёозгүй жуумалзав. Араатанг айлгаж ичээнээс нь гаргаж дээ. Түрэг хүний үнэр нэвт шингэсэн энэ сицили эртэй үзэлцэхэд ямар сонин байх бол?

- Миний юу хүсч байгааг мэдэх үү? Люка толгой сэгсэрсэнд Солоццо шууд ажил хэрэгч яриандаа орлоо.

- Бид дээр нь байгаа хүмүүст сая саяар орлого оруулах дорвитой ажил эхэлж байгаа. Эхний хэсгээс нь л танд тавин мянгыг багтай амлаж чадах байна. Би тун их ирээдүйтэй мансууруулагчийг хэлсэн юм.

- Та үүнийг яах гэж надад яриа вэ? Надаар загалмайлсан эцэгт дамжуулах гэсэн юм уу?

Солоццо жигтэйхэн дургүйцэж ярвайлаа.

- Түүнтэй ярьж үзсэн чинь балиар ажилд оролцохгүй гэсэн болохоор түүнтэй түүнгүй болох л биз. Гэхдээ надад харуул хамгаалалтын сайн хүн хэрэгтэй байна. Миний ойлгосноор бол та Корлеонегийн намд тийм ч жаргаагүй юм чинь эзнээ солиод үзвэл зүгээргүй юу?

Люка мөрөө хавчив.

- Нөхцөл болзол нь тохирвол болох л юм.

Солоццо анхнаасаа л түүний нүүр царайг анхааралтай ажиглаж суугаад одоо л нэгийг шийдэв бололтой.

- Хоёр өдөр сайн бодоорой. Дараа энэ тухай тодорхой ярилцъя - гээд Солоццо босч гар сунгасан боловч Люка хараагүй дүр эсгэн халааснаасаа янжуур гаргав. Бруно Татталья асаагуур гарган Люкагийн нүүрэнд дөхүүлснээ гэнэт асаагуураа унагачхаад түүний баруун гарын бугуйг бахь шиг базаад авлаа.

Люка эгшин зуур хариу хөдөлж сандлаасаа гулсан гараа огцом угзартал Солоццо зүүн бугуйнаас нь зуураад авав. Люка тэр хоёроос хавьгүй хүчтэй тул одоо ч гэсэн мултрад

гарчхаж дөнгөх байсан авч түүний арын харанхуйгаас нэгэн үл үзэгдэх гар нарийхан торгон уяа хүзүүнд нь углан татсанд Люкагийн амьсгаа боогдон, нүүрэнд нь цус хураад хоёр гар нь сул санжганаад явчих нь тэр.

Алуурч Люкагийн хөдөлгөөнийг яг давгаж, нурууг нь өвдгөөрөө тулан гэдийсэнд торгон оосор хөөрхий эрийн хүзүүнд далд ортлоо шигдэв. Люкагийн маш их гайхсан юм шиг нүд нь бүлт үсрэн, гагцхүү энэ гайхсан нүд л түүнд хүнийх гэхээр үлджээ. Тэр хэдийн амьсгаа хураасан байв.

- Үүнийг нэг хэсэгтээ хэн ч олохгүй байх нь чухал, сайн нуугаарай - хэмээн Солоццо зарлиг буулгаад цааш эргэж, түрүүн гарч ирсэн харанхуйдаа замхран алга болжээ.

НАЙМДУГААР БҮЛЭГ

Загалмайлсан эцгийн амь насанд халдсаны маргааш өдөр хүзүүгээр татсан ажилтай байлаа. Майкл утсан дээр суугаад, ирсэн мэдээг Соннид дамжуулж, Том Хейген аль аль талд тохиромжтой зуучлагч олж Солоцотой хэлэлцээр хийхээр хөөцөлдөж явав. Түрэг нэг л булзаж, бултаж давхих болсон нь Клеменца, Тессиогийн хүмүүс ул мөрийг нь шиншлэн хотоор хэрэн явааг мэдчихсэн бололтой. Солоццо болон Таттальягийн намын бух удирдагчид ичээндээ бүгж, яг л Соннигийн бодож байснаар урьдчилан сэргийлэх арга хэмжээ авчээ.

Клеменца Поли Гаттогийн хувь, заяаг шийдвэрлэж, Тессио Люка Бразигийн хаа байгааг олж мэдэх даалгавартай гарсан байна. Тэр эр хоёр өдөр гэртээ ирээгүй нь сайн ч ер биш дээ. Гэвч Брази тэднээс урвасан юм уу, түүнийг гэнэдүүлэн барьж авсан гэхэд Сонни ер итгэхгүй байлаа.

Соннигийн ээж эмнэлэгт ойрхон гээд хотод таньдаг найзындаа хоножээ. Тэдний хүргэн Карло Рицци туслахаар давхиж ирсэн боловч Манхэттены итали дүүрэг дэх мөрийтэй тоглоомын газраа л ажиллуулж байвал барав гээд буцаасан байна. Конни бас л танилындаа байрлаж ээжийнхээ хамт ааваа эргэдэг аж.

Нойрны эм ам уруугаа цутгуулсан Фредди хэвтэртээ хэвээрээ л... Сонни, Майкл хоёр уулзахаар ороод түүний амархан сульдаж шалчийсанд их гайхлаа. Фредди угийн болхи ухаантай, тэгээд ч сэтгэлийн тэнхээ, хатуу шийдэмгий зан, өөртөө итгэх итгэл дутмаг тул эрхэм Корлеоне дунд хүүгээ хэзээ нэгэн цагт байгууллагадаа нэр төртэй байр эзэлнэ гэж горьдохоо бүр больсон нь тийм ч санамсаргүй хэрэг биш ажээ.

Орой нь Голливудаас Жонни Фонтейн утасдахад Сонни харилцуур авчээ.

- Үгүй ээ, Жонни, ирээд нэмэргүй. Аавын бие тун тааруу, хүнтэй уулзуулахгүй байгаа. Хоёрт гэвэл сонин хэвлэлийнхэн шуугиан дэгдээнэ. Харин чи жаахан азнаж, аавыг гайгүй болоод гэртээ гарсан хойно л ирээрэй. Тэгнэ ээ, заавал дамжуулна. За, баяртай.

Сонни харилцуураа тавиад Майкл тийш эргэв.

- Жонни Калифорниос нисэж ирэх гэснийг дуулаад өвгөн ямар их баярлах бол?!

Дараа нь Клеменцагийн залуусын нэг нь ирж хотын утсаар Кей ярьж байна хэмээн Майклыг дуудлаа:

- Аав чинь яаж байна? - хэмээн Кейг нэг л хачин дуугаар асуусанд, бас л аавыг сониныхны хэлдгээр дээрэмчдийн бүлгийн толгойлогч гэдэгт бүрэн гүйцэд итгэхгүй л явна даа гэж Майкл бодож амжив.

- Яах вэ, овоо гайгүй.

Хэн хэн нь эвгүйрхэн хэсэг чимээгүй боллоо.

- Майк чи өөрөө яаж байна? Зүгээр үү?

- Би гэр дотроо эрх дураараа, ганц цагаан гартай нь гэдгийг чи мэднэ шүү дээ. Надаас хэн айх юм бэ? Би хэнд хэрэгтэй билээ? Үгүй ээ, Кей минь, одоо, яах ч үгүй, бүх юм үүгээр дуусна. Тэгээд ч ер нь санамсаргүй болсон хэрэг шүү дээ. Уулзаад тодорхой ярина аа.

- Хэзээ уулзах юм бэ?

Майкл хэсэг зуур бодол болсноо:

- Өнөө орой ч байж магадгүй. Наад зочид буудалд чинь хоол идэж, жаахан юм балгаад, дараа нь би аав уруу очъё. Энэ утас сахиад бүр залхаж гүйцлээ. Тэгж тохирох уу? - гэвэл Кей:

- Тэгье - хэмээн утсаа тавилаа.

Клеменцаг даалгавраас буцаж ирмэгц ажлын өрөөнд бүгд цугларч, Сонни товчхон асуув.

- За яав, бүтэмжтэй юу? Клеменца толгой дохилоо.

- Дахин түүнтэй уулзахгүй байх аа.

Эд нар Поли Гагтогийн тухай ярьж байна гэсэн таавар Майклын толгойд гэнэт харважээ. Хөөрхий бяцхан Полиг дүүгийнх нь хуриман дээр хөгжилдөн бүжиглэж явсан энэ Клеменца алчхаж.

- Солоцотой холбоо бариагүй биз? хэмээн Сонни Хейгенээс асуусанд цаадах нь толгой сэгсрэв.

- Тэр чинь нэг л хэлэлцээр хийхээр зүтгэхгүй байна. Гэхдээ өөр арга байхгүй юм чинь хийлгүй яав л гэж. Маргааш уулзах цаг газраа товлон.

Клеменцагийн хүмүүсийн нэг нь хаалга тогшин орж ирээд:

- Цагдаагийн газар Поли Гагтогийн үхдэлийг машин дотроос нь оллоо гэж сая радиогоор ярилаа - гэвэл Клеменца толгой дохив.

- За за, чи үүнд санаа зовоод юу хийх вэ?

Залуу эр толгойлогч уруугаа гайхан харснаа учрыг ойлгоод өрөөнөөс бушуухан гарлаа.

Сонни Хейгенд хандан:

- Их Эцгийн бие сайжраагүй биз? - гэвэл тэрээр толгой сэгсрэв.

- Арай гайгүй, гэхдээ хараахан ярьж чадахгүй байна. Байдал нилээн хүндэвтэр, хагалгааны дараа ухаан ороогүй байгаа. Ээж чинь Коннигийн хамт өдөржингөө сахисан. Эмнэлгээр дүүрэн цагдаа нар, бас Тессиогийн хүмүүс ч ойр хавьд нь бий, юу болохыг хэн мэдлээ. Хоёр

гурав хоноод Загалмайлан эцгийн бие гайгүй болох биз. Тэгээд л юу хэлэхийг нь сонсьё. Тэр хүртэл Солоцог ноцтой арга хэмжээ авахуулахгүй аргалж байх хэрэгтэй. Тийм л учраас чамайг түүнтэй хэлэлцээр хий гэж шаардаад байгаа юм шүү дээ.

- Клеменца, Тессио хоёр түүнийг олмоор л юм даа. Хэрэв бидэнд аз таарвал энэ зангилааг нэгмөсөн тайлж чадах биз - хэмээн Сонни бувгнахад Хейген үгүүлрүүн:

- Тэгж найдсаны хэрэггүй. Солоццо тэнэг хүн биш, хэрэв хэлэлцээр хийвэл олон юман дээр буулт хийхэд хүрнэ гэдгийг сайн ойлгож байгаа. Тэгээд л яарахгүй байгаа юм шүү дээ. Их Эцгийг зөвшөөрөл өгсөн цагт бидний гарт амь үрэгдэхгүйн тулд Нью Йоркийн бусад намын дэмжлэгийг олж авах гэсэн биз.

- Тэд нар түүнийг дэмжиж яах юм бэ?

- Цус асгаруулсан алаан хядаан дэгдвэл бүгд хохирч, сонин хэвлэлийнхэн, засгийн газар бөөн шуугиан дэгдээх учраас үүнийг гаргуулахгүйн тулд дэмжих л болно. Тэгээд ч Солоццо тэдэнд мансууруулагчийн наймаанаас олох орлогын тодорхой хувийг амлана. Энэ чинь алтны орд л гэсэн үг. Корлеонегийн намд мөрийтэй тоглоомын газрууд байгаа болохоор түүнтэй түүнгүй болно. Харин бусад нь мөнгөний шуналтай. Солоццо угийн хал үзэж халуун чулуу долоосон хүн болохоор энэ ажлаа нилээн өргөн далайцтай зохион байгуулах нь мэдээж. Тэдний хувьд бол амьд Солоццо бөөн капитал, харин үхчихвэл гай зовлонгоос өөр юмгүй.

Сонни Тессио тийш эргэж:

- Люкагийн тухай мэдээ байна уу? - гэвэл цаадах нь толгой сэгсрэв.

- Байхгүй. Лав Түрэгийн гарт орсон биз ээ.

Хейген намуухан дуугаар үгүүлрүүн:

- Солоццо Люкагийн талаар нэг их санаа зовохгүй байгаа нь анхнаасаа л надад таалагдаагүй. Солоццо тийм хүнийг дутуу үнэлэх тэнэг хүн яавч биш. Солоццо түүнийг цааш харуулчихсан юм биш биз? Сонни нилээд сэтгэл түгшсэн янзтай:

- Люка бидний л эсрэг битгий хөдлөөсэй! Би ганцхан үүнээс л айж байна. Клеменца, Тессио та хоёр ямар бодолтой вэ?

Клеменца үгээ зөөн байж ярьсан нь:

- Полиг л бодоод үзэхэд хэн ч итгэл эвдэж мэднэ. Гэхдээ Люка бол яасан ч гуйвж дайвах хүн биш. Люкагийн хувьд ганц бурхан нь Загалмайлан эцэг, түүнээс л айдаг байсан. Зөвхөн айдаг төдийгүй хэнээс ч илүү хүндэлдэг байсныг нь чи мэднэ дээ, Сонни. Люка хүн болгоныг хардан сэрдэж, хамгийн ноцтой юм болоход эсэргүүцэхээр бэлэн явдаг байсан юм чинь Солоццо хэчнээн зальтай чөтгөр байлаа ч гэсэн түүнийг гэнэдүүлж чадаагүй байх учиртай. Хаа нэг тийшээгээ хоёр гурав хоног яваад одоо удахгүй ирэх биз.

Сонни Тессио өөд харсанд Бруклинаас ирсэн итгэмжлэгдсэн төлөөлөгч мөрөө хавчив.

- Хэн ч урваж магадгүй. Люка маш эмзэг, амархан гомддог хүн тул Их Эцэг ямар нэгэн байдлаар доромжилсон ч байж болох шүү дээ. Гэхдээ яагаад ч юм, Солоццо заль хэрэглэн Люкаг барьсан байх гэж надад бодогдох юм. Зөвлөхийн хэлдэг зөв байх. Муу л юм болоо бий вий.

- Солоццо тун удахгүй Поли Гаттогийн тухай дуулж мэдээд яах бол? - хэмээн Сонниг асуухад Клеменца царай барайлган:

- Их л юм эргэцүүлэн бодох ёстой. Корлеонегийн намд тэнэг маанаг хүмүүс цуглаагүй, очигдөр түүний аз нь дайрч санаснаас гайгүй өнгөрснөө ойлгоно - гэтэл Сонни огцом дуугаар хэлсэн нь:

- «Аз дайрч» гэдэг чинь юу гэсэн үг вэ? Солоццо аавын аминд халдах энэ оролдлогоо хэдэн долоо хоног бодож боловсруулсан. Зүгээр л энэ ажлыг унхиагүй залууст даалгаж, дээр нь бас манай аав сэргэлэн хөдөлсөн болохоор харин ч түүний аз нь харьсан юм биш үү. Хэрэв аавыг нам буудчихсан бол би Солоццотой хэлэлцэж тохирохоос өөр аргагүй болж тэрээр их зүйл хожих байсан. Гэхдээ зөвхөн өнөө маргаашдаа л тэр шүү дээ. Яагаад гэвэл, тав юм уу арван жилийн дараа ялгаагүй, би түүнийг заавал алах байсан юм. Пит ээ, түүний аз дайрсан гэж ярьдаг чинь том эндүүрэл. Тэртэй тэргүй сүүлийн үед хэтэрхий олон алдаа гаргалаа.

Хэн нэг нь гал зуухнаас чанасан гоймон, дарс, таваг, сэрээ авчирч бүгд хооллов.

- Мэдээжээр, би бүх учрыг сайн мэдэхгүй боловч Солоццогийн тухай та нарын ярьсан зүйл, тэрээр хэлэлцээр хийхээс цааргалаад байгаа хоёрыг харьцуулаад үзэхэд түүнд нэг нууцгай арга байх шиг надад санагдлаа. Түрэг давуу тал олж авахын тулд нэг юм сэдсэн юм биш биз? Юу сэдсэнийг нь олж мэдвэл л бид дийлнэ дээ - хэмээн Майкл даруухан үгүүлэхэд Сонни дуртай дургүй ам нээлээ.

- Тийм ээ, би өөрөө ч гэсэн бодож үзсэн. Түүний нууц арга нь Люка л болов уу гэж айх юм. Би түүнийг ирсэн даруйд нь энд авчрахыг тушаасан. Тэр болтол түүнийг сэжиглэсэн хэвээр л байх болно. Өөр нэг боломж нь гэвэл Солоццо Нью Йоркийн таван синдикаттай хэлэлцэн тохирсон байж магадгүй. Тэд бидэнд дайн зарласныг маргааш гэхэд л мэдэж болох юм, тийм үү, Том оо?

Хейген толгой дохив:

- Нээрээ тийм юм шиг байна. Эцгийн чинь байхгүй бол бид ийм хүчтэй дайсныг дийлэхгүй, зөвхөн ,Загалмайлсан эцэг л Нью Йоркийн таван намын эсрэг зогсож чадна. Тэдэнд байдаггүй улс төрийн харилцаа холбоо түүнд бий, хэрэгцээ гарвал тэр танил талаа хэлэлцээрийн үеэр ашиглах болно.

- Чиний хүмүүс эмнэлэг дээр байгаа юу? - хэмээн Сонни Тессиогоос асууваас тэрээр энэ ярианы туршид анх удаа итгэлтэй, шийдэмгий хэлсэн нь:

- Өдөржин шөнөжин гадна дотноос нь манаж, цагдаа нар ч зөндөө, тагнуул туршуулууд бололцоо л тарвал мэдүүлэг авчих санаатай өрөөнийх нь үүдийг сахиад, ёстой инээдтэй юм.

Их Эцгийг гуурсаар хооллож байгаа болохоор гал тогооны газрын талаар санаа зовохгүй байж болно. Уг нь түрэгүүд хор хэрэглэхээс ч буцахгүй бузар улс шүү. Үгүй ээ, тэд яагаад ч Загалмайлсан эцэгт хүрч чадахгүй.

- Манай байгууллага тэдэнд хэрэгтэй, надтай тэд ажил төрлөө хамтарч явуулах юм чинь намайг заяа нь шоглохгүй - хэмээн Сонни сандалдаа гэдийж Майклыг инээмсэглэн харав. - Тэд чамд халдах гэсэн юм биш биз? Солоццо чамайг барьж аваад өөрийнхөө болзлыг биднээр зөвшөөрүүлтэл чамайг байлгах гээгүй байгаа?

«Сонни, намайг гэрээс гаргахгүй нь, Кейтэй уулздаг ч өнгөрлөө» гэж Майкл харамсан суутал Хейген яаран үгүүлрүүн:

- Үгүй ээ, хэрэв Солоццо илүү найдвартай баталгаа хэрэгтэй гэж үзсэн бол тэрээр Майкийг дуртай цагтаа бариад авч чадах байсан. Гэтэл Майк манай ажил хэргээс хол хөндий, энхийг эрхэмлэгч гэдгийг бүгд мэднэ. Хэрэв тэд Майкийг баривал Солоццог Нью Йоркод хэн ч дэмжихгүй, Тагтальягийнхан түүний эсрэг хандах болно шүү дээ. Үгүй ээ, ердөө л маргааш гэхэд таван намын бие төлөөлөгч ирж, Түрэгийн санал болгосон ажилд хувь оролцох хэрэгтэй гэж тулган шаардах байх.

Майклын дотор уужран гүн санаа алдав.

- За сайн байна. Тэгвэл би өнөөдөр хот орлоо.

- Яах нь вэ? - хэмээнэ Сонни цочмог ширүүн асуусанд Майкл учир битүүлэг жуумалзан харагдана.

- Эмнэлгээр орж аавыг эргээд ээж, Конни хоёртой уулзъя. Бас бус жаахан ажил байна.

Майкл мөн л Их Эцэг шиг чин санаагаа ер хэлдэггүй, одоо ч гэсэн Кей Адамс дээр очихоор яваагаа цухуйлгахыг хүссэнгүй. Гэхдээ ямар нэгэн онцын шалтгаангүй, зүгээр л сурсан зангаараа нуугаад өнгөрчээ.

Гал зуухны өрөөнд хүмүүс чанга ярилцах дуулдаж, Клеменца юу болсныг мэдэхээр гараад Люка Бразигийн хуяган хантаазыг барьсаар орж ирлээ. Тэр хантаазанд үхсэн загас боосон байв.

- За тэр, Түрэг Поли Гаттогийнхаа тухай мэдлээ дээ. Тессио бас л Клеменцагийн нэгэн адил хөндий дуугарлаа.

Бид ч гэсэн одоо Люка Бразигийнхаа тухай мэдэж авлаа.

Сонни навчин янжуур асааж, виски балгахад юу ч ойлгоогүй Майкл л ганцаараа гайхшран:

- Юун загас вэ? Ямар учиртай юм бэ? - гэсэнд ирланд зөвлөх Хейген түүнд хариу үгүүлрүүн:

- Энэ бол хөөрхий Люка Брази далайн ёроолд мөнх нойрсож байгаа гэсэн үг. Сицил нутгийнхан өнө эртнээс хойш иймэрхүү мэдээг ингэж хүргэдэг юм.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Тэр орой Майкл Корлеоне хот уруу явахдаа санаа сэтгэл нь тун тавгүй байв. Түүнийг гэр бүлийн хэрэгт хүчээр татан оруулж, Сонни албадсаар байгаад утасны дэргэд суулгасанд нь хүртэл дургүйцэл гөрнө. Гэр бүлийн зөвлөгөөн дээр бүгд хэлцэн тохирсон юм шиг аллага хядлагын нарийн ширийнийг ярьж өгөхөд нь түүнд тун эвгүй байлаа. Одоо Кей Адамс уруу явахдаа ч түүний өмнө буруутай юм шиг Майклд санагдан сэтгэл эмзэглэх бөлгөө. Тэрбээр Кейд гэр бүлийнхээ тухай бүх үнэнийг ер яриагүй бөгөөд ойр дотнын хүмүүсээ жинхэнэ дүр төрхөөр нь биш, адал явдалт киноны гол баатрууд мэт дөвийлгөж харуулсан хачин сонин түүх намтар, шог хошин юм ярих төдийгөөр хязгаарладаг байжээ. Гэтэл одоо түүний эцгийг гудамжинд буудаж хүнд шархдуулаад, том ах нь хариу аллага хийхэд төлөвлөж суудаг. Гэвч одоо ч гэсэн Майкл өөртөө хүлээн зөвшөөрсөн шигээ Кейд илэн далангүй, шууд хэлж бас л чадахгүй байв. Тэрээр ердийн «санамсаргүй тохиолдол» болсон, одоо дахиад яах ч үгүй гэж Кейд түрүүхэн хэлсэн билээ. Сонни, Том хоёр тэр Солоцогийн талаар алдаа гаргаж, Сонни хэдий хашир туршлагатай, аюул мэдрэх чадвартай ч гэсэн одоо хүртэл түүний хүч чадлыг зөв үнэлж чадахгүй байна. Түрэгийн өвөрт ямар чулуу байгааг яаж байгаад мэдчих вэ? Сонсоод байвал тэрээр тун зоригтой, ухаантай, гаргуу хатан зоригтой хүн тул хүний санаанд ч оромгүй юм хийж мэднэ. Хавьгүй илүү туршлагатай Сонни, Том, Клеменца, Тессио бүгдээрээ сэрэмжлэн ,хамгаалах бүх арга хэмжээг авсан гэж нэгэн дуугаар батлаад байгаа. Майкл өөрөө бол энд дайнд огт хамаагүй «Энхийг эрхэмлэгч» эгэл хүн шүү гээ. Тэгэхлээр тэд Майклын байлдааны одон медалиас хамаагүй их шан харамж, амлаж байж л түүнийг энэ алаан хядаандаа татан оролцуулах болно доо.

Майкл тэдний хэрэг явдлаас хол хөндий байж, өөрийн зоргоор амьдрахыг хичнээн их хүсэвч байдал тайван болтол гэр бүлийнхэнтэйгээ харилцаагаа тасалж чадахгүй байлаа. Тэгснээ ар талд бүгэж дайтах албанаас чөлөөлөгдсөн, тусгай эрхтэй, ажиглагчийн үүрэг түүнд хүчээр тохоосонд дургүйлхэж байгаагаа Майкл гэнэт мэдрэв. Ийм л учраас «энхийг эрхэмлэгч», «энгийн номхон иргэн» гэсэн үгс санаанаас нь гарч өгөхгүй шаналгаад байгаа юм байна.

Түүнийг зочид буудалд ороход Кей үүдний танхимд хүлээж байлаа. Тэр хоёр хамт хоол идэж, жаахан дарс балгасны эцэст Кей:

- Чи эмнэлэг рүү хэзээ явах вэ? - гэвэл Майкл цагаа харав.

- Тэнд найм хагас хүртэл эргэлт оруулдаг. Би ер нь бүгд явсан хойно очдог юм уу даа. Намайг оруулж л таарна. Аав тусгай өрөөнд, дэргэд нь тусгай сувилагч нар байгаа болохоор би зүгээр л хажууд нь сууж байя. Аав одоохондоо ярьж чадахгүй юм шиг дуулдсан, намайг бараг таних ч үгүй биз. Гэсэн ч би түүнд хүүгийн хүндэтгэл үзүүлэх ёстой.

- Аав чинь тэгэхэд, хуриман дээр надад их таалагдсан, би тун их өрөвдөх юм. Түүний тухай сонинд бичсэн зүйлд би ер итгэхгүй байна. Ихэнх нь худал гүтгэлэг байх.

- Би ч гэсэн тэгж бодож байна. . .

Кейгээс үнэнийг нугаад байгаадаа Майкл өөрөө ч гэсэн их гайхлаа. Тэрээр Кейд хайртай,

түүнд итгэдэг хэдий ч өөрийн гэр бүлийн тухай, аавынхаа тухай хэзээ ч илэн далангүй ярьж чадахгүй ажээ.

- Чи өөрөө яах вэ? Сонинд шүлэнгэтэн бичээд байгаа гангстеруудын дайнд чи бас л оролцох уу?

Майкл инээмсэглэн пиджакныхаа товчийг тайлж энгэрээ яраад:

- Зэвсэггүй явааг минь харж байгаа биз дээ? - гэсэнд Кей тачигнатал хөхрөв.

Тэд өрөөндөө орж Майклыг гар нүүрээ угаагаад үсээ самнаж зогстол Кей араас нь очиж эелдгээр тэвэрлээ.

- Бид хэзээ гэрлэх юм бэ?

- Хэзээ ч яах вэ? Манай гэр бүлийг тойрсон шуугиан жаахан намдаад, аавын бие сайжраадхаг. Гэхдээ чи аав ээждээ зарим зүйлийг тайлбарлах хэрэгтэй л болох байх даа!

- Юу тэр вэ, Майк аа?

- Итали гаралтай, цэвэрхэн царайтай луг залуутай танилцсанаа хэл. Дартмутын их сургуульд гарамгай сурдаг, «Байлдааны гавьяаны» загалмай, «Улаан зүрх» медалиар шагнагдсан, үнэнч шударга, ажилсаг залуу, ганцхан аав нь л мафийн толгойлогч бөгөөд муу хүмүүсийг алдаг, заримдаа өндөр тушаалын хүмүүст хээл хахууль өгдөг, ажил явдлын ялдамд хааяа

хааяа өөрийг нь ч буудчихдаг, гэхдээ энэ нь түүний шулуун шударга, хөдөлмөрч хичээнгүй хүүд нь огт хамаагүй гээрэй, ойлгов уу?

Кей түүнээс холдож, хаалга налан зогслоо.

- Энэ чинь тэгээд үнэн юм уу? Тэрээр хүн алдаг хэрэг үү?

Майкл саамаа сая нэг юм тавиур дээр тавив.

- Яг тодорхой мэдэхгүй, мэдэх ч хүн байхгүй. Гэхдээ тун болзошгүй зүйл.

- Бид удахгүй уулзана биз дээ?

Майкл түүнийг тэвэрч энхрийлэн үнслээ.

- Чи гэртээ хариад, чимээ аниргүй хотхондоо тухтай сайн тунгааж бод. Ядахдаа чи энэ хэрэг явдлаас холхон байх хэрэгтэй шүү. Христосын мэндэлсний баяр өнгөрөөгөөд би их сургууль уруугаа буцах юм чинь Ганноверт уулзъя, за юу?

- За, за.

Түүнийг өрөөнөөс гарч гар даллан салах ёс гүйцэтгээд цахилгаан шатанд орохыг Кей харж

зогсохдоо Майклыг урьд урьдахаас ч илүү дотнотлон хайрлаж байгаагаа сэтгэлийн гүндээ мэдэрчээ. Хэрэв Майклын барааг бүтэн гурван жил олж харахгүй гэж түүнд одоо, хэлсэн бол уй гашуудаа болоод лав галзуурах байсан биз...

Майклыг Франц эмнэлгийн үүдэнд хөлсний тэрэгнээс гарахад гудамжинд нэг ч хүнгүй, эл хуль байхаар үнэнхүү их гайхжээ. Тэрбээр эмнэлэг орж хов хоосон үүдний танхимыг хараад бүр учрыг нь олохоо болив. Чөтгөр алгадмар, Клеменца, Тессио хоёр байлдааны эрдэмд суралцаагүй нь үнэн боловч харуул хамгаалалт тавьчын төдийд бол заавал Вэст Пойнтын цэргийн сургууль дүүргэх албагүйсэн. Үүдний танхимд дор хаяхад хоёр хүн жижүүрлэх ёстой доо.

Хамгийн сүүлчийн хүмүүс аль хэдийн яваад цаг арав хагас болсон тул Майкл сэтгэл түгшин хамаг биеэ хөвчлөв. Эцэг нь тавдугаар давхарт байгаа, өрөөнийх нь дугаарыг мэдэх учир тэрээр лавлахын дэргэд саатсангүй, цахилгаан шатаар дээш гарч, тавдугаар давхрын жижүүрийн ширээ хүрэх хооронд хэн ч түүнийг зогсоогоогүй нь нэн хачирхалтай. Сувилагч түүнийг дуудсан боловч эргэж харсан ч үгүй хажуугаар нь гараад цааш явтал аавынх нь өрөөний үүдэнд бас л хүн алга. Мэдүүлэг авч болох цагийг хүлээгээд сууж байгаа хоёр туршуул хаана байна? Клеменца, Тессиогийн хүмүүс яачхав? Аа, золиг гэж! Өрөөнд нь хүн жижүүрлэж байгаа юм болов уу? Хаалга онгорхой байсанд Майкл шууд орж, арван хоёр сарын хүйтэн сарны гэрэлд орон дээр хэвтээ эцгийнхээ нүүрийг олж харлаа. Түүний цээж тасалдсан амьсгаандаа үл мэдэг түнхэлзэж, орных нь толгой дахь дуслын савнаас хоёр хоолой унжуулан хамрынх нь нүхэнд бэхэлсэн бөгөөд шалан дээр тавьсан шилэн саванд бас л хоолой холбосон харагдана. Майкл жаахан зогсож байгаад ухарсаар гарч сувилагч дээр очлоо.

- Би Майкл Корлеоне, аавын дэргэд жаахан байх гэсэн юм. Түүнийг хамгаалж байсан цагдаа нар яагаа вэ?

Хөөрхөн царайтай, залуу сувилагч цагаан халаадныхаа бүхнийг чадах төгөлдөр хүчинд үнэн голоосоо итгэдэг бололтой.

- Аавыг тань хэтэрхий олон хүн эргэж ирээд эмчийн ажилд саад болоод байсан юм. Арван минутын өмнө цагдаагийн газраас хүн ирж, бүгдийг хөөж явуулснаас хойш таван минутын дараа хамгаалалтын хүмүүсийг утсаар дуудаад авч явсан. Ер нь та битгий санаа зовоорой, би үргэлж л аавыг чинь эргэж тойрч байгаа. Тийм ч учраас бид үүд хаалгаа онгорхой орхисон юм шүү дээ.

- Их баярлалаа. Би аавын хажууд жаахан баймаар байна, болох уу?

Сувилагч тун эелдэг инээмсэглэв.

- Их удахгүй бол болно, дараа нь явах л болно шүү. Нэгэнт тийм журамтайгаас хойш яая гэх вэ?

Майкл аавынхаа байгаа өрөөнд нь дотуур холбоогоор Лонг Бич рүү, аавынхаа ажлын өрөөнд залгасанд Сонни утас авлаа.

- Сонни, би дөнгөж сая эмнэлэг дээр ирээд байна. Сонни минь, энд Тессиогийн хүмүүс, хаалган дээр байсан туршуулууд ч алга. Аавын дэргэд амьд хүний бараа ч байхгүй байна гэхэд Майклын уруул нь чичгэнэх ажээ.

Сонни нилээд удаан байснаа гэнэт сөөнгөтсөн хоолойгоор ийн үгүүлрүүн:

- Солоццо ийм л юм сэдэж дээ...

- Би ч бас тэгж бодох юм. Гэхдээ тэрээр цагдаагийн газрынхнаар бүгдийг хөөлгөж яаж чадав аа? Тэдний туршуулууд хаачаа вэ? Тессиогийн хүмүүс яасан бол? Чөтгөр ав гэж, тэр муу хулхи Солоццо Нью Йорк хотын цагдаагийн газрыг бүхэлд нь гартаа авлаа гэж үү?

- За өвгөн минь, аядаж үз - гэх нь Сонни нилээд тайвширсан бололтой.

- Дахиад л бидний аз болоход чи тийм орой эмнэлэг дээр очжээ. Чи аавын өрөөнд дотроос нь түгжээд элдэв гэнэн болчимгүй юм хийлгүй, арван таван минут тэсч үз, за юу? Би утсаар л яриадахвал бүгдийг аргална.

- За за, ойлголоо.

Эл бүх хэрэг явдал эхэлснээс хойш Майкл анх удаа аавынхаа дайснуудыг яс махнаасаа үзэн ядаж, уур хилэн нь дүрэлзээд ирэв. Тэрээр харилцуураа тавиад хонх дарлаа. Сонни юу ч гэж байлаа гэсэн тэрээр өөрийн үзэмжээр ажиллах нь зөв хэмээн үзээд сувилагчийн орж ирэхэд:

- Танд нэг юм хэлье, харин бүү айгаарай. Аавыг эндээс ондоо өрөөнд оруулах юм уу, өөр давхарт гаргах хэрэгтэй байна. Яаж энэ хоолойнуудыг салгаад орыг нь түрж гаргах вэ? - гэсэнд сувилагч эрс татгалзав.

- Юу гэсэн уг вэ? Эмчийн зөвшөөрөлгүйгээр...

Майкл түүний үгийг яаран тасаллаа.

- Аавын тухай сонинд бичсэн зүйлийг уншсан уу? Тэр ямар ч хамгаалалтгүй үлдсэнийг та харж байгаа биз дээ? Түүнийг алахаар хүмүүс наашаа ирж явааг дөнгөж сая надад мэдэгдлээ. Та надад итгээд тус болж үзээч.

Шаардлага гарсан үед Майкл хэнийг ч ятгаж чаддаг тул сувилагч арга буюу зөвшөөрчээ.

- Энэ чинь зөөврийн төхөөрөмж болохоор хоолойнуудыг салгахгүй байж болно л доо.

- Сул өрөө бий юу?

- Хонгилын мухарт нэг өрөө бий

Тэр хоёр тун хурдан шалмаг хөдөлж, хэдхэн минутад бүхнийг амжуулав.

- Сувилагч аа, манай хүмүүсийг иртэл та энд сууж байхгүй юу? Хонгилд байх тун осолтой шүү! —гэж Майклын хэлтэл орны тэндээс сөөнгөтсөн дуу гарлаа.

- Майкл чи юу? Юу болоо вэ?

Майкл ор уруу тонгойж аавынхаа гараас барив.

- Тийм ээ, би Майкл байна. Битгий ай, чимээгүй дэвтээрэй. Таныг алах гээд байна. Нэрээр чинь дуудвал бүү дуугараарай. Ойлгов уу? Би хажууд чинь байгаа болохоор санаа зовох юмгүй.

Чухам ямар гай учирсныг бүрэн ухаарч амжаагүй эрхэм Корлеоне тэсэхийн аргагүй өвчиндөө шаналж, ухаан алдах дөхөж байсан тул

- Ээ, надад айх юу байх вэ? Намайг аль эртнээс хойш алахаар завдаад, анх арван хоёртойд минь нэг оролдоод үзсэн юм - гэх гэсэн боловч чанга хэлэх тэнхээ нь хүрсэнгүй зөвхөн уруул нь л өмөлзжээ.

АРАВДУГААР БҮЛЭГ

Эмнэлгийн ганцхан ортой багавгар байшингийн цонхоор Майклыг харахад хагас дугуй хашаанаас гудамж уруу гарах шат харагдав. Гагцхүү эл шатаар л эмнэлэгт орж болох ажээ. Машин тэрэг ер үзэгдэхгүй байсан боловч өчүүхэн төдий ч цаг алдаж үл болохыг сайн мэдэхийн эрхээр Майкл өрөөнөөс ухасхийн гарч тавдугаар давхрын шатаар яаран буулаа. Хашаан дотор эмнэлгийн машины зогсоол байвч өдгөө хов хоосон.

Майкл явган хүний зам дээр гарч, тамхиа асаагаад нүүр нь яг гудамжны чийдэнгийн гэрэлд харагдах газар очиж зогсов. Боодолтой юм сугавчилсан нэг залуу Аравдугаар гудамжнаас эмнэлэг рүү түргэн алхаж явах аж. Цэргийн хүрэмтэй, өтгөн буржгар хар үстэй тэр залуу зурвас гэрэлд ороод ирэхэд нэг л таньдаг юм шиг Майклд санагджээ. Сайхь залуу хажууд нь ирж зогсоод гар сунган:

- Эрхэм Майкл, та намайг санаж байна уу? Би талхчин Назорины туслах, түүний хүргэн Энцо байна. Таны эцэг Америкт үлдэх зөвшөөрөл олж өгч, ёстой л миний аминд орсон доо - хэмээн итали аялгатай үгүүлсэнд Майкл сая санаад гар барилаа.

- Би аавд чинь хүндэтгэлээ илэрхийлэх гэж ирсэн юмсан. Намайг эмнэлэгт оруулах болов уу, эсвэл хэтэрхий оройтсон уу?

Майкл нүүр дүүрэн инээмсэглэж толгой сэгсрэв.

- Одоо оруулахгүй, гэсэн ч их баярлалаа. Чамайг эргэж ирснийг би аавд заавал хэлнэ.

Гудамжаар нэг машин шунгинан өнгөрсөнд Майклд нэг л сэжигтэй санагдан сэтгэл түгшив.

- Энцо, чи эндээс бушуухан яв. Энд тайван биш байна. Чи цагдаа нартай зууралдаад хэрэггүй.

Итали залуугийн царай айсан байдалтай хувирахыг Майкл ажиглаж амжлаа. Цагдаа нар ирэх л юм бол америкийн иргэний эрхийг нь хасч, эх оронд нь буцааж магадгүй хэмээн Энцо эмээх боловч байрнаасаа ер хөдөлсөнгүй.

- Тайван биш л байгаа бол би эндээ үлдэж, чамд тусалъя. Би Загалмайлсан эцэгт насаараа өртэй хүн.

Майклын сэтгэл уярч, түүнийг нэн даруй хөөж явуулах гэснээ болилоо. Үлдвэл ч үлдэг, эмнэлгийн өмнө нэг хүн байснаас хоёулаа зогсож байвал Солоццогийн хүмүүс айх ч юм билүү, хэн мэдлээ.

Тэр хоёр арван хоёрдугаар сарын шөнийн хүйтэнд бээрч агийн гудамжны чийдэн дор чичрэн зогсож, янжуураа татаад бараг дуусч байтал гэнэт нэгэн урт хар машин Есдүгээр гудамжнаас Арван гуравдугаар гудамж уруу эргэж, замын хашлага шахан хурдаа хасч наашилснаа огцом ухасхийн хажуугаар нь шунгинан өнгөрөв. Майклыг таньчихсан бололтой. Тэрээр Энцод

дахиад нэг янжуур сарвайхдаа залуугийн гар салганаж байхыг ажаад, харин өөрийнх нь гар яах ч үгүй байсанд их гайхжээ.

Арваад минутын дараа цагдаагийн машины дуут дохио шөнийн нам гүмийг хага зүсч, Есдүгээр гудамжнаас эргүүлийн машин харван гарч ирлээ. Араас нь бас хоёр машин ирж зогсоод эмнэлгийн өмнөх гудамжинд цагдаагийн болон энгийн хувцастай хүмүүс пиг дүүрэв. Ай хөөрхий, Сонни мөн ч хурдан амжуулж дээ хэмээн Майкл санаа амраад тэдний өөдөөс очлоо.

Мангар том биетэй хоёр цагдаа түүний гараас нь барьж аваад гуравдахь нь нэгжиж үзэв. Малгайн дээрээ алтан хиазтай, цагдаагийн ахмадын дүрэмт хувцастай махлаг эр шатаар өгсөж ирсэнд бусад нь хүндэтгэн зам тавьж өглөө. Ахмад нилээд гэдэс сууж, санчиг нь бууралтсан хэдий ч намалзтал шалмаг алхлан хүрч ирээд:

- Италийн бүх танхайчуудыг бүгдийг барилаа гэж би бодсон юмсан. Чи хэн гэгч нь болоод үүгээр эргэлдээ вэ? - хэмээн арслан мэт архирсанд цагдаа нарын нэг нь Майклын хажууд ирж зогсов.

- Ахмад аа, энэ хүн цэвэр шүү

Майкл нэг ч үг дуугарсангүй, ахмадын оч гялалзсан хүйтэн цэнхэр нүд рүү эгцлэн ширтсээр зогстол .хажууд нь байсан энгийн хувцастай туршуул:

- Энэ эрхэм Корлеонегийн хүү Майкл - хэмээн тайлбарлалаа.

- Харуул хамгаалалт хаачсан бэ? Хэн тэднийг эндээс дуудав? - гэж Майкл тун тайван асуусан чинь ахмадын тоосгон нүүрэнд цус хурж бүр ч минчийгээд ирэв.

- Муу дээрэмчин чи надад заах гээ юу? Би дуудаж аваачсан, тэгээд юу гэж? өгөр гангстерууд та нар бие биенээ бүгдийг хядаж дууссан ч надад ямар хамаатай юм бэ? Би л лав өөрөө мэддэгсэн бол эцгийг чинь харж хамгаалах гэж ер гүйхгүйсэн. За одоо эндээс тонил! Эргэлтийн бус цагаар дахиад үүгээр үзэгдвэл хохь чинь шүү, гөлөг минь!

Майкл эл ахмадын үгийг юман чинээ тоосонгүй, урьдын адил түүний туйпуун нүүрийг цоо ширтсээр гүн бодолд дарагджээ. Тэр анхны өнгөрдөг машинд Солоццо байгаад эмнэлгийн үүдэнд зогсож байхыг нь харсан байх уу? Солоццо цагдаагийн ахмадад утасдаж: «Корлеонегийн хүмүүс яагаад эмнэлгийн үүдээр эргэлдээд байгаа юм бэ?Тэднийг зайлуул гэж танд «мөнгө төлөө биз дээ?» гэсэн юм болов уу? Энэ бүхэн сайтар бодож боловсруулсан төлөвлөгөөний нэг хэсэг хэмээн Сонни үнэн хэлсэн гэж үү? Тун ч магадгүй юм байна.

- Аавын өрөөний үүдэнд харуул гаргахаас нааш би эндээс хаашаа ч явахгүй - хэмээн Майкл хэнэггүй царайлсан боловч ахмад түүнийг тоож хариу хэлсэн ч үгүй.

- Фил, наад гөлөгөө аваачаад нэг газар түгжчих.

Майклын хажууд байсан .туршуул эргэлзэн зөрж:

- Ахмад аа, энэ залуу яагаа ч үгүй. Энэ чинь дайны баатар, тэдний хэрэгт хэзээ ч оролцож байгаагүй хүн. Сонин хэвлэлийнхэн шуугиан дэгдээнэ дээ гэсэнд ахмадын уур хилэн дэлбэрэх шахан түүн уруу алхаад:

- Барьж аваачаад түгж гэж байна шүү! гэлээ.

Уур хилэндээ Майклын дотор бачимдсангүй, толгой үлэмж сэргэлэн байсан тул үг үгээр нь таслан тун нухацтайгаар:

- Ахмад аа, манай эцгийн амь насны төлөө Түрэг ганд их мөнгө өгсөн үү? - гэтэл ахмад огцом эргэж хоёр мангар цагдааг цочтол зандрав.

- Алив, наадахаа барьж байгаач!

Майклын хоёр гарыг ард нь мушгиж, ахмадын лут том нударга хагас дугуйран харваж айсууг хармагц тэрээр бултахыг оролдсон боловч яг эрүүн дээр нь тас буулаа. Майклын толгой дотор гар бөмбөг тэсрэх лүгээ адил болж, аманд нь цус нөж, үйрсэн яс дүүрээд, чихэр хүлхчихсэн юм шиг хацар нь памбайн, хөл нь өвдгөөрөө нугарч, нөгөө хоёр барьж байгаагүйсэн бол лав газар тэрий хадах байв. Гэвч тэрээр ухаан алдсангүй, энгийн хувцастай туршуул өмнүүр нь орж дараачийн цохилтоос хамгаалан;

- Та чинь үүнийг бүр зэрэмдэглэж орхилоо - хэмээн хашгирахыг л лав мэдэрчээ. Ахмад бүгдэд дуулдахуйц чанга дуугаар үгүүлрүүн:

- Би наадахад, чинь гар ч хүрээгүй. Энэ өөрөө над руу дайрах гээд бүдэрсэн. Ойлгов уу? Бас баривчлах гэхэд эсэргүүцэл үзүүлсэн.

Майклын хоёр нүдийг улаан манан бүрхсэн боловч эмнэлгийн өмнө хоёр машин ирж олон хүн яаран буухыг харж амжжээ. Клеменцагийн өмгөөлөгч хүрч ирээд эелдэг атлаа итгэлтэй дуугаар: . - Корлеонегийн гэр бүлийнхэн хувийн мөрдөх товчоонд хүсэлт гаргаж, ноёнтон Корлеонег хамгаалах талаар тохиролцсон юм. Харуулын хүмүүс зэвсэг авч явах зөвшөөрөлтэй болохоор хэрэв та тэднийг баривчилбал маргааш өглөө шүүхэд тайлбар тавих хэрэг гарна шүү, ахмад аа гэснээ Майкл өөд эргээд:

- Таныг хэн зодсон бэ? Хэн нэгнийг яллах хүсэлтэй байна уу? - хэмээн лавлав.

Майкл эрүүгээ хөдөлгөхөд янгинаж өвдөөд, ярихад маш хүнд байсан тул:

- Би бүдрээд уначихсан юм гэж арай ядан бувгнахчаа болж, ахмадын маадгар жуумалзахыг ажаад хариуд нь инээвхийлэх аядлаа. Тэрээр уураг тархи, хамаг биеийг нь бүрэн эзэмдсэн хорсол занал, үзэн ядах сэтгэлээ нэг ч хүнд мэдэгдэхийг хүссэнгүй. Эцэг нь ч гэсэн хүсэхгүй байсан биз. Түүнийг өргөөд эмнэлэг рүү авч явах шиг болсноо дараахан нь ухаан алджээ.

Тэрбээр өглөө сэртэл эрүүг нь чиг барьж боосон, бас зүүн талын дөрвөн шүд хугарсан байлаа. Орных нь хажууд Хейген сууж харагдав.

- Надад наркоз хийсэн үү? - хэмээн Майкл лавлав.

- Тийм ээ, буйлнаас шүдний хугархай түүж авах болоод их өвдөх байх гэж бодсон юм. Тэгээд ч чи ухаангүй байсан шүү дээ. Бусад юм зүгээр үү?

- Зүв зүгээр. Хөөе, Сонни чамайг гэртээ байвал дээр гэсэн юм сан. Харьж дөнгөх үү?

- Дөнгөлгүй дээ. Аав яаж байна?

- Бид түүний асуудлыг шийдвэрлэж чадсан байх аа. Хөлсөлж авсан хувийн мөрдөгчид энэ хорооллыг бүхэлд нь хамгаалж байгаа. Хоёулаа машинд ороод тухтай ярилцъя, тэгэх үү?

Клеменца машин барьж, Майкл Хейген хоёр ард нь сууж явлаа.

- Өчигдөр юу болсон юм бэ? Хейген тун тайван хүүрнэж эхлэв.

- Цагдаагийн газарт Соннигийн талын хүн байдаг. Чамайг өмөөрөөд байсан тэр Филипс гэгч бидэнд маш чухал мэдээ өгсөн. Эргэлтийн цаг дууссан даруйд ахмад Мак Клоски Тессиогийн залуусын зарим нь буутай байснаар шалтаглан эмнэлэг, хашааг хамгаалж байсан бүх хүнийг маань зайлуулж, дараа нь өрөөний үүдэнд байсан туршуулуудыг хөөж явуулсан байна. Солоццо эхний удаад ахиухан юм атгуулаад дараа бүр ихийг амласан нь эргэлзээгүй. Одоо тэр яасан ч амар заяа үзүүлэхгүй, өөрийнхөөрөө л зүтгэнэ гэж Филипс хэлсэн.

- Нөгөө залуу, Энцо зугтааж амжсан уу?

- Тэгсээн, чамаас хавьгүй шалмаг хөдөлж, цагдаа нар үзэгдмэгц арилаад өгсөн. Солоццог явж өнгөрөхөд хажууд чинь байсан гэх юм, үнэн үү?

- Яг үнэн, зүгээр залуу билээ.

- За яахав, бид ачийг нь хариулна аа. Аа тийм, Корлеонегийн гэр бүл тооцоо бодож эхэлснийг дуулахад чамд таатай байх. Бруно Таттальяг өнөөдөр үүрээр, дөрвөн цагт цааш харуулсан.

Майкл гайхсандаа байдгаараа гэдийв. - Яагаад тэр вэ? Хүлээхээр шийдсэн гэж би бодсон юмсан.

Хейген мөрөө хавчлаа.

- Эмнэлэг дээр болсон хэрэг явдлаас хойш Сонниг тогтоож барихын аргагүй болсон. Би түүнийг сэнхрүүлэх гээд ядчихлаа. Майкл чи оролдоод үзэх юм, биш үү? Алаан хядаанаас зайлсхийх цаг хугацаа одоохондоо байна.

- Оролдоод л үзье. Өглөө цуглах уу, Том оо? - Тэгэхээс яахав? Солоццо сая нэг юм чимээ өгч, хэлэлцээ хийхэд бэлэн гэж мэдэгдсэн. Бас Люкагийн талаарх бүх юм тодорхой болсон. Түүнийг Их Эцгийн аминд халддагийн өмнөх шөнө Бруно Таттальягийн клубт хороосон байна. Ямарав дээ, Майкл аа?

- Тэгвэл түүнийг яаж гэнэдүүлсэн нь одоо ойлгомжтой боллоо.

Цэцэрлэгт хүрээлэнд орох замыг урт хар машинаар хөндөлсүүлэн хааж, хажууд нь түүнийг түшээд хоёр эр зогсжээ. Баруун, зүүн талын хоёрдугаар давхрын цонхнуудыг цэлийтэл нээсэн харагдана.

Клеменца орох хаалганы дэргэд зогсож, тэр гурав цааш явган явлаа. Хаалганы дэргэд байсан хоёртой Клеменца мэндлэхийн оронд муухай хараад өнгөрснийг бодоход өөрийнх нь бүлгийн эрс бололтой. Хаалга цохих хэрэг гарсангүй, шууд онгойлгож өгсөн нь тэднийг цонхоор харсан хэрэг л дээ. Сонни, Тессио хоёр булангийн өрөөнд хүлээж байснаа Сонни дүүгээ тэвэрч:

- Хөөрхөн ч амьтан бол доо! - хэмээн дооглосонд Майкл ахынхаа гарыг алгадаад авлаа.

Тэд түрүүчийн адил энэ л өрөөндөө цугласан боловч харин хүмүүсийн байдал огт өөр болжээ. Соннигийн нүд сэргэж, тун хөгжилтэй харагдах бөгөөд яагаад ийм баяр баясгалантай байгааг Майкл сайн ойлгож байв. Том ах нь нэгэнт эргэлзэж тээнэгэлзэхээ больж, эцсийн шийдвэр гаргасан тул одоо яагаад ч хориглож чадахгүй. Солоцогийн саяын явуулга Соннигийн тэвчээрийг барагдуулсан тул одоо эвлэрэн найрамдах тухай ярихын ч хэрэггүй.

- Чамайг эзгүй байх хооронд зуучлагч утасдсан. Түрэг одоо хэлэлцээ хийх хүсэлтэй гэнэ - хэмээн Сонни Хейгенд хэлээд инээмсэглэв.

- Сүрхий нохой шүү. өчигдрийнх нь хорон санаа бүтэлгүйтэхээр өнөөдөр хэлэлцээр хийх хүсэл төрж гэнэ. Тэгээд бид сургуультай баавгай шиг хойд хоёр хөл дээрээ суугаад л...

- Өө нээрээ, дүү минь, цагдаагийн газрын гялалзуур ахмадыг бид яах болж байна?

Майкл буурь заан үгээ зөөж:

- Энэ бол туйлшрал мөн нь мэдээж. Гэхдээ туйлын чанга арга хэмжээ авахаас өөр боломжгүй тохиолдол байдаг даа. За яахав, бид аргагүйн эрхэнд Мак Клоскиг хөнөөх боллоо гэж бодъё. Тэгвэл бид түүний жинхэнэ нүүр царайг олны өмнө илчилж, журамт үүргээ шударгаар биелүүлдэг цагдаагийн газрын ахмад биш бузар хэрэгт оролцсон луйварчин, үл бүтэх этгээд болохоор зүй ёсоор цээрлэл хүртсэн гэдгийг хөдөлбөргүй нотлох хэрэгтэй гээд дэмжлэг эрэлхийлэн бүгдийг тойруулан харав.

Тессио, Клеменца хоёр дув дуугүй, дүнсгэр царайлан сууж, Сонни мөн л хачин жигтэй жумалзана.

- Цааш нь үргэлжлүүл, өвгөн минь. Чи сүрхий ярьж байна. Аавын хэлдгээр, нялх хүүхдийн амнаас нуусан үнэн цухалзана гэдэг энэ дээ.

Хейген нүүр буруулан бас л үл мэдэг инээвхийлсэнд Майклын царай час улайгаад явчихлаа.

- Яадаг юм бэ? Намайг Солоцотой уулзахаар очиход Мак Клоски бид гурваас өөр хүн хажууд байхгүй нь лав. Манай мэдээлэгч нарт уулзалт болох газрыг мэдэх бололцоо олгохоор

бодолцоод нөгөөдөр, тэгэхдээ олон нийтийн газар уулзахаар товлочгоо. Орон сууц, хувийн байшинд бол би очихгүй шүү. Зоогийн газар юм уу, бааранд үдийн завсарлагын үеэр уулзвал би ч тайван ажиллана, тэдэнд ч аюулгүй мэт санагдах биз. Бид цагдаагийн газрын ахмадыг буудаж алах зүрх гаргана гэсэн бодол Солоццогийн ч толгойд орохгүй. Намайг очиход сайтар нэгжих нь мэдээж юм чинь би зэвсэггүй очно. Харин та нар биднийг ярилцаж байх завсар яаж надад дамжуулах арга ухаан сийлцгээ. Тэгээд би тэр хоёрыг тэнд нь тонилгоно.

Дөрвөн толгой түүний зүг зэрэг эргээд, Тессио, Клеменца хоёр буурьтай хэдий ч мэл гайхан харж, Хейгений царайд гайхсан биш гунигтай байдал тодрон; гагцхүү Соннигийн л нүд хөгжилтэй гялалзаж байснаа, тэсгэлгүй гэнэт тачигнатал хөхөрч, инээдэндээ хахаж цацан Майклыг хуруугаараа заав.

- Үгүй ерөө! Өнөөх сэхээтэн, оюутан, дээд боловсрол энээ тэрээ гээд манай гэр бүлийн бизнесээс ой гутаад байдаг биш билүү, чи чинь? Гэтэл одоо болохоор зөвхөн Мак Клоскид цохиулсан хорондоо л Солоццо тэр хоёрыг цааш харуулах гээ юу? Жинхэнэ бизнес, ажил хэргийн харилцаанд оролцдоггүй мөртлөө ганц удаа зодуулсандаа гомдоод хоёрын хоёр хүн ална гэдэг чинь юу гэсэн үг вэ? Тэгвэл үнэн хэрэгтээ чиний өдий олон жил биднээс хөндийрсөн чинь зүгээр л тэнэглэж, худлаа дөвчигнөж явсан хэрэг юм уу?

Тессио, Клеменца хоёр юу ч ойлгоогүй учир Сонни дүүгээ хүч хүрэхгүй юманд санаархлаа гэж дооглов хэмээн бодоод бас л өршөөнгүй янзтай инээвхийллээ. Харин Хейген л нилээд сэрэмжилсэн янзтай төлөв царайлан сууна. Майкл тэднийг тойруулан харснаа Сонни руу эгцлэн ширтэв.

- Тэгэхлээр чи тэр хоёрыг тонилгох юм биз дээ? Чи юу даа? Цагдаад зодууллаа гээд л хүн алах хэрэг үү? - гээд Сонни дахин хөхөрсөнд Майкл ухасхийн бослоо.

- Инээж хөхрөхөө одоохон боль!

Майклын царай танигдахын аргагүй хувирсан тул Тессио, Клеменца хоёрын ивээнгүй инээдийг арчаад хаячихсан юм шиг дорхноо төв царайлав. Майкл намхан туранхай биетэй хэдий ч одоо түүний төрх байдал жинхэнэ өшөө хорслын дээдийг илтгэх ажээ. Түүнд чухамдаа л эрхэм Корлеонегийн сүнс шүтэлсэн мэт, нүд нь уур хилэнгийн очоор гялалзан царай нь цонхийн цайгаад, өөрөөс нь насаар ах, хавьгүй хүчтэй Сонни руу дайрах нь уу гэмээр харагдана. Хэрэв Майклын гарт зэвсэг байсан бол Сонни үхлийн ирмэг дээр дэнжигнэх байсан нь дамжиггүй. Сонни гэнэт үүнийг ойлгоод хахаж цацан мэлрэх зуур Майкл хачин өөрчлөгдсөн, хүйтэн хөндий дуугаар үгүүлрүүн:

- Өгөр новш минь, чи намайг дөнгөхгүй гэж бодоо юу?

Энэ хооронд Сонни биеэ бүрэн эзэмдэж амжсан байлаа.

- Яалаа гэж дээ? Би чиний хэлсэн үгнээс болж хөхөрсөн юм биш ээ. Амьдралд ийм юм тохиолддог нь л инээдтэй хэрэг. Чамайг шөрмөстэй залуу, магадгүй, ааваас ч илүү дотуур тамиртай гэж би дандаа ярьдаг Харин Мак Клоскигийн дэлсээд авахад чи хариуг нь өгөөгүй учир Солоццо чамайг хулчгар эр гэж бодож байгаа. Бас манай гэрийнхний хэрэг явдлаас

үргэлж хөндий явсан болохоор чинь чамтай халз уулзахад айх юмгүй гэж бүрэн итгэсэн нь лав. Гэтэл чи эцсийн эцэст жинхэнэ Корлеоне байдаг байгаа чөтгөр алгад гэж! Үүнийг ганцхан би л мэдэж байсан. Аавыг шархдуулснаас хойших гурав хоногийн турш чамайг хэзээ энэ дайны баатар, хөл бөмбөгийн од гэх мэтийн гоёл чимэг, хиймэл багаа хуу татан хаях бол гэж хүлээгээд л байсан. Чамайг баруун гар минь болж, аавыг болон манай гэр бүлийг хөнөөх санаархалтай эл новшнуудыг хамт устгах цагийг тэсэн ядан хүлээсэн юм. Гэтэл ердөө л ганц удаа сайн цохиод авах л хэрэгтэй байж. За чи юу гэмээр байна? - гэснээ Сонни нүүрээ хачин инээдтэй үрчийлгэн:

- Үгүй, нээрээ чи юу гэмээр байна? хэмээн давтан асуув.

Хэрүүл маргааны хар манан дорхноо арилж Майкл толгой сэгсэрлээ.

- Сонни минь, өөр арга байхгүй болоод л би шийдсэн юм. Би гараа хумхиад, дахин халдлага хийхийг нь хүлээж чадахгүй. Солоццо зөвхөн намайг л өөртөө ойртуулна гэдгийг бид мэднэ. Би бүгдийг тунгаан бодож үзсэн. Цагдаагийн ахмадыг устгах хүн надаас өөр байхгүй. Үүнийг чи чадах л даа, Сонни. Гэтэл чи эхнэр хүүхэдтэйгээс гадна аавыг эдгэртэл чи энэ өрхийн тэргүүн болохоор, бас Фредди ах жагсаалаас гарсан болохоор би л хийхээс. Энэ чинь ердийн логик дүгнэлт, харин намайг зодсон нь үүнд ямар ч хамаагүй.

Сонни явж очоод түүнийг тэвэрч авав.

- Чиний бодол дүгнэлт надад огт падгүй, хамгийн гол нь чи манайх? Бас нэг юм чамд нэмж хэлэхэд, чиний хэлсэн бүхэн үнэн. Том, чи юу гэмээр байна?

Хейген мөрөө хавчив.

- Эрүүл ухаанаар сүрхий боджээ. Тэгээд ч Солоццо үнэн сэтгэлээсээ бидэнтэй хэлэлцэн тохиролцох гэсэнд би итгэхгүй байна. Тэрээр дахиад л Их Эцгийг хөнөөх арга хайж эхлэх вий. Тэгэхлээр бид Солоццог устгах л болж байна. Үүний тулд цагдаагийн ахмадыг хамтад нь хөнөөхөд хүрлээ ч гэсэн одоо яая гэх вэ? Ганцхан үүнийг хийсэн хүний толгой дээр цахиур хагарна гэдгийг л бодолцоорой. Майклаас өөр хүн алга уу? - гээд Хейген Клеменца, Тессио хоёр тийш эргэв.

- Ийм даалгаврыг биелүүлчхээр хашир туршлагатай, хэрсүү ухаантай хүн танай хүмүүсийн дунд алга уу?

Клеменца түрүүлэн ам нээв.

- Үгүй ээ, Солоццо бүгдийг таньдаг болохоор бидний бодлыг дор нь л ойлгоно. Тессио бид хоёрын аль нэг нь очлоо ч гэсэн ялгаагүй.

- Хэн ч танихгүй шинэ хүмүүсээс олдохгүй юу? - хэмээн Хейген сонирхвол итгэмжлэгдсэн төлөөлөгчид хоёулаа толгой сэгсрэв.

Сонни захирангуй дуугаар эцсийн дүгнэлт гаргалаа.

- Үй түмэн шалтгаанаар Майкаас өөр хүн дөнгөхгүй. Хамгийн гол нь түүнийг тоохгүй байгаа юм. Түүнээс гадна Майк энэ даалгаврыг биелүүлж чадна гэдгийг би батлан даая. Тэр новшийн Түрэгтэй нүүр тулж уулзах өөр боломж алга. Энэ л бидэнд маш чухал. Тэгэхлээр бүх зүйлийг дээд зэргээр зохион байгуулж бэлтгэх л бидний гол зорилт болж байна. Майк аа, тэр хоёрыг буудсан даруйдаа л буугаа хаяхаа мартав аа! Гэрчийн этгээд байсан байгаагүй ямар ч юмыг аргалж болно. Харин чи гар буутайгаа баригдвал өнгөрлөө гэсэн үг шүү. Чамайг зөөх машин, бүгэх байраар найдвартай хангана. Чи энэ хэргээ амжуулсны дараа чимээ шуугиан намдтал амарна биз. Чи удаан, явах боловч нөгөө хүүхэнтэйгээ утсаар ч гэсэн салах ёс гүйцэтгэж болохгүй шүү. Бүх юм өнгөрч, чамайг хал балгүй хил давуулсан хойно амьд мэнд явааг чинь би өөрөө түүнд хэлнэ.

Бие хайрсан, мөс шиг хүйтэн усаар шүршүүлэх шиг гайхамшигтай сайхан сэтгэгдэл дахиад л Майкл Корлеонег эзэмдэв.

- Сонни минь, Кейд юу хэлэх, юу хэлэхгүй нуух, талаар намайг сургаад дэмий дээ. Намайг утсаар салах ёс гүйцэтгэх гэсэндээ биш, чи үүнийг л хэлсэн биз дээ?

- Чи бүү цухалд. Гэхдээ чи шинэ хүн, тэгээд ч одоохондоо би бүгдийг шийднэ. Үүнийг мартъя - гэж Сонни яаран үгүүлбээс Хейген бүгдэд виски аягалаад: - За яамай, одоо бид чухам юу хийхээ баттай мэдэж авлаа хэмээн гунигтай дуугарчээ.

АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Ахмад Мак Клоскиг цагдаагийн хэсгийн өрөөний хананд өлгөсөн цаг харахад Корлеонегийн гэр бүлийн төлөөлөгчтэй, хийх уулзалтад Түрэгийг дагалдаж очих цаг хариугүй дөхсөн байлаа. Мак Клоски шүүгээ онгойлгон энгийн хувцсаа сольж өмсөөд, эхнэртээ утасдаж, ажил гарсан учир хоолон дээр очихгүй гэдгээ хэлэв. Эхнэр нь тэнэглээд, ганц цалингаар амьдраад байж болно гэж одоо болтол боддог тул тэрээр түүнд олон таван юм ярихаа больжээ. Ээж нь бас тэгж боддог байсан боловч аз болоход аав нь намуу Мак Клоскид нууц орлогын эх үүсвэрийг зааж өгсөн аж.

Түүний эцэг нь цагдаагийн газар түрүүч байхдаа долоо хоног болгон хариуцсан хэсгээ эргэхдээ зургаан настай хүүгээ дагуулан явж, дэлгүүр, мухлагийн эздэд танилцуулан:

- Энэ миний хүү гэдэг байв.

Цаадуул нь түрүүчтэй гар барин мэндчилж, жаал хүүг магтан шагшаад мөнгөнийхөө авдрыг тас нясхийн нээж тав арван, доллар авч өгнө. Үдэш орой болоход хүүгийн халаас мөнгөн тэмдэгтээр дүүрч, өөрийнх нь дотор аавынхаа найз нарт таалагдсандаа бахархан бахдах сэтгэл оволзоно. Мэдээжээр эцэг нь тэр мөнгийг хүүгээ коллежид сургахаар хуримтлуулан, банканд хийж, өөрт нь тавин центээс илүүгүйг өгдөг байлаа.

Дараа нь тэр хоёрыг харьж явахад нь тааралдсан цагдаа ах нар түүнээс том болоод ямар хүн болохыг нь асууваас тэрээр хүүхдийн гэнэн цагаан сэтгэлээр: «цагдаа» хэмээн шулганаж, цаадуул нь элгээ хөштөл хөхрөлдөнө. Тэгээд ч тэрээр дунд сургуулиа төгсөөд аавынхаа хүссэнчлэн коллежид элссэнгүй, цагдаагийн курст оржээ.

Тэрбээр шударга, хичээнгүй, эрэлхэг зоригтой цагдаа байсан бөгөөд явуулын хүмүүсийн зүрхэнд орсон танхайчууд түүний бараанаар л таран зугтааж, сүүлдээ тэр хэсгээс бүрмөсөн хулжин одсон байна. Тэрээр хөвгүүдээ хоршоо дэлгүүрээр дагуулж хэсдэггүй, хогийн сав нь хальсан, машинаа буруу газар тавьсныг чинь уучилсны төлөө мухлагийн эздээс хэд гурван мөнгөний өглөг горьддоггүй, харин бүрэн эрхтэй гэж үзээд шан харамж ил авдаг байлаа. Тэрбээр зарим цагдаа нар шиг эргүүл, жижүүрийн үеэр кино үзэж, өвлийн хүйтэн шөнийг ууш зоогийн газар сууж өнгөрүүлдэггүй, хариуцсан хэсгээ заавал эргэдэг юмсанж. Түүний байхад дэлгүүр мухлагийн эздэд бат цайзад суугаа мэт амар жимэр аж төрж, түүнийхээ хариуд талархахдаа гар татдаггүй байлаа.

Мак Клоски заль мэх хэрэглэдэггүй, хууль бус хэрэгт оролцдоггүй, зүгээр хээл хахууль авдаг аж. Тэрээр онцын үсрэлтгүй ч гэсэн албан тушаал тууштай ахисаар л...

Түүний дөрвөн хүү нь өсч өндийгөөд нэг нь ч цагдаагийн газар алба хаасангүй, бүгд их сургуульд оржээ. Тэр хооронд түрүүчээс дэвшин дэслэгч болж, одоо ахмад цол хүртсэн тул хүүхдүүд нь юугаар ч дутагдаж гачигдахын зовлон үзсэнгүй. Яг энэ үеэс эхлэн Мак Клоски тун зальхай хүн гэж алдаршжээ. Түүний хэсэгт байдаг морин тойруулгын бооцоологч нар гэхэд л хуулиас хамгаалуулсныхаа төлөө Нью Йоркод өөр хэн ч төлдөггүй ихийг Мак Клоскид өгдөг байв. Дөрвөн хүүхдийг нь их сургуульд зэрэг сургахад их мөнгө хэрэгтэй шүү дээ?!

Мак Клоски өрөөл бусдын санааг ойлгосноо хэзээ ч мэдэгдэхгүй байх нь зүйтэй гэж аль эртнээс шийдсэн хүн байжээ. Солоццо түүнд утасдаж, Вито Корлеонегийн хэвтэж байгаа эмнэлгийн харуул хамгаалалтыг зайлуулах санал тавихад ямар учиртайг биш, зөвхөн хэдийг өгөхийг асуугаад, арван мянга гэхээр нь цаад учрыг нь төвөггүй ойлгосон байна. Түүнд бодоод байх юм байсангүй. Корлеоне бол америкийн мафийн томоохон толгойлогчдын нэг бөгөөд засгийн газрын аппаратад бол Аль Капонегээс илүү олон танил тал, холбоо сүлбээтэй хүн. Түүнийг хөнөөсөн хэн бугай боловч тэр дороо л энхжингийн оронд залрахсан. Мак Клоски шан харамжаа урьдчилан аваад Солоццогийн хүсэлтийг биелүүлжээ. Харин эмнэлгийн үүдэн дээр Корлеонегийн хоёр хүн зогсож байна гэж Солоццог утасдахад уур нь ёстой л шатаад явчихлаа. Тэрээр Тессиогийн бүх хүнийг зайлуулж, Корлеонегийн хэвтэж байгаа өрөөний үүдний цагдаа харуулыг татаж авсан биз дээ?! Тэгсэн чинь одоо хэлсэн амандаа хүрдэг хүн байж тэрээр ач нараа сургахад зориулсан арван мянгыг Солоццод буцааж өгөх болох нь ээ! Ийм л учраас Мак Клоски уурандаа багтрах шахсан амьтан эмнэлэг дээр давхиж ирээд, Майкл Корлеонег хар тэнхээгээрээ дэлсээд авсан юмсанж.

Гэвч бүх юм нааштайгаар эргэж, Таттальягийн шөнийн клубт Солоццотой уулзахад үүнээс ч илүү орлоготой ажил хийхийг түүнд санал болгожээ. Мак Клоски хэргийн учир начрыг сайн мэдэж байсан учир юу ч асуусангүй, зөвхөн шан харамжаа л хатуу тохиролцжээ. Хар толгой дээрээ булуу хурааж байна гэсэн бодол түүний толгойд ер орсонгүй. Нью Йоркийн цагдаагийн газрын ахмадыг халах солиотой санаа хэн нэгэн хүнд төрөх юм гэж яав ч байшгүй. Цагдаагийн хамгийн өчүүхэн тушаалтан цохиод авдаг юмаа гэхэд шийдчихсэн дээрэмчин ч гар хөдөлгөхгүй. Ер нь цагдааг егөөтүүлэх ямар ч ашиггүй. Яагаад гэвэл энэ тохиолдолд бүх дээрэмчинг баривчлахад эсэргүүцэл үзүүлсэн буюу хэргийн газраас зугтаасан гээд толгой дараалан буудчихад хэн юу хэлэх юм бэ?

Мак Клоски санаа алдаад явахаар зэхлээ. Бэрхшээл, бас дахин бэрхшээл. Эхнэрийнх нь Ирландад байдаг эгч нь олон жил өвчилж, эмчилгээнд нь өчнөөн төчнөөн мөнгө зарсаар байтал саяхан нас барчихлаа. Дахиад л зарлага. Өөрийнхөө төрөл төрөгсөд, үй олон авга, нагац ах эгч нартаа хааяа ч гэсэн туслахгүй бол болохгүй. Тэрээр гомдол мэдүүлэн гонгинож гар татдаггүй болохоор түүнийг эхнэрээ дагуулан эх нутагтаа очиход цаадуул нь хөл алдан угтаж, байгаа бүхнээрээ дайлдаг бөлгөө. Дайн дуусч, сул мөнгө халаас уруу нь аяндаа урсах болсон юм чинь энэ зун ч гэсэн нутагтаа очоод ирэх юмсан. Мак Клоски хэрэг гарвал хаанаас олж болохыг жижүүрт хэлэхдээ нэг ч их болгоомжилсонгүй, болохгүй бол мэдээлэгчтэйгээ уулзсан гэнэ биз. Тэрбээр хэсгийн байрнаас гарч, хоёр хороолол хэртэй явган алхаад Солоццогийн хүлээж байгаа байшин тийш хөлсний тэргээр явлаа.

...Майклыг хил давуулан орлуулахад шаардлагатай бүх зүйлийг базааж хуурамч паспорт, усан цэргийн үнэмлэх бэлтгэх, сицилийн нэг боомтод очих италийн худалдааны онгоцонд сул ор олох үүрэг Том Хейгенд ноогджээ. Бас сицилийн уулархаг нутгийн мафийн толгойлогчийнд Майклыг толгой хоргодуулах асуудлыг шийдвэрлүүлэхээр тэр өдөртөө Сицили рүү элч

мордуулав.

Майклыг Солоццотой уулзаад зоогийн газраас гарахад найдвартай хүн хүлээж байна гэж Сонни анхааруулсан аж. Тэр найдвартай хүний дүрд энэ удаа Тессио өөрөө тоглох бөгөөд тэр тусмаа нэхэмжлэгдсэн төлөөлөгч өөрөө сайн дураараа зөвшөөрчээ. Тэрээр харахад хариугүй ямбий боловч гайхам хүчтэй хөдөлгүүртэй, хуурамч дугаар зүүсэн машин авчрах байв. Тэр машиныг яах ч аргагүйдээ тулсан онцгой тохиолдолд хэрэглэхээр хадгалж байсан болохоор хуурамч дугааргүй ч гэсэн хэнийх гэдгийг тогтоох боломжгүй.

Майкл өөрт нь сэм шургуулах жижигхэн гар буутай Клеменцагийн хамт ноцолдсоор өдрийг барав. Гэнэт ямар ч гэмгүй атлаа зүрхний хийтэй хэн нэг хөндлөнгийн хүн учрыг нь ололгүй ирж зууралдаад хар зоргондоо алуулах вий гэж болгоомжлоод дуу намсгагч хийхээ болилоо. Харин буун дуу сонсвол ойртохгүй шүү дээ.

Майкл бууны цэцнийг шалгаж байх зуур Клеменца түүнд зааж сургамжилна.

- Буудаж дуусангуутаа л буугаа шалан дээр унагаад тэр дороо зугтаарай. Чиний гарыг биш царай, руу чинь харах тул хэн ч ажиглахгүй, бүгд чамайг зэвсэгтэй л гэж бодно. Тэндээс гүйхээрээ биш тайван алхаж гарахдаа хэн рүү ч эгцлэн харж болохгүй, гэхдээ харц буруулж бас болохгүй. Ингэвэл хавь ойрын хүмүүс чамаас ухаан алдталаа айна, тийм ээ тийм. Чи надад итгэж үз. Чамайг гарахад Тессио бэлэн хүлээж байх болно. Машинд нь суугаад цааших асуудлыг түүнд даатга. Харин одоо бүрх малгайгаа өмс, би нэг хараад орхиё.

Тэрбээр саарал цэмбэн бүрх гүүний толгойд угласанд угийн малгай өмсөх дургүй Майкл эвгүйрхэн ярвайсан боловч Клеменца өөрийнхөөрөө зүтгэсээр байгаад өмсүүлж л саллаа.

- Бүр танигдахгүй болж чадахгүй ч гэсэн лав л гэм болохгүй. Ядахдаа гэрчийн этгээдүүдтэй бид өөрийн аргаар ярилцсаны дараа тэд андуурснаа хүлээж, мэдүүлгээ буцаах аян шалтаг ч болж мэднэ. Аа тийм, Майк, чи аан гэж бай. Бариул, цохиур хоёрыг тусгай наалданги туузаар ороох тул хурууны хээ чамд ер падгүй. Ганцхан гар бууныхаа бусад газраас нь л бүү ,бариарай.

- Солоццо намайг хааш нь аваачих гээд байгааг Сонни мэдэж үү?

Клеменца мөрөө хавчив. - Солоццо тун их болгоомжлоод одоохондоо мэдэж чадаагүй байна. Гэхдээ чи санаа бүү зов, чамайг эсэн мэнд эргэж иртэл зуучлагч бидний гарт байна. Тэр эр тэднийдээ зүгээр нэг «зургаат» биш, дор хаяад «хөзрийн ноён» болохоор тэд чамайг яах ч үгүй. Хамгийн энгийнээр бодоход Солоццо түүний амийг чинийхээр яасан ч солихгүй юм чинь чамд ямар ч аюулгүй, харин бид л дараа нь сандрах байхдаа.

- Та нар хэцүүдэх болов уу?

- Еэ, сүйд болох биз. Таттальягийн гэр бүл Корлеонегийн гэр бүлтэй ил дайтах юм чинь энэ өвөл гудамж цэвэрлэхэд мөн ч олон үхдэл олдох биз дээ - гээд Клеменца толгой сэгсрэв.

- Одоо яая гэхэв, гар бариад бугуй барих улстай өөрөөр ярих аргагүй, шууд л нам цохисон нь

дээр. Яагаав, нөгөө Гитлерийг Мюнхенд л бут ниргэсэн бол яалаа гэж дэвэн дэлхийгээр тэнүүлээд эцэст нь өөрсдөө тамаа цайж явах вэ

Эцэг нь дайнаас өмнө 1939 онд иймэрхүү юм ярьж байсныг дурсан санаад: «Тэр үед Гадаад явдлын яамны эрхийг мафийн гэр бүлийн омгуудад өгсөн бол дэлхийн хоёрдугаар дайн гараа ч уу, үгүй ч үү» гэж бодоод хөх инээд нь хүрэв.

Тэр хоёр Соннигийн төв байр болгон суурьшсан Их эцгийн өргөөнд буцаж ирэхэд тэрээр буйдан дээр түр хажуулсан байв. Загалмайлсан Эцгийн үед ямагт тун цэгцтэй байдаг асан ажлын өрөө нь одоо хямдхан зочид буудлын балиар өрөө шиг харагдана. Майкл ахынхаа мөрнөөс сэгсэрч:

- Хөөе, та тэнүүлчин шиг дэндүү заваан суух юм. Өрөөгөө цэвэрлүүлээч! - гэвэл Сонни амаа цууран алдтал эвшээлээ.

- Үгүй ер өө, ямар сүрхий жанжин ирчхээд хуаран шалгаж яваа юм бэ? Дэмий дөвчигнөхөө больж үз. Майк! Тэр золигийн Солоццо, Мак Клоски хоёр чамайг хааш нь чирч аваачих гээд байгааг мэдээгүй байна. Бид яаж чамд буу хүргэх билээ, чөтгөр алгад!

- Зүгээр л би аваад очдог юм билүү? Олбол олно л биз, яадаг юм бэ? Хурааж авахаас өөр яав л гэж.

Сонни толгой сэгсэрлээ.

- Тэр ярихгүй ээ. Солоццог тонилгох цорын ганц энэ боломжийг алдал хэрхэвч үл болно. Гар буугаа заавал унага гэж Клеменца хэлэв үү?

- Тоть шиг л давтсан даг!

Сонни буйдангаас, босч байдгаараа суняав.

- Эрүү чинь яаж байна, өвгөөн?

- Тун тааруу - хэмээн Майкл нүүрнийх нь зүүн тал тэр чигээрээ янгинан өвдөх тул ширээн дээрээс шилтэй виски авч амаар нь балгасанд өвчин жаахан намдлаа.

Сонни суняасан чигээрээ:

- Хүүе, Майк, аяд гэм. Одоо архидах цаг биш, согтчихвол яана? - гэвээс Майкл өөдөөс нь хэдэрлэв.

- Хол очиж донгос, сүрхий хүн болох гэж ядах юм. Би галын шугам дээр байхдаа Солоццогоос чинь шазруун залуустай үзэлцэж явсан хүн. Санаа шулуудаж шийдэх л хэцүү болохоос алах бол юухан байх вэ? Том Хейген орж ирээд, дуугүй асуусан Соннигийн харцанд толгой сэгсэрч хариуллаа.

- Чимээ ч алга. Солоццо эцсийн мөчийг хүртэл хэлэхгүй нь бололтой.

Утас дуугарч, Сонни дөхөж очоод нэг ч хүн үг дуугараагүй хэр нь бүү шуугьцгаа хэмээн гар өргөв. Тэрээр дэвтэртээ нэг юм сараачиж: «За за, хугацаандаа тэнд чинь очно» гээд харилцуураа өлгөлөө.

- Муу өгөр Солоццо ч сүрхий бэлтрэг юм даа. Тэгэхлээр оройн найман цагт Солоццо, Мак Клоски хоёр Бродвейд байдаг Жек Демпсигийн баарны үүднээс Майкыг авч хэлэлцээр хийх газартаа очих гэнэ. Хаана очихоо хэлэхгүй байна. Бас нэг сонин юм дуулгахад, тэр ирланд нохойд юу ч ойлгуулахгүйн тулд Майк, Солоццо хоёр италиар ярих гэнэ. Тэр Майк Клоски нь италиар «сольди» гэдгээс өөр юу ч мэддэггүй юм байх. Харин Майк чамайг сицили аялгаар ярьдгийг чинь тэд олж мэдсэн ажээ.

- Жаахан мартаж, гэхдээ товчхон ярилцах юм чинь гайгүй биз - хэмээн Майкл хайнга дуугартал Том Хейген ам нээв.

- Зуучлагч энд иртэл Майк байрнаасаа хөдлөх ч үгүй. Энэ тухай хатуу тохиролцсон биз?

Клеменца толгой дохилоо.

- Зуучлагч аль хэдийн ирээд миний гурван залуутай хөзөр наадаж суугаа. Миний утасдахаас нааш үүнийг хааш нь ч явуулахгүй.

Сонни ширэн бүрээстэй буйдан сандалд тухлаад:

- Золиг байх гэж, түүнийг хаана аваачиж хэлэлцээр хийхийг яаж мэдэх вэ? - хэмээн халаглахад, Хейген гүнзгий санаа алдлаа.

- Тэдний араас «сүүл» тавиад хувь заяандаа найдахаас өөр яах вэ?

- Яаж болох вэ, хэрэв хүсвэл тэр «сүүлнээс» чинь дуртай цагтаа ангижирч болно. Энэ талаар тэд юуны түрүүнд санаа тавина шүү дээ.

Ингэж тэгсээр байтал оройн таван цаг хариугүй, болох нь. Гэнэт Хейген хуруугаа инчдэж:

- Нөгөө цагдаагийн газрын залуу, Филипс чинь яагаа вэ? Ахмад Мак Клоски хэрэг гарвал хаанаас олж болохыг мэдээд хэл гэж түүнд утасдаач, Сонни. Өөрийн хүмүүсээс хэн нэг нь хаашаа явсныг нь асуусан байхад тэр ахмад тоохгүй байлгүй - гэлээ.

Сонни утас эрэгдэж нэг юм аяархан хэлснээ харилцуураа буцааж өлгөв.

- Асууж мэдчихээд утасдана аа!

Бараг хагас цаг болоод утас дуугарсан нь Филипс ярьжээ. Сонни дахин юу ч юм бичиж аваад харилцуураа тавихад шанааных нь судас гүрэлзэж харагдав.

- За, нэг юм бүтэв бололтой. Ахмад Мак Клоски өөртэйгөө холбоо барих хаягаа ажил дээрээ үлдээх ёстой юм байна л даа. Тэгээд өнөөдөр тэрээр наймаас арван цаг хүртэл Бронкс дахь «Цэнхэр сар» зоогийн газарт байх гэнэ. Энэ талаар хэн юу хэлмээр байна?

- Үүнээс илүү тохиромжтой газар бидэнд олдохгүй гэж би хэлмээр байна. Нэг гэр бүлийнхэн эрхэлж үйлчилдэг чимээ аниргүй газар. Зочид хөндлөнгийн хүний нүднээс далд ярилцаж болохуйц ширээнүүдийн хооронд хашлага хийсэн болохоор хэн ч хэнийгээ анзаардаггүй, сайхан хоолтой. Маш сайн байна - гээд Тессио ширээнд ойртов.

- Клеменца, чамд цаг тун бага байна. Одоохон хүн явуулж, гар буу хүргүүл. Тэндхийн бие засах өрөө хуучны тоноглолтой, ус хураагуур хана хоёрын хооронд хөндий бий. Гар бууг ус хураагуурын ар талд наалданги туузаар бэхлэх хэрэгтэй. Майк, чамайг машин дотор нэгжээд зэвсэг байхгүй болохоор тайвширцгаана. Зоогийн газар орсон хойноо нүд хуурч жаахан суугаад уучлалт гуйж гараарай. Харин буцаж ирэхдээ цаг алдсаны хэрэггүй. Ширээнд суугаад юу хийхэв, шууд л буудаарай. Яг онож толгойд нь нэг нэг сум зоогоод зугтаах хэрэгтэй.

- Гар буу аваачиж тавина. Үүнийг би батлан даая - хэмээн Клеменца их л нухацтай үгүүлбэл Сонни бослоо.

- За, тэгвэл ажилдаа орёе.

Тессио, Клеменца хоёрыг гарсан хойно Том Хейген асуусан нь:

- Сонни, Би Майкыг Нью Йорк хүргэх үү?

- Үгүй, чи эндээ үлд. Майк ажлаа амжуулсны дараа, энд ажил ёстой л ундарч, чи надад тун их хэрэг болно. Сониныхны талаар бодсон биз?

Хейген толгой дохив.

- Хэрэг мандаад ирэхээр тэдэнд мэдээлэл хаяж эхэлнэ.

Сонни Майкл тийш ойртож очоод нүд рүү нь эгцлэн харснаа гараа сунгалаа.

- За ингээд, өвгөн минь, хөдөлж үз. Явахаасаа өмнө чи ээжтэй салах ёс хийж чадахгүй, би дараа түүнд тайлбарлана. Хүүхэнд чинь ч гэсэн жаахан азнаж байгаад чиний мэндийг дамжуулъя, за юу?

- Одоо яая гэхэв! Тэгээд би удаан хугацаанд харь газар нуугдах хэрэг үү, Сонни?

- Наад зах нь нэг жил.

- Их эцэг наана нь ч аргалж магадгүй хэмээн Том Хейген уг хавчуулав.

- Гэхдээ чи, Майк аа, үүнд битгий их найдаарай. Чиний эргэж ирэх хугацаа сонин хэвлэлийнхэн бидний өгөөшид үнэмших үү, цагдаагийн газрынхан өөрийнхөө хүнийг цагаатгаж өмөөрөх үү, мөн түүнчлэн бусад намууд бидний эсрэг зэвсэглэж босох эсэх зэрэг олон зүйлээс шалтгаална. Элдэв «халдлага мөрдөлт биднийг хангалттай дайрч бид тун хэцүүднэ гэдгийг л ганцхан багтай хэлж чадах байна.

Майкл Хейгентэй гар барилаа.

- Гэлээ ч гэсэн чи түргэлүүлэхийг л хичээж үзээрэй. Би гэрээсээ хол гурван жил тэнэсэн хүн, дахиад удаан дайжихыг хүсэхгүй байна.

Хейген тун зөөлөн дуугаар ийн үгүүлрүүн:

- Майк, асуудлыг өөрөөр шийдэж өөр хун явуулахад хожимдоогүй шүү дээ. Хэрэв чи эрүүгээ хугалуулсандаа гоморхож сүйд болсон бол дэмий дээ. Нэгдүгээрт, Мак Клоски мангуу амьтан, хоёрт, энэ бол зөвхөн хувийн шөргөлцөөн, ажил хэргийн арга хэмжээ төдий л юм шүү дээ.

Өнөөдөр хоёрдахь удаагаа Майкл Корлеонегийн царай баг мэт царцан хөшиж, Их эцгийн шинж төрх тод ялгаран харагдах нь Хейгенд тайлбарлахын аргагүй, үс өрвийм аймаар санагдав.

- Том, чи өөрийгөө хуурахын хэрэг юун. Хэн нэгэн хүнд авсан аливаа ажил хэргийн арга хэмжээ бол хувийн шөргөлцөөн. Ажил хэргийн явцад хүний амсаж үзсэн бузар муухай болгон хувийн шөргөлцөөн. Үүнийг би хэнээс мэдэж авсан гэж чи бодно? Их эцгээс, ааваас. Загалмайлсан эцгээс шүү дээ. Түүний хувьд дотно найзыг нь аянга ниргэсэн ч хувийн шөргөлдөөн байдаг юм. Бас өөр юм мэдэхийг хүсч байна уу? Азгүй тохиолдлыг хувийн доромжлол гэж үздэг хүмүүс гэнэтийн осолд ордоггүй юм. Тийм ээ, миний эрүүг хугалсан явдлыг хувийн доромжлол гэж үзэж байна. Тийм ээ, Солоццо аавыг минь алах гэснийг ч хувийн доромжлолд тооцож байна гээд Майкл инээмсэглэв. Ааваасаа энэ бүхнийг сурч аваад, миний төлөө хийсэн бүхнийх нь хариуд сайн үйл бүтээх бололцоо гарсанд баярлаж байгааг минь түүнд уламжлаарай.

Майкл хэсэг чимээгүй байснаа:

- Аав Сонни, Фредди бид гурвын алинд ч гар хүрч байгаагүй гэхэд чи үнэмших үү? Коннигийн тухай ярихын ч хэрэггүй, түүнийг нэг ч удаа зандарч үзээгүй. За одоо, Том минь, чин үнэнийг нь хэлээд аль. Их эцэг хүний гараар хэдэн хүн егүүтгэсэн бэ? гэсэнд Том Хейген харц бурууллаа.

- Ийм юм ярьж болдоггүйг л чи ааваасаа сурч аваагүй үлджээ гэдгийг чамд хэлмээр байна. Хийхээс өөр аргагүй зүйл гэж байдаг. Түүнийг хийгээд л өнгөрөхөөс биш, түүний тухай цуураад явдаггүй юм. Нэгэнт цагаатгаж үл болох тэр зүйлийг хэн ч зөвгөхийг оролддоггүй. Зүгээр л хийдэг, тэгээд л тэр. Дараа нь мартдаг.

Майкл Корлеоне хөмсөг зангидсанаа санаанд оромгүй тайван дуугарав.

- Солоццо амьд үлдвэл Их эцэгт болон манай гэрийнхэнд аюултай гэдгийг чи зөвлөхийн хувьд зөвшөөрч байна уу?

- Тийм ээ.

- Ойлгомжтой. Тэгэхлээр би түүнийг заавал алах ёстой.

Майкл Корлеоне Бродвейн гудамжинд Жек Демпсигийн зоогийн газрын дэргэд хүлээн зогссоноо цагаа харвал наймд таван минут дутуу байлаа. Солоццо яг цагаа тулгаж ирэх бололтой. Гэтэл тэр ийшээгээ яараад л, бүр арван таван минут хүлээж байдаг, мөн таарч дээ.

Оройн жүжиг эхлэх цаг ойртсон хэдий ч гадаа хүйтэн болохоор Бродвейд тийм ч олон хүнгүй. Гэнэт том хар машин зам шахан зогсож, жолооч нь гар сунган урд хаалга онгойлгоход Майкл давхийн цочив.

- Суу, Майк.

Давирхайдсан юм шиг гөлчийтөл үсээ самнасан, задгай захтай цамцтай энэ хархүүг Майкл анх удаагаа харж байгаа боловч ард нь Мак Клоски, Солоццо хоёр сууж байсан тул үгэнд нь орлоо.

Солоццо суудал давуулан гар сунгахаар Майкл атгасан чинь цаадах нь үгүүлрүүн:

- Майк, чи хүрээд ирдэг чинь болж дээ. Чи бид хоёр энэ будлиантай хэргийг нэг тийш болгож чадна гэж найдаж байна. Миний тооцоолсноос шал өөрөөр эргээд аюултай юм болсон шүү. Энэ бүтэлгүй хэрэг хэнд ч хэрэггүй.

Майкл нэг хэвийн дуугаар хариу үгүүлсэн нь :

- Тийм ээ, бид үг хэлээ ололцоно гэж найдах юм. Аавыг минь дахин оролдохыг би хүсэхгүй байна.

- Оролдохгүй, дахин түүнд хэн ч гар хүрэхгүй гэдгийг хүүхдүүдийнхээ эрүүл мэндээр тангараглая. Харин чи асуудалд ухаалаг хандахыг хичээгээрэй. Чамайг ах шигээ хүн биш гэж найдна. Сонни ёстой л хуурай дарь шиг болохоор ямар ч ажлын талаар тохирч болохгүй юм.

Ахмад Мак Клоски тонгойн Майклын дал мөрийг алгадаад авав.

- Үүнтэй тохирч болно оо. Энэ зүгээр залуу. Майк аа, өчигдрийн явдалд бүү уурлаарай. Хөгширч нас ахиад ийм ажилд тэсвэр тэвчээр хүрэхээ байж. Өдөржин мэдрэл хөдөлгөөд заримдаа биеэ барьж чадахаа больж, тэтгэвэртээ гарах цаг ойртсон шиг байна.

Мак Клоски гунигтай санаа алдаад Майклыг сурмаг нэгжин зэвсэг байгаа эсэхийг шалгаж үзлээ. Арван минутын дараа тэдний машин италичуудын бяцхан хорооллоор орж зоогийн газрын өмнө зогсов. Гадаа гудамжинд нэг ч хүнгүй, дотор ширээний ард оройтсон хэдэн зочид хоолоо идээд дуусч байлаа. Жолоочийг дагаад орох болов уу гэж Майкл сэтгэл түгшиж байсан чинь ашгүй, машиндаа үлдэв. Жолоочийн тухай зуучлагч юу ч хэлээгүй, ер нь түүнийг хэн ч дурсаагүй бөгөөд нарийн яривал жолоочтой ирснээрээ Солоццо хэлцэж тохирсон болзлыг зөрчсөн боловч Майкл энэ тухай ам ангайхгүй байхаар шийджээ. Яахав, хэлэлцээрийн амжилтад муугаар нөлөөлнө гэж айгаад хулчийхдаа жолоочийн тухай юм

ярьсангүй гэж бодвол ч бодог.

Хашлагаар хаасан ширээнд суухыг Солоццо эрс татгалзсан учир тэд цорын ганц дугуй ширээ эзлэхэд тэднээс гадна ердөө хоёрхон хүн үлдсэн нь Түрэгийн зориуд суулгасан хүмүүс биш байгаа даа гэсэн хар сэжиг Майклын толгойд жирэлзээд өнгөрчээ. Одоо тийм байсан ч ямар хамаатай билээ?!

Мак Клоскигийн нүд нь сэргэж:

- Энд итали үндэсний хоол сайн хийдэг үү? хэмээвэл Солоццо түүнийг тайвшруулан зөвлөж:

- Тугалын мах ав. Нью Йоркод өөр хаанаас ч тийм амттай мах олохгүй шүү! —гэлээ.

Үйлчлэгч дарс авчирч онгойлгов. Хамгийн гайхалтай нь Мак Клоски ерөөсөө архи амсдаггүй юмсанж.

- Бүх ирландчуудын дотроос би л ганцаараа архи уудаггүй байх. Ямар олон сайн хүмүүсийн толгойг энэ хор залгисныг би үзэхээрээ нэг болсон.

Солоццо эв эеийг хичээн ахмадад үгүүлрүүн

- Би Майклтай италиар ярилцъя. Танд итгэхгүй байна гэж бүү муу юм санаарай, зүгээр л өөрийн бодлоо англиар илэрхийлэхэд надад хэцүү байна. Гэтэл сайн үйлийн төлөө би энэ алхмыг хийж, өнөөдөр бид хэлцэж тохирвол хэн хэн нь хожно гэдгийг Майклд ойлгуулах хэрэгтэй байна шүү дээ. Та уучлаарай, гэхдээ энэ нь танд итгээгүйдээ биш юм шүү.

Ахмад Мак Клоски доогтой нүдээр тэр хоёрыг ээлжлэн харлаа.

- Дураараа болцгоо. Тэр хооронд чинь би тугалын мах, чанасан гоймон хоёртой ноцолдож байя.

Солоццо Майкл өөд эргээд сицили аялгаар дуржигнуулж гарав.

- Чиний аав бид хоёрын хооронд болсон явдал зөвхөн ажил хэргийн шинж чанартай болохыг чи юуны өмнө ойлгоорой. Би эрхэм Корлеоне гүнээ хүндэтгэж, түүнд хүчин зүтгэхэд нэн дуртай байхсан. Гэвч аав чинь хоцрогдсон үзэлдээ баригдаад бүгд урагшаа дэвшиж байхад эрхэм Корлеоне зам хөндөлсөөд саад хийгээд байгааг чи бас сайн ойлго. Миний өрнүүлсэн ажил бол маргаашийн өдөр, ирээдүйн дуудлага, хэн хэнд маань тоо томшгүй саяын орлого оруулах дорвитой хэрэг юм. Гэтэл чиний аав үеэ өнгөрөөсөн нэрээ бодох, ёсорхох зангаасаа болоод урсгал сөрж, ингэснээрээ над шиг хүмүүст өөрийн хүсэл зоригоо тулгаад байна. Үгүй ээ, тэрбээр үгэн дээрээ бол, та нарын л хэрэг, дураараа болцгоо гэх боловч энэ нь зөвхөн үг төдий зүйл гэдгийг бид хоёулаа мэдэж байгаа. Хэрэг дээрээ бол бид хоёр нэг нэгнийгээ багалзуурдахаас өөр аргагүй. Мөн чанартаа бол, энэ их ашиг орлоготой бизнесээс татгалзах хэрэгтэй гэсэн огт өөр юм надад хэлээд байгаа юм. Тэгээд чи өөрийгөө хүндэтгэдэг, бусдын хүсэл зоригт хэзээ ч захирагдаж чадахгүй тул болох ёстой юм ёсоороо л болсон. Би чиний аавд халдахдаа Нью Йоркийн бүх таван намын зөвшөөрөл дэмжлэг авсан, бас Таттальягийн

нам надтай хамтарсан гэдгийг чамд нэмж хэлмээр байна. Хэрэв эл хямралдаан цаашид үргэлжилбэл Корлеонегийн нам бүгдийн эсрэг ганцаараа сөргөлдөх болно. Аав чинь эрүүл байсан бол та нар тэсээд гарч магадгүй байсан л даа. Гэвч том ах чинь, би түүнийг гомдоох гээгүй шүү. Загалмайлсан эцгийн зиндаанд хүрэх яагаа ч үгүй. Бас танай зөвлөх, ирланд Хейген талийгаач Женко Аббандандог бараадах ч үгүй, амгалан нойрсог хөөрхий. Тийм ч учраас би найрамдлын гэрээ, тодорхой яривал түр эвлэрэх гэрээ байгуулъя гэсэн юм. Загалмайлсан эцэг бие илааршиж, хэлэлцээрт өөрөө оролцох хүртэл дайсагнах бүх ажиллагааг зогсооё. Тагталья миний ятгаж, ухуулж сэнхрүүлснээс хойш Бруно хүүгийнхээ төлөө өшөө авах бодлоо орхихыг зөвшөөрсөн. Энэ хугацаанд эв эетэй байцгаая л даа. Гэхдээ хэрэг явдал зүгширтэл талхныхаа мөнгийг л олох хэрэгтэн юм чинь би өөрийн худалдаа наймааг бага сагаар эрхэлж л байя. Би та нарыг түншлээч гэж гуйхгүй, гагцхүү Корлеонегийн нам надад бүү саад хийгээсэй л хэмээн хүснэм. Миний бодол санаа ийм л байна. Хэрэв би эндүүрээгүй бол, миний санал та нарт тохирох эсэхийг газар дээр нь шийдэх эрх чамд олгосон биз дээ?

Майкл мөн л сицили аялгаар хариу үгүүлрүүн:

- Та ажил хэргээ яаж явуулах, манай гэр бүлийнхэнд ямар роль тохоосон, бид ямар ашиг олох талаар тодорхой ярьж өгөөч.

- Чи намайг өөрийнхөө саналын гол утгыг нарийвчлан тайлбарла гээд байна уу даа?

- Юуны өмнө аавын аминд дахин халдахгүй гэсэн хатуу баталгаа надад хэрэгтэй байна.

Солоццо хэнд ч ойлгогдохоор хоёр гарын алга тэнийлгэн дээш өргөлөө.

- Би одоо өөрөө амиа хоохойлж ядаж байж ямар баталгаа өгч чадах юм бэ? Тэнгэр заяасан нэг боломжийг нь би алдчихсан. Найз минь, чи намайг хэтэрхий үнэлж, их том хүн гэж бодоод байна. Би ид шидтэн биш шүү дээ.

Зөвхөн цаг хожиж, хэдэн хоног ч болов тайван байхын тулд л энэ уулзалт хийсэн гэдэгт Майкл одоо эргэлзэхээ болив. Солоццо яалаа ч гэсэн Их Эцгийн Амь насанд заавал дахин халдана. Хамгийн инээдтэй нь, Түрэг түүнийг тоож үзэхгүй, ердөө л нусгай жаал, нялцгай амьтан гэж бодоод байна. Дотор хүйт оргиулах жихүүн зэвүүцэл гуравдахь удаагаа Майклын бүх биеийг эзэмдсэн боловч тэрээр биеэ барьж харамссан байртай хөмсөг өргөтөл Солоццо сэрдхийгээд явчихлаа.

- Юу болоо вэ?

Майкл ичингүйрэн царай улайлгаж:

- Энэ дарс... Шингэн юм дэндүү уучихжээ. Би түр гараад ирвэл болох уу? - хэмээн англиар хэлэхэд Солоццо тас хар нүдээрээ түүнийг сонжих мэт цоргин ширтэв. Мак Клоски тоомжиргүй дуугаар:

- Наадах чинь яах ч үгүй. Би нэгжсэн шүү дээ - гэв. Солоццо дуртай дургүй:

- За яахав, харин удав аа! - гэх нь араатны сонор мэдрэмжтэй тэр эр нэгийг сэжиглэсэн ч болов уу.

Майкл бие засах газар орж, ус хураагуурын пааландсан арыг тэмтэрч жижигхэн гар буу гаргаж авлаа. Клеменца наалданги тууз дээрх хурууны хээний талаар санаа зовоод хэрэггүй гэсэн тул Майкл туузыг хуулж хаяад буугаа өмднийхөө тэлээнд хавчуулснаа гар үсээ норгон, хээ хуар нь үлдсэн усны цоргыг арчаад гарлаа.

Солоццо тас хар нүдээ сэжиглэнгүй гялалзуулан яг бие засах газрын хаалганы чанх өдөөс хараад сууж байсанд Майкл эелдгээр инээмсэглэн:

- Одоо яриагаа үргэлжлүүлж болохтой боллоо- гээд дотор уужирсан янзтай санаа алдав.

Ахмад Мак Клоски огт хэнэггүй царайлан, энэ хооронд авчирч өгсөн тугалын мах, гоймон хоёрыг сэхээ сэвээгүй үмхэлж гарав. Майклыг нүд салгалгүй ажин мухрын ширээний ард хөшиж орхисон эр бас л санаа амарч бие сул тавилаа.

Майкл хуучин байрандаа суув Буцаад суух хэрэггүй, бие засах газраас гарсан даруйдаа л буудаарай гэж захиж захиж явуулсныг тэрээр мартаагүй боловч гүйцэд ухаараагүй сэтгэлийн хөдөлгөөнөөр ч юм уу, эсвэл айсандаа ч тэр үү, суудалдаа очоод суучихжээ. Майкл өчүүхэн төдий огцом хөдөлбөөс нам буудуулахаа сайн мэдэж байв. Одоо тэр овоо зориг өрж сандал дээр суух нь ийм сайхан санагдаад, хөл нь одоо хүртэл чичирч салганаад байгааг бодоход түрүүнд айж хулчийсан л байх нь дээ!

Солоццо түүн рүү бүх биеэрээ тонгойход Майкл ширээний тавцангаар халхлан пиджакныхаа товчийг мулталж, түүний үгийг хүчлэн сонсох боловч нэг ч үг үл ойлгоно. Чамархайн нь судас хүчтэй лугшин Солоццогийн дуу хоолой уураг тархинд нь ер хүрэхгүй аж. Ширээн доогуур баруун гараа зугуухан явуулсаар бүсэндээ хавчуулсан гар буугаа авгал үйлчлэгч хүрч ирээд Солоццог түүн тийш эргэн хармагц Майкл зүүн гараараа ширээ хөмрөхийн зэрэгцээ баруунаараа гар буугаа өргөн Түрэгийн бараг гавалд нь тулгалаа. Гэтэл Солоццо гайхалтай түргэн хариу хөдөлж, Майклыг хуруугаа ч хөдөлгөж амжаагүй байтал ар гэдрэгээ савав. Гэвч насаар залуу Майклын рефлекс арай түргэн ажиллаж гохоо дарж амжлаа. Яагаад ч юм ганц сум хангалттай гэсэн бүрэн итгэл түүнд төржээ. Сүүлийн эгшинд Солоццо эргэн харахад түүний нүдэнд амьдын шинж аажмаар унтарч байгааг Майкл ажиглаад тэрхэн дороо буугаа Мак Клоски өөд эргүүлэв.

Цагдаагийн газрын ахмад энэ болсон явдал өөрт нь огт хамаагүй юм шиг хайнга ,гэхдээ гайхаж бүлтийсэн нүдээр Солоццог харж байснаа Майкл өөд эргэхэд энэ муу нусгай жаал эсвэл одоохон бууж өгнө, нэг бол хар хурдаараа зугтаах биз гэсэн бат итгэл, биеэ тоосон зэвүүцэл нүүрэнд нь бичээстэй байсан тул Майкл гохоо дарахдаа өөрийн эрхгүй инээмсэглэжээ. Тэрбээр тун тааруухан буудаж, Мак Клоскиг нам унагаж чадсангүй, зөвхөн лут бүдүүн бухан хүзүүг нь оносон учир дараагийн сумаа тун тайван, ончийг нь олж байгаад бууралтаж яваа зулайд нь зоож орхив.

Өрөөн дотор дарьны утаа хөшиглөн ханхалж, Майкл мухрын ширээ рүү цочмог эргэхүй нөгөө эр байрнаасаа ч хөдөлсөнгүй, зориудаар хоёр гараа ширээн дээр тавьж харц бурууллаа. Майкл

атгасан гараа тэнийлгэмэгц гар буу баруун ташаа даган шалан дээр чив чимээгүй гулсан унахыг мухрын ширээний хүн, үйлчлэгч хоёрын хэн нь ч харсангүй. Майкл хэдхэн алхаад л хаалганд хүрч онгойлговол Солоццогийн машин байрандаа зогсож, харин жолооч нь үзэгдсэнгүй. Гэрээр зүүн тийш эргэн явсаар булан тойртол тольдуур гэрэл гялсхийж, будаг нь холцорч хуучирсан машин дэргэд нь ирж, Майклыг онгойлгож өгсөн хаалгаар үсрэн ормогц хөдөлгүүрээ нүргэлүүлэн ухасхийв. Жолооны ард суугаа Тессюгийн царай гантиг чулуугаар сийлсэн мэт хөшиж гөлийжээ.

- Солоццог зүйл дуусгав уу?

- Хоёулаа нам явсан.

- Чи итгэлтэй байна уу?

- Би тэдний уураг тархийг нүдээрээ харсан.

Майклын солих хувцас машин дотор бэлэн байсан тул ер саатсангүй. шууд давхисаар хорин минутын дараа гэхэд Сицилийн эрэг зорьсон италийн худалдааны усан онгоц дээр гарсан байлаа. Хоёр цаг болоод хөлөг онгоц тэнгист гарах зуур Нью Йоркийн шөнийн гэрэл тамын галын дөл мэт яралзан дүрэлзэхийг Майкл цонхоороо хараад сая нэг санаа амрав. Тэр одоо юунд ч хамаагүй, цэвэр мултарч чадлаа. Түүнийг хөнгөн шархдаад байхад нь тэнгисийн явган цэргийн сумангийн хамт буусан арал дээрээс нь авч эмнэлгийн хөлөг онгоц дээр гаргахад бие хөнгөрсөн шиг эдүгээ тэр дотор нь уужран жаргалын дээдийг амсав. Одоо тэнд галав юулж байсан ч нэгэнт тэрээр амь мултарсан хойно ямар хамаатай билээ?!

Солоццо, Мак Клоски хоёрыг алсны маргааш өглөө Нью Йоркийн цагдаагийн бүх хэсэг байцаагч нараараа дамжуулан ахмад Мак Клоскиг хөнөөсөн алуурч баригдах хүртэл мөрийтэй тоглоомын болон янхны газрыг бүгдийг хааж, хууль бусаар орлого олох бүх үйл ажиллагааг түр зогсоосныг зарлажээ.

Орой тийшээгээ Нью Йоркийн таван нам зуучлагчаар дамжуулан Корлеонегийн гэр бүлийнхэн алуурчийг барьж өгөхөө зөвшөөрөх эсэхийг асуулгасанд та нарт хамаагүй гэсэн хариу өгсөн байна. Бүр харанхуй болсон хойно Корлеонегийн мэдлийн байшингуудын ойролцоо, цэцэрлэгт хүрээлэнгийн орцны дэргэд нэг машин давхин ирж, дотроос нь дэлбэрэх бөмбөг хол гэгч нь шидчихээд давхиад явчхав. Бас нилээд хэдэн цагийн дараа Корлеонед хучин зүтгэдэг жирийн хоёр «цэргийг» Гринч Вилиж дахь итали зоогийн газар зүв зүгээр хоол идээд сууж байхад нь буудаж алсан байна. Ийнхүү 1945 оны мафиудын хоорондын дайн эхэлвээ.

АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ

Их эцэг бур арван хоёр настайдаа жинхэнэ эрийн цээнд хүрчээ. Гаднаас харахад бор царайтай, намхан нуруутай хариугүй танхилхан юм шиг байвч үнэн хэрэгтээ хамаг биеэр нь булчин шөрмөс зангирсан, сүрхий чийрэг залуу байлаа. Тэгэхэд тэрээр Испанийн өмнөд хязгаарын Мавритани сууринг санагдуулам Сицилийн Корлеоне хэмээх жижигхэн тосгонд аж төрж байсан бөгөөд хожим энэ нэрээр овоглох болжээ.

Тэр үед тосгоныхон түүнийг Вито Андолини гэж дууддаг байсан боловч нэг удаа хар элэгтэй хүмүүс аавыг нь алаад, хүүгийн нь хоолойг огтлохоор улайран дайрсан учир ээж нь түүнийг талийгаач нөхрийнхөө анд найз нар байдаг алс холын Америк руу явуулахад хүрсэн байна. Харийн нутагт ирээд тэрбээр Корлеонегоор овоглон, ингэснээрээ төрөлх сицили нутагтаа үнэнч сэтгэлээ өвөрмөц байдлаар илэрхийлжээ. Гэхдээ Вито өөдрөг үзэл, сайн санаагаа хүнд мэдэгдэх дургүй тул түүний амьдралд иймэрхүү тохиолдол хуруу дарам цөөн гарсан ажгуу.

Хоёр зууны зааг дээр Сицилийн мафи засгийн газрын аппараттай нягт сүлбэлдэж төрийн бараг бүх хэргийг эрхлэн шийдвэрлэж байлаа. Эцэс төгсгөлгүй сөргөлдөөн, тэмцэлдээнээс хол хөндий байна гэдэг тун бэрх. Витогийн эцэг шиг зориг шулуудсан нэг нь бие даасан байдлаа хамгаалахыг оролдмогц л хөршүүд нь мафиас дэмжлэг горилж тэд нь дуулгаваргүй этгээдийг дор нь номхруулдаг байв. Витогийн эцэг хүлцэн тэвчихийг хүссэнгүй. Орон нутгийн мафийн удирдагчдын нэгийг халз тулалдаанд нухчихсан тул мафийнхан тэр дороо л өшөөгөө авч, ердөө л долоо хоногийн дараа тэсрэх сумаар сийчүүлсэн түүний цогцсыг олсон байна. Аз болоход Вито юу юугүй өсч өндийгөөд эцгийнхээ цусан өшөөг авахаа амьдралын гол зорилго болгоно гэдгийг хожуу ухаарч бүр сар гаруй болсон хойно түүнийг нэхэж иржээ. Гэвч Витогийн төрөл төрөгсөд үүнийг түрүүлж ойлгоод арван хоёр настай хүүг хол газар нууж хөлөг онгоцоор алс холын үл мэдэх Америк руу явуулсан ажээ. Оргодол хүүг эхнэр, нөхөр Аббандандо гэртээ хоргодуулж, хожим тэдний нэг хүү Женко Аббандандо агуу хүчирхэг Корлеонегийн гэр бүлийн ойрын зөвлөх нь болсон юм.

Вито Нью-Йоркийн тамын орон гэхээс өөрөөр хэлдэггүй гудамж дахь Аббандандогийн ногооны мухлагт хөдөлмөрийн гараагаа эхлэв. Тэрбээр арван наймтайдаа Сицилээс дөнгөж саяхан ирсэн итали бүсгүйтэй гэрлэсэн бөгөөд тэр нь ердөө л арван зургаан настай авч хар нялхаасаа хоол хийж, гэрийн ажлаа эрхэлж сурчээ. Эхнэр нөхөр хоёр Витогийн ажлын дэргэд шахуу Есдүгээр гудамжинд нэг байр хөлсөлж авсан нь гучин тавдугаар гудамжнаас тийм ч холгүй юмсанж. Хоёр жилийн дараа Бурхан тэнгэрийн ивээлээр тэр хоёрт хүү заяаж Сантино гэж нэрлэсэн агаад жаал хүү аавыгаа хэзээ ямагт сүүдэр мэт дагах тул хавь ойрынхон нь Сонни—«хүү» хэмээн дуудах болов.

Мөн тэр хороололд зэрлэг догшин царайтай, тэндхийнхнээс эрс ялгарах ганган дэгжин хувцастай, цайвар бүрх малгай өмсдөг, ханхар цээжтэй тагдгар нэгэн эр суудаг байсныг Фануччи гэнэ. Тэрээр мафийнхны нэрийг барьж тэр хавийн мухлагийн эзэд, жижиг гар урчуудаас өргөл барьц хурааж авдаг ажилтай тул хүмүүс түүнийг нүднээс далдуур бол «хар гар» гэцгээнэ. Өргөл барьцыг айлган сүрдүүлж авдаг боловч тэр хорооллуудад идэр хавархаг хүмүүс суух тул өөрийг нь хамгаалах хүүгүй хижээл хүмүүс л Фануччигийн заналаас айх

бөлгөө. Гэхдээ бас ч гэж дандаа айн түгшиж сууснаас хэд гурван юм төлчихсөн нь дээр гэж бодох хүмүүс бишгүй.

Фануччи гол төлөв итали сугалааны тасалбар сэм наймаалдаг юм уу, гэртээ мөрийтэй тоглуулдаг хувийн оромжийн эзэд гэх мэтийн хууль зөрчигч хүмүүстэй сүлбэлдэнэ.

Аббандандогийн ногооны мухлаг ч гэсэн «хар гарын» халаасанд багавтар өглөг байнга шургуулдаг ажээ. Женко аль эртнээс үүнийг эсэргүүцэн Фануччиг хөөгөөд явуулна гэж занах боловч эцэг нь мафийнхантай зууралдахыг түүнд чандаас чанд хориглосон байна. Вито Корлеоне эл бүхнийг мэдэж байсан боловч хөндлөнгийн хүний нүдээр харж ер тоодоггүй байв.

Нэг удаа Фануччиг сайн хашраасан байна. Гурван залуу түүнийг гэнэдүүлэн барьж аваад эрүү хоолойг нь чихэнд нь хүртэл гүехэн ч гэсэн сайн хэрчиж өгчээ. Тэд хөрш эрийгээ алах бодолгүй, зөвхөн айлгах л гэсэн бололтой. Витогийн харсаар байтал Фануччи саарал бүрхээрээ эрүүгээ даран тэр гурваас зугтаахад хүзүүнийх нь шархнаас сад тавьсан цусанд малгай нь нэвт норж хүрэн улаан юм болжээ. Олон жил өнгөрсөн хойно ч гэсэн үнэтэй костюм дээрээ цус дусаачих вий гэсэн юм уу, доромжлол гутамшгаа хүнд үзүүлэхгүй гэсэндээ ч юм уу, эрүүгээ малгайгаар дарж цусандаа хутгалдсан Фануччигийн аймаар дүр Витогийн нүдэнд үзэгдэж санаа зовоодог байжээ.

Энэ хэрэг явдал түүнд эргэлтийн үе болсон байна. Фануччид халдсан залуус ердөө ч танхай алуурчид биш, зүгээр л «хар гарын» занал, хураамжид тээршээж гүйцээд мафиозийг нэг сайн залхаах гэсэн байж л дээ. Харин Фануччи бол ёстой дүүрчихсэн зандалчин болохоор нөгөө гурвын хутга барьж дайрсан нэг нь удалгүй суманд өртөж, үнхэлцгээ хагартал айсан нөгөө хоёрынх нь эцэг эх ирж нулимс бөмбөрүүлэн, өвдөг сөхөрч гуйгаад асар их мөнгө өгсөн тул тэрээр нөгөө хоёрт гар хүрсэнгүй. Тийм болохоор Фануччи сохорсон боловч завшив гэгчээр тэр халдлагаас бүр ч их ашиг олж хураамжийн хэмжээ зүйрлэшгүй өссөнөөс гадна нууц бизнест хувь оролцох болсон байна.

Гэвч Вито Корлеонед энэ бүхэн урьдын адил хамаагүй, түүнийг тойрч өнгөрсөн хэвээр л...

Дэлхийн нэгдүгээр дайны үеэр Аббандандогийн худалдаа буурах тийшээгээ хандаж, чидун жимсний хангалт хомсдоод байтал гэнэт Фануччи түүний түнш болж, түүнийг зөвхөн гадаадын тосоор төдийгүй салями, бяслаг, гахайн давсалсан мах зэрэг европын бусад бараа бүтээгдэхүүнээр хангах болов. Одоо хэрэг явдлын хуй салхи Вито Корлеонег шууд дайрч, Фануччи өөрийн үеэл дүүгээ Аббандандогийн мухлагт оруулсан тул Вито ажилгүй хоцорчээ.

Тэр үеэр Вито дахин нэг хүү Фредерикотой болж, одоо дөрвөн хүн тэжээх хэрэгтэй болжээ. Тэрбээр илүү дутуу юм дуугардаггүй, дотроо бодолтой дороо суурьтай, тайван буурьтай эр болсон байв. Аббандандогийн хүү Женко хар багаасаа түүний хууль ёсны найзад тооцогдож байсан тул эцгийнх нь өөдгүй зан гаргасан талаар Женког зэмлэхдээ Вито гашуун үгээ хайрласангүй. Тэр хоёрын хоёулангийнх нь хувьд огт санамсаргүй яриа болж, Женко гэнэт чавга шиг улайгаад, нэгэнт ийм юм болсон хойно өөрөө аавынхаа мухлагаас хоол хүнс зөөж андыгаа юугаар ч гачигдуулахгүй хэмээн андгайлсан боловч төрсөн эцгээсээ хулгайлах хамгийн ичгүүртэй хэрэг гэж үзээд Вито эрс татгалзсан байна.

Витогийн гомдох, үзэн ядах сэтгэл адгийн муу шаар Фануччигийн эсрэг шөвгөрч, үнийгээ гадна талдаа юугаар ч илэрхийлээгүй боловч тэсвэр тэвчээр нь талаар өнгөрөхгүй гэж найдсаар явлаа. Эхлээд тэр төмөр замд орсон чинь удалгүй дайн дуусч ажиллах хүчин элбэгшсэн тул түр ажил хийж амь зогоохоос өөр аргагүй болов. Гол төлөв Нэгдсэн улс, ирландын ууган иргэд болох мастер, бригадын дарга нар хөлсний ажилчдыг өөрсдийнхөө санаанд л орсон үгийн муугаар хараахад Вито жаахан итали аялгатай л болохоос англиар сайн ярьдаг хэдий ч хараалын нэг ч үгийг нь ойлгохгүй байгаа юм шиг чулуун царай гарган зогсдог байв.

Нэгэн орой Вито эхнэр, хүүхдийнхээ хамт хоолоо идэж суутал цонх тогшжээ. Тэрээр хөшиг яран худаг шиг давчуухан хашаа руу шагайвал эсрэг байшинд суудаг Питер Клеменца цонхоороо цээжээ цухуйлган цагаан даавуунд боодолтой юм сарвайж байхыг хараад нэн их гайхжээ.

- Хөөе, нутгийн ханагар минь, бушуухан үүнийг нууж тус болооч. Би дараа чамаас авья.

Вито хар зөнгөөрөө цонхоор тонгойн гар сунгаж, боодолтой юмыг нь авлаа. Клеменца нэг л базаахгүй юм болсон янзтай их сандарч тэвдсэн харагдах тул хөршдөө тусалмаар санагджээ. Вито галын өрөөнд ганцаараа үлдсэн хойноо боодолтой зүйлийг сониучирхан задалбал машины тосонд будагдсан таван автомат гар буу байсанд хувцасныхаа шүүгээнд нуугаад юу болохыг чих тавин хүлээв. Хөршийг нь тэр өдөр барьж аваад явсныг сонсоод Клеменцагийн хаалгыг цагдаа нар балбаж байх үеэр боодолтой юм өөрт нь сарвайсныг Вито дор нь ойлгожээ. Энэ тухай Вито хэнд ч ам ангайгаагүй бөгөөд үхтлээ айсан эхнэр нь залуу Клеменцаг барьсан шиг нөхрийг нь аваад явчихна гэж бодоод найз бүсгүйчүүлдээ ч хэлж зүрхэлсэнгүй.

Гэтэл хоёр хоноод л Питер Клеменца гэртээ ирж, Витогоос:

- Миний юм бүрэн бүтэн байгаа биз? - гэж далимд асуухад Вито илүү дутуу юм ярих дургүй, угийн дуу цөөнтэй тул дуугүй л толгойгоо дохисон байна.

Клеменца Витогийн араас даган тэднийд орж, дарсаар дайлуулан Вито тэр хооронд хувцасныхаа шүүгээнээс нуусан зүйлээ гаргаж ирлээ. Клеменца дарс балгаж. амарлингуй инээмсэглэн түүний хөдлөх бүрийг анхааралтай ажиглаж байснаа: «Дотор нь юу байгааг мэдэх үү?» гэж асуужээ.

Вито хайнгадуухан толгой сэгсрэв.

- Би хүний юм онгичих. бусдын хэрэгт хөндлөнгөөс оролцох дургүй хүн.

Үүний дараа тэр хоёр шилтэй дарс тавин өөд өөдөөсөө харан удтал сууж, шөнө дөл болоход энэ нь хэн хэнд нь таалагдаж буйг мэдэрчээ. Клеменца хачин сонин зүйл олныг мэддэг, уран гоё ярьдаг, харин Вито анхааралтай сонсож чаддаг болохоор ийнхүү санаа нийлсэн биз.

Хэдэн хоногийн дараа Клеменца тэднийд дахин ирж, зочдын өрөөнд нь том хивс авчирч тавибал ямар санагдахыг Витогийн эхнэрээс асуусанд тэрээр: «Их сайхан санагдана» гээд

хөгжилтэй инээжээ. Гэвч Питер огтхон ч тоглосонгүй, хивс дамжлалцаад ирээч гэж Витоогоос гуйсан байна.

Тэр хоёр нэгэн том байшингийн гантиг шатаар өгсөж, Клеменца өөрийн түлхүүрээр онгойлгон зөөлөн мебель тавилгатай хээнцэр сууцанд ороод:

- Тэр өнцгөөс нь барь - хэмээн тушаав.

Тэр хивсийг цэвэр ноосоор нэхэж, улаан хээ угалзаар чимсэн байх тул Вито Корлеоне найзынхаа өглөгч занг гайхсаар түүний хамт арай гэж хуйлсан хивсээ үүд рүү дааж ядан чирэв. Гэтэл гэнэт хаалганы хонх жингэнэсэнд Клеменца тун хачирхалтай аашлан хивсээ хаяж орхиод цонхонд харайн хүрч хөшиг жаахан яран гадагш сэм харснаа гэдрэг огло үсэрч гар буугаа шүүрэн авлаа. Ингэхээр нь л Клеменцагийн бэлэглэх гээд байсан хивс нь хүнийх, хүнийх ч гэж дээ, тэр хоёр аваад гарч чадвал хулгайн юм байна гэдгийг Вито сая ухаарав.

Вито ч гэсэн цонх руу очиж, хөшиг сэм яран шагайвал үүдэнд зогсож байсан цагдаа дахин хоёр гурван удаа хонх дараад дүрэмт хувцастай ханхар мөрөө хавчсанаа гантиг шатаар буугаад цааш оджээ.

Клеменца сэтгэл хангалуун нуруу тэнийлгээд буугаа далд хийж:

- Бид ч гэсэн хөглөө - гээд хивсний нэг захаас барив. Вито нөгөө үзүүрээс нь мөрлөн тэр хоёр хаалгаар зузаан хуйлсан хивс арай гэж багтаан гарахад цагдаа эр дөнгөж булан тойрч явлаа.

Хагас цагийн дараа тэр хивсийг хайчилж, Вито Корлеонегийн зөвхөн зочдын өрөөнд төдийгүй, бас унтлагын өрөөнд дэвссэн байв. Хивс хайчилж тааруулахдаа Клеменцагийн гар хуруу тун эвлэг хөдлөхөөс гадна хэлхэгэр пиджакных нь халаасанд хэрэгтэй бүх багаж байсан аж. Тэр тийм бүдүүн байгаагүй ч гэсэн бүр залуугаасаа халхайн унжсан уужим хувцас өмсөх дуртай юмсанжээ.

Гэхдээ хэдий гоё ч гэсэн ганц хивсээр гэр бүлээ тэжээх аргагүй. Өдөр хоног жам ёсоороо ээлжлэн өнгөрсөөр, байнгын ажил бас л олдсонгүй удлаа. Вито Корлеоне яахаа бүр мэдэхээ байгаад хэд хэдэн удаа Женкогоос үнэ төлбөргүй хоол хүнс авч хэрэглэхээс сөр аргагүйд хүрэв.

Эцсийн эцэст Клеменца өөр нэг яахаас ч буцахгүй хөрш Тессиогийн хамт Вито дээр ирж, тэдэнтэй хамсаж нийлэхийг санал болгосонд хэдийгээр эрүүгийн хуулиар шийтгэгдэх хэрэг хийж, сүлжмэл бараатай ачааны машин хулгайлах ёстой байсан боловч зөвшөөрөхөөс өөр зам түүнд байсангүй. Клеменца, Тессио хоёрт Витогийн тайван, хэнэггүй, тэвчээртэй зан үлэмж таалагдаж, бас түүний гэр бүл хэрхэн гачигдаж байгааг сайн мэдэх учир түүн дээр ирсэн байна.

Тэднийхээс холгүй, Гучин хоёрдугаар гудамж дахь фабрик дээрээс ачааны машинаар бараа зөөдөг, жолооч нар нь хулчгар, зүрх муутай, дөнгөж гар бууны ам харуулмагц орилж хашгирах юм уу, эсэргүүцэх өчүүхэн ч оролдлого хийлгүй дорхноо л зугтааж алга болдог, ёстой л ивээлийн тэнгэр гэлтэй хүмүүс байв. Тийм учраас сайн эрс ер санаа зовох юмгүй машиныг

хулгайлан эмэгтэй хүний торгон хувцас хунартай боодлуудыг буулгаж, найзынхаа пинд нуудаг байлаа. Харин түүнийг борлуулахад л тун хэцүү. Барааны хагасыг тэндхийн нэг жижигхэн дэлгүүрийн эзэн итали эр худалдан авч, үлдсэнийг нь тэд өөрснөө Артурын гудамж, Бронкс дахь италийн ядуучуудын дүүрэгт болон Манхаттан дэх Челсийн хороололд зардаг байсан тул итали цагаачдын охидууд амьдралдаа ч өмсөж үзэх тавилангүй гэж болохоор гоё хувцас хунараа тун хямдхан худалдаж авдаг байсныг хэлэх юун.

Вито урьд Аббандандогийн мухлагт ажиллаж байхдаа машин гарамгай барьж сураад 1919 онд сайн жолооч нэн ховор байсны учир Клеменца, Тессио хоёрт тун хэрэгтэй болжээ. Вито хоолой дээрээ хутга тавиад хэрэггүй гэдгийг оюун бодлоороо ухаарч байсан хэдий ч тэдний саналыг ямар ч гэсэн хүлээж авлаа. Хэрэгт оролцох болгондоо мянган доллар авах сүүлчийн шалтаг бусдаа илүү нөлөөлсөн байх л даа.

Гэвч түүний бодлоор боломжийн залуус үгсэн нэгдэж амарлингуй боловч азын тэнгэртэй Клеменца, буурь суурьтай зожиг зантай Тессио хоёрын хэн хэнд нь итгэж болох хэдий ч энэ ажлыг ямар муу, дутуу дулимаг бодож боловсруулсан, олсон олзоо хэрхэн хайнга, яаран сандран үрэн таран хийж байгааг хараад тэрээр гайхсан гэж жигтэйхэн.

Эхний дайралт ямар ч эндэгдэлгүй зүв зүгээр өнгөрчээ. Хамсаатнууд нь гар буугаа тулган жолоочийг бүхээгнээс нь хөөж гаргахад Вито юу ч болоогүй юм шиг тайван харж байснаа өөрөө ч гайхаад барсангүй. Анд нар нь ч хэнэггүй царайлан ер сандарч тэвдэхгүй түүнд бас л гүн сэтгэгдэл төрүүлэв. Тэр ч бүү хэл хоёр найз нь жолоочийг томоотой байвал эхнэрт чинь дэгжин палааж бэлэглэнэ гэж хошигнох боловч харин жолооч л юун марзганахтай мантай.

Вито өөрт оногдсон бараагаа ганц нэгээр биш, бөөнөөр нь долоон зуун доллароор зарсан нь 1919 оны ханшаар бол тийм ч бага гэхээргүй мөнгө байлаа.

Маргааш өдөр нь Вито хэзээний л бор улаан костюм өмсөж, саарал бүрх духдуулсан Фануччитай гудамжинд тааралдав. Угийн зэрлэг догшин харцтай тэр эр одоо хэн хүний нүд дальдрам хоёр чихээ холбон зурайсан аймаар сорвитой болсон тул үнэтэй сайхан хувцас өмссөн хэдий ч үзэсгэлэнтэй харагдаж эс чадмой. Гэхдээ өнөөдөр Фануччи аль байдгаараа эелдэг инээмсэглэхийг хичээн өтгөн хар хөмсөг доогуур доогтой нүдээ гялалзуулж, зориуд сицили аялгатай англи хэлээр Витотой ярьж эхэлсэн нь:

- Ноёнтон минь, чи хоёр найзынхаа хамт хоромхон зуур хосгүй баяжсан гэж хүмүүсийн хэлдэг үнэн үү? Тийм бол намайг мартдаг чинь тусгүй л байна даа. Энэ чинь миний дүүрэг, миний гудамж болохоор олзноосоо надтай хуваалцах л байсан юм - хэмээн Фануччи сүүлийн таван үгийг италиар, тэгэхдээ мафийнхан хэрэглэж заншсан «миний уруулыг тосдох» гэсэн утгаар хэлжээ. Гэвч Фануччи өргөл барьц шаардаад байгаа нь орчуулгатай орчуулгагүй ойлгомжтой байв.

Вито Корлеоне дадсан зангаараа үг дуугарсангүй. Фануччигийн юу гэх гээд байгааг цаана нь гартал ухварласан хэдий ч бүр тодорхой хэлэхийг нь хүлээн зогсов.

Фануччи ам дүүрэн алтан шүдээ гялалзуулж, шарх сорвиныхоо ягаавтар арьсыг татвалзуулан дарвайтлаа инээмсэглэж байснаа нусны алчуураа гаргаж духныхаа хөлсийг арчих ялдамд

бүсэндээ хавчуулсан гар буугаа гайхуулсан боловч Вито урьдын адил ам нээсэнгүй тул сайхь эр санаа алдав.

- Таван зуун доллар л шидчихвэл би та нарын эелдэг бус занг мартчих байх гэж бодох юм. Одоогийн залуус та нарыг муу хүмүүжүүлж, над мэтийн хүмүүст яаж хүндэтгэл үзүүлэх ёстойг зааж өгөөгүй юм байна.

Вито Корлеоне үүний хариуд бас л жуумалзаж, харин одоохондоо гараа хэний ч цусаар будаагүй эл залуу эрийн инээмсэглэлд нэг л аюул осол нуугдан буйг Фануччи хар зөнгөөрөө мэдэрч арай эвлэрэнгүй үгүүлрүүн:

- Чам шиг эхнэр хүүхэдтэй хүнд илүү мөнгө дэмий, гай авчирна. Цагдаа нар ч юм уу, эсвэл тэднээс долоон дор зочид гэрт чинь дайрч орвол яана? Магадгүй, хүмүүс худлаа цуурсан юм биш биз? Тэгвэл ч би уруулаа жаахан тосдоод л больё. Гэхдээ гурван зуугаас бага авч яасан ч чадахгүй. Харин надад шилний цаанаас чихэр долоолгоно гэж бүү горьдоорой.

Одоо Витогийн хариулах ээлж ирж, тэрбээр уурлаж бухимдалгүй, маш тайван, тэр ч бүү хэл насаар ах юм уу, нэг бол Фануччи мэтийн нөлөө ихтэй хүмүүсийг хүндэтгэх маягаар үгүүлсэн нь:

- Миний мөнгө найз нарт минь байгаа. Би тэдэнтэй л уулзаж байж больё.

Фануччи энэ заль мэхийг нь чихэр хүлхэх мэт үмхэж орхив.

—Тэр бололгүй яах вэ? Найз нартаа ч гэсэн уруул тосдох ёстойг дамжуулаарай. Клеменца бид хоёр бие биеэ сайн мэдэх болохоор тэрээр ямар учиртайг ер андахгүй. Тэр чамаас илүү туршлагатай, ийм тохиолдолд яах ёстойг чи түүнээс сайн сурч авбал хойшдоо аминд чинь өлзийтэй шүү!

Вито Корлеоне энэ үгийг дуулаад их ичиж зовсноо бүх байдлаараа илтгэн харуулахыг мэрийлээ.

- Тэгэлгүй яах вэ?! Би шинэ хүн болохоор үүнийг мэдсэнгүй, харин жинхэнэ Загалмайлан эцэг шиг зааж сургамжилсан танд гялайлаа.

Фануччи Витогийн эл үгэнд бүр уярч хайлах дөхөөд гараас нь барьж чанга атгав.

- Чи хүн хүндэтгэдэг сайн залуу байна. Биеэ зөв авч явах гэдэг залуу хүнд юу юунаас чухал. Хэрэв чи хэд гурван юм ольё гэж бодвол надтай зөвлөж болно шүү. Би чамайг муу юманд сургахгүй харин тус болж юу магад. Ойлгов уу?

Вито Корлеоне гагцхүү олон жилийн дараа л Фануччитай харалцсан байдлаа цэгнэж үзээд чухам юуны учир биеэ барьж, бялангач зан гаргаснаа ойлгожээ. Зүгээр л мафийн эсрэг илэрхий тэмцэн босч ямар ч утга учиргүй амиа алдсан эцгийнх нь дүр ой ухаанд хадагдан үлдээд, харин хүүд нь уур хилэнгийн зэрэгцээгээр хянуур болгоомжтой зан удамшин үлдсэн юм байж. Тэрээр дуртай ч, дургүй ч энэ ажилд оролцохоор зориглон амь нас, эрх

чөлөөгөөрөө дэнчин тавьхаад байхад Фануччи дээрэмдэх гэж байгааг ойлгоод Вито дэлбэртлээ уурласан ч үгүй, үхтлээ айсан ч үгүй. Эсвэл энэ Фануччи солирсон амьтан юм болов уу? Витогийн л мэдэж байгаагаар түүний найз Клеменца өөрийн хөлс хүчээр олсон мөнгөнөөсөө ядахдаа ганц цент ч гэсэн Фануччид тоолж өгсөн дор бол гэдсээ хүү татуулсан нь дээр гэх хүнсэн. Витогийн хамт хулгайлах гэж байсан хивснээс болоод Клеменца ямар ч гэмгүй нэг цагдааг золтой л тонилгочхоогүйг Вито өөрөө харсан шүү дээ. Бас хэнэггүй хүйтэн харилцаатай Тессио энэ үе нь гуужиж, арьс нь үрчийсэн Фануччиг бодвол алуурчны дүрд хамаагүй илүү тохирох хүн.

Гэвч тэр оройдоо Клеменцагийн гэрт гурвуулаа цуглаад Вито Корлеоне бас нэг сургамжийн зүйлийг мэдэж авлаа. Клеменца үгийн муугаар хараал урсгаж Тессио баргар царайлан «Балиар шаар» гэж бувгнасан боловч хоёулаа Фануччигийн шаардлагад их буурьтай хандав.

Фануччи хун болгоноос хоёр зууг аваад ханаж цадах эсэхийг хэлэлцэж. Тессио тун магадгүй гэсэнд Клеменца эргэлзэж байгаагаа нуусангүй.

- Энэ яасан ч бүтэхгүй, тэр адгийн новш бидний хэд хичнээн мөнгө авсныг дамын наймаачнаас аль хэдийн олоод мэдчихсэн гэж бөндгөрөөрөө дэнчин тавихад ч бэлэн байна. Өөрийнхөөрөө зүтгээд ганц доллар ч нааш нь татахгүй. Гурав гурван зуун долларыг өгч л салахаас өөр ямар ч арга алга даа.

Вито хоёр андыгаа гайхсан нүдээр ээлжлэн харж, өөрийн бодлоо ил гаргаж хэлэхгүй нь дээр гэж болгоомжилсон хэрнээ тэссэнгүй асуусан нь:

- Тэр ганцаараа, бид гурвуулаа, бас зэвсэгтэй юм чинь яаж биднийг албадан мөнгө салгаж чадах юм бэ? Тэгээд ч бидний хөлсөө асгаж олсон мөнгө уруу гар сарвайх ямар эрхтэй хүн бэ?

Клеменца маш их тэвчээр гарган Витод хэргийн бүх учрыг тайлбарлаж өгөв.

- Фануччи уяаны нохой шиг үнэнч найз нартай, бас цагдаа нарын ам тосддог болохоор манай дүүргийг бүхэлд нь атгаж байгаа юм. Өөртэйгөө зөвлөхийг чамд санал болгосон гэдэг чинь бидний төлөвлөгөөг урьдчилж мэдэх гэсэн хэрэг шүү дээ. Тэгээд дараа нь өөрийн дураар шийдэж, биднийг дуулгавартай байвал нээрээ тусалж ч мэднэ, эсвэл цагдаа нарт бариад өгчихнө. Тэгвэл цаадуул нь түүнд бүр ч их өртэй болно биз дээ. Дутуу хэрчүүлсэн тэр хулхи бүх юмыг сайтар тооцоолсон. Энэ дүүргийг эзэгнэх эрхийн бичгийг Маранцалла өөрийн биеэр өгсөн гэлцэх юм билээ.

Хамгийн том намуудын нэгний толгойлогч Маранцаллагийн нэр сонины хуудаснаас салдаггүй тул хүн болгон андахгүй. Хэрэв сонины сурвалжлагч нар худлаа бичээгүй бол тэр эр мөрийтэй тоглоом, зэвсэгт дээрмээр мэргэшсэн гэнэ.

Вито Корлеоне хоёр андынхаа хамт гэрийн дарс балган суухдаа уураг тархиа урьд урьдахаас илүү ажиллуулж, оюун бодол нь маш эмх цэгцтэй тодорхой урган хөврөхөд нь өөрөө хүртэл гайхаж байв. Мафиозийн хоолойг хэрчсэн жаал бандийг буудаж алсан, нөгөө залуусынх нь эцэг эх их мөнгө төлж байж хоёр яс салсан тухай Фануччигийн тухай мэдэх болгоноо тэрээр

эргэн дурслаа. Яагаад ч юм, Фануччигийн үйлчлэл, нөлөөний хүрээ шалихгүй, гангстерын ертөнцтэй дорвитой холбоо байхгүй юм шиг Витод санагдаад ер болж өгсөнгүй.

Маранцаллагийн намыг түшиж тулсан тийм сүрхий хүн цагдаагийн газарт матах юм уу, эсвэл өшөө авах эрхээ өрөөл бусдад худалдаж нэрээ бузарлах гэж байх уу? Арай ч тэгж хөгөө хөлдөө чирэхгүй байлгүй! Нэрээ боддог нэг ч дээрэмчин өөрийгөө доромжилсон хүнийг өршөөж амьд үлдээнэ гэж яасан ч байхгүй. Тэгэхлээр Фануччигийн аз таарсан тулдаа л тэр гурвын нэгийг буудаж хөнөөгөөд, нөгөө хоёрыг нь дийлэхгүйгээ мэдээд эрүүл мэнд, эрэмдэг зэрэмдэгээ мөнгөөр худалдсан байх нь! Бас тэгээд сайхь эр эндхийн мухлагийн эзэд, луйварчин дээрэмчдийг айлган сүрдүүлж, зодож нүдэж байж л өглөг барьц авдгаас биш, араас нь баталгаажуулсан олигтой хүчин юу ч үгүй юм байна. Ямар ч гэсэн нэгэн мөрийтэй тоглоомын эзэн Фануччид нэг ч цент төлөөгүй атал одоо хүртэл яагаа ч үгүй явааг Вито тодорхой сайн мэдэх бөлгөө.

Энэ бүхнээс дүгнэж үзэхэд Фануччи бол шаардлагатай үедээ боломжийн үнээр зэвсэгт дээрэмчдийг түр хөлсөлж бэлэн мөнгөөр тооцоо хийдэг гон бие луйварчин болж таарлаа. Тийм учраас одоо Фануччигийн хувийн байдлын тухай биш, өөрийнхөө хувь заяаны талаар санаа гавих хэрэгтэй болов. Одоо түүний амьдрал, тавилан нь салаа замын уулзвар дээр ирээд байгааг Вито сайн ойлгов. Хаашаа эргэх нь зөв бэ?

Хожим Их эцэг хүн болгон өөрийн гэсэн төөрөгтэй, зөвхөн түүнийгээ л цаг тухайд нь таньж мэдэх хэрэгтэй, тийнхүү сонгож авах мөч ч зайлшгүй ирдэг гэж ойр дотнын хүмүүстээ нэг бус удаа ярьж билээ. Яг тэр эгзэгтэй үед Вито Корлеоне яавал ч яаг гээд бүхнийг орхиж Фануччид шаардсан мөнгийг нь атгуулан хэсэг хугацааны дараа ногооны юм уу, хүнсний мухлагийн худалдагчийн ажил олж хийгээд явж болох л байсан. Дараа нь нас хэвийсэн үедээ өөрийн дэлгүүртэй болох нь гарцаагүй аж. Гэвч заяа тавилан нь өөрөөр шийдэж, Фануччитай учруулаад түүнээс хойш энгийн бус, ээдрээтэй замыг сонгон авч Их эцэг болохоор заяа төөрөг нь тэгж заасан юм байж.

Тэд морин шилтэй дарсаа ууж дууссан хойно Вито Корлеоне үгээ тун сайтар цэгнэн байж анд нартайгаа санал бодлоо хуваалцав.

- Та нар хоёр, хоёр зууг өгчих. би өөрөө түүнийг чинь Фануччид гардуулья. Түүнийг аваад тэрбээр тайвширна гэдгийг би батлан даая. Ер нь үүнээс хойш энэ асуудлыг надад даалга. Би эхийг нь эцээхгүй, тугалыг нь тураахгүй зохицуулж чадна.

Клеменцагийн нүдэнд үл итгэсэн харц гялсхийхийг Вито ажиглаж амжаад хөндий хүйтэн инээмсэглэлээр хариу барилаа.

- Өөрийнхөө анд найз нарыг гэж үздэг хүмүүст худлаа хэлдэг хүн би биш шүү. Маргааш чи өөрөө Фануччитай яриад чамаас хэдийг шаардахыг нь өөрөө сонс л доо. Харин чи юуны түрүүнд түрийвчээ л бүү гаргаарай гэж зөвлөө. Бас зөрж эсэргүүцээд ер хэрэггүй шүү. Мөнгө олох хэрэгтэй, олсон хойноо надаар өгүүлнэ гэж хэл. Түүнтэй наймаацалдаж хэрхэвч болохгүй, та нарыг болзлыг нь хүлээн авсан юм байна гэж бодог. Тэрбээр та нарын бодож байгаа шиг тийм аюултай юм бол бодож санаснаа яагаа ч үгүй байхад түүнд мэдүүлж, зэвүүг нь хүргээд яах вэ?

Эцсийн эцэст тэд яг ингэж л шийдсэн байна.

Клеменца дараа өдөр нь Фануччитай уулзаж ярилцаад Витогийн түмэн зөв болохыг ойлгожээ. Тэрээр хоёр зуун доллароо Витогийн гэрт авчирч өгөөд найзынхаа нүүр рүү цоо ширтэн:

- Фануччи биднээс бага мөнгө аваад сална гэж чи яаж мэдээ вэ? Надад зөвшөөрөхгүй юм шиг санагдсан. Гурван зууг авахаас нааш санаа нь амрахгүй биз. Чи түүнийг аргандаа оруулахаар юу хийх гээд байна? - гэвээс Вито Корлеоне тун тайван хариу өгүүлрүүн:

Энэ бол цэвэр миний хувийн хэрэг. Харин чи миний өнөөдөр тус болсныг хойшид бүү мартаарай.

Нэлээд хожуу ирсэн Тессио Клеменцагаас арай дээр сэтгэж, тун болгоомжтой хандан, аюул мэдрэх талаараа хүнд баймааргүй гойд сэрэмжтэйгээ харуулав.

Тэр новшийг «хар гар» гэж нэрлэдэг нь хоосон үг биш шүү! Үнэг шиг зальтай хүн болохоор чи тун ч мэдээтэй байхгүй бол горьгүй. Чамайг уулзах хооронд би ойр хавьд байж хамгаалах уу?

Вито Корлеоне толгой сэгсэрч энэ үгэнд нь хариу ч хэлсэнгүй, зүгээр л түүнээс гуйсан нь

- Мөнгө надад байгаа, оройн есөн цагийн алдад хүрээд ир гэж чи Фануччид дамжуулж өгөөч? Бага мөнгө өгөөд хоёр тийшээ салахын тулд би түүнийг нам согтоох хэрэгтэй байна.

- Фануччи яасан ч зөвшөөрөхгүй. Чи дэмий юманд санаархах юм.

- Харан байж л больё. Би түүнийг ятгаж, ухааруулахыг л хичээе.

Аянга ниргэхийн өмнө агаар тэнгэр амсхийн нам гүм болдог шиг Их эцэг үхлийн цохилтын өмнөх эцсийн ятгалга учирлага болгон эл үгсээ хэрэглэдэг байсан нь хожим хүн болгон андахаа байжээ. Хэрэв Их эцэг эсрэг этгээдтэйгээ тун тайван ярьж, тэднийг ятган ухааруулж чадна гэж найдаж байгаагаа илэрхийлэх л юм бол хэлэлцэн тохирох хамгийн сүүлчийн боломж үлдлээ гэсэн үг бөгөөд дараачийн алхамд нь хутга мэс юм уу, буу хэрэглэдэг байлаа.

Вито, Тессиог гаргаж өгөөд эхнэрээ дуудаж, оройн хоолны дараа хүүхдүүдээ аваад гадагш гарч хашаан дотор суу, намайг дуудтал хэн ч орж ирж болохгүй гэж захиад, өөрөө Фануччитай тун чухал ажил ярилцана гэдгээ нэмж хэллээ.

Эхнэрийн царайд нь айдас тодрохыг ажаад Витогийн уур нь хүрсэн боловч бүр айлгачихгүйг хичээн ердийн тайван дуугаар:

- Шал мангуу амьтантай суучихлаа гэж чи бодоогүй биз? - хэмээн хэнэггүй асуутал эхнэр нь юу ч дуугарсангүй. Гэхдээ эхнэр нь одоо нөхрөөсөө биш, Фануччигаас айсандаа царай нь цонхийсон байлаа. Яг энэ эгшинд Витогийн төрх байдал харсаар байтал эрс хувирч хэний ч дотор хүйт оргимоор сүртэй, аймаар харагдана. Дандаа л бачимдаж давчидсан сициличүүдийн дунд тун ховор тохиолдох тайван, хэзээд үг дуу цөөнтэй, гэр бүлийн

амьдралдаа өр зөөлөнтэй Вито Корлеоне одоо өнгөлөн далдлах багаа хуулж хаяад хувь заяаныхаа ямар ч дуудлагыг угтан хариулахад бэлэн аюумшиггүй зоригтой эрс шийдэмгий эр болжээ Тэрээр хорин тав хүрсэн хойноо хожуухан эрийн цээнд хүрсэн боловч энэ янзаар бол адал явдлаар дүүрэн сонин амьдрал өмнө угтаа бололтой.

Учрыг сайтар тунгаан бодоод үзвэл Вито энэ Фануччиг замаасаа зайлуулах ёстой. Тэгвэл эл эрээ цээрээ алдсан эрийн авах гээд байгаа гурван зуу дээр хоёр андынх нь өгсөн дөрвөн зууг нэмээд долоон зуун доллар Витогийн халаасанд орно. Харин Фануччи амьд үлдвэл долоон зуун доллароо зүгээр л тавиад туучих хэрэг гарах билээ.

Хамгийн наад захын тооцоо ийм л байна.

Ер нь бол Фануччигийн амь долоон зуун доллар хүрнэ гэж Вито огт бодохгүй байв. Ямар ч л гэсэн үхлүүт өвчин туссан Фануччиг анагаах эмчид Вито өөрөө бол яасан ч долоон зуун доллар өгөхгүй дэг. Тэрээр Фануччид өр ч үгүй. Хамаатан садан нь ч биш, анд найз нь ч байгаагүй юм чинь хөндлөнгийн хүнд ийм их мөнгийг өөрийн гараар бэлэглэх гэж байх уу даа?

Эл бүхнээс ургуулан бодвол, нэгэнт Фануччи хүч хэрэглэн мөнгө салгах гээд байгаа бол тэр хүчийг өөрийнх нь эсрэг чиглүүлэх хэрэгтэй. Вито Фануччиг нухчихлаа гэхэд хорвоо ертөнц түүнтэй түүнгүй тэнхлэгээрээ эргэсээр л байх юм чинь, яав л гэж!

Мэдээжээр бүгдийг урьдаас сайтар тооцоолох нь чухал. Фануччи мафийнхны хэн нэгтэй нь холбоо сүлбээтэй, найз нь ч байхыг байг гэх газаргүй тул тэдний өшөө хонзонгоос сэрэмжлэх бүх аргыг хэрэглэх хэрэгтэй. Цагдаагийн газар, цахилгаан сандал зэргийг ч хэрэгсэхгүй байж хэрхэвч үл болно. Гэвч Вито Корлеоне ухаан орсон цагаасаа хойш биш юмаа гэхэд лав л эцгээ нас барсны дараагаас эхлэн үхлийн ирмэг дээгүүр дэнжгэнэж яваа билээ. Тэрээр арван хоёрхон настай хүүхэд байхдаа далай гатлан харь оронд хуурамч нэрээр бүгэн байж амь гарсан юм. Вито хөндлөнгийн ажиглагч болон өөрийн бодол санааг хэнд ч хэлдэггүй боловч бусдын хийсэн зүйлийг тунгаан бодоод арай өөрөөр хийх ёстойг ойлгон, тэднийг бодвол тэр өөрөө илүү ухаантай, эр зоригтой, тэсвэр тэвчээртэйгээ эрт ухаарчээ. Ганцхан одоо хүртэл Вито Корлеоне өөрийн онолын дүгнэлтээ практик амьдрал дээр сорин шалгах бололцоо олдоогүй л байгаа хэрэг.

Харин одоо л тийм боломж гарчээ. Шийдвэртэй алхам хийхээсээ тэр яагаад зүрхшээн эргэлзээд байгаа юм бэ? Вито ширээн дээр байсан долоон зуун долларыг нямбай эвхэн өмднийхөө зүүн халаасанд хийж, баруунд нь ачааны машин руу дайрахын өмнөхөн Клеменцагийн өгсөн гар бууг хийв.

Фануччи цаг нарийн барьдаг хүн бололтой яг есд ирлээ. Вито бас л Клеменцагаас авсан гэрийн дарсаар түүнийг дайлсанд Фануччи саарал бүрх малгайгаа авч, өргөн зангидсан эрээн зангиагаа суллаад ширээний ард тухлав. Зуны бүгчим үдэш цонхны цаана анивчих хийн дэнгийн гэрлийг ажиглан дарс шимж суух нэн таатай. Гэр дотор ялаа ниссэн ч дуулдахаар ажгуу. Вито зочиндоо элдэв муу юм бодуулахгүйн тулд Фануччигийн ам нээхийг хүлээсэн ч үгүй, өөрөө мөнгөө гаргаж сарвайсанд тэрээр нямбайлан тоолж том түрийвчинд хийгээд өвөртлөв.

Чамаас дахиад хоёр зууг авна шүү - хэмээн дарс балгах Фануччигийн өтгөн хөмсөгтэй зэрэмдэг болсон царай нь одог онгонтой тун төстэй харагдах ажээ.

Вито сицили хүмүүсийн уламжилж ирсэн ёс горимыг яг баримтлан тун эелдэг дуугаар хариу үгүүлрүүн:

- Би ажилгүй нилээд удаж, олон хүнд өртэй болсон тул мөнгийг чинь нэгмөсөн өгөхөд бэрх байна. Ядахдаа хоёр гурван долоо хоног хүлээзнэж үзээч. Хэрэв та дургүйцэхгүй бол тэр шүү дээ.

Ихэнх мөнгөө Фануччи авсан учраас үлдсэн хэсгийг нь түр хүлээж болохоор үл барам, хэрэв харилцан тохиролцвол дахиад хугацаа сунгах юм уу, эсвэл мөнгөний хэмжээг нааш татаж ч болдог тул Витогийн ийнхүү хэлсэнд гайхах юун.

Зочин эр чанга хөхрөөд аягатай дарснаас том балгаж хоолойгоо чийглэв.

- Чиний аманд ч хуруугаа хийлтгүй сүрхий эр юм аа! Урьд нь би чамайг яагаад анзаараагүй юм бол? Хэтэрхий томоотой болоод л ингэж цагаа дэмий үрж байгаа юм байна даа, чи! Хэрчим талхныхаа талаар санаа зовох юмгүй болгохын тулд чамд мөнгөтэй ажил олж өгөх хэрэгтэй болжээ.

Вито Корлеоне зочныхоо үгийг анхааралтай сонссон дүр үзүүлэн дарс дахин аягалсан боловч Фануччи уусангүй, босч малгайгаа өмсөөд Вито өөд гар сунгав.

- За баяртай, залуу минь.. надад муу юм бүү санаарай. Юмыг яаж мэдэхэв хэрэг гарвал надад дуулгана биз дээ. Чи өнөөдөр өөртөө тун ашигтай юм хийсэн шүү, харж л байгаарай.

Фануччигийн нүсэр алхаа шатан дээгүүр замхарч, түүнийг гадагш гарсан хойно Вито араас нь чимээгүй даган бууж харвал гудамжинд хар мянган хүн байв. Тэгэхлээр Фануччиг Корлеонегийн гэрээс эсэн мэнд зөв зүгээр гарсныг нотлоод өгөх гэрч хаа мундах вэ? Фануччи бушуухан харьж, олзны мөнгө, буу хоёроо орхих гэсэн янзтай Арван нэгдүгээр гудамжны зүг яаран алхаж явааг Вито орцны цонхоор харж зогссоноо шатаар харайлган гарч дээврийн хөндийн нүхээр дээш гарлаа. Элэг бөөрөөрөө нийлсэн зэргэлдээ байшингуудын дээвэр дээгүүр осолтой аялал хийсээр тэр хоосон агуулахын шатаар мухар гудамжинд бууж, арын хаалганы түгжээг мулт өшиглөөд гол хаалгаар гарав.

Түүний тооцоолсон нь тун зөв болж, Фануччигийн суудаг байшин яг өмнө нь харагдлаа. Энэ гудамжаар орон сууцны байшингууд баруун тийш Арав дугаар гудамж хүртэл эгнэн ярайж, харин Арван нэгдүгээр гудамжинд бараг Гудзон хүртэл бүхэлд нь төмөр замын тээвэртэй холбоо бүхий том том худалдааны пүүсийн агуулах байр зайгүй чихсэн тул, түүнийг тойрон ургасан зэрлэг өвс, бутас Фануччигийн байшинд тулсан харагдана. Энэ байшинд вагоны үйлчлэгч ганц бие эрчүүд, агуулахын ачигч нар, вокзал хавиар гөрөөлдөг эмс хүүхнүүд суудаг тул тэд орой үдшийн цагаар гэр бүлтэй итали хүмүүс хөршийнхөнтэйгөө далан үг дэлгэн гадаа суудаггүй, үнэ хямдтай гуанз мухлагт халаасаа гөвж цаг нөхцөөдөг аж.

Тийм учраас Витог нэг ч хүнгүй Арван нэгдүгээр гудамжаар хөндлөн гарч Фануччигийн

суудаг орцонд орохыг харсан хүн ганц ч үгүй. Тэрбээр тэнд орсон хойноо нэг ч удаа дуу гаргаж үзээгүй гар буугаа гарган Фануччиг хүлээн зогсохдоо орцны шилэн хаалгаар түүний гарч ирэх Аравдугаар гудамжнаас харцаа үл салгана. Тэр гар буугаар яаж буудахыг Клеменца түүнд гайгүй сайн зааж өгсөн юмсанж. Ер нь бол Вито бүр эцгийнхээ амьд сэрүүн байхад анх буу барьж, ааваараа заалган богинохон гол төмөртэй сицилийн буугаар тун ч ончтой буудаж сурсан нь мафийнхан хэтэрхий аюултай мэргэн буудагч өсч өндийх нь гэж айгаад түүнд алах ял оноох нэг гол шалтгаан болсон байна.

Фануччигийн цайвар дүрс гудамжны зүгээс өөр рүү нь сүүтгэнэж явааг харанхуй хонгилд бүгсэн Вито харж эсрэг хана тийш ухарч шатны хаалга ар нуруугаараа шахан зогсоод бууныхаа цохиурыг татав. Түүний урагш сунгасан гар гол хаалга хариугүй хүрэх шахна.

Хаалга цэлийтэл нээгдэн саарал костюмтай Фануччигийн нүсэр бие босгон дээр гарч ирмэгц Вито гох дарлаа. Буун дуу байшин дүүрэн нүргэлж, гадаа гудамжинд хүртэл хүчтэй цуурайтав.

Фануччи бүдрэн ганхсанаа өрөөсөн гараараа хаалганы жааз модноос зуурч, нөгөө гараа буугаа авахаар пиджак доогуураа шургуулахыг оролдон салганахдаа хамаг товчоо тасар татан хаяхад зөвхөн гар буу нь төдийгүй, бүснээс нь арай дээхэн талд ханхар цээжин дээрх цус нэвчсэн том толбо ил гарч харагдав. Вито нягтлан шагайгаад хурц зүү судсанд шаах мэт хоёрдахь сумыг түрүүчийнх нь араас илгээлээ.

Фануччи үүдний онгорхойд биеэрээ тээглэн өвдөг дээрээ сөхрөн унахдаа аймаар чанга ёолон хашгирахад Витогийн дотор арзасхийхийн зэрэгцээгээр яагаад ч юм тэвдэнгүй инээд алдаж орхив. Вито Корлеонег түүний хөлстэй цулцгар хацарт бууныхаа амыг нааж байгаад гуравдахь удаагаа гох дарах хүртэл Фануччи ёолсоор л байлаа. Зөвхөн үүний дараа л тэрбээр дахиж бие махбодын шаналгаа, сэтгэлийн зовлон эдлэхээ больж амьсгаа хураагаад хаалга таглан хөсөр ойчжээ.

Вито хянуур шалмаг хөдлөн түүний халааснаас зузаан түрийвчийг нь сугалан авч өвөртлөөд үхдэл дээгүүр алхан гарч гудамж хөндлөн гүйсээр түрүүчийн замаараа галын шат, арын хаалгаар дамжин дээвэр дээр хүрч эргэн тойрноо сайн харж авав.

Фануччигийн хүүр түүний орхисон газарт яг хэвээрээ хэвтэнэ. Хажуугийн байшингийн хоёр цонх онгойж хүмүүсийн царай бүрэлзэх боловч сайн харагдахгүй байсан тул тэд ч гэсэн Витог ялган харж чадахгүй, харлаа ч гэсэн танихгүй болж таарлаа. Эндэхийн оршин суугчид цагдаа нарт угийн дургүй тул танилаа ч гэсэн нэг нь ч хов мэдүүлэхгүй. Тийм учраас цагдаагийн эргүүл санамсаргүй дээр нь орчихдоггүй л юм бол Фануччигийн хүүр тэндээ үүр цайтал хэвгэх нь гарцаагүй. Хөршийнхөн нь ч гэсэн цагдаа нарын хардлага сэжгийг толгой дээрээ хураахаас зайлсхийн хаалга үүдээ янгинатал түгжиж аваад нүдэн балай чихэн дүлий сууцгаана. Одоо нэгэнт яарах юмгүй болсон учир Вито дээвэр дээгүүр болгоомжтой явсаар байшиндаа хүрч шатаар буугаад гэртээ орлоо. Хаалгаа түгжээд талийгаач Фануччигийн түрийвчийг уудалж үзвэл Витогийн өгсөн долоон зуун доллароос гадна нэг тавт, хэдэн нэгтийн дэвсгэртээс өөр юм алга, харин тусгай халаасанцарт таван долларын хуучин алтан зоос байсан нь Фануччи сахиусны оронд авч явсан эд бололтой. Тийм ээ, Фануччи үнэхээр баян дээрэмчин байсан бол лав л эд баялгаа биедээ авч явдаггүй байв. Ямар ч атугай энэ

бүхэн Вито Корлеонегийн таамаглалыг баталж байлаа.

Одоо түрийвч буу хоёроос нэн даруй ангижрах хэрэгтэй байсан тул Вито таван долларын алтан зоосыг буцааж түрийвчинд хийгээд (бүр тэр үед, хорин тавхан настайдаа тэрбээр яггүй ухаан сийлдэг байжээ) дахин дээшээ гарч дээвэр дамжин явсаар хоёр байшингийн завсраар Фануччигийн түрийвчийг хаяв. Дараа нь гар бууны хөндий хүрднээс бүх сумыг нь унаган авч гол төмрийг дээврийн нуруу модонд хар хүчээрээ дэлссэн боловч гараа гаргаж хийсэн тэр буу тийм ч амар хэмхрэх янзгүй. Вито буугаа атган чулуун янданг байдаг хүчээрээ балбаж байж дундуур нь цуулж, эцэст нь арай гэж гол төмөр, бариулыг хугалж усны хоолой руу нэг нэгээр нь салган чулуудсанд тэр хэмхэрхийнүүд усны хоолойгоор бүх таван давхрыг дамжин гулссаар хогон дээр. чив чимээгүй ойчив. Өнөө шөнөдөө дахиад дээрээс нь хог хаяж, аз таарвал өглөө гэхэд гар буу найдвартай далдлагдах биз.

Дахиад л түрүүчийнхээ замаар явж гэртээ ирээд хамаг бие нь салганан чичрэхийг мэдэрсэн Вито юмыг яаж мэдэх вэ, цус үсэрсэн байж болох хэмээн болгоомжилж, юуны түрүүн хувцсаа сольж, тайлсан бүхнээ сойз савангаар сайтар угаалаа. Тэр үнэхээр биеэ барьж самбаатай хөдөлж, угаадсаа асган түмпэнг хичээнгүйлэн зайлаад угаасан хувцсаа эхнэрийнхээ угаахаар зэхэж тавьсан хувцас хунартай хольж овоолов.

Тэрээр шинэ цамц сольж өмсөөд гадагш гарч, энэ бух хугацааны турш хашаан дотор тоглож буй хүүхдүүдээ хараад хөрш авгайчуултай хэл амаа билүүдэж суусан эхнэрийнхээ хажууд очиж суужээ.

Сүүлд нь мэдэхнээ, ингэж их болгоомжлохын хэрэг ч үгүй байсан юмсанж. Цагдаагийн газрынхан Фануччигийн хүүрийг олоод үүнтэй холбогдуулан Вито Корлеонег сонирхож ирсэн ч үгүй. Бодвол Фануччи алуулахынхаа өмнө тэднийд ирснийг цагдаа нар мэдээгүй өнгөрсөн биз. Гэтэл Вито өөрөө хэрэгт холбогдолгүйн баримтыг хичээн бэлтгэж, Фануччиг гараад явахад Вито гэртээ үлдээд бидэнтэй сандал дээр сууж байсныг харсан гэж хөршийнхнөөрөө хэлүүлэхээр бүгдийг зохион байгуулжээ. Цагдаагийн газрынхан алуурчийг олох гэж нэг ч их хичээсэнгүй, тэр ч байтугай, бүгдийг залхааж гүйцсэн Фануччигаас ангижирсандаа баярласан ч байж магадгүйг Вито Корлеоне хожим хойно ойлгосон байна. Цагдаа нар гангстеруудын хоорондын дайсагналын тухай хамгийн энгийн таамгийг дуун дээр шүүрч аваад дээрмийн хэрэг буюу хууль бус бизнест орооцолдсон хэдэн луйварчинг байцаасан болоод л өнгөрчээ. Вито Корлеоне тэдний хувьд ямар ч гэмгүй цэвэр хүн тул түүний тухай санасан ч үгүй.

Гэхдээ Вито цагдаа нарыг хуурч дөнгөсөн хэдий ч найз нарыгаа буруу мөр хөөлгөж чадсангүй, тун яггүй эрс байж, Питер Клеменца, Тессио хоёр хоёр гурван долоо хоногийн турш түүнээс дөлж давхиад байснаа нэг орой их л эрхэмлэж хүндэтгэсэн царай гарган тэднийд орж ирсэнд Вито Корлеоне ердийн эелдэг зангаараа ширээнд урин шилтэй дарсаар дайлав.

Клеменца халдаж ядсан байртай яриа эхэлж:

- Есдүгээр гудамжны мухлаг, мөрийтэй тоглоомын газруудыг харж хамгаалах, өглөг барьц авах ч хүнгүй болжээ. Хөндлөнгийн хүмүүс хүрч ирээд эзэгнэх вий дээ? - гэсэнд Вито тэр

хоёрыг ээлжлэн харсан авч хариу юу ч хэлсэнгүй.

- Фануччигийн түншүүдийг гартаа хийгээд авбал байнгын орлоготой боллоо гэсэн үг - хэмээн Тессио ярианд оролцоход Вито хайхрамжгүй үгүүллрүүн:

- Энэ надад ямар хамаатай билээ? Яагаад та нар үүнийг надад санал болгож ирэв?

Клеменца үнэн голоосоо хөхөрч байснаа:

- За, тэр яахав. Миний өгсөн гар буу одоо чамд хэрэггүй болоо биз дээ? Тийм бол надад өгчих, юмыг яаж мэдэх вэ? - гэлээ.

Вито хажуу халаасаа тун яаралгүй уудлан багц доллар гаргаж, аравтын таван дэвсгэрт тоолон Клеменцад сарвайж:

- Чи аан гээч, би ч гэсэн түүний хэрэгцээ өнгөрлөө гэж бодоод ачааны машин дээрэмдсэний дараа хаячихсан. Би оронд нь мөнгө өгье, дургүйцэхгүй биз дээ? - гээд хоёуланд нь инээмсэглэв.

Тэр үед Вито Корлеоне үхэл ёрлосон хүйтэн инээмсэглэл нь хүмүүст яаж нөлөөлдгийг хараахан мэдээгүй явжээ. Тэр ер хэнийг ч гэсэн айлгаж сүрдүүлдэггүй, зөвхөн хоёулаа л ойлгохоос биш, өөр хүн мэдэхгүй наргианы тухай ярьж байгаа юм шиг инээмсэглэх ажээ. Гэтэл яг энэхэн үеэр гол төлөв үхэх сэхэхийн тухай ярьж таараад түүний уруул ярагдан инээмсэглэх авч нүдний нь харц хүйтэн хэвээр цоо ширтэх тул өдөр тутмын хэнэггүй тайван багаа нүүрнээсээ хоромхон зуур хуулан хаях шиг санагдаж нөгөө хүндээ ямар сэтгэгдэл төрүүлдгийг төсөөлөхөд ч бэрх.

Клеменца цочирдон давхийж:

- Надад мөнгө хэрэггүй —хэмээн долларын дэвсгэртүүдийг холдуулан түлхсэнд Вито мөрөө хавчин мөнгөө авч далд хийгээд хоёр найзаа янз үзэх байртай харлаа. Үүнээс хойш хувь заяа нь нэгэн уяагаар холбогдож буйг тэр гурвуулаа сайн ойлгов. Фануччиг анд нь нухчихсан гэдэгт Клеменца, Тессио хоёр ер эргэлзсэнгүй бөгөөд тэд энэ тухай хүн амьтанд нэг ч үг дуугараагүй атал зөвхөн хөршүүд төдийгүй, хавь ойрын хүмүүс нь Вито Корлеонед тэс өөрөөр хандаж, аль болохоор хүндэтгэл үзүүлэхийг чармайх болжээ. Тэрбээр үүнийг зүй ёсны хэрэг гэж үзсэн боловч эзэнгүй Фануччигийн өв хөрөнгийг гартаа авах ямар ч оролдлого хийсэнгүй.

Энэ үеэс хойш үйл явдал бөөрөнхий цас уулнаас өнхрөх мэт эрчимтэй, шулуухан өрнөлөө. Нэгэн орой Витогийн эхнэр нь хөршийнхөө бэлэвсэн номой авгайг дагуулсаар орж ирэв. Хөдөлмөрч хичээнгүй, бүрэг зантай эл итали авгай өнчирч үлдсэн хоёр хүүхдээ ганцаараа хөл дээр нь босгох гэж зүдэрч яваа хүн бөлгөө. Хоёр хүүхэд нь ажилтай, арван зургаатай нэг хүү нь авсан цалингаа дугтуйтай чигээр нь авчирч өгдөг үүнээс нэг насаар эгч охин нь оёдолчин хэдий ч мөнгөөр байнга гачигдах тул орой үдшийн цагаар гэр бүлээрээ нийлж үйл хийн товч хадаж хэд гурван доллар олдог байв.

- Энэ Коломба авхайд нэг базаахгүй юм болоод чамтай ярья гэсэн юм.

Вито мөнгө зээлэх нь гэж бодоод өгөхөөр зэхэж байсан чинь шал өөр хэрэгтэн ирсэн юмсанж. Коломба авхайн хүүгийнх нь амин хайртай хавыг хамар айлын хүмүүс шөнө хуцахаас нь тээршээн тэднийг хажиглаад эцсийн эцэст байрны эзэн нь хаваа зайлуулахгүй бол өөрсдийг нь хөөж гаргана хэмээн сүрдүүлжээ. Коломба авхай хаваа далд оруулахаар амласан боловч хавдаа амин сүнс шигээ хайртай хүүгээ өрөвдөөд хэлсэндээ хүрч чадсангүй. Авхай нохойгоо нуусныг нь байрны эзэн мэдээд зүрхний хий нь хөдлөхдөө тэднийг нэн даруй хөөж, одоохон гарахгүй бол цагдаа дуудна гэж айлгажээ. Коломба авхай нулимс бөмбөрүүлсэн хүүгээ ч үл тоомсорлон золгүй хаваа Лонг Айландад байдаг хамаатныдаа аваачсан хэдий ч нэгэнт тус болохоосоо өнгөрч, хүү нь сэтгэлээр унаж, хаваа зайлуулсан ч амар заяагаа үзэх нэг ч өдөр үгүй...

- Та яагаад над дээр тусламж хүсч ирээ вэ?—хэмээн Вито тун зөөлөн асуусанд Коломба авхай эхнэр тийш нь толгой дохилоо.

—« Авгай чинь л таныг тус болж чадна гэсэн шүү дээ.

Витогийн мэл гайхсаныг хэлэх юун. Фануччиг ирээд явснаас хойш эхнэр нь түүнээс юу ч асуугаагүй, угаагаад овоолсон хувцастай хольчихсон юмыг нь ч сонирхоогүй, Вито ажилгүй хэвээрээ байгааг мэдсээр атлаа гэнэт хаанаас их мөнгөтэй болсныг нь лавласангүй, одоо ч түүний юу бодож байгааг нүүр царайнаас нь мэдэхийн арга алга.

- Би нүүх зардлыг чинь өгч чадах байна. Та нар өөр, холхон газар очиж суувал хэн ч зовоохгүй нь лавтай. Та үүнийг л хүссэн биз дээ?

Архай толгой сэгсрэн, хоёр хацраар нь нулимс урслаа.

- Италиас наашаа хамт ирсэн анд найз мэддэг таньдаг бүх хүн маань энд амьдарч байхад бид хаашаа нүүх юм бэ? Огт танихгүй хүмүүсийн дунд очоод би яаж амь зуух болж байна? Та манай байрны эзэнтэн уулзаад биднийг үлдээлгэж өгөхийг л танаас гуйя?!

Вито түр зуур бодсоноо толгой дохив.

- За тэгье л дээ. Би түүнтэй яриад үзье. Ер нь та нарт байрнаасаа нүүх хэрэг гарахгүй байлгүй гэж бодох юм.

Эхнэрийнх нь уруул дээгүүр инээмсэглэл бүжиглээд ирэхийг Вито харж нэн таатай санагдсан боловч ер хараагүй дүр эсгэв. Коломба авхайн нүд нь сэргэж найдвар дүүрэн хоолойгоор:

- Тэнгэр бурхан таныг өршөөг! Та үнэхээр түүнийг зөвшөөрнө гэж бодоо юу? - хэмээн уйлан үглэсэнд Вито лавлан асуусан нь:

- Хэн, ноёнтон Роберто юу? Зөвшөөрөлгүй хаачих вэ? Тэр чинь сайхан сэтгэлтэй итали хүн, ганцхан түүнд хэргийн учрыг сайн тайлбарлаад өгвөл тэрээр таныг, үр хүүхдийг чинь өрөвдөх л болно. Ингэж зовж шаналаад хэрэггүй, биеэ бод. Та хоёр, хүүхдэдээ хэрэгтэй гэдгээ

бүү мартаарай.

Ноёнтон Роберто хотын хамгийн ядуу хороололд орших өөрийн мэдлийн байшингуудаа өдөр болгон эргэдэг заншилтай. Гэвч тэрбээр бараг л Европоос Америкийг зорьсон хөлөг онгоц дээр гэрээ байгуулан италиас цагаачилж яваа хүмүүсийн үнэ хямдтай хөдөлмөрийн хүчийг томоохон пүүс, корпорацад дамлан худалдах замаар үндсэн орлого олдог нэгэн бөлгөө. Чухамхүү энэ мөнгөөр л одоо тэр хөөрхий итали цагаачид толгой хоргодож буй эл байшингуудаа худалдан авсан аж. Тэр эр өөрөө Италид гэхдээ Умард Италид төрж, дээд боловсролтой болсон байхад Сицили, Неаполиас гаралтай өмнөд Италийн энэ харанхуй бүдүүлэг хүмүүс юу ч хийж чадахгүй, байр сууцанд нь эмх замбараагүй язганалдах тул тэднийг зэвүүрхэн үл тоомсорлоно. Хог новшоо агаар сэлгэх хоолой руу хаяж, хана туургыг нь цох хорхой өрөмдөн идэж, хөлөмжөөр нь үхэр оготно дүүрсэн хэдий ч үүнтэй тэмцэх талаар тэдний хэн нь ч, юу ч хийсэнгүй.

Уг нь ноёнтон Роберто гэр бүлийнхээ төлөө үнэнхүү санаа тавьдаг, тийм ч муугүй хүн боловч үл хөдлөх хөрөнгө нь эвдрэн сүйрч, бэл мөнгө нь гарын салаагаар урсан арилж, засвар өнгөлгөөний ажилд байнга зардал шаардагдаж байгаад зовж шаналсаар байгаад мэдрэлийн ядаргаа нь туйлдаа хүрчээ. Тийм учраас Вито Корлеоне уулзаж ярихаар гудамжинд зогсооход тэрээр найр тавин угтсангүй. Гэхдээ өмнө зүгийн хүн болгон хутга авч явдаг, яльгүй л юм санаанд нь таарахгүй бол дүрж бүлэх муу зуршилтайг болохоор түүний өөдөөс хэт ширүүн ааш ч гаргасангүй.

Байрын эзнийг саатуулан зогсоосон залуу өнгөцхөн ажихад овоо тохитой харагдана. Вито Корлеоне түүнд хандан үгүүлрүүн:

- Ноёнтон Роберто, өмгөөлж хамгаалах хүнгүй нэг ядуу бэлэвсэн авгайд тус болохыг би танаас хүсэх гэсэн юм. Хөршүүдтэйгээ таарамж муудсаны улмаас тэр авгай таны байшингаас нүүх болсондоо цөхрөн аргаа барж явна. Тэдний хооронд нэг нохойтой холбогдсон ялихгүй зөрөлдөөн болсон юм шиг билээ. Тэр нохой одоо тэнд байхгүй болохоор тэднийх танай байранд сууж болохгүй нь юу билээ? Түүнд нүүх зардал ч байхгүй, туслаад дэмжих анд найз ч үгүй. Миний авгай түүнийг таньдаг болохоор би тантай уулзаж, итали хүн итали хүнтэйгээ ярьж байгаа юм шиг учирлаад үзье гэж амласан юм. Энд нэг өчүүхэн эндүүрэл болсон байдаг. Гэтэл та хэр баргийн юмны наана цааныг ойлгохтойгоо, ухаантай хүн шүү дээ.

Ноёнтон Роберто эл залууг сайн харвал дээрэмчинтэй ер адилгүй аж. Загзгар шөрмөслөг биеийг нь харваас тариачин эр байж, бас эн зэрэгцэх санаатай: «Итали хүн итали хүнтэйгээ» гээд байгаа. Ёстой инээдтэй юм!

- Би тэр сууцыг өөр хүмүүст арай илүү үнээр хөлслүүлчихсэн. Танил авгайг чинь өрөвдлөө гээд хэлэлцэж тохирсноосоо буцалтай биш дээ.

Вито Корлеоне түүнийг бүрэн ойлгож байгаагаа илэрхийлж тэргүүнээ гудайлгав.

- Одоо та хэдээр илүү хөлс авч байгаа вэ?

- Таван доллароор.

Байрны эзэн илэрхий худал хэлжээ. Коломба авгайн сард арван хоёр доллароор хөлсөлж байсан яг төмөр замын гүүрэн дор оршдог харанхуй тохьгүй сууцыг илүү үнээр өгөх ямар ч бололцоо байхгүй. Чимээ шуугиан ихтэй давчуухан тэр дөрвөн өрөөнд арван хоёр доллар ч ахадсан хөлс ажээ.

Вито Корлеоне халааснаасаа багц мөнгө гаргаж, аравтын гурван дэвсгэрт тоолж авлаа.

- Энэ хагас жилийн байрны хөлсний зөрөө. Харин намайг өгсөн гэж тэр авгайд бүү хэлээрэй, их бардам хүн шүү. Зургаан сарын дараа би дахиад төлнө. Гэхдээ та одоо нохойгоо гэртээ байлгахыг тэр авгайд зөвшөөрөх ёстой.

- Чи мөн донгосов оо?! Өөрийн мэдлийн байшиндаа нохой байлгах эсэх, тэр авгайг суулгах байхаа чамаар заалгах юм уу, ёстой гайгүй байлгүй! Надад зааж сургаад, мөнгө сарвайгаад байдаг чи ер нь хэн юм бэ? Адгийн муу сицили турсгаа хуулуулах дур чинь хүрээд болж өгөхгүй байна уу?

Дэлбэртлээ уурласан Робертогийн хашгичин доромжилсон угийг Вито Корлеоне ер тоолгүй, чихнийхээ хажуугаар өнгөрөөгөөд зориуд гайхсан дүр үзүүлэв.

- Би таныг нэг тус болооч л гэж гуйснаас өөр юмгүй. Хэний тусламж дэмжлэг хожим хэрэг болохыг хэзээ ч урьдаас мэдэх аргагүй, тийм биз дээ? Мөнгө бол зөвхөн миний сайн санааны илэрхийлэл болохоос биш, энэ асуудлыг та л шийдэх хэрэг шүү дээ - гээд Вито байрын эзний гарт аравтын дэвсгэртүүдээ хүчээр атгуулж, мөрөн дээр нь алгадаад авсанд цаадах нь хэлэхийн аргагүй ихээр гайхжээ. - За за, татгалзаад юу хийхэв, наадахаа далд хийгээд сайн бодож үзээрэй Хэрэв та энэ мөнгийг надад буцааж өгье гэвэл маргааш ч юм уу, хэзээ ч амжина шүү дээ. Байшин таных болохоор та л тэр бэлэвсэн авгайг суулгахгүй гэвэл би яаж ч чадахгүй гэдгээ сайн ойлгож байна. Сууцанд нохой хуцаад байх хэнд сайхан санагдах юм бэ? Надад ч таалагдахгүй сэн. Гэвч нэг нутгийн улс бие биедээ туслах хэрэгтэй шүү дээ. Та аль ашигтайгаар нь л шийд. Би бяцхан тус хүргэхийг танаас гуйлаа. Надьг мэдэх хүмүүс тус болсон хүнээ мартдаггүйг минь батлаад миний тухай яриад өгөх байх. Хүнд тус болбол өөрийн үйлс бүтнэ гэдэгт би итгэдэг хүн шүү!

Гэвч ноёнтон Роберто тэртэй тэргүй өөрөө зарим нэгэн зүйлийг ойлгож эхэлсэн ажээ. Вито Корлеонегийн тухай асууж лавлах гэж их төвөг удсангүй, тэр оройдоо л ноёнтон Роберто тэднийд ирж, хачин эвгүй эндүүрэл болсныг өөрөө хэлж уучлалт гуйсан байна. Мэдээжээр, Коломбо авхайн гэр бүл сууцандаа үлдэж болохоос гадна хэрэв тэд нохой байлгах гэвэл тэрээр ер хориг тавихгүй. Ер нь хөршүүдийн дургүйцэх нь ямар хамаатай юм бэ? Таалагдахгүй бол өөр байр эрж олно биз, тэрбээр хэнийг ч хүчээр барьж суулгахгүй.

Тэгээд ноёнтон Роберто өглөө авсан гучин доллароо өглөгч зангаар гарган тавиад чин сэтгэлээсээ үгүүлсэн нь:

- Таны тусч зан, өгөөмөр сэтгэл намайг бүр уярааж орхилоо. Бид бүгдээрээ итали хүмүүс, нигүүлсэнгүй сэтгэл бидэнд ч гэсэн харш бус. Би тэр бэлэвсэн авгайн байрны хөлсийг хэвээр

нь байлгахаар шийдсэн. Ингэвэл зүйд нийцэх биз ээ

Нэг үгээр хэлэхэд энэ жүжигт оролцсон хүмүүс тус тусын дүрдээ гарамгай тоглож, Вито Корлеоне дарс аягалан, эхнэр нь гэрийн амтат боов авчирч зочноо дайллаа. Вито байрын эзэн тийш гар сунгах зуураа хавь ойрын хүмүүстээ туслахад бэлэн нинжин сэтгэлийг нь тэнгэрт тултал хөөргөн магтаж, ноёнтон Роберто түүнтэй танилцсаны ачаар хүмүүсийн буянт үйлсэд итгэх итгэлээ эргүүлэн олж авах гэх ухааны юм амандаа бувтнасаар гарыг нь удаан сэгсэрч салах ёс хийгээд гарч одлоо.

Роберто гарцаагүй үхлийн аман дээр ямар ойрхон очоод байснаа бодохоос ар нуруугаар нь могой гүйх шиг болж, Аравдугаар гудамжнаас нэн даруй холдож зайлаад, Бронкс дахь гэртээ ирсэн даруйдаа орон дээрээ тэрийн ойчсоноос хойш бүтэн гурван хоног гадагшаа хоншоороо ч цухуйсангүй гэнэ.

Ингэж Вито Корлеоне өөрийн тойрогт нэр хүндийг нэгэнт олж авсан болохоор олонх хүмүүс түүнийг сицилийн мафитай шууд холбоотойд тооцон ивээл халамжийг нь эрэн горилох болсон байна.

Тэр дүүргийн нэгэн тоглоомын газрын эзэн Вито Корлеонегийн гэрт өөрийн биеэр заларч, долоо хоног бүр хорин доллар сайн дураараа төлж байя гэжээ. Вито үүний хариуд нь зөвхөн үе үе л тэднийхээр зочилж байвал тоглоомчид найдвартай хамгаалалтад байгаагаа мэдэрч тайвшрах юм гэнэ. Шальдар бульдар луйварчдаас багагүй хохирол амсдаг мухлаг, дэлгүүрийн эзэд ч гэсэн түүнээс тусламж хүсэх болж Витогийн оролцсоноор энэ хэрэг шувтраад тэрээр үлэмжийн шан харамж авчээ. Одоо Вито Корлеонегийн долоо хоногийн орлого зуун долларт хүрсэн нь тэр үеийн ханшаар бол чамлахааргүй мөнгө байлаа. Тэрбээр Клеменца, Тессио хоёрыг хамсаатан, анд найзаа гэж боддогийн учир өөрийнхөө санаачилгаар тэдэнд тодорхой хувиар орлогоосоо тальбин олгожээ.

Нэг хэсэгтээ эргэцүүлж бодсоны эцэст гадаадаас чидун жимсний тос оруулж наймаалах ажлаар хөөцөлдөж, багын найз Женко Аббанданотой түншлэхээр товлоод, эл ажлын бүх зардлыг Вито дааж, харин гаднаас бараа оруулах, Италиас тээвэрлэх, боломжийн үнээр худалдан авч хадгалах, борлуулах зэрэг бусад асуудлыг Женкод хариуцуулахаар шийджээ. Тэд эхлээд Женкогийн эцгийн агуулахыг ашиглахаар бодож, тэрээр энэ талаар зохих туршлага суусан тул дөнгөнө гэж товлосон аж. Клеменца, Тессио хоёрыг ч гэсэн энэ жилд оролцуулах бөгөөд тэд «Женкогийн худалдааны пүүс» гэсэн тэмдэгтэй чидун жимсний тосны захиалгыг Бруклин, Манхэттен, Бронкс дүүргийн хүнсний дэлгүүр, мухлагаас авах ажлыг зохион байгуулахаар болов. Вито Корлеоне угийн даруу төлөв зангаараа өөрийн нэрийг эл пүүсийн нэрэнд хавчуулахыг бодсон үй. Гэхдээ нэгэнт тэр л бүх ажил хэргийг удирдаж байгаа тул энэ нь хамаа юун?! Пүүсийн ихэнх капитал түүний мэдэлд, тэгээд ч хамгийн гол нь бусдын хүч хүрэлцэхгүй тохиолдолд л тэр хэрэгт оролцож бүгдийг зохицуулдаг байлаа. Тухайлбал, мухлагийн эздийн хэн нэг нь Клеменца, Тессио хоёрын үгийг үл тоомсорлон «Женкогийн худалдааны пүүсийн» тосыг авахаас татгалзаад байвал Вито өөрөө очиж гарцаагүй байдалд нь хийдэг бөгөөд заримдаа ч зөвхөн нэрийг нь дурсахад л зөрүүд хүний зан нь зөөлөрдөг болов.

Вито Корлеоне наймаачин, бизнесмен хүний амьдралдаа сэтгэл хангалуун явж, эл ажилдаа үнэн голоосоо зүтгэсний ачаар, эхлээд даржинхан байсан пүүс нь ахархан хугацаанд хөл дээрээ босчээ. Гэр бүлдээ бол тэрээр халамжтай нөхөр, сайн эцэг хэвээр үлдэж, гагцхүү хамаг цагаа ажилдаа зориулан гэр орондоо үзэгдэх нь л цөөрсөн байна.

Яваа яваандаа «Женкогийн худалдааны пүүсийн» тос олонд алдаршиж, ямар ч л гэсэн Америк даяар худалдагдах болов. Үүний зэрэгцээгээр Вито Корлеонегийн аюулгүй байдлын тогтолцоо улам боловсронгуй болсоор байлаа. Аливаа овсгоотой ажил хэрэгч хүн өрсөлдөгчдөө цаг тухайд нь цохилт өгч, үнэ өртөгт нөлөөлж, арилжаачдын анхаарлыг гагцхүү өөрийн бараанд татаж чаддаг байх ёстой. Заримдаа бусад пүүсийн чидун жимсний тосыг бус, зөвхөн өөрийн бүтээгдэхүүнийг агуулахдаа нөөцлөхийг эздээс нь шахан шаардах ч хэрэг гардаг байв. Вито аливаа бизнесмений нэгэн адил өөрийн салбартаа дангаараа бүрэн эрх эдлэхийг чармайхын учир эсвэл түүнд зам тавьж өгөх, нэг бол түүнтэй хамтран ажиллах талаар албадлага хавчлагын элдэв арга хэрэглэхэд хүрдэг юмсанж. Тэрбээр дан ганц өөрийн ятган сэнхрүүлэх чадварт найддагаас гадна тэдний чидун жимсний тос бусдынхаас илүү гэдэгт нэг ч их итгэдэггүй учир худалдаа наймааныхаа ажлыг бусдын тусламж дэмжлэггүй гагцхүү өөрийн хүчээр, тэр ч бүү хэл ямар нэг зар сурталчилгаа ч үгүй эхэлсэн билээ. Гэвч худалдаа арилжааны ердийн арга залиг мэдэхүй болохоор Вито Корлеоне зөвхөн өөрийн нэр хүнд, хүч хэрэглэх арга дээр тулгуурладаг байв.

Тэрбээр залуугаасаа хэрсүү ухаантай, уужуу дотортой тайван хүн байсан бөгөөд айлгаж сүрдүүлэлгүйгээр ажил хэргээ амжуулах, хэн хэндээ ашигтай хэлцэл хийхийг эрмэлздэг нь ч илүү үр дүн өгдөг байжээ. Үүний тулд янз бүрийн арга хэрэглэхэд хүрдэг байсан нь мэдээж. Бизнес эрхлэх болсноосоо хойш зах зээл бол ердөө л зах зээл, харин онцгой эрх гэдэг бол бүхнийг захирах засаглал гэдгийг Вито тун удалгүй ойлгож авчээ. Тэгэхлээр юуны өмнө өөрийн салбартаа онцгой эрх олж авах хэрэгтэй.

Санасан бүхэн тийм ч амар бүтсэнгүй. Зөрүүд зангийнхаа улмаас «Женкогийн худалдааны пүүсийг» чидун жимсний тосны цорын ганц ханган нийлүүлэгч гэдгийг хүлээн зөвшөөрөхийг үл хүссэн чидун жимсний наймаачид Бруклинд цөөнгүй байжээ. Вито Корлеоне тэдэнтэй биечлэн уулзаж, эрүүл ухаанаар сайтар тунгаан бодохыг уриалсны дараа ч гэсэн цаадуул нь түүний саналыг хүлээн авахаас эрс татгалзсан байна.

- Үгүй ээ, тэд зөв бодож үзэх ямар ч чадваргүй улс байна. - гэж Вито Корлеоне нэгтгэн дүгнээд Бруклин руу Тессиог явуулжээ. Хүний үг авдаггүй зөрүүд худалдаачдын агуулахыг чанар сайтай, бөх бат барьсан боловч гал түймрийн эсрэг яаж тэсэх билээ?! Цистернтэй чидун жимсний тос гудамжны голд ногоовтор нуур болон асгарч, тос ачсан машинууд яагаад ч юм дандаа онхолдоод байх болжээ.

Миланаас америкт ирээд ёстой л толгой нь эргэж, лам бурханд итгэхээс илүү цагдаа нарт итгэсэн нэгэн хүнсний мухлагийн эзэн хэдэн үе дамжин уламжилсан бие биенээ өмгөөлөн хамгаалах хуулийг ор тас огоорон нутаг нэгт хүмүүсээ яллан гомдол мэдүүлэхээр хууль сахиулагч нар дээр харайж хүрчээ. Гэвч түүний гомдлын өргөдлийг хэрэгт хавсарган үдэж ч амжаагүй байхад ухаан согогтой Милан эр сураггүй болж, эхнэр хүүхдүүдээ уй гашууд унагалаа. Аз болоход эрийн цээнд хүрсэн хүүхдүүд нь учир явдлыг эцгээсээ илүү түргэн ойлгоод чидун жимсний тос наймаалах «Женкогийн худалдааны пүүстэй» нэн даруй хэл

амаа ололцсон байна.

Эхээс төрөхдөө хүн болгон адилхан боловч цөөн хэд нь л сод ухаантан, үлэмж биетэн, гоц авьяастан болдог хойно доо.

Тус оронд «хуурай хууль» тогтож, согтууруулах ундаа наймаалахыг хориглоход Вито Корлеоне олиггүй, хууль бус арга хэрэглэхээс ч буцдаггүй бизнесменээс гэмт хэрэг үйлддэг хэмээгддэг ч атугай ямар ч л гэсэн бие даасан эзэнт улсын ноён захирагч, хорвоогийн хамгийн хүчирхэг хүмүүсийн нэг болох дараачийн алхам хийжээ. Энэ бүхэн нэг өдөр, нэг жилийн дотор болоогүй нь мэдээж боловч «хуурай хууль»-ийн үе дуусч, ардчилал, зогсонги байдлын эрин үе эхлэхэд Вито Корлеонег Загалмайлсан эцэг, Их эцэг, эрхэм Корлеоне хэмээн авгайлах болсон байлаа.

Санамсаргүй тохиолдол, эсвэл заяа төөрөг нь асуудлыг голчлон шийдвэрлэсэн байж болох юм. Тэр үеэр «Женкогийн худалдааны пүүс» чидун жимсний тос тээвэрлэх бүрхүүлтэй ачааны машин зургаатай байжээ. Италийн хилийн хулгайн хэсэг наймаачид эл машинуудаар Канадаас согтууруулах ундаа тээвэрлэх санал тавьсныг Клеменца Вито Корлеонед уламжилжээ. Нууц худалдаа дөнгөж эхлээд хүн хүч асар их хэрэгцээтэй байсны дээр ачааны машин, хүмүүс ашигласны төлөө Вито Корлеонед хэмжээгүй их мөнгө төлөхөөр амласан тул тэрээр тос тээвэрлэж байсан машинаараа спирт зөөхөөр шийдэхдээ ер цааргалсангүй. Одооноос эхлэн Вито хууль засаглалтай харшин зөрчилдөж байгаадаа ч санаа зовсонгүй, бас италийн хилийн хулгайн наймаачид асар их шан харамж амлахдаа нягт өнгөлөн далдалсан сүрдүүлэг дагалдуулсныг ч тоосонгүй. Вито Корлеоне бүр тэр үед занал сүрдүүлгийг доромжлол гэж үздэггүй, хувь хүний асуудалтай ажил хэргээ холбон уялдуулалгүй шийдэж чаддаг байсан тул нэн ашигтай хэлцэл хийх бололцоо байхад увайгүй аашилсан хэдэн хүнд гоморхоод хэрэггүй гэж үзэхэд түнш хулгайн наймаачдын занал нь тийм ч ноцтой бусаас гадна тэд ийм үл бүтэх арга хэрэглэснээрээ зөвхөн нэрээ хөөдсөнөөс өөр юмгүй.

Бүх юм сайнаар эргэж, шинэ ажилд оролцсоноороо Вито Корлеоне шинэ туршлага, баялаг хөрөнгөтэй болж, хамгийн гол нь олон хүнтэй хэлхээ холбоо тогтоожээ. Туршлага, холбоо сүлбээ гэдэг бол түүний хувьд дэлхийн аль ч банкнаас илүү найдвартайгаар капитал арвижуулах хэрэгсэл байв. Эдгээр хүчирхэг хэрэгслийн аль алийг ашиглах талаар Вито Корлеоне зөвхөн чадамгай төдийгүй, жинхэнэ авьяастайгаа харуулж чадсан байна.

Ямар ч ажилчин хүнд боломжийн үнээр, өөрөөр хэлбэл аяга вискиг арван таван центээр гэрээр нь зарж үйлчилдэг бүх итали хүн түүний эцэг ёсны халамжийг хүртдэг боллоо. Коломбо авхайн бага хүүг адислах ёслол дээр Вито Корлеоне загалмай зүүлгэсэн эцгийнх нь хувиар тэр залууд хорин долларын алтан зоос бэлэглэв. Бас эрт орой хэзээ боловч түүний ачааны машинуудыг илрүүлэх нь гарцаагүй тул цагдаагийн газарт танил тал хэрэгтэй болохыг ойлгоод тэрээр хууль зүйн албаны дээд газруудад холбоо сүлбээ ихтэй нэг сайн өмгөөлөгчийг хөлсөлж авчээ. Удалгүй эрх баригч засаглалын бүх шатыг дээрээс доор нь хүртэл хамарсан шан харамжийн бүхэл бүтэн тогтолцоо буй болж, Корлеоне сар болгон «гар цайлгах» ёстой хариуцлагатай албан тушаалтны жагсаалт гаргав. Өмгөөлөгч эдгээр хээл хахуулийн хэмжээг сонсоод жаахан эвгүйрхэж, болж өгвөл багасгаач гэсэн боловч Вито Корлеоне эрс татгалзлаа.

- Өнөөдөр биш гэхэд хожим их хэрэг болох чухал хүнийг гомдоож байснаас илүү мөнгө

төлсөн нь дээр. Эвтэй найрсаг харилцаанд би итгэх учир өөрөө эхлээд сайхан сэтгэл гаргахад бэлэн байна.

Корлеонегийн эзэнт улс жилээс жилд өргөжин бэхжиж, «Женкогийн худалдааны пүүсийн чидун жимсний цэвэр тос» гэсэн зар сурталчилгааны бичигтэй ачааны тэрэгний тоо улам олширч, орон даяар хэрэн сүлжилдэх болж, Вито Корлеонегийн найзад тооцогдох албан тушаалтны жагсаалт ч үлэмж уртассанаас гадна Клеменца, Тессио хоёрт хүчин зүтгэдэг хүмүүсийн тоо ч гэсэн мэдэгдэхүйц нэмэгдлээ. Ийнхүү нийт байгууллагынхаа дотоод бүтцийг нарийвчлан тогтоож, чиг үүргээ тодорхой хуваарилах цаг болсон тул Вито Корлеоне энэ ажлаа хугацаа алдалгүй эхэлсэн байна.

Эхэн үедээ тэрээр Женко Аббандандог зөвлөхөөрөө томилон Клеменца, Тессио хоёрыг өөрийн итгэмжлэгдсэн хүмүүс хэмээн нэрлэж, цэргийнх шиг ахмад цол олгосон байхад тухайн Намын доторх бусад бүх хүн байлдагчийн зиндаанд байлаа. Яваа яваандаа Вито, жирийн гүйцэтгэгч нарын хооронд шат дамжлага олширч, одоо тэрбээр зөвхөн зөвлөх юм уу, итгэмжлэгдсэн хүмүүстээ тушаал захирамж өгдөг болов.

Учир иймээс Вито Корлеонегийн өөрийнх нь амнаас тушаал авсан гэж сайрхах хүний тоо цөөрөн цөөрсөөр, эцэст нь түүний нэрийг намынх нь аль нэг ажил хэрэгтэй холбох нь улам бэрх болж, Их эцэг бүхний нүднээс далд, ноён оргилд нь амгалан залрах болов.

Дараачийн шатанд Клеменца, Тессиогийн бүлгийг салган тусгаарлах болж, Вито Тессиогийн мэдэлд Бруклинийг өгч, түүний залууст эл дүүргийг хяналтдаа авахыг даалгасан байна. Тэднийг Клеменцагийнхнаас салгахдаа хожим хойно онцын шаардлага гараагүй цагт амин хувийн асуудлаар ч гэсэн хоорондоо харилцаа холбоотой байхыг хориглох болсноо Вито сайтар мэдүүлжээ. Ингэвэл хууль сахиулах байгууллагынхан тэдэнд хүрэхэд хүндрэл учирна гэж тэрээр энэ алхмаа тайлбарласан боловч энэ үеэс эхлэн хоёр ахмад бие биенээсээ тусгаарлагдаж, Их Эцгийн эсрэг хуйвалдан хэлцэх дур хүсэл боломж багасахаар бодож тооцоолсныг нь андаасаа илүү ухаантай Тессио дор нь ойлгосон байна. Гэхдээ Вито Корлеоне тэднийг урван тэрсэлнэ гэж хардан хавчин боогдуулах гэсэндээ бус, зөвхөн төрөлхийн болгоомжтой, хэрсүү ухаантайн улмаас иймэрхүү хорон санаа гаргахгүй байхыг л бодсон нь тэр.

Витогийн эл санааг ойлгоод Тессио гомдсонгүй, Вито ч ийнхүү зөвөөр бодож ухаалаг хандсаныг нь хариуд түүнд өөрийн дураар Бруклинд ажиллах бүрэн эрх чөлөө олгож, харин идэвх зүтгэлээр илүү боловч ухаан дутуу Клеменцаг хажуудаа байлган алхам бүрийг нь хянах болжээ. Клеменца гаднаас нь харахад хөгжил наргиантай, хорхойд гэмгүй залуу шиг боловч Тессиогоос илүү улайрсан, болчимгүй хөдөлдөг, зэрлэг авирладаг болохоор түүнийг сайн харж хянаж байлгүй тун горьгүй.

Олныг цочруулсан «зогсонги байдал» Корлеонегийн Намыг сулруулаагүйгээр үл барам улам бэхжин батжиж, чухам тэр үед л тэр үнэн чанартаа сүр хүчин төгөлдөр Их Эцэг болох төрхөө гүйцэд олжээ.

Улс орон даяар сая сая үнэнч шударга америкчууд ямар ч хөдөлмөр хийхэд бэлэн хэрэн тэнүүчилж, эсвэл зөвхөн өлбөрч үхэхгүйн тулд бардам зангаа албадан дарж ивээл

тэтгэмжийн газрын өглөг барьцад гутран зогсож байхад Вито Корлеонегийн хүмүүс тэргүүнээ ихэмсэг өргөн, ажилгүй болно гэж айх юмгүй түнтгэр түрийвчээ тэмтрэн алхана. Тийм болохоор хамгаас даруу эрхэм Корлеоне өөрийн эзэнт улсаа нүүр бардам, сэтгэл хангалуун харж суулаа. Үнэхээр ч түүний буй болгосон бяцхан ертөнцөд орчин тойрныхныг бодвол ажил хэрэг нь хавьгүй сайн, мэдэгдэхүйц амжилттай байсны дээр өөрт нь итгэж зүтгэсэн хүн болгоныг асран халамжилж, Намынх нь төлөө эрх чөлөө, амь насаараа дэнчин тавьсан хэнээс ч нүүр буруулдаггүй байв. Эдгээр залуусын хэн нэг нь гэнэтийн учирлаар цагдаад баригдан шоронд орохдоо ар гэр нь өлсөж зовохгүй гэдэгт бүрэн итгэх бөгөөд тэгэхдээ энэ тусламж нь өглөг хаяцын төдий биш, гэрийн эзний урьдын цалин пүнлүүтэй ойролцоо байдаг ажээ.

Энэ бүхнийг зөвхөн буяныг бодож хийгээгүй нь мэдээж хэрэг. Вито Корлеоне хамгийн дотно найз нар нь хүртэл манай нүгэлт замбуулин дээр бууж ирсэн гэгээн хутагт гэж үздэггүй байлаа. Түүний өглөгч зан, хайр халамжийн цаана хол харсан нарийн тооцоо байх бөгөөд ямар нэг шалтгаанаар торны цаана хоригдох болсон хүн ам алдахгүй л байгаа цагт эхнэр хүүхдийг нь эргэж тойрсоор байх болно гэдгийг сайн мэднэ. Түүнийг шоронгоос гарахад нь найр тавин угтахыг л хүсч байгаа бол цагдаа нарт ямар нэгэн мэдээлэл дуулгаж үл болохыг тэр хүн ойлгох бөгөөд дөнгөж гараад ирмэгц нь чамин тансаг идээ будаа, архи дарстай ширээ засаж, зөвлөх Женко Аббандандо аягүй бол агуу Их эцэг өөрийн биеэр морилон ирж тэсвэр хатуужил, гуйвалтгүй үнэнч байсных нь төлөө хундага өргөөд явахдаа тэр жирийн гүйцэтгэгч эрд нилээн хэдэн тэгтэй мөнгөний чек бичиж өгнө гэдгийг бүгд андахгүй. Их эцэг юуны өмнө гайхамшигтай сэтгэл зүйч, дараа нь л агуу их Загалмайлсан эцэг байсан тул захирагдагсдынхаа сэтгэлд зүрхийг нэвт харж чаддаг хүн байлаа.

Чухамхүү тэр үед л Вито Корлеоне өөрийнх нь Намын тайван зоргоороо амьдралд байсхийгээд л саад тотгор учруулдаг орчин тойрны том ертөнцийг түүний өштөн дайснууд захиран залж байгаагаас хавьгүй илүүгээр тэрээр эзэнт улсаа удирдан чиглүүлж байгаагаа ойлгосон байна. Тоо томшгүй ядуучууд тусламж дэмжлэг эрэлхийлэн агуу хүчирхэг Их эцэг дээр байнга ирдэг нь үүнийг гэрчлэх бөлгөө. Тэдний нэг нь орон сууцгүй, нөгөө нь хүүгээ ажилд оруулах юм уу, шоронгоос суллахыг хүссэн, зарим нь тэтгэлэггүй, амь зуухад бэрх болж бага хэмжээний зээл тун хэрэгтэй болсон байх жишээтэй агаад иймэрхүү шалихгүй атлаа амин чухал хүсэлт гуйлтад нь Их эцгээс өөр хэн ч тусалдаггүй байлаа. Заримдаа ажилгүй суугчийн хоолой дээр хутга тавьж хөлс нэхээд байгаа байрны эзэнтэй уулзаж ухамсарлуулахад л хангалттай байх нь цөөнгүй. Их эцэг гуйхын гутамшигт шаналсан хүнд сайхан үг хэлж зовлонг нь нимгэлэн, зүгээр нэг ивээнгүй байдлаар биш, дуртайяа тусалдаг байлаа. Үүний үр дүнд хотын зөвлөлийн юм уу, конгрессын сонгууль дөхөөд ирэхээр тойргийн бүх итали иргэн ивээн тэтгэгчийнхээ амыг харж, Загалмайлсан эцгийн л дэмжсэн нэр дэвшигчийн төлөө саналаа өгдөг байсанд гайхах юун.

Эрхэм Вито Корлеоне улс төрийн намын удирдагч нар ч, засгийн газрын ухаалаг томоохон түшмэдүүд ч тоомсорлохгүй байхын аргагүй улс төрийн лут хүчин болж хувирав. Загалмайлсан эцэг хэтийн төлөвийг харж чаддаг болохоороо ядуу зүдүү итали гэр бүлээс гаралтай авьяаслаг хүүхдүүдийг сэтгэл харамгүй дэмжин, тэд эрхэм Витогийн мөнгөөр коллеж, их сургуульд суралцаад, дараа нь өмгөөлөгч, прокурорын туслах, прокурор, шүүгч ч болдог аж. Вито Корлеоне бяцхан эзэнт улсынхаа ирээдүйг төлөвлөхдөө жинхэнэ улс

үндэстний жолоодогчийн холч мэргэн ухаан зарж, ялангуяа хууль, эрхзүйн салбарыг сонгож авсан хүмүүсийг дэмжин урамшуулахад үлэмж их хүч хөрөнгө зардаг байлаа.

«Хуурай хуулийг» хүчингүй болгосноор нийт хилийн хулгайн наймаачдад том цохилт өгсөн боловч Их эцэг энд ч гэсэн урьдчилан харж, үйл явдлаас урьтаж амжжээ. Чидун жимсний тос наймаалах ажилдаа буцаж орох нь ямар ч утгагүй, инээдтэй хэрэг байсан учраас Вито өөр хувилбар сонгон авч мөрийтэй тоглоомын газар ажиллуулахаар шийдлээ. 1933 онд тэрээр өөрийн хүнээ Манхэттен руу явуулж, Сальвадор, Маранцаллатай уулзуулжээ. Маранцалла мөрийтэй тоглоомтой холбоо бүхий бүх зүйлийг, тухайлбал, усан боомт дахь хөзрийн луйварчдын орогнол газраас ихээхэн тавьдаг томоохон, баян тансаг тоглоомын газар хүртэл багахан мөнгө хүүлэгчдээс морин тойруулгын бооцоо үзүүлэх тоолуур, айлган сүрдүүлж мөнгө шаардах авилгач хүмүүсийг хүртэл хяналтдаа авсан байв. Вито Корлеоне нэг талаас эл бизнесийн зохион байгуулалтыг сайжруулж, засгийн газрын болон цагдаагийн албаны эрх баригчидтай холбоо тогтоох, нөгөө талаас нөхөрлөлийн хүрээ өргөтгөж хэн хэндээ харилцан ашигтай хамтран ажиллах саналыг Маранцаллад дэвшүүлсэн байна.

Маранцалла Нью-Йоркийн гэмт хэрэгтнүүдийн дотор дээгүүр зиндааны том хүн байсан тул эл хөндлөнгөөс шургалан орсон Корлеонегийн найрсаг саналд үлэмж зэвүүрхэн эрс татгалзав. Маранцаллагийн анд найз нарын тоонд агуу их Аль Капоне орж, Корлеонегийнхаас илүү найдвартай байгууллагыг толгойлсон, хэнийг ч давж дийлэх мөнгө, хүн хүчтэй юм чинь энэ жинхэнэ мафиозтой төсөө ч үгүй чалчаа эртэй зууралдаад юу хийх вэ?

Маранцаллагийн ийнхүү татгалзсан нь гучин гурван оны цус асгаруулсан их дайн дэгдэх шалтаг болж, дэлхийн нэгдүгээр дайнаар улс гүрний хилийн дэнсийг өөрчилсөн шиг үүний үр дүнд гэмт хэрэгтний аймгийн дотоод бүтэц, нөлөөллийн хүрээ хязгаарыг шинэчлэн тогтоов.

Эхэн үедээ хүчний хуваарь Корлеонед ашиггүй байлаа. Сальвадор Маранцалла гаднын сайн дэмжлэг бүхий нилээд хүчирхэг гангстерийн байгууллагатай, Аль Капонетай өөртэй нь үерхдэгээс гадна хэрэгцээ гарвал Чикагогийн толгой зандалчдаас тусламж авч чадна. Амьд бараа буюу өөрөөр хэлбэл янхан эмс худалдаж орлого олдог, бас мансууруулагчийн наймааг гартаа авах эхний оролдлогоо хийж буй Таттальягийн намтай Маранцалла эвийн харилцаатайгаас гадна хөндлөнгөөс хэрэгт оролцсон үйлдвэрийн эзэд, анархист бүлгийн удирдагчдыг айлган сүрдүүлэхийн тулд дээрэмчдийн бүлгийн тусламж авахаас буцдаггүй улс төрийн зүтгэлтнүүдтэй холбоо тогтоосон аж.

Энэ нүсэр хүчний эсрэг Вито Корлеоне ердөө л сайтар сургуулилж, сүрхий зохион байгуулагдсан хэдий ч хүн цөөвгөр хоёрхон бүлэг сөргүүлэн тавьж чадах байв. Клеменца, Тессио хоёр тун сүрхий ахмад болохоо харуулж, тэдний залуус нийтийн үйл хэргийн төлөө амиа ч хайрлалгүй зүтгэх болжээ. Маранцалла ямар хүчтэй тулгарснаа төсөөлөх ч үгүй байсан агаад ер нь бүгд л Корлеонегийн жирийн цэргүүдийг дутуу үнэлж, Тессио, Клеменца хоёрыг хоорондоо ямар ч холбоогүй, саланги тусгаар бүлгүүд гэж эндүүрсэн нь Корлеонед тун ашигтай байлаа.

Гэсэн хэдий боловч чухамхүү Корлеоне мэргэн ухаан сийлж, уран гоц ганц цохилт хийгээгүй

бол хэрэг явдал яаж төгсөх байсныг хэн мэдлээ?!

Маранцалла эл нойтон хамуу шиг Корлеонегээс нэгмөсөн ангижрахаар шийдээд мэргэжлийн хоёр мэргэн бууч ирүүлэхийг Аль Капонегээс хүсжээ. Гэвч тэр үед Витогийн мэдээллийн албаны сүлжээ маш шуурхай ажилладаг болчихсон байсны ачаар алуурчид Чикаго-Нью-Йоркийн галт тэргэнд сууж амжаагүй байхад эрхэм Корлеоне энэ тухай мэдчихсэн байлаа. Тэр оройдоо ирэх галт тэрэг угтуулахаар Их эцэг Бразиг явуулахдаа яаж залхаахаа өөрөө мэд гэж хэлсэн нь угийн эрүү шүүлтэд гарамгай тэр эрийн хүн аймаар хорон сэтгэлгээг улам ч дэвэргэжээ. Люка гурван туслагчийнхаа хамт Чикагогийн элч нарыг буудал дээр отон харуулдаж, зориуд худалдан авсан тээш зөөгч тэдний чемодануудыг вагоны хаалган дээрээс шүүрэн авч, мөн л өөрийн хүн жолоодсон машинд дагуулан аваачиж гэнэ. Хаалга хаагдаж ч амжаагүй байхад Люка Брази дагалдагсдын хамт тэр машинд чихэж суугаад нэрийн хуудасны оронд гар буу үзүүлэн чикагогийн мэргэн буучдыг хөл дороо шалан дээр хэвтүүлжээ. Ийм байрлалаас мэргэн буудлагын дээд урлагийг харуулах гэдэг үнэхээр бэрх л дээ.

Эл машин усан боомтын засварын газрын арын хашаан дахь хоосон агуулахуудыг зорилоо. Люкагийн урьдчилан үзэж сонгосон нэг агуулахад Капонегийн төлөөлөгчдийг оруулан гар хөлийг нь хүлээд аманд нь гар нүүрийн саглагар алчуур чихэж шалан дээр хэвтүүллээ.

Дараа нь Люка Брази хана түшүүлэн зэхэж тавьсан байсан сүхээр тэдний нэгийг хонины мах эвдэж байгаа мэт хэсэглэж гарав. Тэрээр эхлээд хөлийг шагайгаар нь, дараа нь өвдгөөр нь, дараа нь ташаа хавиар нь тас цавчлаа. Брази бөх хүн шиг тэнхээтэй хэдий ч сүх далайн тонголзсоор байгаад ядарч гүйцэх тэр үед түүний, гарт тамлуулсан этгээд, мэдээжээр аль хэдийн хадан гэртээ морилж, агуулахын шалан дээр тийм гэхийн тамтаггүй мах, цус, ясан овоо л үлдсэн байлаа.

Брази ийнхүү Чикагогийн нэг зочныг зүйл дуусгаад нөгөөх рүү нь очтол дахин сүх далайх хэрэгцээ нэгэнт өнгөрч, тэр эр хэний ч санаанд оромгүй юм хярж айсандаа болоод амандаа чихүүлсэн гар нүүрийн алчуурыг залгиж бүтэж үхсэн байв. Цагдаа нар тэр үхдэлийг олж юунаас болж нас барсныг тогтоохоор задлан шинжилгээ хийлгэхүйд талийгаачийн улаан хоолойноос гар нүүрийн алчуур гарч ирсэнд их юм үзэж, нүд тайлсан шинжээчдийн хүртэл нүд нь орой дээрээ гарах шахсан гэдэг.

Хэд хоногийн дараа Аль Капоне ийм нэгэн дипломат маягийн захидал Вито Корлеонегээс хүлээн авчээ. «Миний дайснаа яаж дардаг нь одоо танд нууц биш болсон байх аа. Гэвч та Неаполийн хүн атлаа сицили эрсийн тэмцэлдэж байхад хоёр галын дунд ороод юугаа хийх гэсэн юм бэ? Би таныг андаа гэж тооцвол их баярлах байна. Хэрэв миний саналыг та зөвшөөрвөл би танд насан туршдаа өртэй болж, үерхэл хүндэтгэлээ үгээр биш үйл хэргээр нотлоход хэзээ ч гэсэн бэлэн байна. Ажил явдлаа гаднын хүний гар харалгүй өөрөө зохицуулж дөнгөдөг, дуртай цагт чинь дэмжлэг үзүүлж чадах хүний үерхэл танд ашигтай гэдгийг эрхбиш ухааран болгоох буйзаа. Үерхэн найрсах тохиромжтой цаг хараахан болоогүй гэж таныг үзвэл би гомдохгүй. Гагцхүү манай хотын чийгтэй уур амьсгал Неаполийн хүнд тун зохимжгүй тул ялангуяа одоо манай энд ирээд ер хэрэггүй гэдгийг л танд чин сэтгэлээсээ зөвлөх байна».

Эл захидал өдөөн сөргөсөн, дээрэнгүй ч гэмээр өнгө аястай мэт санагдаж болох авч Вито

Корлеоне сайтар тунгаан эргэцүүлсний эцэст ингэж бичжээ. Түүний бодлоор бол Капонегийн нам хэтийн төлөв муутай, нэр нөлөөгөө бага багаар алдаж байгаа аж. Аль Капоне өөрөө олны зан заншлыг дайрч өдөн, дээрмийн эд баялгаараа сайрхан гайхуулдгийг Их эцэг тун болчимгүй хэрэг хэмээн үзэх бөлгөө. Яагаад гэвэл, хамгийн улангассан шийдчихсэн дээрэмчдээр хамгаалуулсан ч гэсэн Капонегийн цайз гадаад холбоогүй, зохих өнгөлөн далдлалт хийхгүй, ёс зүйг сахин баримтлахгүй бол амархан сөнөх тавилантай. Капонегийн эзэнт улс уналтын шатандаа орж, хүн аймаар домог яриа, хатуу ширүүн харгислал дээр тулгуурласан түүний нэр хүнд Чикагогоос хальж гарахаа байгаад уджээ.

Загалмайлсан эцэг энэ удаад ч буруу замаар будаа тээсэнгүй зөвхөн харгис яргалал хэрэглэсэндээ ч биш, гол нь Вито Корлеоне хэний ч итгэмээргүй богино хугацаанд, эгшин зуур эрс шийдвэртэй хариу арга хэмжээ авсны ачаар түүний тактик амжилтад хүрсэн байна. Аль Капоне саруул ухаанаар тунгаан бодоод, хэрэв Корлеоне ухаантай, зоригтойгоос гадна ийм нарийн тодорхой холбоотой бол түүнтэй дайсагнах нь илүү маяг гэж үзжээ. Тэгсэн дор бол үерхэл найрамдал, түүний хамт ирээдүйд тусалж дэмжихээ амлаж ирүүлсэн саналыг нь хүлээн авах хэрэгтэй хэмээн үзээд Капонегийн нам төвийг сахихаа эрхэм Корлеонед мэдэгдсэн аж.

Ийнхүү сөргөлдөгч талуудын хүч, боломж тэнцсэний дээр Вито гийт гэмт хэрэгтний аймаг даяар тэр дороо л үлэмж хүндэтгэх болж, Аль Капоне яаж овжин номхруулсан, Маранцаллаг хэрхэн тал бүрээс нь хазаарлаж авсныг нь Нью-Йорк төдийгүй Америк даяар шагшин шуугилдах болов.

Вито ердөө л жил хагас гаруйхан хугацааны дотор Маранцаллаг залгиж амжжээ. Тэрээр Маранцаллагийн хамгаалалтын дор байдаг мөрийтэй тоглоомын газруудад тайван ажиллах бололцоо өгөхөө байж, түүний хүмүүс Гарлем дахь хамгийн том тоглоомын газрын эзнийг мөшгөсөөр барьж аваад тэр өдрийн бүх орлогыг нь төдийгүй, шоо, хожооны хясаа, өрийн дансыг нь булааж авав. Вито Корлеоне дайсагнагч этгээдээ алхам алхмаар шахан зайлуулж, нэхмэлийн үйлдвэрүүд дээр хүртэл Клеменцагийн хүмүүс очоод Маранцаллагийн хавчин гадуурхсан үйлдвэрчний эвлэлүүдийг хамгаалсан байна. Нэхмэлийн үйлдвэр, бэлэн хувцасны дэлгүүрийн эзэд Клеменцагийн залуусыг яаж ч чадсангүй дийлдэж, үүнээс хойш Маранцаллад итгэхээ болилоо.

Давшилт бүх фронтоор зэрэг явагдаж газар бүхэнд амжилт олж, анд найз нартаа хөгжөөн наргиантай авч атаат дайсандаа харгис галзуу Клеменцаг Их эцэг зөв залсны ачаар түүний хэрцгий яргалал нь их тус хийсэн билээ. Эцэст нь нэгэн сайхан өдөр Вито Корлеоне Тессио захирагчтай бэлтгэл хүчээ ажиллагаанд оруулж Маранцаллаг өөрийг нь авлах даалгавар өгсөн

байна.

Маранцалла Корлеонегийн намын тухай болчимгүй юм хэлж, тавьтаргүй аашилсандаа нэг бус удаа харамсаж, зуучлагчаар дамжуулан эвсэн найрамдахыг оролдсон боловч одоо Их эцэг өөрөө татгалзаж, элдэв янзын шалтаг заан хэлэлцээ хийхээс зайлсхийх буюу тодорхой хугацаагаар хойшлуулах болов. Маранцаллагийн бүх цэрэг тарж бутарлаа. Ямар ч хэрэггүй байхад хэн хутга мэс, бууны суманд өртөж хохирох дуртай байх билээ дээ?! Хамгийн түрүүнд

өөрсдийнх нь ашиг сонирхлыг үнэхээр хамгаалж чадах хүнд л өргөл барьц өгөх эрмэлзэлтэй морин тойруулгын бооцоологч, мөнгө хүүлэгч нар нөгөө талд урвалаа.

Хоёр бүлэглэлийн хоорондын дайн дуусах тийшээгээ хандаж, шинэ 1932 оны босгон дээр Тессио Маранцаллагийн халуун мөрөөр орж чаджээ. Маранцаллагийн ойрын хүрээллийн хүмүүс хүч мөхөсдөж яваа толгойлогчийнхоо төлөө амиа алдахыг үл хүсэн өөрсдөө түүнийг бушуухан барьж өгөх арга олж ядаж явсан тул Вито Корлеоне түүнтэй Бруклиний нэг зоогийн газар уулзахаар бэлэн байгааг тэднээр дамжуулан Маранцаллад хэлүүлжээ. Өөрөөс нь урван тэрсэлсэн бие хамгаалагч нараа дагуулсаар Маранцалла болзсон газраа ирж захиалгатай ширээндээ өнчин бургас шиг ганцаараа суугаад саяхан барьсан итали талхнаас хазаж ч амжаагүй шахуу байхад Тессио дөрвөн туслахын хамт хүрч ирлээ. Маранцаллагийн бие хамгаалагчид хоромхон зуур алга болж, түүний хазсан талхаа залгиж ч амжаагүй байхад духанд нь сум шигтгэсэн байна.

Дайн дууслаа.

Корлеонегийн эзэнт улс Маранцаллагийн мэдэлд байсан газруудыг эрхэндээ авсны дараа шинэ Их эцэг татварын хэмжээг өөрчлөн тогтоосон боловч өгөөмөр зан гарган хэнд ч гар хүрсэнгүй, хуучин ажил хэргээ эрхлэхийг зөвшөөрчээ. Харин нэхмэлийн болон оёдлын үйлдвэрүүд дээр үйлдвэрчний эвлэлийн нөлөөг хүчтэй болгон бүрэн хяналтдаа авсан нь тун цагаа олсон чухал алхам байсныг хожмын үйл явдлууд тодхон харуулж билээ.

Хүрээлэн байгаа орчинтойгоо холбоо харилцаагаа янзалж зохицуулаад Вито Корлеоне жаахан амсхийх санаатай байтал гайтай асуудал гэр дотроос нь ундраад ирж.

Сантино Корлеоне, Санни арван зургаан нас хүрч, итали хүүхэд гэхэд итгэмээргүй өндөр голшиг биетэй, хүнд харцтай боловч нимгэн цэвэрхэн царайтай залуу болжээ. Фредо угийн ноомой амгалан зантай, Майкл юмны учрыг ухварлах болоогүй хар нялхаараа амьтан гүйж явахад харин Санни элдэв хэрэг төвөгт орооцолдсон амар заяа үзүүлнээ гэж нэг үгүй. Тэрээр дөнгөн данган суралцан, хавь ойрын зодоон болгонд оролцдогийг эс үгүүлэн үгүүлэх нь: нэг удаа Сантинод загалмай зүүлгэсэн эцэг нь болох Клеменца түүнийг зэвсэгт дээрмийн хэрэгт холбогдсоныг эрхэм Корлеонед дуртай дургүй хэлэв. Өнгөцхөн харахад энэ нь хүүхдийн саваагүй зан мэт харагдах боловч их төвөг учруулж магадгүй байснаас гадна гол нь Санни бүх зүйлийг санаачилж, нөгөө хоёр залуу нь түүнийг зүгээр л аялдан дагасан нь мэдээж.

Энэ мэдээг сонсоод эрхэм Корлеоне ердийн амгалан байдлаа алдан сэтгэл сэнсэрсэн нь хуруу дарам цөөхөн учирдаг ховор тохиолдол байлаа. Юуны өмнө Их эцэг тэр үед Корлеонегийнд ирээд гурван жил болж байсан Том Хейген эл хэрэгт холбогдсон эсэхийг Клеменцагаас асуусанд тэрээр толгой сэгсрэв. Тэгэхээр нь Их эцэг хүүгийнхээ хойноос машин явуулж, Санниг шууд «Женкогийн худалдааны пүүсийн» албаны өрөөнд авчирчээ.

Гэвч Их эцэг хүүтэйгээ ярилцаад дийлж гарах тавилангүй байсан юмсанж. Тэрээр хүүтэйгээ хоёулхнаа үлдээд Саннигийн толгой дээр эцэг хүний уур хилэнгийн үгсийг сицили аялгаар хачир нэмэн урсгаж дотроо онгойлгоод:

- Чи үүнийг яах гэж хийв? Хэнийгээ дууриахаар ийм дэггүй амьтан болдог байна аа? - гэвэл

Санни юу ч дуугарсангүй. Харин Их эцэг үлэмж зэвүүцсэн янзтай:

- Чи мөнгөөр дутаад байна уу? Ийм тэнэг юм хийх гэж бас байдаг аа? Чи тэгээд тавин доллар олов уу? Эсвэл хорийг уу? Нохой долоосон хоёр аравтаас болж ингэж аз туршина гэдэг чинь юу гэсэн үг вэ? - хэмээн хашгичсанд Санни тэссэнгүй үг сөргөж орхилоо.

- Таны хэрхэн Фануччиг алахыг би харсан.

Загалмайлсан эцэг хий л амаа ангалзуулж байснаа

«Ө-өх!» хэмээн уртаар санаа алдаад буйданд лагхийн сууж хүүгээ өөр юу гэхийг алмайран хүлээлээ.

- Фануччиг явсны дараа ээж гэртээ орж болно гэхээр нь би шатаар дээш өгсөж таны дээвэр дээр гарахыг хараад араас чинь сэмхэн дагасан юм. Би эхнээс нь дуустал, түрийвч хаяхыг чинь, гар буу эвдэхийг чинь, бүгдийг харсан.

- Өө, тэгвэл би чамд зааж сургаад нэмэргүй юм байна. Чи өөрөө л мэдэх хэрэг болж. Чи чинь их сургуулиа төгсгөхгүй юм уу? Уг нь бичгийн сав сугавчилсан нэг өмгөөлөгч нүүрэндээ багтай, гартаа буутай зуун сайн эрээс илүүг бүтээх юм даа.

Санни нүүр дүүрэн инээмсэглэж, баашгүй гэж хэлэхийн аргагүй өнгөөр үгүүлрүүн:

- Би гэр бүлийнхээ бизнесээр оролдмоор байна.

Аав нь эл үгийг сонсоод ер ажирсангүй, түүний хошигнолд инээх ч үгүй, уурлах ч үгүй байгааг хараад Санни: «Чидун жимсний жимс наймаалж сурмаар байна» гэж яаран нэмж хэллээ.

Их эцэг хэсэг зуур чимээгүй байснаа мөрөө хавчив.

- Хүн болгон хувь заяаныхаа эзэн нь байдаг даа.

Тэрээр хүүгийнхээ нүдэн дээр хүн алсан нь Саннигийн хойшдын тавиланг тодорхойлсон талаар дэлгэрүүлэн ухааж бодохыг хичээсэнгүй хайхрамжгүй дуугаар нэмж хэлсэн нь:

- Маргааш есөн цагт ажил дээр очоорой. Женко чиний хийх юмыг зааж өгнө.

Гэвч Женко Аббандандо жинхэнэ зөвлөх байсан болохоор Загалмайлсан эцгийн чин хүслийг нэвтэрхий мэдэрч, хүү Корлеоне аавынхаа дэргэд байвал Намыг толгойлон удирдах нууцад суралцах бололцоотой болно хэмээн Санниг гол төлөв Их эцгийн бие хамгаалагчаар ашиглаж эхэлжээ. Их эцэгт ч гэсэн гэр бүлийнхээ бизнесийн алдаж онодог адармаатай замд ууган хүүгээ зааж сурган хөтөлж явах хүсэл төрсөн учир Санни дур зоргоороо орхисон сургуулиасаа дутахааргүй элдэв янзын шинжлэх ухааны дамжаа дүүргэсэн байна.

Санни байсхийгээд л бодолгүй, болчимгүй юм хийж загнуулна. Их эцэг айлган сүрдүүлэх гэдэг ямар ч утгагүй тэнэг хэрэг, харин уурынхаа мунхагтаа толгойгоо мэдүүлэх нь илүү маяг

гэж хүүдээ дандаа зааж сургадаг байв. Үнэхээр ч Загалмайлсан эцгийн заналхийлж байхыг хэн ч, хэзээ ч сонсоогүй, тэрээр зөвхөн ойр дотнын хүмүүсийнхээ дэргэд л хааяа уурлан хилэгнэдэг аж. Их эцэг хүүгээ өөр шигээ уужим дотортой, самбаатай хүн болгон хүмүүжүүлэхийг хичээн, биеэрээ үлгэрлэж үзүүлэхээс гадна хэрэв дайсан чиний сул тал дутагдлыг хэтрүүлж үнэлбэл, их аз, харин анд найз сайн тал, чадварыг чинь дутуу үнэлбэл үүнээс хавьгүй дээр гэж сургамжлан захидаг байлаа.

Санни «онолын хичээл» судлахын зэрэгцээгээр хашир туршлагатай Клеменцагийн хараа хяналтын дор буу буудаж сицилийн уламжлалт зэвсэг болох боомилжийг хэрэглэж сурчээ. Хоолой боох энэ уяа хэтэрхий америкжсан Саннид таалагдсангүй, ер нь тэрээр англо-саксын маягаар харилцан буудалцах гэх зэрэг ил шулуухан хорон заль мэхгүй аргаар тэмцэхийг илүүд үздэг байсанд Клеменца их л сэтгэл дундуур явна. Гэвч Санни бие хамгаалагчийн үүргийг гарамгай биелүүлж, машин жолоодон, амьдралын аар саар юм болгонд тусалдаг тул Их эцгийн байнга дагуулж явах дуртай хүн нь болжээ.

Хоёр жилийн дараа юм бүхэн хэвийн хэмжээнд орж, хүү нь аавынхаа ажил хэргийн арга барил учир начрыг аажмаар ойлгон эзэмшиж, тэнгисээс сувд шүүх, тэнгэрээс од шүүрэх гэж хэт санаархахгүй ч гэсэн хэрдээ таарсан авьяас, хичээл зүтгэл гарган ажилласан нь аль ч бизнесийн хүрээнд байдаг л зүйл бөлгөө.

Энэ хооронд түүний багын найз, хуурай ах Том Хейген бас л өсч өндийгөөд коллежид оржээ. Фредо дунд сургууль дүүргэх дөхөөд, хамгийн бага Майкл нэгдүгээр ангийн босго алхаж байхад, эмэгтэй дүү Конни нь дөнгөж дөрөв хүрч байв.

Корлеонегийн гэр бүл аль хэдийн Нью-Йоркийн ядуучуудын хорооллоос Бронкст нүүж ирээд, одоо Лонг Айлендад харш худалдаж авах талаар ярилцаж байсан цаг. Гэвч Загалмайлсан эцэг нүүж суухын хажуугаар өөр хэдэн ажил зэрэг амжуулах бодолтой байсан тул нэг ч их яарсангүй.

Вито Корлеонегийн хамгийн гол авьяас нь аливаа зүйлийг хоёр нүүдлийн цаана тооцоолох чадвар юм. Америкийн гэмт хэрэгтний аймгийг цус асгаруулсан дотоодын тэмцэл, хямралдаан үе үе донсолгон, хууль бус үйл ажиллагааны халдвар тус орны бараг бүх салбарт гүн нэвтэрч нэр алдарт дуртай, аагтай догшин гангстерууд хорхой хүрмээр дориун олзны төлөө бие биенийхээ толгой дээр цахиур хагалахад бэлэн байлаа. Намын удирдагч нар эрхэм Корлеонегийн нэгэн адил урьдаас тогтоосон хил хязгаарын халдашгүй дархан байдлыг хангаж эрээ цээрээ алдсан нөгөө нэгэндээ өөрийн орлого ихтэй газраа алдчихгүй хамгаалахын тулд байнга сонор сэрэмжтэй байхад хүрдэг аж.

Вито Корлеоне сонин хэвлэлийн нийтлэлээр олон нийтийн санаа бодлыг анхааралтай ажиглаж, байдал хурцадсаар байгааг ойлгожээ. Улс төрийн зүтгэлтэн, сэтгүүлчид аливаа гэмт хэрэг бүрийг хууль чангатгах зорилгодоо хадны мангаа болгон ашиглаж, цагдаагийн залхаан цээрлүүлэх арга хэмжээ авахыг шаардах болов. Ойрын ирээдүйд хэт хүлцэнгүй, эвлэрэнгүй дэг журмыг бүх нийтийн эсэргүүцэл зэвүүцэл, шахалтын дор хүчингүй болгож, энэ нь хууль бус бизнесийн бүх төрөлд гай чирч тун ч магадгүй боллоо. Корлеонегийн эзэнт

улс дотроо бол найдвартай, баг бэх боловч аюул гаднаас ойртож буйн учир Их эцэг хожимдоогүй дээр нь түүнээс урьдчилан сэргийлэхээр шийдсэн байна.

Үүний тулд Нью-Йоркод болон улс орон даяар хоорондоо дайсагнасан бүлэглэлүүдийг эвлэрүүлэх шаардлагатай байв. Энэ зорилго амархан бүтнэ гэж Вито ойлгож байлаа. Зөвхөн Нью-Йоркийн дээрэмчдийн бүлгийн толгойлогч нартай тус тусад нь ээлж дараалан уулзаж, сайн харилцаа тогтоон учирлаж нөлөөлөл эзэмшлийн хүрээг арай шударгаар хуваарилсан хожим Намуудын зөвлөлөөр бататгахаар ятгахад л бүтэн жил зарцуулав. Бас хажуугаар нь толгойлогч нэг бүрийн ямар хүн болох, хэр зэрэг аюултай, хэдий хэмжээгээр итгэл даахыг тандаж мэдэх хэрэгтэй байсныг хэлээд ч яахав. Гэвч Их эцгийн хийсэн нөр их ажил ямар ч үр дүн өгсөнгүй, бүлэглэлүүд саланги тусгаар хэвээрээ, тэдний ашиг сонирхол давчуу орон зайд байнга мөргөлдөж, хоорондоо хэзээ ч эвлэрэхгүй мэт санагдана.

Иймэрхүү янзаар хэл амаа ололцож чадахгүйг мэдээд Вито Корлеоне бусад олон эрхтэн дархтаны нэгэн адил тархай бутархай тусгаар бүлэглэлийн тоог цөөлөхөөс өөр аргагүй гэсэн дүгнэлтэд хүрчээ. Ийм омог бүлэглэл хуруу дарам цөөн болоод ирсэн цагт эв эеийн хэлэлцээрээ цааш үргэлжлүүлж болно. Үгүйдээ гэхэд, чухам хэнтэй ийм хэлэлцээ хийх хэрэгтэй нь мэдэгдээд ирнэ.

Уг нь энэ үеэр эрх мэдлийг нь хасах хязгаарлах тухай ярихын ч хэрэггүй лут хүчирхэг тав, зургаан нам бусдаасаа тодорч ялгараад байсан бөгөөд одоо тусдаа хороололд олз хайдаг «хар гар» мэтийн ганц бие хүмүүс, бор зүрхээрээ аз туршиж яваа мөнгө хүүлэгч, морин тойруулгын бооцоологчид, томоохон бүлэглэлүүдийн алинд ч ордоггүй, жижиг бүлгүүдийг нэгтгэн захиргаандаа авах нь чухал байв. Вито Корлеонегийн сэдсэн энэ зүйл уг чанартаа эзлэн түрэмгийлэх дайн бөгөөд тэрээр тархай бутархай, зохион байгуулалтгүй жижиг хүчний эсрэг байнгын ажиллагаатай жинхэнэ цэрэг хөдөлгөжээ.

Нью-Йорк болон түүний орчин тойрныг байлдан дагуулахад гурван жил зарцуулсан боловч огт санаандгүй их амжилтад хүрсэн байна. Удаан хугацааны турш энэ санаа бүтнэ гэхэд бүгд эргэлзэж байсан төдийгүй устгахаар товлосон бүлэг хулгайчдын нэг ирланд эр галзуурах дөхөөд тохиолдлоор хамгаалалтын хүрээг нэвтлэн орж Их эцгийн цээжийг шархдуулав. Солиотой этгээдийг газар дээр нь нам буудсан боловч ингэлээ гээд ямар сайн байх билээ?! Гэвч сохорсон биш завшив гэгчээр, Загалмайлсан эцгийн арга буюу хэвтэрт байх хугацаанд Сантино Корлеоне байлдааны ажиллагааг биечлэн удирдаж өөрийн хүч чадлаа сорьж үзсэн аж. Тэрбээр нэг ёсондоо өөрийн шадар цэргийн анги байгуулж Клеменца, Тессии хоёрын нэгэн адил ахмад цолтой болмогц идэр залуу, аюумшиггүй зоригт Наполеон шиг тулалдаанд шуургалан орлоо. Бүрэн ялалт байгуулахад эцэгт нь дутаад байсан дайснаа үл өршөөх, хатуу ширүүн хандах зан чанар хүүд байгаа нь дайн тулааны хүнд бэрх нөхцөлд илэрч гарсан агаад тэрээр ямар ч гуйлтыг үл тоомсорлон, нэг бол байлдан эзэлж захиргаандаа оруулдаг, эсвэл бут ниргэн устгадаг байв.

Байлдааны ажиллагаа явагдах хугацаанд Санни Корлеоне Нью-Йоркийн гэмт хэрэгтний аймагтаа хамгийн хорон зальтай, хайр найргүй өрөвдөх сэтгэлгүй алуурчны нэртэй болсноос гадна зөвхөн нэрийг нь дурсан ярихад л хэний ч нуруугаар хүйт оргидог Люка Брази гэгч догшин харгис эртэй тэрбээр хамт ажилладаг байсан нь ёстой л гал дээр тос нэмсэн хэрэг болов уу.

Чухамхүү Люка Брази нөгөөх Их эцгийн аминд халдаж ихээхэн балаг тарьсан ирландын бүлэг хулгайчдын мөрөөр мөшгөж бүгдийг нь толгой дараалан хүйс тэмтэрсэн билээ. Бас хамгийн том зургаан Намын нэг нь бие даасан жижиг бүлгүүдийг өмгөөлөн өрвөлзсөнд түүний толгойлогчийг хэний ч туслалцаагүй мөрдөн олж, шадар туслагч нарынх нь хамт устгасан нь сайн эр Люкагаас өөр хэн байх вэ. Хожим нь, Их эцэг бие илааршсан хойноо энэ намтай өөрөөр хэлбэл, намаас үлдсэн хэсэгтэй нь хэл амаа ололцож чадсан бөлгөө.

1937 оны эцэс гэхэд Нью-Йорк хотод амар амгалан байдал тогтож, заримдаа хүний амь хороосон ч гэсэн цар хүрээгээрээ яльгүй будлиан сөргөлдөөн гарах боловч, яая гэхэв, энх тайвны хэлцэлтэй улс гүрний хооронд ч гэсэн хилийн мөргөлдөөн болдог хойно доо.

Хотын хэрмэн хананы дэргэд овоорсон хээрийн догшин омог аймгийнхныг хараа салгалгүй ширтэж суухад хүрсэн эртний эзэд хаад лугаа адил эрхэм Вито Корлеоне өөрийн асар удам эзэнт улсын хилийн чанадад болж буй бүхэнд анхаарал тавина. Тэрбээр Германд Гитлер засгийн эрхэнд гарч, Испанийн Бүгд Найрамдах улс мөхөн унасан, англичуудтай Мюнхенд хэлцэл хийсэн зэрэг үйл явдлуудыг ихэд сонирхон ажиглаж, хорвоо ертөнцийг юу юугүй дэлхийн дайны эргүүлэгт хаях гэж буйг урьдаас харж чаджээ. Энэ дайн гадаадад болж буй үйл явдлаас бүрэн тусгаарлагдсан өөрийнх нь бичил ертөнцийг улам бэхжүүлж, бүр баяжуулах бөгөөд амандаа орсон шар тосыг хэлээрээ түлхчихгүй л бол дорвитой бэл хөрөнгө хэмжээгүй өсөх аятайхан бололцоо гарах юм. Үүний тулд түүний бяцхан эзэнт улс дэлхийн дайны шуурган дунд ганц амгалан тайван, эв нэгдэлтэй түшиц газар нь болох ёстой.

Эрхэм Корлеоне жинхэнэ дипломат хүний зангаар хамтран зүтгэгчид, үзэл санаа нэгтэндээ хандан уриалга гаргаж Лос-Анжелес, Сан-Франциско, Кливленд, Чикаго, Филадельфи, Майамид суурьшсан нутгийнхаа иргэдийг зөвлөгөөнд дуудлаа. Тэрбээр эцсийн эцэст томоохон намуудын хоорондын зөвшилтийг хангаж чадсанаар нисваанисыг тэвчсэн архад найдан шиг гэмт хэрэгтний нийт аймагт энх тайван, эв эеийг авчрав. 1939 онд тус улсын шинэ Үндсэн хууль шиг Нам болгон тодорхой муж улс, хотын хэмжээнд бие даан тусгаар тогтнох зарчмыг дэвшүүлсэн хэлэлцээр байгуулж, үйл ажиллагааны хаяа хүрээг тодорхойлсон, ийм нарийн хуваарилалт хийсэн нь сайн хөршийн харилцааг тогтоон сахихад нэн их тус дөхөм үзүүлсэн байна.

Сайн санаат хүмүүс олон удаа уриалан дуудаж, Ромын хамба лам өөрийн биеэр мөргөж гуйсаар байтал хорвоо дэлхийн улс гүрний дөнгөөгүй зүйлийг Вито Корлеоне хийж чадсан бөгөөд томоохон улс орон хоорондоо дайтан цусаа асгаруулж байхад нууц байгууллагууд амар жимэр аж төрж суулаа

Тийм ч учраас 1939 онд Гитлер байлдааны ажиллагаа эхэлж, 1941 онд Америкийн Нэгдсэн Улс гитлерийн эсрэг эвсэлд нэгдэх үеэр Вито Корлеонегийн хэрэг тун урагштай бүтэж, цэрэг армийн захиалгаар ажиллах аж үйлдвэрийн газрууд, «хар захын» мундагчуудын хувьд зайлшгүй ирдэг алтан ургацаа хураах үеийг хүлээн зохих бэлтгэлээ базааж байв. Засгийн газрын төвлөрсөн хангамж хомсдож, тээвэрлэлтийн хэмжээ багасан хүнсийг картаар, бензинийг талоноор олгодог болоод ирэхээр элдэв заль мэх, холио сэлгээ хийх өргөн бололцоо нээж өгнө. Корлеонегийн намынхан өөрсдөө тээврийн хэрэгсэлтэй тул гадна дотноос ирсэн хүмүүсийг шулж, «хар зах» дээр хүнсний карт дамлан, халамжлан хамгаалдаг үйлдвэрийн газрууддаа улсын ашигтай захиалга авахад нь тус дэм үзүүлэх, нэмэлт нөөц эрж

олохын гадна олсон бараагаа гурав дахин өндөр үнээр зарах зэргээр суусан газраасаа шороо атгаж алт болгодог байлаа.

Вито Корлеоне хэдийн хөл дээрээ босч үлэмж хүчирхэгжчихээд байсан тул харьяат албадаа бүх нийтийн цэргийн дайчилгаанаас чөлөөлөх бололцоотой болж, үй олон залуусыг бусдын ашиг сонирхлын төлөө амь нас хохирох аюулаас аварч чадсан байна. Түүнээс гадна эмнэлгийн комиссын үзлэгийн өмнө ямар ямар эм зажилж залгилах учиртайг зааж зөвлөдөг эмч нарыг тэжээн тэтгэдгээс гадна зарим залуусаа цэргийн дайчилгаанд хамаарахгүй ажилд оруулсан байна. Тийм учраас Их эцэг олсон амжилтаараа бахархах бүрэн үндэстэй байв. Түүнд үнэнч байхаа тангарагласан хүмүүсийн хувьд Загалмайлсан эцгийн эзэнт улс найдвартай түшиг тулгуур болдог байхад сая сая хүнийг гарцаагүй үхэл буюу ядуурал гуйланчлалын ангал руу түлхэж буй улсын байгууллага ингэж сайрхаж чадахгүй нь мэдээж.

Гэхдээ бас амжилт бүтэмжийн баяр баясгалангийн хажуугаар харамсан халаглах юм гарсаар л байв. Хамгийн бага хүү Майкл нь эцгийн туслалцаанаас эрс татгалзаж, төрийн далбааныхаа дор амь өрсөн тулалдахаар сайн дураараа фронтод яваад өгчээ. Мөн өөр нэлээд хэдэн итали айлын хөвгүүд Майклыг дууриан дайнд мордсонд Их эцэг үнэн их гайхсан байна. Тэдний нэг нь ийм хачин шийдвэрийнхээ шалтгааныг тайлбарлахаар оролдохдоо өөрт нь эх эцэг шиг сайхан сэтгэлээр хандсан улс гүрэндээ буян болохыг хүссэн гэх ухааны юм хэлж гэнэ. Вито Корлеоне итгэмжлэгдсэн төлөөлөгчөөсөө энэ тухай сонсоод: Зэ чааваас, улс биш, би л түүнд сайхан сэтгэл гаргасан юмсан гэж гомдолложээ. Сайн дурынхан эл эх оронч алхмаасаа болоод баларч мэдэх байсан боловч отгон хүү нь бас ингэсэн болохоор бусдын нь хэрэг явдлыг мэдээ ч үгүй хүн болоод өнгөрлөө. Нэгэнт тэд нар хэний өмнө, ямар үүрэгтэйгээ нээрээ мэдэхгүй бол одоо яая гэхэв дээ,

Дэлхийн хоёрдугаар дайн дуусахад Корлеонегийн бяцхан ертөнцөд ээлжит өөрчлөлт гарах нь дамжиггүй. Загалмайлсан эцэг үүнийг урьдчилан харж мэдээд өөрийнхөө байгууллагыг уян хатан ажиллагаатай болгож хөгшин ертөнц рүү тэмтрүүлүүдээ сэмхэн нямбай сунгадаг байлгах хэрэгтэй гэж үзсэн байна. Ажлын энэ шинэ хэлбэрийг хэрэгжүүлэхэд болохгүй гэх юм байгаагүй тул дээрх өөрчлөлт гайгүй өнгөрч, тэд ашиг хонжоогоо алдахгүй гэж Их эцэг тооцоолжээ.

Гадаад ертөнцийн хууль нь ёс суртахууны талаар гэмт хэрэгтний аймгийнхнаас ер дээрдэх юмгүй гэж үзэх үндэслэл Их эцэгт байсан ажгуу;

Нилээн дээр үед талхчны дагалдангаар ажиллаж байсан Назорини Их эцгээс тусламж гуйжээ: Тэрээр сүйт бүсгүйн хамт орон гэрээ тохижуулахаар шийдэн шударга хөдөлмөрөөрөө хураасан гурван зуун доллароо мебелийн дэлгүүрийн эзэнд төлж; хоёр ор, эргэнэг, жижиг ширээтэй унтлагын өрөөний тавилга, алтан утсаар шагласан зөөлөн мебель зочдын өрөөндөө тавихаар сонсон авсан юмсанж. Назорини сүйт бүсгүйн хамт орон гэрээ ямар болгохоо төсөөлөн ярилцаж, аз жаргалдаа мансууран явсаар долоо хоног өнгөрсөн боловч үнийг нь төлсөн тавилгыг нь хэн ч авчирч өгөөгүй тул Назорини сураг гаргах санаатай очоод дөнгөж саяхан тэр мебелийн дэлгүүр дампуурсныг сонсмогц золтой л бахардаж унасангүй. Түүний мебель сонгож авсан асар том агуулахуудыг одоо ломбодож лацдан, доторхыг нь өртэй хүмүүст өгөхөөр шийдсэн бөгөөд мебелийн наймаачин өөрөө зугтаан алга болж, хууран мэхэлсэн хүмүүстээ чихнээс далд холхон хараал ширээлээ дураараа урсгах болгосон ажээ.

Назорини бусад хохирогчдын нэгэн адил өмгөөлөгч дээр харайж хүрсэн чинь эл хэргийг шүүхээр хянан хэлэлцэж, одоо байгаа нэхэмжлэлийн бүх өргөдлийн шаардлагыг хангах хүртэл хүлээх хэрэгтэй гэсэн аж. Энэ бүх ажиллагаа гурваас наашгүй жил үргэлжилж, сайндаа л гэхэд Назоринид гурван зуун долларынх нь арван хувийг төлнө, аягүй бол төлөхгүй ч байж магадгүй гэнэ.

Вито Корлеоне Назоринигийн ярьсныг сонсоод тун их эргэлзэж, гүн бодолд дарагдав. Тэгэхлээр хууль ердөө л ийм дээрмийг өөгшүүлж байгаа хэрэг болох нь. Мебелийн наймаачин өөрөө Лонг-Айленд дахь хувийн эдлэн газартаа буянаа эдэлж, ганган машинаар нааш цааш давхисан хэвээрээ, хүүхдүүд нь ч урьдын адил төлбөр ихтэй коллежид суралцсаар л... Гэтэл тэрээр хоосон ядуу Назоринигийн хуруу хумсаа химлэж байж хураасан гурван зуун долларыг луйвардаж яаж зүрхлээ вэ? Юу ч боллоо гэсэн, нэгэнт мөнгийг нь төлсөн мебелийг эзэнд нь хүргэж өгөх ёстой л байсан сан.

Вито Корлеоне үнэн хэрэг дээрээ юу болсныг шалгаж мэдэхийг чидун жимсний пүүсийнхээ өмгөөлөгч нарт Женко Аббандандогоор дамжуулан даалгажээ. Хорон зальт наймаачин бүх мөнгө, эд хөрөнгөө эхнэрийнхээ нэр дээр болгосон учраас одоо дэлгүүр нь хаагдах болоод ирэхээр тэрээр өөрөө ямар ч хариуцлага үл хүлээн далд нуугдаж үлдээд, бүх хохирлыг корпорац нь нөхөн төлж байгаа ажээ. Сайхь эр хариугүй дампуурдгийнхаа даваан дээр Назоринигаас мөнгө авч байгаагаа мэдэж байсан нь гарцаагүй, энэ ч яах аргагүй түүний нүгэл боловч анхны удаагийнх нь ч тэр биш, хамгийн эцсийнх нь ч тэр биш, ийм юм хийдэг хүн зөндөө л бий. Хууль энд яаж ч чадахгүй, Назоринид туслах ямар ч арга алга.

Хууль цаазаас тусламж горьдолгүй өөрсдөө аргалах хэрэг гарч, Их эцэг дампууралд орсон мебелийн наймаачин руу Женко Аббандандог явуулсанд яг л түүний тооцоолсноор наймаачныг нэг их удаан гуйж гувших хэрэг гарсангүй. Сайхь эр угийн үнэгэн зальтай болохоор юу шаардаад байгааг дор нь ойлгоод талхчинд тэр тавилгыг нь хүргүүлэх талаар яаралтай арга хэмжээ авсан байна.

Вито Корлеоне ч гэсэн энэ түүхээс өөртөө тун ашигтай нэг сургамж олж авчээ. Гэтэл хоёрдахь удаад нь бүр ч сургаалтай юм болж, ямар ч л гэсэн Вито Корлеоне хожим нэг бус удаа түүнийг хэрэглэж билээ. 1939 онд Их эцэг хотын захад шилжин суурьшихаар зориглон шийдсэн нь сайн эцгийн хувьд хүүхдүүдээ тэндхийн олигтой сургуульд сургах гэсэн хэрэг. Бас хүний нүднээс далдхан байж, хүн ам шигүү суудаг хотын дүүрэгт талын түймэр шиг дорхноо эрчимтэй тархдаг цуу ярианы шалтаг гаргахгүй байх нь Их эцэгт өөрт нь ч гэсэн хэрэгтэй байсан юмсанж. Шинэ газарт чидун жимсний худалдаачны нэр хүндэд харшлах юу ч гарсангүй, тэрээр Лонг-Бичид багавтар эдлэн газар худалдан авчээ. Тэр үед тэнд ердөө л дөнгөж барьсан дөрөвхөн байшин байсан учир шинээр барилга барих газар хаа мундахав?!

Санни тэгэхэд Сандратай сүй тавьчихаад байсан тул дөрвөн харшийн нэгийг түүнд хуримын бэлэг болгон өгөхөөр товлож, дараагийнхад нь Их эцэг, гурав дахь байшинд Женко Аббандандо гэрийнхэнтэйгээ орж, харин дөрөвдөх харш нь одоохондоо эзэнгүй байв.

Их эцэг шинэ харшдаа ороод дөнгөж долоо хонож, олигтой төвхнөж амжаа ч үгүй шахуу байтал Лонг-Бич дэх байшингуудын дундах талбайд ажлын хувцастай гурван залуу суулгасан ачааны машин хүрч ирээд хотын галын шалган байцаах газраас яваа гэж хэлсэн тул бие

хамгаалагч тэднийг доод давхрын халаалтын төхөөрөмжид дагуулж аваачлаа.

Энэ үеэр Их эцэг эхнэр, Санни хоёрын хамт тэнгисийн эрэг хавийн давсархаг агаараар амьсгалан цэцэрлэг дотуур зугаалж явтал бие хамгаалагч ирж Их эцгийг дуудсанд тэрээр дургүйлхэж ярвайсаар араас нь явав. Очоод харсан чинь зочилж ирсэн гурван ханхар залуу ус халаах төхөөрөмж болон галын өрөөний пийшинг задлан эд ангиудыг нь шалаар нэг тараан хаячхаад гэрийн эзнийг яадаг бол гэсэн янзтай доогтой харж зогсоно. Байцаагч нарын ахлагч нь бололтой хамгийн лужир биетэй нэг нь сөөнгөдүү хоолойгоор эрс ширүүн хэлсэн нь:

- Танай энд эвдэрхий, галын аюултай юм их байна. Хэрэв та техникийн үзлэгийн өртгийг оролцуулан зуун тавин доллар өгчихвөл бид энэ бүхнийг чинь засаад өгч болно. Бид энэ улаан картон картыг пийшин дээр чинь бэхэлчихвэл дахин хэн ч таныг зовоохгүй. Ингэж тохирох уу даа, өвөө?

Загалмайлсан эцэг сүүлийн долоо хоногийн турш орон гэрээ тохижуулах гэсээр байгаад хэвийн амьдралаас жаахан хөндийрч төсөөрсөн байсан тул энэ үгсийг сонсоод ёстой л хөх инээд гээч нь хүрч, хүнд нэгийг бодогдуулах гэхээрээ хэрэглэдэг итали гаж аялгаа улам тодруулж.

- Хэрэв би мөнгө төлөхгүй бол энэ пийшин яах вэ? гэж асуулаа.

Гурван зочны нөгөөх ахимаг настай нь мөрөө хавчин:

- Яах ч үгүй, энэ чигээр нь орхиод л яваад өгнө хэмээн эвдэрхий пийшин, төмөр ширэм эд ангиудыг гараараа тойруулан заасанд Их эцэг ер уурлаж зэвүүцсэнгүй, тайван дуугаар:

- Миний эргэж иртэл та нар жаахан хүлээх л болж дээ гээд цааш эргэн цэцэрлэг рүү явжээ.

Их эцэг том хүү дээрээ очоод:

- Санни, тэнд хэдэн залуу ирчхээд пийшин ухаад байна. Юу хэрэгтэй нь би ойлгохгүй юм. Чи тэдэнтэй уулзаад учрыг нь олоодохооч - хэмээхдээ үнэхээр хэлсэн гэхээсээ наргиан болгосон нь илүүтэй боловч сэтгэлийн мухарт нэгэн далд санаа агуулжээ. Хэрэв нээрээ л Санни Их эцгийн орлогчийн хувьд ажил хэрэгт оролцох гээд байгаа юм бол түүнийг янз янзын нөхцөл байдалд туршиж үзэх хэрэгтэй байлгүй яах вэ?!

Санни Сицилд уламжлал болсон уран чамин арга хэрэглэлгүй, шув шулуухан айлган сүрдүүлсэнд нь Вито Корлеоне жаахан сэтгэл дундуур хоцорчээ. Санни урилгагүй зочдоос хэд гурван юм асууснаа элдвээр маяглалгүй, шууд л гар буу тулган «Байцаагч нарыг» ухааруулаад өг гэж харуулын залууст тушаав. Хүрэлцээтэй хэмжээгээр зодуулж, өшиглүүлсэн байцаагч нарын чих гайхалтай зөөлөрч нүд ирмэхийн зуур халаах төхөөрөмж, пийшинг буцааж угсарснаар үл барам бие хамгаалагчдын гярхай хараан дор галын өрөөг шүүрдэж арчсан байна.

Галын өрөөг цэвэрлэсний дараа Санни тэднийг нэгжиж үзсэн чинь тэд үнэхээр галын байцаагч нар, гэхдээ Суффолк гүнлэгт хамаарах пүүсийн хүмүүс ажээ. Санни пүүсийн эзний

овог нэрийг мэдэж аваад сайхь эрсийг гэрээсээ хөөж гаргав.

- Хэзээ нэгэн цагт та нар Лонг-Бичид ирж дахиад миний нүдэнд харагдаад үзээрэй! Тэгвэл хамаг үе мөчийг чинь тасалж салгаад хооронд нь сольчихно шүү, ойлгов уу, хар малууд аа?

Үүгээр зогссонгүй, Сантино энэ хэргийг мухарлахыг хүсч, Суффолк дахь пүүсийн эзэнтэй холбоо барьж албан хаагч нарынх нь элдвээр дөвчигнөснийг дуулган анхааруулсан нь тэр үед Саннигийн харгис хэрцгий зан хараахан тодорч гараагүй, хэрэгцээнээс илүү нигүүлсэнгүй сэтгэлээр ивээдэг байсных болов уу даа.

Гэхдээ энэ жижиг хотхонд Корлеонегийн гэр бүл нүүж ирснээрээ багагүй буян үйлдэнэ. Тэд нэн даруй цагдаагийн газартай ажил төрлийн холбоо тогтоож, нэгэнт Их эцэг ойр хавьдаа юу болж байгааг хамгийн сайн мэддэг хүн байсан тул Лонг-Бичийн танхай этгээд, гангстеруудад амь зулбан зугтаахаас өөр арга олдсонгүй. Нэг жил ч өнгөрөөгүй байхад эл хотхонд гэмт хэрэг бүрэн арилж, Лонг-Бич нь Нэгдсэн Улсдаа хамгийн амгалан тайван хотын нэгд тооцогддог боллоо. Мэргэжлийн хулгайч, дээрэмчид ердөө ганц удаа л энэ хавиар түйвээгээд явмагц дараа нь юу болохыг тэдэнд тэр дор нь анхааруулна. Хэрэв хэн нэг нь үүнийг үл тоомсорлон хоёрдахь удаагаа оролдлого хийвэл дахиад хэн ч, хэзээ ч хаана ч түүнийг олж харахаасаа өнгөрдөг байлаа. Шальдар бульдар луйварчид, галын байцаагчид шиг авилгач эрст ч гэсэн Лонг-Бичээр үзэгдээд хэрэггүй гэж эелдгээр сануулах цайлган сэтгэлийн зөвлөгөөг тоогоогүй маанагдуу нэг нь ясаа хэмхчүүлж байж сая амьд мэнд сална. Лонг-Бичид төрсөн гэртээ байдаг, гэхдээ элдэв янзын хэрэг зөрчил гаргахаас буцахгүй хөвгүүдэд нэг бол хотоос зайлж одохыг дотночлон зөвлөх ажгуу.

Ийнхүү Лонг-Бич үлгэр жишээч хотын нэр цол авч чадахаар болсон байна.

Вито Корлеонегийн хамгийн их гайхсан нэг зүйл гэвэл, өөрийнх нь байгуулсан эзэнт улсыг бодвол том ертөнцөд шударга ёсны хэмжүүр тун ч эргэлзээтэй, хуурамч шиг санагдан, дэг журам ер дээрдэх юмгүйг сайн харж байлаа. Хэрэв Вито гэдэг үнэнч, шулуун зантай залуухан хүү ногооны мухлагт ажиллаж байхад түүний авьяас билэг, мэдлэг чадварыг ашигласан бол тун ч их зүйл хийж чадах байснаа сайн ойлгох боловч тэр үед хэн ч түүнд нийгмийн дотор зохих байр сууриа эзлэхэд нь тусалсангүй. Харин одоо бол бүх юм Вито Корлеонегийн өөрийн гарт нь байгаа болохоор юу хийхээ хэнээр ч заалгахгүй, өөрийнхөө нэр төрд тохирно гэж үзсэн ямар ч байр суурь албан тушаал, нэр алдрыг дуртай цагтаа олж авч чадахтайгаа болжээ.

Тэрбээр Лонг-Бичийг өөрөө сонгож аваад дэлхийн хоёрдугаар дайн дуустал, үүний хамт амгалан байдал алдагдаж түрэг Солоццогийн өдөөн хатгалгаар Нью-Йоркийн таван намын хооронд цус асгаруулсан тэмцэл, сөргөлдөөн дэгдэх хүртэл, Вито Корлеоне өөрөө дээрэмчдийн таван сум биедээ зоолгон эмнэлгийн оронд хадагдах хүртлээ өөрийн газар дээр, хувийн харшдаа амар жимэр, тохь тухтай тааваараа аж төрж суусан юмсанжээ.

АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ

Хөдөө нутгийн аль ч хотхоны нэгэн адил Нью-Гемпширт ямар нэг хачин сонин хэрэг явдал мэдэгдэлгүй өнгөрнө гэж заяа нь үгүй, хэзээний л цонхныхоо цаана амьсгаа даран нугдайсан гэрийн эзэгтэй нар заавал олоод харчихсан, эсвэл хэрэгт дуртай мухлагийн эзэд яг цагийг нь олоод газар дороос гарах мэт хаалган дээрээ зогсон ажиглаж байх жишээтэй. Тийм учраас Нью-Йоркийн дугаартай хар машин дөнгөж л хүрч ирээд Адамсынхны байшинг зүглэсэн даруйд энэ тухай гудамжныхан, магадгүй тэр хотынхон бүгд мэдээд амжжээ.

Их сургуулийн амьдралаар жаахан хачирласан болохоос биш мөн чанартаа удам угсаанаасаа нэг ч их холдоогүй, дотоод сэтгэл нь хөдөөнийх хэвээрээ үлдсэн Кей Адамс бас л сониуч зандаа хөтлөгдөн юу болоод байгааг мэдэхээр унтлагын өрөөнийхөө цонхны хөшгийг сөхөн харлаа. Үдийн хоолны цаг дөхөөд тэрээр шалгалтад бэлдэн уншиж суусан номоо хаагаад боссоноо ийнхүү зогтусан харваас нэгэн хар машин тэднийх рүү ойртож явав. Кей яагаад ч юм, өөртэй нь уулзахаар ирж яваад цочирдсонгүйгээр үл барам, чухам л гангстерийн адал явдалтай кино гарч байсан дэлгэцнээс шууд буугаад ирсэн юм шиг хоёр лут эр яг үүдэн тушаа зогссон машинаас гарч наашаа зүглэсэнд нэг их гайхсан ч үгүй.

Эл хоёр гоц залууг Майкл юм уу төрөл төрөгсөд нь явуулсанд бүрэн итгээд Кей хаалганд түрүүлж хүрэхийн тулд шатаар хар хурдаараа буув. Майклаас, түүний тойрон хүрээлэгчдээс ичиж зовсондоо өөрөө тэдэнтэй биечлэн уулзах нь дээр гэж бодсондоо ч биш, зүгээр л эцэг эх нь хуучны уламжлалаар хүмүүжсэн жинхэнэ Шинэ Английн америк хүмүүс болохоор тэднийг урьдчилан бэлтгэхгүй бол гэнэт ийм зочдыг хүлээн авахдаа тулгамдаж эвгүй байдалд орох вий гэсэндээ л тэр.

Тэрээр яг хонх дуугарах үеэр амжиж очоод онгойлгож өгвөл босгон дээр зогсож байсан хоёрын нэг нь өвөр рүүгээ гараа шургуулах нь яг л кинонд гангстерууд буугаа шүүрэхтэй нэн адил харагдсан тул Кей өөрийн эрхгүй давхрын аяархан дуу алдав. Гэтэл сайхь эр цамцныхаа энгэрийн халааснаас ширэн гадартай үнэмлэх гарган сурамгай дэлгэж үзүүллээ.

- Би Нью-Йоркийн цагдаагийн эрэн сурвалжлах газраас яваа Жон Филиппс, энэ миний туслах, туршуул Сириани гээд хар хөмсөгтэй, бов бор царайтай ажилтан тийш зааснаа: - Та Кей Адамс мөн үү? хэмээв.

Кей дуугүй л толгой дохилоо.

- Танайд орохыг зөвшөөрнө үү? Бид, Майкл Корлеонегийн тухай тантай ярилцах гэсэн юмсан.

Хүүхэн зай тавьж, тэднийг оруулах тэр эгшинд аав нь хонгилоос гараад ирэв.

- Энэ юун улс вэ, Кей?

Буурал үстэй эцэг нь орон нутгийн баптист сүмийн санваартан лам байж, эрдэмтэн хүний нэрийг дэмий зүүгээгүй болохоор хэзээ ямагт цэвэр цэмцгэр харагдана. Ер нь бол Кей

аавынхаа хайртай гэдэгт огт эргэлздэггүй хэдий ч эцэг охин хоёр бие биеэ тун бага мэддэг, нилээд хөндий байдаг ажээ. Гэхдээ тэд ямар ч л гэсэн нэг нэгэндээ итгэдэг байсан тул яг л үнэнийг хэлжээ.

- Энэ Нью-Йоркийн цагдаагийн газрын мөрдөгч нар миний нэг танилын тухай надтай ярилцахаар ирсэн юм байна.

Ноён Адамс ер ажралгүй:

- Тэгвэл миний ажлын өрөөнд орцгооё гэсэн боловч Филиппс эелдгээр үгүүлрүүн:

- Ноён Адамс, бид танай охинтой ганцаарантай нь ярилцвал тун гялайхсан.

Ноён Адамс түүнээс ч дутуугүй боловсон зан гаргалаа.

- Тийм бол миний ажлын өрөө та нарын мэдэлд ноёд оо! Та нар бидэнтэй хоол идээд явах юм биш биз?

Цагдаа нар талархлаа илэрхийлэн татгалзаад Кейгийн хамт ажлын өрөөнд орж бололцооны хэрээр тухлан суусан хойно Жон Филиппс түрүүлж ам нээлээ.

- Хатагтай Адамс, та сүүлийн гурван долоо хоногийн дотор Майкл Корлеонетой уулзсан уу? Эсвэл ямар нэг мэдээ сураг дуулаагүй биз?

Ганцхан энэ асуултаас л үндэслээд Кей учир шалтгааны холбоотой гинжин хэлхээ бодлыг ургуулан сэтгэжээ. Мафитай холбоотой асан цагдаагийн ахмад, мансууруулагч бодисын наймаачин Виргили Солоццо хоёр гурван долоо хоногийн өмнө Нью-Йоркод алуулсан тухай тэрээр сониноос уншсанаа санав. Бостоны сонингууд энэ аллагын тухай мэдээг эхний нүүрэндээ нийтэлж, гангстерын бүлэглэлүүдийн хооронд ширүүн дайн эхэлж байгаа тухай үгүүлээд Корлеонегийн нэрийг дурссан байсан ажээ.

Кей толгой сэгсэрч:

- Түүнийг барагцаалбал нэг сарын өмнө шархадсан эцгээ эргэхээр эмнэлэг рүү явснаас хойш уулзаагүй гэсэнд нөгөө туршуул нь ярианд оролцож эрс ширүүн үгүүлсэн нь:

- Та хоёрын тэр уулзалтын тухай бид бүгдийг мэднэ. Харин одоо уулзаж байгаа эсэх, захиагаар харилцдаг эсэх чинь л бидэнд сонирхолтой байна.

- Уулзаа ч үгүй, захиа аваа ч үгүй.

Туршуул Филиппс их л албархуу жигд дуугаар:

- Тэр нэгэн болзооноос хойш та Майкл Корлеонетой ямар нэгэн байдлаар уулзсан л бол илэн далангүй хэлсэн нь дээр байхсан. Энэ чинь мөрдөн байцаалтад үнэхээр чухал юм шүү. Хэрэв та түүнтэй холбоо барьдгаа нууж хаавал тун базаахгүй хэрэгт холбогдоно гэдгийг зориуд анхааруулъя. Майкл Корлеонед ямар нэгэн байдлаар туслалцаа үзүүлбэл танд л муу юм

болно шүү гэвэл Кей эгдүү нь хүрч эцгийнхээ уужим буйдан сандал налан гэдийлээ.

- Би яагаад түүнд тусалж болдоггүй юм бэ? Бид хоёр удахгүй гэрлэх юм чинь эхнэр нөхрийн ёсоор бие биеэ дэмжих ёстой бус уу?

Энэ удаад туршуул Сириани түүнд хариулав.

- Цагдаагийн ахмад, түүнтэй ажлаа ярилцахаар уулзсан мэдээлэгч хоёрыг хороосон хэрэгт яллагдаж байгаа пайзыг чинь бид эрэн сурвалжилж яваа болохоор та түүнд тусалснаараа хам хэрэгтэн болж хариуцлага хүлээнэ. Чухамхүү Майкл Корлеоне буудсаныг бид сайн мэдэж байгаа.

Кей үнэн голоосоо тачигнатал хөхөрсөнд хоёр туршуул нэгийг бодов бололтой гайхсан харц солилцлоо.

- Тэр ёстой ярихгүй. Майкл гэрийнхэнтэйгээ таарч тохирдоггүй юм чинь тийм юм яасан ч хийх хүн биш. Би түүний дүү, Коннигийн хурим дээр очихдоо тэднээс ямар хол хөндий байдгийг нь ажигласан. Түүнтэй бараг л гаднын зочны адил харилцаж байсныг би нүдээрээ харсан тул андуурах аргагүй. Хэрэв тэр одоо нуугдсан бол, зөвхөн түүний нэрийг сонинд элдвээр гоочлон. гаргаж шуугиан дэгдээхгүй гэсэндээ л тэр байх. Майклыг би та нараас хамаагүй илүү мэдэх тул түүний гангстер биш гэсэн үгэнд минь итгэж үзээрэй. Тэрээр шударга тэвшин, томоотой хүн болохоор ямар ч болов хүн алж чадахгүй. Майкл ялихгүй ч гэсэн хуулийн заалт зөрчдөггүй, түүний худлаа хэлж байхыг би л лав мэдэхгүй том байна.

- Та хоёр танилцаад удаж байна уу?

- Жил гаруй боллоо гээд Кей туршуул Филиппс тийш дайрч өдсөн янзтай хартал хоёр цагдаа тушаал авсан юм шиг нэгэн зэрэг инээмсэглэхийг ажаад үлэмж гайхжээ.

- Тэглээ ч гэсэн та түүний тухай бүгдийг мэдэхгүй юм шиг байна. Майкл танаас салж, эцэг дээрээ очсон тэр орой эмнэлгээс гарахдаа цагдаагийн ахмадтай хэрэлдэж маргалдаад цаадах нь Майклын эрүүг хугалж, хэдэн шүд цөм цохисон тул андууд нь түүнийг гэрт нь хүргэж өгсөн. Гэтэл маргааш орой нь Майклыг зодсон ахмад буудуулж, тэр өөрөө бараа сураггүй алга боллоо. Бүгд л түүнийг буудсан гэх боловч нотолгоо баримт бидэнд алга. Алуурчинг харсан үйлчлэгч эр зураг хараад Майклыг таниагүй, гэхдээ нүүрэлдүүлбэл таних ч юу магад. Тэднийг зоогийн газар аваачсан жолооч бас гэрчилж чадах боловч Майклыг олоогүй цагт ярихаас татгалзаад байгаа. Одоо ХМТ-г оролцуулан манай бүх хүчээр түүнийг эрэн сурвалжилж байна. Гэвч амжилт олоогүй болохоор л ямар нэг сэжүүр таны гарт байгаа болов уу гэж бодсон хэрэг л дээ.

- Ноён Филиппс, би таны нэг ч үгэнд итгэхгүй байна хэмээн Кей хөндий хариулахдаа, Майклын эрүүг хуга цохисон гэж бодохоос л нуруугаар нь хүйт даагаад явчлав. Эд нар лав л худлаа хэлээгүй байх. Гэвч Майкл зөвхөн эрүүгээ хугалуулсны төлөө хүн алсан гэдэгт Кей яагаад ч итгэхгүй.

- Хэрэв Майклаас сураг чимээ дуулдвал бид танд найдаж болох уу? хэмээн Жон Филиппсийн

асуухад Кей зэвүүцэн толгой сэгсэрсэн чинь хоёрдахь туршуул Сириани унтууцан эрс ширүүн үгүүлсэн нь:

- Та түүнтэй зугаалахаараа нэг болсныг бид андахгүй. Зочид буудлын бүртгэлийн дэвтэр дэх тэмдэглэлээс гадна өдий төдий гэрч бий. Ийм мэдээг сонин хэвлэлийнхэн санамсаргүй шүүрээд авчихвал аав, ээж хоёрт чинь ямархан санагдах бол доо? Таны эцэг, эх шиг нэр төрөө эрхэмлэх ямар ч америк хүн охиноо дээрэмчинтэй энгэр зөрүүлдгийг мэдээд лав л баяр хөөр болохгүй нь мэдээж. Тэгэхлээр эсвэл та одоохон үнэнээ хэл, үгүй бол би аавыг чинь дуудаж бүгдийг хэллээ.

Кей түүний зүг гайхан харснаа босч хаалга онгойлгоод цонхны дэргэд гаансаа нэрж зогссон эцгээ «Аав аа, та ороод ирэхгүй юу?» хэмээн дуудсанд тэрээр эргэн харж охиндоо инээмсэглээд орж ирлээ.

- Жентельменүүд минь, юу болоод байна? Би анхааралтай сонсьё.

Цагдаа нар хоёулаа дув дуугүй, харин Кей нөгөөх туршуул Сирианид хандан ихэмсэг зан гаргав.

- За дарга аа, хэлэх гээд байсан юмаа яриач дээ?!

Сирианигийн нүүр минчийж хүрэнтээд ирлээ.

- Охин чинь цагдаагийн ажилтанг алсан хэрэгт сэжиглэгдэж буй этгээдтэй нөхцөж явсныг та нарыг л бодож сонордуулья. Эрэн сурвалжлах ажиллагаанд туслахаас цааргалах юм бол өөрт нь их гай болно гэдгийг бид анхааруулсан. Гэтэл асуудал яаж хүндрээд байгааг охин чинь ойлгохгүй байх шиг санагдлаа. Та л охиндоо хэлж, ойлгуулмаар юм даа.

- Тэгж ч ярихгүй ээ! хэмээн ноён Адамс асуудлыг зөөлрүүлэх санаатай тал засвал Сирианигийн уур хилэн бүр ч бадрав бололтой:

- Таны охин Майкл Корлеонетой учирдаг болоод жил гаруй хугацаа өнгөрөх хооронд олон зочид буудалд эхнэр нөхрийн нэрээр зөндөө хонож өнжсөн байна. Одоо цагдаагийн ажилтныг алсан хэргээр сэжиглэн Майкл Корлеонег хайж байгаа юм. Гэтэл охин чинь эрэн сурвалжлах ажиллагаанд тус болох юмыг хэлэхээс татгалзаад байна. Ийм л юм боллоо. Та ингэх ёсгүй гээд зүтгээд байгаа боловч үүнийг нотлоход тун амархан.

- Би таны үгэнд өчүүхэн төдий ч эргэлзсэн юм үгүй ээ. Гэвч таны яриад байгаа шиг гай зовлон охинд минь учрах ёсгүй. Хэрэв та нарын хэлдгээр миний охин «шалиг эм» биш л бол тэгж балрахгүй. Та нар тэгж ярьдаг биз дээ?

Эцгийнхээ яриаг анхааралтай сонсож байсан Кей цагдаа нарыг өөрсдөд нь ч үл мэдэгдэхээр доромжлоод байгааг ойлгосон боловч одоо хүртэл ийнхүү биеэ барьж чадсанд нь их гайхжээ.

Эрхэм Адамс хэсэг азнаснаа:

- Би таны үгэнд нээрээ итгэж байгаа шүү, эрхэм ээ! Хэрэв та нарын эрж сураад байгаа тэр

залуу манайхаар үзэгдэх л юм бол одоогийн нөхцөл байдлыг харгалзан зохих газарт нь нэн даруй мэдэгдэхээ миний бие өөрийн иргэний үүргээ хэмээн үзнэ. Миний охин ч мөн адил. Харин одоо уучлаарай, хоол маань хөрчих гээд байна... хэмээн эелдэг боловсон атлаа эрс шийдэмгий байдлаар цагдаа нарыг босго давуулан гаргасан даруйдаа хаалгаа яаран хааж түгжлээ.

Дараа нь тэрээр Кейг гараас нь хөтлөн хонгилын мухарт байдаг галын өрөөг зүглэн:

- Хонгор минь явья, ээж чинь хүлээгээд тэсч ядаж байгаа гэсэнд Кейгийн хямарсан сэтгэл нь тавирч, хүнд хэцүү үед туслан дэмжсэн аавдаа баярлахдаа хоёр цэнхэр нүднээсээ сувдан хэлхээ унагав. Ээж нь охиныхоо нулимсыг хараагүй дүр үзүүлсэнд Кей суудлаа эзлэх зуур «Цагдаа нарын ирсэн тухай аав хэлээд амжиж дээ» хэмээн бодлоо. Тэр даруйд ээж нь түүнд хоол аягалан гурвуулаа мөргөл уншаад хооллож эхлэв,

Хэзээ ямагт үсээ нямбай самнаж, цэвэрхэн хувцасладаг Адамс авхай жаахан махлаг боловч залуугаараа харагдахаас гадна сэтгэлээр унан санааширсан юм уу, цөхрөнгөө баран алмайрсан байхыг нь Кей л лав нэг ч удаа үзээгүй бөлгөө. Адамс авхай охиноо огт эрхлүүлдэггүй, бишрэн хүндэтгэх хүлцэнгүй байдлаар хүмүүжүүлсэн бөгөөд ер нь сэтгэлийн хөдөлгөөнөө ил гаргах нь ёсон бус гэж үздэг бөлгөө. Энэ удаад ч гэсэн мөн л тиймэрхүү янзын өнгө аястай:

- Кей, сүйдтэй юм болоогүй байхад уйлж унжаад яах вэ, хөө! Дартмутын оюутан хүн ийм бузар хэрэгт орооцолдох нь юу л бол? гэсэнд Кей ээж өөдөө гайхан харлаа.

- Майкл Дартмутаг сурдгийг та яаж мэдээ вэ?

- Өө, хөөрхий! Мөн их юм нуув аа, чи? Аав бид хоёр чинь бүр эхнээс нь бүгдийг мэдчихээд ганцхан чиний хэлэхийг л хүлээгээд байсан юм.

- Та нарт Майклын гэр бүлийнхний тухай яаж хэлэхээ мэдэхгүй самгардаад л би дуугүй яваад байлаа л даа. Гэнэт дуулгахад муужраад ойччихвол яана? хэмээн ичиж зовсон Кей арай ядан дуугарсанд Адамс авхай түүний үгийг хүлээн зөвшөөрлөө.

- Урьдаас мэдээгүй байсан бол ч ухаан алдахаар л байлаа. Хөөе, үнэхээр чи Майклын тухай юу ч мэдэхгүй юм уу? Чамд юу ч дуулгаагүй юу?

Кей толгой сэгерэн:

- Тэрээр ямар ч хэрэгт орооцолдоогүй гэдэгт би бүрэн итгэж байна гэх зуураа аав ээж хоёрынхоо нэг л жигтэй харц солилцохыг ажиглаж амжжээ.

Эрхэм Адамс их л цэрвэн болгоомжилсон янзтай:

- Тэр үнэхээр гэм буруугүй атлаа сураггүй алга болсон бол нэг л учир байна. Алаг эрээн хорвоо дээр аль алдаж онохыг тэр гэх вэ? гэсэнд нэг хэсэгтээ эл үгс Кейгийн ой тойнд буухгүй байснаа гэнэт ойлгомгогц тэрбээр ухасхийн босч гүйхээрээ гарч оджээ.

Гурван хоногийн дараа Кей Адамс хөлсний тэргээр Лонг-Бич орж, эрхэм Вито Корлеонегийн байрны гадаа буув. Тэрээр ийнхүү ирэх тухайгаа урьдчилан мэдэгдсэн учир түүнийг хүлээж байгаа нь дамжиггүй. Гэвч Том Хейген хаалга онгойлгож өгсөнд: «Энэ хүн надад юу ч хэлэхгүй, бүх юм ойлгомжтой» хэмээн бодоод Кейгийн урам нь хугарчээ.

Том түүнийг зочдын өрөөнд урьж оруулаад дарс аягалж өгөв. Байшин дотор танихгүй хүмүүс хөлхөлдөөд

Санни ер үзэгдэхгүй тул Кей арга буюу Том Хейгенээс шууд асуулаа.

- Майк хаана байгааг та мэдэхгүй биз, Түүнтэй холбоо барихад минь тус болж үзээч?

- Тэрээр амьд мэнд явааг л танд хэлж чадах байна. Харин хаанаас олж болохыг бид мэдэхгүй. Цагдаагийн тэр ахмадыг буудахад Майкл өөрөө энэ хэрэгт холбогдоно гэж айгаад түр хугацаагаар нуугдчихсан. Хоёр гурван сарын дараа өөрөө танд хэл өгнө биз дээ.

Түүний үг хэн ч ойлгохоор илэрхий хуурамч сонсогдсон нь үнэнийг хэлэх боломжгүйгээ мэдүүлэх гэсэн бололтой. Том ядахдаа Кейг шал мангуу амьтан гэж бодоогүй нь яамай даа.

- Тэр ахмад үнэхээр Майкын эрүүг хугалсан юм уу?

- Тийм л болов уу. Гэвч Майкл хэзээ ч өшөө хонзон өвөрлөж явдаггүй учраас энэ хүн амины хэрэгт огт холбоогүй гэдэгт би бүрэн итгэж байна.

Кей цүнхээ ухаж захиа гаргаад:

- Тэрээр та нартай ярих юм уу уулзвал та үүнийг дамжуулчихгүй юу? гэвэл Хейген толгой сэгсэрлээ.

- Танаас захиа авсныг минь шүүх хурал дээр илэрвэл Майкл хаана байгааг мэдсэн мөртлөө нуугаад хэлээгүй гэж тангарагтны шүүгч нар намайг яллах болно. Та жаахан тэвчиж үз, Майкл тантай холбоо барих аргаа яаж ийгээд олохдоо л олно.

Энд суугаад ямар ч нэмэргүйг ойлгоод Кей аягатай дарсаа ууж дуусмагц бослоо. Хейген түүнийг гаргаж өгөхөөр даган явтал тэр хоёр тас хар хувцастай хижээл авгайтай гол хаалган дээр золтой л мөргөлдчихсөнгүй. Кей Майклын ээжийг таниад бэрэгшээн мэндчилэв.

- Амар байна уу, хатагтай Корлеоне! Таны бие сайн биз дээ?

Авгай агшин зуур Кейгийн толгойноос хөл хүртэл нь гүйлгэн харснаа гар сунган мэндлээд гэнэт огт санаандгүй байтал үрчлээтэй хорчгор нүүр нь эелдэг дотно дулаахан инээмсэглэлээр тэнийгээд явчихлаа.

- Аа, чи Майклын минь хүүхэн үү? Чамайг эд нар хооллов уу? хэмээн тэрээр хачин их итали аялгатай дуугарсан тул Кей юу гэснийг арай гэж ойлгоод юм идэхгүй гэж толгой сэгсэртэл авгай өөрийнхөөрөө ойлгон: - Хөөрхий энэ бүсгүйд аяга кофе уулгачхаж болно оо доо? Чи яасан ичих нүүрээ элгэндээ наасан амьтан бэ?» хэмээн Том Хейгенийг толгой түрүүгүй

загнаж гарав.

- Одоо чи кофе ууж, жаахан юм идчих. Дараа нь манай залуус чамайг машинаар хүргэж өгнө. Чам шиг залуухан хүүхнүүд хот дүүргийн галт тэргээр ганцаараа сэлгүүцэх нь надад ер таалагдахгүй байна.

- Би Майклтай холбоо тасраад тун удсан болохоор түүний тухай сураг дуулах санаатай явна. Ноён Хейген хэлэхдээ хэн ч юу ч мэдэхгүй, өөрөө чимээ өгтөл нь хүлээ гэх юм.

Том Хейген яаран ярианд оролцож:

- Ээж ээ, одоохондоо өөр хэлэх юм бидэнд байхгүй шүү гэвэл хатагтай Корлеоне Том өөд тун ч янзгүй, зэвүүрхэн харав.

- Чи чинь миний юу хэлэх, хэлэхгүйг арай заах гээгүй биз? Эр нөхөр минь хүртэл хэзээ ч зааж сургадаггүй юм шүү. Бурхан түүнийг өршөөг!

Кей авгайг сатааруулах санаатай асуусан нь:

- Ноёнтон Корлеонегийн бие яаж байгаа вэ?

- Овоо дээрдэж байгаа. Гэхдээ өвгөрч, зөнөглөж дээ, хөөрхий. Тэгээгүй бол яалаа гэж хэдэн шалдан банди нарт буудуулж байх вэ дээ? хэмээн хатагтай Корлеоне хариу өчөөд толгойгоо тогшиж хачин занах нь Их эцгийг хүндэтгэсэн шинжгүй.

Кофе ууж дуусаад хатагтай Корлеоне дахин Кейгийн гараас барьж, нөгөө алгаараа гар дээрээс нь аяархан алгадаад:

- Чи Майклаас захиа хүлээгээд нэмэргүй. Тэр чинь хэнд ч юу ч бичихгүй, хоёр гурван жил, түүнээс удаан ч нуугдаж магадгүй. Чи түүнийг хүлээж шар махаа хатаахын оронд гэртээ харьж, олигтойхон залуу олоод суучихвал хавьгүй дээр дээ, чамд - хэмээн тун тайван буурьтай үгүүллээ.

Кей цүнхнээсээ захиагаа гаргав.

- Энэ бичсэнийг минь та түүнд хүргүүлж болохгүй юу?

Майклын эх захидлыг авч Кей руу сүрхий харснаа хацрыг нь хайрлан иллээ.

- Тэгэлгүй яах вэ? Санаа зовсны хэрэггүй.

Хейген ярианд оролцох санаатай өндөлзсөн боловч авхай италиар тас загнаад Кейг өөрөө үдэн гаргаж хацар дээр нь шовхийлгээд:

- Чи Майклыг бодоод санааны гарз. Тэр одоо чамд хань болохоосоо нэгэнт өнгөрсөн.

Хэдийн үүдний харалдаа хүлээн зогсоо машины арын суудалд хоёр эр хүлээн сууснаа Кейг

суулган Нью-Йорк руу зочид буудалд хүргэхээр явах замдаа хэн хэн нь үг дуугарсангүй. Кей энэ хооронд голын хайртай Майкл нь цадигаа алдсан алуурчин гэдэг бодлыг хүлцэн хүлээн зөвшөөрөхийг оролдож ядсаар явлаа. Гэвч хамгийн найдвартай эх сурвалж болох Майклын ээжийнх нь амнаас юу болсныг сонссон хойно Кей одоо эргэлзэх хэрэггүй болжээ.

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Хорвоо ертөнц тэр чигээрээ үгсэн өөрийнх нь эсрэг хандсан шиг Карло Риццид санагдана. Эрхэм Корлеонетой худ ураг болсон хэрнээ Манхэттены бөглүү зэлүүд газар Ист Сайдад нэг муу арчаагүй морин тойруулгын контороос өөр олигтой юм олж аваагүй юм чинь уурлаж бухимдахаас өөр яах юм бэ? Лонг-Бич дэх Их эцгийн байшингуудын аль нэгнээс хүнийг нь хөөж гаргаад Конни тэр хоёрыг оруулж суулгана гэж сэхүүн юм бодсоныг яана гээ? Тэрбээр гэр бүлийн бизнесийн гүн дунд орж идэвхтэй хөдлөн амархан хөлжинө гэдэгт хормын төдий ч эргэлзэхгүй явсан чинь Их эцэг түүнийг ажил төрөлдөө хавьтуулсангүй, хүргэн хүүгээ зүй ёсоор үнэлсэнгүйд нь гоморхон: «Үхсэн хойноо л агуу Их эцэг бол?!» гэж дотроо бодон шазуур зуужээ. Зүгээр нэг гудамжны гуйлгачин шиг гадаа буудуулж байгаа хөгшин зөнөг нэгэнт л тэгсэн юм чинь нам буудуулсан бол аштай юу?! Санни тэр хоёр багаасаа үй зайгүй үерхэж явсан болохоор Санни Нам толгойлох юм бол тэнгэрийн умдаг атгалаа л гэсэн үг дээ, уг нь.

Рицци кофе аягалж байгаа эхнэрээ зэвүүцэж ярвайн харж суулаа. Тэнгэр минь, ямар арчаагүй амьтантай суучхаа вэ? Хадамд гараад хагас жил ч болоогүй байхад бие галбир нь танагаа алдаад гэдэс нь гэж харсаар байтал бүдүүрэх юм. Ер нь энэ италийн зүүн мужийн хүүхнүүд зөвхөн шүргүүлээд өнгөрөхөд л жирэмсэлдэг байх аа!

Тэрээр урагш тонгойн Коннигийн лужир гуян дээрээс чимхээд авсанд авгай нь аятайхан инээмсэглэсэн боловч Рицци зориуд доромжилмоор санагджээ.

- Чиний гуяыг харсан ямар ч гахай атаархаж үхэх юм байна даа.

Гомдсондоо болоод Коннигийн царай урвайж, нүдээр нь нулимс цийлгэнэхийг Карло хараад бах нь ханаж бүр маадайлаа. Конни агуу Их эцгийн охин л юм байгаа биз, гэхдээ одоо түүний өмч болсон юм чинь түүнтэй яаж ч харилцсан явдаг юм бэ? Тэр түүний авгай, түүний дэвсгэр гэж бодохоос Карло биеэ улам тоож, хүч чадал улам нэмэгдэх шиг санагдана.

Карло бүр эхнээс нь ширүүн гараар барьж, өөрийн зоргоор бүхнийг шийдсэн нь тун зөв болсон. Авгай нь хуримын бэлэгний мөнгө дүүрэн чихсэн цүнхээ өгөхгүй гэж зөрүүдлэхээр олон юм ярьсан ч үгүй өрөөсөн нүдийг нь булуу болтол дэлсчхээд хамаг мөнгийг нь хамж авчээ. Түүнээс хойш Карло энэ талаар дахин үг цухуйлгаагүй тул тэр мөнгийг яаж, юунд үрснийг эхнэр нь одоо хүртэл мэдээгүй яваа. Тэгсэн нь ч болсон юм. Хэрэв тэр үүнийг мэдсэн бол их гай чирч болзошгүй байснаас гадна Карло өөрөө ч гэсэн арван таван мянгыг эмс хүүхэн, шөнийн цэнгээнд яаж үрчихсэнээ үл ойлгон гайхсаар яваа бөлгөө.

Эхнэр нь хараад байгааг Рицци ар дагзаараа мэдэрч зориуд биеэ чангалан, нимгэн хувцасны цаанаас илт гүрэлзэх булчин шөрмөсөө гайхуулан гар сунгаж зууш авав. Шарсан өндөг, гахайн махаа аль хэдийнээ идчихсэн боловч ийм том хүн сайн хоол их идэлгүй тун горьгүй.

Ер нь яг Карло шиг булчинлаг ханхар цээж, нарийхан бэлхүүстэй, шөрмөслөг чанга гартай, шар үстэй хүнд ухаангүй дуртай гэж эхнэр нь өөрөө хэлж эр нөхрөө ямар ч хүүхнийг уярааж чадна хэмээн ойлгуулсан тул тэрээр эрийн чадалдаа нээрээ үнэмшин их л додигор явдаг

байв. Карло Загалмайлсан эцгийн Намд хүчин зүтгэдэг ямар ч шалчгар эрсийн дэргэд, тэр ч бүү хэл Клеменца, Тессио Рокко Лампоне зэрэг шадар туслахуудыг бодвол жинхэнэ эр хүн шиг харагддаг шүү дээ. Саяхан шилээр нь нар харуулчихдаг тэр Паоло Гатто ч гэсэн доождоогүйдээ л алуулсан хэрэг. За тэр ч яахав, буянаараа болоо биз. Хэрэв дангаараа халз үзэх юм бол Карло хэдий өөр жинд тоглодог ч гэсэн Санниг дийлнэ. Хүн зон Саннигийн талаар элдэв долоон юм ярьдаг боловч нэгэнт Карлогийн найз нарын тоонд ордог тул хэрэв Их эцэг өнхрөөд өгвөл тэрээр л лав харамсаж халаглаж сүйд болохгүй дэг.

Карло Рицци уруу царайлан аяга кофе очиж суулаа. Орон гэртээ хүртэл тэрээр мөрөөрөө бариу пиджак өмссөн юм шиг сэтгэл давчдан, гүйцсэн контортоо очиж уйтгартай ажлаараа зууралдана гэхээс толгойтой үс нь өрвийх шиг болно. Үдээс өмнө л тэр ажлаа яаж ийгээд амжуулахгүй бол ням гаригт хэзээ хэзээнээс зав муутай дээр нь бас америк хөл бөмбөгийн тэмцээн, морин тойруулгын уралдаантай тул тун горьгүй. Тэнгэр минь, ямар уйтгартай хорвоо вэ?

Конни ард нь нэг юм шар шурхийлгэхээр дургүйцэн эргэж харвал авгай нь хувцаслаж байв. Тэрээр бахь л байдгаараа ямар ч утга учиргүй, цэцгэн хээтэй хачин тод өнгөтэй, олон нугалаа бүхий хөлхийсөн ханцуйтай торгон палааж өмсөж дээр нь бас бүдүүлэг хийцтэй алтан ээмэг бугуйвч зүүсэн нь хорьтой хүүхэн биш дөчтэй авгай шиг харагдах ажгуу.

- Чи чинь тогос шиг гоёж гоодоод хаачих нь вэ?

- Лонг-Бич орж аавыг эргэе. Хэвтрийн хэвээрээ л байгаа шүү дээ. Ганцаараа уйдаж байгаа биз.

Карлогийн чих нь соотойн нүд нь сэргэж:

- Тэгвэл одоогоор Санни тэнд бүхнийг захирсан хэвээрээ юу? - гэвэл эхнэр нь ер ойлгосон шинжгүй:

- Бүхнийг захирсан хэвээрээ гэдэг чинь юу гэж байгаа юм бэ? хэмээн маанагтахаар нь Карлогийн хамаг цус нь хөөрч, зүрхний хилэн дүрэлзээд явчихлаа.

- Аа, өөдгүй муу новш! Ийм янзаар надтай ярьж яаж зүрхлээ вэ, чи? Олон юм донгосоод байвал өлөн гэдсийг чинь хөлд чинь ороогоод хаячихна шүү!

Коннигийн царай айсандаа зэвхийрэн таталдаад ухаан зүггүй ухарч давхисан нь Карлогийн уурыг бүр ч дэврүүлжээ. Тэрээр багтрах шахан, ухасхийнгүүтээ авгайнхаа хацрыг хар хүчээрээ алгадаад автал таван улаан зурвас татаад, дахин тас тас хийтэл гурав алгадаад авсан чинь Коннигийн дээд уруул пимбийж хавдан хамраас цус гарав. Зөвхөн үүнийг хараад л сая ухаан орж, ийм илэрхий ул мөр үлдээж хэрэггүй байснаа ойлголоо. Түүнийг дөнгөж цааш эргэмэгц Конни хажуугаар нь шурхийн гарч унтлагын өрөөндөө орж үүдээ янгинатал түгжсэнд Карло тачигнатал хөхөрч ширээндээ буцаж суугаад өөртөө дахин кофе аягалж авав.

Дараа нь тамхиа баагиулж сэтгэл хангалуун хэсэг сууснаа нэгэнт ажилдаа явах цаг нь болсон тул унтлагын өрөөний үүдэнд очиж түлхсэнээ:

- Онгойлгохгүй бол чинь цөм өшиглөлөө шүү хэмээн зандарвал хаалганы цаана таг чиг байсанд:

- Битгий тэнэглээд бай, би хувцасламаар байна шүү дээ гэлээ.

Орны пүрш хяхтнан, шал шал гэх хөлийн чимээ ойртон цоожны түлхүүр арай ядан чахарсаар эргэв. Түүнийг босго алхахад авгай нь нүүр буруулан орон дээрээ цаашаа хараад хэвтээд өгсөн энэ завшааныг ашиглан яаран хувцсаа өмсөх зуураа палаажаа тайлаад халаадаа өмссөнийг нь ажиглаж амжжээ. Уг нь Конни аав дээрээ очоод шинэ сонин мэдээ дуулаад ирсэн бол аштай юу гэж бодоод тэрээр асуусан нь:

- Хөдөлж цөхөөд байх чинь, ганц хоёр алгадуулаад л хэдэн мөчөө эвлүүлэх тэнхээгүй болчхоо юу? Мөн ч залхуу мэлхий бол доо!

- Би өнөөдөр тийшээ яасан ч явахгүй гэхдээ нулимс гомдол хоёр хоолой дунд нь холилдож хутгалдаад хариу хэлсэн үг нь хэр баргийн хүнд ойлгогдохын аргагүй байсан тул Карло мөрнөөс нь угзран эргүүлж харлаа. Үнэхээр тэрээр санаснаасаа илүү хүчтэй алгадаж, нөжирч памбайсан дээд уруул нь хамартайгаа нийлэх шахаад хажуунаас нь харахад шовойх юм алга.

- За, тийм байдаг байж. Ням гаригт хамгийн их ажилтай, эрт ирнэ гэж бүү горьдоорой гээд Карло гадаа гарч машиндаа ортол буруу газар тавьсны торгуулийн ногоон тасалбар салхины шилэн дээр нь хавчуулсан байлаа. Иймхэн зүйлд гонсойдоггүй Карло эл тасалбарыг бээлийний хайрцагт байгаа ижил төрлийн хорин долоон тасалбартай нийлүүлж хийгээд таг мартжээ. Вито Корлеонегийн төрсөн охиныг доромжлох бүрдээ түүний сэтгэл сэргэж, ихийг бодоод дутууг авч чамлахын ихээр чамлаж яваа гоморхсон зүрхээ жаахан ч болов тайтгаруулдаг юмсанж.

Хуримын шөнө анх удаа авгайдаа гар хүрээд Карло тоглоом ч үгүй айж эмээсний учир нь гэвэл, Конни тэр дороо л Лонг-Бич рүү хурдлан хүрч, доод зовхиныхоо хөх няцыг аав ээждээ харуулан өмөг түшиг эрж өрөвдүүлэхээр явсан байна. Гэтэл эхнэр нь эзэндээ цохиулсан нохой шиг шалдаа бууж ирээд бусдад үлгэр жишээ болохоор жинхэнэ итали эхнэр шиг аяг зан гаргасан аж. Нэг талаар цочирдож мэгдсэн Карло Рицци гайхаж эргэлзээд хоёр нарны хооронд хайртай авгайдаа хамаг байдгаараа дур хүслийг нь хангахын төлөө хүчээ шавхан дайчилж өө сэвгүй эр нөхрийн дүр эсгэсээр хэдэн долоо хоног. Тэгээд эцэст нь гэрлэх ёслолын анхны шөнө эр нөхөр нь зүгээр л согтсондоо элдвээр аашилсан гэж бодоод Конни тэр өдөр юу болсныг тодорхой ярьжээ.

Гэтэл аав ээж хоёр нь Конниг ер хайрлаж хөөрхийлсөнгүй, харин ч бага зэрэг сониучирхан тоглоом тохуу хийснээс өөр юмгүй. Чин үнэнийг хэлэхэд ээж нь Конниг эмэгтэй хүний хувьд өрөвдөн, хар хүнтэй нь сайн ярихад илүүдэх юмгүй гэх ухааны үг цухуйлгасан боловч Их эцэг эрс татгалзсан байна.

- Энэ миний охин ч гэсэн эдүгээ эр нөхрийн гарт орсон болохоор тэр нь гэр орондоо эмх журмаа өөрийн дураар тогтоох нь зүйн хэрэг. Одоохон гэртээ хариад нөхөртөө дахин зодуулахгүй байхаар бүхнийг хийсэн чинь дээр дээ.

- Гэхдээ чи ээжид ганц удаа ч болов гар хүрч үзсэн гэж үү?

Конниг багаасаа эрхэлж, аав ээждээ хамаагүй аашилж сурсны эрхээр ингэж хэдэрлэх зүрхтэй байсан тул Их эцэг ер ажирсангүй.

- Миний авгай тэгж зодож нүдэх аян шалтаг хэзээ ч гаргаж байгаагүй.

Коннигийн эх эл үгсийн баталгаа болгон нүүр дүүрэн мишээв. Гэсэн ч Коннигийн санаа амарсангүй.

- Гэхдээ миний нөхөр бэлэгний мөнгөний цүнх булаагаад авчихсан шүү дээ. Тэгээд тэр мөнгийг яах гэж байгаагаа ч хэлээгүй нь тун ч гомдолтой хэмээн үглэж гарав.

- Эр нөхрөөсөө ялих ялихгүй юм харамлаад янзын зан гаргадаг зөрүүд, хорлонтой. эхнэртэй хүзүү толгой холбосон бол би ч гэсэн нэг их ёсорхох үгүй байсан гэж эцэг нь хайнгадуу дуугарсан тул аавын хайртай ганц охин хэдий хачирхан гайхсан авч арга буюу гоморхол бачимдлаа шүдэн завсар зуусаар гэртээ харьжээ.

Гэвч үнэн хэрэг дээрээ бол Их эцэг ганц хайртай охиныхоо хэрэг явдал, зовлон зүдгүүрийг ер анхаарч хайхарч үзээгүй юм биш ажээ. Тэрээр охиноо бодвол нэн даруй арга хэмжээ авч, хүргэн нь Намын гишүүдээс хандивласан хуримын бэлгийг чухам юунд зарцуулсныг лавтай магадалсан байна. Их эцэг Рицигийн бооцооны конторт өөрийн хүнтэй байсан тул хүргэний нь алхах гишгэх бүрийг Том Хейген цаг тухайд нь олж мэдээд Загалмайлсан эцэгт дуулгадаг байжээ. Гэвч Их эцэг охиныхоо гэр бүлийн хэрэгт хөндлөнгөөс оролцох хэрэггүй гэж үзсэн аж. Эхнэрийнхээ хамаатан садангаас айн дагжиж амьдрах юм бол яаж Рици жинхэнэ эр хүн, нөхөр хүн шиг байх юм бэ? Гэхдээ байдал улам хурцдаж, Рици арван таван мянгыг эмс хүүхэн, наргиан цэнгээнд үрчхээд байхад Их эцэг түүнтэй ярихаас цэрвэсэн хэвээр л байлаа. Дараа нь Конни хөл хүндтэй болж, Их эцэг ийнхүү харзсан хүлээсэн нь зөв болсонд бүрэн итгэв. Заримдаа охин нь эр нөхрөө ээждээ муулан тэр гомдлыг нь Их эцэгт сонордуулах авч ердөө л мөрөө хавчин гараа алдлахаас цаашгүй.

Эцсийн эцэст цөхрөнгөө барсан Конни нөхрөөсөө сална гэж хэлж хүртэл үзсэн боловч эцэг нь амьдралдаа анх удаагаа охиндоо уурлаж хорон үгээр тагласан байна.

- Яаж байгаа чинь тэр вэ? Карло хүүхдийн чинь эцэг байхад төрсөн үрээ амьдаар нь өнчрүүлэх гээ юу?

Хэрэв Загалмайлсан эцэг ийм хүлцэнгүй зан гаргаад байх юм бол ямар ч аюулгүй гэж Рици бодсоноор үл барам авгайгаа гэдэстэй болсноос хойш тоохоо ч больсноо ажлынхаа газрын хоёр хүнд сайрхаж ярьсан байна. Агуу Их эцгийн төрсөн охины тухай хэлж буй тул Сэл Рэгс, Коуч хоёр даргынхаа донгодон донгосохыг хүндэтгэсэн царай гарган сонсжээ.

Гэхдээ Санни Корлеоне дүү хүүхнийхээ гэр бүлийн амьдралын талаарх яриаг сонсоод яаж уурласныг мэдсэн бол Рици ингэж хамаа намаагүй чалчих нь юу л бол?! Зөвхөн эр эмийн хооронд илжиг бүү жороол гэсэн Их эцгийн хатуу тушаал л Саннигийн уур, гарыг хорьж, хүргэн дүүгийнх нь амийг аварчээ. Тийм учраас булбарай хөөрхөн Конниг нь зодож нүддэг

өөдгүй муу

новшгой тааралдвал биеэ барьж чадахаа болиод уурандаа яаж ч мэднэ хэмээн болгоомжилсон Санни хүр дүүтэйгээ нүүр учрахаас аль болохоор зайлсхийх болжээ.

Өөрт нь ямар ч гай тохиолдохгүй гэдэгт бүрэн итгэсэн Карло Рицци цорхиртлоо уйлсан эхнэрээ гэртээ орхиод машиндаа сууж, Ист-Сайдын зүг Есдүгээр гудамжаар хурдалж явах үеэр хэрэг явдал иймэрхүү л байлаа. Яг тэр үед Саннигийн машин булан тойрон гарч ирээд гэрийнх нь үүдэнд зогсохыг яаж ч харах юм билээ дээ?!

Санни Корлеоне нууц амрагтаа тэмүүлэх хүсэлдээ хөтлөгдөн Лонг-Бичээс гарч хот ороод Люси Манчинигийнд хоног тааруулжээ. Тэрбээр Люситэй өдрөөр тун ховорхон уулздаг тул түүнийг хот руу явахад нь отон хүлээх аюул бага.

Харин энэ ням гаригт нэгэнт Нью-Йоркийн төвд ирснийх амралтын өдрөөрөө эцэг эх дээрээ очиж заншсан дүү хүүхнээ аваад явмаар санагджээ. Карло өнөөдөр ажилтай, тэгээд ч тэр муу новшийн харамч эр эхнэртээ машин гаргаж өгнө гэдэг санахын ч гарз болохоор Санни дүүтээ суулгаад явалгүй яах вэ.

Тэд гол хаалганы дэргэд зогсож, бие хамгаалагчдын хоёр нь түрүүлэн Санни араас нь дагалдаад, машинд үлдсэн хоёр бие хамгаалагч нь гудамжийг бүхэлд нь хараандаа аван хоцорлоо. Дөрвөн хүн дагаж явдгийн учир нь гэвэл онцын шаардлага гараагүй үед аз туршихын хэрэггүй гэж зөвлөлдсөний үр дүн бөлгөө. Дайсагнах этгээд нь яг одоо энд ирнэ гэдгийг мэдэж отох бололцоо бараг байхгүйтэй адил боловч Санни юм бүхнээс болгоомжлох, өвсний толгой бүрээс ч сэрэмжлэх ёстойг Намуудын хооронд дэгдсэн түрүүчийн тулаанаас ойлгож авчээ.

Ямар ч цахилгаан шатны тэжээлийг тасалчихвал сайхан урхи болдгийг Санни сайн мэдэхийн эрхээр өргүүрт орсонгүй, шатаар гүйсээр дөрвөн давхарт гарч, нэгэнтээ гэрэл анивчуулаад далд орсон Карлогийн машиныг нүдний булангаар харсан тул дүү нь гэртээ лав байгааг мэдээд хаалга хүчтэй балбав. Хаалга онгойлгож өгсөнгүй. Тэрээр дахиад чанга нүдсэн чинь:

- Хэн бэ? гэсэн дүүгийнх нь айж эмээсэн, цэрвэж болгоомжилсон дуу сонсогдоход Санни үнэхээр их гайхлаа. Конни бүр хар нялхаасаа сэргэлэн цовоо өсч, өөрийгөө хамгаалах, наргиан наадам хийх талаар хэнийг ч дагуулахгүй хүн байсан чинь ийм аймхай, үлгэн салган дуугарах болтлоо хөөрхий минь ямар их дарлуулаа болоо?!

- Конни, онгойлгооч? Би байна!

Түгжээ тар хийн хаалга савж нус нулимсандаа хутгалдсан Конни түүнийг тэврэн авлаа. Санни огт санаандгүй байсан тул нэг хэсэгтээ балмагдаад үг дуугарах ч сөхөөгүй зогссоноо дүүгээ цаашлуулан хөх няц болон хавдсан нүүрийг хараад хамаг учрыг дор нь ойлгов.

Саннигийн уур хилэн цээжиндээ багтаж ядан оволзож, адгийн муу шаар Карлогийн хойноос ухасхийсэн боловч Конни хоёр гараас нь тас зуураад тавьж өгсөнгүй. Дүү нь Санниг чирсээр байгаад гэртээ оруулж, анх гомдсондоо уйлсан бол одоо айсандаа нулимс асгаруулсаар

ахьгаа арай гэж сандалд суулгалаа. Тэрээр Саннигийн цочмог ууртай, түргэн гартайг сайн мэдэх бөгөөд эр нөхрийнхөө элдэвлэн маяглах болгонд ахдаа юу ч хэлэлгүй явсаар ирсэн нь лав л тохиолдлын чанартай мартамхай зан яав ч биш.

- Би өөрөө л маажих самардах гэж зүтгээд зангидсан нударгыг нь нүдээрээ мөргөчихсөн юм. Түүнээс биш тэрээр ер ингэж хүчтэй цохих гээгүй.

Саннигийн царай агшин зуур хөгширч үрчийсэн амрагийн бурхан Купидоны чулуун хөшөөнийх шиг царцан хөшиж орхив.

- Чи өнөөдөр Лонг-Бич орохгүй биз? Чамайг аав дээр очиж магадгүй гэж бодсондоо л хот орсных гээд дайраад гарлаа.

Конни үнэн гунигтай толгой сэгсэрлээ.

- Намайг ийм болчихоод байгааг аав ээж хоёр хараад хэрэггүй биз ээ. Дараа очимз.

- За яахав, дураараа л бол хэмээн Санни аяыг нь дагаад харилцуур авч: - Би эмч дуудаж, наад нүүр амыг чинь янзлуулъя. Уг нь чи биеэ бодмоор юм даа! Хэзээ төрөх вэ? гэв.

- Хоёр сарын дараа. Гэхдээ чи, Санни элдвээр бүү аашлаарай, чамаас гуйя!

Санни ёстой л ходоодны мухраас наг наг хөхөрч хорлонтой инээмсэглэн:

- Хонгор дүү минь санаа бүү зов, наадах хүүхдийг чинь би л лав төрөхөөс нь өмнө өнчрүүлэх гээгүй байна хэмээн дүүгээ энхрийлэн хацар дээр нь үнсээд гарч одлоо.

Ист-Сайдын Зуун арван хоёрдугаар гудамж дахь нарийн боовны бяцхан дэлгүүрийн хаяг дор нуугдсан Карло Риццигийн бооцооны газрын өмнө автомашин хоёр эгнэн ярайж, «хөнгөн гартай» хэмээн азаа туршихаар хүүхдүүдээ дагуулсан аав нар бараг л босгон дээр жагсан суужээ.

Тэд нар Карло Рицциг олж хармагцаа хамгийн шийдвэрлэх мөчид саад болж мэдэх хүүхдүүдээ мөхөөлдөсний мөнгөөр хууран холдуулж, өнөөдрийн тэмцээний зар нийтэлсэн сонин руу нүдээ бэлчээнэ.

Карло тэднийг ер тоосонгүй өнгөрөөд ажлын өрөөнд явж орвол туранхай боловч шөрмөслөг Сэл Рэгс, зүгээр л Коуч гэж дууддаг мангар эр хоёр аль хэдийн хүлээгээд зогсож байлаа. Тэд дөрвөлжин шугамтай бүртгэлийн зузаан дэвтэр өмнөө дэлгээд өнөөдөр хөл бөмбөг тоглох дээд зиндааны арван зургаан багийн нэрсийг самбар дээр хос хосоор нь нямбайлан бичиж, ард нь бооцооны хэмжээ тавих хоосон зай үлдээжээ.

Рицци шув шулуухан явсаар харилцуур авч эрэгдээд одоо тоглох багуудын оноог сонсон самбар дээр тэмдэглэж авлаа. Сэл Рэгс, Коуч хоёр хэнэггүй царайлан зогсох боловч энэ бүх тоог хэдийн дуулж мэдчихээд одоо түүнийг хянан ажиж буйг Карло яахан мэдэх билээ?!

Рицци эл бооцооны газар ажилласан эхний долоо хоногт утсаар дуулсан мөрийний тоог

самбарт бичихдээ андуурч, бооцоолсон бүх хүний бахыг хангасан ажээ. Үүний үр дүнд эрхэм Вито Корлеонегийн хүргэндээ бэлэглэсэн контор зургаан мянган доллароор хохирч, эл бүтэлгүй эрийн үйлдэл бүрийг нүд салгалгүй тандаж байхыг Их эцэг чандлан тушаахаас өөр аргагүйд хүрсэн юмсанж.

Уг нь бол Корлеонегийн гэр бүлийнхэн ийм аахар шаахар хэрэгт тоож оролддоггүй, бооцоологч мэтийн хүмүүс, эрхтэн дархтан хоёрыг дор хаяхад тав зургаан шат дамжлага зааглан тусгаарлах хэдий ч Загалмайлсан эцэг хүргэн хүүгээ ямар хүн болохыг таньж мэдэхийн тулд онцлон үзэж түүний ажил төрлийн талаарх дэлгэрэнгүй мэдээг өдөр болгон Том Хейгенд дамжуулж байхыг хатуу шаардсан байна.

Самбар дээр тоо бөглөж дуусмагц наадагчид нарийн боовны мухлагийн арын өрөө рүү хошууран овооров. Тэдний зарим нь хүүхдээ дагуулж ирсэн харагдана. Багц багцаар нь мөнгө хожих санаатай ирсэн нэгэн эр гараасаа салахгүй зуурсан жаахан охиноос:

- Хонгорхон минь, «Гигантууд», «Пиратууд» хоёр багийн аль нь дээр гэж чи бодож байна? гэв. Сүр бадруулсан нэрийг нь л арай гэж ойлгосон охин өөдөөс нь:

- Аварга биетэн чинь далайн дээрэмчнээс хүчтэй биз дээ? хэмээн сөргүүлж асуусанд бүгдээрээ, эцэг нь ч гэсэн нирхийтэл хөхрөлдлөө.

Риццигийн хоёр ажилтны ширээний өмнө мөрий тавих хүмүүс дараалан зогсож Рэгс, Коуч хоёр бүртгэлийн хуудас бөглөж, дотор нь бооцооны мөнгө хийн нугалаад Карлод өгөхөд тэрээр дээд давхрын нэг өрөөнд орж, утсаар мөрийний хэмжээг дамжуулан мөнгийг нь жижигхэн төмөр шүүгээнд хийгээд буцаж ирнэ.

Бүтэн сайн өдөр хоёр цагаас нааш тэмцээн эхэлдэггүй болохоор мөрийгөө хийчхээд эхнэр хүүхдийнхээ хамт хотын зах руу явж зугаалахаар яаран эртэлж ирсэн гэр бүлтэй наадагчдын халааг ганц бие хүмүүс буюу хонжоо, мөрийндөө хорхойтон ар гэрийнхнээ амралтынх нь өдөр хотын бүгчим сууцанд нь түгжихээс ч буцахгүй сайн эрс залгуулан авна. Наадагчдын эл хоёрдахь урсгал чимээ шуугиан ихтэй, их ч мөнгөөр мөрийцдөг бөгөөд зарим нэг нь гадуур явж жаахан бодоод буцаж ирэхдээ дахин бооцоолох гэж төвөг удах тул чухам эднээс л болоод Рицци, түүний ажилтан нарын ажил нь хүндэрдэг бөлгөө.

Нэг хагасын алдад наадагч олны тоо арай цөөрөөд ирэхээр Карло Сэл Рэгсийг дагуулан тамхи татахаар гадааллаа. Тэр хоёрыг нарийн боовны мухлагийн ар талд цэцгийн мандлын хашлага дээр суух үеэр цагдаагийн машин хажуугаар нь өнгөрөхөд Карло юман чинээ тоосонгүй. Нарийн боовны мухлаг, бооцооны контор хоёр орон нутгийн засаг захиргааны найдвартай хамгаалалтад байгаа юм чинь юунд ч санаа зовох билээ?

Коуч хамгийн сүүлийн хүнд үйлчилж дуусаад бас гарч ирэв. Тэр гурав эр хүний зангаар хөл бөмбөгийн тухай, эмс хүүхний тухай дэмий ярьж суутал Карло сайрхан:

- Өнөөдөр дахиад л хэн нь гэрийн эзэн болохоо мэдүүлэх гээд би эхнэрээ сайн болгож тавьсан гэвэл Коуч хайнга дуугаар сонирхсон нь:

- Хүүхдээ гаргах дөхөж байгаа биз дээ?

- Аа, цаадах чинь яах ч үгүй. Хоёр гурав алгадаад авахад арай дугуу төрчихгүй байлгүй. Тэр бүр давраад, миний хүзүүн дээр мордох санаатай даг шүү. Тэгнэ байх аа!

Наадагчид тарж явах арай л болоогүй, нарийн боовны мухлагийн үүдээр хөлхөлдөн, зарим нь үүдний шатан дээр суугаад хоорондоо элдвийг хөөрөлдөнө.

Гэнэт хашаан дотор тоглон бужигнаж байсан хүүхдүүд тархан бут үсэрч, танк шиг нүсэр машин мухлаг руу хар хурдаараа давхиж ирээд хяхнатал тоормослон зогсохоос нь өмнө, явуут дунд нь нэгэн эр үсрэн буумагц хурсан олны зүг хөлийн хурд мэдэн харайлгасан нь Санни Корлеоне байлаа.

Янаг амрагийн тэнгэр Купидоны чулуун хөшөө лугаа адил хөшсөн царай нь уур хилэнгээр бадарч Карло Риццигийн суугаа газар агшин зуур үсэрч хүрээд түүнийг заамдан чирч гулдарсаар явган хүний зам тийш зүтгэв. Үнхэлцэг нь хагарах шахсан Карло толгойгоо аль болохоор нугдайн шатны төмөр бариулаас тас зууран чаргуулдтал цамц нь Саннигийн гарын аяыг даасангүй, хүү татагдлаа.

Дараа нь хүн бүрийг сандран цочирдуулсан аймаар юм болов. Санни хар чадлаараа Карлогийн толгой түрүүгүй балбаж, цохих болсондоо хачин муухай хашгиран мэддэг хамаг л хараал ширээлээ урсгах нь өөрөө өөрийгөө зоригжуулж байгаа бололтой. Карло өөдөөс нь өрвөлзөхөд хүрэлцээтэй хүч чадал байсан хэдий ч айдас жихүүдэс хамаг булчин шөрмөсийг нь чөдөрлөн барьсан тул ер эсэргүүцэл үзүүлж чадсангүй, тэр ч бүү хэл өршөөл гуйх ч тэнхэлгүй хэвтэх амой. Хэрэв Санни хүр дүүгийнхээ голыг таслахаар шийдсэн бол хоморгонд нь амь эрсдэх илүү маяг гэж бодоод Коуч, Сэл хоёр даргаа өмөөрч зүрхэлсэнгүй.

Ид хорхойтон тоглож байхад нь том машин шуугиж ирээд гацаа болсонд бухимдсан хүүхдүүд жолоочоос хариу авахаар гүйлдэж ирснээ Саннигийн зэрлэг авирласныг хармагц зогтусан, эмэж балмагдсан нүдээр холоос ажин чив чимээгүй зогсоцгооно. Тэр хооронд Саннигийн бие хамгаалагчид хөлөглөсөн машин давхиж ирсэн боловч тэд хүртэл эл хэрэгт оролцсонгүй, зөвхөн хөндлөнгийн хүмүүсээс хэн нэг нь Карлод туслах гэж тэнэглэвэл Санниг хамгаалахаар зэхэн тойрч зогсов.

Ингэж хайр найргүй зодож нүдэж байхад Карло бие хамгаалах, учирлаж тайлбарлах ямар ч оролдлого хийгээгүй нь хачин гайхалтай ч, чухам үүний ачаар л амь мэнд гарсан байх аа. Тэрбээр Саннид чирэгдэн гудамжинд гарчихгүйн тулд шатны бариулын сараалж төмрөөс тас зуурсан хэвээрээ, хүч тэнцүү хэдий ч ямар ч эсэргүүцэлгүй зодуулсаар хадам ахынхаа уур намдахыг тэвчин хүлээнэ. Тэгж тэгж Санни сая нэг юм хоёр гараа савлахаа больж хүндээр амьсгаадан Карлогийн нүүрийг хараад шазуур зуун үгүүлсэн нь:

- Дахиад чи миний дүүд гар хүрвэл цувдай дотрыг чинь цус нөжтэй нь хутгаад хаячихна шүү.

Хачин гайхалтай нь гэвэл Саннигийн ийнхүү занаж зүхэхээр Карлогийн дотор уужирчээ. Нэгэнт л харааж загнаж байгаа л бол одоо алахгүй нь мэдээж. Чухамдаа гэвэл Санни дүүгээ өрөвдөөд хүр дүүгээ нэгмөсөн тонилгочихож магадгүйдээ бухимдсандаа л хараал зүхэл

болсон юмсанж.

Карло хадам ах өөдөө харах зүрх нь хүрсэнгүй, саваа төмрөөс зуурсан чигээрээ л зогсож байтал машин хөдлөх чимээ сонсогдон дараа нь Коучийн жигтэйхэн өрөвдсөн дуу гарлаа.

- За за, Карло, одоо явъя. Олны өмнө зогсоод яах вэ?!

Гагцхүү ингэсэн хойно л Карло шатны чулуун гишгүүрээс зориг гарган харц салгаж, гараа тавиад өндийн харваас тойрон бүгсэн хүүхдүүд ичингүйрэн эмээсэн нүдээр түүнийг ширтэн зогсоно. Санни түүнийг хар хүчээрээ нүдэж балбасан боловч гэмтээж бэртээсэнгүй, болохоор Карлогийн толгой эргэн нүдэнд нь хамаг юм дайвалзаж харагдах нь зодуулснаас бус айснаас болсон байх л даа.

Карло Коучид дүүжлэгдэн явсаар нарийн боовны мухлагийн арын өрөөнд орж цус шүүрээгүй боловч хөх няц болон хавдсан нүүрэндээ мөс наах зуур айж эмээсэндээ салганан чичирхийлсэн бие нь аажим аажмаар тавирсан боловч яаж доромжлуулж дарлуулснаа бодохоос л дотор нь муухай болж, эцэс сүүлдээ бүр огиулж гарлаа. Коуч шал согтуу хүнийг арчлах аятай түүний толгойг түшин барьж дараа нь хоёр суганаас нь дэмжин өргөсөөр дээш нь гаргаж нэг орон дээр хэвтүүллээ. Энэ хооронд Сэл Рэгс салхинд хөөгдсөн хамхуул адил аль хэдийн арилаад өгснийг анзаарах сөхөө Карло Рицид үнэхээр байсангүй.

Гэтэл Сэл Рэгс энэ үеэр Гуравдугаар гудамж орж Рокко Лампеонед сая юу болсныг дуулгаад, тэрээр цааш нь Питер Клеменцад мэдэгдсэн чинь сайхь эр арга тасран:

- Ээ, тэнгэр минь! Галзуу солиотой энэ Санни газрын гаваар далд ороосой! хэмээн ганиран гаслах боловч сүүлчийн өгүүлбэрээ хэлэхийн өмнө утсаа сэрэмжлэн тасалчихсан тул Рокко юу гэж зүхсэнийг нь дуулсангүй.

Питер Клеменца жаахан амьсгаа дараад эл гажиг мэдээг Лонг-Бич рүү хулган хулган дамжуулбал Том Хейген их ядарсандаа юм уу, хэсэг чимээгүй байснаа:

- Саннигийн буцах замд нь аваар осол, элдэв юм болох вий, хоёр машинаар залуусаа явуул. Уурандаа болоод цаадах чинь юу хийж байгаагаа сайн ухаарах тэнхэлгүй болсон шиг байна. Саннигийн хаана, юу хийж явааг эсрэг этгээдүүд маань дуулчихсан ч юм билүү, хэн мэдлээ?! гэв.

Клеменца үүнд эргэлзэн:

- Манай залуусын хот орох гэсээр байтал Санни буцаад ирнэ биз. Тэгээд ч энэ хооронд Татталья яаж ч амжихгүй гэвэл Хейген тэвчээр заан тайлбарлаж үгүүлрүүн:

- Тийм ч болов уу даа! Гэхдээ ямар нэгэн юм Санниг саатуулбал юу болж балрахыг хэлэхэд бэрх. Учир иймд Питер минь түргэлж үз. Бололцоотой бүхнийг хий!

Хорвоо ертөнцийн хамаг бүхнийг хараан зүхсээр Клеменца Рокко Лампеонед утасдаж, Лонг-Бич рүү ирэх замыг тосон хаах даалгавар өгөөд өөрөө дурлан авсан «Кадиллак»-даа гурван

бие хамгаалагчийн хамт сууж, Атлантик-Бичийн гүүрээр гардаг хамгийн дөт замаар Нью-Йоркийн зүг довтолгов.

Гэтэл Таттальяагийн намд мэдээлэгч хийж хөлс авдаг нэгэн эр зодоон болсон мухлагийг тойрон гайхах олны дунд зогсож байснаа ивээн тэтгэгч нартаа нэн даруй хэл өгч Санни Корлеоне хот орж ирээд дөнгөж саяхан хүр дүүгээ нэвширтэл зодсон тухай мэдээлсэн байна. Гэвч Таттальяа дайсагнасан маллагаанд оролцох эсэхээ бүрэн шийдээгүй юм уу, эсвэл үл шалих матаачийн үг Намын удирдлагын сонорт хүртлээ хэтэрхий удсан ч юм уу, ямар ч л гэсэн үүний халуун мөрөөр арга хэмжээ авсангүй. Таттальяагийн омгийн тэргүүн эл болсон явдлын тухай дуулж мэдэх тэр үеэр Санни Корлеоне Лонг-Бичид эргэж ирээд, айдгаа авдрандаа хийчихсэн амар амгалан сууж байлаа. Одоо түүнд эрхэм Вито Корлеонегийн эцэг хүний ёсоор уурлан зэмлэхээс өөр айх юмгүй бөлгөө.

АРВАН ТАВДУГААР БҮЛЭГ

Корлеонегийн Намаас хүчээ нэгтгэн эвссэн бусад таван омгийн эсрэг хийсэн хүнд бэрх дайн хэн алинд нь үлэмж их гарз хохирол учруулжээ. Тэд хоорондоо сөргөлдөхийн дээр ахмад Маккლოსкигоо алуулж нэрээ хөөдсөн цагдаагийн газрынхан хор шарандаа хэн алиныг нь хавчин мөрдөж төвөг учруулах бөлгөө. Хууль зөрчсөн хэдий ч хор гэмгүй, цэвэр арилжаа наймааны болгоноо хориглож, хааж, торгож, хөөж дөвчигнөөд тэр хэдэн албан тушаалтан бослого гаргасан цэргүүдээ захирч дийлэхээ байсан штабын хэсэг офицер шиг яаж ч чадсангүй.

Дээд зиндааны хүмүүсийн өмөг хамгаалалт үгүй болсон нь Корлеонегийн гэр бүлд үлэмж хохирол учруулсан хэдий ч өрсөлдөгчид нь бас л багагүй хэлмэгджээ. Харин мөрийтэй тоглоомын газар, нууц сугалаа гаргагчдыг цагдаа нар байнга дайран сүйтгэж, тэдний заримыг билетээ худалдаж байхад нь баривчилж шоронд хорьсноос гадна мөрийтэй тоглоомын газруудад бооцоо барьдаг «банкны эзэн» хэд гурван хүнийг илрүүлж дээрэмдээд хууль, шүүхээр айлган сүрдүүлсэн байна. Тэд мэдээжээр өмгөөлөл хамгаалал эрж гэр бүлийн зөвлөгөөнөөр хэлэлцсэн боловч одоохондоо яах ч арга байсангүй. Гарлемд зөвхөн бор зүрхээрээ ажиллаж азаа туршдаг негрүүд л үлджээ,

Гэвч аажимдаа даралт шахалт суларч, аюул нимгэрэх тийшээ хандлаа. Маккლოსкиг буудаж алсны дараахнаас эхлэн цагдаагийн ахмадыг мафи, мансууруулагч, Солоцогийн нэртэй холбосон материал сонин хэвлэлд нийтлэгдэж, ялгуулсан ахмад маань төрөл арилжихынхаа өмнө бэлэн мөнгөөр авсан хээл хахуулийг тоотой баримттай нь илчилсэн мэдээ энд ч тэнд ч үзэгдэх болов. Энэ мэдээллийн эх сурвалж нь Том Хейген байсан бөгөөд тэрээр сонины сурвалжлагч нарын сонирхлыг татах мэдээ болгоноор харамгүй, хамгийн гол нь цагт нь олж чадварлаг хангадаг нь Корлеонегийн Намын ашиг сонирхолд ч бүрэн нийцэж байлаа. Цагдаагийн яам тамгын газар Маккლოსкигийн нэртэй холбогдсон материалыг сонин хэвлэлийнхэнд тайлбарлаж өгөхөөс татгалзсан байна.

Эдгээр нийтлэл олон нийтийн санаа бодолд зохих нөлөө үзүүлж, цагдаагийн газар учрыг нь олох санаатай дөнгөж ухаж төнхөөд эхэлтэл Маккლოსки үнэхээр гэмт хэрэгтний ертөнцтэй холбоотой байсныг нотлох үй олон мэдээ өөрийнхөө (нэгэн зэрэг Корлеонегийн омогт хүчин зүтгэдэг) ажилтан нараас авсан аж. За яахав, тэрээр мухлагийн эзэд, жижиг луйварчдаас хээл хахууль авдаг байсан нь ч яамай хэрэг. Цагдаа болгон нь өөрийнхөө хэсгээс ямар нэгэн байдлаар шан харамж авч бор ходоодоо баярлуулдаг хойно түүнийг онцлон зэмлэх явдалгүй. Гэтэл тэрээр наркомафи, хүн амины хэргээс олсон бохир мөнгөнд гар дүрсэн тул ийм нүглийг эрх зүй, цагдаа хүний нэр төрийг хуулийн үүднээс яасан ч уучлах аргагүй бөлгөө.

Хамгийн хачирхалтай нь гэвэл, цагдаа нар хууль дэг журамд үнэн голоосоо итгэж, түүнийг хүч чадал сэлбэх шидэт эх сурвалж хэмээн шүтэхээс наахнуур эрхэмлэх атал жирийн бэртэгчин буруутан цагдаа нарын хамгаалах ёстой хуулийн гарт ормогц нийгэм хүнлэг энэрэнгүй гэх элдэв уриа лоозонгийн дор шийтгэлийг хөнгөрүүлж, тэдний хамаг хичээл зүтгэлийг талаар болгох нь цөөнгүй. Энэ хэрэгт заавал нэг томоохон улс төрийн зүтгэлтний нэр холбоотой байх юм уу, эсвэл шүүх нүдэн дээр ил байгаа нотлох баримтыг зориуд үл

харгалзан дүүрчихсэн өөдгүй новшнуудад тэнсэн ял онооно. Түүнээс гадна бас дээд засаглалын харамгүй тараадаг өршөөл гэж бий.

Тийм болохоор хууль бол хууль л юм биз, гэхдээ эл бүхнээс ганц зөв дүгнэлт хийхэд амархан бөгөөд жаахан ч гэсэн эрүүл ухаантай цагдаа болгон эцсийн эцэст үүнийг ойлгох бөлгөө. Нэгэнт л гэмт хэрэгтэнгүүд яаж ийгээд ял шийтгэлээс мултарч гараад байдаг юм бол тэр өөрөө үүнээс ашиг олж яагаад болдоггүй билээ? Тэр тусмаа цагдаагийн цалин тансаг амьдралд хүрэлцэхгүй, гэтэл хүүхдүүдээ коллежид сургаж, эхнэртээ үнэтэй хувцас хунар, эд юмс олигтойхон дэлгүүрээс худалдан авч өгөх, өөрөө ч гэсэн Флоридын аль нэг наран шарлагын газар ядахдаа жилд ганц удаа амрах хэрэгтэй байдаг. Нийгмийн хэв журмыг сахиулах үйлсэд тэрээр хүчин зүтгэж өдөр бүр амиараа дэнчин тавьж явааг бодоход энэ нь тийм ч их юм биш шүү дээ.

Гэвч зан суртахууны тодорхой хууль энд ч гэсэн бас үйлчилдэг. Морин тойруулгын бооцоо баригчаас хээл хахууль авлаа гэхэд нийгэмд тийм ч их хохирол учрахгүй. Хурд хэтрүүлсэн юм уу, машинаа буруу газар тавьсан жолооч тэртэй тэргүй л торгууль төлөх юм чинь түүнээс «гар цайлгах» мөнгө авахад яадаг юм бэ? Биеэ худалдаж амь зогоодог хүүхнүүдийг тодорхой хөлс өгвөл өөрийн хариуцсан хэсгээсээ хөөж туухгүй байхад болохгүй нь юу байна? Энэ бүхэн эрх зүйн зөрчил яах аргагүй мөн боловч хүний мөн чанар, сул тал дээр үндэслэгдсэн тул бас ч гэж уучилж болох талтай. Гэхдээ ямар ч цагдаа хүний давж гарч болдоггүй хэмжээ хязгаар гэж байдаг. Цагдаагийн газрын нэг ч ажилтан уул шиг алт амлаж байлаа ч гэсэн дээрэмчин, алуурчин юм уу, мансууруулагчийн наймаачинд тус дэм үзүүлэх ёсгүй. Хэрэв ингэвэл эрх зүйн дэг журмыг хамгаалах үүрэгтэй цагдаагийн газарт итгэхээ больж хуулийн төлөөлөгчдийн нэр хүнд нэг ёсондоо хааны амь насанд халдсантай адил хүнд гэмт хэрэг. Гэвч Макклоскиг мансууруулагч наймаалдаг нэртэй дээрэмчний хамт буудсан тухай мэдээ ахмадын хамтран зүтгэгчдэд нэгийг бодогдуулав. Харин тэрээр хүн амины хэрэгт холбогдон сэжиглэгдэж байгаа нь мэдэгдсэнээс хойш хамгийн их хорсож занасан цагдаа нар ч гэсэн өш хонзон авахаар улайран хөөцөлдөхөө больжээ. Гэтэл, энэ Макклоскиг чөтгөр алгадаасай, цагдаа нарыг зээлийн хүү төлөхөөс хэн ч чөлөөлөөгүй, хуучирч муудсан машиных нь оронд хэн ч шинийг аваад өгөхгүй болохоор, ахмадыг алсан тухай чимээ шуугиан жаахан намжмагц цагдаа нар нууц «орлого» олох хуучин аргаа хэрэглэн, Нам, омгуудтай урьдын харилцаагаа сэргээж, гагцхүү үнэ хөлсөө тэнгэр хадаасан байна.

Намууд тэдэнтэй үнэ хаялцахыг бодоо ч үгүй тул газар сайгүй цагдаа нарын үйлчилгээний нэмүү төлбөрийн шинэ жагсаалт мөрдөх болж, хэв журам, эсвэл түүний бүдэг сүүдэр хэв журмархуу юм дахин тогтлоо.

Вито Корлеонегийн хэвтэж асан эмнэлгийг хамгаалахад хувийн мөрдөгч нарыг оролцуулах санааг Том Хейген гаргаж, догшин Тессиогийн зарим дайчдыг ч тэдэнтэй хүч хавсруулсан байна. Гэхдээ Санни ямар ч гэсэн сонор сэрэмжээ сулруулж үл болно гэж үзлээ. Зөвхөн хоёрдугаар сарын дундуур Их эцгийн бие жаахан гайгүй болж, зөөж тээвэрлэх бололцоо гармагц «түргэн тусламжийн» машинаар Лонг-Бич дэх гэрт нь авчирснаас хойш сая л бүгд санаа амарчээ. Зузаан ханаар найдвартай хамгаалагдсан гэрийнх нь унтлагын өрөөг эмнэлгийн тасалгаа болгон өөрчилж, анагаах ухааны сүүлийн үеийн төгс боловсронгуй тоног, багаж хэрэгслээр бүрэн төхөөрөмжлөөд сайтар шалган зориуд шилж авсан сувилагч

нар өвчтөнг өдөр шөнөгүй сахин харна. Эмч Кеннеди өгөхөөр амласан шагналын хэмжээг сонсоод тэссэнгүй, өвчтөнг бүрэн эдгэртэл гэрээр нь эмчлэхийг зөвшөөрчээ.

Одоо Лонг-Бичийн талбай жинхэнэ хэрэм цайз болон хувирч, оршин суугчдыг нь төрж өссөн сицили нутаг руу нь амрахаар явуулаад оронд нь Санни, Клеменца хоёрын зэвсэглэсэн бүлгийн мэргэн буучдыг суулгав.

Фредо Корлеонег биеэ эмчлүүлэх, бас хажуугаар нь Лас-Вегаст барьж байгаа цогцолбор тансаг зочид буудал, тоглоомын газарт гэр бүлийнх нь бизнесийг эрхлэн явуулах хэтийн төлөв байгаа эсэхийг тандаж мэдэх даалгавар өгөөд тийш нь явуулжээ. Лас-Вегас эл дайнд төвийг сахисан Өрнөд эргийн омог, намуудын мэдэлд байдаг тул Фреддигийн аюулгүй байдал бүрэн баталгаатай байлаа. Тэгээд ч ар гэрт нь аюул гай дүүрэн байхад Нью-Йоркийн намуудын хэн нь ч Фреддиг харийн эзэмшил нутагт даган мөшгөөд дайсныхаа тоог нэмэгдүүлэхийг хүсэхгүй биз.

Кеннеди эмч аливаа ажил хэргийн яриагаар өвчтөнг шаналгахыг тас хориглосон боловч өөрийн оролцоотой цэргийн зөвлөгөөн нэн даруй хийлгэх гэсэн Их эцгийн хүсэл дийлж, тэр оройдоо Санни, Том Хейген Питер Клеменца, Тессио нар өвчтөний өрөөнд цугларчээ.

Вито Корлеонегийн бие хараахан сул, ярьж чадахгүй хэвээрээ байсан боловч өөрөө тэд бүгдийн үгийг дуулж, шаардлагатай бол хориг тавих эрхээ эдлэхийг хүссэн байна. Мөрийтэй тоглоомын газар байгуулах асуудал судалж газар дээр нь танилцахаар Фреддиг Лас-Вегас руу явуулсан мэдээний хариуд Загалмайлан эцэг сайшаан толгой дохиж, Бруно Таттальяг хороосон тухай сонсоод зэмлэн буруушаасан янзтай толгой сэгсэрч хүндээр санаа алдав. Харин чухам Майкл цагдаагийн газрын ахмад, Солоццо хоёрыг буудаж алаад одоо Сицилд нуугдаж байгааг сонсмогц Загалмайлан эцэг юу юунаас илүү гутарч зөвлөгөөн хаасныг мэдэгдэн гар зангамагц тэд бүгд гарч хууль зүйн ном пиг дүүрэн өрсөн мухрын өрөөнд ороод яриагаа үргэлжлүүлжээ.

Санни Корлеоне сурсан зангаараа аавын бичгийн ширээний хажуугийн буйдан сандалд тухлан суугаад:

- Хэрэг явдлыг яаравчлан түргэтгээд юу хийхэв, ямар ч л гэсэн өвгөнийг эдгэртэл хоёр гурван долоо хоног санааг нь чилээх хэрэггүй юм шиг санагдлаа хэмээн хэсэг чимээгүй сууснаа цааш үгүүлрүүн:

- Энэ хооронд би ажил хэргээ эмхлэн цэгцэлж дуусмаар байна. Цагдаа нар буулт хийж байгаа болохоор урьдын ажлаа үргэлжлүүлж болох байх. Юуны түрүүнд Гарлемаас л эхлэх хэрэгтэй. Хар арьстан залуусыг тэнд тонгочуулж ханалаа, одоо тэндээс хөөж зайлуулах, цаг нь болсон. Тэд дур зоргоороо аашлан, бооцооны хэмжээг зориуд даран, мөнгөний хагасыг нуун монжиж бидэнд их хохирол учруулдаг атлаа өөрсдөө «кадиллак» машинаар сэлгүүцэн, үнэтэй чамин хувцсаа гайхуулах нь таалагдахгүй байна. Хамгийн гол нь үйлчлүүлэгчдийг хууран мэхэлж, бидний нэр хүндийг унагаж байгаад нь бүр ч дургүй хүрэх юм. Тэднээс аль болох түргэн ангижрах хэрэгтэй байна, Том оо. Цагдаа нартай хэл үгээ ололцсоныг манай бооцоо баригч «банкчин» нарт дуулгавал л бүх юм ёсоор болно.

Том Хейген нилээн бодлогоширсон янзтай үгүүлэв.

- Гарлем дахь негрүүдийн дотор их мөнгөний ам танд орсон шазруун залуус хэд хэд бий. Тэд одоогийн байр сууриа тийм ч амар тавьж өгөхгүй болов уу гэж айх юм.

Санни мөрөө хавчлаа

- Тэгвэл тэдний овог нэрийг Клеменцад дуулгачих, тэр бүх юмыг дээд зэргээр аргалж дөнгөнө.

Клеменца татгалзсангүй.

- Бололгүй яхав.

Тессио ярианд оролцож, хамгийн эмзэг сэдвийг хөндөв.

- Биднийг ажлаа дөнгөж эхэлмэгц таван Нам бүгдээрээ л бидэн рүү дайран довтолж, Гарлем дэх «банкчин», Ист-Сайдын морин тойруулгын бооцоологч нарыг дээрэмдэх болно. Манай ивээлд байдаг их дэлгүүрүүдийг зүгээр байлгахгүй байж юу магад. Зардал ч их гарна даа.

- Заавал тэгэх албагүй шүү дээ. Дайрахгүй ч байж магадгүй. Тэд өөрсдөө яаж балрахаа ойлгохгүй байна. Би Таттальяагийн отгон хүүгийн төлөө хүссэн мөнгийг нь төлөх санал гарган тэдэн рүү зуучлагч явуулсан. Тэд түүнийг аваад тайвширч юу магад хэмээн Санни хариу өчсөнд Хейген зөвшөөрсөнгүй.

- Одоо хүртэл тэд бидний энхийн саналыг ер тоож үзээгүй., Тэд тун их хохирол амсаж, бүх гэм бурууг бидэнд тохож байгаа нь тийм ч үндэслэлгүй биш гэдгийг хэлэх юун. Тэд нар Их эцгийн улс төрийн холбоо сүлбээг өөрсдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахын тулд биднийг мансууруулагчийн наймаанд ямар ч гэсэн татан оруулахаар шийдсэн юм шиг санагдаад байна. Өөрөөр хэлбэл, талийгаач Виргилий Солоцогийн болзлыг бидэнд тулгаж байгаа юм. Гэвч Татталья үүнийгээ хүлээн зөвшөөрөхөөс өмнө Корлеонегийн Намыг сүлдуулахын тулд тун хүчтэй цохилт өгөхийг оролдоно. Тэгвэл бид хаашаа ч гарах газаргүй болж, мансууруулагчийн арилжааны талаар тэдэнтэй хэлэлцэж тохирох болно.

- Мансууруулагчтай зууралдах хэрэггүй. Нэгэнт л Их эцэг тэдэнд татгалзсан болохоор зөвхөн тэр л шийдвэрээ өөрчилж чадна хэмээн Санни ширүүхэн дуугарсанд Хейген үгийг нь дорхноо өлгөж авлаа.

- Тэгвэл бидэнд стратегийн биш, тактикийн асуудал тулгараад байгаа юм байна. Морин тойруулга, мөрийтэй тоглоомын газар гээд л бидний хамаг юм ил болохоор хэн ч бидэнд амархан цохилт өгч чадна. Гэтэл Таттальяагийн намынхан янхны газар, хөлөг онгоцны засварчдын үйлдвэрчний эвлэлийг харьяалдаг юм чинь бид яаж тэднийг хорлож чадах юм бэ? Бусад намын бизнесийн ихэнх хэсэг нь далд нууц байдаг. Зарим нэгэнд нь тоглоомын газар байдаг ч энэ нь гол биш. Таттальяагийн шөнийн клубийг хүн болгон андахгүй болохоор тийшээ дайралт хийнэ гэдэг тэнэг хэрэг. Гэтэл Их эцгийн хөл дээрээ босоогүй цагт бид Таттальяагийн нэгэн адил түүний улс төрийн холбоо харилцааг ашиглаж чадахгүй. Хамгийн

гол нь номхтгон цээрлүүлж, айлган сүрдүүлж чив чимээгүй хүч хэрэглэж сурсан улс. Тийм болохоор бидэнд тулгарсан бэрхшээлийг дутуу үнэлж үл болно.

- За за, Том минь, энэ миний л шийдэх ёстой асуудал. Харин чи хэлэлцээрээ үргэлжлүүлж, өдөр тутмын ажилдаа хяналт тавьж бай. Одоо бид урьдын ажилдаа эргэж ороод азын тэнгэр хааш нь аваачихыг харж сууя. Тэд нар тавуулаа нийлээд бидний эсрэг үзэлцэх боллоо ч гэсэн Клеменца, Тессио хоёрт хүн хүч, зэр зэвсэг хүрэлцээтэй бий. Тун болохгүй бол «ширдэг дэвсээд» бүгчихнэ биз.

Цагдаагийн газар хангалттай мэдээлэл аваад хамаг юмыг дуртай нь аргагүй янзалчихсан болохоор бооцоологч негрүүдийг Гарлемаас хөөх гэж зүдэрсэнгүй. Тэр үед арьсны өнгөөр гадуурхах үзэл арилаагүй байсан тул нэг ч цагдаа хар арьстангаас хахууль авахгүй байсан. Гарлемын асуудал аяндаа л шийдэгдэнэ гэж Санни хэлсэн нь яах аргагүй үнэн ажээ.

Гэвч Их Таван Нам гар хумхин алгуурлаж суусангүй хэний ч санаанд ороогүй газар цохилт өгч Корлеонегийн өмгөөлөн дэмждэг нэхмэлийн ажилчдын үйлдвэрчний эвлэлийн хоёр удирдагчийг устгасны гадна тэнгисийн усан боомт, хөлөг онгоцны засварын газрын хавиар байсан бооцоологч, мөнгө хүүлэгч нарыг шаргуу шахан зайлууллаа. Боомтын ажилчдын үйлдвэрчний эвлэл өөрсдийнхөө хувьд ухаалаг шийдвэр гарган таван Намын талд орж, Нью-Йорк даяар бүх бооцоологч, сугалаа эрхлэгчдийг харьяаллаа солихыг улаан цайм уриалан дуудах болов. Гарлемын хамгийн том «банкчинг» бусдыг нь айлган сүрдүүлэхийн тулд тун зэрлэгээр тамлан алжээ.

Одоо сонгон шилэх, цааш хүлээх арга байхгүй болж, дайн нэгэнт хамгийнхаа аюултай үе шатандаа орсон тул Сонни итгэмжлэгдсэн хүмүүстээ «ширдэг дэвсэн бүгэх» тушаал өгөв.

Хотод хоёр сууц хам хум төхөөрч шаардлагатай тооны ор дэр, хоол хүнс дүүрэн чихсэн хөргөгч, зэр зэвсэг, галт хэрэгсэл аваачаад, нэг сууцанд нь Тессио хүмүүсийнхээ хамт, нөгөөд нь Клеменцагийн бүлэг залуус орж суулаа. Морин тойруулгын бооцоо баригч болгонд бие хамгаалагч гаргасан авч Гарлем тэр чигээрээ дайсны талд орж, тэднийг одоохондоо яах ч арга олдсонгүй. Зардал улам бүр өссөөр байхад ашиг орлогын хэмжээ өдрөөс өдөрт багасах нь хүсэл дээр хясал гэлтэй.

Тун удалгүй Корлеонегийн Нам хүчээ хэт үнэлсэн нь тодорхой болж Саннигийн сэтгэл үлэмж гонсойв. Уг нь үүнийг тайлбарлаж ядах юмгүй санж. Их эцгийн бие гүйцэд сайжраагүй, тулгамдсан зорилтыг шийдвэрлэхэд биечлэн оролцох бололцоогүй, дээд хүрээний танилуудынхаа улс төрийн хүчийг ашиглаж хараахан чадахгүй хэвээрээ л. Энх амгалан аж төрсөн хэдэн арван жилийн дотор Намын дайчин салбарууд ч, түүний ахмад Клеменца, Тессио хоёр ч эрч хүч, уян хатан, шуурхай чанараа нилээд алджээ. Клеменца эдүгээ тун сайн зохион байгуулагч, гаргуу хичээн зүтгэдэг гүйцэтгэгч болсон хэдий ч аливаа цэргийн жанжинд заавал байх ёстой хүмүүсийг биеэрээ үлгэрлэн дагуулах чадвар, залуу хүний оргилуун бадрангуй сэтгэлээс нь ул мөр ч үлдсэнгүй. Тессио хэрсүү ухаантай ч уулгалан дайрах хатан зориг нь мохож, халз тулахаасаа булангийн цаанаас буудахыг илүүд үздэг долоо буудуулсан хашир чоно шиг болгоомжтой болжээ. Тэрээр одоо урьдын адил хайр найргүй, эрс шийдэмгий хөдөлж чадахаа байсан төдийгүй, өөрийгөө арай гэж хүчлэн байж зэвсэгт отрядаа тулалдаанд оруулах болсон бөлгөө.

Түүнээс гадна энхийн цагт өө сэвгүй сайн зөвлөгч байсан Том Хейген дайн тулааны хатуу ширүүн үеэр эл үүрэгтээ тэнцэхээ больсон нь бусадтай зүйрлэшгүй авьяас билэгтэй ч сицили эр биш байсантай холбоотой байж магадгүй боловч бас л үүнийг засаж залруулах ямар ч бололцоогүй.

Тийм учраас Их тавд дайн зарлахдаа Корлеонегийн Намын хүч чадал хамгийн сайн байсан гэж яав ч хэлж болохооргүй байв. Санни цэрэг дайчдынхаа сул талыг сайн мэдэх хэдий ч түүнийг засан залруулж чадахгүйгээ бас андахгүй мэдэх бөлгөө. Тэрээр Их эцэг биш, тэгэхлээр боловсон хүчний асуудлыг толгой даан шийдэх эрхгүй. Итгэмжлэгдсэн хүмүүс, зөвлөхийг зөвхөн Вито Корлеоне л халж сольж чадна. Ер нь гарам руу орсон хойноо унасан морио сэлгэх шиг аюул тулгарсан цагт дээд тушаалын хүмүүсийг өөрчлөн томилох нь байдлыг улам хүндрүүлж, тэртэй тэргүй эргэлзэн тээнэгэлзсэн жирийн дайчдад айдас төрүүлэх бус уу?! Гэтэл самгардаж сандарч, тэвдсэн хүн айж хулчийгаад урван тэрслэх нь амархан болдог аюултай.

Их эцэг бүрэн илааршиж, удирдлагын бүх жолоог гартаа атгах хүртэл Санни байлдааны ил ажиллагаа явуулах бодолтой байлаа. Гэвч нөхцөл байдал эгзэгтэй хурцадмал болж, гарлемын «банкчид» урваад, бооцоологч нарыг толгой дараалан хядах аюул тулгарсныг харгалзан тэрээр дүгрэглэсэн хамгаалалтад шилжиж, эрс шийдвэртэй эцсийн цохилт атаат дайсныхаа амин зүрхэнд нь алдалгүй онож хийхээр бэлтгэж эхлэв.

Санни Таван Намын толгойлогчдыг нэгэн зэрэг тонилгох асар том ажиллагаа төлөвлөсөн бөгөөд хэрэв энэ нь амжилттай бүтсэн бол аз хийморь Корлеонегийн Нам руу нэгмөсөн эргэж ивээх байсан нь дамжиггүй.

Гэтэл нийт Таван Намын удирдагч нарыг нүд салгалгүй нягтлан мөрдөж эхлээд бараг долоо хоноо ч үгүй байхад бас л хэвтгээ байдалд шилжсэн бололтой гүн нүхэнд шигдэн бүгж, хоншоороо ч цухуйлгахаа болив.

Ийнхүү бүгд отолт бүгэлтэнд орж, Корлеонегийн эзэнт улс, Их таван намын хоорондын дайн мухардмал байдалд орлоо.

АРВАН ЗУРГААДУГААР БҮЛЭГ

Америго Бонасерагийн иргэдэд үйлчлэх товчоо ердөө хажууханд нь шахуу Мальборо гудамжинд байх тул гол төлөв гэртээ хоол иддэг нэгэн. Тэрбээр товчооны бүрэнхий танхимд талийгаачтай салах ёс хийхээр оройн цагаар ирдэг төрөл төрөгсөд, анд найз нарын уй гашууг хуваалцах нь ариун үүргээ хэмээн үзэх тул хоолоо идчихээд ажил дээрээ ирдэг байв. Тэр орой ч гэсэн Бонасера товойлгож угалзлуулсан хээтэй хоолны шүүгээний дөрвөн буланд Охин тэнгэр Мариягийн алтадсан баримал тавьж, мөнгөн тавиуртай лаа асаасан хоолны тохилог өрөөндөө дадсан зангаараа үдшийн зоог барьж, эхнэрийн аягалж өгсөн шөлөнд ам хүрэхийн өмнө хайрцаг «Камел» гаргаж, америк вискинээс нэг сайн балгав. Тэр хоёр охиноо газар сэлгэн, зодуулж доромжлуулсан бие сэтгэлээ жаахан ч болсон сэргээг гээд Бостон руу, эхнэрийн эгчийнд нь явуулжээ. Түүнд халдан гар хүрсэн өөдгүй шаарууд үеийн үед хамаг амьтны хараал идэг! Эрхэм Корлеоне шударга ёс сахиулж өгсөн нь л яамай даа.

Шөлөө ууж дуусахын алдад авгай нь:

- Өнөөдөр чи дахиад л ажил дээрээ очих уу? гэж асуухаар Америго Бонасера дуугүй толгой дохив.

Хатагтай Бонасера эр нөхрийнхөө мэргэжлийг хүндэтгэх боловч гүнд нь ортол ойлгодоггүй, тухайлбал, хөдөөлүүлэх ёслолын зөвхөн техник ажиллагаа нь гол биш гэдгийг ер ухаардаггүй байлаа. Тэрбээр бусад олны нэгэн адил эр нөхөр нь талийгаач хүнийг амьд байснаас нь дутуугүй гоёж гоодон, сайхан хувцаслаж чаддаг болохоор л хүмүүс ахиу мөнгө төлдөг гэж эндүүрэх бөлгөө. Үнэхээр ч нас барсан хүнийг засч янзлах талаараа түүнтэй эн зэрэгцэх нэгэн ч үгүй, түүний ур чадвар нь ёстой л урлагийн ноён оргилд хүрсэн гэлтэй. Түүний үзэж байгаагаар шарилын дэргэд шөнөжин сахиж манах хамаатан садангийн хамт өөрөө байлцаж сэтгэлийн дэм өгдөг нь юунаас ч чухал болой. Өнчирч хоцорсон гэр бүл үхлийн сүүдэр нөмөрсөн шарилын хөлд хуран цугларах үер гагцхүү Бонасера л нөгөө ертөнцийн онгорхой хаалга манасан сахиулын хувьд жинхэнэ голт зүрхний уй гашуу, албан ёсны арга хэмжээ хоёрын хоорондох хэврэг нимгэн заагийг сахин барьж чадах ажгуу. Мөн түүнчлэн цорхирон уйлах төрөл төрөгсдийг тайтгаруулахын зэрэгцээ тэвчээр муутай заримыг нь зантран журамлах, эл хүнд бэрх үеэр хэзээний л хараа хяналтгүй хоцорч хамаагүй тонгочих хүүхдүүдийг арчлан санаа тавих зэргээр хөдөөлүүлэх ёслолыг зохион байгуулах талаараа хэнийг ч дагуулахгүй хүн. Тийм учраас Бонасерагийн товчоогоор нэг л үйлчлүүлсэн хүн ахиад гай зовлон эмгэнэлт явдал тохиолдоход өөр хүн дээр очих тухай боддог ч үгүй тул талийгаачийг эцсийн замд нь хамт үдэлцэхээр орой үдэш, шөнийн цагаа харамгүй үрдэг нь тийм ч хэрэггүй зүйл бус бөлгөө.

Ихэнх өдөр тэрээр оройн хоолны дараа ажил руугаа буцахаас өмнө жаахан ч гэсэн хажуулаад авч амждаг бөгөөд босч хүйтэн шүршүүрт ороод сахлаа хусан цасан цагаан цамц өмсөж, хөхөрсөн арьсаа далдлан оо энгэсэг хайр найргүй түрхсэний дараа хар бараан костюм, гялалзсан хар шаахай өмсөв. Хувцас хунар нь гашуудлын хар баргар өнгөтэй хэдий ч Бонасера хэн ч аймаар зэвүүн хүн биш, харин ч уй гашууд автагдсан хүмүүсийн анд найз нь болж харагдах увидастай эр.

Америго ер нь хоол бага иддэг тул авгай нь шөлний дараа ногоогоор хачирлаж давтсан мах жаахныг авчирч өгөв. Тэрбээр хоолоо идээд аяга кофе ууж, «Камел» янжуураасаа нэгийг асааж, охиныхоо тухай дахин бодолд дарагдлаа. Тэр одоо хэзээ ч урьдынх шигээ хөгжөөн наргиантай байхаасаа өнгөрсөн. Нүүр хувиргах хагалгааны тусламжтайгаар түүний царайд засал хийж бараг хуучин янзанд нь оруулсан боловч анчинд хөөгдсөн бяцхан араатны айдас мөнхөд хурсан юм шиг нүдэнд нь хэн амгалан тайван, хөгжилтэй харц тодруулж чадах юм бэ? Үе үе охиныхоо харцтай Бонасера харц мөргөлдөх болгондоо сэтгэл нь цочмог хямраад ер болж өгсөнгүй учраас түүнийг Бостон руу явуулсан байна. Цаг хугацаа бүхнийг анагаах юм чинь бүх юм хэвийн болох биз. Гагцхүү үхэл л гарцаагүй болохоос биш ямар ч зовлон шаналгаа яваандаа арилдгийг Бонасера хэнээс ч илүү сайн мэдэх ажгуу.

Бонасераг сүүлийн аяга кофегоо уугаад дуусах гэж байтал утас хангинав. Түүнийг гэртээ байхад эхнэр нь хэзээ ч харилцуур авдаггүй тул Бонасера янжуураа унтраан босч, зочдын өрөөг зүглэх замдаа: «Жаахан ч гэсэн зүүрмэглээд авах л хэрэгтэй дээ» гэж бодоод цамцныхаа дээд товчийг тайлан зангиагаа сулрууллаа. Тэрээр харилцуур авч, эмгэнэл илэрхийлж дадсан хоолойгоор:

- Би сонсож байна гэтэл харилцуурт шаналж гутарсан дуу сонсогдов.

- Би Том Хейген байна. Эрхэм Корлеонегийн даалгавраар танд дамжуулах гэсэн юм.

Америго Бонасерагийн уусан сүүлийн балга кофе хоолой дээр нь тээглэх шиг болж, эгээтэй л огиулж орхисонгүй. Тэрээр гагцхүү охиныхоо л бодож шударга ёс эрэлхийлэн эрхэм Корлеоне дээр очиж, насан туршдаа өртэй болсон цагаас хойш бүтэн жил өнгөрчээ. Мэдээжээр тэр өрөө хэзээ нэгэн цагт төлөх хэрэгтэй болно гэдгийг сайн ойлгож байсан боловч эл хугацаанд энэ бодол санаа нь бүдгэрч амжжээ. Тэгэхэд сонины эхний нүүрнээс охиныг нь доромжилсон хоёр залуугийн эрэмдэг зэрэмдэг болсон үзэшгүй муухай царайг олж хараад Бонасера хязгааргүй их баярлаж, Загалмайлан эцгийн хүссэн болгоныг хийхэд бэлэн байсан аж. Гэтэл одоо тэр талархах сэтгэл нь жижигхэн горхины ус ширгэх шиг зөвхөн гарцаагүй учрах гай ланчигаас айж, цөхрөнгөө баран тарчлах үлдсэнийг ойлгоод Бонасерагийн хөл дор газар дайвалзан ангал гарах шиг болж, ямар ч аврал алга мэт санагдлаа.

Тэрээр арай ядан байж, чичгэнэсэн хоолойгоор дуугарагчаа болов.

- Ойлголоо. Би тус болоход бэлэн байна.

Том Хейген итали хүн биш боловч яг л итали эр шиг боловсон зан гаргаж, хүн болгонтой эелдэг зөөлнөөр харилцдаг атал энэ удаад мөс шиг хүйтэн, бараг зэрлэг, тасалдангуй дуугаар ярих нь нэн гайхалтай.

- Та Загалмайлан эцэгт өртэйгөө мартаагүй биз? Тэрээр таны хариу тус хүргэх сэтгэлд чинь ер эргэлзэхгүй байгаа тул таныг баяртай тусална гэдэгт би итгэхийг хүснэ. Тийм ховор бололцоо танд өнөөдөр гарч байна. Нэг цаг гаруй болоод Их эцэг танай ажил дээр очиж, таны зүгээс ямар тусалцаа шаардлагатайг өөрөө хэлнэ. Та хүлээж байгаарай. Танаас өөр нэг ч ажилтан тэнд байх ёсгүй, бүгдийг гэрт нь явуул. Та миний хэлснийг ойлгов уу? Хэрэв ямар

нэг юм бүтэхгүй бол одоо шууд хэлчих, би эрхэм Корлеонед дамжуулъя. Энэ хэрэгт тус болох өөр найз түүнд бишгүй дээ л бий.

Америго Бонасера үнхэлцгээ хагартал айн хариуд нь орь дуу тавилаа.

- Загалмайлсан эцэгт ямар нэг юман дээр татгалзаж би яаж зүрхлэх вэ? Би Их эцэгт ямар өртэйгөө мартаагүй болохоор чадах бүхнээ л хийнэ. Одоохон ажил дээрээ очоод хүлээж байя.

Том Хейгений дуу арай зөөлөрсөн авч нэг л хачин өнгө аястай хэвээрээ л.

- Их баярлалаа. Би л тээнэгэлзээд байснаас биш, Их эцэг танд өчүүхэн төдий ч эргэлзээгүй юм шүү. Харин та өнөөдөр түүнд тус болбол би өөрийн зүгээс хэзээ ч, ямар ч нөхцөлд туслахад бэлэн байна. Хэрэгтэй цагтаа надад утасдаарай, та ер харамсахгүй шүү.

Америго Бонасерагийн бүр сүнс нь зайлах дөхөөд, ердөө л нэг юм амандаа бувтнахаас цааш чадал нь хүрсэнгүй.

- Загалмайлсан эцэг өөрөө над дээр ирэх юм уу?

- Тийм ээ, Америго.

- Тэгвэл тэрээр Бурхны ивээлээр эдгэрээ шив дээ, за яамай даа хэмээн Бонасера гөвгнөсөн боловч энэ нь асуусан юм шиг сонсогджээ. Утасны нөгөө үзүүрт чив чимээгүй болсноо:

- Тийм ээ хэмээн Хейген их л болгоомжлон хариулаад харилцуураа тавилаа.

Бонасерагийн духаар хүйтэн хөлс чийхэрч, өөрөө мэдэлгүй унтлагынхаа өрөөнд орж цамцаа солиод, шүдээ зайлсан боловч, зангиагаа солих тэнхээ нь хүрсэнгүй.

Дараа нь тэрбээр туслахдаа утасдаж, маш чухал ажил гарсан тул ээлжит талийгаачтай салах ёс хийх. ажиллагааг түүнгүйгээр, гэхдээ үүдний танхимд хийхийг даалгав. Туслах нь нэг юм асуух гэсэн боловч авчин үгийг нь тас дайрч, өөрийнхөө оронд шарилын дэргэд заавал байхыг дахин тушаагаад харилцуураа шиджээ.

Бонасера өдөр ажилдаа өмсөж явсан костюмаа буцааж өмссөнд эхнэр нь гайхан харлаа.

- Яаралтай ажил гарлаа хэмээн тайлбарласанд эхнэр нь Бонасерагийн хөшиж царцсан хачин царайг хараад балмагдсандаа ямар ажил гарсныг тодруулж асуусангүй. Авчин эр гэрээсээ гарч оршуулгын контор хүрэх дадсан замаараа явлаа. Иргэдэд үйлчлэх эл товчоо цагаанаар будсан төмөр хашаатай уужим байшинд байрлах агаад гудамжнаас орсон «түргэн тусламжийн»

болон оршуулгын тэрэг аажим өгсөх асфальтан замаар явсаар шууд арын хаалганд тулж очдог аж. Барилгын ёслолын танхимд, бусад өрөө тасалгаануудаас дуу чимээ үл нэвтрэх нүсэр зузаан хаалгаар тусгаарласан арын хэсэгт нь Бонасерагийн ажлын өрөө, авс болон оршуулгын бусад хэрэгсэл агуулах байр, мөн түүнчлэн ажилдаа хэрэглэдэг аймаар мэт харагдах элдэв багаж төхөөрөмж, химийн бүтээгдэхүүн найдвартай цоожлон хадгалдаг занданшуулах

лаборатори байдаг амой.

Авсчин эр контортоо орж, бичгийн ширээнийхээ ард очиж суугаад ажил дээрээ ер тамхи татдаггүй атлаа хайрцаг янжуур гаргаж тавив. Түүнээс ямар тусламж шаардаад байгаа талаар ер төөрөлдөөгүй сайн мэдэж байсан тул тэрээр арга мухардаж, цөхрөнгөө бараад Их эцгийг хүлээсээр суулаа.

Ер нь ямар сайн юм болно гэж горьдох ч юм билээ дээ? Корлеонегийн нам Нью-Йоркийн Их таван мафитай цус асгаруулсан дайн дэгдээгээд жил шахуу болж, гангстеруудын энэ харгис аллага хядлагад аль аль талаасаа олон хүний амь сүйдсэн тухай мэдээ сонин хэвлэлд байн байн хэвлэгдэж байсан болохоор энэ удаад хэтэрхий содон гэмт этгээд эрсдэж, сэмхэн газарт булах шаардлага гарсныг тааж мэдэхэд тийм ч бэрх биш байлаа. Ийм тохиолдолд ил ажиллагаатай оршуулгын конторын тусламжтайгаар түүний цогцсыг хөдөөлүүлж орхивол ул мөрөө баллах хамгийн энгийн, найдвартай арга бөгөөд сураггүй алга болсон талийгаачийг эрж олох гэдэг ямар ч утгагүй хэрэг биш гэж үү?!

Иймэрхүү үйлдлийг хуульд юу гэж үздэгийг ч Америго Бонасера андахгүй мэднэ. Хэрэв эл бүх ажил явдал нь хэзээ нэгэн цагт илэрч мэдэгдвэл тэрээр гэмт хэрэгт хамтран оролцогч болж олон жилээр шоронд хоригдох ял шийтгүүлэхээс гадна өөр хоорондоо дайтсан мафиудын цуст хэрэгт холбогдон орчин тойрны хүмүүсийн нүдэнд нэр төрөө бүрмөсөн бузарлах болно.

Тэрээр хоёрдахь янжуураа асаасан нь хэмжээнээс хэтрүүлсэн хэрэг боловч хүч сэлбэх шаардлагатай байсан тул өнөөдөр ингэхээс өөр аргагүй. Америго Бонасера янжуураа шуналтай сорсноо гэнэт нэгэн аймшигт бодол төрж амьсгаа дарав. Түүнийг эрхэм Корлеонед тус үзүүлснийг Таван намын толгойлогчид мэдмэгц дайсны эгнээнд орсонд тооцож, ердөө л жоом гишгэж байгаа юм шиг няц дарах нь дамжиггүй. Америгогийн хамаг бие нь нэг халуу шатаад, нэг хүйт даан дагжиж, гай болоход очиж очиж эрхэм Корлеонегийн эхнэртэй танилцаж үерхсэн авгайдаа дургүй нь хүрэхийн зэрэгцээ өшөө хонзон авахаар Загалмайлсан эцгийнд очсон өдөр, цагаа хараан зүхэж суулаа. Түүгээр ч үл барам Америк улсыг бүхэлд нь, заяа муутай охиноо, өсөн дэгжиж яваа товчоогоо хүртэл үгийн муугаар хэлсээр байснаа удалгүй жаахан тайвширч, ердийн өөдрөг үзэл нь дийллээ. Бүх юм хараахан баларчхаагүй байна шүү дээ?! Хэрэг явдал түүний бодсончлон тийм ч найгаа алдчихаагүй байж болох юм биш үү? Эрхэм Корлеоне угийн хашир, гүйлгээ хар ухаантай хүн тул лав нууцлан далдлах талаар санаа тавьсан байх ёстой. Бонасера ганцхан биеэ эзэмдэн барьж, сандарч тэвдэхгүй байх л хэрэгтэй. Эцсийн эцэст ямар ч лай ланчиг дайрлаа гэсэн Загалмайлсан эцгийг уурлуулснаас л дор юм болохгүй юм даг!

Тэрээр эрзээн дугуй хайрга шаржигнуулах чимээ сонсоод машин хашааны хаалгаар орж, арын хаалга руу ирж явааг ойлгоод тоормос хяхтнах дуунаар хаалга онгойлголоо.

Хамгийн түрүүнд аварга том, бүдүүн Клеменца, дараа нь жинхэнэ гангстер төрхтэй хоёр залуу орж ирмэгц мэндэлсэн ч үгүй, ер нь нэг ч үг дуугарсангүй өрөөн доторхыг нэгжиж үзээд Клеменца гарч хоёр эр үлдэв.

Сэтгэлийн шаналгаатай хэдэн минут хүлээсний эцэст өөр нэг машин орж ирэх шиг болсон нь

«түргэн тусламжийн» тэрэг ажээ. Клеменца дахин босгон дээр үзэгдэж, араас нь энэ удаад дамнуурга дамжилсан хоёр хүн дагалдсан харагдана.

Дотроо бодож таамаглаж байсан хамгийн аймшигтай юм нь биелэгдэж эхэлж байгааг Америго Бонасера ойлголоо. Саарал өнгийн бүтээлгэнд ороож дамнуурга дээр тавьсан үхдэлийн ил цухуйх лав шиг өнгөтэй хоёр тавхай яах аргагүй эр хүнийх аж. Клеменца занданшуулах лаборатори ордог хаалга тийш нөгөө хоёртоо занган дохиж, Бонасераг сэхээ авч амжаагүй байтал хашаан доторх харанхуйгаас өөр нэг хүн чийдэн гэрэлтүүлсэн өрөөнд орж ирсэн нь Загалмайлсан эцэг, эрхэм Вито Корлеоне байв.

Турж эцээд арай ядам хөдлөх Их эцэг малгайгаа гартаа барьж толгой нүцгэн орж ирлээ. Армаг тармаг үетэй, том толгой нь гялалзан, Бонасера хуриман дээр хамгийн сүүлд харснаас хойш нилээд өтөлж бөгтийсөн хэдий ч ихэмсэг зан, сэтгэлийн тэнхээ нь хэвээрээ харагдана.

Тэрбээр бүрх малгайгаа элгэндээ тэврээд авсчин өөд анхааралтай ширтсэнээ:

- За өвгөн минь, өнөөдөр чи надад тус болоход бэлэн үү?

Бонасера юу ч дуугарсангүй зөвхөн толгой дохиход Их эцэг энэ байшинд олон орж гарч байсан хүн шиг шууд л лаборатори чиглэн, харин Бонасера зочин хүн лугаа адил араас нь дагалдав. Дамнуургыг задлан шинжилгээ хийдэг, хажуугаараа тусгай хөнхөр сувагтай ширээн дээр тавьсан байв.

Эрхэм Корлеоне үл мэдэг гар дохисонд авсчин, тэр хоёроос бусад нь гарч. Бонасера хэлэх үгээ олж ядан:

-- Би юу... юу хийх болж байна?

Их эцэг амьсгаа хураасан хүүгээ харан толгой гудайлгасан хэвээр:

- Чи намайг хүндэтгэдэг л бол урлаг ур чадвараа дайчлах болж дээ. Эх нь ийм юм харвал юу болох билээ? гээд саарал бүтээлгийг хуулбал Бонасера хатан зоригтон, мэргэжлийнхээ дагуу их юм үзсэн хашир хандгай хэдий ч айж цочсондоо уулга алдан хашгирч орхилоо. Санны Корлеонегийн толгой суманд сэглүүлж, зүүн нүдний цөцгий нь цус дүүрсэн ухархай дотроо хөвөөд, хамрын уг, эрүүний яс нь хугарч цөмөрсөн ясны үйрмэг, мах арьсны тасархай холилдон хутгалджээ.

Хоромхон зуур Их эцгийн тэнхээ алдарч гуйваад Бонасерагийн гарыг түшингээ:

- Миний муу хүүг ямар болгосныг харж байгаа биз дээ гэжээ.

АРВАН ДОЛООДУГААР БҮЛЭГ

Санни Корлеоне лав арга мухардсандаа болоод л эцсийн эцэст өөрийнх нь сүүлчийн зам болсон цус асгаруулсан, мөхлийн замаа сонгож авсан бололтой. Тийнхүү өөр арга байхгүй болсон тулдаа л ганирсан сэтгэлдээ хөтлөгдөн, ялагдаж шившгээ тарихгүйн эрхэнд ил тулаанд амь эрсэдсэн байж магадгүй.

Хавар, зуны зургаан сарын турш тэрээр өштөн дайснаа хядаж, цус асгаруулсан дайн өрнүүлсэн боловч түүний гарт Их таван намын эгнээнээс гол төлөв жижиг сажиг ялихгүй юмнууд нь өртжээ. Тагтальяад хүчин зүтгэж хоол зогоодог өчүүхэн зуучлагч нар, Гарлемд үүрлэсэн мөнгө хүүлэгч, морин тойруулгын бооцоологч нар л дараа дараагаараа хорвоогоос халин одов. Дараа нь Таван намын талд орсон усан боомтын үйлдвэрчний эвлэлийн удирдагч нарын ээлж ирж, харин үйлдвэрчний эвлэлийн бусад зүтгэлтнүүдэд төвийг сахихыг сануулж анхааруулаад л өнгөрсөн аж. Бас Корлеонегийн Намын харьяаны бооцоологч, мөнгө хүүлэгч нарыг тэнгисийн эрэг хавиар ер ойртуулдаггүйг мэдмэгц Санни усан боомтын хороололд дэг журам сэргээн тогтоолгохоор Клеменцагийн төмөр нударгуудыг явуулжээ.

Эл бүх аллага хядлага намууд хоорондын дайны эцсийн үр дүнд яав ч нөлөөлж чадахгүй байлаа. Өнөө маргаашийн хувьд Санни гялалзсан амжилт олоод байгаа боловч дайн тулааныг бүхэлд нь урагштай явуулж ялалт байгуулахын тулд яах аргагүй Вито Корлеонегийн холын хараа, стратегийн авьяас шаардагдаад байв. Аль хэдийнээс эхлэн эл дайнд партизаны арга хэрэглэж ирсэн нь цаашдаа явуургүй гэдгийг аль аль тал нь сайн ойлгож, хэлмэгдэн амь эрсэдсэн хүмүүсийн тоо өдрөөс өдөрт нэмэгдэх хэдий ч мухардмал байдлаас гарах ямар ч арга алга.

Эцсийн эцэст Корлеонегийн Нам эхлээд нэг, дараа нь хэд хэдэн бооцооны газар, түүн дотор Загалмайлсан эцгийн Карло Риццигийн эзэгнэдэг мөрийний газрыг хаахад хүрсэн байна. Карло бүр сэтгэлээр унаж, шөнийн цэнгээний газрын сүрэг хүүхнүүдтэй зэрэг заваарах болсон тул Коннид бас нэг зовлон нэмэгдлээ. Саннид зодуулснаасаа хойш Карло Рицци авгайдаа гар хүрэхээс эмээх болсон хэдий ч эр нөхрийн үүрэг биелүүлэхээ бүр больж, Конниг өвдөг сөхрөн мөргөж гуйсан ч үл тоомсорлон:

- Чи гоморхоод байгаа бол ахдаа алтан хошуу хүргэхгүй юу? Ахад чинь дахиад зодуулбал чи надад дахиад таалагдаж ч юу магад хэмээн даажигнана.

Гэсэн хэдий боловч тэрбээр Саннигаас үхтлээ айж, хадам ахтайгаа цэвдэг хөндий боловч хүндэтгэл үзүүлсэн харьцаагаа бүр таслахгүйг хичээнэ. Тэр өөрөө хамаг хүчээ шавхан сэтгэлийн тун их тэнхээ гаргаж байж л гэмт хэрэг хийнэ байх гэхэд Саннигийн хувьд хүн ална гэдэг хүйтэн цай залгилахтай адил гэдгийг сайн ойлгох бөлгөө. Гэхдээ эл чанар нь Саннигаас өөрийг нь дээрдүүлэн цагаатгах зүйл биш гэж Карло бодохгүй хэдий ч үлгэр домог шиг цуурхан ярьдаг түүний харгис хэрцгий занд атаархах сэтгэл төрдөг нь аргагүй л эр хүний зан буюу.

Том Хейген Намын зөвлөгчийн хувьд Саннигийн үйл явдлыг үл таалах боловч бас ч түүний тактик олон талаараа зөвдсөн тул энэ талаар Их эцэгт хэлж сэтгэл санааг нь зовоох хэрэггүй

гэж шийдлээ. Нэгэн үе булангийн цаанаас буудалцах эл дайн Их Таван намынхныг залхаасан мэт санагдаж, тэд тулалдаанд оролцох нь цөөрсөөр сүүлдээ бүр болив.

Хейген үүнд нь үл итгэн ийм нам гүм болсонд баярлаж сүйд болсонгүй атал харин Санни бүр баяр хөөр болж:

- Би тэдний цусыг нөжтэй нь холиод өгнө өө, гайгүй. Тэр муу хулчгар новшнууд өөрсдөө найрамдал гуйгаад мөлхөөд ирэхгүй хаачив гэж! хэмээн Томд сайрхана.

Ийнхүү баяртай итгэл найдвар төрөхийн хажуугаар лай ланчиг гэр дотроос нь ундарч, авгай нь Санниг Люси Манчинитай хардан хэрүүл маргаан өдөөх болсон тул түүний сонор сэрэмж нилээд суларсан байна. Урьд нь Сандра Саннигийн хэмжээлшгүй тачаалын талаар олны дунд дураараа бурдаг байсан бол одоо түүнийг өөр хүүхэнтэй самбаганалаа гэж зэмлэх болжээ. Эр нөхөр нь өвөрт нь ер орохоо больсонд гомдсон Сандрагийн үглэж янших нь Санниг бүр залхааж гүйцсэн байна.

Тэртэй тэргүй Санни алхам болгоноо хянан тооцоолон, хавь ойрынхоо бүх юмыг хариуцаж сэтгэл тавгүй, бухимдуу явгал бас ийм гай газар дороос гараад ирдэг байна. Санни нэр цуугтай хүний хувьд анд нарынхаа ч, дайсныхаа ч нүдэнд ил байх тул түүний Люси Манчинитай тогтоосон нууц амрагийн харилцааг тэд аль хэдийн олж мэдсэн байлгүй яах вэ? Санни хэдийгээр урьдчилан сэргийлэх болгоомжлох бүх л арга хэмжээг авсан боловч ийм холбоо нь тойрон хамгаалалтын хамгийн сул тал гэдэг нь хэнд ч ойлгомжтой байлаа. Харин Люси өөрөө бол өдөржин шөнөжин хатуу хараа хяналтад байгаагаа ер мэдэхгүй явжээ. Сантино түүнийг харж хандах хүмүүсийг өөрийнхөө отрядаас гаргаж, Люсигийн амьдардаг давхарт нэг байр сулармагц хамгийн сонор соргог, сэргэлэн хүнээ тэнд суулгасан байна.

Их эцгийн бие аажимдаа сайжирч, түүнд эрх мэдлээ шилжүүлэх цаг ойртсоор...

Тэр үед нөхцөл байдал Корлеонегийн намд ашигтайгаар эргэнэ хэмээн Санни найдах бөгөөд тэр хүртэл эзэнт улсынхаа хил хязгаарыг хуучнаар нь сэргээн тогтоох, аавынхаа хүндэтгэл талархлыг хүлээхийн тулд харьяалан захирсан хүмүүсийнхээ аюулгүй байдлыг хангах гээд л ер нь түүнд хийх юм хаа мундах вэ?! Их эцгийн хэргэм цолыг өв залгамжилж авдаггүй, харин эцгийнхээ бизнесийг өвлөх эрхээ нотлох хэрэгтэй байна.

Гэтэл дайсны эгнээн дэх одоогийн амар жимэр байдал аянга буухын өмнөх нам гүмийг санагдуулна.

Өрсөлдөгч дайснууд нь бас л төлөвлөгөө боловсруулан, нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж үзээд ялагдлаас зайлж гарах ганц бололцоо нь Санниг бүр мөсөн устгах явдал гэсэн дүгнэлтэд хүрчээ. Тэд одоогийн байдлыг шүүн хэлэлцээд, эрүүл ухаантай дотроо бодолтой Загалмайлсан эцэгтэй яаж ийгээд тохирч болох бол Саннитай яриад ямар ч найдваргүй гэж үзсэн байна. Түүний тэсвэр тэвчээргүй, улай хүсэн хонзогнох сэтгэл нь зэрлэг бүдүүлгээс гадна өширхөн хорсохоороо ямар ч ажил хэрэгч саналыг хүлээж авдаггүй ажээ. Гэтэл Корлеоне Маранцаллатай дайтсан үеийнх шиг үймээн самууны цөвүүн эрин үед эргэж орохыг хэн ч хүсэхгүй байлаа.

Нэг орой Конни Корлеоне ганцаараа гэртээ сууж байтал утас дуугарч үл таних эмэгтэй Карлог сураглаж гэнэ.

- Хэн асууж байгаа юм бэ? хэмээн Конни тэссэнгүй уулга алдтал нөгөө хүүхэн аальгүйтэн хөхрөв.

- Зүгээр л нэг найз бүсгүй нь байна. Надад өөр ажил гараад өнөөдөр түүнтэй уулзаж чадахгүй болсноо л дуулгах гэсэн юм.

- Өө, муу балиар новш! Ичих нүүрэндээ элэг наасан гичий! гэж ирээд л Конни хашгирч гартал утасны нөгөө үзүүрт харилцуур тавьчихлаа.

Карло тэр орой морин тойруулга очоод их мөнгө алдсандаа дэлбэртлээ уурлан, байн байн балгасаар байгаад шал согтчихсон амьтан оройхон гэртээ ирсэн чинь авгай нь хараал ширээл тавьсаар угтжээ. Тэрээр ялаа үргээх мэт авгай руугаа гар савчсаар шууд халуун усны өрөөнд орж түгжиж авлаа. Шүршүүрт цохиулсны дараа жаахан сэргэсэн Карло шав шалдан гарч ирээд биеэ арчин нэг тийшээгээ явах бололтой хувцсаа солихоор зэхэв.

Конни ташаа тулан, өширхөж хорссондоо царай нь зэвхийрэн:

- Сүйд болтлоо гоёж гоодоод хэрэггүй. Цаад хүүхэн шүү юм чинь утасдаад өнөөдөр чадахгүй гэж хэлүүлсэн. Чи гэрийнхээ утсыг янхан эмстээ өгч яаж зүрхлээ вэ? Өөдгүй новш чамайг алсан ч багадна гээд сайн маажчих, болж өгвөл эмзэг газар нь өшиглөчих санаатай давшлав.

Карло булчин шөрмөстэй гараараа эхнэрээ хол дуулж:

—Чи галзуурав уу? Нэг нь л дэмийрч, тоглоом наадам хийгээ биз? хэмээн хайнга дуугарах хэдий ч түүний сэтгэл түгшсэнээс үзэхэд цаадах нь үүнээс байтугай юм хийж мэдэх хүүхэн бололтой.

Конни нөхрийнхөө гараас мултарсан даруйдаа нүүрэнд нь урт хумсаа шигтгэн, үзэн ядах сэтгэлдээ ташуурдуулан улам ч хүч орох шиг болж, арьс нь хумсан дороо үлдтэл зулгааж маажлав. Карло жирэмсэн эхнэрээ өрөвдсөн юм уу, тун гайхалтай тэвчээр гаргаж болгоомжлоод зөвхөн түлхэж орхихоор нь Конни бүр давраад хашгирч загнаж гарлаа. Түүнээс гадна эр нөхрийн энхрийлэл амсалгүй удсаны дээр хүүхдээ гаргахаас өмнө хоёр сар хүнтэй хавьтаж болохгүй гэж эмч зөвлөснийг санахаас бүр ч шатаж гарав. Эмэгтэй хүний ханаагүй хүсэл нь хорсол гомдол дээр нь давс нэмжээ.

- Өнөөдөр чи хаашаа ч явахгүй, гэртээ бай!

- За, Конни минь, намайг тайван байлгаад өгөвч?! хэмээн Карло ярдаглах зуур нүцгэн шахуу сайхан биеийнх нь уран налархай хөдлөл бүрийг эхнэр нь өлөн нүдээр шүлэнгэтэн ширтэхийг ажаад тоглоом наадмаар өнгөрүүлэх санаатай: - Энэ гэрт намайг хооллох хүн байна уу? гэх нь эхнэрээ гэмтээж бэртээхээс эмээсэн хэвээр байгаа ажээ.

Эхнэр хүний ядахдаа нэг үүргийг нь сануулсанд сэтгэл сэргэсэн Конни ээжээрээ заалгаж

хоол хийх урлагт гаргуу суралцсан болохоор төвөг удсангүй, тугалын мах шарж, зууш салат бэлтгэв.

Түүнийг гал зуухны өрөөнд бөгтгөнөх зуур Карло виски дүүргэсэн аяга бариад орон дээрээ тухалж, маргаашийн морь уралдааны программыг уншиж байтал эхнэр нь орж ирээд урилга хүлээсэн янзтай хаалганы дэргэд хэсэг зогсов.

Дур хүрэхээ байчихлаа хэмээн Карло залхуутай үгүүлээд аягатайгаа нэгмөсөн хөнтөрч дахин виски хийж авав.

- Хоол хийгээд ширээн дээр тавьчихсан шүү дээ.

- Тэгвэл цааш нь далд хийчихгүй юу? гэтэл Коннигийн уур нь дүрсхийн гал зуухны өрөөнд орж ширээн дээрээс тавагтай хоол шүүрэн авч сав угаах тосгуур руу шидэж орхив. Сав суулга хагарах чимээнээр Карло унтлагын өрөөнөөс үсрэн гарч ирээд угийн цэвэр цэмцгэр байх донтой тул ханаар нялагдсан мах өөх, тос, хагарч бяцарсан аяга таваг хармагц уур хилэн нь дүрсхийгээд явчхав.

- Заваарсан шаар минь, одоохон цэвэрлэ! Тэгэхгүй бол наадахыг чинь чамаар арччихаж би дөнгөнө шүү!

- Би цэвэрлэх юм гэнэ, солиоров оо, чи! хэмээн Конни хэгжүүрхээд бүргэдийн савар шиг урт хумстай гараа Карлогийн нүцгэн цээж рүү сарвалзууллаа.

Карло унтлагынхаа өрөөнд гүйхээрээ орж минутын дараа өмднийхөө тэлээг нугалж барьсаар гарч ирээд:

- Одоохон арилга, наадах аа! хэмээн дахин заналхийлэн зандрав. Конни түүнд тоож хариу хэлсэнгүй, хөдөлсөн ч үгүйд Карло түүний бүдүүн гуяыг нэг их өвчингүй ч хорсгохоор чанга ороолгоод авлаа.

Конни гал зуухны ширээ рүү ухарч шургуулганаас талхны урт хутга тэмтэрч аваад нөхөр рүүгээ чиглүүлсэнд Карло тачигнатал хөхрөв.

- Корлеонегийн гэр бүлийнхэн хүүхнүүд нь хүртэл бүгд алуурч юм гээч!

Карло өмднийхөө тэлээг орхиж авгай руугаа дөхсөнд Конни хутгатай гараараа гэдэс рүү нь цохих гэсэн боловч бүдүүрч хүндэрсэн биеэ бүрэн эзэмдэж чадсангүй нөхөр нь гарыг нь амархан барьж авчээ. Карло авгайгаасаа хутгыг булааж аваад хөх няц болгочихгүйг хичээн хоёр хацрыг нь яаралгүй жигд алгадаж гарав. Конни гараараа толгойгоо халхлан, зодуулахаас зайлсхийх санаатай ухрах боловч Карло түүнийг өвдөж, доромжлуулсандаа болоод жаахан хүүхэд шиг цорхиртлоо уйлтал нь залхаах цээрлэлээ үргэлжлүүлсээр байв. Эцэст нь Конни нөхрөө хамаг чадлаараа хазаад авах санаатай ухасхийсэн авч Карло үснээс нь зуурч угзарсан тул түүний шүд агаарт хий тасхийгээд өнгөрлөө. Карло авгайгаа унтлагын өрөөнд хөөж оруулаад орон дээр өрөвдөлгүй шидэж, өөрөө орны хажуугийн ширээн дээрээс шилтэй виски авч хэд сайн балгаснаа шал согтов бололтой, гөлийсөн цэнхэр нүдэнд нь гялалзах галзуу

очийг хараад Коннид жинхэнэ айдас төрөв.

Ширээн дээр хоосон шилээ тавиад Карло орон дээр хэвтгээ эхнэрийнхээ дээрээс тонгойн хажуу бөөрнөөс нь хатуу яхир хуруугаараа хүчтэй базаад авсанд Конни өвдсөндөө хамаг чадлаараа хашгирч аврал өршөөл гуйв.

- За больж, үз, италийн тарган гахай чамаар би яах юм бэ? хэмээн Карло зэвүүрхээд гарч одлоо.

Конни нэг хэсэгтээ өндийж зүрхлэхгүй хэвтсээр байснаа сүүлд нь тэссэнгүй, өлмий дээрээ гишгэсээр сэмхэн очиж шагайвал Карло дахин нэг шил вискинээс байн байн балган буйдан дээр хэвтгэж байв. Удахгүй нам согтож унтахаар нь гал зуухны өрөөнд орж Лонг Бич рүү утасдаж болох юм байна гэдгийг Конни ойлголоо. Хэн нэгнийг ирүүлж, түүнийг эндээс авахуулах хэрэгтэй. Санни биш, Том Хейген юм уу ээж утас авбал сайн юмсан.

Оройн арван цаг болж байхад эрхэм Корлеонегийн гэрт утас хангинаж, бие хамгаалагчдын нэг нь харилцуур авснаа Коннигийн ээж, хатагтай Корлеонед бушуухан өглөө. Гэвч охин нь уйлж унжихын зэрэгцээгээр хажуугийн өрөөнд хурхирч хэвтгээ нөхрөө сэрээчихгүйг хичээн аяархан ярих тул ээж нь юу ч ойлгосонгүй Энэ үеэр Коннигийн царай уруул нь памбайтлаа хавдаад дуулгаваргүй уруулаараа шивнэх үгсийг хүн ойлгох ямар ч аргагүй тул хатагтай Корлеоне бие хамгаалагчдын нэгээр хүүгээ дуудууллаа.

Санни зочдын өрөөнд Том Хейгентэй ярилцаж сууснаа ээжийнхээ дуудахаар гал зууханд орж ирээд харилцуур авав.

- Би байна, Конни.

Зочдын өрөөнд дугжирч хэвтгээ нөхөр, юу ч хийхээс буцахгүй том ах хоёроосоо хоёулангаас нь үхтлээ айсан Коннигийн үгс бүр ч ойлгогдохоо больжээ.

- Чи надад машин ирүүлээч? Би очоод бүгдийг ярья. Сүйд болсон юм алга, та өөрөө ирсний хэрэггүй шүү. Томыг явуулчих. Би зүгээр л та нар дээр очих гэсэн юм.

Том Хейген Их эцэгт нойрны эм өгч унтуулчхаад Санниг хараанаасаа салгахгүй байхыг эрмэлзэх тул яг энэ үеэр гал зуухны өрөөнд орж ирээд юуны түрүүнд түүний царайг олж харжээ. Тасалгаанд байсан бүх хүмүүс Саннигийн царайг ажиглаж, бие хамгаалагч хоёр эр телефон утас руу айсан нүдээр ширтэнэ. Саннигийн лужир бүдүүн хүзүүнд аажим аажмаар цус хуран хүрэнгээ нүдэнд нь уур хилэнгийн оч гялалзаж, царай нь хөшиж гөлийгөөд харилцуур атгасан гар нь үл мэдэг чичгэнэх боловч харин хоолойгоо эзэмдэн тайван дуугарч чадлаа.

- Дүү минь тайвширч үз. Чиний араас одоохон хүн очно, хүлээж байгаарай. Юунаас ч бүү ай.

Тэрээр харилцуураа тавиад минут хэртэй уур хилэндээ багтран хөдлөлгүй зогсож байснаа аяархан дуугаар:

- Ёстой муу шаар! Дүүрчихсэн тэнэг амьтан! гэснээ огло үсрэн гарлаа.

Хейген Саннигийн нүүр царайгаар нь одоо ятгаж хэлсэн ямар ч үг хүлээж авах чадваргүй болсныг нь ойлгоод түүнийг хорьж зогсоох гэдэг хурдан галт тэрэгний өөдөөс нүцгэн цээжээрээ дайрсантай адил болохыг сайн мэдэх тул ямар арга хэмжээ авахаа яаран бодно. Санни хот ортлоо уур нь жаахан намдаад юмны учир ойлгож эхэлнэ. Жаахан ч гэсэн сэрэмжлэн хамгаалах талаар бодож үзээсэй билээ. Карло ч баларч дууссан байхаа даа!

Цонхны цаана машины хөдөлгүүр нүргэлэхээр Санни өөрөө яваад өгснийг ойлгомогц Хейген:

- Бушуухан араас нь явцгаа! хэмээн бие хамгаалагч нарт тушаав.

Дараа нь утас шүүрэн авч, хотод амьдардаг Саннигийн отрядын залуусын нэг даруй Карлогийнд очиж, гэрээс нь авч гар хэмээн тушаав. Өөр нэг бүлэг дайчид ахыг нь очтол Конниг хамгаалж байх ёстой ажээ. Санни хэдхэн гэрчийн этгээдүүдийн нүдэн дээр бол хүр дүүгээ нухахаас буцахгүй байх гэж Хейген юу юунаас илүү айсан тул аль болох олон хүн тийш нь явуулжээ. Дайсан этгээдээс тэрээр энэхэн үед нэг их айсангүй. Таван намынхан Загалмайлсан эцэгтэй хэлэлцээ хийх аятайхан цагийг хүлээн ямар ч дайсагнасан ажиллагаа явуулалгүй удсан тул одоо хамгийн гол нь Санниг өөрөөс нь хамгаалах хэрэгтэй байлаа. Түүний энэ байр суурийг Их эцэг сайшаана гэдгийг Хейген сайн мэднэ.

Үнэхээр ч Санни Лонг-Бичийн аюулгүй бүсээс гарсан даруйдаа болгоомжлох ёстой атал тэгсэнгүй, Их Таван нам чимээ аниргүй байгаад хууртан ямар ч аюулгүй юм шиг санагджээ. Гэхдээ түүний араас бие хамгаалагч өөр машинаар ухасхийн хөдлөхийг сонсоод Хейгений шалмаг ажиллагаанд сэтгэл хангалуун явлаа.

Санни үүдний танхимаар гүйж гарахдаа халаасандаа гар буугай пиджакаа шүүрэн авч амжсанаас гадна өөр нэг гар буу машиных нь нууц хайрцагт байгаа билээ. Энэ «бьюик» машин нь өөр хүний нэр дээр бүртгэлтэй болохоор дугаар нь өштөн дайсны ч, цагдаагийн газрынхны ч анхаарлыг татахгүй. Тэгээд ч ер нь буугаа ямар ч тодорхой зорилгогүй хар зөнгөөрөө шүүрч авсан билээ. Тэр муу Карло Рицциг нээрээ буудалтай биш, одоо яахаа Санни бүр мэдэхээ байжээ.

Санни машиныхаа хар хурдаар давхих зуур эргэцүүлэн тунгааж бодсоор төрөөгүй хүүхдийн эцгийг, тэр тусмаа төрсөн дүүгийнхээ хар хүнийг хороож чадахгүйгээ ойлголоо. Тэгээд ч гэр бүлийн хэрүүл маргаанаас болоод хүн алалтай биш дээ. Гэвч тэр өөрөө төрсөн дүүгээ энэ адгийн шаартай анх танилцуулсан болохоор Коннигийн зол жаргалгүй амьдралын төлөө өөрөө хариуцлага хүлээх ёстой гэсэн нэгэн бодол Саннигийн сэтгэлийн мухарт сүүтгэнэнэ.

Хамгийн гайхалтай нь гэвэл, Санни хэдийгээр галзуу догшин зан авиртай боловч хэзээ ч эмэгтэй хүнд гар хүрч, нялх хүүхэд юм уу, тэнхээ тамиргүй өвгөд өтгөсийг гомдоож чадахгүй бөлгөө. Тэр нэгэн удаа Карло Рицци рүү нударга зангидан дайрахад нь тэрээр ер эсэргүүцэл үзүүлээгүй тулдаа л амь гарсан юм. Карло өөдөөс нь жаахан арвалзсан бол Санни түүнийг үнэхээр үхтэл нь зодох байсан бөгөөд харин гартаа зэвсэггүй, номхон хүлцэнгүй хэнийг ч болов танилгож чадахгүй байлаа. Ер нь Санни багаасаа өр зөөлөн, сайхан сэтгэлтэй байсан

агаад алуурчин больё гэж огт бодоогүй, зүгээр л хувь тавилан, заяа төөрөг нь тийм байсан юм болов уу даа.

Санни Корлеоне Жоунс-Бич ороход заавал дайрдаг далан дээрх нарийхан гүүрээр гарч явахдаа: «Гэлээ ч гэсэн Коннигийн асуудлыг нэгмөсөн шийдэх цаг болжээ» хэмээн бодлоо. Тэрбээр Нью-Йорк орохдоо хөл хөдөлгөөн багатай болохоор хар хурдаараа давхиж болдог энэ замаар дандаа явдаг байлаа. Хурдан явсандаа болоод толгой сэргэж жаахан тайвшрав. Тэрээр зүгээр л очоод дүүгээ машиндаа суулгана. Харин тэр муу шаар дүүг нь дахиад зодсон байвал эрэмдэг болтол нь зодохоос өөр яах вэ? Дутуу онгойлгосон цонхоор сэрүүн салхины аясаар тэнгисийн давсархаг агаар амтагдан Санни цээж дүүрэн амьсгалахаар шилээ бүр гүйцэд буулгав.

Жоунс-Бичийн зам урьдын л адил эл хуль байсанд гол замын гэрэл харагдтал хар хурдаараа давхин хүрвэл энэ үеэр гол зам дээр ч машин тэрэг бараг үзэгдсэнгүйд тэрээр хурдаа саасангүй. Бие хамгаалагч нарын машин тэртээ ард хол хоцорчээ.

Эргэн тойрон нэг ч машин хүнгүй, зөвхөн замын татвар хураагчийн бүхээгийн гэрэл л цайран харагдана. Санни тоормос дээрээ гишгэх зуур задгай мөнгө эрэн халаасаа тэмтэрсэн боловч олсонгүйд өрөөсөн гараараа пиджакны халааснаас түрийвчээ авч нэг дэвсгэрт сугалаад бүхээгийн өмнө хүрч очтол өмнө нь нэг машин зам хаан зогссон байхыг хараад их гайхлаа. Жолооч нь машиныхаа дэргэд зогсоод татвар хураагчтай нэгэн зүйлийг хүүрнэж байснаа Саннигийн дохио дуу гармагц бушуухан машиндаа орж суугаад зам чөлөөлөн зайлуулав.

Санни цаасан дэвсгэрт авч өгөөд машин дотор хэтэрхий хийтэн болсон тул хажуугийн шилээ тултал нь дээш өргөлөө. Татвар хураагч хариулт мөнгө тоолон мунгинаж байгаад шалаар нэг тараачихсан бололтой цонхны цаанаас цухуйсангүй.

Нөгөө машин бүр явсангүй, жаахан урагшлаад, Саннигийн машинаас хэдхэн метрийн зайтай бас л зам хаагаад зогсож байхыг Санни ажиглах тэр үед дотроо гэрэлгүй бүхээг дотор нэгэн сүүдэр бүртэлзэх шиг санагджээ. Гэвч урьд нь зогсож байсан машинаас хоёр эр гарч өөрийг нь чиглэн алхахыг хараад Санни ямар ч дүгнэлт хийж амжсангүй, зүгээр л амьд явах эцсийн мөч ирснийг яагаад ч юм, дор нь ойлгов.

Саннигийн сэтгэлийн мухарт үүрд гүн нуугдаж асан айдас зайлшгүй үхлийн өмнө гэнэт гадагш шахагдан гарахдаа сэтгэл санааг нь ариутган цэвэрлэсэн мэт уурлан хорсон, үзэн ядах ямар ч бодол төрсөнгүй. Гэсэн хэдий боловч одоо хүртэл амьд явах хүслэн түүний дотор оргилон буцлах тул тэрбээр ер цааргалж тээнэгэлзсэнгүй, «бьюик»-ийн хаалга налан ойчих тэр агшинд харанхуй бүхээгнээс анхны сум шунгиналаа.

Чийдэнгийн гэрэл туссан Саннигийн дүрс тун аятайхан бай болж, юуны түрүүнд хүзүү, толгой нь суманд өртөн доош гулсав. Нөгөө хоёр эр бараг тулж ирээд гар бууныхаа хүхээг суллаж, Саннигийн бие хаалга мөргөн онгойлгож, барагшин зам дээр унахад хөл нь машин дотор үлдэв. Хоёр дээрэмчин сумаа дуустал буудаад, алуулсан эрийг танигдахгүй болтол нь зэрэмдэглэхийг хичээн хүнд гутлаараа нүүр нүдгүй өшиглөж гарлаа.

Хэдхэн хормын дараа гурван алуурч, замын татвар хураагчийн дүрд тоглосон эр дөрвүүлээ машиндаа суугаад Модоубрук Паркуэй ордог замаар хурдалж явав. Саннигийн бие хамгаалагчид хэрэг явдал болсон газар давхиж ирэхэд манаачийн цагаан бүхээгийн хажууд зам хаасан машиныхаа дэргэд цус нөжиндөө хутгалдан тэрийсэн Саннигаас өөр хэн ч алга байлаа. Алуурчдыг хөөж гүйцэх боломжгүй, гүйцэх ч онцын шаардлагагүй байсан учраас бие хамгаалагчид нь машинаа огцом эргүүлж автомат утасны бүхээг рүү хурд мэдэн давхиж хүрээд, нэг нь явуут үсрэн бууж Лонг-Бич дэх Том Хейгений утсанд залгав.

- Санни Жоунс-Бичийн дэргэдэх гармын хажууд отоон дээр давхиж ороод алуулсан байна.

- Ойлголоо. Одоохон энд хүрээд ир гэж Клеменцад дамжуул. Цааш яах тухай захирамжийг та нар түүнээс авах болно хэмээн Хейген тайван дуугарчээ.

Тэрбээр гал зуухны өрөөнөөс ярьж байсан тул дэргэд нь охиндоо хоол унд бэлдээд нааш цааш холхих хатагтай Корлеонед аймшигт гай гамшгийг мэдэгдэхгүйн тулд хамаг хүчээ шавхан хэнэггүй царайлан гараад булангийн өрөөнд ирсэн хойноо л сая бүх биеэ сул тавилаа. Байдгаараа чичгэнэх хоёр гараа өвдгөндөө хавчин буйдан дээр толгой гудайн суусан боловч нэмэр болсонгүй хамаг бие салганах нь чөтгөр шулмын хар хүчинд мөргөл үйлдэн бөөлж байна уу гэлтэй.

Тэрээр дайн тулааны үеэр Намын зөвлөхийн үүрэг гүйцэтгэж чадахгүй нь одоо тодорхой боллоо. Их Таван намынхан түүнийг нусгай жаал шиг молигодож, тэрээр хуурамч хүлцэнгүй байдалд нь хууртаад хорон муу санаагаа гүйцэлдүүлэх бололцоо тэдэнд олгосон байна. Тэд Санни Корлеонегийн ялалтыг хүлээн зөвшөөрсөндөө биш, далд санаа агуулсандаа хүлцэнгүй номхон дүр үзүүлж байгаад тохиромжтой нөхцөл бүрдмэгц үхлийн цохилт өглөө. Женко Аббандандо яалаа ч гэсэн нүцгэн дэгээнд хууртахгүй, дайсан этгээдээ оромж нүхнээс нь утан гаргах арга ухаан сийлж, Санни өөд сунгасан цуст саврыг тас цохихсон... Томын зүрхэнд алдаа доголдлоо ойлгох гашуун сэтгэл жинхэнэ уй гашуутай холилдон шаналгаж гаслан гиншив. Санни түүний амийг аварч гэртээ авчраад хуурай ах нь болж төрсөн дүүгээсээ ялгаагүй ханддаг байсан болохоор Том Хейген үнэхээр хайртай дотно хүнээ алджээ.

Гэхдээ өөрөөс нь илүү уй гашууд унах ээжид нь хэлж зүрхлээгүй болоод Том Хейген гал зуухны өрөөнөөс зугтаасан юмсанж. Фредо Невадад нуугдаж, Майкл Сицилд амиа хаацайлж байх энэ үед дэргэд нь үлдсэн ганц хүү нь алуулсныг хатагтай Корлеонед дуулгана гэхээр л ам хэл нь ер эвлэж өгсөнгүй аж.

АРВАН НАЙМДУГААР БҮЛЭГ

Сантино Корлеоне ийнхүү алагдсан нь ногоон цүнхээлд шидсэн чулуу шиг нийт Америкийн гэмт хэрэгтний ертөнцийг тэр чигээр нь цочроон донсолгожээ. Эрхэм Корлеоне удирдлагын жолоог дахин атгахаар өвчнийхөө хэвтрийг орхин боссон тухай мэдээ ирж, оршуулгын газраас буцаж ирсэн тандагчид Их Эцгийн бие бүрэн илааршсан байртай харагдсаныг мэдэгдсэн даруйд л өшгөн дайсан нь эл халдлагын хариуд цус асгаруулсан дайн өдөөх нь зайлшгүй гэдэгт өчүүхэн ч үл эргэлзэх Таван намын төлөөлөгчид хамгаалалтад яаран бэлтгэж хөл хөөрцөг болцгоосон нь зүйн хэрэг буй заа. Эрхэм Корлеонед учирсан энэ золгүй явдлын дараагаар түүнийг хэрэгсэхгүй орхин эс тоомсорлох түүний гэнэн бодол тэдний хэний ч толгойд буусангүй. Их Эцэг есөн буянт, есөн нүгэлт хорвоо дээр амьдрах эл хугацаандаа цөөхөн алдсан хэдий ч алдаа болгоноосоо ямар нэгэн сургамж авч гарсан нь мэдээж хэрэг.

Харин ганц Хейген л Их Эцгийн чин үнэн санааг мэдэж байсан тул найрамдал байгуулахаар Таван нам руу төлөөлөгч явуулахад нь ер гайхсангүй. Тэрбээр зүгээр ч нэг эв эеэ ололцох гэсэнгүй, харин ч Нью-Йоркийн бүх нам, бүлэглэлийн зөвлөгөөн хийж, бас нийт улсын бүх отгийн синдикатуудыг урьж оролцуулах санал гаргажээ. Тухайн үед Нью-Йорк хотноо Америкийн хамгийн хүчирхэг омгийнхон хуран төвлөрөөд байсан болохоор тэдний эв түнжингээс бусдынх нь амар түвшин амьдрал тодорхой хэмжээгээр хамаарна гэдгийг бүгд сайн ойлгож байлаа.

Энэ саналыг сонсоод бүгдээрээ эргэлзэн гайхжээ. Занга юм болов уу? Дайсан этгээдийнхээ сонор сэрэмжийг сулруулж байгаад гэнэдүүлэн дайрах гэж байна уу? Толгой дараалан алж хядан хүүгийнхээ амийг нэгмөсөн бүгдээс нь нэхэх гэсэн юм биш биз? Гэвч эрхэм Корлеоне чин үнэн цагаан сэтгэлийнхээ баталгааг нэн даруй гаргалаа. Юу гэвэл нэгдүгээрт, тэрээр энэхүү уулзалтад гүрэн улсын өнцөг булан бүрээс синдикатуудыг урин оролцуулж байгаагаас гадна өөрийн тэргүүлсэн хүмүүсээ байлдааны бэлэн байдалд оруулах юм уу, хань хамсаатан элсүүлэхээр яаран оролдох нь огт мэдэгдсэнгүй. Дараа нь тэрээр энэ уулзалтад Боккикьогийн намаар зуучлуулахаар тохиролцсон нь санаа бодлынхоо үнэн шударгыг хөдөлбөргүй эцэслэн нотолсон, чухал алхам болсны зэрэгцээгээр дээд хэмжээний зөвлөгөөнд оролцогчдын аюулгүй дархан байдлыг бүрэн хангаж чадсан байна.

Боккикьогийн нам гэдэг нь нэгэн бодлын цорын ганц онцгой үзэгдэл бөгөөд тэртээ нэгэн цагт хосгүй зэрлэг харгисаараа нэрд гарсан сицилийн мафиас салаалсан эл омог Америк тивд харин эв найрамдлын өвөрмөц зэвсэг болон хувирчээ. Тухайн үедээ галзуу харгислал, яргаллаар хоолоо олж иддэг байсан отгийнхон одоо ариун гэгээнтний гэмээр нигүүлсэнгүй үйлдлээр ходоодоо тэжээх болсон аж. Боккикьогийнхны нэг үнэлж баршгүй ховор нандин чанар гэвэл нийт омгийг хэрэн сүлжиж яс модыг нь гагнах цусан төрлийн ган бат холбоо, хамаатан садандаа эхнэр, нөхрөөсөө илүү үнэнч явдаг орчинд ч ховорхон тохиолдох аймаг угсааны нягт нэгдэл байлаа. Чухамхүү энэ шалтгааны улмаас л Боккикьогийн нам өшөөрхөн дайсагнасан мафийн омгийнхон найрамдахаар эвийн хэлэлцээр хийх үед зуучлах, барьцаанд үлдэх хүмүүсээ ирүүлдэг байв.

Омгийн гишүүд их багагүй бүгдээрээ төрөлхийн богино бодолтой, тодруулж хэлбэл,

мулгуудуу болхи ухаантай улс. Ямар ч гэсэн тэд өөрсдөө энэ доголдлоо ойлгохын хэрээр биеэ худалдах, мөрийтэй тоглох, мансууруулагч наймаалах, томоохон луйвар хийх зэрэг нарийн төвөгтэй ажил хэргийг эрхлэн зохион байгуулж, эрхшээлдээ авах тэмцэлд мафийн бусад нам омгийнхонтой өрсөлдөн хүчээ үзэхийг санаархдаг ч үгүй байлаа. Жирийн цагдаад мөнгө атгуулах зэргийн юманд бол ч тэдний сүүхээ ухаан хүрэлцэнэ үү гэхээс биш, нөлөө бүхий томоохон албан тушаалтай «шаврын хаалтад» хээл хахуул өгнө гэдэг нь гүндүүгүй гүдэхэн, гэнэн цайлган тэдний хувьд ёстой баршгүй хоол, давшгүй даваа ажээ. Гэхдээ тэд өөрсдийн ярьдгаар нэр төр гэгчдээ хязгааргүй үнэнч явдаг, бас дээр дурдсанаар хэмжээгүй харгис авирладаг хоёроороо бусдаас давуу талтай.

Боккикьогийн отгийнхноос хэн нь ч худал хэлж, урваж шарвадаггүйн учир гэвэл иймэрхүү нарийн ширийн юм оюуны их хүчлэлийг шаарддагт байгаа л болов уу. Бас эл отгийнхноос нэг ч хүн гомдол доромжлолыг өршөөнө гэж байхгүй, хариугаа авахын тулд яахаас ч буцдаггүй. Дэргэд нь чухамхүү энэ хоёр зан чанар байж, дээрээс нь тэнгэр ивээсний хүчээр л тэд өдгөөгийн энэ орлоготой ажлаа олж авчээ.

Сөргөлдөн тэмцсэн нам, омгууд эв эеийг эрхэмлэн найрамдлын хэлэлцээр хийхийг хүсвэл Боккикьогийн овогтой холбоо барихад л хангалттай бөгөөд омгийн толгойлогч уулзалт хийх урьдчилсан болзлыг тохиролцсоны хойт дээр шаардлагатай тооны барьцааны хүмүүсийг ирүүлнэ. Тухайлбал, Майклыг Солоцотой уулзахаар явахад түүний хөлсөлж авсан Боккикьогийн төлөөний этгээд Майклын амь насны барьцаа болон Корлеонегийн төв байранд үлдсэн ажгуу. Хэрэв заяа Солоццо Майклыг ертөнцөөс халиулахаар шийдвэл барьцааны хүн түүний араас диваажинд одож, Боккикьогийнхны өш хонзонгийн сүхний ир тэдний садангийн сүйрэлд гэм буруутай Солоцогийн ар дагзан дээр буух бөлгөө. Хомсхон оюуны улмаас ч юм уу, бүү мэд, эл тохиолдолд Боккикьог зохих хариугаа авч шийтгэхэд нь юу ч ямар ч хатуу ял цээрлэл саад үл болно. Үхэх хэрэгтэй л бол тэд үхээд өгдөг болохоор урван тэрсэлсэн хэн боловч хохь нь болоод өнгөрөхөөс өөр ямар ч арга зам байдаггүй болохоор Боккикьогийн барьцааны хүн нөгөө этгээдийнхээ аюулгүй байдлыг хангах зуун хувийн баталгаа болдог байв.

Тийм ч учраас эрхэм Корлеоне энэ уулзалтад зуучлуулахаар Боккикьод хандаж эвсэн найрамдах зөвлөгөөнд ирж соёрхох нам, отог болгонд таарах тооны барьцааны хүн ирүүлэхээр тохиролцсоны хойт дээр эргэлзэж тээнэгэлзэх юмгүй болжээ. Нэгэнт л Боккикьо батлан даалт гаргасан бол юуны чинь хоёр нүүр гаргах, молиго үмхүүлэх вэ?! Энэ зөвлөгөөнд хурим руу явж байгаа юм шиг л амар тайван очиж болно.

Барьцааны хүмүүс хэлсэн ёсоор хүрэлцэн ирж, уулзах газраа ч товлон тохирч, нэгэн багавтар арилжааны банкны хурлын танхимыг сонгон авчээ. Банкны ерөнхийлөгч эрхэм Корлеонегийн өмнө их өртэй, бас үгийн далимд дурдахад, Их Эцэг эл банкны нилээд акцыг мөн л ерөнхийлөгчийн нэр дээр худалдан авсан байсан юм. Загалмайлсан эцгийн гуйлт ерөнхийлөгчийн хувьд тушаалаас өөрцгүй тул тохоон товлосон бямба гаригт банкны захиргаа, бусдаас тусгаарласан арьсан бүрээстэй буйдан сандлаар тоногдсон том танхимын хамт тэр чигээрээ өрхийн синдикатуудын мэдэлд шилжжээ.

Арван цагийн орчим банкны харуулын дүрэмт хувцас өмсөн тоо томшгүй шилдэг залуус гадуур дотуургүй бүслэн хамгаалсан хурлын танхим руу уулзалтад оролцох хүмүүс цувж

эхэллээ. Эл зөвлөгөөнд Нью Йорк хотын Таван намаас гадна тэдний сүрэг дэх хамуутай хонь гэгддэг Капонегийн харьяалах нутаг Чикагогоос л бусад газар болгоноос хүмүүс урьж оролцуулахаар товлосон юм. Чикагогийн тэр догшин хэрцгий залуусыг соёл иргэншилтэй нийгмийн шаардлагын дагуу өөд татан засч хүмүүжүүлэх оролдлогоос аль хэдийн татгалзсан хийгээд ийм буурь суурьтай зөвлөгөөнд тийм цагаандаа гарсан зэрлэг балмадуудыг урих нь илүүц гэж үзсэн байна.

Уулзалтад оролцогчид урьдчилан тогтоосон дэс дарааллаар ес хагасаас арав хүртэл хуран цугларав. Олон зүйлийн дотор бас цаг барихыг чухалчлан эрхэмлэдэг эрхэм Корлеоне эвийн хэлэлцээрийг санаачлагч, нэг ёсондоо энэ зөвлөгөөний тэргүүлэгчийн хувьд хамгийн түрүүнд ирлээ, Дараахан нь эрх мэдлийн хүрээ нь өмнөд муж улсуудаар тархсан Карло Трамонти ирэв. Сицили хүн гэхэд хэтэрхий өндөр, наранд борлосон цэвэрхэн царайдаа тохируулж үсээ самнасан, дэгжин хувцастай дунд зэргийн насны буурьтай төвшин тэр эрийг итали хүн гэж итгэхэд хэцүү. Чөлөөт цагаараа амины дарвуулт онгоц дээрээсээ загас барьж буй америкийн саятангуудыг сэтгүүлийн хуудаснаа яг л иймэрхүүгээр дүрсэлдэгсэн. Трамонтигийн омгийн орлого эд, баялаг нь мөрийтэй тоглоомоос уг сурвалжтай бөгөөд омгийн тэргүүлэгчийг нь харсан хэн ч гэсэн тэртээ нэгэн цагт сайхь эр ямар их хатуу зүрх гарган, зэрлэг харгислал үйлдэж байж эзэнт улсаа эрх мэдэлдээ оруулж эмхлэн байгуулсныг огтхон ч сэжиглэхгүй. Бага насандаа тэрээр хувь заяаны догшин бугуйлд цаламдуулан Сицилээс Флоридад ирж, тэндээ өсч өндийгөөд, өмнөд нутгийн хотуудаар нэг тарсан мөрийтэй тоглоомын газруудыг эзэмшдэг синдикатад ажиллах болжээ. Синдикатын эзэд нь болох орон нутгийн засаг захиргааны ажилтан америкчууд дотроо бодолтой буурьтай хүмүүс, тэдний түшиг тулгуур нь болсон цагдаагийн албан тушаалтан нар ч гэсэн доль цохисон хашир эрс байсан тул төөрч яваад энд ирсэн эл сицилийн нусгай бандид дийлдэнэ чинээ зүүдлээ ч үгүй явжээ. Залуу эрийн зэрлэг араатан лугаа адил харгис хэрцгий зан тэднийг цочирдуулах хэдий ч болжмор буудахад сумны гарз гэж бодоод өөрт нь ширүүлдэггүй байж л дээ. Гэтэл Трамонти цагдаагийн газрынхны хүртэх хувь шанг нэм нэмсээр өөрийн талд оруулж аваад, харин ямар ч ухаан сүүхээгүй хөдөлж ажил хэргээ арай ядан явуулж асан хөдөөгийн хэдэн мангаруудыг зүгээр л толгой дараалан хядчихсан гэдэг. Түүгээр ч үл барам эл овсгоотой эр Кубыг эзэгнэн захирч Батистатай холбоо сүлбээ тогтоож, тун ч их удалгүй мөрийтэй тоглоомын газар, янхны ордон зэрэг Гаванагийн цэнгээний газруудад ихээхэн мөнгө өгөөмөр гараар цутгасан нь тэдний гял цал буусан өнгөний сайхнаар Америк тивээс түрийвч зузаантай үрэлгэн хүмүүсийг хорхойтуулан даллан дуудах гэсэн холын хараа байлаа. Эдүгээ сайхь Трамонти нь Майами-Бич дэх хамгийн хээнцэр тансаг зочид буудлыг эзэмшиж, сая саяар тоологдох хөрөнгөө улам арвижуулж суугаа нэгэн.

Бас л өөр шиг нь борлосон гарын зөвлөхөө дагуулсан Трамонти танхимд орж ирээд хүүгээ алдсан эцэгт таарч зохилдох хэмжээгээр эмгэнэл илэрхийлсэн дүр эсгэж эрхэм Корлеонег тэврэв.

Удаад нь Детройтын их эцэг Жозеф Залукки ирсэн аж. Залуккигийн нам Детройтын ойролцоох нэгэн морин тойруулгыг зохих халхавчийн дор далдуур эзэмшдэгээс гадна олон тооны наадгайн газартай. Залуккигийн хүү нь Америкийн эртний сурвалжит, нэр хүндтэй гэр бүлээс эхнэр авч ураг төрөл болсон тул сэтгэл хангалуун сайхь эр саран мэт дүгрэг малигар царайдаа аз жаргал амарлингуй байдлыг гэрэлтүүлэн Гросс-Пойнт дахь зуун

мянгын үнэ бүхий чамин харшдаа налайж хэвтэхээс ч өөр яах билээ?! Эл Их эцэг эрхэм Корлеонегийн нэгэн адил хал үзэж халуун чулуу долоосон ханамж сэрэмжтэй хүн болохоор хүч хэрэглэсэн гэмт хэргийн тоогоороо мафийн эрхшээлд байдаг бүх хотын дотроос Детройт хамгийн эцсийн байр эзэлж, сүүлийн гурван жилийн дотор ердөө л хоёр хүний амийг цаазаар авчээ. Харин Детройтын их эцэг мансууруулагчийн наймааг ойшоодоггүй юмсанж.

Залукки бас л гарын зөвлөхөө дагуулан ирж хоёулаа эрхэм Корлеонетой тэврэлдэв. Бага зэргийн Залуккигийн зугуухан хүнгэнэх эр хонгор хоолойг цэвэр америк хүний дуу гэж андуурмаар. Үнэхээр ч чамбай оёсон костюм өмсөж, ажил хэрэгч царай гарган дур булаам элэгсэг харилцдаг тэр эр гадна төрхөөрөө яг л жинхэнэ америк бизнесмен шиг харагдана.

Тэрээр эрхэм Корлеонед хандан:

- Танаас өөр хэний ч атугай дуудлагаар энд ирэхгүйсэн гэвэл Их эцэг талархан толгой дохих зуур энэ Залуккигийн дэмжлэгт найдаж болох юм байна гэж бодлоо.

Өрнөд эргийн хоёр их эцэг хоршин ажиллаж, ямагт хамт байхыг эрхэмлэдэг тул энэ удаад ч гэсэн нэг машинаар Нью-Йоркод иржээ. Фрэнк Фальконе, Энтони Молилари хоёр «дөч шүргэж яваа, эл уулзалтад оролдогчдоос хамгийн залуу нь бөгөөд Голливудын нөлөө юм байлгүй хамаа намаагүй хувцасладаг эрээ цээргүй харилцдаг байв. Фрэнк Фальконе үйл ажиллагааныхаа хүрээнд киноны ажилтан нарын үйлдвэрчний эвлэлүүд, киностуд дахь мөрийтэй тоглоомын газруудыг хамруулж, дээр нь Алс Өрнөдийн муж улсуудын нутаг дахь эмсийн хүрээлэнгүүдийг бүсгүйчүүд, хүүхнүүдээр тасралтгүй хангадаг ажээ. Өөрийгөө эрхэмлэн хүндэтгэдэг их эцэг эстрадын жүжигчин шиг аяглах нь урьд дуулдаагүй хэрэг бөгөөд үнэхээр ч ажил төрөл нэгтэй Фальконе үл итгэх харцаар хялайн гадуурхдагт гайхах юун.

Энтони Молилари бол Сан-Францискогийн усан боомтуудын хорооллуудад ноёрхлоо тогтоосноос гадна спортын тэмцээнд мөрийцөн тоглох ажлыг дангаараа гартаа авчээ. Италийн удам дагасан загасчдаас гаралтай болохоороо Сан-Францискод хамгийн сайн «Тэнгисийн хишиг» зоогийн газар нээж, түүгээрээ тун их бахархдаг тул орлого олох нь бүү хэл хохиролтой ч гэсэн хоолныхоо үнийг нэмдэггүй гэлцэнэ. Бас мөрийтэй наадгайд мэргэшсэн байрын царайтай эл эр Мексикийн хилээр юм уу, дорно зүгийн тэнгисүүдээр мансууруулагч сэм нэвтрүүлэн наймаалах хэрэгт холбоотой хэмээн жиг жуг гэх ч хүн цөөнгүй. Энэ хоёрыг дагалдан яваа гунан бухын тэнхээтэй чийрэг хос залуу яав ч зөвлөх биш, бие хамгаалагч нь лавтай мөн бөгөөд харин зэвсэгтэйгээ энд ирсэн нь юу л бол. Эл залуус каратегийн арга мэхэнд гаршсан нь хэнд ч нууц биш боловч хуран цугларсан хүмүүс үүнд санаа зовсон нь ер үгүй, харин ч зугаатай санагдсан бөгөөд ингэж хүн инээлгэе гэсэн бол Калифорнийн их эцгүүд ромын хамба ламын аравнайлсан сахиус хүзүүндээ зүүж ирсэн ч чадах байсан биз ээ.

Дараа нь ирсэн Бостоны намын элч нь бусад их эцгүүд бүгдээрээ нэгэн санаагаар үзэн яддаг цорын ганц хүн бөгөөд эл эр өөрт нь хүчин зүтгэдэг хүмүүстэй өөдгүй муухайгийн цаагуур харилцдагийг хүн болгон мэддэг аж. За энэ ч бас яахав гэхсэн, харамч бирд л байгаа биз, өөрийн бодол өөртөө зөв гэдэг шүү дээ. Харин тэрээр өөрийн эзэмшил дэвсгэр дээрээ дэг журам тогтоож чаддаггүй дэндүү олон хүн хядаж, эрх мэдлээ булаацалдан хэлмэгдэж, бие

даасан тонуулчид, «чөлөөт уран бүтээлчид» хэтэрхий олширч, нэг үгээр хэлэхэд Бостонд хуулийг даанч илэн далангүй бүдүүлгээр зөрчдөг нь уучлах аргагүй. Хэрэв Чикагод харгис хэрцгий хүмүүс түйвээдэг бол Бостонд адгийн шаар хог новшнууд гаарч гүйцжээ. Бостоны их эцэг загзгар ясархаг биетэй Доменик Панц бол нэгэн их эцгийн мэргэн онож хэлснээр харваас шилийн хулгайч шиг царайтай эр ажээ.

Америкийн мөрийтэй тоглоомын онц эрхт нэгдлүүдийн дотроос хамгийн хүчирхэг нь гэгдэх Кливлендийн синдикатыг төлөөлж ядрангуй боловч цэвэрхэн шаравтар царайтай, цал буурал толгойтой өвгөжөөр насны их эцэг ирлээ. Энэ синдикат түүний удирдлагын дор тохируулга сайнтай машин шиг ажиллаж, их эцэг Винсент Форленца цагаан гартай, цамаан зан төрхтэй хэдий ч цус үзээд ухаан алдлаа гэж дуулдаагүй бөлгөө. Тэрээр ийм эелдэг ялдам, боловсон хүнд баймааргүй хатуу ширүүн төмөр гараар атган захирдаг нь яг л аман дээрээ бал, алс цаанаа жад гэгчийн үлгэр л болов уу.

Эцэс сүүлд нь шил шилээ даган орж ирсэн Нью Йоркийн Таван намын толгойлогч нар нүүдлийн шувуу шиг тохиолоор хурсан хөдөөгийн бусад их эцгүүдийг бодвол хамаагүй буурь суурьтай, сүрлэг жавхаатай харагдаж байгааг Хейген гярхай ажжээ. Тарган цатгалан, байргашуу биетэй, толгой томтой тэд нар бүгдээрээ махлаг хянган хамар, дарвагар зузаан уруул, үрчлээ дүүрэн унжгар хацраараа бусдаас ялгарахаас гадна ганган дэгжин костюм өмсөө ч үгүй, үс гэзгээ тосолж толийгоо ч үгүйг нь үзвэл ажил ихтэй, төлөв томоотой хүмүүст гадаад төрх байдал мэтийн аар саар юмаар хөөцөлдөж явах чөлөө зав байхгүй гэдгийг л ойлгуулах гэсэн мэт.

Тэднээс гадна Нью-Жерси муж улс болон Манхаттан дахь Вест-сайдын усан онгоцны зогсоолуудыг эзэгнэдэг Энтони Страччи ч энд байлаа. Тэрээр Нью-Жерсийн мөрийтэй тоглоомын газруудыг гартаа атгахын зэрэгцээ ардчилсан намын тамгын газарт их нөлөөтэй ажээ. Страччи бас ачааны машины парктай бөгөөд жолооч нар нь замд гарахдаа даацаа хавьгүй хэтрүүлж, замын цагдаагийн газрынхан тэднийг ер зогсоож торгодоггүй тул үлэмж орлого олдог байв. Нүсэр хүнд ачаатай аварга том машины дугуйнд засмал, цардмал зам амархан эвдэрч, нөгөө л Страччигийн мэдлийн зам засварын компани муж улсын захиргаатай тун ашигтай гэрээ хийж засна. Ингээд л ашиг орлого ихтэй нэг ажил нөгөөгөө урин залж их эцэг уран чамин атлаа маш энгийн аргаар хөлжиж баяждаг санж. Тэгэхдээ хуучин цагийн дүрэм журмыг ягштал сахидаг Страччи усан онгоцны зогсоолын эзэн хааны хувьд мансууруулагч хууль бусаар хил нэвтрүүлэх хэрэгт хүссэн ч, хүсээгүй ч холбогдож л таарах боловч харин амьд барааны арилжааг хэзээ ч эрхэлж яваагүй нь цорын ганц гэгээтэй тал нь гэлтэй ч юм уу даа.

Нью-Йорк муж улсын умард хязгаарыг Оттилио Кунео ноёрхон захирч түүний нам италийн цагаачдыг Канадын хил нууцаар давуулан хөлжиж, харьяа нутгийнхаа мөрийтэй тоглоомын бүх газруудыг эрхэндээ оруулснаас гадна Кунеогийн ивээл дэмжлэггүй л бол морин тойруулга нээж ажиллуулах зөвшөөрөл муж улсын засаг захиргаанаас олж авна гэдэг санасны гарз. Албан ёсоор бол сүү, сүүн бүтээгдэхүүний томоохон компанийн эзэн гэгдэгч Кунео тосгоны талхчных шиг малигар царайдаа цайлган сэтгэл гэрэлтүүлээд хэн ч харсан нүдэнд дулаахан эр. Тэгээд ч тэр юм уу ер нь хүүхдэд хайртайдаа ч юм уу мань эр шоргоолж шиг олон ач зээ нараа болон гарын доорх хүмүүсийнхээ үр хүүхдүүдийг эрхлүүлэх ая таарах вий

хэмээн горилж дандаа халаас дүүрэн чихэртэй явдаг байлаа. Тэрээр толгойноосоо огт салгадаггүй зөөлөн бүрхнийхээ хүрээг бүсгүй хүн лугаа адил доош нь дарж өмсөөд түүний дороос нарны туяа цацруулах мэт нүүр дүүрэн инээмсэглэж явах нь цаанаа л нэг донжтой. Дийлэнх их эцгүүдийг бодвол Кунеог ганц ч удаа шоронд хориогүйгээр үл барам түүний үйл ажиллагааны жинхэнэ мөн чанарын талаар хэзээг ч эргэлзээ сэжиг төрж байгаагүй билээ. Тэр ч байтугай түүний үнэнч шударгын төлөө хэнбугай нь ч тээнэгэлзэж маргалддаггүй тул Кунео олон нийтийн янз бүрийн хороодод бөгс өндийлгүй шахуу хуралдаж, нэг удаа худалдааны тэнхимээс жил бүр олгодог «Нью-Йорк муж улсын тэргүүний бизнесмен» цол хүртэж байжээ.

Таттальягийн намын ойрын холбоотнуудын нэг болох их эцэг Эмилис Барзини ч энд байлаа. Бруклин, Куинс зэрэг эл хотын мөрийтэй тоглоомын газар, цөөнгүй тооны эмсийн хүрээлэн, шүдээ хүртэл зэвсэглэсэн хөлсний этгээдүүдийг захиалгаар хангах, Статен-Айлендыг ноёрхох хэмжээгүй засаглал, Бронкс, Вэст честерын морин тойруулга, мансууруулагчийн арилжаа гээд л өчнөөн төчнөөн юм энэхүү овог нэртэй холбоотой. Бас Лас-Вегас, Рино зэрэг Невадагийн нээлттэй хотуудын цэнгээний газруудын орлогоос хувь хүртэн Майами-Бич, Кубын цэнгээний бизнест оролцоно. «Барзинигийн нам» гэдэг ойлголтын цаана ийм л юм нуугдаж байгаа юм даа. Корлеонегийн намын дараагаар түүнийг Нью-Йоркийн, тэгэхлээр, нийт Америкийн хамгийн хүчирхэг отогт тооцож болох биз ээ. Барзини бүр Сицили хүртэл гар сунгаж, овоохон орлоготой хууль бус үйл ажиллагааны нэг ч хэлбэр түүний оролцоогүйгээр бүтдэггүйгээс гадна Уолл стритэд ч хүртэл нэвтэрч чадсан гэдэг дам яриа бий. Далд дайны анхны өдрөөс эхлэн Барзини өөрийн бүх хөрөнгө, хүч нөлөөгөө Таттальягийн намыг тэтгэн дэмжихэд зориулсны учир гэвэл түүний нандин хүсэл нь эрхэм Корлеонег мохоон огцруулж өөрөө Америкийн хамгийн хүчирхэг, нэр хүндтэй мафиин толгойлогчийн байранд залрахын ялдамд Корлеонегийн эзэнт улсын ахиухан хэсгийг гартаа хийх явдал байжээ. Үгийн далимд дурдахад, тэрээр олон талаар эрхэм Корлеонетой төстэй, харин орчин үеийн шаардлагад зохицон нийцэх, аливаа асуудлыг өргөн харж зоригтой шийдвэрлэх чадвар ажил хэргийн сүүхээ овсгоогоороо түүнээс ч илүү эр санж. Эрхэм Корлеоне шиг элэгсэг дотно байдал огт үгүй, харин ч хүйтэн сэтгэл, хүчтэй зуунги зан Барзинигийн нүүрэн дээр бичээстэй юм шиг тодорч, нэг үгээр хэлэхэд өнөөгийн өдөр сүрэг толгойлох самбаатай, од нь гэрэлтэж, онгод нь орж яваа зоригтой эр гэж хэн ч харсан хэлэх буй заа. Яг тухайн үед тэрээр Таван намын дотор хамгийн «хүндтэй хүн нь байсан болов уу.

Бүгдийн сүүлд ирсэн хүн нь Солоццог дэмжих замаар Корлеонегийн засаглалыг түлхэн унагаах гэж улайм цайм тэмцэгч намын тэргүүн Филипп Татталья ирлээ. Сайхь эр эдүгээ эл зорилгодоо хүрэхэд хуруу дутуу болчихоод байхад Тавтын бусад гишүүд түүнд бага зэрэг үл тоомсорлосон хандах нь гайхалтай хэдий ч гашуун үнэн билээ. Яагаад гэвэл, нэгдүгээрт, тэрээр тун гоомой хөдөлж, Солоццо гэдэг энэ зальжин түрэгт дөрлүүлж тухайлбал Нью-Йоркийн том намуудын өдөр тутмын ажил хэрэгт хөнөөл хохирол ингэж их учруулан төвөг удсан энэ хөл үймээнийг дэгдээж бантан хутгажээ. Хоёрдугаарт ханан гэр нь холдож, хадан гэр нь ойртоод жар хол гарчихсан атлаа авгай хүүхний хойноос хөөцөлдөж, загвар өмсөгч шиг залуурхан гангалдаг бөгөөд дур хүслээ дүүрэн хангах бүх бололцоо түүнд бий аж.

Учир нь гэвэл, Таттальягийн намын гол үйл ажиллагаа нь эмэгтэйчүүдийг худалдах явдал агаад янхан эмсээс гол орлогоо олдог байлаа. Түүнээс гадна тэрээр Америкийн бараг бүх

шөнийн цэнгээний газрыг захирч, өсөх ирээдүйтэй авьяаслаг залуусыг аль ч хотод суудаг байсан хамаагүй, дор нь эрхшээлдээ оруулж, ямар нэг олигтойхон дуучин юм уу хошин жүжигчинг боолчлон шүүсийг нь сорохын тулд хүч хэрэглэхээс ч буцдаггүй байв.

Хувь хүний зан чанараараа Филипп Татталья өөрийн хамсаа холбоотнууддаа хүртэл таалагддаггүй, үрийн үргэлж л ямар нэг их хохирол амсаж байгаа тухайгаа гонгинон гонгинож явдаг ажээ. Адсага шиг адаар ааштай, хошин хойрго хүүхнүүд эмсийн зарим нь оргож босоод нөгөө хэд нь амиа хорлодог л гэнэ. Зуучлагч нар нь хэнийг ч сохор зоосоор худалдахад бэлэн зальхай луйварчид, олигтой дориун овсгоотой ажилтанг өдрийн цагаар дэнлүү барьж эрээд ч олохгүй л гэнэ. Сицили гаралтай өөрийн гэсэн залуус нь хүний хоолой хэрчиж, гэдэс хүүлэхдээ хээв нэг инээж зогсдог атлаа эмс хүүхнийг турхирч худалдахыг гутамшигт үзэн ярвайлдаж хамар буруулдаг өөдгүй новшнууд л гэнэ. Филипп Татталья жаахан доромжилсон. баахан дооглосон сонсогчдынхоо дунд иймэрхүү л юм донгосч суудаг зуршилтай нэгэн. Хуруу хөдөлгөх төдийгөөр шөнийн клуб, цэнгээний газруудад нь согтууруулах ундаа зарахыг зөвшөөрөх юм уу. хориглох эрх мэдэл бүхий түшмэдүүдийг л юу юунаас илүү хараан зүхэхдээ мань эр албаны тамга атгасан авилгач тэр моньднуудад хээл хахууль цутгасаар байгаад ганцаараа Уолл-стритээс ч олон саятнуудыг төрүүлсэн гэж аминчлахаас наахнуур батлан үгүүлнэ.

Корлеонегийн отгийг хариугүй ялдгийн даваан дээр очсон хойноо ч гэсэн зүй ёсны хүндэтгэл хүлээж чадаагүйн учир гэвэл тэгэхэд түүний гол хүч юуны түрүүнд Солоццо, дараа нь Барзинигийн нам байсныг хүн болгон андахгүй мэддэгт орших буй заа. Бас тэгээд Татталья гэнэтийн дайралтын давуу талаа ашиглан бүрэн гүйцэд ялж чадаагүй нь түүний нэрийг хөөдөж дуусчээ. Чухамдаа тэрээр арай л овсгоотой шалмаг л хөдөлсөн бол эрхэм Корлеонегийн үхэл дайныг дуусгавар болгож, одоо бүгдээрээ ингэж муугаа үзэж суухгүйсэн дээ...

Энэ хаяа хадарсан дайнд хайртай хүүгээ алдсан дайснууд болохоор эрхэм Корлеоне, Филипп Татталья хоёр зөвхөн албархуу толгой дохилцов. Том Таван намын толгойлогчид эрхэм Корлеонег онцгой анхааран шархдаж гэмтсэн, хүүгээ алдсаны ул мөр, суларч доройтсоны шинж тэмдэг эрэлхийлэн өлөн нүдээр гярхай ажиглахын зэрэгцээ хайртай хүүг нь зэрлэг балмадаар хөнөөчхөөд байхад Загалмайлсан эцэг эв эеийг эрэлхийлж явахаар бүгд л сэжиглэн сэрдхийж суулаа. Хэрэв ингэснээр бууж өгсөн бичиг мутарлаж байгаа бол Корлеонегийн хүчирхэг ноёлол одооноос эхлэн буурах ёстой. За даа, энэ бүхэн тун удахгүй тодорхой илэрхий болно биз.

Бие биетэйгээ мэнд мэдэлцэн хөөрцөглөх нь намжиж, тойруулан хүртээсэн шилэн аягаа хоосолцгоож, эрхэм Корлеоне толийтол өнгөлсөн том ширээний ард байраа эзлэх хүртэл хагас цаг хавьгүй өнгөрчээ. Ар шилд нь, жаахан сүүлдэхийн Том Хейген суусан нь бусдад нэгэн ёсны дохио болж, их эцгүүд ширээ тойрон сууцгаахад дагалдан ирсэн гарын зөвлөх нар нь хэрэгтэй үед чухал үгээ эзэн ноёндоо саадгүй шивнэхийн тулд бараг л нурууг нь налах шахан тухалцгаав.

Эрхэм Корлеоне уулзалтыг нээн үг хэлэхдээ ер нь юу ч болсон шинжгүй, хээв нэг байдалтай харагдана. Тэрээр өөрөө хүнд шархдан хайртай хүүгээсээ хагацаагүй юм шиг цус асгаруулсан аллага хядлага эзэнт улсыг нь түйвээн бусниулаагүй мэт амьд үлдсэн хүүхдүүд нь дэвэн

дэлхийгээр таран Фредди Өрнө зүг Моларинигийн ивээл дор очиж, Майкл нь сицилийн аглаг бөглүү газар толгой хоргодохоор одоогүй юм шиг сицили хэллэгээр тайван тогтуун ярьж гарлаа.

- Юуны өмнө би та бүхнийг тав тух зав чөлөөгөө үл хайхран хүрэлцэн ирсэнд талархал илэрхийлэхийн ялдамд үүнийг намайг онцлон хүндэтгэл үзүүлсэн хэрэг хэмээн өндрөөр үнэлж, хуран цугларсан хүн болгонд өртэй үлдсэнээ ойлгож байгаагаа сонордуулахыг зөвшөөрнө үү. Урьдчилан үгүүлэхэд миний бие хэрүүл шуугиан дэгдээх юм уу, өөрийгөө зөвтгөн санаа оноогоо нотлох гэсэндээ бус, харин хэргийн байдлыг хэлэлцэж учрыг олон хужрыг тунгаасны эцэст эндээс бид бүгд анд найзын сэтгэл өвөрлөн тарцгаахын тулд эрүүл ухаанд нийцүүлэн бололцоотой бүхнийг хийх цорын ганц зорилготой ирсэн билээ. Үүний баталгаа нь миний үнэн үг. Та нарын дотроос намайг мэддэг нь дэмий хоосон худал ярьдаггүйг минь нотлоод өгөх биз ээ. Бид гарын үсэг зурсан баталгаа бие биедээ бэлдэж өгөхөөр цугласан хуульчид биш. нэр төрөө эрхэмлэдэг ажил хэрэгч хүмүүс болохоор энэ тухай удаан нуршаад яахав, шууд хэлэлцэх асуудалдаа оръё.

Түүнийг дуугаа хураахад бусад нь үг сонсож ч чаддаг, тэвчин хүлээж ч чаддаг тул хэн ч нам гүм байдлыг эвдсэнгүй. Хэн нэг нь навчин янжуур баагиулж, нөгөө зарим нь виски шимж суугаа эдгээрийг нэгтгэн адилтгах өөр нэг юм гэвэл, тэд бүгдээрээ толгой дээрээ ноён суулгахыг яс махнаасаа үзэн яддаг, зохион байгуулалттай нийгмийн засаглалыг юман чинээ тоодоггүй, ижил төрлийнхөө дотор ч гэсэн гайхал төрүүлмээр адгуу зөрүүд ааштай аж. Дур хүслээс нь гадуур харьяалан захирах ямар ч хүч хорвоо дэлхий дээр байхгүйгээс гадна тэд арга заль, аллага хядлагаараа өөртөө санал бодлын эрх чөлөөгөө байлдан олдог бөгөөд үүнийг нь гагцхүү үхэл мөхөл, эсвэл туйлын эрүүл ухаан л эцэслэн өөрчилж чадах бөлгөө.

Эрхэм Корлеоне хэнд ч тухайлан хандаагүй, хоосон асуулт тавьж:

- Энэ хэрэг ингэж их газар авсан нь юунаас болов оо? Ер нь тэгээд харамсалтай огтын хэрэгцээгүй олон тэнэг юм хийж дээ, бид. Та нар зөвшөөрвөл, зарим баримт сэлтийг өөрийн ойлгож байгаагаар тайлбарлахыг оролдъё гээд хэн нэгэн болсон үйл явдлыг өрөөсөн талаас нь тайлбарлахыг эсэргүүцэж юу магад хэмээн хэсэг чимээгүй хүлээзнэв. - Миний бие Бурхны ивээлээр илааршиж, энэ хүнд байдлаас гарах ухаалаг арга олж ч юу магад гэж бодном. Миний хүү хэтэрхий шулуухан дайрч болчимгүй юм хийсэн ч байж болох л доо. Ямар ч л байсан, Солоццо миний хөрөнгө, холбоо сүлбээнд найдан надад ажил хэрэгч санал гаргасан юм. Мансууруулагчийн тухай энэ саналыг Тагтальягийн нам дэмжсэн гэж надад хэлсэн боловч би номхон даруу хүн, мансууруулагчийг сонирхдоггүй, иймэрхүү ажил насны минь эцэст хал болно гэдгээ Солоццод тайлбарлав. Миний бие түүнийг ч гэсэн, Тагтальягийн намыг ч гэсэн адил хүндэтгэн, ийнхүү татгалзсан хариу өгөхдөө чадлынхаа хирээр эелдэг зан гаргасансан. Бас түүний хэрэг явдал минийхэд ер саад болохгүй, ийм аргаар мөнгө олоход нь татгалзах юм надад алга гэдгээ ч нэмж хэлсэн. Гэтэл миний цааргалсан хариуг буруугаар урвуулан ойлгоод бидэнд гай гамшиг тарилаа.. Алаг эрээн хорвоогийн алдаж онодог амьдрал ийм л хойно яая гэхэв. Бидний хэн нь ч гэсэн зовлон жаргалаа тоочвол зөндөө л юм бий дэг. Гэвч би ингэхийг үл хүснэ.

Эрхэм Корлеоне рашаан хий хэмээн Хейгенд дохиод дөнгөж аягаа дүүрмэгц бушуухан авч хоолойгоо норгосноо:

- Татталья хүүгээсээ хагацсан, би ч гэсэн хүүгээ алдсан, хэн хэндээ өглөг авлагагүй тул би энэ маргаантай асуудлыг эв эээр эцэслэн шийдвэрлэхийг хүсч байна. Эрүүл саруул ухаанаар тунгаан шүүхийн оронд бүгдээрээ л өшөө хонзон өвөрлөж өр гэдсээ хүүлэлцээд байх юм бол хорвоо ертөнц дээр юу гээч нь болох билээ?! Бүх эрчүүд нь цусан өшөө авах гэж улайран хөөцөлдсөөр байгаад идэх талхныхаа мөнгө олох завгүй явдаг нь төрөлх Сицилийг минь нөмөрсөн түмэн нүгэл буман гай биш гэж үү? Ухаангүйн цаадах мунхаг гэдэг чухам энэ биш юм уу? Тийм ч болохоороо бүх юм хуучин байснаараа л байг гэж би та нарт хэлэх байна. Хүүг минь хэн алж, хэн урван тэрсэлснийг тогтоох алхам би хийгээгүй, хэрвээ энэ хэргийг цэвэр шийдвэл хийх ч үгүй. Өөр нэг хүү минь одоохондоо гэртээ буцаж ирэх аргагүй болчихоод байгаа. Түүнийг эргэж ирэхэд ямар ч саад бэрхшээл, гай тотгор учрахгүй гэсэн баталгаа надад хэрэгтэй. Энэ асуудлыг энд эвээр шийдчихвэл бидний, сонирхсон бусад ажлаа хэлэлцэж, эл уулзалтаа хэн хэндээ ашигтайгаар дуусгаж болох байна. Миний хүсэн хүлээж буй юм гэвэл ийм л байна даа гээд бүгдэд ойлгомжтой, хүлцэнгүй байдлаар ширээн дээр алга хавсран тавив.

Зүрхэнд шингэсэн энэ үнэн үгэнд аль эртний танил болсон эрхэм Корлеонегийн дороо суурьтай, дотроо бодолтой, хүлцэнгүй номхон хуучин төрх илт харагдах хэдий ч би эв эрүүл боллоо гэж цохон тэмдэглэсэн нь хуран цугласан хүн болгоны чих дэлсжээ. Тэгэхлээр Корлеонегийн намыг айхавтар гай зовлон шил даран дайрсан хэдий ч Загалмайлсан эцэг хэнд ч дарлуулж доромжлуулахгүй, хэний ч тоглоом тохуу болохгүй гэсэн үг. Бас түүний хүсч байгаа эв найрамдлыг нь одоо байгуулж өгөхгүй аваас өөр асуудал хэлэлцээд ямар ч нэмэргүй гэсэн далд утгатай үг цухалзуулсныг нь бүгд анзааралгүй өнгөрч чадсангүй. Түүгээр ч үл барам, тэрбээр сүүлийн жилд бусдаас илүү гарз хохирол амссан хэдий ч урьдын байдлыг хэвээр нь сэргээх санал гаргаж, өөрөөр хэлбэл ямар ч асуудал дээр буулт хийх бодолгүй байгаа нь анхаарлын гадуур өнгөрсөнгүй.

Эрхэм Корлеонед Татталья хариулсангүй, харин Эмилио Барзини үг хэлэх зөвшөөрөл авч хөндий хүйтэн, ил тодорхой, гэхдээ бүдүүлэг ширүүн, доромжилж басамжилсан гэж хэн ч хэлэхээргүйгээр ярьж эхэллээ.

- Саяын ярьсан цөм үнэн, гэхдээ эрхэм Корлеоне даруу зан гаргаад бүх юмаа шавхаж ярьсангүй. Учир нь гэвээс, эрхэм Корлеонегийн тусламж дэмжлэггүйгээр Солоццо болон Таттальягийн нам эл шинэ ажлаа эхэлж чадахгүй байсан. Тэгэхлээр тэрээр ийнхүү санаандгүй татгалзсанаараа тэдэнд хохирол учруулсан л гэсэн үг. Баримт бол баримт. Мансууруулагчийн холбогдолтой ажлаар ч гэсэн эрхэм Корлеонегээс гарын бэлэг авч болзошгүй шүүгч улс төрч нар ийм асуудлаар өөр хэнийг ч ойртуулж хавьтуулахгүй Солоццо өөрийн хүмүүст нь өршөөл үзүүлж нигүүлсэнгүй хандана гэх зарим нэгэн баталгаа олж авах хүртлээ хөл гар нь хүлээстэй юу ч хийж чадахгүй байсан нь хүн болгонд ойлгомжтой. Ийм ивээл үгүй бол бидний хэн маань ч мод барьсан гуйлгачин болно шүү дээ. Ял шийтгэл хатуурч чангарсан өдгөө цагт манай хүмүүс мансууруулагчтай баригдахаар шүүгчээсээ эхлээд прокурор хүртлээ тэнгэр хадсан шан хөлс нэхэх юм. Сицилийн шазруун эрс хүртэл хорин жилийн ял сонсоод сэтгэлээр унахдаа нууц хадгалах омерта тангаргаа зөрчөөд ам алдчихаж магадгүй. Ийм явдал хэрхэвч гаргаж үл болно. Хэрэг мөрдөх шүүн таслах ажиллагааг бүхэлд нь гартаа атгасан эрхэм Корлеоне бидэнд ч гэсэн энэ машиныг өөртөө ашигтайгаар хэрэглэх бололцоо өгөхгүй гэдэг нь нөхөрсөг үйл мөн гэж үү? Эдүгээ хүн болгон дур зоргоороо

дургиж, дунд чөмгөөрөө жиргэж явдаг цаг биш болохоор эрхэм Корлеоне эхнэр, хүүхдийн маань үмх талхыг булаан өлбөрүүлж үхүүлэх гээгүй л бол Нью-Йорк хотын бүх шүүгчдийг халаасандаа хийчихсэн хүний хувьд маньд туслах, эсвэл тэр түшмэдүүдэд хүрэх шууд замыг нээн ногоон гэрэл асааж өгөх ёстой. Эцсийн эцэст бид ямар коммунистууд биш, тэрээр ийм тус хүргэснийхээ хариуд шан харамж нэхэх эрхтэй нь мэдээж хэрэг. Ямар ч л гэсэн эрхэм Корлеоне алтан худгийн амтат уснаас ганцаараа утгаж уух учиргүй. Тийм эрх ч байхгүй.

Барзини үгээ өндөрлөж танхимд нам гүм болов. Ингээд асуудал тодорхой болж, хуучин байдалдаа эргэж орох хөг өнгөрлөө гэсэн бодол хүн бүрийн толгойд харвалаа. Хамгийн гол нь эв найрамдал энэ уулзалт дээр байгуулж чадахгүй бол Барзини Таттальягийн талд орж эрхэм Корлеонегийн эсрэг илээр тэмцэнэ гэдгээ ойлгуулжээ. Тэгээд ч зогссонгүй, нэгэн чухал зүйл дээр давамгайлан дийлж чадлаа. Тэдний амь нас, сайн сайхан байдал нь үнэхээр харилцан дэмжих тусламж дээр суурилан тогтох бөгөөд өөрийн талын хэн нэгний гуйлт биелүүлэхээс татгалзана гэдэг нь мөн чанартаа өширхөн дайсагнасан хэрэг байлаа. Тэд угаасаа хэрэггүй юм гуйдаггүй, хүсэлт биелүүлэхээсээ хий дэмий татгалздаггүй улс бөлгөө.

Нилээд байтал эрхэм Корлеоне дахин ам нээв.

- Нөхөд минь, хар буруу хорон санаа өвөрлөсөндөө би татгалзсан юм биш ээ. Хэнд ч, юунд ч татгалзаж байгаагүйг минь та нар эрхбиш мэдмээр дээ. Харин энэ удаад яах ч аргагүй байсан юм. Яагаад гэвэл, энэ гүрэнд мансууруулагчийг хэтэрхий үзэн ядаж нүд үзүүрлэх болсон тул түүнтэй нэр холбогдвол биднийг хэзээ ч уучлахгүй, ойрын ирээдүйд л мөхөх аюул нүүрлээд байна гэж бодсон сон. Виски, мөрийтэй тоглоом, эмс хүүхнүүд гээд л олон хүний бие сэтгэл гижигдсэн зүйл, тэр ч атугай сүм хийд, төр улсаас хорио тавьсан бусад юм бол өөр хэрэг. Харин мансууруулагч чинь нэр холбогдсон хүн болгонд хал балтайгаас гадна бусад бүх үйл ажиллагааг нураан сүйтгэх аюул агуулсан хөнөөлтэй эд. Цаашилбал шүүхийн түшмэл болон хууль зүйн бусад ажилтны дотор бүхнээс хүчирхэг нь намайг гэсэн үг сонсоход чихэнд чимэгтэй л байна. Үнэхээр тийм ч болоосой! Тийм ээ, би тодорхой хэмжээний нөлөөтэй. Гэвч одоогоор миний үгэнд ордог хүмүүс мансууруулагчийн тухай яриад унахаар чихэн дүлий нүдэн балай болж мэдэх юм. Тэд энэ хорыг өөрсдөө ч үзэн ядах учир түүнийг тараан худалдах ажилд хутгалдана гэхээс толгойтой үс нь өрвийж морин тойруулга, мөрийтэй тоглоомын газар шөнийн клуб ажиллуулахад бидэнтэй хөл нийлдэг цагдаа нар ч хүртэл мансууруулагч хил давуулахад дэмжлэг үзүүлнэ гэдэг юу л бол. Учир иймд, хэн нэгэнд иймэрхүү ажилд тус болооч хэмээн надаас гуйнаа гэдэг өөрөө өөртөө ус болох зүйл гуйсантай утга нэг. Гэсэн хэдий ч та нар бүгдээрээ ийм арга хэмжээг чухалчилж байгаа бол гол асуудлаа эвээр тохирохын тулд би түүнийг чинь хийвэл ч хийчихнэ шүү.

Түүнийг дуугүй болсны хойт дээр түгшүүртэй байдал арай намжиж, хүмүүс шивэр авир гэлдэн, зарим нь ширээний хоёр талаас намуухнаар үг хэлэлцэж эхлэв. Эрхэм Корлеоне хамгийн гол асуудал дээр буулт хийж, мансууруулагч зохион байгуулалттай борлуулах ажлыг өмгөөлөлдөө авах, өөрөөр хэлбэл улс орны өнцөг булан бүрээс энэ зөвлөгөөнд хуран цугларагсад шаардаж шахсан тохиолдолд бүр анхнаасаа Солоцогийн санал болгоод байсан тэр зүйлийг хийхээр зөвшөөрчээ. Харин тэрээр мансууруулагчийг яг гардан наймаалахад оролцохгүй, хөрөнгө мөнгө оруулахгүй, зөвхөн хууль, шүүхийн байгууллага дахь танил талаа ашиглан эл ажиллагааг халхлан хаацайлахаар тохирчээ. Гэлээ ч гэсэн энэ нь асар том буулт

байлаа.

Бусдаас түрүүнд Лос-Анжелесын их эцэг Фрэнк Фальконе хариу өчсөн нь:

- Манай хүмүүсийг мансууруулагчийн наймаанаас хөндийрүүлэн хориглох ямар ч арга байхгүй. Тэсч тэвчихийн аргагүй тийм их орлоготой ажил болохоор хориг цээр тавивал тэд зүгээр л бор зүрхээрээ бие даан арилжаалж, биднийг бүр ч хөөднө. Тэгсэн дор бол энэ ажлыг гартаа авч, илүү зохион байгуулаад сайтар өмгөөлөн хамгаалахын зэрэгцээ урьдчилан сэргийлэх арга хэмжээ өргөн хүрээтэй авч чадваас бидэнд хавьгүй ашигтай. Эцсийн эцэст хүн болгон дур зоргоороо авирлаж эмх замбараагүйтвэл хор хөнөөл ихтэйгээс гадна аливаа ажилд хагуу дэг журам, найдвар төгс байдал, сайн зохион байгуулалт юу юунаас чухал ач холбогдолтой юм чинь бидний үүрэг роль тийм ч сонжилтой, гэм зэмтэй биш гэж бодогдоно.

Энд цугларсан хүмүүсийн дотроос л Корлеонегийн талд илүү үнэнчээр зүтгэдэг Детройтын их эцэг ч гэсэн анд найзынхаа санал бодлыг эсэргүүцэн, хэргийн байдлыг эрүүл саруул ухаанаар эргэцүүлэн тунгаахыг уриалав.

- Би ч гэсэн мансууруулагчийн эсрэг зогсдог болохоор өөрийнхөө хүмүүсийг мансууруулагчаас л холхон байлгахын тулд жилээс жилд нэмүү цалин төлдөг атал ямар ч нэмэр болсонгүй. Та нар бодоод үз л дээ. Захын нэг хүн хүрч ирээд л: «Нунтаг нь надад байна. Гурав дөрвөн мянгыг хаявал чинь түүнийг борлуулаад тавин мянгыг унагана» гэхээр чинь ийм их сул мөнгөнөөс ямар тэнэг нь татгалзах юм бэ? Ганц нэг удаа мансууруулагч наймаалж, эцэстээ олзонд шунаж амтанд нь их орчихлоор надаас цалин авдаг үндсэн ажил минь хохирч л таараа. Өдрөөс өдөрт эрэлт хэрэгцээ нь өсөн нэмэгдсээр байгаа энэ арилжааг нэгэнт л хорьж чадахгүйгээс хойш гагцхүү эмхлэн цэгцэлж дорвитой суурьтай бизнес болгох нь бидний зорилт мөнөөс мөн. Хүүхэд залууст тэр хорыг наймаалах нь гутамшигтай явдал тул сургуулийн тийш зүглүүлэх ч үгүй байвал зохино. Өөрийнхөө хотод бол би эл барааг гол төлөв өнгөт хар арьстанд борлуулахыг хичээдэг. Тэд хэрэг төвөг учруулдаггүй хамгийн амар худалдан авагчаас гадна тэртэй тэргүй мал юм чинь эхнэр хүүхэд гэр бүлээ бодно ч гэж байхгүй, өөрсдийгөө ч хүндэлнэ гэж үгүй цагаандаа гарсан улс, хордож үхвэл үхнэ л биз... Харин энэ ажлаас хөндийрч, урсгалаар нь тавьж яасан ч болохгүй бидэнд л хор хохиролтой.

Детройтын их эцэг яг голыг нь онож хэлсэн тул үгээ дуусгахад нь бүгд дэмжин сайшааж бөөн шуугиан дэгдлээ.

Хүн болгон санал бодлоо хэлж, мансууруулагч борлуулна гэдэг тун бузар муухай энэ ажил эцсийн дүнд яав ч сайн юманд хүргэхгүй боловч түүнийг хориглон зогсоох арга байхгүйг бүгд хүлээн зөвшөөрчээ. Эл наймаа зүүдэнд ч оромгүй их орлоготой амархан баяжих тул түүнд хорхойтон улангассан хүмүүс мөнгөнд улайраад хэний ч үгэнд орохгүй, юуг ч тоохгүй болно. Хүн гэгч амьтны мөн чанар ийм л хойно доо.

Эцсийн эцэст тэд хэл амаа ололцож, мансууруулагчийн арилжаанд оролцохыг буруутган зэмлэхгүй байхаар тохиролцов. Улсын дорнод хязгаарт энэ ажлыг эрхэм Корлеоне хуулийн хараа хяналтаас хаацайлан хамгаалж, голчлон Барзини, Таттальягийн намууд мансууруулагчийн наймааг өргөн цар хүрээтэй эрхлэн явуулахаар боллоо. Энэ хэцүү даваа хэрүүлийн цөмийг эвээр зохицуулсны хойт дээр тус зөвлөгөөн арай нийтлэг, гэхдээ бас л

нарийн төвөгтэй асуудалд шилжив Лас-Вегас, Майами хоёрыг их ирээдүйтэй гэдэг дээр санал нэгдэн нам овгуудын аль нь ч үйл ажиллагаагаа явуулахад чөлөөтэй дэвсгэр нутагт тооцоцгоолоо. Хэн нэгнийг замаас зайлуулах шаардлага гарч, тэгэхдээ хэтэрхий шуугиан дэгдэж болзошгүй онцгой тохиолдолд чухамхүү энэ зөвлөгөөнийг сайшаан дэмжсэнээр уг ажиллагааг явуулж байхаар тохиролцов. Түүнчлэн нам овгийнхон. тухайлбал тангарагтан шүүгчдийг хахуульдах зэрэг амин чухал асуудал дээр бололцоотой нэг нь нөгөөдөө туслах, ялын тогтоол гүйцэтгэгчдээ илгээлцэх зэргээр харилцан бие биедээ үйлчилж, дэм үзүүлж байхыг бүгд зөвшөөрчээ.

Зөвлөгөөн хэт сунжирч магадгүй болоод ирэхийн цагт Барзини эцсийн дүн гаргаж үг хэлэх нь зүйтэй гэж үзлээ.

- За ингээд, бүх асуудлаа хэлэлцэж дуусав шив дээ. Эрхэм Корлеонегийн хучин зүтгэлээр эв эеэ ололцсонд баяр хүргэе. Миний хувьд гэвэл үүнд их баярлаж байна. Иймд энэ асуудлаа цэглэж бүхнийг шинээр эхэлье.

Гэвч өрсөлдөөн тэмцэл эхэлбэл Сонни Корлеонег хороосон гэм буруутай Филипп Тагтальягийн л амь насанд бусдаас илүү аюул заналхийлэх учраас мань эр ганцаараа сэтгэл түгшсэн хэвээр үлдсэн янзтай өгүүлрүүн:

Би хэдийгээр хүүгээ алуулсан ч хагацал зовлонгоо умартаж, энд гаргасан санал болгоныг хүлээн зөвшөөрөхөд бэлэн байна. Гэхдээ Корлеонегээс арай хатуухан шиг бат найдвартай ам өчгийг нь авмаар санагдах юм. Тэрээр хувийн өшөө хонзон авахаар оролдохгүй, эсвэл байр сууриа бэхжүүлж, хүч чадлаа бэхжүүлж авсны хойт дээр бидний эвтэй найрсаг энэ хэлцлийг умартан тэрслэхгүй гэх баталгаа хаана байна? Үнэхээр бид эндээс амарлингуй сэтгэл өвөрлөн эвтэй найртай таран явж болно гэж үү? Эрхэм Корлеоне яг миний одоогийнх шиг хатуу чангаар батлан хэлж чадах юм бол уу?

Түүнийг дөнгөж амаа хамхимагц эрхэм Корлеоне хожим удтал хүн болгоны сэтгэлд хоногшин үлдсэн үгээ анх удаа босоогоор хэлж, түүндээ Черчиллийн бодож олсон «төмөр хөшиг гэгчээс ч дутахааргүй суутай, гэхдээ арваад жилийн дараа л олонд түгсэн нэрт хэллэгээ хэрэглэсэн байна.

- Эрүүл саруул ухаан ер хамаагүй юм бол та бид чинь ямар хүмүүс байх вэ? Тэгвэл адгуус мал, араатан амьтнаас юугаараа ялгагдах юм бэ? Үгүй ээ, оюун ухааныг бидэнд дэмий заяасан юм биш шүү. Бид бүгдээрээ! тойрч суугаад тунгаан хэлэлцэх, эргэж хариад гав ганцаараа эргэцүүлэн бодох чадвартай. Надад дахиад л эмх замбараа алдуулж, үймээн самуун дэгдээж, хүчирхийлэл дайсагналд урин дуудах ямар хэрэг байна? Миний зураг төөрөг тийм л юм байлгүй, би хүүгээ алуулж, энэ уй гашуугаа элэг зүрхэндээ шаналан тээсээр дуусах болно. Гэлээ гээд би ямар ч гэм буруугүй бусад хүмүүсийн энэ хорвоо дээрх амьдралыг сүйтгэн үймүүлж яах юм бэ? Өс хонзон өвөрлөх ямар ч бодолгүй байгаагаа нэр төрөөрөө батлан тангараглая. Хэн хүний гар хөлийн үзүүр болж явах дургүй, орой дээрээ ноён суулгаж онц шаардлагагүй бол хүнд захирагдах Дургүй хүмүүс энд цугларчээ. Энэ улсад л бид аз хийморьтой явна. Одоо ч гэсэн үр хүүхэд маань биднээс дээр амьдарч, сурган хүмүүжүүлэгч, эрдэмтэн, хөгжимчин, жүжигчин болсон нь цөөнгүй байгаа нь бахархалтай. Ач үрс маань бидний мөрөөр орж, халгаатай ээдрээтэй ийм зам туулахыг хэн ч хүсэхгүй нь мэдээж. Энд,

Америкт болохгүй бүтэхгүй юм гэж байхгүй тул миний ач гуч нараас мужийн сайд, тэр ч бүү хэл улсын ерөнхийлөгч ч төрж гарах юм билүү, хэн мэдлээ. Гагцхүү цаг үетэйгээ хөл нийлэн алхах л хэрэгтэй. Эдүгээ буу, сум, хутга мэсний үе өнгөрч, хэрвээ бид үнэхээр ажил хэргийн хүмүүс л юм бол овжин сэргэлэн сүүхээ, саруул тунгалаг оюун ухаанаар л ялан дийлэх цаг иржээ.: Харин бид чухам юу хийж яаж амь зуухаа тэр бүхний өмнөөс бүгдийг шийддэг, хүний гараар могой барьдаг дарга ноёдоос яасан ч асуухгүй. Өөрсдийн эрх ашгийг хамгаалан, ерөөлийн ашиг сонирхлыг хохирохоор бодож тэдний гаргасан хуулинд бид заавал захирагдах үүрэгтэй гэж хэн хэлсэн юм бэ? Бидний амин чухал ашиг сонирхлоо хамгаалахад хөндлөнгөөс оролцох хорио саад хий гээд байдаг тэд ер нь хэн юм бэ? Энэ чинь бидний л хувийн хэрэг биз дээ? Бид өөрийн гэсэн энэ ертөнц Коза нострадаа өөрсдөө л учраа олох ёстой болохоор түүнийг бусдын халдлагаас хамгаалан хаахын тулд мөр мөрөө түшиж, гар гараасаа бат барилцвал зохино. Тэгж чадахгүй л бол энэ оронд сая сая Неаполийн болон итали хүмүүсийг цаламдан уургалсан шигээ биднийг дөрлүүлсэн бух шиг дарлан доромжлох болно.

Чухам үүнээс зайлсхийхийн тулд л, бүгд нийтийн ашиг сонирхол бүхний тусын тулд л би амь үрэгдсэн; хүүгийнхээ өшөөг авахаас татгалзаж байна. Овог отгийнхоо үйлдэл, ажиллагааг би удирдан хариуцаж байгаа цагт шударга үндэслэл, ноцтой шалтаггүйгээр та нарын хэнд ч гар хүрэхгүй гэдгийг андгайлъя. Бүгдийн ашиг тусын тулд би өөрөө хонжоо орлоготой хэрэг үйлээс ч татгалзахад бэлэн гэдгээ та бүхний мэдэж байгаагаар хэзээ ямагт чандлан сахиж ирсэн үнэн үг, нэр төрөөрөө батлан даах байна.

Тэгэхдээ энд хувийн ашиг сонирхол надад бас буйг нуух хэрэг юун. Отгон хүү минь Солоццо, цагдаагийн ахмад хоёрыг буудан алсан хэрэгт сэжиглэгдэн, оргож зайлахаас ондоо аргагүй болсон. Тэгэхлээр би одоо эл хуурамч яллагааг няцаан хэрэгсэхгүй болгож, хүүгээ гэрт нь амар амгалан авчирч байлгах арга хэмжээ авмаар байна. Энэ миний л хэрэг, үүнийг би дөнгөнө ч гэж найднам.

Гэхдээ энд би нэг юм, тухайлбал сүсэг сүжлэгтэй хүн гэдгээ цохон хэлмээр байна. Ичмээр л юм, гэвч яая гэхэв. За тэгэхлээр, хэрэв бага хүүд минь золгүй явдал тохиолддог ч юм уу, эсвэл цагдаагийн офицер санаандгүй буудчихдаг ч юм уу, нэг бол шоронгийн өрөөнд өөрийгөө боймолж үхдэг ч байна уу, үгүй бол гай нь таарсан гэрчийн этгээдүүд гарч ирээд түүний эсрэг мэдүүлэг өгөх юм бол би мухар сүжигтээ хөтлөгдөөд энэ болгоныг та нарын хэн нэгний хорон атгаг санаатай холбох болно шүү. Тэгээд ч зогсохгүй, хэрэв хүүгийн минь толгой дээр гэнэт аянга цахилгаан буух аваас миний бие та нарын заримыг буруутгана. Хэрэв заяа түүний суусан онгоц газарт унаж хөлөг онгоц нь далайд живэх юм уу, үгүй гэхэд аминд халтай ханиад томуу хүрдэг ч юм уу, эсхүл машин нь галт тэргэнд гэнэт дайруулах ахул нөгөөх л сүжиг сэжгийнхээ улмаас та нарын хэн нэг нь надад зовлон учруулж гай тарих бодол цээжиндээ тээсэн хэвээр байна гэж үзэх хүн шүү. Иймэрхүү хорон санаа, тиймэрхүү золгүй тохиолдлыг би хэзээ ч өршөөж уучлахгүй. Харин үүнээс л бусад талаар бол өнөөдрийн энд байгуулсан эв найрамдлыг ямар ч нөхцөл байдлыг эвдэхгүй гэдгээ ач гуч нарынхаа амь насыг барин тангараглая.

Ингэж хэлээд эрхэм Корлеоне суудлаасаа босч, Филипп Таттальягийн зүг намбатай зөөлөн алхвал цаадах нь ч гэсэн тосон өндийж, тэр хоёр тэврэлдэн үнсэлцэхүй танхим дүүрэн алга

нижгэнэж, бусад их эцэг ч гэсэн ухасхийн босоцгоогоод, найрсаг харилцаа тогтоож, эв эеэ олсонд нь эрхэм Корлеоне ноён Татталья хоёрт баяр хүргэхийн зэрэгцээ бас өөр хоорондоо гар барин тал засч шуугиан боллоо. Гэхдээ энэ бол хорвоо дээрх хамгийн халуун дотно бат найрамдал биш, хэзээ ч тэр хоёр баяр ёслолоор бие биедээ бэлэг сэлт илгээж сүйд майд болохгүй хэдий ч, ядахнаа нэг нэгнээ яргалж алахгүй гэдгийг цугларсан хүн болгон сайн ойлгож байв. Үүнийг эвсэг нөхөрлөл гээд хэлчхэд алд дэлэм алдах нь юу ч бол, оргүй дор охинтой гэгчээр арга тасрах цагт энэ ч гэсэн их юм.

Эрхэм Корлеоне, Том Хейген, дөнгөж өнөөдөр жолоо барьж бие хамгаалахаар гарсан Рокко Лампоне гурвыг Корлеонегийн төв байр орших цэцэрлэгт бүсийн хаалгаар ороход бүрэнхий болж байв. Машинаас бууж гэрээ зүглэх зуур Их эцэг Хейген руу эргэж:

- Манай жолооч, энэ Лампоне сайн ажиж тогтоож ав. Энэ залуу арай дөнгүүр ажилд тэнцэх юм шиг санагдаад байна гэх хэдэн үг унагасанд цаадах нь хачин их гайхсан аж.

Лампоне бүхэл өдөржингөө ам нээгээгүй тэднийг машинаар явах хугацаанд ганц ч удаа эргэж хараагүй болохоор гарын зөвлөхийн олж үзээгүй ямар нэг юм Их эцгийн гярхай харцанд өртсөн л байж таарлаа.

Гол хаалганд хүрээд Их эцэг өрөөндөө Клеменца, Тессио хоёрыг дагуулан арван цагийн алдад ирэхийг Хейгенд даалган, тэр болтол цаад хоёртоо зөвлөгөөний явцыг ярьж, хэргийн учир байдлыг ойлгуулах ёстойг хэлээд явуулжээ.

Яг арван цагт тэр дөрөв хамгийн мухарт орших Их эцгийн ажлын өрөөнд уулзахад эрхэм Корлеоне эхэлж ам нээн:

- За ингээд бид сая найрамдал байгуулж, би нэр төрөөрөө андгайлсан нь та нарт ч гэсэн хангалттай байх биз. Гэхдээ холбоотон сүлбээтэн маань тийм ч найдвартай бус тул урьдын л сонор сэрэмжтэй байцгаая гээд Хейгений зүг нүд өргөв. - Боккикьогийн барьцааны хүмүүсийг явуулсан уу?

Хейген толгой дохиж:

- Тийм ээ, ирсэн даруйдаа л Клеменцад утасдсан гэвээс Корлеоне тэвэрье гэхэд хоёр гар талд нь хүрэхгүй том лагс биетэй эр рүү хартал итгэмжлэгдсэн бие хамгаалагч нь мөн л толгой дохив.

Цус асгаруулсан дайн тулаан нэгэнт дуусгавар болж, жаахан ч гэсэн амсхийхтэй болсон тул эрхэм Корлеоне өөрөө дарсны холимог бэлдэн нөгөө хэддээ аяга бариулсан хойноо өөрийнхөөсөө болгоомжтой амсаад навчин янжуураа асаалаа.

- Та нараас хэн нэг нь Сонниг хөнөөх ажлыг хэн, яаж зохион байгуулсныг мэдэхээр оролдоод хэрэггүй, энэ асуудлыг эцэслэж мухарласан, мартацгаа. Бусад нам, овгийнхон ховдоглож шунаад бид хэр хэмжээнээсээ хавьгүй багыг авч хохирсон ч гэсэн бид тэдэнд тус дэм үзүүлж байхыг би хүснэ. Майклыг гэртээ авчрах арга бодож олтол энэ эв найрамдлыг ямар ч өдөөн хатгалга, урван тэрслэлт эвдэн бусниулахгүй байхыг би хүснэ. Одоогоор та бүхний эрхэмлэн

хичээж чухалчлан оролдох гол зүйл чинь энэ шүү. Түүнийг эргэж ирэхэд ямар ч аюулгүй, байхын бүрэн нот баталгаа надад хэрэгтэй байгааг бүү мартаарай. Жинхэнэ гэрчийн этгээдүүдийг бид сайн мэднэ, тэдний мэдүүлэг нэг их хор хүргэхгүй. Харин туршуул тандаач нар Майкл Корлеоне л ахмад Макклоскиг алсан хэмээн нэгэн дуугаар батлан хэлсэн болохоор цагдаагийн газар илчлэн буруутгах баримт өөрөө хуурамчаар үйлдэхээс л айж сэрэмжлэх нь зүй. За яая гэхэв. Хэрэв тийм бол том Таван нам туршуулуудын мэдүүлгийг өөрчлүүлж цагдаагийн газрынхны энэ санаа бодлыг өөрчлөхийн тулд бололцоотой бүх арга чаргаа хэрэглэхийг бид шаардах ёстой. Өнөөдрийн миний үг хэлснээс хойш шинэ холбоотнууд маань бидэнд туслах нь өөрсдийнх нь ашиг сонирхолд ч нийцэхийг ойлгоно гэж би найдаж байна. Гэвч энэ хангалтгүй. Бид Майклыг бүрмөсөн, эцэст нь хүртэл цагаатган зөвтгөх арга олох нь чухал. Чадахгүй бол тэрээр эргэж ирэхийн ч хэрэггүй. Одоо сайн бодоцгооё. Одоохондоо бидэнд үүнээс чухал юм алга.

За цааш нь. Амьдралдаа ганц удаа ч алдаж гэнддэггүй хүн гэж байхгүй биз. Би ч нэг удаа эндэж осолдсон. Одоо хэнийг ч гэсэн бүтэн бээрийн зайнаас цэцэрлэг рүү өлөн нүдээр шагайлгахгүйн тулд цэцэрлэгт хүрээлэнгийн тойргийн доторх бүх эдлэн газар, түүн дээрх байшин барилгыг бүгдийг нь би худалдаж аваад хашаагаар хүрээлж хаа сайгүй харуул хамгаалалт тавихыг хүсч байна. Нэг үгээр хэлбэл энэ мөчөөс эхлэн би бат цайзад суумаар байна. Би хот руу ажилдаа явахаа болилоо. Ажил хэргээсээ түр зуур хөндийрсөнд тооцож болно. Харин цэцэрлэгт мод цэцэг, газар шороотой ноцолдон усан үзэм болж гүйцэхээр гэртээ дарс хийж, ер нь суурин аж төрөх дур хүрээд байна.

Ажил хэргээ би та нарт улам улмаар шилжүүлж, Сантиногийн бүлгийг тараагаад Хүмүүсийг нь та нарт тарааж өгнө. Ингэснээрээ бид шинэ найз нартаа найдвар төрүүлж, энхийг эрхэмлэх санаа бодолтой байгаагаа батална. Том оо, чи Лас-Вегас орж тэнд юу болж байгааг нэгд нэгэнгүй мэдээлэх хэсэг хүмүүсийг сонгож ол. Далимд нь Фредо тэнд ямар гээчийн бантан хутгаад хөглөж явааг мэдэж ирцгээг. Төрсөн хүү минь төрөл арилжсан мэт танигдахгүй болтлоо өөрчлөгдөн тогоочийн ажилд орж. нас бие гүйцсэн эр хүн гэхэд эмс хүүхнүүдтэй эрээ цээргүй, арай дэндүү орооцолдоод байна гэлцэх юм. Ер нь бүгдийг мэдээд ирэг.

- Танай хүргэнийг явуулбал яасан юм бэ? Ямар ч гэсэн Карло Невадад төрж өссөн, тэндхийн байдлыг сайн мэднэ, танил тал ч ихтэй шүү дээ хэмээн Хейгенийг тун болгоомжтой асуухад эрхэм Корлеоне толгой сэгсрэн:

- Үгүй ээ, хүүхдүүдээс хэн нэг нь хажууд байхгүй бол эхнэр маань уйтгарлаж гүйцнэ. Би Констанция, хүргэн хоёроо энд авчирч аль нэг байшиндаа суулгаад Карлод олигтойхон ажил өгмөөр санагдах юм. Би түүнтэй хэт ширүүн харьцдаг байсан ч байж магадгүй, бас тэгээд ... хөвгүүд минь надад дутагдаад байна. Мөрийтэй тоглоомын ажлаас түүнийг татан авч, үйлдвэрчний эвлэлийн шугамаар ажиллуулна биз дээ. Тэнд чухам л хэл амаа билүүдэж бичиг цаастай зууралдах хэрэг гардаг болохоор цаадах чинь дөнгөх байлгүй дээ гэх дуунд нь үл тоомсорлох, үзэн ядах өнгө илт цухалзав.

Хейген толгой дохисноо:

- Би Фреддиг хэдэн хоног гэртээ ир гэж дуудах уу? гэхэд Их эцэг дуугаа өндөрлөж:

- Яах юм бэ? Тэндээ л сууж байг. Тэртэй тэргүй эхнэр маань хоол ундаа муугүй хийдэг хэмээн хатуухан зуунги үгүүллээ.

Цаад гурав нь тун эвгүй байдалд орж суудал дээрээ хавчганав. Төрсөн эцэг нь Фреддид ийм их дургүй болсон гэж тэд зүүдлээ ч үгүй явсан агаад өөрсдийн нь үл мэдэх ноцтой шалтгаанаар л ингэснийг сая ойлгоцгоожээ.

Эрхэм Корлеоне санаа алдан:

- Энэ жил ногооны талбайд маань ногоон чинжүү, улаан лооль өөрсдөө идэж барахааргүй их ургах төлөвтэй болохоор та нартай хуваалцана аа. Ер нь нас дээр гарсан хойноо амар тайван, ажин түжин аж төрөн суумаар санагдах боллоо. За ингээд гүйцээ шив дээ. Наадах аягаа дүүргэ ууцгаа, идэцгээ гэсэн нь яриа дууссаны дохио байлаа.

Бүгд босч, Хейген нөгөө хоёроо машинд хүргэж өгөх зуур хэзээ уулзахаа тохиролцоод Их эцэг хүлээж буйг мэдэж байсан учир ажлын өрөөнд нь буцаж ирэхэд эрхэм Корлеоне пиджак зангиа хоёроо тайлж, ннлээд ядарч цуцсан царайтай булангийн ханзан дээр хэвтэж байснаа сульдсан гараараа сандал руу сулхан зангав.

- За зөвлөх минь, чи өнөөдрийн миний үйлдлийг сайшаахгүй л байна уу?

Хейген шууд хариу хэлсэнгүй түр азнаан бодол болсноо:

- Үгүй, яалаа гэж дээ? Харин энэ бүхнийг та хийсэн гэхэд үнэмшмээргүй, тийм ч шийдэмгий тууштай бус санагдсан шүү. Сантино яаж алуулсныг тодруулж мэдэх, өшөө авахыг та хүсэхгүй байна гэх юм. Би итгэхгүй байна. Та энх тайван байдлыг эвдэхгүй гэж ам өгсөн, тэгэхлээр эвдэхгүй л байж таарна. Гэвч та өнөөдөр өшгөн дайснууддаа ялагдсан болж үлдээд энэ чигээрээ амарлингуй суугаад байна гэдэгт би яасан ч итгэхгүй. Миний ухаан хүрэхээргүй ээдрээтэй оньсого шиг юм хийсэн болохоор тийм нарийн төвөгтэй үйлдлийг тань ойлгож тайлаагүй байж би яаж сайшаах юм уу, буруушааж зүрхлэхсэн билээ?

Их эцгийн царайд сэтгэл дүүрэн байдал гэрэлтээд ирлээ.

- Үгүй ерөө чи мөн намайг сайн мэдэх болжээ, хэлэх ч юм алга. Сицилид төрөөгүй ч гэсэн чамайг би сицили эр болгож чадсан шиг байна. Чиний хэлсэн бүгд үнэн. Харин энэ оньсогоны тайлбарыг хэрэг нэг тийш шийдэгдэхээс хамаагүй өмнө чи өөрөө ойлгоно оо, гайгүй. Том минь, хамгийн гол нь Майклыг аль болох түргэхэн шиг гэрт нь ирүүлэх хэрэгтэй байна. Энэ бол бидний тэргүүний зорилт, бүх ажил хэрэг, оюун бодлоо үүнд л зориул. Ямар ч үнээр хамаагүй хууль ёсны нүх сүв, боломж болгоныг судалж, хамгийн сайн эрүүгийн өмгөөлөгч нартай зөвлө. Хүү минь буцаж ирэхдээ нялх үрийн нулимс шиг цэвэр байх ёстой шүү. Хэрэгтэй бол чамайг хувийн журмаар хүлээн авах шүүгч нарын нэрийг би хэлж өгнө. Харин одоо хэн ч хэзээ ч урван тэрсэлж магадгүй учир бид маш хянуур болгоомжтой байх хэрэгтэй.

- Жинхэнэ илчлэх баримт ч яая гэхэв, харин хуурамчаар гаргуулсан мэдүүлэг сэлтэд л би таны нэгэн адил санаа зовох юм. Майклыг наанадаж гэхэд түр саатуулан хорих л юм бол

цагдаагийнхан өөрсдөө ч юм уу, эсвэл аль нэг хоригдлын гараар устгаж дөнгөнө. Тэгэхлээр түүнийг баривчлах, тэр ч байтугай яллах ч аян шалтаг байхгүй гэж би бодож байна.

Эрхэм Корлеоне гүнзгий шүүрс алдав.

- Мэднэ ээ мэднэ. Чухам тэр чинь л маш хэцүү байгаа юм. Гэхдээ л Сицилид байдал тайван бус учир цааргалж, хойш тавих нь тун аюултай. Залуус нь ахмад буурлуудынхаа үгэнд орохоо болиод, бас Америкаас хөөгдөж очсон сайн эрсийн дотор тэндхийн баазхан их эцгүүдэд дийлдэхээргүй догширсон хашир чоно цөөнгүй бий. Нэг нь биш гэхэд нөгөө нь Майклыг хөнөөчхөж чадахаа л чадах учраас би зарим нэг арга хэмжээ авсан. Одоохондоо түүнд найдвартай орогнох газар бий, гэхдээ хэр удахыг хэн мэдлээ? Энэ бол өнөөдөр миний арга буюу найрамдал байгуулахад хүрсний нэг шалтгаан. Барзинигийн найз нөхөд Сицилид бий, тэд нар нь аль хэдийн Майклын ул мөрийг шиншилж эхэлсэн. Нөгөө оньсогоны чинь нэг тайлал энэ. Хүүгээ аюулгүй байлгахын тулд би найрсаж эвсэхээс өөр аргагүйд хүрсэн.

- Нарийн ширийн зүйлийг би Таттальягийнхантай тохиролцохдоо зөвхөн нэр цэвэр ямар ч сэжиг авахуулаагүй хүмүүсээр мансууруулагч наймаалуулахыг шаардах уу, болих уу? Урьд нь ял эдэлсэн хүнийг зөөлхөн шийтгээд, өгөөч гэж шүүгчээс шаардах хэцүү шүү дээ.

Эрхэм Корлеоне дал мөрөө хавчив,

- Үүнийг тэд өөрсдөө л тооцоолох ёстой. Шахаж шаардах хэрэггүй, зүгээр л сануулаад орхичих. Маниас шалтгаалах бүхнийг бид хийнэ, гэхдээ тэд энэ ажилд нэвширсэн мансуурагчийг тавьж мунхаглаад тэр нь баригдаж баларвал бидний хүч хүрдэг асуудал биш гээд л гэдийчих нь биз. Тэгээд ч Барзинид зааж сургах хэрэггүй өөрөө сайн мэдэж байгаа. Тэр нохой нэг ч үгээр өөрийгөө энэ хэрэг явдалтай холбоогүй, хөндлөнгөөс ямар ч хамаагүй юм шиг үлдсэнийг чи анзаарсан биз дээ. Тэр чинь хэзээд л биендээ хир халдаалгүй цэвэрхэн мултраад гарчих хүн шүү.

Хейген гайхан давхийж:

- Өөрөөр хэлбэл, тэрээр бүр анхнаасаа Солоццо, Татталья хоёрын ард нуугдан турхирсан гэж та хэлэх гээ юу? хэмээсэнд Их эцэг дахиад л санаа алдлаа.

- Татталья зөвхөн зуучлагч, өөр гавих юмгүй болохоор ганцаараа бол Сантиног хэзээ ч дийлэхгүй байсан. Тийм ч учраас энэ бүхэн яахан болж өнгөрснийг тодруулж мэдэх хэрэг надад байгаагүй. Барзини л үүнийг хийсэн гэдгийг би мэднэ. Энэ л хангалттай.

Хейген хэлсэн болгоныг нь анхааралтай, сонсож, нягтлан ухаж бодох ажээ. Их эцэг түүнийг алхам алхмаар асуудлын тайлалд хөтлөн аваачихдаа маш чухал нэгэн зүйлийг тойрон өнгөрсөн, тэр нь чухам юу болохыг хал үзэж хашир суусан зөвлөх андахгүй хэдий ч хэлээгүй юмыг асууж шалгаах хал балтай гэдгийг ч сайн мэднэ. Тэрээр салах ёс гүйцэтгэн цааш эргэтэл Их эцэг араас нь үгүүлрүүн:

- Майклыг гэртээ авчрах л хамгийн чухал гэдгийг хатуу сана. Энэ талаар өдөр шөнөгүй сэхээ сэвээгүй бод. Аа тийм, өөр бас нэг юм байна Холбооны товчоон дээр очоод Клеменца,

Тессо хоёрын өөрсдийнх нь болон тэдэнтэй ярьсан яриа болгоныг жагсаагаад сар болгон ирүүлж байхыг залгагчтай нь тохироорой. Би тэднийг ер сэжиглэж хардаагүй, намайг хэзээ ч хөөдөж баллахгүй гээд тангараглахад ч бэлэн. Гэвч өчүүхэн төдий ч зүйлийг урьдчилаад мэдчихсэн байх нь зүйтэй, хожим хэрэг болж юу магад.

Хейген толгой дохиод гарах зуураа Их эцэг намайг бас ингэж шалгадаг болов уу гэсэн юм бодсоноо гэнэт өөрөө өөрөөсөө ичиж орхив. Харин Загалмайлсан эцгийн уураг тархины нарийн сүлжилдсэн нугачаа атираа болгонд холын хараатай чухаг төлөвлөгөө боловсрон, өнөөдрийн ухралт нь зөвхөн тактикийн сэлгээ болохыг бат мэдэж авчээ. Дээр нь бас эрхэм Корлеонегийн дурсалгүй өнгөрч, өөрөө ч асууж зүрхлээгүй нэгэн учир битүүлэг явдал үлдсэн зэргээс дүгнэж үзэхэд хариу шан хагуухан хүртээх өдөрт одооноос бэлдэж байгаа нь тодорхой боллоо.

АРВАН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Гэвч заяа тавилангийн эрхээр зөвхөн нэг жил өнгөрсөн хойно л сая эрхэм Корлеоне хүү Майклыгаа Нэгдсэн улсад буцааж авчирчээ. Энэ хугацааны туршид нам овгийнхон нь толгой гашилган элдэв арга сүвэгчилсэн нэг ч төлөвлөгөөг Их эцэг сайшаасангүй.

Эцсийн эцэст Боккикьогийн гэр бүлд тохиолдсон золгүй явдал л эл ээдрээтэй асуудлыг нааштай шийдвэрлэхэд тус болжээ. Тэр овгийн Америкт төрсөн нэг гишүүн Феликс гэгчид байгаль эх сэргэлэн толгой заяаж, мань эр Боккикьогийн намын хууль ёсны ажил болох хог цэвэрлэхээс татгалзсанаас гадна шударга төвшин гэр бүлээс гаралтай англи бүсгүйтэй гэрлэсэн нь төрөл садантайгаа улам эвдрэлцэж түнжин хагарахад хүргэсэн аж. Хуульч болох санаа өвөрлөн оройн цагаар сургуульд сурч, өдрийн цагаар шууданд ажилладаг тэр залуу энэ хооронд гурван хүүхэдтэй болсон авч гэргий нь аж ахуйгаа арвигамтай эрхлэн хөтлөх тул диплом автлаа зөвхөн цалингаараа амь зуугаад байж дөнгөжээ.

За ингээд, Феликс Боккикьо залуу халуун насны харгайгаар нэгэнт л ийнхүү хүч гарган хөлс дуслуулж байж дээд боловсрол, дуртай мэргэжлээ эзэмшсэн хойно аз хийморь нь аяндаа сэргэж, авах олох мөнгө нь ч ахиад ихсээд ирнэ гэж бодсон чинь амьдрал огт өөрийг харуулж дээ, хөөрхий. Гэвч угийн бардам зантай тэр эр төрөл төрөгсдөөсөө ямар нэгэн дэм туслалцаа авахаас улангасан татгалзаж гөжжээ. Бас л залуу хуульч, гэхдээ танил тал ихтэй, өмгөөллийн томоохон товчоонд өсөх ирээдүйтэй алба хашдаг нэгэн найз нь өнгөн дээрээ хууль ёсны авч үнэн хэрэгтээ хуурамч дампууралтай холбоо бүхий асар нарийн төвөгтэй хэрэгт тус үзүүлэхийг хүссэнд арга бааш нь илрэх магадлал өчүүхэн бага, саяас нэг л байсан тул Феликс Боккикьо үзээд алдахаар шийдлээ. Энэ хэрэгт мэргэжлийн гаргуу ур чадвар шаардах байснаар мань эр сэтгэлээ сүлэн уг заль мэхний гэмт хэргийн биш гэхэд зэмлэн буруушаавал зохих мөн чанарыг нэг их тоож

үзсэнгүй.

Яаж ч байгаад юм, ямар ч л гэсэн нүгэл нь нүдээр цувж заль мэх нь илэрч, хуульч анд нь Феликсийг аврах талаар хуруу ч үл хөдөлгөснөөр үл барам утасдахад нь хүртэл харилцуураа авсангүй. Гол дүрд тоглосон хашир хөгшин хоёр луйварчин Феликсийг болхи бүдүүлэг ажилласан гэж хараан зүхсээр гэм буруугаа хүлээж, мөрдөн байцаалтад туслахдаа түүнийг л энэ хэргийг зохион байгуулсан тэдэнд итгэл олон эцэст нь гартаа хийж авахын тулд занаж сүрдүүлсээр байгаад уруу татсан гэж мэдүүлэв. Бас хүч хэрэглэсэн гэмт хэрэгт урьд нь шийтгэгдэж асан үеэл дүү, авга ах нартай нь Феликсийг холбон дурдсан тул энэ бүхнийг үндэслэн мань эрийг шүүхэд шилжүүллээ. Хоёр луйварчин тэнсэн ял авсан төдийхнөөр өнгөрч, Феликс Боккикьод таван жил хорих ял оноожээ. Хэзээ ямагт хамаатан садангийнхаа халамж дэмжлэгээс цэрвэн татгалздаг сэхүүн Феликсийг хашрааж, гэр бүлийнхнээс нь өөр тус болох хүн үгүй, өрх омог нь нийгэм төрөөс илүү түшигтэй найдвартайг ой тойнд ортол ойлгуулах санааны үзүүрээс тэд эрхэм Корлеонегээс ч, бусад нам, овгийнхноос ч тусламж эрсэнгүй.

Ингээд л Феликс шоронд гурван жил сууж гараад гэртээ ирж, эхнэр хүүхдүүдээ үнсэж элгээ

дэвтээн нам тайван нэг жил болсны дараа Боккикьо гэдэг овог нэр дэмий ч зүүж яваагүй болохоо баталж өглөө. Сайхь залуу хаанаас ч юм нэг гар буу олж аваад найз хуульчаа буудаж алсны хойт дээр нөгөөх хоёр сайн эрийг зуушны газраас гарахад нь отож байгаад цохонд нь сум зоочоод хэнэг ч үгүй цаашилж зуушны газар кофе балган баривчлахаар ирэх цагдаа нарыг тайван хүлээсэн гэдэг.

Түүнийг шүүхэд түвэг удсангүй, хатуу ял оноосон нь мэдээж. Гэмт хэргийн ертөнцийн адгийн шаар болсон энэ хорт могой үнэн шударгаар, зүй ёсоор торонд хориулсан золгүй гэрчийн этгээдүүдийг өрөвдөх сэтгэлгүйгээр буудаж алсан нь нийгэм, төрд илэрхий дайсагнасан хэрэг биш гэж үү? Өдий төдий хугацаа өнгөрсний дараа л сая энэ нийгмийн түшиг болсон гарамгай зүтгэлтэн, олон нийт, сонин хэвлэлийнхэн, тэр ч байтугай өр зөөлөн атлаа харалган бодолтой энэрэнгүй үзэлтнүүд хүртэл Феликс Боккикьоог цахилгаан сандал дээр сууж байхыг нь харах хүслээ нэгэн дуугаар илэрхийлнэ. Мэдээжээр одоо Феликсээрээ бахархах болсон Боккикьогийн отог омгийнхон ялын тогтоолыг дээд шатанд давж заалдахын тулд мөнгө хайргүй зарахад бэлэн байсан боловч эл хэргийн дүнг урьдаас шийдчихсэн, яаж ч өөрчлөх аргагүй байв. Хуульд заасанчлан хий дэмий албаны үйлдлийг ёс төдий гүйцэтгэж дуусмагц Феликс цахилгаан сандал дээр суух байлаа.

Сайхь залууд туслан аврах горьдлого нь тасраагүй Боккикьогийнхны нэгний хүсэлтээр Хейген энэ тухай Их эцэгт дуулгатал: «Би ямар ид шидтэн биш, хүмүүс дандаа л болж бүтэхгүй зүйл гуйх юм» гэсэн хүйтэн хачир хариу өгч, эрс татгалзжээ. Гэвч маргааш нь л Хейгенийг дуудаж, энэ хэргийг үндэс суурьтай, маш тодорхой ярьж өг гээд түүнийг тайлбар яриагаа дууссан хойно Боккикьогийн овгийн толгойлогчийг хэлэлцээ хийхээр Лонг-Бичид урихыг тушаав.

Үүний дараа болсон хэрэг явдал бүх л суут үйлийн нэгэн адил маш энгийнээр явагдаж өнгөрчээ. Эрхэм Корлеоне хөөрхий Феликс Боккикьогийн эхнэр хүүхдүүдийг харж тэтгэн дориухан мөнгө хөрөнгө өгөх үүрэг хүлээж, энэ мөнгийг омгийн тэргүүлэгчид нэн даруй гардуулахаар болов. Үүний хариуд Феликс өөрөө Солоццо болон цагдаагийн ахмад Маккლოსкиг алсан гэж мэдүүлэх ёстой байлаа.

Нарийн ширийн бүхнийг нягтлан тохиролцож, омгийн толгойлогч мөнгөө авснаас гадна ялтанд хэргийн учрыг хэлж мэдүүлэн, зохих заавар өгөхийн тулд холбоо тогтоожээ. Энэ гайхамшигт төлөвлөгөө санаснаас ч илүү бүтэмжтэй болж хоёрын хоёр хүн амины хэрэг бөөн шуугиан дэгдээсэн хэдий боловч угийн хал үзэж халуун чулуу долоосон хашир Их эцэг ялын тогтоолыг ёсоор болгох хүртэл дөрвөн сар хүлээсний эцэст л сая Майкл Корлеонег гэртээ эргэж ирэх тушаал өгсөн бөлгөө.

ХОРЬДУГААР БҮЛЭГ

Сонниг амь эрсэдсэнээс хойш бүгэн жилийн турш Люси Манчини уй гашуудаа дарагдан, сэтгэлийн шаналгаагаар барьж чадахгүй баахан зовжээ. Харин одоо, олон сарын дараа тэр бүсгүй Невадагийн улбар шар нарны зөөлөн туяанд биеэ таатай шарж буянаа эдэлж, хөлд нь эвхрэн тухалсан гоолиг сайхан залуу улыг нь гижигдэн эгдүү хүргэнэ. Бүтэн сайны өдөр үдэш тийшээ хэвийсэн хэдий ч тансаг хээнцэр зочид буудлын усан санг тойроод хүн зоны хөл тасрах яагаа ч үгүй.

Люси хоёр хөлөө татангаа:

- Жул минь, битгий оролдоод байгаач. Ядахдаа эмч нарыг ийм гэж бодоогүй юмсан гэхэд Жул мөргөлдөх гэсэн ухна шиг толгой сөхөн ярзайтлаа инээд

алдлаа.

- Лас-Вегаст ийм л байдаг даа.

- Тайван байлгаад өгөөч гэж байна шүү би! хэмээн хүүхнийг уурсан хашхирахад Жул тэр даруйдаа далан таваар бууж өгөөд:

- Болилоо, болилоо, шувуухай минь. Одоо гүйцээ! хэмээн бүсгүйн булбарай зөөлөн өвдөг дэрлэн хэвтэж байснаа нэг мэдэхнээ зүүрмэглэж орхив.

Люси усанд орж байгаа хүмүүсийн хөөрцөглөн бужигнахыг ажиглан хөдөлгөөнгүй суусаар... Хоёр жил хүрэхгүй хугацааны дотор амьдрал нь ийнхүү эрс өөрчлөгдөх юм гэж тэрээр яаж зүүдлэх билээ?! Конни Корлеонегийн хурим дээр «ухаангүй аашилж» ойворгонтсондоо нэг ч удаа харамссангүй. Түүнээс илүү алд биеийн жаргалыг урьд өмнө амсаж яваагүй болохоор хуял тайлсан хоргой торгон мөчийг сэтгэл санаандаа байн байн ургуулан тээж, хожим нь зүүдэн бодолдоо биш зэргэлдээх орон дээрээ жинхэнээр эдэлсэн удаа цөөнгүй...

Сонни түүн дээр долоо хоногт дор хаяхад хоёр удаа, заримдаа түүнээс ч олон ирдэг байлаа. Тэдний хүсэл тачаал нь сэтгэл санааны нийцэл, яруу сайхан тэнгэрлэг үзлээс хамаагүй хол хөндий гагцхүү махан биеийн бүдүүлэг догшин дурлал байсан юм. Сонниг одоо очлоо гэж утасдахад тэр бүсгүй юуны өмнө маргааш нь үд хүртэл цэнгэл жаргалаа эдлэх хугацаанд архи дарс, идэш зууш хүрэлцээтэй эсэхийг яаран сандран шалгадагсан.

Соннигийн эцгийг гудамжинд буудсан тэр үед Люси нууц амрагт нь ч гэсэн үхлийн аюул нүүрлэсэн байж болзошгүйг анх удаа ойлгоод өрөөндөө гав ганцаараа цорхиртол уйлж, уйлах ч гэж дээ бүр араатан амьтан лугаа адил эгшүүлэн эхэр татаж гаслан гиншиж гарчээ. Дараа нь бараг гурван долоо хоног Соннигийн барааг олж хараагүй тэр бүсгүй зөвхөн нойрны эмээр л бор хоногийг өнгөрүүлж, өдрийн цагаар сэтгэлийн зовлонгоо намжаан дарахын тулд зогсоо зайгүй архи ууж, хямрал шаналгаандаа болоод хамаг бие, яс нь шархиран өвдөнө. Сонниг арай гэж нэг юм босго алхмагц хүүхэн хоёр гараас нь тас зуурч аваад хормын төдий ч тавьсангүй. Үүнээс хойш үхэн үхтлээ Сонни нэг ч болзоог өнгөрүүлээгүй юмсанжээ.

Түүний амь эрсэдсэн тухай Люси сониноос уншиж мэдээд, тэд оройдоо л нойрны эм атга атгаар нь зажилж идсэн боловч яагаад ч юм үхсэнгүй, харин гэрээсээ гарч цахилгаан шатны үүд арай гэж хүрсэн даруйдаа хяргуулсан мэт хөсөр ойчтолоо хүчтэй хорджээ. Түүнийг тэр шатны тавцан дээрээс олж эмнэлэгт аваачсан бөгөөд Сонни тэр хоёрын харилцааг гадарлах хүн цөөн учир сонин хэвлэлд энэ хэрэг явдлын тухай хэдхэн мөр нийтлээд өнгөрчээ.

Чухам тэр эмнэлэгт л Том Хейген тайтгаруулан тайвшруулахаар эргэж ирэхдээ Соннигийн дүү Фредди Корлеонегийн эрхлэн удирддаг Лас-Вегасын зочид буудалд ажиллахыг санал болголоо. Тэрээр нүүх суухтай холбогдсон бүх асуудлыг гардан зохион байгуулж, очих газарт нь бэлэн сууц хүлээж байхаар зохион байгуулсан төдийгүй, өөрийн биеэр онгоцны буудал хүргэж, замдаа хэрвээ тэнд ганцаардах юм уу, таалагдахгүй юм гарвал заавал утасдаж мэдэгдэх ам өчгийг нь хүчээр шахуу авчээ.

Онгоцонд суух болсныг зарлахаас өмнө Люси бага зэрэг тээнэгэлзэн байснаа:

- Соннигийн аав мэдэж байгаа юу? Чи энэ бүхнийг хийхдээ түүнээс зөвшөөрөл авсан юм уу? гэвэл Хейген зөөлөн инээмсэглэв.

- Өөрөө мэдээд, гэхдээ түүний заавраар хийж байна үү дээ. Тэрээр ийм юмыг хуучин үзэл баримталсан хүний нүдээр хардаг тул хүүгийнхээ хууль ёсны гэргий хэзээ ч гай тарихгүй. Гэхдээ хар нялхаараа чам шиг охин юу ч мэдэхгүй, харин Сонни л бүгдийг бодож тунгаах ёстой байсан гэдгийг сайн ойлгож байгаа. Тэгээд ч бас нойрны эмээр биеэ хордуулсанд чинь бүгд цочирдож балмагдсан шүү дээ.

Хэн нэгэн амиа хорлож үхэх бодол толгойд нь орно гэдэг Их эцэг шиг хүний санаанд ч багтахгүй зүйл гэдгийг харин Хейген нэмж хэлсэнгүй. Хэлээд ч яах юм билээ дээ.

Одоо, Лас-Вегаст ирж суусан жил хагасаа Люси бараг аз жаргалтай өнгөрүүлснээ гэнэт ойлгоод их гайхсан аж. Тэрээр энд буянаа эдлэхдээ усан санд загас шиг сэлж, Мид нуурын мандлыг дарвуулт завиар зүсэн, чөлөө завандаа элсэн цөлөөр ухаангүй хурдлан давхисаар байгаад эцэж турсан хэдий ч бие галбир нь засраад өөрт нь их зохижээ. Люси жуулчдыг үйлчлэх товчоонд ажиллаж, ажил дээрээ Фреддитэй тааралдахдаа нэг их дотносож сүйд болдоггүй байлаа.

Хагас жилийн дараа Хейген Люсигийн хэрхэн аж төрж буйг үзэхээр ирсэн аж. Сар болгон тэр бүсгүй цалингаасаа гадна зургаан зуун долларын чек авдаг байв. Энэ мөнгийг хаанаас авдгаа татвар хянан шалгах газарт тайлагнах хэрэгтэй болохыг Том Хейген түүнд тайлбарлаад, өөрийнхөө нэр дээр итгэмжлэл бичиж өгвөл Люсид орлогын хууль ёсны эх сурвалж олж баримт бичгийг нь бүрдүүлж өгнө гэжээ. Өөрөөр хэлбэл, бусдын хувьд тэрээр өөрийн ажиллаж байсан зочид буудлын мөрийтэй тоглоомын газрын таван «хувьцаа» эзэмшигч болох ёстой байв. Харин энэ тухай хөндлөнгийн хүнд ярих хэрэггүй, хэрэв байцаагч шалгахаар ирвэл түүнийг өмгөөлөгч рүүгээ явуулаад л асуудал хал балгүй шийдэгдэнэ гэдгийг Хейген Люсид сайн ойлгуулсан болохоор татгалзсангүй.

Энэ бүхэн чухам ямар учиртайг Люси мэдэж байсан хэдий ч ачийг тусаар хариулах ёстой тул ийнхүү түүнийг «шаврын хаалт» болгон ашиглаж байгаад ер эвгүйрхэж дургүйцсэнгүй.

Харин Хейген эргэн тойрондоо юу болж байгаа, ялангуяа Фредди болон зочид буудлын эзэн, хяналтын багц хувьцаа эзэмшигчийн юу хийж байгааг сайтар ажиглаж байхыг Люсигээс хүссэнд өөрийн эрхгүй:

- Фреддиг тагнах гэж үү? Пөөх, Том минь, заавал ингэх албатай юм уу? хэмээн уулга алдсанд Хейген битүүлэг жуумалзав.

- Аав нь түүнд санаа зовоод байгаа юм. Тэрээр Мой Гринтэй хэтэрхий найзалж, хүзүү сээрээрээ холболдоод байгаа болохоор хэрэг төвөгт орчихоос нь сэргийлэх хэрэгтэй юм л даа.

Их эцэг зөвхөн хүүдээ толгой хоргодох газар болгохын тулд Лас-Вегасын элсэн цөлд энэ зочид буудлыг бариулаагүй, харин үүнийг шинэ газар нутаг булаан эзлэх түшиц газар болгох гол зорилготой байсан гэдгийг энэ хүүхэнд яриад юу хийх юм бэ?

Хэдэн сарын дотор Люси зочид буудлын эмч, хүчтэй салхинд хугарчихмаар нарийхан туранхай биетэй, цэвэрхэн царайтай Жул Сегалтай жинхэнэ найзын ёсоор үерхэж, харин ойртож хавьтсангүй. Ингэж гэжүүд зан гаргахаар эмч залуу гайхахын ихээр гайхаж байгаа нь илт авч бусдын адил гоморхож уурласангүйд Люси түүнийг улам их хүндэтгэх болжээ. Тэрээр тун сайн мэс засалч, тухайн үдээ Нью-Йоркийн нэртэй эмнэлэгт ажиллаж байсныг Люси санаандгүй олж мэдээд ямар учраас ийм газар ирснийг нь гайхан асуухад цаадах нь зэрвэсхэн хараад:

- Надад өөрийнхөө эмгэнэлт нууцаа итгэж хэлбэл чинь би энэ тухай ярьж өгнө хэмээн жуумалзлаа.

Эмэгтэйчүүдийн ямар нэг өвчин тусчхаад байсан болохоор Люси энэ үгийг дуулмагц чавга шиг улайчхав. Түүнд энэ тухай хүнд ярьсан дор бол үхсэн нь дээр байхсан. Гэвч Жул өөрт нь амь тавьдаг тун сайн найз тул хүүхэн эцсийн эцэст ичгүүр эвгүйрхлээ хүчлэн дарж, түүнд үзүүлэхийг зөвшөөрсөн байна. Эмч үзлэг хийснийхээ дараа тавиур дээрээс сурах бичиг авч, Люсигийнхтэй адил өвчин, түүнийг анагаах хагалгааны тухай бичсэн хуудсыг нээснээ:

- Хэвтэн эмчлүүлэхээс өөр арга ч алга даа. Эрүүл мэндээрээ тоглож хэрхэвч болохгүй... За ингээд, би чиний золгүй нууцыг мэдэж авсан болохоор өөрийнхийгөө ч ярьж өгье. Сонин хэвлэлд бичсэнчлэн дорнод хязгаартаа л толгой цохих залуу мэс засалч байж намайг яахлаараа ийм наргиан самууны газар өдөр хоног өнгөрөөхөд хүрснийг чи дандаа асуудаг. Яагаад гэвэл, чи ойлгож байна уу, би ажлаас гадуур үр хөндөж мөнгө олдог байсан юм. Эмч нарын ихэнх нь ингэдэг л юм чинь энэ ч бага хэрэг. Харин бусад нь яагаа ч үгүй байхад би гэдэг золгүй амьтан нууцаар аборт хийж байгаад баригдан хар дансанд орж эмч нарын Холбооны гишүүнээс хасагдаад, эмнэлгээсээ хөөгдөж хөгөө хөлдөө чирсэн хар толгой доо. Гадаадын хөлсний цэргүүдийг хамт эмчилж, дотно үерхсэн нэг найз Кеннеди минь Корлеонегийн гэр бүлээр дамжуулан туслахыг амлаж, тэд л намайг энд авчирсан юм даа. Энд сав умайгаа цэвэрлүүлэх эмс хүүхнүүд ямар мундах юм биш, овоо орлоготой, олонд хэрэгтэй, цагтаа л ирж үйлчлүүлэх юм бол ядаж цөхөх юмгүй аятайхан ажил шүү, минийх...

Хагас сарын дараа л гэхэд Жул Сегал Лос-Анжелесын эмнэлгийн мэс заслын өрөөнд өөрийн

найз эмч Фредерик Келнер хэрхэн Люси Манчинид хагалгаа хийхийг харж зогслоо. Түүнд мэдээ алдуулагч үнэртүүлэхээс өмнөхөн Жул бүсгүйн дээрээс тонгойж:

- Би чамтай гэрлэх бодолтой гэдгээ түүнд хэлчихсэн, тэгэхлээр чамд дээд зэргээр үйлчилнэ хэмээн чихэнд нь шивнэсэнд Люси гэнэт цочирдсон хамаг айдас жихүүдэс нь замхран алга болжээ...

Маргааш өглөө нь түүн дээр иртэл өрөө нь өнгө өнгийн цэцэгт умбаж орны нь дэргэд гаднын хоёр хар хүн сууж байсанд Жулын нүд орой дээрээ гарах шахав. Тэрээр баярын жишээл гэрэлтүүлсэн Люсиг танилцуулахаас ч өмнө тэдний нэг нь алдарт Жонни Фонтейн байхыг дор нь танилаа. Бяр тэнхээтэй, бадриун шөрмөслөг биетэй, ичгүүргүй нүүрэндээ увайгүй инээмсэглэл эсгэсэн нөгөө эрийг нь Нино Валенти гэнэ. Тэд хоёулаа Жулын гарыг атган мэндэлсэн даруйдаа түүнийг мартаж орхиод Люсиг элдвээр оролдон шоолж Нью Йорк дахь хуучин хорооллоо, бага насны дүрсгүйтэл, хэн нэг хүмүүсийг дурсан ам булаацалдаж байгаад л хөөрөлдөж хөхрөлдөв. Энэ бүхэн Жулд ямар хамаагүй байсан тул:

- За би дараа ирье дээ гэж Люсид хэлтэл Жонни Фонтейн хүмүүсийн дур булаах увидасаа дээд цэгт нь тулган инээмсэглээд:

- Түр азнаач! Бид одоо явлаа, та үлд. Энэнийг маань олигтойхон эмчлээрэй! гэв.

Жул түүний хоолойн өвөрмөц сөөнгө авиаг сонссон даруйдаа Жонни Фонтейн дуулахаа болиод жил гаруй болж байгаа, бас урьд нь тоглосон дүрд нь л «Оскар» өгснөөс биш, дуу дуулж шагнуулаагүйг гэнэт нэхэн саналаа. Ингэж нас бие гүйцсэн хойноо хоолойгоо эвдэж, тэгээд энэ тухай сонин хэвлэлийнхэн орчин тойрны хүмүүс нууж дараад дуугүй өнгөрсөн хэрэг үү? Хөшигний цаадах нууцад угийн дуртай Жул Фонтейны дуу хоолойг анхааралтай чагнан яагаад ингэж өөрчлөгдсөнийг мэдэх гэж хичээв. Зүгээр л дэндүү хүчтэй орилсон эсвэл архи, тамхи их хэрэглэсэн, нэг бол зугаа цэнгээнээр хэт хөөцөлдсөн байж ч болох юм. Тун эвгүй хэржигнэн сааралтах ийм хоолойтой хүн яаж ч тайзан дээр гарах билээ дээ гэж бодоод Жул:

- Та чинь хоолойгоо дааруулчихсан юм уу даа? гэж болгоомжтой нь аргагүй асуусанд Фонтейн эелдэг боловсноор хариу үгүүлрүүн:

- Тийм дээрээ тулбал ч эцэж цуцтал нь хэрэглэсэн байх аа. Өчигдөр орой дуулах гээд үзсэн чинь болдоггүй шүү. Насны эрэмбээр хоолой мууддаг нь яах аргагүй үнэн юм даа. Хөгширнө өө гэдэг хорвоогийн жам хойно, яая гэхэв гээд цайлган цагаанаар инээд алдав.

- Эмчид үзүүлсэн үү? Эмчлүүлээд үзвэл эдгэчих юм биш биз дээ?

Фонтейны найрсаг элэгсэг байдал илтэд бууран Жулыг хүйтэн харцаар удаан ширтлээ.

- Хоёр жилийн өмнө үзүүлсэн, үзүүлсэн. Дээд зэргийн мэргэжилтэн нар, бас энэ салбартаа хамгийн сайнд тооцогддог хувийн эмчдээ хүртэл үзүүлсэн чинь хэт ядрахгүйг хичээн олигтойхон амарч бай гэсэн. Насны л юм, аюултай зүйл биш ээ.

Тэрээр цааш эргэж, түрүүн дутуу орхисон яриагаа үргэлжлүүлэхдээ тэгэхээс тэгэх гэж ганцхан Люсид хандан сэтгэлийг нь гижигдэж, өөртөө татахыг хичээнэ. Жул улам хичээн чих тавибаас яах аргагүй багалзуур хоолойд нь хавдар үүссэн шиг санагдав. Яахлаараа, чөтгөр ав гэж, тэр мэргэжилтнүүд нь мэдэлгүй өнгөрөөчхөө вэ? Эсвэл хагалгаа тус болохгүй хорт хавдар юм болов уу? Тийм бол өөр аргаар эмчилдэг сэн дээ.

Тэрээр Фонтейны яриаг тас дайрч:

- Хамгийн сүүлд та хэдийд хоолойгоо үзүүлсэн бэ? гэвэл ингэж асууж шалгаахад дургүй нь хүрсэн Фонтейн дотроо бухимдах авч зөвхөн Люсиг бодоод биеэ барьж буй нь илт.

- Жил хагасын өмнө.

- Хувийн эмч тань үе үе үздэг биз дээ?

- Мэдээж хэрэг. Харин та түүнээс илүү мэддэг гэх гээгүй биз дээ?

- Түүнийг чинь хэн гэдэг юм бэ?

Фонтейн цээж түхийлгэн ханхалзах аястай:

- Таккер эмч Таккер. Та ийм нэр дуулсан уу?

Дэлгэцийн алдарт одод, эрүүл мэндийн тэнгэр хадсан үнэтэй төв зэрэгтэй холбоо бүхий эл нэрийг дуулсан, дуулахаар барахгүй сайн мэддэг Жул:

- Тэгэлгүй яах вэ? Овжин эрхэм дээ хэмээн ёжтой нь аргагүй жумалзахад Фонтейн уур хорслоо нууж чадахаа байлаа.

- Та өөрөө түүнээс дээр гэж боддог юм уу?

Люси хөнжлөөсөө гараа сугалж, Жулийг татаж ойртуулав.

- Харахад дэнгийн эрвээхий шиг хөнгөн хийсвэр ч гэсэн мэргэжилдээ гаршсан дээд зэргийн мэс засалч юм шүү, энэ чинь. Таккер эмчээс өөрийгөө илүү л гэж хэлсэн бол, тийм байж таараа. Үүний үгэнд ор, Жонни минь.

Сувилагчийн шаардсанаар тэд өвчтөнийг орхин гарч хонгилоор явж байхдаа Жул дахиад л Фонтейнд хандан:

- Би энэ эмнэлэгт байн байн ирж зөвлөгөө өгдөг, өөрийн болсон хүн. Одоо таны хоолойг үзвэл яасан юм бэ?

Дотроо санаа зовчхоод яахаа мэдэхгүй явсан Жонни үгийг нь өлгөж авлаа.

- Хэр удах бол?

- Таны төвөнх дотор хавдартай байна. Хэрэв хүсвэл хэдэн цагийн дотор хорт хавдар мөн эсэхийг нь мэдчихэж болно. Хүсэхгүй бол хэрэггүй.

Валенти тэдний ярианд оролцож:

- Үзээд алдья л даа, Жонни, яадаг юм бэ? Би доошоо буугаад студи руу утасдчихья гэснээр асуудал шийдэгдэж, шинжилгээ удаан үргэлжилсэн хэдий ч хорт хавдар биш, зүгээр л үү гарсан нь тогтоогдоод авахуулахаар тохиролцов. Үүний зэрэгцээгээр Жул эмч хар нүдээ хага татсаар л архи ханхлуулсан Нино Валентид хандан иймэрхүү янзаар бол таван жилээс илүү настай гэдгийг нь анхааруулсан чинь мань эр ер тоосон шинжгүй тас тас хөхөрсөөр хоцорчээ.

ХОРИН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Майкл Корлеоне сицили нутагт хөөгдөн таван жил суухдаа л эцгийнхээ хувь тавилан, зан чанарын талаар олон юм мэдэж авчээ. Мөн төрсөн ах нь оногдсон үүрэг рольтойгоо яагаад хүлцэнгүй эвлэрч, Люка Брази юм уу зэрлэг догшин Клеменца шиг хүмүүс хаанаас гардгийн ч учрыг оллоо. Загалмайлсан эцэг ямар учраас хүн болгонд өөрийн гэсэн цорын ганц хувь тавилан заяагдсан байдаг гэж ахин дахин сургамжлах дуртайг ухаарч. хууль ёсны засаглал засгийн газрыг үл хүндэтгэх, ам алдахгүйн тангаргаа зөрчсөн хэнийг ч болон үзэн ядах үзлийн эх үүсвэр юунд байдаг нь ч тодорхой болжээ.

Үнгэгдэж үрчийсэн костюм өмсөж, элэгдэж хуучирсан саравчтай малгай духдуулан Палермод усан онгоцноос буусан Майклыг Сицили арлын гүн рүү авч явав. Бөглүү зэлүүд хөдөө мужийн гол төв энэ нутагт мафи, түүний гар хөл болсон цагдаа-харуул дангаараа ноёрхох бөгөөд толгойлогч нь урьдын цагт онцгой чухал юман дээр аминд нь орсон эрхэм Корлеонед их өртэй, ачийг нь хариулахын тул үхэн зүтгэх ёстой ажээ. Чухам энэ л мужид эцэг нь Америк руу оргон гарахдаа нэрээр нь овоглосон Корлеоне тосгон орших боловч эмэгтэйчүүд нь байгалийн жамаар нас барж, эрчүүд нь цусан өшөөнд өртөн алуулж, эсвэл төрөлх нутгаа орхин дайжсаар Их эцгийн төрөл төрөгсөд гэх хүн нэг ч үлдсэнгүй.

Майклын суулгасан гэрийн эзэн, сайхь цагдаа-харуулын нагац ах, дал гарсан гозгор гонь өвгөн тэр тойрогтоо л цорын ганц эмч нь аж. Цагдаа-харуул Томмазино гэдэг тавин тав орчим насны эр сицилийн хамгийн сурвалжит нэг гэр бүлийн мэдлийн асар удам эдлэн газрыг харж хамгаалах албатай, тэртэй тэргүй атаршиж гүйцсэн газраас өчүүхэн хэсгийг ч гэсэн ядууст ашиглуулахгүй, түүн дээр нууц ан хийлгэхгүй байх үүрэгтэй. Эрхэм Томмазино энэ мужид ус хуваарилан түгээх асуудлыг хариуцахаас гадна хаалт далан барих нь өнө эртнээс уламжлан гүний худгаас ундааны ус наймаалах орлоготой ажлыг үндсээр нь сүйрүүлэх учир Ром дахь засгийн газраас зөвшөөрөлтэй байсан ч гэсэн дэвсгэр нутаг дээрээ далан хаалт барихад аль болохоор саад хийнэ. Ийм хүний өмгөөлөл дор амар тайван санаа зовох юмгүй амьдарч болох хэдий ч Майклын чухам хэн болохыг ямар ч байсан нуухаар шийдсэн тул түүний амьдрах орчин Таза эмчийн эдлэн газрын хашаагаар хязгаарлагдах нь тэр ээ.

Тэнгэр сайхан үдэш Таза эмч, Томмазино, Майкл гурав хар усан үзмийн мододтой ид шидийн аргаар хаяа дэрлэн ургасан юм шиг санагдах гантиг хөшөө ярайсан уужим цэцэрлэгт тухлан сууж буурал эмч мафи, түүний хэрэг явдлын тухай хэдэн эрин үеийн урт түүх хүүрнэхэд Майкл Корлеоне шүлэнгэтэн сонсоно. Заримдаа алаг цэцгийн анхилуун үнэр ханхалсан шөнийн тансаг агаар, хатуухан амтат дарс, үлгэрийн энэ цэцэрлэгийн амар амгалан, үзэсгэлэн гуад сэтгэл уярч бие тавирсан Томмазино ч гэсэн өөрийнхөө ажил хэргээс дурсан ярих нь бий. Өвгөн эмч түүх домгийн илэрхийлэл юм бол эрхэм Томмазино өнөөгийн бодит байдлын биелэл байлаа.

Чухам эртний энэ ховор чамин цэцэрлэгт л эцэг шиг нь хүмүүсийг төрүүлсэн үндэс суурь Майклын өмнө нүүр царайгаа дэлгэж их юм мэдэж авсанд гайхах юун. Анхандаа «мафи» нь «орогнох газар» гэсэн утгатай үг байснаа энэ ард түмэн улс гүрнийг хэдэн зуун жилээр

дарангуйлан захирч байсан төрийн эрх баригчидтай тэмцэх зорилгоор байгуулагдсан нууц байгууллагын нэр болсон байна. Үүн шиг хатуу хэрцгий дарлал доромжлол амссан нутаг түүхэнд байгаагүй гэдэг. Харгислал, эрүү шүүлт ядуу, баяныг үл ялган хар хуй салхи мэт хуйлран нөмөрч, сурвалжит язгууртай газрын эзэд католик сүмийн томоохон лам нар малчид тариачдыг төмөр гараар номхтгон дарж байв. Энэ засаглалын гар хөл, зэвсэг нь болсон цагдаагийн газрыг энгийн ардууд яг л засаг ноёд, эрх баригчидтай адилтган үзэх тул хэн нэгнийг цагдаа гэж муулан дуудахаас илүү аймшигтай доромжлол Сицили нутагт байсангүй.

Дураараа дургих харгис засаглалын өрөвдөх сэтгэлгүй дарлал дор тарчлан зовсон ардууд амьд үлдэх арга хайн сүвэгчлэхдээ гомдон өшсөн юм уу, хорсон хилэгнэснээ хэзээ ч ил гаргахгүй байж сурчээ. Хар уурандаа занаж сүрдүүлбэл түүнийгээ хэрэгжүүлэхээс нь өмнө хариу шийтгэл амсах учир тийм үг хэлж болохгүй. Нийгэм чиний дайсан гэдгийг хэзээ ч үл умартан, хэрвээ шударга бус явдлын хариу хонзонгоо авах гэвэл нууцаар босогчид мафид л очих хэрэгтэй. Энэ мафи өдрөөс өдөрт бэхжин хүчирхэгжээд нийтээр бие биенээ хаацайлан даах хууль, нууц хадгалах тангараг буюу омерита гэгчийг Сицилид анх гаргажээ. Хөдөө нутагт явгаар буюу унаагаар зорчсон хэн боловч ойрын хот орох зам асуугаад хариу сонсоно гэж санасны гарз. Тухайлбал, хэнд буудуулснаа цагдаад хэлнээ гэдэг бол мафийн гишүүний хувьд хамгийн нүгэлтэй гэмт хэрэг байв Энэ нууц хадгалах омерита гэгч нь яваандаа хүмүүсийн сүсэглэн бишрэх шүтээн нь болж, эмэгтэйчүүдээс хэн нь ч эр нөхрийг нь алсан, хүүхдийг нь эрэмдэг болгосон, охиныг нь хүчиндсэн хүний нэрийг цагдаад хэлнэ гэдэг ёстой үгүй. Засаг төрийн эрх баригчдаас шударга үнэнийг хүсэн хүлээх нь бухын доодохыг харж үнэг турж үхдэгтэй адил гэдгийг хүн зон андахгүй мэдэх болсон байна.

Өнөөгийн өдрийг ч хүртэл мафи энэ үүргээ тодорхой хэмжээгээр гүйцэтгэж, юм л болбол хүмүүс орон нутгийн цагдаа-харуул руу гүйлдэнэ. Тэрээр тойргийн оршин суугчдын хувьд нэг ёсны тэргүүн дарга, тэднийг ажилд оруулж, өлсөхөд нь талх хоол залгуулдаг ивээн тэтгэгч өмгөөлөгч нь болжээ.

Гэвч он жил улиран өнгөрсөөр эцсийн эцэст Сицилийн мафи нь баячууд хөрөнгөтнүүдийн дарангуйллын зэвсэг, дуулгавартай гар хөл, тодорхой утгаараа улс төрийн тогтолцооны түшиг тулгуур нь болж хувирсныг Таза эмч цухуйлгасан ч үгүй, харин Майкл өөрөө хожим олж мэджээ

Эцэг шиг нь зан төрхийн хүмүүс хууль ёсыг дагаж хүлцэнгүй номхон явахын оронд яахлаар хулгайч дээрэмчин, алан хядагчид болдгийг ч Майкл Корлеоне ойлгож авчээ. Айж эмээх, эрх мэдэлгүй дарлуулах, үгүйрэн ядуурах явдал газар авч хууль ёсны засаглалын хүний үнэргүй, хуурамч хуудуу үйлдэл хөдөлбөргүй мэт санагдан олон хүн Америкт дүрвэж гарсан хойноо ч гэсэн энэ үзэл бодлоосоо салж хагацдаггүй аж.

Нью-Йоркоос санд мэнд зугтаасан болохоор Майкл хугархай эрүүгээ сайн эмчлүүлж чадсангүй, одоо хүртэл зүүн шанаандаа ахмад Маккლოსкигийн үлдээсэн ул мөрийг тээсэн хэвээрээ л яваа. Яс нь л буруу бороолсноос болоод ялангуяа нүүрнийх нь зүүн хагас дээрэмчнийхэрхүү харгис хэрцгий шинжтэй харагдана. Таза эмч засч янзлаад өгье гэсэн боловч Майкл энд байх хугацаандаа түүнээс дор эмч Сицили даяар эрээд ч олохгүй гэдэгт эргэлзэхгүй болсон тул эрс татгалзжээ. Сицилийн мафийн хамгийн хүчирхэг нөлөө бүхий толгойлогчдын нэг нь тухайн үедээ тусалсны ачаар л тэрээр шалгалт өгч, эмчийн диплом

өвөртөлсөн аж. Чадах чадахгүй нь хамаа алга, авьяас, хичээл зүтгэлийг үл хэрэгсэн мафийн толгойлогч их эцэг дуртай хүндээ мэргэжлийн диплом ийнхүү бэлэглэдэг байлаа.

Өдрийн цагт Майкл эрхэм Томмазинод хүчин зүтгэдэг хоёр малчнаар хамгаалуулан хавь орчноороо элдвийг эргэцүүлэн зугаалж яваад дараа нь мах ихтэй, этүүртэй сайхан шөл цадталаа идэж, нэг шил хатуухан дарсаар даруулсны хойт дээр зүүн эрүү нь тэсэхийн аргагүй янгинан өвдөх хэдий ч унтах зүүрмэглэхийн хооронд хэдэн цаг болдог байв. Таза эмч нүүрээ мурийлгачихаад ингэж тарчилж явснаас мэс засал хийлгэсэн нь дээр гэх ухааны юм яриад ер салахаа байж, бас өвчин нь улам ихсэж тэрээр байн байн Таза эмчээс эм гуйх болсон хэдий -ч эмчлүүлэхээс татгалзсан хэвээрээ л... Эцсийн эцэст эмчийн тэвчээр алдарч яагаад дургүйцээд байгааг нь асуусанд тэрээр хөмсөг зангидан гашуунаар инээвхийлж:

- Ямар ч гэсэн төрсөн гэртээ байсны минь дурсгал юм даа гэжээ.

Хөдөө нутгийн энэ амар тайван жаргалтай амьдрал нь зургаа, долоон сар үргэлжилж байтал эрхэм Томмазино нэг л зүйлд санаа зовсон байртай, хаашаа ч юм өдий төдий хоногоор алга болж, гэртээ бараг үзэгдэхээ болив. Палермод «шинэ мафи» гэгч юм гарч дайны дараах барилга байгуулалтын нүргээнт дүйвээнээр бөөн мөнгө олдог болоод цаг үеэсээ хоцорч гундсан хөдөөгийн сайн эрчүүдийг улам бүр шахан түрж эхэлсэн тул эрхэм Томмазино эзэмшил нутгаа хамгаалах ажлаар хөөцөлдөөд амсхийх завгүй явжээ.

Нартай цэлмэг нэгэн өглөө Майкл мөн л өнөөх хоёр бие хамгаалагчаа дагуулан нуга талаар зугаалж явлаа. Тэдний нэг Кало гэдэг дуу цөөнтэй, индиан хүн шиг хэнэггүй дүнсгэр царайтай эр яг л жинхэнэ сицили хүн лүгээ адил тагдгар, шөрмөслөг биетэй. Нөгөө арай залуувтар хөгжилтэй эр нь усан цэрэгт алба хааж англичууд онгоцыг нь живүүлж өөрөө олзлогдохоосоо өмнө цээжээ шивүүлж амжжээ. Фабрицио цээжнийхээ энэ шивээсээрээ нэг их гайхуулдаггүй боловч нөхөр нь өөр хүнд тэврүүлсэн эхнэрээ хутгалж буй эл зургийг хааяа харахдаа Сицили эр хүний нэр төрөө хамгаалах нандин чанар ийм л байх ёстой гэж боддог байв,

Тэр гурав тод хурц өнгийн будагтай тэрэг чирсэн илжигнүүдийг гүйцэж түрүүлэн хөдөөний тоостой замаар алхаж явлаа. Эргэн тойрны юм бүгд, амттай жүржийн цэцэрлэг чидун жимсний болон бүйлсийн модон шугуй тэр чигтээ алаг цэцэгт умбажээ. Майкл сициличүүдийн үгээгүй ядуурлын тухай сонсохоороо л нэг болсон тул ийм тансаг сайхан газар биш эзгүй элсэн цөл л байгаа хэмээн бодож явсан аж. Ийм сайхан диваажингийн орноо орхиж явнаа гэдэг үнэхээр л арга нь тасарсан хэрэг байх даа..

Тэрээр орой тийшээгээ тэнгисийн эргийн Мадзар тосгон хүрч, тэндээсээ автобусаар Корлеонед буцаж ирэхээр тооцож, хоёр малчин эр замын хүнс талх, бяслаг базааж гарсан боловч тэд тэр өдөртөө тэнгис хүрч чадсангүй, арван тав зургаан бээр яваад амтат жүржийн төглийн сүүдэрт амсхийхээр суув. Фабрицио хэзээ нэгэн цагт Америк руу яаж гарах тухайгаа ам хамхилгүй чалчих зуур идэх юм, лонх дарсаа гарган, тэд цадтал хооллож аваад сэрүүцэн хэвтэцгээлээ. Фабрицио цамцныхаа товчийг тайлж, цээжнийхээ булчинг хөдөлгөн шивээс зургаа амилуулан тоглоод түүнийг нь Майкл сонирхон харж суутал Сицили нутагт ярьж заншсанаар аянганд ниргүүлэх шиг болжээ.

Амтаг жүржийн цэцэрлэгийн цаана үзэгдэх жижигхэн хээнцэр харшаас гэнэт тосгоны бүсгүйчүүд сүргээрээ шуугилдан гарч гүйлдлээ. Өнө эртний уламжилж ирсэн ёсоор нутгийн ноёндoo тэд алба гүйцэтгэн гэр оронг нь цэвэрлээд одоо тасалгаанд тавих цэцэг түүхээр гарцгаасан нь энэ бололтой. Модны сүүдэрт хэвтсэн харцуулыг харалгүй тэр охид улам наашлан дөхөн, хоёр нь найз бүсгүйгээ хөөж хөхрөлдөн гүйлдсээр хариугүй ойртов.

Тэрээр төглийн захад ирж эрчүүдийн цоохор цамцыг гэнэт харснаа зогтусч огло үсрэн бултах гэж байгаа согоо шиг сээтгэнэн зогсоход цэвэрхэн царайндаа зохисон ягаавтар туяатай том бор нүд, өтгөн хөмсөг, урт сормуус, цайвар гөлгөр арьсыг нь ойроос харж цочирдсон Фабрицио:

- Бурхан тэнгэр минь өршөөж хайрла, би хариугүй муужирч унах нь хэмээн амандаа бувгналаа.

Түүний дууг сонссон даруйдаа сайхь бүсгүй өлмий дээрээ эргэн найз охид руугаа тэнхээ мэдэн харайлгаж хүрмэгц төглийн зүг хуруугаараа зааж нэг юм хэлснээ тас тас хөхрөлдөн гүйж одоцгоов.

Майкл Корлеоне гэнэт сэхээ орохдоо босоод зогсчихсон бага зэрэг гуйвж, зүрх нь галзуутай дэлсэж байгаа гэдэг жигтэйхэн. Амтаг жүрж, усан үзэмний эхүүн үнэр цэцэгсийн анхилуун үнэртэй холилдон толгой эргэх шиг болохын хажуугаар хоньчин эрс инээлдэж эгдүүг нь хүргэх ажээ.

- Яав аянганд ниргүүлчихэв үү? гээд Фабрицио дал мөр рүү нь алгадан, хэр баргийн юм тоодоггүй гол төлөв дүнсийж явдаг Кало хүртэл тохойноос нь атган Майклыг яг л машинд дайруулчихсан юм шиг санаа зовж:

- Зүгээр залуу минь, зүгээр хэмээн тайтгаруулсанд Майкл гэнэт дүрсхийв.

- Хонь ямааны хань ижил, хар чөтгөрүүд минь, юу донгосоод байна аа?

Дотоод сэтгэл, бодол санаа нь ийнхүү нүүрэн дээр нь бичээстэй байдагт Майкл сүрхий эвгүйрхэн гайхлаа. Гэвч амьдралдаа анх удаа л ингэж сэтгэл нь хямран донсолжээ. Төрсөн гэрээсээ дайжин алсад суухдаа тэрээр Кейгээ дурсан уйтгарлаж байснаа энэ мөчөөс эхлэн түүний тухай бодлоо таягдан хаялаа.

Фабрицио Майклын бодлыг таасан янзтай, ажил хэрэгч царай гарган шилээ маажиж:

- Тосгон орж юун хүүхэн юм, мэдмээр байна гэсэнд дүнсгэр найз нь дув дуугүй толгой дохив. Майкл ч гэсэн үг дуугарсангүй, тэднийг даган замаар орж тосгон руу алхлаа.

Тосгоны төв талбай дээр заавал байдаг усан оргилуурын харалдаа орших бяцхан гуанзны сэрүүн тавцан дээр гурван ширээ чихцэлдүүлэн тавьжээ. Малчин залуус нэг ширээний ард, Майкл нөгөө ширээний ард очиж суув. Эргэн тойрон эл хуль, ганц илжиг дэмий сэлгүүцэн хэдэн хүүхэд тоос шороо бужигнуулан тоглоно.

Гуанзны эзэн богинохон хөлтэй тагдгар эр гарч ирээд дуу алдан мэндэлж, түрэг вандуйтай таваг, өөрийн хийсэн хүрэн улаан шарз шиг хатуу дарстай домбо авчирч тавихад Фабрицио эхэлж ам нээлээ.

- Та эндхийн хүн болгоныг мэддэг байлгүй дээ. Сая замд маань танай тосгоны нэг хөөрхөн бүсгүй тааралдаад манай найз аянганд ниргүүлчихсэн юм шиг болчихлоо.

Гуанзны эзэн Майкл тийш өрөвдөнгүй сонирхсон харц чулуудахад мань эр тодруулж:

- Буржгар үстэй цайвар царайтай, маш том нүдтэй бүсгүй, та танихгүй биз? гэхэд гуанзны эзэн огцом дуугаар

- Би юу ч мэдэхгүй. Тийм хүн байхгүй гэхээд гэртээ орчхов.

Мань гурав дарсаа яаралгүйхэн шимж домботойгоо ёроолдоод дахиад авчраач гэж хашгирсан боловч хариу алга, таг чиг. Фабрицио гуанзны эзэнтэй уулзахаар дотогшоо орсноо тэрхэн дороо толгой сэгсэрсээр гарч ирлээ.

- Би бүр мэдээд байсан юм аа, тэр чинь гуанзны эзний охин нь байна. Уурандаа дэлбэрчих шахсан юм сууна. Юмыг яаж мэдэх вэ, Корлеоне руугаа буцсан нь дээр байх аа. Хүч чадлаар бурхан гомдоогоогүй хоёр сайхан хүүтэй, исгэрэхийн төдийд л давхиад ирнэ гэж хөгшин төгцөг анхааруулсан шүү. Явна байгаа, андууд минь.

- Майкл түүнийг эвгүйрхсэн хүйтэн харцаар цоо ширтэв. Хөдөөгийн хоёр залуу гэнэн цагаан сэтгэлийн угаас Майклыг Сицилид орогнох болсныг бодоход эр хүний хугархай хэдий ч хорхойд гэмгүй, ноомой залуу гэж саяхан хүртэл бодож явсан нь том эндүүрэл болжээ. Хад чулуу шиг хахир, хувхайж цайсан царайнаас нь хүйт дааж, хорсолтой ширүүн харцан дор нь хоёр залуугийн инээмсэглэл арчигдан ариллаа.

- Тэр хүнийг аваад ир хэмээн Майклыг үгээ зөөн зуунги үгүүлэхэд хоёр залуу нүд ирмэхийн зуур тайрмал буугаа мөрлөн байшинд орж хагас минутын дараа л гуанзны эзэнг дагуулж ирэв. Загзгар сицили эр ер айсан шинжгүй, зөвхөн дайсагнасан хүйтэн харцанд нь сэрэмжилж болгоомжилсон байдал илэрчээ.

Майкл сандлын түшлэг налан гэдийж хэдэн хором түүнийг дув дуугүй сонжин ширтэж байснаа тайван, намуухан үгүүлрүүн:

- Миний л ойлгосноор бол, би охины чинь тухай асууж таныг гомдоосон шиг байна. Намайг уучилж үзээрэй. Би энд ирээд удаагүй, зан заншлыг сайн мэдэхгүй дээ ингэлээ. Би таныг ч, охиныг чинь ч гомдоохыг хүсээгүй гэдгээ л хэлье.

Аль нэг тосгоны санаандгүй ирсэн жирийн хүн биш байна гэдгийг гуанзны эзэн хэдийн ойлгосон тул улам сэрэмжтэй, сонор соргог болж:

- Та хаанаас яваа юун хүн, миний охиноор яах гэсэн юм бэ? гэхэд Майкл өчүүхэн төдий ч эргэлзсэнгүй хариу үгүүлрүүн:

- Намайг Майкл гэдэг, америк хүн, энд цагдаа нараасаа нуугдаж байна. Сайн хөлс төлдөг болохоор та алтан хошуу хүргэсэн ч болно. Гэхдээ энэ тохиолдолд охин чинь эр нөхрөө олох байснаа алдаж эцгээсээ хагацах л байх даа. Ямар ч л гэсэн би таны зөвшөөрлөөр, гэр бүлийнхний чинь дэргэд түүнтэй уулзаж танилцахыг хүснэ. Би шударга журмын хүн, таны охиныг бузарлаж гутаах бодол ч байхгүй. Хэрэв уулзаж ярилцаад бие биедээ таалагдвал бид гэрлэнэ. Үгүй бол та намайг дахин олж харахгүй.

Гуанзны эзэн мань эрийн нүүрний гүн шархнаас эхлээд энэ нутагт ховорхон үзэгдэх урт хөл хүртэл анхааралтай ажигласнаа тайрмал буугаа зориуд харуулах мэт ил мөрлөсөн хоёр малчин залууг нүдний үзүүрээр харж, энэ харь залуутай харгалдан маргалдах хэрэггүй гэдгийг зөн билгээрээ ойлгоод: .

- Ням гаригт үдэш тийшээгээ ирээрэй. Миний нэр Вителли, тосгоны цаадах толгой дээр амьдардаг, гэхдээ та энд ирээрэй. Дараа нь надтай хамт манайх руу өгсөнө биз дээ хэмээн дуртай дургүй гөвгнөв.

Майкл тэнгисийн эрэг хүртэл зугаалах ямар ч сонирхолгүй болж тэндхийн гараашаас нэг машин олж даруй гэрийн зүг жолоо эргүүллээ. Тэр оройдоо Майкл цэцэрлэгт сууж байхдаа эрхэм Томмаинод хандан:

- Энэ бүтэн сайн өдөр намайг биш, хонь малаа хариул гэж хоёр залуудаа хэлээрэй. Би нэг бүсгүйнд зочилно, тэр хоёр тийшээ салгалаад хэрэггүй биз гэсэнд тэрээр толгой сэгсрэв.

- Би эцгийн чинь өмнө чамайг хариуцаж байгаа тул ингэж гуйсны гарз. Тэр ч байтугай чи гэрлэх барих юм цухуйлгасан гэлцэнэ. Би эрхэм Корлеонетой уулзаж энэ тухай ярилцахаас хэн нэгнийг явуулж, хариу авах хүртэл яасан ч зөвшөөрч чадахгүй.

Сайн ч, муу ч өмнө нь нэр хүндтэй хүн сууж байгаа болохоор Майкл үг болгоноо няхуур сонгон үгүүлрүүн:

- Эрхэм Томмаино. Та миний эцгийг сайн мэднэ. Хэн нэгэн түүнд «үгүй» хэмээн эсэргүүцэх юм бол «за» гэж зөвшөөртөл нь нүдэн балай, чихэн дүлий явдаг хүн. Би ч гэсэн олон удаа «үгүй» гэж хэлж үзсэн. Харуул хамгаалалт ч одоо яая гэхэв, та нарт тайван байгаа бол тааллаараа болцгоо. Харин би эхнэр авъя л гэвэл авч л таараа. Төрсөн эцэгтээ хүртэл хувийн амьдралд минь хөндлөнгөөс оролцохыг зөвшөөрдөггүй юм чинь танд би яаж зөвшөөрөх вэ? Эцгээ хүндэтгээгүй, хүн гэж тоогоогүй болно биз дээ?

Цагдаа-харуул зөвхөн шүүрс алдав.

- За яахав дураараа л бол. Гэхдээ би цэгт чинь энэ тухай дуулгах ёстой. Энэ миний үүрэг.

Ням гаригаас өмнө Майкл автобусаар Палермо орж бэлэг сэлт бэлдсэнээс гадна тэр бүсгүйг Аполлония гэдгийг мэдээд шөнө болгон энэ чихэнд чимэгтэй нэрийг амандаа үглэн, нүдэнд дулаахан хөөрхөн царайг нь зүрх сэтгэлдээ дүрслэн бодсоор унтдаг болжээ. Түүнд хуучивгар боловч хурд сайтай «альфаромео» олж өгөөд, Майкл Сицили даяар сүм дуганы хонх дүнгэнэсэн бүтэн сайн өдөр тосгоны талбайд ирж, гуанзны өмнө зогслоо. Арын суудалд

налайсан Кало, Фабрицио хоёрыг сэрүүн тавцан дээр хүлээж байхыг тушаасан бөгөөд тэнд загзгар Вителли хэдийнээ хүлээж байснаа хоньчин залуустай энэ удаад гар барьж мэндлэв.

Майкл машиныхаа суудал дээрээс бэлэг сэлт бүхий гурван боодлоо авч, гуанзны эзнийг даган толгой өгсөн тосгоны жирийн байшингаас хавьгүй уужим байшинд орлоо.

Нөхөр шигээ чийрэг намхан биетэй эрс шийдэмгий хөдөлгөөнтэй гэрийн эзэгтэй амралтын өдрийн хар өмсгөлөө өмсөж тэднийг босгон дээрээ угтаж өрөөн дотор бас л мөргөлийн хар хувцастай, хөвгүүд нь бололтой хоёр мангар залуу хүлээн, харин охин нь хаана ч үзэгдсэнгүй.

Майкл авчирсан хоёр боодлоо задалж, ноён Вителлид тамхины алтан сав хатагтай Вителлид хоршоонд л худалдаж байсан хамгийн сайн даавуунаас нэг толгойг бэлэглэв. Гурав дахь боодлыг хүүхэнд авчирсан ажээ. Гэрийн эзэд Майклд даруу төлөв байдлаар талархал илэрхийлж эрхэм Вителли хүн эр хүнтэйгээ ярьж буй мэт эрэмгий бүдүүлэгдүү дуугаар хэлсэн нь:

- Биднийг анх тааралдсан хэнийг ч хамаагүй гэртээ урьдаг хүмүүс гэж та бүү бодоорой. Эрхэм Томмазино өөрийн биеэр таныг батлан даасан, манай мужид энэ сайн санаатай хүний үгэнд бүгд итгэдэг юм шүү. Гэхдээ л та манай охинтой суухаар үнэхээр шийдсэн бол бид таны тухай арай илүү юм олж мэдмээр байна.

Майкл эелдгээр толгой дохиж:

- Юу л хүссэнээ дуртай цагтаа мэдээд авч болно гэх тэр торгон мөчид өрөөнд гэнэт алаг цэцэгс, амтат жүржийн анхилуун үнэр ханхалж, хүүхэн ороод ирснийг тэрээр бие сэтгэлээрээ мэдэрчээ.

Майкл эргэн харвал бүсгүй хамар өрөөний босгон дээр зогсох агаад хөх туяатай тас хар үс, мөн тийм өнгийн хувцасны аль алинд нь цэцэг байсангүй. Хүүхэн хэдхэн хором Майклыг харснаа үл мэдэг инээмсэглэн харцаа буулгаад эхийнхээ дэргэд очиж суув.

Дахиад л Майклын дотор давчдан амьсгаа нь давхцаж, зүрх нь галзуурсан мэт цохилоод одоогоор хүүхэнд гар хүрч, эндээс авч явах гэсэн хэнийг ч гэсэн өөрийн гараар багалзуурдаж алахад бэлэн болчихсон байв. Бүсгүй ах руугаа харж инээмсэглэсэнд Майкл тэр залуу тийш үзэн ядсан харамч харц чулуудсанаа өөрөө ч мэдсэнгүй. Тэрээр хайрт бүсгүйнхээ дур булаам хөөрхөн царайг харах тусам сэтгэл догдлох хэдий ч нэрээр нь дуудаж хараахан зүрхэлсэнгүй.

- Саявгархан би таныг төглийн захад харсан. Гэвч та тэр дороо гүйгээд явчихсан. Би таныг тэгж их айлгасан гэж үү?

Хүүхэн эгшин зуур харц өргөж, толгой сэгсрэхэд эх нь доогтой янзаар түүнийг тохойлдон ёвров.

- Аполлония ядахдаа ямар нэг юм хэлээч? Энэ хөөрхий залуу чамтай уулзах гэсэндээ л хаа байсан хол газраас ирлээ шүү дээ.

Майкл боодолтой юмаа хүүхэнд сарвайсанд тэрээр аваад өвдөг дээрээ тавьчихлаа.

- Охин минь задлаач гэж эцэг нь хэлсэн хэдий ч бүсгүй хөдөлсөнгүй.

Эх нь тонгойж, алтлаг цаас задлан дэлгэхдээ ягаан хилэн бүрээстэй хайрцгийг яаж онгойлгохоо мэдэхгүй баахан эргүүлж тойруулж байснаа санаандгүй пүршийг нь дарчихлаа.

Хайрцаг дотор нилээд жинтэй алтан гинж байсан боловч Аполлония энэ үнэтэй бэлгэнд гар хүрсэнгүй учир бас л эх нь гинжийг авч хоёр үзүүрээс нь чимхээд хүүхний хүзүүнд барихад тэрээр дахиад л согооных шиг борхон нүднийхээ буурьтай харцыг Майкл руу өргөв.

- Баярлалаа.

Ингэж л Майкл түүний дууг анх сонсжээ.

Удалгүй мань эр өндийсөнд бусад нь ч дагалдан босч, ёсорхуу байдлаар салах ёс гүйцэтгэсний дараа охины эцэг түүнийг машинд хүргэж өгөөд дараагийн ням гаригт үдийн хоолонд урилаа. Майкл хүүхний барааг харалгүйгээр бүтэн долоо хонож чадахгүйгээ урьдаас сайн мэдэж байсан хэдий ч талархал илэрхийлэв.

Маргааш нь тэрээр бие хамгаалагч нараа орхиод дахиад л ганцаараа тосгонд ирж гуанзны гадаа сэрүүн тавцан дээр сууж, эзэнтэй нь удтал ярилцсанд цаадах нь Майклыг өрөвдөхдөө гэр рүүгээ хүүхэд гүйлгэн эхнэр охин хоёроо хүрээд ир гэж хэлүүллээ. Энэ болзоо түрүүчийнх шигээ тийм хүйтэн хөндий болсонгүй Аполлония ч цэрвэж бишүүрхэх нь багасаж зан ааш нь зөөлөрсөн байв.

Маргааш нь энэ байдал дахин давтагдаж, харин энэ удаад хүүхэн түүний бэлэглэсэн алтан гинжийг хүзүүндээ зүүсэн харагдсанд урам хайрлаж байгаагийн шинж гэдгийг ойлгоод тааламжтай инээмсэглэв. Тэрээр хүүхнийг, толгой өөд, гэрт нь хүргэж өгөхөд эх нь алхам ч хоцрохгүй өсгий даран дагажээ. Нэгэн эгц өгсүүр газар Аполлония хөл халтирч, Майкл түшиж аваагүй бол газар унах байлаа. Гэвч уулын янгир шиг охиноо хөлд орсон цагаасаа хойш энэ налуу дээр ганц ч удаа халтирч байгаагүйг андахгүй мэдэх эх хөөрхий залууд хурим хүртлээ үүнээс өөрөөр охины биед хүрэх арга нээрээ ч алга юм даа гэж бодоод ард нь жумалзаж явааг сайхь эр яахан мэдэх билээ?!

Иймэрхүү байдлаар хоёр долоо хоног өнгөрлөө. Майкл үйл явдлыг яаравчилж, анхнаасаа хүүхэнд таалагдсанаас гадна баян чинээлэг гэдгээ мадаггүй ойлгуулсан тул хагас сар болоод л нэг бүтэн сайн өдөр хуримаа хийжээ. Тосгоны уламжлал ёсоор сүмээс сүйт бүсгүйн гэр рүү явган яваа залуу хосыг тосгоны оршин суугчид амьд цэцгээр булж, тэд хариуд нь чихэрлэсэн бүйлс атга атгаар цацаж явлаа. Хурим найр шөнө дунд хүртэл үргэлжилсэн боловч амраг хоёр түүний өндөрлөхийг хүлээж тэссэнгүй «альфа-ромео»-доо суугаад Корлеоне тосгоноос холгүйхэн орших Таза эмчийн харш руу арилж өгөв.

Тэр шөнө, түүнээс хойших хэдэн долоо хоногт л Майкл Корлеоне чухам яагаад хуучны ёс уламжлалаа эрхэмлэн дээдэлдэг энгийн ард олон охин насны ариун нандиныг тэгтлээ их үнэлдгийн учрыг сая олж билээ л. Энэ хугацаанд хоёр сэтгэлийн гал дөл, итгэл хүндэтгэл,

онгон биеийн нойрмоогоос сэрсэн хайр дурлалын хөлгүй далайд умбаж залуу хос маань амьдын жаргалаа дүүрэн эдэлжээ.

Аполлониог ирснээс хойш харш дахь эршүүд дүнсгэр амьдрал хөгжөөнтэй, дуу шуутай болж, эрхэм Томмазино өдөр бүр үдийн зоогт ирэхээс гадна Таза эмч цусан улаан цэцгээр чимсэн хөшөө баримлууд энд тэндгүй цайвартах цэцэрлэгт аяга дарстай нөхөрлөн суугаад улиг болсон домог яриандаа шинэ өнгө аяс оруулан хөөрөн хүүрнэх болов. Үдшээ ингэж өнгөрөөгөөд шөнө нь болохоор Аполлония эр нөхрөөсөө дутуугүй янаглаж, сульдан тамирдсан тэр хоёрыг үхсэн мэт нам унтахын цагт үүр тэмдэгрэн гийдэг байлаа. Майкл заримдаа хөшиг яран, цонхны тавцан сандайлаад авааль гэргийнхээ нүцгэн биеийн тэнгэрлэг сайхан, амгалан нойрсох хөөрхөн царайны үзэсгэлэн гуаг гагцхүү италийн нэрт зураачдын зүрхлэн дүрсэлсэн эх дагинастай зүйрлэн бодож нүд баясгаж сэтгэл тэнийнэ.

Хуримын дараах долоо хоногт тэр хоёр байсхийгээд л идэш ууш зэхэн тэрхэн хавиараа явган зугаалах юм уу, хаа нэг тийшээ «альфа-ромео»-гоор аялдаг байв. Гэтэл нэг өдөр эрхэм Томмазино Майклыг зайдуухан дагуулж аваачаад энэ гэрлэлтээс болоод ойролцоо нутгийн хүн бүр түүний хэн болох, хаанаас ирснийг андахаа байсан тул эл далд бөглүү газар ч хүрэхүйц урт гар савартай Корлеонегийн омгийн дайснуудаас сэрэмжлэх арга хэмжээ авах хэрэгтэйг мэдэгджээ. Ингээд харшийн эргэн тойронд зэвсэглэсэн харуул гаргаж, Кало, Фабрициогийн хамт байшин, цэцэрлэгийг өдөржин шөнөжин харж манах болсноос хойш Майкл, Аполлония хоёр хаашаа ч гарсангүй. Тэрээр цаг нөхцөөхийн эрхээр эхнэртээ англиар бичиж унших, хашаан дотроо машин жолоодохыг зааж өдөр өнгөрөөнө.

Нэг өглөө Майклыг босоход эрхэм Томмазиног Палермо руу яаралтай дуудсан байсан бөгөөд тэрээр орой буцаж ирээд Майклтай аминчлан уулзав. Сантино Корлеоне амь үрэгдсэн тухай эмгэнэлт мэдээ Америкаас ирсэн юмсанжээ...

Сицили нутгийн өглөөний эртэч нар нимбэгэн шар туяагаараа өрөө дүүрэн гийгүүлэх үеэр Майкл эмэгтэй хүний торгомсог зөөлөн арьс халуун мөрөнд нь шүргэхийг мэдэрсээр сэргэж, Аполлониягийн дээрээс тонгойн үнсэж таалсаар байгаад арай гэж сэрээлээ. Эхнэр нь босч, нүцгэн хөлөөрөө шал алгдан халуун усны өрөөнд орохыг чагнан тэрээр тааваараа хэд суниаснаа тамхиа авч асаав. Эрхэм Томмазино түүнийг Сицилийн өмнөд эргийн нэгэн хотхонд нүүлгэн суулгах болсон тул өнөө өглөө Майкл эл байшинд сүүлийн удаа нар угтаж буй нь энэ. Жирэмслээд сар ч болоогүй Аполлония эхлээд, хоёр гурван долоо хоног эцэг, эхийндээ байж, дараа нь түүний шинэ оромжид очихоор тохирчээ.

Урьд орой нь, Аполлонияг унтахаар явсан хойно эрхэм Томмазино Майклтай цэцэрлэгт удаан суухдаа нэг л юманд сэтгэл түгшиж их ч ядарснаа нууж чадсангүй, Майклын амь насны төлөө санаа зовоод байгаагаа хүлээн зөвшөөрчээ.

- Хурим найрнаасаа болоод чи олны нүдэнд өртжээ. Чамд өөр орогнох байр олох талаар эцэг чинь одоо хүртэл бодоогүй нь гайхалтай.

Тэрээр яаралтай ажлаар өглөө эрт Палермо орох тул үдэж өгч чадахгүй, харин Фабрицио, Кало хоёр машинаар Майклыг хамгаалан хүргэж өгнө гэдгийг нэмж, бас Таза эмчид нүүх тухайгаа дуулгах хэрэггүй, нүглийн үүр тэр хөгшин чөтгөр өнөөдөр Палермо орж зугаа

цэнгэл хөөцөлдөхдөө аягүй бол ам алдчихна хэмээн сануулжээ. Эрхэм Томмазино сүүлийн үед буу зэвсгээсээ салахаа байж, бие хамгаалагч үгүйгээр хаашаа ч гарахаа больсон тул Майкл түүнд ямар нэгэн гай нүүрлээд байгааг өөрөө ч мэдэж байв.

Өглөөний нар хэдийн хөөрч хайр найргүй шарж эхэллээ. Майкл тамхиа унтраагаад ажлын хувцсаа өсөн, Сицилид ихэнх эрчүүдийн өмсөх дуртай саравчтай малгай духдуулсхийж очиж цонхоор шагайваас гадаа тавьсан сандал дээр Фабрицио налайж, өтгөн хар үсээ залхуутай нь аргагүй самнахчаа болж сууна. Майкл шүгэлдэж, түүнийг толгойгоо өндийлгөхөөр:

- Машинаа гарга. Таван минутын дараа хөдөлнө. Кало хаана байгаа вэ? гэсэнд цаадах нь ч бослоо.

- Галын өрөөнд кофе ууж байгаа. Гэргий чинь бас бидэнтэй явах уу?

Саянаас эхлэн энэ Фабрицио Аполлония руу хэтэрхий шүлэнгэтэн хараад байх болж дээ. Их эцгийнхээ найзын эхнэртэй сээтгэнэх гэсэндээ ч биш байх л даа, ямар аминаасаа уйдсан хүн байгаа биш, гэхдээ л...

- Үгүй, миний авгай эцэг эхийндээ хэд хононо хэмээн Майкл хүйтэвтэр хөндий хариу өчөөд «Альфаромео»гийн гарааш болгосон өмөрцөг чулуун пин тийш яаран алхах Фабрициоог харсаар үлдлээ.

Гар нүүрээ угаачхаад Аполлония алга, явахаас нь өмнө хоол хийж өгөх гээ юм болов уу хэмээн бодоод доош буусан чинь галын өрөөнд ч алга. Гайхаж суутал нь Кало орж ирлээ.

- Машин бэлэн. Чемодан буулгах уу?

- Үгүй, би өөрөө. Харин Аполло хаана байна?

Калогийн хэнэггүй царайд инээмсэглэл тодров.

- Машин дотор жолооны ард сууж байгаа. Америк орныг өрөөсөн нүдээрээ ч хараагүй атлаа яг америк хүүхэн шиг зан сурчээ.

Сицили нутгийн тариачин бүсгүй машин жолоодно гэдэг урьд өмнө ер дуулдаагүй тул дүнсгэр дүйнгэ Кало хүртэл гайхах нь аргагүй биз ээ.

- Чи Фабрициоог дууд. Тэгээд намайг машинд хүлээж бай хэмээн Майкл тушаал буулгаад шатаар өгсөж унтлагын өрөөнөөсөө өчигдөр бэлдсэн чемоданаа авахын өмнөхөн цонхоор шагайвал машины нь гаргаад, харин галын өрөөний биш, гол хаалганы шатны дэргэд тавьсан байв. Аполлония машин дотор сууж тоглох дуртай жаахан охин шиг залуур мушгин арын хаалгаар нь Кало замын хүнстэй сагс оруулж тавьж байх аж .Гэтэл Фабрицио гэнэт ямар нэг юм хэрэг болсон янзтай, хаалгаар далд орж харагдсанд Майкл урьд нь юугаа бодож явсан моньд вэ хэмээн зэвүүрхэх зуур сайхь эр хулгайч шиг мөрөн дээгүүрээ сэмхэн харц чулуудлаа. Энэ хоньчин залууг сайн хашраахгүй бол болохгүй нь ээ!

Тэрээр чемоданаа барьсаар галын өрөөний шатан дээр гарахад арваад метрийн зайнаас

Аполло түүнд гараараа дохихоор нь би машинаа аваачъя, байж бай гэж байгааг нь ойлголоо. Кало тайрмал буугаа барьсан чигтээ машины дэргэд инээмсэглэн зогсож, харин Фабрицио бараа ч алга хэвээрээ. Яг энэхэн мөчид Майклын уураг тархинаа үл ялих жижиг зүйлүүд нийлэн хэргийн тодорхой дүр зураг тод дурайж бүх юм тохирох нь тэр!

- Боль! Хэрэггүй! хэмээн тэрээр Аполлониягийн зүг тэнхээ мэдэн хашгирсан боловч хүүхэн асаагуурын түлхүүр нэгэнт мушгисан тул дуу нь нүсэр тэсрэлтийн чимээнд дарагдлаа. Галын өрөөний хаалга зомгол болж, долгионы цохилтод Майкл өөрөө тээр тэнд тэрий хадан, дээврээс нурж унасан шавар чулуунаас нэг нь яг толгой дээр нь буув. Тэрээр ухаан алдахынхаа өмнөхөн «Альфа-ромео»-гоос ердөө л дөрвөн дугуй, хойт урд хоёр гол л үлдэж бусад нь юу ч үгүй болсныг харж амжжээ.

Түүнийг нэг ухаан ороход хав харанхуй хэн нэгний бүдэг дуу сонсогдох авч юу ярьж байгааг нь ойлгох аргагүй. Тэрээр зөн билэгтээ хөтлөгдөн, ухаан орсноо мэдэгдэхгүйг хичээсэн боловч хүмүүсийн ярилцах нь намжаад орных нь хажууд суусан нэг хүн түүн рүү тонгойн:

- За ашгүй, нэг юм ухаан оров уу? гэв.

Гэрэл асч нүд гялбуулсанд Майкл цааш эргэхэд толгой нь дүйрч өвдөөд тэсэхийн арга алга. Орон дээр зүүгдэн тонгойсон цайвар зуйван толбо аажимдаа тодрон тодорсоор Таза эмчийн царайтай төстэй болж ирэв.

- Би одоо бушуухан чамайг үзээд гэрлээ унтраая гэж эмч зөөлөн дуугараад Майклын нүд рүү гар чийдэн тусгаж: - За зүгээр зүгээр, бүх юм дажгүй гэснээ эгцрэн гэдийгээд хэн нэгэнд хандав. - Үүнтэй чи ярьж болно оо.

Орны дэргэдэх сандал дээр эрхэм Томмазино сууж байгааг Майкл одоо тод харлаа.

- Майкл, хүүе Майкл аа! Чи намайг сонсож байна уу? Надтай ганц хоёр үг сольж чадах уу?

Хариуд нь гараа өргөх л хамгийн амархан байсан тул Майкл санаснаараа болсонд эрхэм Томмазино:

- Хэн гараашаас машин гаргасан бэ? Фабрицио юу?

Майкл өөрөө ч мэдэлгүй мөс шиг хүйтэн инээмсэглэж батлан хариуллаа.

- Майкл аа, аан гэж бай. Фабрицио алга болчихсон. Чи бүтэн долоо хоног ухаангүй хэвтсэн, ойлгож байна уу? Бүгд л чамайг алуулсанд тооцож хэн ч мөрдөн мөшгөхөө больсон, одоо аюул өнгөрсөн. Би энэ тухай эцэгт чинь мэдэгдээд зохих заавар авсан. Чи удахгүй Америктаа буцна, тэр хүртлээ уулын зэлүүд хавцалд байдаг миний байшинд амар тайван хоргодох болно. Чамайг амь эрсэдсэн гэсэн цуу гарсан даруйд л Палермо дахь миний өштөн дайснууд эвлэрэх санал гаргасан болохоор бүр эхнээсээ л тэдэнд би биш, чи хэрэгтэй байж. Тэд зөвхөн өнгөн дээрээ намайг нууцаар хорлох дүр эсгэж нүд хуураад, тэр хооронд чамайг хөнөөх ажлаа бэлтгэсэн байна. Чи үүнийг хатуу санаж яв. Харин бусад талаар надад найдаад сэтгэл зоволгүй, зөвхөн эдгэрэхээ л бод.

Майкл одоо л бүх юмыг, эхнэр нь амь эрсдэж, Кало ч алуулсныг санаж, уруулаа шилэмдэн арай гэж хөдөлгөв.

Фабрициогийн тухай малчдад мэдэгд. Фабрициог олж өгсөн хүн Сицилид хамгийн сайн бэлчээрийн эзэн болно.

Авга ах, ач хүү хоёр санаа нь амран бие биеэ учиртай харж, Таза эмч ор руу ойртон очоод хэсэг бодлогоширсноо:

- Чи, дүү минь, одоо бэлэвсэрсэн. Эм нь түрүүлж үхдэг чинь Сицилид тун ховор тохиолдол доо хэмээн хэдэн үг унагасан нь ийм онцгой ялгаагаар тайвшруулах гэсэн юм болов уу даа.

Майкл эрхэм Томмазиног хуруугаараа занган дуудсанд тэрээр орон дээр шилжиж суугаад тонгойв.

- Намайг гэртээ аваачаач гэж аавд хэл хүргэ. Би түүний дэргэд хүү шиг нь хүү байж чадна гэдгийг дамжуулаарай.

Гэвч түүний бүрэн эдгэртэл бүтэн сар өнгөрч, дараа нь зохих бичиг баримт бүрдүүлж, зам зуурынх нь хотуудыг зохицуулж аюулгүй байдлыг хангатад хоёр сар болжээ. Үүний эцэст л сая Майклыг Палермогоос нисэх онгоцоор Ром оруулж Ромоос Нью-Йорк хүргэсэн байна. Эл бүх хугацаанд Фабрициогийн сураг ч гарсангүй.

ХОРИН ХОЁРДУГААР БҮЛЭГ

Кей Адамс их сургуулиа төгсөөд Нью-Гемпширийн төрөлх хотхондоо бага сургуулийн багшаар ажиллах болов. Майклыг алга болсны дараах эхний хагас жилд тэрбээр долоо хоног болгон эх рүү нь утасдаж сураглах боловч Корлеоне авхай дандаа л эелдэг хариулж:

- Чи хорвоод хосгүй бүсгүй. Майклыг мартаад өөр сайн хар хүн олж ав гэсэн үгээр яриа болгоноо төгсгөдөг байлаа.

Энэ авгай өөрт нь сайн санасандаа ингэж байгааг Кей мэдэх тул ийнхүү шулуухан хэлдэгт нь огт гомддоггүй аж.

Сургуулийн амралт эхэлмэгц тэрээр Нью-Йорк орж, олигтой хувцас хунар худалдаж авах, их сургуульд хамт сурч асан найз бүсгүйчүүдтэйгээ уулзахаар шийдэн өглөө эрт галт тэргээр гараад гурван цагийн алдад зочид буудалд иржээ. Замдаа их ядарсан тул хоршоо дэлгүүрээр хэсэх дур хүрсэнгүй. Гэтэл нүдэнд өртсөн юм болгон Майклтай аль нэг зочид буудалд ганц, хоёр хоног дуртай байсан жаргалтай үеийг нь санагдуулаад гав ганцаараа өрөөндөө суугаад байж бас чадсангүй. Тийм учраас л Кей харилцуур авч Лонг-Бич руу утасджээ.

Тод итали аялгатай танил дуу хэн бэ гэж асуусанд Кей бага зэрэг зүрх алдсанаа арай ядан биеэ барилаа

- Корлеоне авхай, та мартчихаагүй бол, би Кей Адамс байна. Майклаас сураг чимээ байна уу, яаж байгаа бол гэж асуух гэсэн юмаа.

Харилцуурт хэсэг чимээгүй болсноо Корлеоне авхай итгэл төгс тод дуугаар:

- Майкл гэртээ байгаа. Чамд утасдаагүй юу? Та хоёр уулзаагүй юм уу? гэсэнд хүүхний дотор зарсхийж, нэг юм хоолой дээр нь тээглэж. нүдийг нь нулимс бүрхээд ирэв.

- Ирээд удаж байна уу?

- Хагас жил.

- Өө, тийм бий? Ойлголоо.

Тийм ээ үнэхээр ойлгомжтой. Ичсэндээ нүүр нь халуу оргин час улайж Майклын хувьд тэрээр юу ч биш гэдгийг эх нь сайн мэдэж байна гэж бодохоос л ичгүүр зовиур нь гэнэт хорсол хилэнгээр солигдов. Майкл өөртэй нь суухаа больсон ч гэсэн Кей найзын хувьд хувь заяаных нь төлөө санаа зовж байгааг ойлгохгүй байна гэж үү?

Кей аль болох тайван, хэнэггүй дуугарахыг хичээн;

- Ойлгомжтой, их баярлалаа, танд. Майкл гэртээ ирж, бүх юм нь бүтэмжтэй болсонд тун баяртай байна. Би зөвхөн үүнийг л мэдэх гэсэн юм. Дахиад утасдахгүй ээ гэсэнд Корлеоне

авхай энэ үгсийг огт сонсоогүй юм шиг:

- Майклтай уулзах бол хүрээд ир. Санаанд ороогүй сайхан учрал болог. Хөлсний тэрэг аваад тоолуурын тооноос хоёр дахин их мөнгө амлаарай. Тэгэхгүй бол ийм хол газар явахгүй шүү. Би хаалганы харуулд хэлээд үнэ хөлсийг нь төлүүлчихнэ ээ гэсэнд Кей хүйтэн хөндий дуугаар хариу үгүүлрүүн:

- Тэр бүтэхгүй ээ, Корлеоне авхай. Майкл надтай уулзахыг хүссэн бол аль эрт утасдах байсан. Урьдын харилцаагаа сэргээх дургүй бололтой.

Корлеоне авхай тэвчээр алдарч байгаа янзтай:

- Ийм нүдэнд дулаахан, сайхан ч хөлтэй хүүхэн байж ухаан л заяасангүй дээ. Чи Майкл дээр биш, надтай уулзахаар ирж байгаа. Надад чамтай ярих юм байна. Дуугүй такси аваад хүрээд ир. Харин унааны хөлс бүү төлөөрэй. Би хүлээж байя гээд харилцуураа тавьчав.

Дахин утасдаад очиж чадахгүй гээд хэлчхэж болох байсан ч Кей Майклтай заавал уулзаж, эртний танилын хувьд ч гэсэн хэдэн үг солих ёстойгоо мэдээд болилоо. Тэрээр нэгэнт гэртээ ирээд нуугдаж бүгэхээ больсон юм чинь тэр нэгэн аймаар хэрэг явдал дуусгавар болсон байж таараа. Кей ухасхийн босч нүүр амаа будаж янзлах зуур Майкл бүтэн зургаан сард ганц ч удаа утасдаагүй юм болохоор ингэж их гоёж гоодоод хэрэг байна уу даа гэсэн бодол толгойд нь зурсхийгээд өнгөрөв.

Цагийн дараа тэрээр Лонг-Бич хотын ойролцоо цэцэрлэгт хүрээлэнгийн бүсэд хүрч очсонд эндхийн хамаг юм танигдахааргүй өөрчлөгдөж, орон сууцны барилгуудыг ган хаалгатай төмөр хашаагаар хүрээлсэн байлаа! Улаан ягаан цамц, цасан цагаан хүрэмтэй нэгэн залуу эр хаалга онгойлгож өгөөд машины цонхоор шагайн тоолуур харснаа мөнгө тоолж өгвөөс таксины жолооч сэтгэл нэн хангалуун «хэ-хэ» гээд буцаж давхижээ.

Корлеоне авхай хаалга онгойлгонгуутаа Кейг хөлөөс толгой хүртэл сонжин ширтээд маргашгүй үнэний дуугаар:

- Тун хөөрхөн. Хөвгүүд минь мөн ч тэнэг юм даа гэснээ Кейг хөтлөн галын өрөөнд оруулахад ширээ зассан, зуух дээр кофе буцалж уур савсана. - Майкл удахгүй ирнэ. Суу.

Авхай өөрөө ч сууж Кейг амттан бүхнээр хичээнгүйлэн дайлах зуур элдэв зүйлийг шүлэнгэтэн шалгааж гарсанд сэтгэл догдолж, сандарсандаа бүсгүй эг маг хийн хариулахчаа болж суув.

Санамсаргүй цонхоор хартал байшингийн үүдэнд нэг машин ирж, хоёр ханхар эрийн араас Майкл гарч ирснээ тэдний нэгэнд хэдэн үг хэлж байгаа бололтой түр саатлаа. Балчир хүүхэд дүрсгүйтэн хуванцар хүүхэлдэйн хацрыг дарчихсан юм шиг гүн хонхорхой шарх мань эрийн зүүн шанаанд байхыг хүүхэн хараад зэрэмдэг болж, зүс царай нь гутсан гэж бодоогүй ч өөрийн эрхгүй хоёр нүдэнд нь нулимс хуржээ.

Гадаад хаалга дуугарч, галын өрөө хүрдэг хонгилд хөлийн чимээ гарснаа тэрээр орж ирсэн

даруйдаа л түүнийг олж харав. Майкл эхний хэдэн хоромд ***** гадас шиг хөдлөлгүй зогссоноо уруулынхаа нэг угаар инээмсэглэсэн нь нөгөөх зүүн талын хонхорхой шарх саад болсных биз ээ. Харин зөвхөн л «За, сайн уу? Ингэж уулздаг байжээ» хэмээн хайнгадуу хүйтэн дуугарахаар зэхэн бараг зуу дахин сургуулилсан Кей сандлаасаа суга үсрэн харайж түүнийг хүзүүдэн тэврээд шал нойтон нүүрээ цээжинд нь нуув. Майкл хацар дээр нь энхрийлэн үнсэж, тайвширтал нь хүлээж байснаа мөрөөр нь тэврээд машин руугаа аваачих замдаа бие хамгаалагчдаа хөөж явуулав.

Хашааны хаалгаар гарсан хойноо Кей будаг шунхныхаа үлдэгдлийг арчих зуур:

- Би уг нь хүсээгүй, гэтэл аяндаа ингэчихлээ. Чамайг ийм хүнд бэртсэн гэж хэн ч надад хэлээгүй юм л даа хэмээн учирлахад Майкл хөгжөөнтэй инээд алдаад зүүн шанаагаа тэмтэрлээ.

- Аа, энэ үү? Зүгээр, зүгээр. Гэртээ ирсэн хойно засвар хийлгэж болох байлгүй... Би яамд захиа бичиж, ер нь яаж ч чадахгүй байсан гэдгийг чи юуны өмнө ойлгох ёстой.

- Ойлгосоон. Үнэн хэрэгтээ цагдааг хэн алсан нь тодорхой, болоо юу? Чи тэгээд л гэртээ эргэж ирсэн үү?

Майкл хариу хэлэхийн өмнө түр азнав.

- Тийм ээ, тодорхой болсон. Нью-Йоркийн бүх сонинд гарсан шүү дээ, уншаагүй юм уу?

Тэгэхлээр энэ минь алуурч биш байх нь гэж бодсон Кейгийн нүүрэнд баярын мишээл тодорч.

- Уншсан бол ээж рүү чинь аль эрт утасдахгүй юу? гэснээ гэнэт түгдрэв. - Эхтэй чинь тэгэхэд ярьсны дараа үнэхээр чамайг хүн алчихсан гэдэгт хариугүй итгэх дөхсөнөө одоо бодоход инээдтэй юм.

- Ээж өөрөө ч гэсэн эхэндээ үүнд итгэж явсан байж магадгүй дээ.

- Юу гэнэ ээ? Төрсөн эх үү?

Майкл бас л өрөөсгөл жуумалзав.

- Эх хүн яг л цагдаа шиг, дандаа муу юмыг л түрүүлж боддог биз дээ?

Нью-Йорк ороод тэрбээр машинаа гараашид тавихад гараашийн эзэн хэзээний танил нь бололтой элэгсэг дотноор мэндлэх ажгуу. Манай хоёр булан тойроод Майкл дээр үед дэгжин хээнцэрт тооцогдож асан одоо хуучирч гундсан байшингийн гол хаалгыг түлхүүрээрээ онгойлгон орвол дотроо харин баян чимэглэлтэй цэвэр цэмцгэр гэдэг нь жигтэйхэн аж. Майкл шатаар өгсөн Кейг дагуулсаар цэлгэр саруулхан хоймрын өрөө, түүнтэй хамар мөн л уужим галын өрөө бүхий сайхан сууцанд оров. Хаалттай өөр нэг хаалга унтлагын өрөөнийх бололтой. Майкл дарсны шүүгээнээс гурав дөрвөн шилтэй архи гарган хоёр шилэн аяганд хольж бэлтгээд буйдан дээр дуугүй баахан сууснаа:

- За, яадаг юм бэ? Орох уу? хэмээн хаалттай хаалганы зүг толгой дохисонд Кей таатай жуумалзан аягатайгаа нэг сайн балгаж аваад:

- Тэгье гэлээ.

Кей яг л хуучин байсан шигээ алд биеийн жаргалыг эдэлж, хэдийгээр хоёр жил Майкл сураггүй алга болсон ч гэсэн түүнтэй нэгэн хөнжилд ийнхүү тас тэврэлдэн хэвтэх нь зүй ёсны хэрэг мэт санагдлаа.

- Чи надад итгэсэн л бол зурвас ч атугай илгээж болох л байсан. Би л бол энд Сицилийн омеритаг нэвтрүүлнэ дээ. Америкчууд ч бас тийм ам задгай улс биш шүү.

- Тийм дуулиантай хэрэг мандсаны хойт дээр намайг хүлээх юм гэж ер бодоогүй юм чинь бий яаж ч чамд захиа бичих билээ дээ.

- Тэр хоёрыг чи алсан гэхэд би хормын төдийд ч итгээгүй. Ээжтэй чинь ярьснаас хойш хааяа эргэлзэх нь эргэлзэж л байсан боловч сэтгэлийн гүнд бол огт итгээгүй. Би чамайг дэндүү сайн мэднэ дээ.

Харанхуйд Майклын шүүрс алдах нь тод сонсогдов.

- Тэднийг хэн алсан би юу, өөр хүн үү гэдэг нь тийм ч чухал биш. Үүнийг чи хатуу ойлгож авах л хэрэгтэй болж дээ.

- Ямар ч л гэсэн чи алсан эсэхээ хэлээд өгөөч.

Майкл дэр налан өндийж суугаад харанхуйд шүдэнзээ тэмтрэн авч тамхи асаав.

- Чи надтай суугаач. Эсвэл үүний тулд би эхлээд чиний асуултад хариулах ёстой юм уу?

- Би чамд үнэхээр сэтгэлтэй болохоор надад хамаа алга. Харин чи надад хайргүй учраас л үнэнийг хэлэхээсээ айгаад байна. Чи гэртээ эргэж ирээд утасдаа ч үгүй шүү дээ.

- За яахав, энэ удаад би хариулъя. Чи миний хайртай, дотнын цорын ганц хүн. Гэртээ ирээд эцэг, эх, Конни, Том нарын хэнтэй нь ч уулзсандаа би баярлаж сүйд болоогүй атлаа өнөөдөр, чамайг харсан даруйдаа л сэтгэл хөөрч, үнэхээр баяссан. Тэр хэргийн дараа намайг тоож харахаа болино биз гэж бодсондоо л би чамд утасдаагүйгээ давган хэлье. Одоо би эцгийнхээ төлөө хүчин зүтгэж байна. Хэзээ нэгэн цагт би түүнийг орлох ёстой. Манай гэр бүл чидун жимсний тос гадаадаас оруулж борлуулах бизнес эрхэлдэг. Гэхдээ манай гэр бүлд, эцэгт минь дайсан мундахгүй олон. Тэгэхлээр чи залуу зандан насандаа бэлэвсэрч ч магадгүй. Бас нэг юм байна. Би орой гэртээ ирээд өдөр юу хийсэн болгоноо чамд тоочиж суухгүй. Чи миний эхнэр л болохоос биш, эн зэрэгцэх анд нөхөр минь хэзээ ч болж чадахгүй.

Кей тээнэгэлзэн толгой сэгсэрсэн боловч харанхуйд харагдсангүй.

- Амьдралынхаа хамгийн гол зүйлийг эхнэртээ итгээд ярьж чадахгүй юм бол ер нь гэрлэхийн хэрэг юу байгааг би огт ойлгохгүй юм. Эцэг чинь эхэд итгэдгийг би сайн мэднэ.

- Тийм л дээ. Гэвч энэ чинь аав түүнд далан булчирхайгаа дэлгэн тоочдог гэсэн үг биш.

- Бид гэрлэнэ гэж бодоход, танайд тэдэнтэй хамт амьдрах уу?

Майкл толгой дохилоо.

- Тэр дажгүй ээ бид тусдаа байшинд, бие даан амьдрах болно. Эцэг эх минь бидний хувийн хэрэг явдалд оролцдоггүй юм. Ямар ч гэсэн энэ бүхнийг л зохицуултал би цэцэрлэгт хүрээлэнгийн бүсэд амьдрах ёстой.

- Түүний гадна амьдрахад чамд аюултай болоод л тэр байлгүй дээ гэчихсэн даруйдаа л Кей Майклтай танилцсанаасаа хойш анх удаа сайхь эрийн уур хилэн мөс шиг хайрахыг мэдэрчээ.

- Чи кино, сонин хэвлэлийн элдэв балай юмаар толгойгоо дүүртэл чихсэн болохоор эцгийн минь Корлеонегийн гэр бүлийн тухай буруу ойлголттой явдаг юм байна. Сүүлчийн удаа, дуулж байна уу, эцсийн удаа л тайлбарлаж өгье. Миний эцэг эхнэр хүүхдээ болон хүнд бэрх цагт хэрэг болж мэдэх найз нөхдөө хангалуун амьдруулахыг хичээсэн ажил хэрэгч хүн. Бидний аж төрж буй нийгмийн дэг журмыг дагах юм бол эцэг минь алхам тутамдаа ялагдал хүлээж, ядарч зүдрэх тул тэрээр энэ дэг журмаас татгалзсан. Түүний эцсийн зорилго нь ямар ч гэсэн энэ нийгэмд орох, тэгэхдээ өмгөөлөл, ивээл тэтгэмжгүй хүнийг нийгэм хамгаалж хаацайлдаггүй болохоор зохих бэлтгэлээ хангаж, тодорхой хэмжээгээр хөрөнгөжин хүчирхэгжсэн хойноо нэгдэн орох юм. Харин одоохондоо тэрээр хууль ёсны гэгдэгч ёс суртахууны ойлголтоос хамаагүй илүү эрхэмлэн баримталдаг өөрийн хувийн дүрэм журмаар амьдарч байгаа билээ.

Гайхан цочирдсон Кей харанхуйд түүний царайг олж харахаар хичээн оролдов.

- Энэ чинь зэрлэг мунхаг явдал! Хүн болгон ингэж бодох юм бол нийгэм маань сүйрэн унаж бид хүй нэгдлийн үедээ эргэж орно шүү дээ! Майкл аа чи өөрөө үүнд итгэж байгаа хэрэг үү?

—Би чамд аавынхаа үзэл бодлыг л тайлбарласан юм.

- Харин чи өөрөө яах вэ?

- Би чамд болон чи бид хоёрын ирээдүйн гэр бүлдээ итгэдэг. Би ч гэсэн энэ нийгэм маниусаа хамгаалж өмөөрнө гэдэгт итгэдэггүй болохоор зөвхөн сонгуулийн үеэр үнэн худлыг хольж арга заль бүхнээ ашиглаж байгаад олонхын саналыг олж авахаас өөр юм чаддаггүй хүмүүст хувь заяагаа даатгахыг үл хүснэ. Ямар ч гэсэн өнөөдрийн хувьд байдал ийм байна. Гэхдээ миний эцэг шиг хүмүүсийн цаг үе улиран өнгөрч, хэтэрхий их хохирол амсах учраас түүний арга барилаар ажиллах аргагүй боллоо. Бидний хүссэн хүсээгүй Корлеонегийн гэр бүл одоогийн оршин тогтнож буй нийгмийг хүлээн зөвшөөрч, түүнд нэгдэн орох болно. Тэгэхдээ миний түрүүнд хэлснээр өөрсдийн тодорхой хүчирхэг байдлаа, өөрөөр хэлбэл мөнгө бусад үнэт зүйлийн нөөцөө хадгалсан хэвээр нийлэн орох юм. Хүүхдүүд минь бусад олныхоо хувь тавиланг хуваалцахаас өмнө би өөрөө тэднийг аль болох найдвартай хамгаалж, хэний ч гар харахааргүй болгох бодолтой байна.

- Хөөе, чи энэ улсынхаа төлөө сайн дураар дайнд явсан баатар хүн. Бодол санаа чинь яагаад ингэж эрс өөрчлөгдчихөө вэ?

- Би мах цусанд минь шингэсэн заншил уламжлалаа дагаж, өөрөө л өөрийгөө хамгаалан өөртөө л найдахыг илүүд үздэг Нарийн дээрээ очвол, манай засгийн газар ард олныхоо төлөө тийм ч их санаа тавьж халамжлахгүй байна шүү дээ. Гэвч одоо асуудлын гол нь үүнд биш, харин би эцэгтээ тусалж, түүний талд бат зогсох үүрэгтэй гэдгээ чамд хэлсэн. Харин чи намайг дэмжих эсэх нь чиний л шийдэх асуудал.

ХОРИН ГУРАВДУГААР БҮЛЭГ

Чамин хээнцэр тавилгатай өрөөний цонхоор харахад ягаан чийдэн голыг нь ороож гэрэлтүүлсэн далдуу мод элсэн цөлийн хурц оддыг тольдон Гялалзах хоёр том усан сан зэрэг хүний гараар бүтсэн байгалийн үзэсгэлэн гуай нүдэнд чимэгтэй үзэгдэх амой. Нүд хүрэх л хаяагаа элсэн манхан элгэн хадаар мануулсан хөндийдөө Лас-Вегас неон гэрэлд умбан, яг л өөхөнд ороолттой бөөр лугаа адил тухтай бөөцийлөгджээ. Жонни Фонтейн зөвхөн гараа буулгах төдийхнөөр алтан утсаар шаглаж чимсэн саарал хөшигний хуниасыг буулган тэнийлгээд цонхноос нүүр буруулав.

Нино Валенти аягатай виски барьж, зөөлөн ханз тохойлдон хэвтгээд, мөрийтэй тоглоомын газрын хүмүүс хэзрийн тоглоомын тах хэлбэртэй ширээ хэрхэн цэвэрлэж, зургаа долоон сандал зөөж гаргахыг харж хэвтсэнээ:

- Жонни, нааш ирээч. Тэр новшнуудын эсрэг чи надтай нэг гар болж тоглоогүй чинь тун харамсалтай. Яаж шатаахыг минь харсан биз дээ? хэмээн хэлээ орооцолдуулан чүү чамай дуугарахад Жонни ханзны харалдаа сандал дээр очиж суув.

- Мөрийтэй тоглодоггүйг минь чи мэднэ шүү дээ. Бие чинь зүгээр үү?

- Маш сайн гээд Нино жуумалзав. - Шөнө дундын алдад хүүхнүүд ирэхээр зад наргия. Энэ орой таван мянгыг хожсон ямар вэ дээ?

- Тийм нь ч тийм. Харин чамайг хорвоогоос халихын цагт энэ бүхэн хэний гарт орох юм болдоо, хөөрхий.

Нино аягатайгаа нэгмөсөн хөнтөрлөө.

- Жонни, чи ер нь хүн чанараар л овоо юу гэхээс үглэж яншсан, золигийн уйтгартай эр байна шүү. Яаж наргиж цэнгэхийг надаар заалга.

Нино Валенти бүтэн хоёр цаг наргисны гор нь одоо л гарч урагшаа тонгосхийгээд хариугүй онхолддогийн даваан дээр хашир туршлагатай хоёр ажилтан амжин шүүрч аваад унтлагын өрөө рүү нь дамжилж аваачихад мөрийтэй тоглоомын газрын гуравдахь ажилтан ширээний дэргэд үлдлээ.

Жонни түүнээс:

- Энэ дандаа ингэдэг юм уу? хэмээн сонирхвол тэрээр мөрөө хавчив.

- Өнөөдөр арай эрт өнхрөөд өглөө.

- Та бүх давхрыг нэгжиж байгаад ч болсон эмч олоод ирээч.

Арван таван минутын дараа орж ирсэн Жул Сегал эмч хүн шиг биеэ авч явж ер сураагүй,

гартаа барьсан хар цүнх нь тун хөгийн инээдтэй харагдсанд Жонни дотроо дургүйлхсэн хэдий ч арга буюу Ниногийн хэвтэж байгаа унтлагын өрөөнд дагуулж орлоо.

- Энэ яачхав аа, та үзээд өгөөч?

Жул тун шалмаг сурамгай хөдөлж Ниног үзэхдээ зүрх чагнан судас барьж, даралт хэмжсэнээ цүнхнээс тариур гаргах мөртлөө гарт нь хайнгадуухан зүү шаатал тун ч удсангүй, Ниногийн үхээнц цонхигор царай аажмаар амилж, хацар нь ягаараад ирэв. ,

- Сүйд болсон юм алга. Үүнийг энд анх удаа ухаангүй унахад нь би эмнэлэгт хүргүүлж, шинжилгээ хийлгэсэн. Хөнгөн хэлбэрийн шижин өвчин, эм ууж, цагаан хоол идвэл зуу хүртэл ч насална. Гэтэл найз чинь огт тоохгүй, лонх ёроолдоод ер болохгүй юм. Элэг нь бараг устаж, одоо уураг тархинд нь нөлөөлөх янзтай. Харин саяынх бол түр зуурын ухаан алдалт. Энэ хүнийг сэтгэц гажгийн эмнэлэгт хэвтүүл гэж эмчийн хувьд зөвлөх байна гээд Жул хананд суулгасан дарсны шүүгээ рүү очиж өөртөө архи аягалав.

- Галзуугийн эмнэлэгт үү? Та арай тоглоогүй биз дээ? хэмээн Жонниг асуутал хаалга тогшиж, онгойлгосон чинь Люси Манчини орж ирснээ:

- Жонни! Ямар сонин хүн бэ? гээд түүнийг тэвэрч үнсэв.

- Тийм ээ, уулзалгүй уджээ.

Люси үлэмж гуалиг болж үсээ сайхан засуулж, хувцсаа тааруулан өмсөж сураад ер нь урьдахтай нь харьцуулахын аргагүй өөр болсныг Жонни ажаад энэ тухай магтан хэлэх гэтэл орон дээрээс:

- Хөөе, залуус аа, нэг хөнтрөх наг болсон юм биш үү? гэх дуу сонсогдов.

Өндийгөөд суучихсан Нино одоо тийм ч муугүй, бараг зүгээр юм шиг харагдах нь гайхалтай. Мань эр хуруугаа инчдэн:

- Жонни минь, чи яав аа? Цаг эрт, юм уумаар байна. Ээ халаг, ширээ аваад явчихдаг нь ч юу билээ? хэмээн ганирах зуур Жул эмч аягатай архинаасаа том балгаж аваад:

- Та уугаад хэрэггүй. Эмчийн хувьд зөвшөөрөхгүй гэхэд Нино нүүрнийхээ хамаг арьсыг хамар дээр овоолон хөмсөг зангидлаа.

- Тэр эмч домч надад ямар хамаатай юм бэ? Алив, Жонни, түргэл. Тэгэхгүй бол чинь би өөрөө бослоо шүү!

Жонни мөрөө хавчисхийн дарсны шүүгээ зүглэхэд Жул хайнгадуу саарал дуугаар:

- Би болохгүй гэсэн шүү! хэмээсэн хэдий ч Жонни хэдийнээ архи аягалаад орны дэргэд иржээ.

- За ямар ганц аяга архинаас л үхчхэв гэж дээ!

- Үгүй, нэг аягатайгаас бол үхэхгүй гэж Жулын хэнэггүй царайлсанд Нино аягыг авч дуустал нь гэдийлгэхийг Жонни инээмсэглэн харж зогслоо. Эмч зөвшөөрөхгүй гэнэ, мөн донгосов оо? Хөнжлийнхөө хэрээр хөлөө жийвэл барав.

Гэнэт Нино амаа ангалзуулан амьсгаа нь давхцаад, царай нь зөвхийрэн хөхрөхийн хамт хамаг бие нь уснаас гаргасан загас лугаа адил татгасхийн атиралдаад нүд нь цагаанаараа эргэлдлээ. Жул эмч араар нь тойрч өрөөсөн гараараа тэврээд нөгөө гараараа мөрөнд нь, бараг хүзүү рүү нь тариа хийсэнд Ниногийн бие сулбайн унжиж чимээ тасарснаа удалгүй дэрэн дээрээ гулсан унамагц нүдээ анив.

Жонни, Люси болон Жул эмчийн хамт сэм сэмхэн гишгэсээр зочдын өрөөнд орж цайны ширээнд суусан хойноо:

- Балга виски уугаад ингэнэ гэдгийг та мэдэж байсан уу? хэмээн асуухад Жул мөрөө хавчлаа.

- Уг нь ингэнэ гэдгийг урьдчилан хэлж болох л байсан.

- Тэгээд үхсэн үлийгээ хийгээд надад хэлээгүй юм

бэ?

- Би танд анхааруулсан шүү дээ.

- Ингэж ч анхааруулдаггүй байх шүү, эмч гуай! хэмээн Фонтейн хахир хорсолтой дуугаар шүд зуун үгүүлэхэд Жул тоосон шинжгүй инээвхийлж:

- Яаж хэлэх ёстой юм бэ? Голливудын эмч нар шиг манжлах хэрэг үү? Тиймэрхүү анагаагч нар газрын аль гаваар гай болж гараад ирдэг байна аа? Тэд юу ч мэддэггүй мангуу юм уу эсвэл юуг ч тоодоггүй луйварчид юм уу, яагаад Ниногийн бие муудаж буйг харсангүй өнгөрөв өө? Хэрэгтэй хэрэггүй хог шаар ам руу нь чихээд маргааш болговол манай аз гэхээс биш амьд гарах, үхэж үрэгдэх нь тэдэнд ер хамаагүй биз. Харин надад, магадгүй уучилж болшгүй, нэг сонирхол бий. Миний бие хүний амь аврахыг хичээдэг гайхал л даа. Өнөө маргаашгүй Нино хэрхэн баларч магадгүйг та нарт харуулахын тулд л би түүнд балга виски уулгахыг тань тас хориглоогүй юм гээд урагш тонгойсноо хэнэггүй, хөндий дуугаар цааш үгүүлрүүн: - Найзыг чинь аврах арга бараг алга болсныг та хоёр ойлгохгүй байна гэж үү? Тийм ээ, би галзуугийн эмнэлэг гэсэн. Албадан эмчлэхгүй, хатуу дэглэм сахихгүй бол тэр өнгөрнө гэдгийг шуудхан хэлчихье. Анд найзаа та нар сэтгэл мэдрэлийн эмнэлэгт хэвтүүлж, амь насыг нь аварвал авар, үгүй бол түүнээс үүрд хагацна. Намайг иймэрхүү тохиолдолд ийм үгсийг анх удаа хэлж байна гэж та нар бодно уу? Би өдөр болгон өчнөөн төчнөөн хүмүүст: «Ингэж их идвэл үхнэ, ийм олон янжуур татвал талийгаач болго, ядартлаа ажиллаад мал болтлоо уугаад байвал өөрийгөө хөнөөнө» гээд л тоть шиг давтдаг боловч сонсдог хүн нэг ч үгүй. Яагаад гээч? Яагаад гэвэл би «маргааш» гэж хэлдэггүй. За тэгэхлээр, Нино маргааш нас барж магадгүй гэдгийг би бүрэн үндэстэйгээр хэлж байна. Ийм амин чухал юм хэлээд байхад тоохгүй улс юм даа, та нар.

- Би тоогоогүй биш, харин ч тунгаан бодож байна.

Люси хоёр эрийн яриа түр завсарласныг овжноор ашиглан өөр сэдэв сэдэж:

- Жонни, чи Вегаст юу хийж ирээ вэ? Голливудын том хөрөнгөтний албан үүргээс зайлж амрахаар явна уу, эсвэл ажлаар ирэв үү? гэж асуухад Жонни толгой сэгсрэв.

- Бүү мэд, Майкл Корлеонед л хэрэг болсон юм байх аа. Том Хейген тэр хоёр өнөөдөр нисч ирнэ. Тэд чамтай ч гэсэн уулзахаар тохирсон гэж Том хэлсэн. Яах гэснийг нь мэдэхгүй биз, Люси?

- Бид бүгдээрээ, Фредди ч бас, маргааш оройн хоол хамт иднэ гэдгийг л мэднэ. Зочид буудалтай л холбоотой болов уу. Онцын шалтгаан байхгүй юм шиг мөртлөө сүүлийн үед мөрийтэй тоглоомын газрын орлого илт унасан. Их эцэг хаана юу болохоо байж гацсаныг Майклаар шалгуулах гэсэн байж болох юм даа.

- Майк эрүүгээ янзлуулсан гэлцэх юм, үнэн үү?

- Кей л шахаж шаардсанаас зайлаа гэж үү? Нүүрэнд нь мэс засал хийх үеэр түүний гэр бүлийнхэн Жулыг зөвлөгч, ажиглагчаар урьсан шүү гээд Люсиг жуумагнахад Жул бодлогошрон үгүүлсэн нь:

- Хамгийн гайхалтай нь, тэрээр хэнд ч итгэхгүй байсан шүү. Нарийн төвөгтэй биш, захын эмч хийчихмээр мэс засал атал зөв хийж байгаа эсэхийг намайг сайн ажиглаарай гэж ахин дахин захиад байсан.

Унтлагын өрөөнд чимээ гарч, тэд тийшээ харсан чинь Нино ухаан орсон байлаа. Жонни ор руу нь очиж хажууд нь суугаад Жул, Люси хоёр орны хөл түшин зогсохуй Нино сулхан инээвхийлмэр болов.

- За за, би ямар жаахан хүүхэд хуурч байгаа биш, бие тун тааруу байна шүү... Жонни чи нэг жилийн өмнө хоолойныхоо үүг авахуулаад Жул эмчид утасдаж хэзээ дуулж болох вэ гэж асууснаа санаж байгаа биз дээ? Тэгээд Палм-Спрингсэд хоёр хүүхэнтэй цэнгэж байгаад гэнэт дуулж эхлэхэд чинь би чамд атаархаагүй, харин чиний төлөө их баярласан шүү. Чи надад итгэж байна уу, Жонни?

Жонни түүнийг тайвшруулан:

- Мэдээж, итгэлгүй яах вэ, тэнэгхэн минь! гэх зуур Жул Нинод дахин үзлэг хийгээд:

- Би танд шөнийн асрагч дуудаж өгье. Хоёр гурван хоног хэвтэх болж дээ. Би тоглоогүй байна шүү гээд эмнэлэг рүү утасдсаны хойт дээр Люсиг дагуулан гарч, харин Жонни асрагчийг хүлээн ядарч туйлдан зүүрмэглэх Ниногийн орны хажууд байхдаа дөнгөж сая найзынхаа хэлсэн үгийг тунгаан бодож, Нино өөрт нь юунд атаархсаныг гайхсаар суулаа...

Асрагч эм тан дүүрэн өрсөн тэргэнцэр түрсээр орж ирэхэд Жонни босч унтаж буй, эсвэл амьсгаа хурааж ч байгаа юм уу бүү мэд, найз руугаа өнгийн харав. Үгүй ээ, Нино түүний дуулж эхэлсэнд үнэхээр атаархсангүй, харин дахин дуулахдаа ямар их жаргалтай, баяр

хөөртэй байгаад нь агаархсаныг Жонни ойлголоо. Яагаад гэвэл, Нино Валентигийн хувьд тийм их аз жаргал, баяр хөөр авчрах юм юу ч үлдсэнгүй...

ХОРИН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Майкл Корлеоне бүр орой болсон хойно онгоцоор нисч ирэхэд урьдчилан тохиролцсон ёсоор хэн ч угтаж авсангүй, зөвхөн Том Хейген, шинэ бие хамгаалагч Альберт Нери гэдэг залуугийн хамт дагалдан явжээ. Тэднийг зочид буудлын хамгийн хүндэт зочдод зориулсан тохилог өрөөнд оруулсан бөгөөд хүлээх тасалгаанд Майклын уулзах ёстой хүмүүс хэдийнээ цугларсан байлаа.

Фредди дүүгээ элэгсэг дотноор тэвэрч авав. Тэрээр биежин таргалж царай нь зөөлөрч, ганган хувцаслаад сэргэлэн цовоо аашлах нь дөрвөн жилийн өмнө Нью Йоркоос явахдаа ертөнц дээр юуг ч хайхрахаа байсан алмай эрээс шал өөр хүн гэлтэй. Тэрээр жаахан холдож Майклыг хайр гэрэлтсэн нүдээр ширтэн:

- Шарх сорвиноос чинь ул мөр ч үлдсэнгүй, гялалзаж байх шив дээ? Кей яаж байна? Бидэн дээрээ хэзээ нэг ирж гялайлгах юм бэ?

Майкл цайлган инээмсэглэлээр нүүрээ чимлээ.

- Чи ч гэсэн дажгүй, бүр танигдахааргүй өөрчлөгджээ. Кей ирэх л байсан, даанч дахиад хөл хүнд бас хүүхэд харах хүн байдаггүй. Тэгээд ч, Фредди, би ажлаар ирсэн, маргааш, за цаанадаж гэхэд нөгөөдөр буцна.

- За, ямар ч гэсэн эхлээд хоол иднэ ээ. Зочид буудлын тогооч нь тун алдартай, хуруугаа хамт хазчихмаар амттай хоол хийдэг юм. Чи шүршүүрт орж, хувцсаа соль, тэр хооронд чинь би ширээ энд зас гэж хэлээд ирье. Чиний уулзах хүмүүс энд ээлж дугаараа хүлээгээд зогсож байгаа.

- Моу Гринтэй сүүлд нь уулзъя тэгэх үү? Жонни Фонтейн, Нино, бас Люсиг тэр эмчтэй нь хамт хоолонд уриарай. Тэгээд л ярилцъя.

Шөнө дунд өнгөрсөн хойно ширээнд сууцгаалаа. Оройн зоог дуусан дуустал Майкл хүн болгоны анхаарлыг татаж, зан авир болон ярих хөдлөх нь хүртэл эцэгтэйгээ адилхныг бүгд анзаарчээ. Хейген дадсан ёсоороо даруухан сууж шинэ бие хамгаалагч Альбер Нериг хэн ч мэдэхгүй тул тэрээр бас л нийтийн ярианд оролцсонгүй, гэдэс өлсөөгүй гээд хаалганы дэргэдэх буйдан сандалд суугаад орон нутгийн сонин уншиж гарав.

Удалгүй үйлчлэгч нарыг явуулж, Майкл эхлээд Жонни Фонтейнд хандан:

- Чи дахиад, тэгэхдээ хуучнаасаа хамаагүй дээр дуулдаг болсон гэсэн үү? Баяр хүргэе! гэвээс Жонни хариуд нь:

- Баярлалаа гэх зуур Майкл өөрийг нь яах гэж дуудсан, юу шаардах гэж байгааг тааварлахыг хичээнэ.

Майкл гол зүйлдээ орж бүгдэд хандан үгүүлрүүн:

- Корлеонегийн нам худалдааны «Женко пура» компаниа худалдаад энд, Вегаст төвлөрч суурьшихаар шийдсэн. Их эцэг үүнийг Хейген бид хоёртой зөвшилдөөд манай намын хувьд Невадад хөгжин дэгжих ирээдүй байна гэсэн дүгнэлт хийлээ. Би өнөө маргаашийн дотор нүүгээд ирнэ гэж хэлэхгүй. Бүгдийг бэлтгэж зохицуултал гурав дөрвөн жил ч болж магад. Гэхдээ л үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөө ийм байна. Энэ зочид буудал, мөрийтэй тоглоомын газарт оруулсан хөрөнгийн дийлэнх хэсэг нь бидний найз нөхдийн мэдлийнх, үүнийг л үндэс болгон ажлаа эхэлнэ. Моу Грин бидэнд өөрийнхөө хувийг худалдана, ингээд л энэ бизнес манай намын мэдэлд бүрэн шилжинэ.

Фредди Корлеонегийн малигар махлаг нүүрэнд санаа зовсон байдал илрэв.

- Майк. чи бүрэн итгэлтэй байна уу? Моу Грин энэ тухай юу ч яриагүй. Тэрээр энэ зочид буудалд амиа тавьдаг болохоор ний нуугүй хэлэхэд түүнийг зөвшөөрөхгүй гэж бодох юм.

Майкл хоосон хөндий, жирийн намуун дуугаар:

- Би түүний татгалзаж чадахааргүй тийм санал хэлнэ гэхэд Загалмайлсан эцгийн амны уншлага болсон хэллэгийг сонссондоо ч тэр үү, бүгдийн дотор зарсхийлээ.

Майкл дахиад л Жонни Фонтейнтэй яриа дэлгэв.

- Эхний үед чамайг бидэнд тусална гэж Их эцэг найдаж байгаа. Эстрадын тоглолтоос өөр, үйлчлүүлэгчдийг хуйлруулан татах юм байхгүй гэдгийг бидэнд тайлбарласан. Жилд таван удаа ирж долоо хоног концерт тоглож байх гэрээ бидэнтэй байгуулахаас чи татгалзахгүй юм байгаа биз дээ? Киноны ертөнцийн найз нар чинь ч гэсэн энэ талаар бидэнд туслахаас цааргалахгүй гэж найдна. Чи тэдэнд их юм хийж өгсөн, одоо тэдний ээлж болсон байх аа.

- Энэ талаар санаа зовсны хэрэггүй. Загалмайлсан эцгийн төлөө миний хийхгүй юм хорвоо дээр үгүйг чи мэднэ дээ, Майк гэснээ Жоннигийн дуу эргэлзсэн өнгөтэй боллоо.

- Гэхдээ, чи ойлгож байна уу, энэ хаяанд Полост арваад зочид буудал, казино барьж байгаа. Та нарыг нүүх суух гэсээр байтал бусад нь зах зээлийг эзлээд, ийм ширүүн өрсөлдөөний үед та нар хожимдож магадгүй дээ.

Том Хейген анх удаа ам нээв.

- Тэднээс гурван зочид буудлын барилгын ажлыг Корлеонегийн гэр бүлийн найз нөхөд санхүүжүүлж байгаа.

Энэ нь гурван зочид буудал, түүн доторх мөрийтэй тоглоомын бизнесийн хамт Корлеонегийн намын мэдэлд ирж тэр их ашиг орлогоноос ойр дотнын хүмүүстээ овоохон хувь хүртээнэ гэсэн үг болохыг Жонни даруй ойлголоо.

- За сайн байна. Надад татгалзах юм алга, одоохон ажилдаа орно.

Майкл энэ удаад Жул Сегал тийш харав.

- Та надад тун их тус хийсэн. Та дахиад л шударга иргэдийн гэдэс дотрыг огтолж хэрчихийг мөрөөдөж, харин таныг тэр нэгэн үр зулбах золгүй явдлын улмаас хагалгааны ширээнд ойртуулахгүй байна гэж дууллаа. Та үнэхээр үүнийг хүсч мөрөөдөөд байгаа эсэхийг амнаас чинь сонсмоор байна.

- Тийм ч болов уу. Гэхдээ та анагаах ухаанд тогтсон дүрэм журмыг сайн мэдэхгүй. Та нар хичнээн хүчирхэг байлаа ч гэсэн эрх мэдэл чинь анагаах ухааны салбарт хамаарахгүй. Энэ талаар надад туслах ямар ч аргагүй байх л гэж айх юм гээд Жулын инээвхийлэхэд Майкл огт өөрийг бодон хайнгадуу толгой дохих аж.

- Тийм ээ, тийм, таны зөв. Гэхдээ ажил хэрэгч хүмүүсийн дунд нилээд нэр хүндтэй найз нар минь Лас-Вегаст том эмнэлэг барих бодолтой. Хот өдрөөс өдөрт хүрээгээ тэлж, хүн ам нь зогсолтгүй өсч буй тул тийм эмнэлэг гарцаагүй хэрэгтэй. Хэрэв энд ухаантайхан хандвал танд мэс засал хийх бололцоо олдох биз. Чөтгөр ав, ийм элсэн цөлд гарамгай мэс засалч хичнээн л олон ирэв гэж дээ! Тэр эмнэлэгт тус хийхэд юу нь болохгүй байх вэ! Тэгэхлээр та хэрэгтэй цагт гар дор байгаарай. Люси та хоёрыг гэрлэх юм гэж дуулсан, тийм үү?

Жул мөрөө хавчин:

- Ирээдүй минь тодорхой болсон цагт л шийднэ дээ гэхэд Люси царай барайлгаад:

- Тэгэхлээр, Майк минь чи эмнэлэг энд барихгүй л бол би гэртээ хөгширсөн хүүхэн явсаар хорвоог барах нь байна шүү гэсэнд бүгд хөхрөлдөж Майкл л ялаархсан морь шиг зөвхөн толгой дохисоор үлдлээ.

- За тэгж тохиролцъё. Харин эмнэлэг барьж дуустал та дөрвөн зочид буудлын эмнэлгийн албыг хариуцах болно. Ажилтан нараа өөрөө сонгож аваарай. Люси, чамд ч гэсэн хариуцлагатай ажил даалгамаар байна. Худалдааны гудамжинд байрлах бүх лангуу, мухлаг, захын ажлыг зохицуулах юм уу, эсвэл мөрийтэй тоглоомын газар хүүхнүүд элсүүлж авсан ч болох юм. Хэрэв Жул чамтай гэрлэхгүй бол ядахдаа гэртээ хөгширсөн баян хүүхэн үлдэхгүй юу даа!

Энэ зуур Фредди уурандаа дэлбэрчих шахан навчин тамхины утаа зай завсаргүй баагиулсанд Майкл түүн рүү эргэж:

- Би зөвхөн Их эцгийн элч шүү дээ, Фредди. Чамд ямар хувь хүртээхийгээ тэр өөрөө хэлэх нь лавгай. Чухам юуг мэдэхгүй, гэхдээ чамд таалагдана гэдэгт би итгэж байна. Чиний эндхийн ажил сайн байгаа гэж байн байн ярьдаг юм.

- Тэгвэл яагаад надад уурлаад байгаа юм бэ? хэмээн Фредди уйлагнав. - Мөрийтэй тоглоомын газрын мөнгөө алдаад байна гэж тэр үү? Би энэ ажлыг эрхэлдэггүй, Моу Грин хариуцдаг шүү дээ. Ер нь өвгөн надаар яах гээд байгаа юм бэ?

- За за. Дэмий юм бодож хий бухимдаад яах нь вэ? гээд Майкл дахиад л Жонни Фонтейн өөд харав,

Хөөе, ингэхэд Нино хаана байна? Энд уулзана гэж бодсон юмсан.

Жоннигийн царай барайгаад явчихлаа.

- Нино бур баларсаан, баларсан. Өрөөндөө сувилагчаар асруулаад хэвтэж байгаа. Эмч түүнийг галзуугийн эмнэлэгт хэвтүүлэх хэрэгтэй, зориуд өөрийгөө авсанд оруулах гээд байна гэсэн. Ойлгож байна уу? Мөнгө, хөрөнгө Ниногийн гарт өөрөө орж ирээд, тайзан дээр дуулсан ч, кинонд тоглосон ч, ер нь юу дуртайгаа хийх бололцоотой. Ганц кинонд тоглоод л тавин мянгыг өвөртлөх атлаа бүгдийг үрэн таран хийчих юм. Алдар нэрийг юман чинээ тоохгүй. Архи дарс, авгай хүүхнээр л хөөцөлдөх юм, моньд чинь.

Жул нэг юм хэлэх гэтэл хаалга тогшиж, харин хажууханд нь байгаа хүн хөдөлсөн ч үгүй, сониноо шагайсаар суухыг хараад их гайхжээ. Хейген босч хаалга онгойлгосон даруйд Моу Грин бараг түүнийг түлхэж орхиод том том алхалсаар орж ирэхэд араас нь хоёр бие хамгаалагч дагалдав.

Цэвэрхэн царайтай, мангар биетэй Моу Грин амьдралаа Бруклинд хөлсний алуурчнаар эхэлсэн сэжиг бүхий намтартай хүн бөгөөд Лас-Вегас шиг ийм газрын ирээдүй, бололцоог анх олж хараад бусдаас түрүүлэн энд мөрийтэй тоглоомын газартай зочид буудал барьжээ. Одоо ч гэсэн уур уцаартай үед нь нүдэнд нь өртөх осолтой учир зочид буудлын хүн болгон айж холуур дөлдөг амой.

Тэрээр цэвэрхэн нүүрээ борооны үүлнээс илүү барайлган духайлгаад:

- Майк, хичнээн хүлээх юм бэ? Маргааш ажил жигтэйхэн их болоод өнөөдөр хүчээр шахуу орж ирлээ. Ярих уу, яахав? гэсэнд Майкл Корлеоне найрсгаар инээмсэглэн:

- Тэгэлгүй яах вэ? гэснээ Хейгенд дохио өгөв, - Эрхэм Гринд дарс аягалаач, Том.

Альберт Нери гэж өөрийгөө танилцуулсан эр Моу Гринийг анхааралтай ажиглаж харин цаадах нь бие хамгаалагч нартаа хандан:

- Энэ хүмүүст хожлын хасаа тарааж өг, казинод очиж тоглоцгоог гэсэн нь яах аргагүй Жул, Люси, Жонни Фонтейн, Майклын бие хамгаалагч Альберт Нери нарт хамааруулсан байсан тул Майкл Корлеоне сайшаан толгой дохив.

- Муугүй санаа байна.

Хэдэн минутын дараа өрөөнд зөвхөн Фредди, Том Хейген; Моу Грин, Майкл нар л үлдэж, Грин шилэн аягаа ширээн дээр тавихдаа галзуу уур хилэнгээ арай ядан барьж буй нь илт байлаа.

- Корлеонегийн гэр бүл миний хувийг худалдаж авах гэж байна ч гэх шиг юу ярилцаад байгаа юм бэ? Тэгдэг дээрээ тулбал та нар минийхийг биш, би та нарынхыг худалдаж авах байх шүү!

- Хэний ч санаанд оромгүй юм болж, мөрийтэй тоглоомын газар чинь дампуурч гүйцлээ. Чи нэг л юман дээр алдаж дээ. Бид илүү сайн зохион байгуулж ч юу магад.

Грин бүдүүлэг гэхэд хэтэрмээр чанга хөхрөв.

- Сицилийн дүнхүү толгойнууд минь арай солиороогүй биз? Хүнд байдалд ороход чинь Фреддиг би орогнуулсан. Одоо болоход намайг үлдэн хөөх гээ юу? Ёстой санасны гарз байлгүй дээ! Тус дэм болчхоор найз нөхөд надад ч гэсэн олдоно шүү.

Майкл мөн л урьдын адил тайван, намбатай үгүүлрүүн:

- Корлеонегийн гэр бүл зочид буудлыг засч чимэглэх, мөрийтэй тоглоомын газар нээхэд чинь зориулж ихээхэн мөнгө өгсөн болохоор л чи Фреддиг орогнуулсан. Гэтэл тэнгисийн эргийн Молинаригийн омог Фреддигийн болон чиний наадгайн бизнесийн аюулгүй байдлыг хангасан. Ингэхээр чи бидэнтэй өгөө аваа байхгүй болоо биз дээ. Харин яагаад дургүйцэн дөвчигнөөд байгааг чинь ер ойлгохгүй байна. Хувиа худалдаад өөрийнхөө хэлсэн боломжийн үнэ авахад хохирох юм юу байна? Шударга бус гэж хэн ч хэлэхгүй. Харин ч сүйрч байгаа казиног чинь авч бид буян болж байгаа юм биш үү?

Грин толгой сэгсэрч харагдана.

- За больж үз, чи. Корлеонегийн намын хүч чадал урьдынхаасаа хавьгүй суларсан. Загалмайлсан эцгийн бие муудаж, Таван намынхан та нарыг Нью-Йоркоос түлхэн зайлуулж байгаа болохоор л энд ирвэл амархан хоол олдоно гэж бодсон хэрэг. Чамд л гэж зөвлөхөд, ингэж санасны гарз Майк минь.

- Аа, чи ийм учраас л Фреддиг олны өмнө доромжилж, дэлсээд авсан ч болно гэж бодсон хэрэг үү?

Фредди Корлеонегийн царай час улайчихлаа.

- За боль доо, Майк... Моу хааяа огцом уурлах нь бий л дээ, гэхдээ бид хоёр эв зүйгээ олдог. Тийм биз дээ, Моу?

- Тэгээд яагаа вэ? Бид хоёр биенээ буруу ойлгоод жаахан ухаан суулгах хэрэг гарсан юм гэх Гриний дуунд сэрэмжилсэн өнгө илт цухалзав.

Майкл хайхрамжгүй мэт тэвчээртэй царай гарган ах руугаа харлаа.

- Одоо чи ухаан суугаа юу Фредди?

Фредди хусмаа чамласан хүүхэд шиг хүнхийж духайгаад дүү рүүгээ сэм харсан авч юм дуугарсангүй. Моу Грин шиг хүнд доромжлуулчхаад зүгээр сууж байх нь Корлеонегийн гэр бүлийн нэр хүндийг гутаасан хэрэг. Яагаад эцэг нь түүнд муудсаны учир одоо л олдлоо.

Майкл босч уулзалт өндөрлөснийг мэдүүлэв.

- Би маргааш Нью-Йорк руу буцна. Чи үнэ өртгийн талаар сайн бодоорой.

- Илжиг минь, чи намайг ийм амархан хөөж туучихна гэж горьдсон юм биш биз дээ? Би Нью-

Йорк орж өөрөө Их эцэгтэй ярилцана хэмээн Гринийг архирахад Фредди сэтгэл түгшсэн байртай Том Хейген рүү харлаа.

- Том, чи гарын зөвлөх нь байна, Их эцэгтэй яриад сайн тайлбарлаад өгөөч дээ.

Чухам энэ мөчид л мөс шиг хүйтэн салхинд сөхөгдсөн мэт Майкл жинхэнэ нүүр царайгаа харуулав.

- Их эцэг бараг ажил хэргээсээ хөндийрч, гэр бүлийн бизнесийг үндсэндээ би толгойлж байгаа. Харин Томыг бол би гарын зөвлөхийн албан тушаалаас чөлөөлсөн тул өдгөөгөөс эхлэн тэрээр дан ганц эрх зүйн асуудлыг эрхлэн, хоёр гурван сарын дараа гэр бүлийн хамт энд ирж Вегас дахь миний хуулийн зөвлөхийн хувьд ажил хэргийн хууль зүйн талын асуудлаар хөөцөлдөх болно. Тийм учраас танд хэлэх юм байвал надад одоо л ярь.

Хэн ч хариу дуугарсангүйд Хейген очиж хаалга онгойлговоос Моу Грин, Фредди нар салах ёс хийсэн ч үгүй гарч одов.

Маргааш өглөө нь Моу Грин өөрийнхөө хувьцааг ямар ч их мөнгөөр худалдахгүй гэснийг Фредди дүүдээ хэлсэнд Майкл зөвхөн мөрөө хавчжээ.

- Явахаасаа өмнө Нинотой уулзмаар байна.

Ниногийн өрөөнд ороход Жонни Фонтейн ханзан дээр суугаад өглөөний хоол идэж, харин Ниног эмч үзэж байсан тул унтлагын өрөөний хөшиг хаалттай байв. Хэсэг хүлээсний эцэст Жул Сегал хөшиг яран гарч ирсэнд Майкл тийшээ ороод хүний оронцог болсон нь энгийн нүдээр харахад ч илт Нинотой тав, зургаан минут хэртэй ярилцсаны хойт дээр явахаар бослоо.

- Их эцэгт Юу гэж хэлэх вэ Нино? Тэрээр чамайг! байнга асуух юм.

Нино хормын төдий хуучныхаа байдалд орж доогтой жуумалзав.

- Намайг хоногоо хүлээж байна гэж хэлээрэй. Тэгээд бас шоу бизнес осолтой. Чидун жимсний тос наймаалахаас ч илүү аюултай гэдгийг дамжуулна биз дээ.

Фредди дүүгээ дагалдан явагчдынх нь хамт нисэх онгоцны буудал хүргэж өгчээ. Онгоцонд суусан хойноо Майкл бие хамгаалагч руугаа эргэн:

- За, Аль минь, Моу Гринийг сайн зүсэлж авав уу?.

Альберт Нери хуруугаар духаа тогшиж:

- Зургийг нь аваад угааж буулгаад, дугаар тавьчихсан гэж билээ.

ХОРИН ТАВДУГААР БҮЛЭГ

Нью-Йорк хүрэх онгоцны зөөлөн сандалд сууж явахдаа Майкл Корлеоне биеэ сул тавин тайвширч унтаад, авах гэсэн чинь ер болсонгүй. Түүний амьдралын хамгийн аймшигтай, үйлээр ирсэн золгүй ч байж болох үе ойртон ойртсоор, үүнийг саатуулан хойшлуулах ямар ч арга алга. Бэлтгэл бүх ажил дуусч, юм болгоныг урьдаас тооцоолоод, сэрэмжлэн сэргийлэх бүхий л арга хэмжээ авч энэ бүгдэд хоёр жил зарцуулсан бөгөөд одоо дахиад хойш тавьж яасан ч болохгүй боллоо. Өнгөрсөн долоо хоногт Их эцэг итгэмжлэгдсэн бие хамгаалагч, омгийн бусад гишүүдийг байлцуулан ажил хэргээс хөндийрөн холдох бодлоо албан ёсоор мэдэгдэхэд аавынхаа юу хэлэх гээд байгааг мэдээд өөрийнх нь цаг ирснийг Майкл сайн ойлгож билээ.

Тэрээр төрсөн гэртээ эргэж ирснээс хойш гурван жил өнгөрч, Кейтэй суугаад хоёр жил болжээ. Энэ гурван жилд омог, гэр бүлийн ажил хэрэгтэй танилцан бэлтгэл ажлаа базаж, Том Хейген болон Их эцэгтэй олон цагаар ярилцаж суудаг байхдаа Корлеонегийн гэр бүлийн эд баялаг хүч чадал, эрх мэдэл ямар ихийг мэдээд үлэмж гайхсан аж. Тэднийх Нью-Йоркийн төвд хэмжээлшгүй үнэтэй үл хөдлөх хөрөнгө болох бараг хагас хорооллыг эзэлсэн захиргаа, конторын тэнгэр баганадсан байшингууд, Лонг-Айленд дахь банкны корпорацийн болон оёдлын пүүсүүдийн акцыг эзэмшиж, өөр хүний нэрээр Уолл-стрит дахь брокерийн хоёр пүүст хувь оролцдог оос гадна нууц мөрийтэй тоглоомын газрын өргөн сүлжээтэй байлаа.

Майкл Корлеоне нам, овгийнхоо ажил хэрэгтэй танилцаж байх зуур нэгэн сонирхолтой нээлт хийв. Дайны дараахан тэд хуурамч пянз борлуулдаг бүлэг овжин залуусыг ивээн хамгаалж дориухан мөнгө олж байжээ. Тэр зальжин луйварчид нэрт хөгжимчид дуучдын пянзыг хуулбарлан жинхэнэ үйлдвэрийнх нь дугтуйд хийж худалдаад маш овсгоо гаргасан тул нэг ч удаа баригдаагүй юмсанж. Ийм пянз борлуулсан орлогоноос жүжигчдэд өөрсдөд нь юу ч оногдоогүй нь мэдээж хэрэг. Яг энэ үеэр, хоолой сөөхөөсөө өмнөхөн Жонни Фонтейны пянз маш их гүйлгээтэй байсан учир тэрээр юуны өмнө эл ов мэхтэй ажилбараас үлэмж хохирол амссаныг Майкл яахан анзаарахгүй өнгөрөх билээ.

Их эцэг яагаад загалмай зүүлгэж өгсөн хүнээ монжих бололцоо тэр муусайн луйварчдад олгосныг Майкл Том Хейгенээс асуусанд тэрээр мөрөө хавчлаа. Нэгдүгээрт, бизнес бол бизнес. Хоёрт гэвэл, Жонни тэр үед унаган багын найз хүүхнээсээ салаад Марго Эштонтой гэрлэсний улмаас ивгээлээ алдаад байсан аж.

- Энэ ажиллагаа хожим нь яагаад зогссон юм бэ? Гэнэн хонгорууд баригдчихсан хэрэг үү?

Хейген толгой сэгсэрлээ.

- Зүгээр л Их эцэг, Коннигийн хуримын дараахан тэднийг ивээн тэтгэхээ больчихсон юм.

Түүнээс хойш Их эцэг зарим талаар өөрөө гар оролцсон гай гамшгаас хүмүүсийг аварч хонжоо олдог иймэрхүү зан үйлийг Майкл хожим нэг бус удаа харж билээ.

Кей түүнийг ажлаар яваад буцаж ирэхэд нь бөөн баяр хөөр болдог юм чинь нисэх онгоцны

буудал дээр лав угтаж ирнэ дээ. Майкл өөрөө ч гэсэн авгайгаа их санадаг бөгөөд харин энэ удаад түүнтэйгээ шууд гэртээ харьж чадахгүйн учир гэвэл Майклыг онгоцноос дөнгөж буумагц гурван жил түүнийг хичээнгүйлэн бэлтгэсэн их үйл явдал эхэлнэ. Майклыг Их эцэг өөрөө, бас итгэмжлэгдсэн төлөөлөгч бие хамгаалагч нар хүлээж байгаа. Ингээд л Майкл Корлеоне тушаал заавар өгч өөрийн болон нам омгийнхоо хувь заяаг тодорхойлох шийдвэр гаргаж эхлэх болно доо...

Нэгэн үе Кей Адамс-Корлеоне өглөө эртлэн босч хүүхдээ хөхүүлэх тоолондоо Их эцгийн эхнэр Корлеоне ээж нэг бие хамгаалагчийн хамт цэцэрлэгт хүрээлэнгийн төв байрнаас хаашаа ч юм машинаар яваад цагийн дараа эргэж ирэхийг хардаг байснаа удалгүй учрыг мэджээ. Хадам ээж нь ийнхүү сүмд очиж мөргөл үйлдээд буцаах замдаа байн байн тэднийхээр орж аяга цай уун бага ачаа эрхлүүлдэг байв. Нэг удаа Кей эгзгийг нь тааруулж байгаад католик шашинтан болгон заавал өглөө бүр сүмд очих ёстой эсэхийг асуужээ.

- Үгүй ээ, яах юм бэ? Зарим католик шашинтан Улаан өндөгний баяр, Христосын мэндэлсний өдрөөс бусад цагт сүмд шагайдаг ч үгүй. Ер нь хүн хүний л дурны асуудал шүү дээ.

- Тэгвэл та чинь яахлаараа өдөр өнжилгүй очдог юм бэ? гээд Кейг инээвхийлэхэд Корлеоне ээж бүр нэг ердийн юм ярьж буй мэт хайхрамжгүй дуугаар:

- Би нөхрөөсөө л болоод, түүнийг тийшээ бүү унаасай гэсэндээ очдог гээд шал руу зааж: - Тэгээд, тийш нь очуулах гэж өдөр болгон мөргөдөг хэмээн адар чичлэв.

Ингэхдээ тэрээр ямар нэгэн байдлаар эр нөхрийнхөө дур зоригийг сөрөн эсэргүүцэж байгаа мэт зальжин инээмсэглэж урьдын л янзаар Их эцгийн эзгүйд түүнийг үл тоосон байдлаар ярилаа.

Дараахан нь бараг л ээжтэйгээ зөрөөд сууцны хорооллын цаад захаас Конни Корлеоне хүүхдүүдээ дагуулсаар ирж дэмий баахан ярина. Кей бэргэн дүүгээ хөгжилтэй зан арвитайд нь, ахдаа амиа тавьдагт нь хайртай байдаг бөгөөд өнөөдөр ч гэсэн бэргэн дүү нь Майклыг эр нөхөр Карлод хэрхэн ханддаг талаар шалгааж гарав.

Корлеонегийн гэр бүл, омгийнхон Карлод яаж ханддаг талаар яриа үүсэх болгонд л Конни байж ядан сандарч, магтаалын үгийг тэсч ядан хүлээдгийг Кей аль хэдийн ажигласан байна. Карло-Майклд таалагддаг эсэхийг мэдэх гэж Конни хэрхэн сэтгэл түгшин хөөцөлдөөд байгааг Кей битгий хэл, сохор хүн ч олж харахаар байлаа. Кей нэг удаа энэ талаар нөхөртэйгөө яриа өдөж, яагаад тэдний гэр бүлийнхэн Соннигийн нэрийг одоо хүртэл огт дурсдаггүйг ойлгохгүй байгаагаа нэмж хэлжээ.

Соннигийн алуулдаг тэр шөнө Карло эхнэрээ зодож, тэрээр гэр рүүгээ утасдсан чинь гай болоход Сонни харилцуур аваад ухаан балартлаа уурлан дүүгээ хамгаалж өмөөрөхөөр харайлгасан тухай Майкл дуртай дургүй ярьж өгсөн байна, Чухам энэ хэрэг явдлаас л болоод гэр бүлийнхэн нь тэднийг Соннигийн мөхөлд шууд бусаар ч гэсэн гэм буруутайд тооцдог юм биш байгаа гэсэн асуулт Конни, Карло хоёрыг байнга зовоох болжээ. Гэвч тэр хоёрыг хэн ч буруутгаагүй гэж Майкл авгайдаа тайлбарлаж өгөв. Тэднийг Их эцгийн эдлэн газар нүүлгэн

авчирч, үйлдвэрчний эвлэлийн тамгын газарт Карлог чухал ажилд итгэн томилсон нь үүнийг гэрчилнэ. Нам омгийнхон сүүлийн хоёр жилд түүний хийсэн ажил, зан аашийн талаар сэтгэл хангалуун байгаа гэнэ.

- Тийм л юм бол хэзээ ч, юм, нэг орой тэр хоёрыг урьж, энэ бүхнийг тайлбарлаад дүүг чинь тайвшруулбал яасан юм бэ? Хөөрхий дүү чинь шаналж тарчилж гүйцлээ. Эсвэл чиний ярьсныг би өөрөө түүнд хэлэх үү?

Яг ингэх нь зүйн хэрэг гэдэг нь хэнд ч ойлгомжтой атал Майкл хариугаа маш удаан бодсон нь тун гайхалтай.

- Минийхээр бол хэрэггүй байх аа, Кей. Ямар ч тус болохгүй, юу ч ярьж, юу ч хийлээ гэсэн Конни санаа зовсон хэвээр л байх болно.

- Гэхдээ Соннигийн үхэлд үнэхээр түүнийг буруутгахгүй байгаа биз дээ?

Майкл гүнзгий шүүрс алдлаа.

- Үгүй байлгүй яах вэ? Тэр чинь миний хамгийн хайртай ганц эмэгтэй дүү. Карло хэдийгээр засарсан ч гэсэн түүнд таарч тэнцэхээр эр нөхөр нь яав ч биш, гээд одоо яая гэх вэ. За за энэ тухай ярихаа больё.

Майклыг Лас-Вегасаас ирэх өдөр Рокко Лампоне урт хар лимузинээр Кейг нисэх онгоцны буудалд авчирчээ.

Түүнийг Том Хейген, шинэ бие хамгаалагч Альберт Нери хоёрын хамт онгоцны шатаар бууж явахыг нь Кей харж байтал тэр Альберт юугаараа ч юм Люка Бразитай адилхан санагдаад гэнэт дургүй нь хүрсэнд их гайхсан аж. Гэтэл чухам тэр Альберт л хурсан олны дотор түүнийг түрүүлэн олж хараад Майклд зааж өгөв.

Кей нөхрийнхөө өөдөөс гүйхээрээ очиж тэврэн авахуй тэрээр авгайгаа бушуухан үнсчихээд жаахан зайлуулж, оройжингоо эцгийн дээ байж ажлаа тайлагнах ёстойгоо хэлсэнд Кей өөрийн эрхгүй хөмсөг зангидлаа.

- Кей чи минь уучилж үзээрэй. Харин маргааш хоёулаа зад наргиж, орой нь театрт очиж, зоогийн газраар орно гэснээ Майкл жирэмслээд долоон сар болж буй гэргийнхээ гэдсийг аяархан алгадав. - Аягүй бол чи хүүхдээ гаргаад гэрээсээ гарч чадахаа байчихна биз дээ. Жил бүр хүүхэд цувуулаад яг л итали эхнэр шүү. Бас тэгээд өөрийгөө америк хүүхэн гээд байгаа, болоогүй.

Кей мөчөөгөө өгсөнгүй хариу ёжилж:

- Чи тэгвэл жинхэнэ америк нөхөр юмаа. Орон гэртээ орж ч амжаагүй байж ажил яриад унах юм. Бас тэгээд болоогүй, өөрийгөө итали хүн гээд байгаа! Ядахдаа хэт оройтохгүй юм байгаа биз дээ? гээд доогтой жуумалзав.

- Арван хоёроос өмнө харих байх аа. Нойр чинь хүрвэл намайг хүлээсний хэрэггүй биз дээ.

- Би хүлээнэ ээ.

Орой нь эрхэм Корлеонегийн байшингийн булангийн өрөөнд Их эцэг, Майкл, Том Хейген, Карло Рицци, хоёр итгэмжлэгдсэн төлөөлөгч Клеменца, Тессио нар зөвлөгөөн хийхээр цугларав. Урьд нь бараг л төрөл төрөгсөд шиг бие биедээ найр тавьдаг байсан бол энэ удаад тэд сэтгэл түгшин биеэ барьж сэрэмжилсэн байртай байх бөгөөд ийм байдал эрхэм Корлеоне нам омгийн тэргүүний үүрэгт ажлаас хэсэгчлэн таггалзаж, түүнийгээ Майклд шилжүүлж байгаагаар зарласан өдрөөс хойш үргэлжилсээр ажээ. Гэр бүлийн синдикатад дандаа л хүү нь эцгээ орлодог гэвэл худлаа болно. Эднийхээс өөр омог бол Клеменца, Тессио хоёрын зиндааны итгэмжлэгдсэн төлөөлөгч их эцгийг залгамжлахаар оролдож болохсон билээ. Үгүй ядахдаа өрх тусгаарлан салж өөрийн намаа байгуулахаар зүтгэж болох л байсан.

Түүнээс гадна эрхэм Корлеонегийн өөрийнх нь санаачилгаар Таван том намтай энхийн гэрээ байгуулснаас хойш эдний омгийн хүч чадал буурсан нь мэдрэгдэж байв. Барзини одоо Таттальяатай холбоо байгуулан Нью-Йоркийн хамгийн хүчирхэг нам болж, урьд өмнө Корлеонегийн эзэлж байсан байр суурийг эзлэх болжээ. Түүгээр ч үл барам тэд Корлеонегийн омгийн хүчийг далдуур элээн сулруулж, мөрийтэй тоглоомын бизнесээс аажим аажмаар шахан зайлуулахдаа тийш нь өөрийн бооцоологчоо оруулж, жаахан хүлээж байгаад ямар ч хариу арга хэмжээ авахгүй болохоор нь дараагийнхыг суулгадаг боллоо. Эрхэм Корлеоне ийнхүү ажил хэргээсээ хөндийрсөнд Барзини, Татталья хоёр ёстой л алдсан морио айлын хашаанд олж харсан хүн шиг баярлажээ. Майкл ажил хэрэгтээ дадаж юу чаддагаа харуултал хэзээ ч билээ, лав л арван жилээс нааш алсын хараа, нэр нөлөөгөөрөө эцэгтэйгээ эн зэрэгцэхгүй нь лавтай. Корлеонегийн намын уналт доройтлын өдрүүд ирсэн нь хэнд ч эргэлзээгүй.

Эдний нам хэд хэдэн ноцтой цохилт хүлээж, урагшгүй явдалд өртжээ. Фредди хичээгээд хичээгээд зочид буудлын эрхлэгчээс өөдөө гарахгүй нь илэрхий болсны хажуугаар Соннигийн үхэл тус омгийн хувьд жинхэнэ гамшиг байв. Сонни бол тоомсорлохгүй байхын аргагүй аймшигт хүч байжээ. Ер нь Загалмайлсан эцэг шиг ухаантан хүн ирланд эрийг гарын зөвлөх болгодог нь л уучилж болшгүй том алдаа болсон юм. Нарийн арга заль, хорон санаагаараа ирланд хүн жинхэнэ сицили эрийн хаана нь хүрэх юм бэ?... Бусад нам омгийнхон иймэрхүү янзаар сэтгэн бодоод Корлеонег биш, харин Барзини-Таттальягийн холбоог илүү хүндэтгэх болжээ. Майклын хувьд гэвэл, тэрээр сэтгэлийн хатан зоригийн хувьд Соннид хүрэхгүй, гэхдээ оюун ухаанаар түүнийг давах боловч эцгээсээ төө дутуу, нэг үгээр хэлэхэд дунд зэргийн хэр тааруу эр тул ийм залгамжлагчаас онц айж эмээх зүйлгүй гэж бүгд үзсэн аж.

Түүнээс гадна Их эцгийн энх тайвныг тогтоож чадсан дипломат аргын урныг бүгд шагшин сайшаах боловч Соннигийн өшөө аваагүйг нь үл ойшоон, хүч дутсандаа л цус урсгахын оронд манж зан гаргалаа гэж бүгд бодсон байна.

Энэ бүхнийг эрхэм Корлеонегийн мухрын өрөөнд сууж буй хүмүүс бүгд мэдэхээс гадна зарим нь ч бүр ийм үзэл бодлыг хуваалцдаг ч байв. Карло Рицци Майклыг ихэд таалах боловч тухайн үедээ Соннигоос айж эмээдэг байсан шигээ түүний өмнө сүрдэн чичрэх нь үгүй. Клеменца ч гэсэн Түрэг, цагдаагийн ахмад хоёрыг устгах ажиллагааг овжин хийснийх нь хувьд Майклыг зүй ёсоор үнэлэх хэдий ч сэтгэлийнхээ мухарт түүнийг Их эцэг болж

чадахгүй гэж үзнэ. Корлеонегийн омгоос салан тусгаарлаж өөрийн эзэнт улс байгуулах бололцоо олгоно гэж Клеменца найдсан авч Их эцэг ингэж найдаад нэмэргүйг ойлгуулсан тул тэрээр түүнийг хүндэтгээд үгэнд нь оржээ. Гэхдээ цаг нь ирэх хүртэл хүлээхээр хатуу шийдсэнийг хэн ч мэдсэнгүй.

Харин Тессио бол Майклыг илүү үнэлж, энэ залуу эрийн чадамгай нуун халхалсан сэтгэлийн хүч тэнхээ, жинхэнэ хэрэг дээрээ юу хийж чадахаа бусдын нүднээс далд байлгах гэсэн атгаг хүслийг нь таан мэдсэн байна. Анд найз бол сайн талыг чинь дутуу үнэлж, атаат дайсан бол сул талыг чинь хэт үнэлж байвал хэзээ ч ашигтай гэсэн Загалмайлсан эцгийн сургаалын үр аргагүй л шимт хөрсөнд унасан гэлтэй.

Харин Их эцэг, Том Хейген хоёр л Майклын жинхэнэ, үнэ цэнийг мэдэж байлаа. Хэрэв Загалмайлсан эцэг хүүгээ Корлеонегийн намын урьдын хүчирхэг байр суурийг сэргээж мандуулж чадна гэдэгт бүрэн итгэлтэй байгаагүй бол намын тэргүүний үүргээсээ өөрөө татгалзах бодол толгойд нь орох ч үгүй байсан юм. Хейген хоёр жил Майклын сургагч багш байсан нь талаар өнгөрсөнгүй, тэр залуу эр гэр бүлийн бизнесийн ур ухааныг явуут шүүрэн ухаарч авахыг шагшин харж, нээрээ л эцгээ өвчсөн хүү юм даа гэж гайхан магтана.

Майкл Клеменца болон Тессиогийн журам сахиулагчдын тоог хорогдуулж, Соннигийн дайчин эрсийн ээлж халааг сэргээх арга хэмжээ аваагүйд тэр хоёр үлэмж дургүйлжээ. Эдүгээ Корлеонегийн нам үнэн хэрэгтээ хоёрхон, тэгэхдээ бас хүч нь суларсан зэвсэгт бүлэгтэй болсон байна. Итгэмжлэгдсэн хоёр төлөөлөгч ялангуяа Барзини, Татталья хоёр тэдний эзэмшил газар, эрх мэдлийн бизнес рүү халдан довтолж буй нөхцөлд ийм алмай байдлыг амиа хорлож үхсэнтэй адил хэрэг гэж үзжээ. Их эцэг чухам л энэ алдааг засахаар онц чуулганыг зарласан хэмээн тэр хоёр найдаж ирсэн юмсанж.

Майкл ярианыхаа эхэнд Вегаст явсан тухай, мөн Моу Грин мөрийтэй тоглоомын газрын хувьцаагаа худалдахаас татгалзсан тухай мэдээлээд:

- Гэхдээ түүний татгалзаж чадахааргүй тийм зүйлийг бид санал болгоно. Корлеонегийн нам ажил хэргийн үйлдлээ Өрнөд рүү шилжүүлэх бодолтой байгааг та бүхэн мэдэж байгаа. Манай гэр бүлийн бизнесийн үндэс нь Полос дахь мөрийтэй тоглоомын газартай дөрвөн зочид буудал болно. Гэхдээ энэ бүхэн гэнэт хийгдэхгүй, үүнд цаг хугацаа хэрэгтэй гээд Клеменцагийн нүүр рүү эгцлэн ширгэв. - Пит ээ, Тессио чи ч гэсэн сонс. Энэ нэг жилийн турш та хоёр хэзээ ямагт надтай хамт байж, үг дуугүй захирагдах ёстой. Энэ хугацаанд бид эв найртай хамтран ажиллах нь мэдээж. Харин түүнээс хойш тусгаарлаж өөрсдийн намаа байгуулж болно. Юуны талаар ч санаа зовсны хэрэггүй. Та нарт болж бүтэшгүй мэт санагдах асуудлыг шийдэхээр хэлэлцээ хийж байгаа. Одоохондоо тэвчээртэй хүлээж л байх хэрэгтэй.

Тэр хоёроос Тессио түрүүлэн ам нээж:

- Моу Грин эцэгтэй чинь уулзъя гэж байхад чи яагаад дургүйцсэн юм бэ? Их эцэг хэнийг ч ятган ухамсарлуулж чадна шүү дээ гэвэл энэ удаад Их эцэг өөрөө хариу өчив.

- Би ийм асуудлыг шийдэхээ больсон. Хэрэв би хөндлөнгөөс оролцсон бол Майклын нэрийг бусдын дунд муудуулах байсан. Тэгээд ч би тэр хүнтэй уулзаж учирлаж тайлбарлахыг үл

хүснэ. .

Тессио дотроо Их эцгийн энэ үгийг нэгэн удаа Моу Грин Лас-Вегасын зочид буудалд олны нүдэн дээ Фредди Корлеонег нүүр нүдгүй зодсон гэх дам яриатай харьцуулж үзээд бүгдийг ойлгов... Ингэхлээр нэгэнт Корлеонегийн нам ятгаж сэнхрүүлэхийг үл хүсэх учир Моу Грин хорвоо дээр тоос хөдөлгөх хоногийн тоо гүйцэж байгаа юм байна.

Энэ үеэр Карло Рицци ярианд оролцон:

- Тэгэхлээр Корлеонегийн гэр бүл Нью-Йорк дахь ажил хэргийн бүх үйлдлээ зогсоож байгаа юм уу? гэхэд Майкл толгой дохилоо.

- Чидун жимсний тос гадаадаас оруулж борлуулах компанийг худалдана. Харин бусад бололцоотой бүгдийг Тессио, Клеменца хоёрын мэдэлд өгнө. Карло чи ч гэсэн ажилгүй үлдэнэ гэж бүү санаа зов. Чи Невадад төрж өссөн нутаг ус хүн зоноо сайн мэдэх учир биднийг тийшээ нүүж очихлоор баруун гар минь болно гэж найднам.

Карло сэтгэл хөөрч баярласандаа бүр чавга шиг улайж орхив. Түүний ч гэсэн од хийморийн цаг ирж эрх мэдэл гартаа атгасан шилмэл хүмүүсийн хүрээнд багтах нь энэ дээ!

Майкл үргэлжлүүлэн:

- Энэ өдрөөс эхлэн Том Хейген гарын зөвлөх биш, Вегас дахь манай хуулийн зөвлөх болно. Хоёр сар хэртэй болоод тэрээр эхнэр хүүхдийн хамт тийшээ нүүж суурьших болно. Одоо хэн ч хууль зүйгээс бусад асуудлаар түүнд хандах хэрэггүй. Гэхдээ энэ нь түүнийг ажил төрөлдөө таарч тэнцэхгүй боллоо хэмээн нэр хүндийг нь хөөдөж байгаа юм биш шүү, би зүгээр л аваас минь илүү гарын зөвлөх хаанаас олох вэ? гэсэнд бүгд инээлдэв.

Хэдийгээр Майкл ингэж наргиан болгосон ч гэсэн юу ч өөрчлөгдсөнгүй, нэгэнт л Томын эрх мэдлийг хумьж л байгаа хойно яах бол хэмээн бүгд хулгай харц шидэлтэл Хейген ер тоосон шинжгүй хэнэггүй царайлах ажээ.

Тессио хэсэг бодолхийлснээ тайван үгүүлрүүн:

- Журам сахиулагч нар нэмж авахыг чи бидэнд зөвшөөрсөн нь дээр байх аа. Өдрөөс өдөрт миний мэдлийн дэвсгэр нутгаас өмөлж аваад байгаа тэр Барзинигийн малуудыг нэг сайн хашраагаад өгмөөр байна, Майкл аа.

- Үгүй, тэгж хэрхэвч болохгүй. Өрвөгнөж овогнохын оронд зүгээр л чимээгүй сууж бай. Тэр бүхнийг чинь бид Невада руу нүүхээсээ өмнөхөн учрыг нь олчихно.

Тессиод энэ хариулт хангалтгүй санагдсан бололтой Майклын уурыг хүргэхээсээ ч айлгүйгээр толгой дээгүүр нь даван эрхэм Корлеонед хандан:

- Уучилж үзээрэй, Загалмайлсан эцэг минь, олон жил үерхэж, эвтэй найртай явсандаа л болоод хэлж байгаа юм шүү. Миний бодоход, Майкл та хоёр алд дэлмээр алдаж байх шиг. Ар талдаа, энд олигтой хүч дээр түшиглээгүй байж Невадад яаж амжилт олох юм бэ? Тэгээд бас

та нарыг нүүгээд явчихлаар Пит Барзини-Таттальягийн холбоог сөрөн тэмцээд яасан ч дийлэхгүй, Тэр их хүчтэй. Корлеонегийн нам хүчээ зузаатгаж байж л ийм алхам хийх ёстой гэж би хэлмээр байна. Бид юуны өмнө зэвсэглэсэн бүлгээ бэхжүүлж, булаалгасан газар нутгаа дор хаяхад Статен-Айленд дахь дэвсгэр нутгаа буцааж авах хэрэгтэй байна гэхэд Их эцэг толгой сэгсрэв.

- Миний эвлэрэн найрамдсаныг чи мартаад байна. Би хэлсэн үгэндээ эзэн болох ёстой.

Ингээд зөвлөгөөн өндөрлөлөө. Тохиролцсон гол зүйл гэвэл, ойрын ирээдүйд Клеменца, Тессио хоёр журам сахиулагч нар дээрээ үндэслэн өөр өөрсдийн гэр бүлийн синдикат байгуулж болохоос гадна Тессио Бруклин дахь мөрийтэй тоглоомын болон хөлөг онгоцны засварын газруудыг авч харин Манхэттены мөрийтэй тоглоомын бизнес, Лонг-Айлендын морин тойруулгын бооцоон дахь Корлеонегийн намын хувь хэсгийг Клеменца эзэмших болов.

Хоёр итгэмжлэгдсэн төлөөлөгч далдуур төрсөн эргэлзээгээ тас нуусаар сэтгэл дундуур гарч одоход Карло Рицци эхнэрийнхээ төрөл төрөгсдийн дунд одоо л өөрийн хүнд тооцогдох болов уу хэмээн горьдож үлдсэн боловч Майкл ер тэгэх янзгүй байгааг даруй ойлголоо. Альберт Нери түүнийг хаалга хүртэл үдэж, тольдуурын хурц гэрэл туссан сууцны хорооллын цаад зах руу алхахдаа Нери шатан дээр зогсоод араас нь нүд салгалгүй ажиглаж буйг мэджээ.

Их эцэг, Том Хейген, Майкл гурав дэндүү олон жил нэг дээвэр дор амьдарч, нэг тогооноос хоол идсэн тул амихнаараа үлдсэн даруйд л мухрын өрөөний уур амьсгал илт дотно нөхөрсөг боллоо.

Том Хейген эхэлж анир чимээгүйг эвдэн:

- Майкл чи яагаад намайг гол ажил хэргээс холдуулж байгаа юм бэ? гэвэл цаадах нь үнэхээр гайхсан мэт:

- Вегас очоод чи миний хамгийн чухал хүн болно шүү дээ. Бид одоо бүрмөсөн хууль ёсны үйл ажиллагаа явуулахад чи гол хуульч нь болно. Үүнээс дээгүүр албан тушаал хаана байгаа юм бэ? гэхэд Хейген гунигтай инээмсэглэв.

- Би тэр тухай биш, харин Рокко Лампонег надад мэдэгдэлгүйгээр зэвсэглэсэн бүлэг байгуулж байгаа тухай, чи Неритэй харилцахдаа намайг ч алгасч шууд ярилцдаг тухай л хэлээд байна. Далимд нь дурдахад чи Лампонег сонгож авснаараа оносон байна билээ, ямар ч өө сэвгүй ажиллаж байгаа шүү.

Майкл өөрийгөө ч юм уу, хэнийг ч юм, голсон байртай ярвайлаа.

- Нохой долоо гэж, чи олоод л мэдчихсэн болохлоор тийм ч олигтой ажиллаж чадаагүй л байна даа. Ямар ч гэсэн түүнийг би биш, Их эцэг сонгож авсан.

- Энэ тийм чухал бус. Тэгээд чи яагаад намайг зайлуулж байгаа юм бэ?

Майкл түүний нүд рүү эгцлэн ширтлээ.

- Том минь ээ, дайн зарласан цагт чи гарын зөвлөхийн рольд тэнцэхгүй. Гэтэл нөхцөл байдал хурцдаж бид алалдан тулалдахад хүрэхийг үгүй гэх газаргүй болоод байна. Юмыг яаж мэдэх вий гэсэндээ л би чамайг халуун цэгээс холдуулж байгаа юм.

Хейген час улайчлав.

- За, тэр тийм гэж бодъё. Одоо өөр нэг юм хэлэхэд чамайг хүч чадалдаа аархсан биш, сул доройдоо айсан хүний ажил үйлдэл хийлээ гэсэн Тессиотой би санал нэг байна. Энэ чинь муу. шүү. Өлөгчин чоно Барзини чамайг тасар татаж хэмлээд ирэхийн цагт бусад нам овгоос хэн нь ч тусламжийн гар сунгахгүй гэж мэдээрэй.

Одоо Их эцгийн ам нээх ээлж болжээ.

- Том, үүнийг Майкл бор зүрхээрээ шийдсэн бус, би зөвлөсөн юм; Аль ч талаараа миний сэдсэн байж үл болох арга хэмжээ бид авахаас өөр аргагүйд хүрч ч болзошгүй тул би ингэж шийдсэн билээ. Би чамайг зөвлөгч гэж хэзээ ч бодож яваагүй учир надад бүү гомдоорой. Би Майклд зуун хувь итгэдэг шиг чамд ч бүрэн итгэдэг. Энд удахгүй эхэлж болзошгүй цус асгаруулсан хэрэг явдалд одоогоор хэлж үл болох шалтгаанаар чи яасан ч оролцож болохгүй. Энүүхэндээ гэхэд, Лампонегийн нууц бүлэг чиний хараанаас зайлахгүй гэж би Майклд хэлээд л байсан юм. Миний чамд итгэдгийн баталгаа энэ биш гэж үү?

Өөрийг нь аргадан ая засч буйг Хейген ойлгож байв.

- Би энд хэрэг болох юм биш үү?

- Үгүй, чи явсан нь дээр, Том оо.

- Чамайг зэмлэж байгаа юм биш шүү, Майк, зөв ойлгоорой. Чи бараг юугаараа ч ааваасаа дутах юм алга. Гэхдээ ганцхан зүйлийг л сурах хэрэгтэй дээ.

- Юу тэр вэ?

- Хүмүүст яаж «үгүй» гэж хэлэхийг сур.

- Чиний зөв. Би хойшид анхааръя гээд Майкл Том Хейгенийг гарсны хойт дээр тоглоом шоглоомын хооронд аясаар эцэгтээ хандан:

- За ингээд та надад бүхнийг зааж өглөө. Одоо хүмүүсийн сэтгэлд юм хийчихгүйгээр яаж татгалзахыг л хэлж өгөх үлдээ шив дээ гэсэнд Их эцэг нэгэн нүсэр том ширээний ард очиж суув. Ер нь өөрийн таалдаг, хайртай байдаг хүмүүстээ "үгүй" гэж хэлж болохгүй, ядахдаа л олон дахин хэлэх хэрэггүй. Үүнд л хамар нууц нь байгаа юм. Тун аргагүйдвэл чиний "үгүй" гэсэн үг чинь "за" гэж байгаа юм шиг сонсогдох ёстой. Эсвэл тэднээр өөрсдөөр нь "үгүй" гэж хэлүүлэх хэрэгтэй. За яамай, би хуучнаараа сэтгэж байж магадгүй. Чам шиг орчин үеийн залууст юугаа ч сургах билээ больё цаашаа.

Майкл ходоодны мухраас тас тас хөхөрч:

- Гэхдээ Том энэ хэрэгт оролцоод дэмий гэдгийг та зөвшөөрч байгаа биз дээ? гэхэд Их эцэг толгой дохив.

- Тийм ээ, холхон байсан нь өлзийтэй.

- Би зөвхөн Аполлония, Сонни хоёрын өшөө авах гэсэндээ ч ийм хэрэг сэдсэн биш гэдгээ танд хэлэх цаг болсон байх аа. Барзинигийн талаар Тессо, Том хоёр үнэнийг хэлсэн болохоор ингэхээс өөр аргагүй байлаа.

Эрхэм Корлеоне дахиад л бодлогошрон толгой дохив.

- Өс Хонзон гэдэг чинь хөргөн байж идвэл адууны мах шиг илүү амттай хоол шүү. Чамайг эсэн мэнд эргүүлж авчрах өөр арга байсан бол би яасан ч найрамдал байгуулахгүй сэн. Гэтэл Барзини юуг ч үл тоомсорлон чамайг хороох оролдлого дахин хийсэн нь хачирхалтай.

- Түүнийгээ бас эрхэм Томмазиногийи амь насанд халдсан болгох гэж нүд хуурсныг нь яана? Бараг таны ч тааж мэдэхээргүй тун овжин ажилласан шүү. Гагцхүү тэдний аз дутахад би амьд үлдчихсэн юм.

- Тэр хоньчин залууг олсон уу?

- Жилийн өмнө би өөрөө эрж явж олсон. Өөр хүний нэр дээр хуурамч паспорт хийлгэж өвөртлөөд өгөр толгой Фабрицио чинь Буффалод пиццаны газар нээчихсэн тун додигор байдаг шүү.

Их эцэг харц доошлуулан тэргүүнээ, гудайлгав.

- Тэгэхлээр одоо хойшлуулах шаардлагагүй болоо шив дээ. Хэзээ эхлэх гэж байна даа?

- Юмыг яаж мэдэх вэ, ямар ч гэсэн Кейгийн амаржихыг харзная. Бас Том маань эндээсээ бүрэн хөндийрч Вегаст суурьшиг даа. Жилийн дараа л эхэлье гэж бодож байна.

- Чи бүгдийг тооцоолж сайн тунгаасан биз дээ?

Майклын сэтгэл үлэмж уярчээ.

- Үүнд та ямар ч хамаагүй, би л толгойгоороо хариуцна. Их эцэг нилээд удаан дуугүй сууснаа гүн шүүрс алдав.

- За тийм байдаг байж. Ингэнэ ч байх гэж бодоод би ажил хэргээс хөндийрч, бүх эрх мэдлээ чамд шилжүүлсэн юм. Би энэ амьдралдаа хийх юмаа хийчихсэн хүн, үүнээс илүү яах ч билээ дээ. Ер нь зарим тохиолдолд хүлээсэн журамт үүрэг ямар ч бат хүчийг нугалдаг юм байна. Эхэлбэл эхэл дээ.

Гэвч Кей Адамс Корлеоне он гарахаас өмнө нярайлж, дахин хүү төрүүлэв. Түүнийг

эмнэлгээс гараад цэцэрлэгт хүрээлэнгийн төв байранд ирэхэд яг л гүнж шиг хүндэтгэн угтав.

Бас л тэр он дуусахаас өмнө Нино Валентигийн тархинд цус харваж нас барав. Үүнээс хэдхэн долоо хоногийн өмнө Ниногийн гол дүрд нь тоглож урьд үзэгдээгүй их амжилт олсноор түүнийг дэлхийн киноны тэргүүн оддын эгнээнд оруулсан киног Жонни Фонтейн дэлгэцнээ гаргасан учир сонин сэтгүүлийнхэн сүйд майд болж эхний хуудасны нүүрэнд мэдээлжээ. Нэг удаа Жонни Фонтейн ярилцлага өгөхдөө найзыгаа хүчээр ч хамаагүй эмнэлэгт хэвтүүлэх байсан, тэгсэнгүй байсаар байгаад алдлаа хэмээн өөрийгөө хараан зүхсэн боловч хүмүүс түүнийг нь тоосонгүй. Нино Валентиг чухамдаа Жонни Фонтейн л киноны од болгоогүй гэж үү? Үнэнч нөхөрлөлийн өөр ямар гэрчилгээ хэрэгтэй юм бэ?

Их эцэг өөрөө Калифорни ормоор байсан чинь гэнэт зүрхээр нь хатгуулаад сар гаруй хэвтэж байгаа тул Ниног оршуулахад Альберт Нери Корлеонегийн намын албан ёсны төлөөлөгчөөр иржээ.

Ниног оршуулснаас хойш хоёрхон хоногийн дараа Моу Гринийг голливудын нэрт жүжигчин хүүхний байшинд үүлэн борооны ажлынх нь үед буудаж алжээ. Альберт Нери Голливудаас шууд Карибын тэнгис рүү явснаа пад хар болтлоо наранд шарж сайхан амарсан тэр залуу гурван долоо хоногийн дараа Нью-Йоркод эргэж ирээд үүрэгт ажилдаа оров. Майкл Корлеоне түүнийг угтахдаа нүүр дүүрэн инээмсэглэх атлаа магтаалын үг ховорхон унагах зуур Нери энэ өдрөөс эхлэн тэдний намын мэдлийн Ист-Сайд дахь мөрийтэй тоглоомын газрын орлогыг цалин дээрээ нэмж авах болсныг мэдэгдэж амжсан байна. Нери оногдсон ажлаа шударга сайн биелүүлсэн хүнийг зүй ёсоор үнэлж, гавьяа зүтгэлээр нь шагнаж урамшуулдаг ертөнцөд амьдарч байгаагаа ухамсарлан сэтгэлээ сүлээд тун додигор амьтан Майклын өрөөнөөс гарч оджээ.

ХОРИН ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Майкл Корлеоне өчүүхэн зүйлийг хүртэл харгалзан үзэж бүгдийг урьдаас тооцоолоод урьдчилан сэргийлэх бүх арга хэмжээг авсны дараа бэлтгэлээ бүр мөсөн дуусгахаар бүтэн жил тэвчээртэй хүлээжээ. Гэвч хувь заяа нь түүнд хүсэн мөрөөдсөн жилийн хугацааг нь олгож гялайлгасангүй. Хэний ч санаанд ороогүй байтал Загалмайлсан эцэг, бүхнээс хүчирхэг Их эцэг өөрөө Майкл Корлеонег хөөдсөн байна.

Тэр нэгэн нарлаг өглөө, эмэгтэйчүүд сүм рүү явсан хойно Вито Корлеоне ногооны газар ажиллахдаа өмс дөг өвдөг гарсан хуучин муу саарал өмд, гандуу цэнхэр цамц, үрчийж халтартсан бүрхээ углав. Их эцэг сүүлийн жилүүдэд жин их нэмэн, эрүүл мэндээ бодоод л улаан лооль суулгаж байгаа гэж ярих боловч шал худлаа гэдгийг нь бүгд мэдэх бөлгөө.

Үнэн хэрэгтээ бол тэрээр ногооныхоо үелээ даланг засч янзлан айдас жихүүдэс уй гашуу эцгийн нь үхлээр гутааж харлуулаагүй бага нас, Сицили нутгийг нь санагдуулах тул өглөө эртлэн босч түүнийгээ харах дуртай аж. Түрэг шош дээгүүрээ жижгэвтэр цагаан цэцгээр чимэг зүүж, ногоон сонгинын болцгор түрүү газрын хөрснөөс шивээлэн цухуйжээ. Талбайн захад идэшний ногооны хамгийн сайн бордоо болдог үхрийн шингэн баастай торхнууд хүндэт харуулд ярайж, хажууханд нь их эцгийн өөрөө хийсэн сараалжин мод дагаад улаан лоолийн хэлхээ өөдөө авирсан харагдана.

Нар дээшилж, усны дусал болгонд гал болон цацраад шанцайн навчийг цоо түлэхээс нь өмнө усалгаагаа дуусгах гэж Их эцэг их яарсны хэрээр яг л хугацаандаа амжив. Нар хэдийн зулайг нь төөнөж эхлээд эрхэм Корлеоне өөрөө өөртөө «Боллоо, больж үз» хэмээн дотроо сануулан одоо энэ сүүлийн даланд л хэдэн гадас шаагаад харья гэж бодтол гэнэт нар доошлон чанх толгой дээр нь буух шиг болсноо өвдөг сөхөрсөн өвөө рүүгээ харайлган хүрсэн Майклын том хүүг нүд сохлом шар дөл халхлаад авав. Гэвч хөлөө хэмлэж байж хавхнаас мултарсан чоно шиг хашир Их эцэг үүнд хууртсангүй, шар дөлтэй хөшигний цаана тамын хар үхэл яг харайн үсрэхээр зэхсэнийг мэдмэгц жаал хүүг түлхэн холдуулж амжив. Дахиад эгшин л өнгөрсөн бол дээрээс нь дарж унах байжээ. Цээж рүү нь хүнд лантуугаар цөм цохих шиг санагдан амьсгаа нь давчидсанаа Их эцэг улаан нүүрээрээ газар харуулдан ойчлоо.

Майкл Корлеоне харуулын хэдэн хүнтэй гүйхээрээ хүрч очоод уруугаа харж, гараараа газар самардан хэвтээ Их эцгийг өргөн чулуун хавтан дэвссэн хашааны сүүдэрт хэвтүүлэв. Майкл аавынхаа гараас атган өвдөг сөхөрч бусад нь эмч «Түргэн тусламж» дуудахаар харайлгасан хойгуур Их эцэг хүүгээ эцсийн удаа харахаар хүний хэрээс хэтэрсэн хүч гарган нүдээ нээхэд наранд борлож улаа бутарсан царай нь бүтэн цус харвалтын улмаас цэлдэн хөхрөөд сүүлчийн мөч ирсэн нь илэрхий ажээ. Тэрээр далангийн хар шорооны анхилуун эхүүн үнэрийг эцсийн удаа амьсгалтал нүдэнд нь шар дөлөн хөшиг дахин маналзаад зөвхөн:

- Амьдрал мөн ч сайхан аа? хэмээн шивнэж л амжлаа.

Хувь тавилан эмэгтэйчүүдийн нулимс харж шаналах зовлонгоос түүнийг ангижруулж, Их эцэг тэднийг сүмээс ирэхийн өмнө, эмч болон «түргэн тусламж»-ийг ч ирэхээс урьд, хайртай хүүгийнхээ гарыг атган атгасаар насан өөд боллоо.

Загалмайлсан эцгийг, яг л эзэн хаан лугаа адил хүндэтгэлтэйгээр оршуулж Тессио, Клеменцагийн битгий хэл, том Таван нам өөрсдийн их эцэг, итгэмжлэгдсэн төлөөлөгч нараа ирүүлснээс гадна Жонни Фонтейн хүртэл Майклыг хориглосоор байтал оролцож энэ тухай сонин хэвлэл нэн даруй улс орон даяар тараажээ. Өнө эртний заншил ёсоор салах ёслолыг талийгаачийн гэрт хийсэн бөгөөд авсанд ойртож очсон хүн болгон агуу их Загалмайлсан эцгийн нүүрнээс үхэл ч гэсэн нэр төрөө эрхэмлэх ихэмсэг сүрлэг байдлыг нь арилгаж чадсангүйг тэмдэглэн хэлэхэд Америго Бонасера Их эцгийн царай ямар аймшигтай байсныг нь ганцаараа мэдэх тул өөрөө өөртөө баярлан бахархаж цээжээ улам түхийлгэв.

Хуучин найз нөхөд, ойр дотнын хүмүүс цөм цугласны дотор Назорини эхнэртэйгээ, охин нь нөхөр хүүхдийн хамт, мөн Сан-Франциско, Лос-Анжелес, Бостон, Кливлендийн их эцэг нар байснаас гадна Люси Манчини, Фредди, Том Хейген гэр бүлийн хамт Лас-Вегасаас нисэх онгоцоор иржээ. Орон сууцны байшин болгонд гадна дотногүй амьд цэцгийн гөрмөл титэм дүүрэн овоолсон байв.

Хашааны хаалганы гадна сонин сурвалжлагч гэрэл зурагчид хөлхөлдөн, жаахан цаана, пикап машины тэнд Холбооны Мөрдөх товчооны туршуулууд кинокамер бариад энэ түүхэн үйл явдлыг хальснаа буулгаж авахыг яаран овооролдоно.

Майкл Корлеоне нь Кей, Том Хейген, Фредди гурвын хамт ихэнх цагаа мухрын өрөөнд өнгөрүүлж, эмгэнэл илэрхийлэхээр ээлж дараагаар орж ирсэн хүн болгоныг хүндэтгэн хүлэн авах бөгөөд харин хэн нэг нь «Загалмайлсан эцэг юм уу, «Их эцэг Майкл» хэмээн үгээ эхлэх тоолонгоор дургүйлхэн уруулаа тас жимийж байхыг ганц Кей л ажиглажээ.

Жаахан байзнаад тэр өрөөнд Клеменца, Тессио хоёр орж ирсэнд Майкл өөрөө тэдэнд архи аягалан аваачиж өгөөд цэцэрлэгт хүрээлэнгийн бүс дэх эдлэн газрыг бүх байшингийн хамт санаанд оромгүй өндөр үнээр барилгын пүүс худалдан авч байгаа тухай ярьж эхлэв. Үүнээс үүдэн Их эцгийн нас барснаар Корлеонегийн эзэнт улс Өрнө зүг шилжин нүүх явц улам түргэсэхийг бүгд ойлгожээ.

Агуу их Загалмайлсан эцгийн шарилыг оршуулах цаг нэгэнт болсон тул Майкл эхнэрээ сугадан, амьд сэрүүндээ Их эцгийн ивээлдээ багтааж байсан тоо томшгүй хүмүүс пиг чихсэн цэцэрлэгт хүрээлэн рүү гарахад дайсан байсан хүмүүс ч хүртэл түүнийг сүүлчийн замд нь үдэхээр ирсэн харагдав.

Майкл энэ бүхнийг үл тоомсорлон эелдэг атлаа царцанги хөндий инээмсэглэн харж, эцэстээ хатан зориг гарган «Амьдрал мөн ч сайхан аа!» гээд нүд аньж чадвал бусад нь ямар хамаатай вэ? Тэрээр эцгийнхээ мөрөөр замнан үр хүүхэд, гэр бүлдээ тавих анхаарал халамжийг мөрөн дээрээ үүрч, харин хүүхдүүдээ өөрийнхөөсөө илүү хүмүүнлэг энэрэнгүй нийгэмлэгт амьдрах бүх нөхцөлийг хангахаар хатуу шийдсэн байна.

Загалмайлсан эцгийг хөдөөлүүлсний маргааш өглөө нь Корлеонегийн намын хамаг толгойлогчид цэцэрлэгт хүрээлэнгийн төв байранд цугларч үд дундаас өмнөхөн тэднийг Их эцгийн эзгүйрч хоосорсон харшид оруулахад Майкл Корлеоне хүлээн авав.

Итгэмжлэгдсэн төлөөлөгч Клеменца, Тессио хоёр, сэтгэлийн тэнцвэр сайтай, сүйхээтэй

овжин Рокко Лампоне, байх ёстой байраа мэдээд нам болсон Карло Рицци, эмгэнэлт явдлын улмаас хууль эрхийн асуудлаасаа арга буюу хөндийрсөн Том Хейген-эд бүгд мухрын өрөөнд шил шилээ даран орж ирлээ. Шинэхэн Их эцгийг сүүдэр мэт салахгүй дагах Альберт Нери байсхийгээд л Майклд тамхийг нь асааж өгөх юм уу дарс аягалах зэргээр тасралтгүй үйлчилнэ.

Эрүүл ухаанаар дүгнэн цэгнэж үзэхэд Их эцэг нас барснаар Корлеонегийн нам хүч чадлынхаа ихэнх хэсгийг алдан, сүйрлийн ирмэгт тулж Барзини-Таттальягийн холбоотой хийх хэлэлцээрийн үеэр тун хүнд байдалд орох болсныг хүн бүр сайн мэдэх тул Майклын юу хэлэхийг чих тавин сонсжээ. Тэдний хувьд Майкл хараахан шинэ Их эцэг болоогүй, энэ байр суурийг ч ийм цол хэргэмийг ч хүртэх болоогүй байлаа. Эрхэм Корлеоне дахиад жаахан амьд байсан бол хүүдээ бүх эрх мэдлээ залгамжлуулах нь мэдээж байсан ч одоо энэ асуудал тун ч маргаантай болчихоод байв.

Нериг хүн болгонд аягатай дарс бариулж дуусгахыг хүлээж байснаа Майкл намуун дуугаар үгүүлсэн нь:

- Та бүгдийн сэтгэл санаа хямарсныг сайн ойлгож байгаагаа юуны өмнө хэлмээр байна. Та нар эцгийг минь яаж хүндэтгэн харилцдаг байсныг би мэднэ. Гэвч одоо хүн болгон өөрийгөө, ойр дотнын хүмүүсээ ямар ирээдүй хүлээж байгаа, урьд өгсөн амлалтад энэ эмгэнэлт явдал яаж нөлөөлөх талаар санаа зовж буй нь мэдээж. Үүнд би юу ч өөрчлөгдөхгүй, бүх юм хэвээрээ үлдэнэ гэж хариулах байна.

Клеменца сэгсгэр үстэй том толгойгоо эргэлдүүлэн:

- Барзини, Татталья хоёр одоо л бидэнд жинхэнээр халдаж довтолно шүү, Майкл аа. Нэг бол сайн хамгаалах хэрэгтэй, үгүй бол ялагдсанаа хүлээх хэрэгтэй гэхдээ тэрээр Майклыг их эцэг гэж дуудаагүйгээр үл барам бүтэн овог нэрийг нь ч хэлээгүйг өрөөнд байсан бүх хүн анзааралгүй өнгөрч яахан чадах вэ?

- Хүлээн байж, юу болохыг харъя. Эхлээд тэд л энхийн гэрээг зөрчиг.

Тэртээ булангаас Тессиогийн зулгуй гэтүүр дуу гаран:

-Тэд хэдийн зөрчиж, өнөө өглөө Бруклинд морин тойруулгын бооцооны хоёр цэг нээчихсэн, Майк аа. Үүнийг би халдаж үл болох газруудын жагсаалт гаргаж өгдөг цагдаагийн ахмадаас дөнгөж сая олж мэдлээ. Энэ янзаараа бол сарын дараа гэхэд л надад Бруклинд хөл тавих газаргүй болох нь.

Майкл түүн рүү гүн бодол шингэсэн харц өргөв.

- Хариуд нь чи арга хэмжээ авсан уу?

- Үгүй, чамд төвөг удахыг хүссэнгүй.

- Тун зөв, тэгэх л хэрэгтэй. Та нар ч гэсэн нүдэн балай, чихэн дүлий суугаад бай. Ямар ч

өдөөн хангалтад бүү хариул. Юм болгоны учрыг олж зохицуулан, аль зүг рүү хөдөлбөл бид бүгдэд ашигтайг тодорхойлох хүртэл хэдэн долоо хоног надад хэрэгтэй байна. Тэр цагт бид дахин цугларч бүх асуудлыг бүрмөсөн шийдвэрлэнэ.

Тэдний гайхаж балмагдсан царайг тэрээр ер хараагүй дүр эсгэн дохио өгсөнд Альберт Нери бүгдийг өрөөнөөс эелдэг атлаа шаргуугаар гаргаж эхлэв.

- Том оо, түр азнаач хэмээн Майклын огцом дуугарахад Хейген үлдээд цонх руу очиход Нери харуул хамгаалалтынхны дэргэдүүр итгэмжлэгдсэн хоёр төлөөлөгч, Рокко Лампоне нарыг гарган өгч харагдлаа. Тэрээр нааш эргэн:

- Бидний улс төрийн бүх холбоо сүлбээг чи гартаа атгаж чадсан уу? гэхэд Майкл харамсан толгой сэгсрэв.

- Заримыг нь амжсангүй. Надад дахиад гурав дөрвөн сар байдаг ч болоосой... Яг энэ асуудлаар Их эцэг бид хоёр хөөцөлдөж байсан юм л даа. Бид хоёр шүүгч нараас эхэлсэн болохоор бүгд миний гарт орсон. Бас хамгийн их нөлөө бүхий конгрессын зарын гишүүд, Нью-Йорк дахь улс төрийн намын тэргүүн нар манайх болсон. Корлеонегийн нам бусдын боддогоос хавьгүй илүү хүчтэй хэдий эмзэг газаргүй, бат бэх болгож амжина гэж би найдаж байсан юмсан. Чи бүгдийг бодож тооцоолоод цөмийг ойлгочихсон л биз дээ?

Хейген толгой дохив.

- Энэ тийм ч хэцүү биш байлаа. Ганцхан энэ ширүүн тулааны талбараас яагаад намайг зайлуулсныг чинь л эхэндээ ойлгосонгүй. Гэвч дүрсэлж хэлбэл сицилийн шовгор малгай асааж, тархиа сайтар ажиллуулсан хойноо л бодож олсон шүү.

Майкл сэтгэл хангалуун инээмсэглэв.

- Өвгөн яг ингэнэ гэж хэлээд байсан юм, хөөрхий. Гэвч чи одоо надад чухам энд хэрэг болоод байна. Ядахдаа ойрын хэдэн долоо хоног энд үлд, Вегас руу эхнэртээ утасдаад учрыг нь, гаргаж хэлнэ биз дээ.

Хейген хэсэг зуур бодолд дарагдан дуугаа хураав.

- Тэд чамайг аль талаас нь оролдож эхэлнэ гэж чи бодож байна?

- Тун ойр дотно байдаг хүмүүсийн хэн нэгийг ашиглана гэж талийгаач маань тодорхой хэлсэн. Барзини бусад хүмүүсийн ямар ч сэжиггүй, бүрэн итгэлтэй гэж боддог хүнээр л намайг хөнөөлгөх оролдлого хийх нь лав.

- Яг над шиг үү? гээд Хейгений жуумалзахад Майкл мөн л тийм янзаар хариу жуумалзлаа. Майк:

- Чи ирланд хүн, чамд тэд итгэхгүй.

- Тэгж яривал эцэг минь герман хүн шүү. Ер нь бол би америк хүн.

- Тэдний хувьд энэ чинь ирланд л гэсэн үг. Чам дээр тэд яасан ч ирэхгүй. Нери цагдаагийн газарт алба хашиж байсан болохоор түүн рүү бас очихгүй. Ер нь та хоёр хэт ойрын, Рокко Лампоне тийм ч ойрын бус хүрээллийнх болохоор тэд ингэж аз туршихгүй. Үгүй ээ, тэд ухаантай л улс бол Клеменца, Тессио, Карло Рицци гурвын аль нэгтэй л уулзах ёстой.

- Карло л болов уу даа.

- Харан байж л больё. Удахгүй учир нь мэдэгдэх биз.

Энэ асуудал маргааш өглөө нь тодорхой болов. Хейген, Майкл хоёр өглөөний хоол идэж суутал утсан дээр дуудсан тул Майкл ажлын өрөөндөө орсноо удалгүй буцаад ирэв.

- За ингээд гүйцээ Яг долоо хоногийн дараа би Их эцгийн нас барснаас үүдэн шинээр байгуулбал зохих энхийн гэрээний нөхцөлийг тохиролцохоор Барзинитай уулзахаар боллоо.

- Хэн зуучилж утасдсан бэ?

Эсрэг талын холбоо барьж зуучилсан хүн л урвагч гэдгийг тэр хоёр сайн мэдэж байв.

Майкл зөвлөх рүүгээ гунигтай инээмсэглэн харлаа.

- Тессио.

Дахин юм ярилцсангүй хоолоо идэж дуусаад кофе ууж сууснаа Хейген гэнэт толгой сэгсрэв.

- Карло, за бүр үгүй юм аа гэхэд Клеменца л байх гэж тангараглахад ч би бэлэн байлаа. Очиж очиж Тессио гэж ер бодсонгүй. Тэдний дотроос хамгийн овоо нь шүү...

- Тэрээр хамгийн ухаантай нь болохоор өөрөө хамгийн ухаалаг гэж бодсоноо л хийсэн хэрэг. Тессио намайг Барзинид барьж өгөөд Корлеонегийн намыг залгамжлан толгойлно. Харин намайг яасан ч ялж чадахгүй гэж тооцоолсон болохоор надтай үлдвэл хамтдаа үрэгдэнэ шүү дээ.

Хэсэг чимээгүй байснаа Хейген дургүй ч гэсэн илт хүчлэн байж:

- Түүний тооцоолсон нь тэгээд хэр үнэний хувьтай юм бэ дээ? гэж асуухад Майкл мөрөө хавчлаа.

- Гаднаас нь харсан хэн ч гэсэн хэрэг базаахгүй л гэж хэлнэ. Харин улс төрийн ертөнц дэх холбоо, нөлөө хэдэн арван итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс ч илүү хүчтэйг тэр болгон ухаарахгүй ганц эцэг минь л ойлгож байсан юм. Үндсэндээ одоо энэ хүч миний гарт байгаа, харин үүнийг надаас өөр хэн ч мэдэхгүй. Зүгээр зүгээр, Том минь, тэд намайг Их эцэг гэж дуудахдаа л дуудна.. Гэхдээ л Тессиог бодохоор сэтгэл сэнсрээд нэг л эвгүй байна.

- Чи Барзинитай уулзахаа зөвшөөрөв үү?

- Тэгэлгүй яахав. Тессиогийн харьяа нутаг Бруклинд, над дээр ялаа ч сууж чадахгүй тийм

амар амгалан газарт долоо хоногийн дараа уулзана гээд Майкл дахин инээд алдлаа.

- Тэр болтол болгоомжтой байж үзээрэй.

Анх удаа Майкл Хейгений тийш хүйтэн харцаар ширвээд авав.

- Ийм зөвлөгөө сонсьё гэсэн бол надад гарын зөвлөхөөс өөр хүн олдолгүй дээ!

Барзинигийн намтай энхийн хэлэлцээр хийх өдөр хүртэлх долоо хоногийн дотор Майкл яаж сонор соргог, анхаарал болгоомжтой байх ёстойг Хейгенд харуулж чаджээ. Тэрээр эдлэн газрынхаа хаалганаас цааш ганц ч алхсангүй, өөрийн бие хамгаалагчгүйгээр нэг ч удаа хэнийг ч хүлээж авсангүй. Харин нэг харамсалтай бэрхшээл учирч төвөг удаагүйсэн бол бүх юм сайн сайхан байхсан. Конни, Карло хоёрын том хүү эрийн цээнд хүрч католик шашны дэг жаягаар ёслол үйлдэх болоход Майклыг загалмай зүүлгэсэн эцэг нь болооч гэж Кей гуйсан боловч тэрээр татгалзсан аж.

Гэвч Кейгийн найдвар тасарсангүй.

- Би тийм ч олон юм чамаас гуйдаггүй шүү, Майкл. Намайг бодоод зөвшөөрчих л дөө. Конни, Карло хоёр үүнийг маш их хүсэн мөрөөдөж байгаа юм. Тэдний хувьд амин чухал юм гэнэ. Би чамайг гуйя.

Түүний ийнхүү шалаад салахгүйд Майкл ихэд уурлаж байгаа нь илт дахиад л татгалзах байх даа гэж бодсон чинь толгой дохин зөвшөөрсөнд эхнэр нь их гайхжээ.

- За яахав, тэгье. Харин би гэрээсээ гарч болохгүй. Тэгэхлээр насанд хүрсний ёслолыг энд хийг, бүх зардлыг би хариуцна. Сүм хийдийн толгойлогчид зөрүүдлэн дургүйцэх юм бол Хейген зохицуулчихна биз.

Ингээд Барзинитай уулзахын өмнөх өдөр Майкл Корлеоне, Карло болон Конни Риццигийн ууган хүүгийн насанд хүрсний ёслол дээр загалмай зүүлгэх эцгийн хувьд оролцож алтан оосортой цаг хөвгүүнд бэлэглэжээ. Дараа нь эл баярт үйл явдлыг Карлогийн гэрт тэмдэглэн Их эцгийн бэлэвсэн гэргий болон цэцэрлэгт хүрээлэнгийн бүсийн бүх оршин суугчдыг урьж оролцуулав. Конни магнай хагартал баярласандаа болоод тэр оройжингоо ах, бэр эгч хоёроо тэвэрч үнсэв. Карло, Рицци ч гэсэн сэтгэл уярч, Майклын гарыг сэгсчин, аятайхан тохиолдол болгоныг ашиглан түүнийг загалмайлан эцэг гэж дуудах нь тун ядаргаатай.

Конни сэтгэл догдлон амьсгаадаж:

- Одоо Карло минь Майклтай жинхэнэ ёсоор үерхэж нөхөрлөх байх аа. Ийм үйл явдал хэзээ ямагт хүмүүсийг ойр дотно болгодог шүү дээ! гээд Кейд шивнэсэнд тэрээр түүнийг сугадан тэврэв.

- Тэгвэл мөн ч сайхан аа!

ХОРИН ДОЛООДУГААР БҮЛЭГ

Альберт Нери Бронкс дахь байшиндаа, цагдаагийн хуучин дүрэмт хувцсаа хичээнгүйлэн сойздож суув. Бууны гэртэй суран бүсээ сандлын түшлэг дээр тоож, зүлгэхэд эвтэйхэн гээд таних тэмдгээ мултлан авч ширээн дээр тавьжээ. Хэзээ язааны хэвшил болсон эл чимхлүүр ажиллагааны улмаас эхнэрээсээ салснаас хойших сүүлийн хоёр жилд ховорхон үзсэн жаргалаа амсаж байлаа.

Суусныхаа дараахан Рита Нери эр нөхрөө хайрын харцаар ширтэж, түүний зөвхөн хэмжээлшгүй бяр тэнхээнээс төдийгүй юуг сайнд, юуг мууд тооцох өөрийн гэсэн онцгой ойлголтдоо бат үнэнч байдгаас нь хүмүүс, айдгийг нүдээрээ үзэж дотроо сэмхэн бахархдаг байв. Альберт аливаа асуудлын эв зүйг олж зохицуулах нь ховор, эелдэг боловсон зан гаргаж хүний хэлснийг зөвшөөрөөд өнгөрнө гэж хол, дээр нь бас жинхэнэ сицили хүний огцом халуун зан авиртай тул уур хилэн нь бадарсан үедээ хавь ойрынхныхоо айдсыг хүргэдэг нэгэн.

Нью-Йоркийн цагдаагийн газар таван жил алба хаахдаа хотын дэг журам сахиулагчдын дотроос хамгийн аюултай нь, тэгэхдээ бас бараг л хамгийн үнэнч нь болж алдаршжээ. Гэхдээ тэрээр тун өвөрмөц маягаар ажиллаж, хэв журам зөрчигсдийг хувийн өстөн дайсан мэт үзэн, орой үдшийн цагаар танхай залуус хаа нэгтэй булан тохойд хүн амьтныг боорлон хоргоохыг харсан даруйдаа л баавгайнх шиг бяр чадлаа хэрэглэн хоромхон зуур эрс шийдэмгий арга хэмжээ авдаг байсан юмсанж.

Тэрээр иймэрхүү мөргөлдөөний үеэр тун шалмаг хөдлөн нүд ирмэхийн зуур хийх ажлаа дуусгаад хүн зоны хуран цугларч хүүе хаая гэхийн завдалгүй эргүүлийн машины хаалга тасхийтэл хааж, хоршоо нөхөр нь хаазаа нэмэн алга болдог байв. Мэдээжээр хангал ширүүн зантай ойворгон залуус хааяа тааралдаж эсэргүүцэл үзүүлэх буюу хутга мэс шүүрэх нь байдаг бөгөөд тийм хүнийг зөвхөн өрөвдөж хөөрхийлөхөөс өөр аргагүй. Нери түүнийг хоромхон зуур зэрлэг догшноор зодож цус нөжтэй нь холиод машиндаа шидчихдэгээс гадна бас баривчлан хорьж төрийн төлөөлөгчийн эрх чөлөөнд халдсан хэрэгт яллана. Гэхдээ хэв журам зөрчигч эмнэлгээс гарахыг хүлээх нь олонтой л байдаг юм даа.

Ийнхүү цаг улирал ээлжлэн өнгөрсөөр нэг өдөр Нериг Нэгдсэн Үндэстний Байгууллагын байшин оршдог хэсэгт шилжүүлжээ. НҮБ-ын ажилтан нар дипломатын халдашгүй дархан эрхээ далимдуулан цагдаагийн газраас тогтоосон журмыг зөрчин ойр хавийнхаа бүх гудамжийг лимузинуудаар бөглөж орхино. Нери дарга нартаа гомдол мэдүүлсэн боловч чимээ шуугиан бүү дэгдээ, хараагүй юм шиг өнгөрч бай гэдэг байв. Гэтэл нэг орой ундуй сундуй тавьсан машинуудаас болоод бүхэл бүтэн гудамжны хөдөлгөөн тэр чигээрээ хаагдсанд Нери эргүүлийн машинаас авсан нилээд жинтэй гар чийдэнгээр зэвсэглэн шөнө дунд өнгөрсөн хойно тэр гудамж руу орж машинуудын урд шилийг баруун солгойгүй бут, дэлбэ, бяц балбан будаа болгожээ. Хэдий өндөр тушаалын дипломат байсан ч гадаад маркийн машины салхины шил сольж хийх гэж лав л хэд хоног хөөцөлдөх нь гарцаагүй. Автомашины эзэд энэ зэрлэг балмад явдалд гомдол мэдүүлэн, өмгөөлж хамгаалахыг шаардсан бичиг цаасаар цагдаагийн хэсгийг булж, үнэн мөнийг олох гэсээр байтал дахин нэг долоо хоногийн

турш салхины шил бут үсэрсээр байлаа. Ингээд эцсийн эцэст юмны эзэн сумны занги Альберт Нериг Гарлем руу шилжүүлэв.

Үүнээс хоёр сарын дараа Аль Нериг шөнийн ээлжээс буугаад ирсэн чинь эхнэр нь түүнийг хаяж, хувцас хунараа жаал зугаа юмтайгаа хамт боож аваад эцэг эх дээрээ оччихсон байлаа. Хадам эцгээсээ асуусанд ийм жолоо хазааргүй догшин хүнтэй хамт амьдрахаас Рита айгаад салсан гэхийг сонсоод Аль духан дундуураа сүхдүүлсэн мэт мэл гайхаж, цэл хөхөрчээ. Тэрээр авгайдаа гар хүрэх нь бүү хэл хараан зандарч муухай ч харж үзээгүй ёстой л өөхөнд ороосон бөөр шиг эрхлүүлж хайрлан энхрийлж байсан тул гэнэт цочирдож балмагдсандаа хэд хоног хүлээж өөрөө сэхээ ороод дараа нь очиж учраа олохоор шийдсэн байна.

Гэвч маргааш нь, гай газар дороос гэгчээр яг түүний ээлжин дээр хэрэг мандлаа. Хэсгийнхээ харьяа нутаг дэвсгэрийг эргэж явтал гарлемын нэг гудамжинд хэн нэгнийг хутгалж байна гэсэн дуудлага ирж, Нери хэвшиж дадсанаараа бараг л машины явуут дунд жинтэйхэн гар чийдэнгээ барьсаар үсрэн буув Орон сууцны байшингийн нэг орцны үүдэнд хүмүүс шавчихсан байх тул хэргийн газрыг олох гэж зүдэрсэнгүй. Нэгэн негр эмэгтэй түүнд:

- Тэнд хүүхэд хутгалах гээд байна гэжээ.

Нериг орцны хаалгаар ороход хонгилын цаад мухрын онгорхой хаалганаас урц гэрэл тусч ёолон гаслах дуу сонсогдсонд тэрээр гар чийдэнгээ чанга атгасаар босго алхмагц шалан дээр тэрийсэн хоёр хүнд тээглэн золтой л бүдэрч унасангүй. Хорин тав орчим насны хар арьст хүүхэн, хажууд нь хэвтээ арван хоёр наснаас хэтрээгүй охин хоёр сахлын хутганд хэрчүүлж цус нөжиндөө хутгалджээ. Зочдын өрөөнд орвол эл хэргийн гэм буруутан, негр Вэкс Бейнз дүрээрээ зогсож байв. Хутга мэс хэрэглэхдээ гарамгай мэргэшсэн засаршгүй танхай тэр этгээд мансуурч гөлийсөн нүдээ цагаанаар эргэлдүүлэн, эвхдэг сахлын хутгаа чанга атгасан гар нь үе үе татганах аж.

Нийгмийн хэв журам ингэж бүдүүлгээр зөрчсөнийг хармагц Неригийн уур хилэн бадраад явчхын хажуугаар зай завсаргүй шахуу сийчүүлсэн жаал охиныг үзээд дотор нь муухай болсон хэдий ч Бейнзийг баривчилж хэсэг дээр аваачихын оронд газар дээр нь учрыг олохоор шийдлээ.

Энэ үеэр тэр байшингийн оршин суугчид араас нь шахалдан түрж эргүүлд хамт гарсан нөхөр нь ч хүрээд ирэв.

Нери негр эрд хандан:

- Хутгаа хая, чи баривчлагдсан гэж тушаасан чинь Бейнз өөдөөс нь доогтой хөхөрч:

- Би л чамд ингээд баригдаж гэнэ, гайгүй байлгүй. Ингээд чи баривчил гээд хутгаа далайлаа.

Нери эргүүлийн нөгөө цагдаадаа буу гаргах зав зай өгөхгүйн тулд маш хурдан хөдөлж, зүүн гараараа негр эрийн хутгатай гарыг хөдөлгөөн дунд дунд нь шүүрэн бариад, гар чийдэн атгасан баруун гар нь огцом дугуйран Бейнзийн чамархайн тус газар буув. Мань эр согтуу хүн шиг тахимаараа суун туссанаа хутгаа алдаж ямар ч арчаагүй байдалд орлоо. Тийм учраас

хөрш гэрчийн этгээдүүд, эргүүлийн хоршоо цагдаагийн шүүх хурал дээр мэдүүлсэнчлэн дахин цохих шаардлагагүй байсан бөгөөд хоёр дахь удаагаа Нери Бейнзийн гавлын ясыг цөм цохиж, тэр негр хоёр цагийн дараа Гарлемын эмнэлэгт нас баржээ.

Нери санамсаргүй хүний амь бүрэлгэсэн хэрэгт холбогдон, шүүх түүнд нэг жилээс арван жил хүртэл хорих ял оноохыг сонсохдоо эргэлзэн гайхсан, галзууртлаа уурласан холимог сэтгэл нүүрэн дээр нь бичээстэй байв. Тэрээр энэ торгон мөчид, амьдарч буй энэ нийгмээ яс махнаасаа үзэн ядаж, ер нь яасан ч хамаагүй болоод явчихжээ. Түүнийг гэмт хэрэгтэнд тооцсоноор үл барам тэр муу танхай зандалчин өөдгүй шаарыг устгалаа гэж шоронд хорих гэнэ! Насан туршдаа эрэмдэг зэрэмдэг болсон охин, хүүхэн хоёр одоо хүртэл эмнэлэгт шаналж байгаа нь хэнд ч хамаагүй хэрэг үү?

Тэрээр шоронгоос айсангүй, нэгд цагдаа байсан, хоёрт ямар хэргээр орсныг нь мэдээд тэнд нааштай сайнаар харьцана гэсэн итгэл дүүрэн байлаа. Хамт ажиллаж байсан зарим нөхөд нь түүний тухай зохих эрх мэдэл бүхий хүмүүстэй ярилцах ам өгчээ. Гагцхүү Бронкс дахь загасны мухлагийн эзэн хадам эцэг нь жинхэнэ итали хүний сэргэлэн ухаантай тул Альберт Нери шиг хүнд жилийн дараа шоронгоос амьд гарч ирэх боломж тун бага гэдгийг ойлгож байв. Нэг бол үүнийг хамт хоригдогсдоос хэн нэг нь зүйл дуусгана, эсвэл тэр өөрөө тэдний нэгийг цааш харуулж таарна. Хуучин ёс горимыг чандлан сахидаг Неригийн хадам эмэгтэй хүний тунирхуу зангаар сайн нөхрөө хаясан охиныхоо гэм бурууг ухамсарлан Корлеонегийн намынхныг сайн таньдгийн хувьд тэднээс тусламж гуйсан байна.

Тэд ч тэсэн Альберт Нериг андахгүй сайн мэднэ. Ер нь хэв журмыг улангасан сахиулагч тэрээр нэг ёсондоо домогт хүн болсон бөгөөд зөвхөн цагдаагийн дүрэмт хувцас өмсөж, буу шийдэм зүүсэндээ ч биш, өөрөө тун сүртэй аймшигтай тул тоглоом хийх битгий хэл тойроод өнгөрөхөд ч аминд халтай, аюултай хүн гэж алдаршсан байлаа. Корлеонегийн нам иймэрхүү хүмүүсийг хэзээ ямагт сонирхон холоос ажиглахаас гадна цагдаагийн газарт ажиллаж байсныг онц ач холбогдолгүй гэж үздэг байв. Залуу зандан насандаа гэнэдэж, эндэж, зураг төөргөөр оногдсон хувь тавиландаа хүрэх замдаа алдаж онож, будлиж явсаар цаг хугацаа, элдэв тохиолдлын эрхээр зөв замдаа орох хүн алийг тэр гэх вэ?!

Товчхон хэлэхэд, Альберт Нериг Нью-Йоркийн шоронгоос засан хүмүүжүүлэх ангид шилжүүлж амжаагүй байтал эд мөрийн шинэ баримт, түүнчлэн цагдаагийн газрын томоохон албан тушаалтан нарын мэдүүлгийг үндэслэн шүүгч түүний хэргийг дахин хянан үзээд түрүүчийн ялыг тэнсэх ялаар сольсон тул Нери харсан зүгтээ тонилж болно гэдгийг мэдэгджээ.

Альберт Нери тэнэг хүн биш, хадам нь ч гэсэн арван наймт шиг ичиж зоволгүйгээр хэргийн учрыг шууд хэлсэн тул мань эр хадам эцгийнхээ ачийг бодож Ритад гэрлэлтээ цуцлуулах зөвшөөрөл өгөөд авран ивээгчиддээ талархал илэрхийлэхээр Лонг-Бич рүү явсан байна. Энэ уулзалтыг мэдээжээр, урьдчилан товлож, Майкл түүнийг мухрын өрөөндөө хүлээн авлаа.

Гайхалтай нь Нери баярласан гялайснаа ёсорхог байдлаар хэлж эхэлтэл Майкл гүндүүгүй зан гаргаж халуун дотноор үгүүлэн:

- Чөтгөр алгадмар, нутгийн хүн, сицили эрд минь ингэж хүний үнэргүйгээр хандахыг би яаж

тэвчих билээ?! Таныг шийтгэх байтугай, харин ч шагнаж урамшуулах ёстой юм шүү дээ, уг нь. Та аан гээч, би таны тухай тодорхой магадлан, ямар шударга бус хэрэгт өртсөнийг чинь багтай мэдэж аваагүй бол яасан ч хөндлөнгөөс оролдохгүй байсан даг. Таныг хадам чинь тэнгэрт гартал магтаад л байна билээ. Тийм хүн ч ховор доо ховор гэхдээ Нериг эхнэртээ хаягдсаныг энд дурдах нь эвгүй хэмээн үзээд хэлсэнгүй.

Тэр хоёр чин сэтгэлийн яриа хөөрөө дэлгэж, Нери ухаан орсон цагаасаа л хойш ам задгай, үг олонтой гэгдэж яваагүй атлаа энэ удаад бүхий л амьдрал, үүх түүхээ Майклд уудалж гарчээ. Ярианы төгсгөлөөр Майкл түүний өвдөг дээр гараа тавьж:

- Зөвхөн гудамжинд гаргаад гаргуунд нь хаячхын тулд л таныг хоригдох ялаас чөлөөлөх хэрэггүй байсан нь хэн хэнд маань ойлгомжтой биз. Би танд ажил олж өгч чадна. Лас-Вегасын мөрийтэй тоглоомын бизнесийн нилээд хувь миний мэдлийнх болохоор таных шиг туршлагатай хүнд аюулаас хамгаалах албанд хэзээд ажил олдоно. Хэрэв та өөрөө биеэ даан ямар нэг ажил хэрэг эрхлэхээр товлосон бол зээл хөрөнгөний талаар банкныхны чихэнд хэдэн үг шивнэчхэж чадна шүү, би.

Баярлаж талархахын зэрэгцээгээр санаа зовж орхисон Нери хангал бардам зангаар татгалзаад тэнсэн ч гэсэн ялын тогтоол хүчинтэй байгаа цагт хуулийн байгууллагын хараа хяналтад байсаар байх учраа нэмж үгүүлсэнд Майкл ажил хэрэгч байдлаар үгүйсгэн тайлбарласан нь:

- Өө, энэ чинь ядах юмгүй. Банкныхан таны намтар түүхээс өө эрэх гэвэл тэр дор нь аргалчхаж бололгүй яах вэ.

Нери цагдаагийн газарт дэндүү удаан ажиллаж, хэтэрхий их юм үзсэн болохоор түүний үгэнд ер эргэлзсэнгүй, гагцхүү өөр шиг нь өчүүхэн амьтны төлөө Майкл ингэж төвөг удаж хөөцөлдөхөд бэлэн байгаад л баахан гайхжээ.

- Тусламж хэрэгтэй болбол би танд хэл хүргэнэ ээ.

- За тийм байж гээд Майкл цагаа харсанд Нери битүүхэн дохио өгч байна гэж ойлгоод явахаар өндийтөл Майкл дахиад л гайхахад хүргэв.

- Үдшийн зоог барих цаг болж. Манай гэрийнхэнтэй жинхэнэ, сицили хоол идэхгүй юу? Талийгаач эцэг минь тантай танилцахсан гэж дандаа ярьдаг сан, хөөрхий. За яах вэ, явах уу?

Альберт Нери гурав хоног ч бололгүй хувь заяагаа эцэслэн шийдлээ. Түүнтэй эелдгээр харьцан тал засч байгааг тэрээр ухаж мэдсэний зэрэгцээ бас өөр олон зүйл, тухайлбал Неригийн хийсэн үйлдлийг нийгэм, олон нийт зэмлэн буруушааж, өөрт нь ял шийтгэл оноосон байхад Корлеонегийн нам сайшаан дэмжиж, зүй ёсоор үнэлж байгааг ойлгож авав. Бас Корлеонегийнхан өөрсдийн бүтээн байгуулсан ертөнцийн хүрээнд Неригийн одоо хүртэл амьдарч ирсэн нийгмээс илүү хүчтэй, тийм учир Корлеонегийн намтай хувь заяагаа холбоход хэзээ ч алзахгүйг сайн ойлгожээ.

Нери Майклтай дахин уулзаад санасан бодсон бүхнээ нууж хаалгүй шууд хэлж, Вегас дахь албан тушаал нэг ч их сайхан санагдахгүй, харин Нью-Йоркод бол Корлеонегийн намд хүчин

зүтгэхэд бэлэн байгаага ойлгуулсанд тэр хоёр хэл амаа дорхноо ололцсон байна. Гэхдээ Майкл түүнийг эхлээд Майами дахь намын мэдлийн зочид буудалд үнэ төлбөргүй амарч, зугаа цэнгэлийн зардалд гар татахгүйн тулд нэг сарынхаа цалинг урьдчилж аваад явахыг зөвлөж, бараг шаардсан аж.

Майамид очоод Альберт Нери амьдралдаа анх удаа баян тансаг байдал цэнгэлийн дээдийн захаас амсав. Зочид буудалд очиход нь түүнийг Майкл Корлеонегийн андын хувьд онцлон халамжилж захын нэг заваан өрөөнд чихэж орхисонгүй, хамгийн тохилог сайхан өрөөнд оруулж шөнийн цэнгээний газрын эрхлэгч хөөрхөн хүүхнүүдтэй танилцуулжээ. Ингээд Нери Нью Йоркод буцаж ирэхдээ амьдралыг шал өөр нүдээр хардаг болчихсон байсанд гайхах юун.

Түүнийг Клеменцагийн зэвсэглэсэн бүлэгт элсүүлж, шинэ цэрэг сонгон авч сургуулилахдаа хосгүй мэргэшсэн итгэмжлэгдсэн төлөөлөгч Нериг дээд зэргээр хичээнгүйлэн хатуу шалгав. Ямар ч гэсэн тэрээр цагдаа байсан болохоор сэрэмжлэн болгоомжлоход илүүдэх юмгүй, тэгэх ч шаардлагатай байсан бөгөөд жил ч болоогүй байхад түүний «хөдөлмөрийн дэвтэрт» хүн амины хэрэг бичигдсэн нь эргэж буцах бүх замыг нь бүрмөсөн хаасан бөлгөө..

Нери жинхэнэ рид хувилгаан, ёстой гайхамшиг, Люка Брази гэж ирээд л Клеменца магтах үгээ олж ядахаас гадна зэвсэглэсэн бүлгийн захирагч нь Клеменца өөрөө байлаа ч гэсэн жирийн хөлсний цэргээр байгаад байх хүн яав ч бишийг ойлгосон учир Майкл Корлеонегийн шууд харьяанд өгч, Том Хейген тэр хоёрын хоорондын байнгын дамжлага, хэл зөөгч болгосон байна. Тэрээр Майкл Корлеонег үлэмж таалан сүсэглэж, мөргөх нь холгүй байдаг тул нэг удаа Том Хейген хошигнон

- За ингээд чи хувьдаа бас нэг Люкатай боллоо доо гэсэнд Майкл хариуд нь толгой дохив.

Тийм ээ, тэрээр Альберт Нериг бүрмөсөн гартаа оруулж үхэн үхтлээ үнэнч зүтгэхээр болгож чадсан. Мэдээжээр энэ аргыг ч гэсэн Майкл эцгээсээ сурсан бөгөөд олон сарын турш эцэг нь гэр бүлийн бизнесийн нууцыг нээн таниулж байх үеэр нэг удаа:

- Люка Брази шиг залуур жолоодлогогүй араатанг та яаж ашиглаж чадаад байсан юм бэ? гэсэнд аав нь тайлбарлаж өгсөн аж.

- Хаана ч байсан намайг алаад өгөөч хэмээн гуйж, гуйх нь битгий хэл бүр шаардаад явдаг хүмүүс хорвоо дээр цөөнгүй байдгийг чи ч өөрөө анзаарсан биз. Тэд цэнгэлдэх хүрээлэнд хэрүүл зодоон өдөж, машинд нь жаахан зураас, сэв суулгачхаар нударга зангидан давшилж, анх таарсан хүнийхээ талаар юу ч мэдэхгүй, халаасанд нь юу байгааг үзээ ч үгүй байж түүнийг доромжлон дайрдаг. Тэд газар дэвслэн дөвчигнөж: «За би энд байна. Алаад аль, намайг!» хэмээн хашгирч гуугалаад, мэдээжээр алаад өгөх хүн мундахгүй олддогийг бид өдөр болгон сонин хэвлэлээс залхглаа уншдаг. Иймэрхүү маягийн хүмүүс бусдад ч гэсэн хор хүргэдэгт гайхах юу бах вэ. Люка Брази яг ийм хүн байсан, гэхдээ тэднээс ялгагдах нэг юм нь гэвэл чухам түүнийг хэн ч хороож чадалгүй их удсан юм. Аминаасаа тэр хүмүүсийн ихэнхтэй нь орооцолдох ер хэрэггүй боловч Люка Брази шиг хүнийг олигтойхон залж удирдвал аюултай зэвсэг болж чадна шүү. Чи ойлгож байна уу, нэгэнт тэрээр үхлээс айхгүй, тэр ч бүү хэл өөрөө эрээд яваа бол, түүний хувьд хорвоо дээр гарт нь өртөж үхэхийг үл хүсэх цорын ганц хүн нь болоход л хэргийн гол учир байгаа юм. Өөрөөр хэлбэл, тэрээр үхлээс айдаггүй,

гагцхүү чамд алуулахаас л айдаг байх ёстой. Тэгж чадвал тэр чинийх.

Энэ бол Их эцгээс түүнд хайрласан хамгийн үнэтэй сургаалийн нэг байсан бөгөөд Майкл сайхь Альберт Неригээр хувийн Люка Брази хийж авахын тулд тэр сургаалийг ашиглажээ.

Ингээд л Альберт Нери Бронкс дахь байшиндаа тухлан суугаад цагдаагийн дүрэмт хувцсаа дахин өмсөхөөр зэхэж хичээнгүйлэн цэвэрлэж байв. Дараа нь бууныхаа гэрийг гялалзтал арчин, бас малгайгаа сайн янзалж саравчийг нь олигтойхон зүлгэхгүй бол өнгөө алдчихжээ. Зузаан хар түрийтэй шаахайгаа ч тослох хэрэгтэй юм байна. Нери иймэрхүү юм бодон ажилдаа үнэхээр улайрчээ. Нэгэнт л тэрээр амьдралд эзлэх байр сууриа олж, Майкл түүнд итгэл найдвараа хайрласан тул өнөөдөр юу чадахаа харуулна даа, харуулна.

ХОРИН НАЙМДУГААР БҮЛЭГ

Мөн тэр өдөр Лонг-Бич хотын дүүрэг дэх цэцэрлэгт хүрээлэнгийн төв байрны хашааны гол хаалгаар хоёр машин орж ирсний нэг нь Конни Корлеонег ээж, нөхөр хоёр хүүхдийнх нь хамт нисэх онгоцны буудал хүргэж өгөх байлаа. Лас-Вегаст бүрмөсөн суурьшихаасаа өмнө одоохондоо газар байдалтай нь танилцаж, бас амрахаар Карло Риццигийн гэр бүлийг тийш нь түр явуулах захирамж өгөхдөө Майкл, Барзинигийн намтай хэлцэл хийх хүртэл хамаатан садангийн бүх хүмүүсээ эдлэн газраас хол байлгах нь зүйтэй гэж үзсэнээ тайлбарлаж хэлсэнгүй. Тэр тусмаа энэ уулзалт хэлэлцээрийн тухай хоёр шадар туслахаас өөр хэнд ч үл хэлэн чандлан нууцалсан юмсанж.

Суудлын вагон шиг нүсэр нөгөө машин нь хүүхдүүдийнхээ хамт эцэг, эхийндээ зочлохоор Нью-Гемпшир орох Кейг хүлээж байв.

Урьд орой нь Карло Рицциг арга буюу эндээ хэд хонуулаад долоо хоногийн эцсээр эхнэр хүүхэд рүү нь явуулна гэж Майкл нөхөрт нь хэлснийг сонсоод Конни уурлан бухимдаж, Майкл руу утсаа халтал залгасан боловч түүнийг хот орохоор явсан гээд яриулсангүй Конни одоо ч гэсэн түүнийг нүдээрээ эрж хайтал алга Майкл мухрын өрөөндөө Том Хейгентэй ажил хэрэг зөвлөлдөөд бүү саад бол гэсэн гэнэ. Конни замд гарахаасаа өмнө нөхрөө тэвэрч үнсээд лимузинд суухдаа

- Хоёр хоног хүлээгээд гурав дахь дээр нь өөрөө ирж авна гэж мэдээрэй хэмээн сүрдүүлээд гэнэт зовнин духаа үрчийлгэж, дорхноо л хөгширч царай алдлаа. - Майкл чамаар яах гэсэн юм бол, мэдээгүй биз?

Карло дал мөрөө хавчисхийн:

- Албан тушаал ахиулахаар амлаад удаж байгаа юмсан, тэр талаар ярих гэсэн юм болов уу? хэмээхэд Коннигийн царай гэрэлтээд явчихлаа.

- Нээрээ юү Карло?

Мань эр эхнэрийнхээ сэтгэлийг сүлэн толгой дохих зуур машин ч зуугуухан хөдөлж хаалгаар гарч, хэдийнээ бараа тасарсан хойно л Майкл хүүхдүүд Кейтэйгээ салах ёс гүйцэтгэхээр ирж, Карло ч гэсэн тэдэнд аян зам нь өлзийтэй байхыг ерөөв.

Хоёр дахь машин хашаанаас гарч далд орсон хойно Майкл ам нээн:

- Ийм юм болсонд уучлаарай, Карло. Ердөө хоёр л хононо, илүү удахгүй -гэхэд Карло яаран:

- Зүгээр зүгээр, санаа бүү зов хэмээн хариу өчлөө.

- Тун сайн. Утасныхаа дэргэд байгаарай, би ярина. Харин одоо зарим нэг юм зохицуулмаар байна, за юу?

- За за, тэгье. Майк аа.

Нилээд удаан хүлээж байтал нэг цагийн алдад хашааны хаалгаар машин үзэгдэж, Клеменцагийн араас шахуу Тессио ирсэнд бие хамгаалагч тэр хоёрыг Майкл руу оруулсны дараа хоёр цаг болоод Клеменца явж, харин Тессио дахин үзэгдсэнгүй.

Карло хэдэн минут цэвэр агаар амьсгалахаар түр гадаалахдаа цэцэрлэгт хүрээлэнгийн харуулд гарсан хүмүүсийг бүгдийг таньдаг, заримтай нь ч бүр дотносож андалсны хувьд хэн нэгтэй нь хэд гурван үг солиод авах гэсэн чинь өнөөдөр дандаа шинэ хүмүүс манаанд зогсож байсанд их гайхсанаас гадна хамгийн хачирхалтай нь хаалгыг Рокко Лампоне өөрөө сэргийлэн хамгаалах бөлгөө. Гэтэл Рокко зөвхөн онцгой тохиолдлоос бусад үед ийм хар ажил хийхээргүй өндөр тушаалын хүн гэдгийг Карло юу андах билээ.

Карлогийн сэрэмжилж түгшсэн харцыг ажаад Рокко найрсгаар инээмсэглэн гар барьж мэндлээд:

- Хөөе, чи чинь амрахаар явах гээгүй билүү? гэхэд Карло гараа огцом дэлгэв.

- Майк хоёр гурван хоног азна гэсэн. Ямар нэг ажил гарсан бололтой.

- Тийм байхаа. Би ч гэсэн чухал хэрэг гарлаа гэж бодсон чинь харин хаалга манадаг юм байна. За тэр ч яахав, хар гэртээ хаан, бор гэртээ богд юм биз дээ, нохой долоо.

Карло түүний энэ хошин аясыг дэмжсэнгүй.

- Майк юу хийхээ мэдэж байгаа нь лав гэсэнд Рокко энэ битүү зэмлэлийг дув дуугүй хүлээхээс өөр аргагүйд хүрчээ.

- За би явлаа гэгчхээд Рокког байшин тийш эргэж алхахад Карло нэг л юм болж, харин Роккод хэлээгүй юм байна гэж бодлоо.

Карло Рицциг ийнхүү хэрэн хөлхөж явааг Майкл зочдын өрөөний цонхоор харж зогстол Хейген хундага дүүрэн шарз мөрөн дээгүүр нь сарвайв. Майклыг амтат шарз таатай нь аргагүй шимэх зуур Хейген тун зөөлөн дуугаар:

- Майкл, эхлэх цаг болжээ гэв.

Майкл гүн санаа алдлаа.

- Цаг даанч давчуу байна даа. Өвгөн маань нүд анихаа жаахан хүлээсэн ч болоосой.

- Зүгээр, бүх юм ёсоороо болно.

Майкл цонхноос эргэн нааш харав.

- Маш их зүйлийг тэрээр өөрөө бодож боловсруулсан юм шүү. Түүнээс өмнө би аавыгаа тийм толгойтой гэж төсөөлөө ч үгүй явсан сан. Юу ч ярих вэ дээ, чи өөрөө сайн мэдэх хойно!

- Дахиад тийм хүн байхгүй, төрөх ч үгүй. Гэхдээ чи ч гэсэн тийм ч арчаагаа алдсан хүн биш шүү.

- Амьдрал харуулах биз дээ! Клеменца, Тессио хоёр ирсэн үү?

Хейгенийг толгой дохиход Майкл ганцхан балгаад хундагаа ёроолдлоо.

- Клеменцад би өөрөө заавар өгнө, нааш нь оруулчих. Харин Тессиотой уулзахыг ч хүсэхгүй байна, зүгээр л хагас цагийн дараа бид Барзинитай хэлэлцээр хийхээр түүнтэй хамт явна гээд хэлчих. Бусдыг нь Клеменцагийн залуус учрыг нь олно.

Хейген хөндий хоолойгоор сааралтуулан асуусан нь:

- Тессиог аврах алга алга уу?

- Байхгүй.

Буффало хотын нэгэн нарийхан гудамж дахь пиццаны газар үдийн цайны үеэр хөл гишгэх зайгүй байснаа аажмаар хүн цөөрч, худалдагч нь зарагдаагүй пиццатай дүгрэг төмөр тавиураа лангуунаас авч асар том туйпуун пийшинд дээр тавьснаа гадагш нь боож наймаалдаг жижиг цонх руу эргэв. Танхайдун байрын залуу цонхоор шагайн:

- Надад нэг хувь пицца гэсэнд худалдагч модон хүрзэнцрээр хөрсөн хэрчим утгаж аваад халаахаар пийшинд шургуулах зуур нөгөө залуу ширээнд сууж идэх гэсэн бололтой, хоосон танхимд орлоо. Худалдагч пийшин рүү толгой шургуулан, хучлага бяслаг нь хөөсрөөд ирсэнд халуун зүсэм гаргаж цаасан таваг дээр тавихад сайхь залуу эр мөнгөө гаргаж сарвайхын оронд яагаад ч юм өөдөөс нь цоо ширтжээ.

- Ах аа, таны цээжин дээр дэгжин шивээс байдаг гэлцэх юм. Тэр цухуйгаад байгаагаа харуулчихгүй юу?

Худалдагч байсан байрандаа ***** гадас лугаа адил хөшиж орхив.

- Хөөе, чи цамцныхаа товчийг тайлаадхаач.

- Надад биш ээ, орой ажилладаг ээлжийн минь хүнд шивээс бий хэмээн худалдагч англи үгсийг хугачиж нугачин бувтнах аядахад үйлчлүүлэгч эр чихэнд чийртэй эвгүй хөхрөв.

- Тайл гэж байна шүү, чамайг. Хараад орхиё.

Худалдагч пийшингийн ар руу гэтэн ухарч, агуулах ордог хаалга руу дөхсөн боловч залуу эр аль хэдийнээ буутай гараа лангуун дээгүүр давуулж гох дарсанд цээжиндээ сум зоолгосон худалдагч пийшин мөргөтлөө үсэрснээ шал руу аажуухан гулслаа. Үйлчлүүлэгч лангууны араар орж дээрээс нь тонгойн цамцных нь товч тас үсэртэл угз татсанд цус нөж болсон хэнхдэг дээр нь дөрвөн мөчөөрөө орооцолдон тэврэлдсэн нууц амрагууд, эхнэрээ хутгалж

буй эр нөхрийг дүрсэлсэн шивээс тод харагдаж худалдагч эгцлэн ширтэх харцнаас халхлах мэт сульдсан гараа өргөв.

- Фабрицио чамд Майкл Корлеоне мэнд дамжуулж байна гээд алуурчин маань худалдагчийн тархинд бараг тулган буудчихаад гүйхээрээ гарч хаалга онгойлгон хүлээж байсан машинд суугаад талийж өгөх нь тэр ээ.

Рокко Лампоне ган хаалганы тулгуур баганаас өлгөсөн утас руу очиж авсан чинь:

- Барааг чинь баглачихсан гэх хэн нэгний дуу сонсогдоод чимээ тасарлаа.

Рокко машиндаа сууж, Сонни Корлеонег алсан далангийн замаар Жоуз-Бич руу нилээд явснаа цэцэрлэгт хүрээлэнгийн засмалаар эргэн төмөр замын Уонт өртөө хүрэхэд өөр машинтай хоёр хүн хүлээж байв. Арван минутын дараа тэд Үүрийн туяаны гол засмалын дэргэд орших нэг жижиг байшинд хүрч, Рокко хамт яваа хоёроо орхиод машинаас гарсан даруйдаа л хаалгыг нь дэлбэ өшиглөн дайрч орлоо.

Далан нас шүргэж яваа Филипп Татталья нялхаараа шахуу бүсгүйн хэвтэх орны дэргэд чармай нүцгэн зогсож байхлаар нь Рокко дөрөв буудаж, бүх сумаа гэдсэнд нь зоогоод цааш эргэмэгц өөрийнхөн дээрээ гүйж очив. Рокко, Уонт өртөөн дээр буунгуут өөрийнхөө машинд сууж ирсэн замаараа буцаж, Майкл Корлеонетой түр уулзсаны дараа дахиад л хашааны хаалганы дэргэд манаандаа гарчээ.

Бронкс дахь сууцандаа Альберт Нери цагдаагийнхаа дүрэмт хувцсыг цэвэрлэн янзалж дуусаад яаралгүй өмссөнөө гар бууны гэр зүүсэн суран бүсээ сандал дээрээс авав. Халагдахад нь хэн нэгний ажлын хариуцлагагүйгээс цагдаагийн таних тэмдгийг нь буцааж аваагүй атлаа гар бууг нь хураасан тул Клеменца түүнд буу өгсөн юмсанж.

Нери цагдаа малгайгаа цаасан уутанд хийж бариад дүрэмт хувцас дээрээ энгийн цув эгэлдрэглэн цагаа харвал машин ирэхэд арван таван минут дутуу байсанд толинд өөрийгөө тухтай нь аргагүй сонжин харсан чинь жинхэнэ цагдаагаас ялгагдах юм ер алга.

Машины урд суудалд Рокко Лампонегийн хоёр цэрэг хүлээж байсан тул Нери арын хаалгаар орж, дүүргээсээ гарахын даваан дээр дөнгөж мөрөө хөдөлгөх төдийхнөөр энгийн цуваа доош унагаж цаасан уутаа угз татан ураад дадсан хөдөлгөөнөөр малгайгаа өмслөө.

Тавин тавдугаар гудамж Тавдугаар өргөн чөлөөний уулзвар дээр машин явган хүний зам шахан зогсоход Нери гарч, цээжин дотроо нэг л хачин сэтгэл оволзуулсаар өргөн чөлөө уруудан алхав. Энэ хувцсаа өмсөөд ээлжийн жижүүрт гарахдаа хичнээн ч удаа гудамж хэрэн хэсэв дээ... Эргэн тойрон хүн зон зай завсаргүй хөлхөлдөнө. Тэрээр гурван хороолол өнгөрч Гэгээн Патрикийн сүмийн эсрэг орших Рокфеллерын төвийн өмнө очиход түүнд хэрэгтэй лимузин «Зогсохыг хориглоно, «Машин тавихыг хориглоно» гэх мэтийн бичигтэй ярайсан тэмдэгний дор тэгэхээс тэгэх гэсэн юм шиг гав ганцаараа гонжийн харагдана. Жаахан эрт байсан тул Нери алхаагаа удаашруулан түр саатаад тэмдэглэлийн дэвтэртээ юм бичиж байгаа

дүр үзүүлснээ лимузинтэй зэрэгцмэгц бороохойгоороо тогшсонд жолооч нь гайхан харц өргөв. Нери «Зогсохыг хориглоно» гэсэн бичигтэй самбар руу зааж яв хэмээн дохисон чинь жолооч ер тоосон шинжгүй амаа цууртал эвшээлгээд цааш харахаар нь Нери нөгөө талаар нь тойрч жолоочийн суугаа онгорхой цонхонд очингоо илтэд доромжилсон дуугаар:

- Хөөе, суут ухаантан гуай, цаашаа яваад зохих газарт нь зогсох уу, эсвэл зарлан дуудах хуудас бөгсөн дээрээ наалгамаар байна уу? гэсэнд жолооч хайхрамжгүй хариулсан нь:

- Хэсэг дээрээ очоод асуу л даа, тайлбарлаад өгөх байлгүй. За за, тэгж их дур чинь гозгоноод байгаа юм бол торгож л байхгүй юу.

- Одоохон эндээс зайл. Тэгэхгүй бол наанаас чинь татаж гаргаад хүзүүг чинь хуга мушгина гэж мэдээрэй.

Жолоочийн гарт илбээр гэлтэй арван долларын дэвсгэрт бий болж мөн тэр гараараа дөрвөлжилж нугалаад Неригийн халаасанд хийхийг оролдвоос тэрээр дахин явган хүний зам дээр гарч жолоочийг хуруугаараа занган дуудаад:

- Жолооны үнэмлэх, техникийн гэрчилгээгээ гарга гэв.

Яг эл торгон эгшинд «Плаза»-гийн шадар лагс загзгар биетэй гурван хүн бууж, Тавдугаар чөлөө уруудахыг Нери нүдний булангаар дөнгөж харж амжтал Майкл Корлеонетой уулзахаар гарсан Барзиниг дагалдан яваа бие хамгаалагчдын нэг нь бусдаасаа түрүүлэн хүрч ирээд:

- Юу болоод байна? гэсэнд жолооч цухалдангуй хариу өчлөө.

- Юу ч болоогүй ээ. Шинэ цагдаа бололтой, торгож орхилоо, харалмар,

Барзини нөгөө бие хамгаалагчийн хамт хүрч ирээд:

- За бас яачихаа вэ? хэмээн уцаарлав.

Нери албаны дэвтэртээ машины дугаарыг тэмдэглэж аваад эрхийн үнэмлэх, техникийн гэрчилгээг жолоочид буцааж өгсний хойт дээр тэмдэглэлийн дэвтрээ халаасанд хийж, харин гараа эгүүлж авах зуур гар буугаа гэрээс нь суга татмагц Барзинигийн торх шиг цүндгэр цээжинд гурван сум дараалан зоочоод ам ангайн хөшсөн жолооч, бие хамгаалагчдын сэхээ орохоос өмнө олны дунд орж булан тойрсон даруйдаа түүнийг хүлээж байсан машинд үсрэн орлоо. Тэд Есдүгээр өргөн чөлөө рүү нисэн гарч зүүн тийшээ эргэн Челси-парк арай хүрээгүй явах зуур Нери хувцсаа сольж гар бууныхаа хамт суудал дээр орхиж өөр машинд шилжин суув. Нэг цагийн дараа гэхэд Альберт Нери хотын дүүргийн төв байранд эсэн мэнд ирж Майкл Корлеонед тайлангаа тавьж байлаа.

Талийгаач Их эцгийн гал зуухны өрөөнд Тессио аягатай кофеноос хааяа балган цаг нөхцөөж суугал:

- Майк явахад бэлэн боллоо. Барзинид утасдаад одоо гар гэж хэл.

Тессиио хананд өлгөсөн утас руу очиж Барзинигийн Нью-Йорк дахь ажлын байрны дугаар эрэгдэн:

- Бид Бруклин руу явлаа гэсэн даруйдаа харилцуураа өлгөчхөөд Хейген тийш инээвхийлэн харав.

- Майкл маань өнөөдөр бидэнд аз хийморь амжилт ололт хайрлана гэж найдах л үлдээ шив дээ.

- Би үүнд итгэлтэй байна хэмээн Хейген нухацтай үгүүлээд Тессииог дагуулан Майкл Корлеонегийн байшинд очиход нэг бие хамгаалагч тэднийг зогсоов.

- Эзэн өөр машинаар явна гэсэн. Та хоёр түрүүлээд явж бай.

Тессиио, Хейген тийш хөмсөг зангидан харж:

- Хөөе, ингэж яаж болох вэ дээ. Тэрээр хэлэлцэж тохирсон хамаг юмыг баллаад хаячихлаа байна.

Энэ эгшинд өөр гурван бие хамгаалагч газар дороос гэлтэй гараад ирэхэд Хейген намуухан үгүүлсэн нь:

- Би ч гэсэн тантай явж чадахгүй, Тессиио.

Шөвгөр царайтай шадар туслах нүд ирмэхийн зуур бүгдийг ойлгож, ойлгосон даруйдаа зүй ёсоор хүлээн авчээ. Тессиио зөвхөн хормын төдий л сэтгэлийн тэнцвэр алдсанаа тэрхэн дороо биеэ барьж чадлаа.

- Энэ бол ажил хэрэгч арга хэмжээ байсныг Майклд дамжуулаарай. Тэр надад хэзээнээс таалагддаг байсан юм шүү.

Хейген толгой дохин:

- Тэрээр үүнийг ойлгож байгаа гэхэд Тессиио хэсэгхэн зуур түгдэрснээ аяархан дуугаар:

- Том оо, чи хуучин нөхөрлөлөө бодоод энэ удаа намайг аргалчхаж чадахгүй биз? гэвээс цаадах нь толгой сэгсэрчээ.

- Чадахгүй.

Бие хамгаалагч нар Тессииог тойрон бүчиж машин руу аваачихыг харж зогсохдоо Хейгений дотор харамсан гашуудах сэтгэл төрөв. Тессиио уг нь Корлеонегийн намынхны шилдэг цэрэг байсан бөгөөд Их эцэг, Люка Брази тэр хоёроос өөр хэнд ч тэгж их итгэдэггүй байсан даа. Тийм ухаан сүйхээтэй хүн өдий хүртэл насалчхаад ингэж золгүй эндсэн нь тун ч харамсалтай, гэвч одоо яая гэх вэ?, алдаж онодог алаг эрээн хорвоо хойно.

Карло Рицци, Майклтай уулзах цагаа хүлээсэн хэвээр, ирж очих энэ олон машиныг харж

зогссоноо гэнэт сэтгэлд нь түгшүүрийн харанга дэлдэж эхэллээ. Магад нэг л чухал юм болоод түүнийг бас л гадуурхаад орхичхов бололтой. Тэвчээр нь барагдаад Майкл руу залгасан чинь дотоод хамгаалалтынхнаас хэн нэг нь утас авч Майклыг дуудахаар явснаа эргэж ирээд тэрээр удахгүй завтай болно, жаахан хүлээж бай гэлээ.

Карло нууц амрагтаа утасдаж оройн зоогны дараа хамт хонохоор тохиролцов. Майкл удахгүй гэсэн хэдий ч ажил хэргийн уулзалт лав л хоёр цагаас нааш өндөрлөхгүй тул хожим цаг алдахгүйн тулд хувцсаа өмсөхөөр шийдэн дөнгөж цамцаа сольтол хаалга онгойлгосон даруйдаа л толгойтой үс нь өрвийх шиг болон өвдгөөрөө нугарчих шахсаны учир гэвэл босгон дээр Майкл Корлеоне яг л Карлогийн сүүлийн хэдэн өдөр дараалан зүүдэлсэн шиг үхэл мөхөл нүүрлээд зогсож байлаа.

Мөрөн дээгүүр нь цухуйх Хейген Рокко Лампоне хоёр дотроо дургүй хэрнээ арга буюу анд найздаа аюултай мэдээ дуулгах болсон хүмүүсийн дүр эсгэн духайн харж зогсоно. Карло Рицци тэднийг дагуулан зочдын өрөөнд орохдоо жаахан тайвширч мэдрэл ер нь муудаж байгаа юм байна даа гэж бодтол Майклын хэлсэн хэдэн үг яг ар дагз руу нь лантуудах шиг цочирдуулжээ.

- Сантиногийн амийг чи амиараа хариуцах болж дээ!

Карло ойлгоогүй хүн болоод хариу дуугарсангүй. Хейген, Лампоне хоёр салж баруун, зүүн хананы дэргэд очоод, Майкл өөдөөс нь харж зогсмогц сааралтсан яхир хоолойгоор:

- Чи л охин дүүг минь шоглож, баахан жүжиглэж... Барзинигийн залуусын аманд Сонниг түлхэж хийсэн. Корлеонег иймхэн юмаар хуурчхаж дөнгөнө гэж Барзинид чи итгэсэн хэрэг үү?

Үнхэлцгээ хагартал айсандаа тэрээр бардам доодгор зан, нэр хүндээ ч хүртэл бүгдийг умартан:

- Би ямар ч буруугүй, нээрээ шүү. Хүүхдүүдийнхээ амь насаар андгайлъя, надад ямар ч гэм зэм байхгүй. Майк аа хэрэггүй, чамаас гуйя өршөөж хайрлаач дээ хэмээн хэл амаа орооцолдуулан бувтнах аядсанд цаадах нь юу ч болоогүй юм шиг тайван дуугаар:

- Барзини алуулсан. Филипп Тагталья ч мөн адил сөнөсөн. Өнөөдөр би гэр бүлийнхээ бүх тооцоог нэгмөсөн дугуйлна. Тийм учраас гэм буруугүй, энээ тэрээ гэж донгосоод ямар ч нэмэргүй, үнэнээ хэлсэн чинь л дээр гэснээ Карлог дув дуугүй байхаар нь цааш үгүүлрүүн: - Чи юунаас ингэтлээ айгаа вэ? Бодоод үз, яалаа гэж би төрсөн дүүгээ бэлэвсрүүлж, дүү нараа өнчрүүлэхийг хүсэх юм бэ? Эцсийн эцэст би нэг хүүд чинь загалмай зүүлгэсэн эцэг нь шүү дээ. Үгүй дээ, чамайг өөрөөр залхаана. Чи манайд ажиллах хоногийн тоо гүйцсэн. Одоо онгоцоор Вегас орж эхнэр хүүхэд дээрээ очоод чимээгүй сууж бай. Амь зуулгын мөнгө би Коннид илгээж байна, тэгээд л гүйцээ. Харин намайг усан тэнэгт тооцон гэм зэмгүй хүн болох гэж битгий уур хүргээд байгаарай. Тагталья, Барзини хоёрын хэн нь чамтай уулзсан бэ?

Амьд үлдэх найдварын гэгээ дөнгөж сүүмэлзээд ирэхээр алах ялаас арайхийж хэлтэрсэндээ сэтгэлийн гүнд нар ургасан Карло Рицци нэг л мэдэхнээ:

- Барзини гээд хэлчихсэн байлаа.

- Аа тийм бий хэмээн Майкл аяархан дуугараад Карлог занган дуудав. - За одоо чи яв. Чамайг нисэх онгоцны буудал хүргэж өгнө.

Карло түрүүлэн, бусад нь дагалдан гарахад харанхуй болсон хэдий ч цэцэрлэгт хүрээлэн хэзээний янзаар өдөр шиг гэрэлтэй аж. Тэрхэн даруй машин ирж өөрийнх нь гэдгийг Карло таньсан авч жолооч нь ер зүс үзээгүй эр байз. Арын мухарт бас нэг хүн суужээ. Лампоне хаалга нээж өгсөнд Карло жолоочийн хажууд суухдаа торгон цамцаа нэвт хөлөрснийг сая л мэдлээ.

Машин хаалга тийш хөдлөн хурдаа нэмж, Карло Рицци ард нь хэн байгааг харах санаатай толгой эргүүлэх агшинд Клеменца чамин шалмаг хөдөлгөөнөөр хүзүүнд нь шидмэс угласанд Карло ухасхийсэн чинь гөлгөр уяа арьс зүсэн маханд нь шигдээд улам бүр хөвчрөн чангарав. Клеменца баттай, найдвартайг нь бодоод торгон шидмэсээ дахиад хэдэн минут лавшруулан чангааж байснаа тавьтал Карло Риццигийн лагс бие хаалга налан нугдайхад Клеменца шидмэсээ буцааж хийгээд суудал засан тухлав.

Корлеонегийн нам ялалтаа ёслон тэмдэглэж болохоор боллоо. Мөн л тэр хэдхэн өдрийн дотор Клеменца, Лампоне хоёр хамаг цэргүүдийнхээ уяаг сунган Корлеонегийн эзэмшил газарт халдан довтолсон хүн болгоныг ёстой хүйс тэмтэрчээ. Аль Нери хуучин Тессиогийн зэвсэгт бүлгийг толгойлон Барзинигийн морин тойруулгын бооцооны «цэгүүдийг» үнсэн товрог болгож, өндөр өртөг хөлс авдаг хоёр яргачинг нь Малбери гудамжны итали зоогийн газар гүнцэг бариад бод идсэн боохой шиг додигор амьтад шүдээ чигчийлэн суухад нь нам бууджээ. Биеийн тамирын бооцоог ивээн тэтгэж, төрийн эрх баригчид болон Барзинигийн намын хооронд зохицуулан зуучилдгаараа нэрд гарсан нэг эрийг морин тойруулгаас овоо юм монжоод буцаж явахад нь цааш харуулснаас гадна усан боомтын хорооллын хоёр томоохон мөнгө хүүлэгч ор сураггүй алга болж, олон сарын дараа Нью-Жерсийн намаг дотроос цогцос нь олджээ.

Ийнхүү Майкл ганц далайлтын харгис хатуу цохилтоор Нью-Йоркийн гэмт бүлэг синдикатуудын дотор Корлеонегийн намын толгойлох байр суурийг нөхөн сэргээж чадсан байна.

Майкл Корлеоне энэ ялалтаараа бахархан баярлах бүрэн бололцоотой байсан авч дүү Конни нь шуугиан тарьж тун эвгүй байдалд оруулав...

Конни хоёр хүүхдээ Вегаст орхиод ээжтэйгээ онгоцоор ирж лимузин цэцэрлэгт хүрээлэнгийн бүс хүртэл биеэ барьж явснаа тэнд ормогц ээжийнхээ саад хориг хийж амжихаас өмнө үсрэн бууж, Майкл Корлеонегийн харш руу хөлийн хурд мэдэж харайлгав. Кей нөхрийнхөө хамт зочдын өрөөнд сууж байснаа Конниг дайран орж ирэхэд эгчийгээ тэвэрч тайтгаруулахаар боссон боловч ахынхаа толгой дээр мөндөр мэт буулгасан хараал зүхэл, гомдол зэмлэлийн үгийг сонсоод зогтгусчээ.

- Өөдгүй новш, адгийн шаар! Чи миний нөхрийн толгойг залгисан! Аав нас барж, хорих саад хийх хүнгүй болохыг хүлээж байгаад алсан! Соннигийн хариуд л тэр. Та нар бүгдээрээ

түүнийг үзэн ядаж, өс хонзон өвөрлөж явсан! Харин миний тухай бодсон уу? Гонж байлгүй!
Одоо би яах юм бэ?

Араас нь хоёр бие хамгаалагч асуусан харцаар Майклыг ширтсээр хүүхэнд дөхөөд ирсэн авч Майкл дүүгийнхээ үгийг хэлж дуусахыг хүлээн дув дуугүй зогсох бөлгөө.

Кей гайхан балмагдсандаа:

- Конни, тайвширч үз, чи чинь яаж байна аа? гэхэд Конни нэгэнт орилж чарлаж, уйлж унжихаа болиод хонзогносон хилэгнэсэн хоолойгоор шүд зуун:

- Нөхөр чинь яагаад надтай дандаа хүйтэн хөндий ханддаг, яагаад Карлог байнга дэргэдээ байлгадаг гэж бодож байна, Кей? Майкл бүр анхнаасаа Карлог ална гэдгээ мэдэж байсан юм. Зөвхөн аав түүнд тийм зөвшөөрөл олгохгүйг мэдээд аятай цагийг хүлээж байсан. Дараа нь биднийг айлгаж үргээчихгүйн тулд хүүд маань загалмай зүүлгэж өгсөн. Ёстой өрөвдөх сэтгэлгүй мал! Чи нөхрөө сайн мэддэг гэж бодно уу? Миний Карлогийн хамт энэ чинь хичнээн хүн хороосныг чи мэдэх үү? Сонин уншаач. Барзини, Тагталья гээд л бас бус олон хүний аминд хүрсэн дээ, наадах чинь!.. гээд Майклын нүүр рүү нулимах гэсэн боловч ам нь хатаад шүлс гарсангүй.

- Үүнийг гэрт нь аваачаад эмч дууд! хэмээн Майклыг тушаамагц ард нь байсан хоёр залуу Конниг дор нь сугадаж аваад чирэхээс наахнуур гаргалаа.

Кей түрүүчийнх шигээ бантаж балмагдаад хоолой шахаж:

- Конни сая юу ярив аа, Майкл минь? гэхэд Майкл мөрөө хавчив.

- Зүгээр л хийрхэж байгаа юм.

- Майкл аа, энэ бүхэн худлаа биз дээ? Ийм юм болоогүй гээд хэлээд өгөөч, чамаас гуйя.

- Худлаа байлгүй яах вэ. Чи надад итгэ. Анхны бөгөөд сүүлчийн удаа ажил хэргийн минь тухай асуухыг зөвшөөрч хариу хэлье. Энэ бүгд худлаа.

Тэрээр гэргийнхээ нүд рүү эгцлэн ширтэж урьд хэзээ ч ярьж байгаагүй итгэлтэйгээр хэлж, олон жил ханилан суухдаа хоорондоо тогтоосон итгэл, хүндэтгэл хайр сэтгэл бүгдийг ашиглан байж сая л Кейд итгүүлж чадлаа. Эхнэр нь гэмшингүй инээмсэглээд үнсүүлэхээр хацраа өгөв.

- Яг л одоо жаахан дарс балгадаг цаг даа! хэмээн мөс авахаар гал зууханд ороод байтал хаалга дуугарах шиг болохоор нь шагайж харвал Клеменца, Нери, Рокко Лампоне гурав бие хамгаалагч нараа дагуулан зочдын өрөөнд орж явлаа. Клеменца тэдэн рүү буруу харж зогссон Майклд хандан:

- Эрхэм Майкл, Их эцэг ээ! хэмээн үлэмж ёслол төгөлдөр үгээ эхлэв.

Тэд ийнхүү ёслон хүндэтгэхийг зүй ёсоор хүлээн авч буй Майкл баруун гараараа ташаа тулан

зүүн хөлөө жаахан урагшлуулж, нүүрэнд нь бүгдийг захирах хатан зориг, нугарч мятаршгүй их хүч бичээстэй юм шиг тодорч харин шадар туслахууд нь тэргүүнээ гудайлган хүлцэнгүйгээр номхон зогсоно. Чухам энэ эгшинд л Майклыг зэмлэн буруушааж Коннигийн хэлсэн үгс цөм үнэн гэдгийг Кей ойлгож, галын өрөөндөө буцаж ормогц цорхирон уйлж гарлаа.

ХОРИН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Майкл Корлеоне бүтэн жилийн турш уран нарийн дипломат арга мэх хэрэглэж байж л сая нэг юм Америкийн хамгийн хүчирхэг гэр бүлийн синдикатуудын нэгний байр сууриа батжуулан бэхжүүлж, ингэснээрээ өөрийн гэр бүлийн цус асгаруулж байж олсон ялалтыг эцэст нь хүргэн мухарлаж чадсан аж. Бүтэн арван хоёр сарын турш тэрээр бүхий л цаг заваа Лонг-Бич хотын дүүрэг дэх төв байр, Лас-Вегас дахь шинэ байшин хоёрынхоо хооронд тэлээ хурга шиг тэлчигнэсээр өнгөрөөгөөд жилийн эцсээр л Нью-Йорк дахь бүх ажиллагаагаа бүрмөсөн зогсоож, эдлэн газраа худалдахаар шийдсэн байна. Орон гэрээрээ шилжин нүүхтэй холбогдон хийх аар саар зүйл толгойтой үснээс олон үлдсэн тул Майклыг ажил хэргээ дуусган мухарлах хооронд Кей эд хогшлоо баглан савлаж явуулаг гэсэндээ тэрээр гэрийнхнийгээ Лонг-Бичд сүүлчийн удаа авчирчээ.

Одоо Корлеонегийн гэр бүлийн толгойлон манлайлах эрх нь хөдөлшгүй бат болсон тул Клеменца өөрийн намыг байгуулан түүнээс өрх тусгаарлаж, шадар туслахын албан тушаалд Рокко Лампоне ганцаараа үлдэв. Альберт Нери намын хяналтад байдаг бүх мөрийтэй тоглоомын гаар, зочид буудалд аюулаас хамгаалах албыг толгойлон, Хейген ч гэсэн Майклын удирдсан өрнөдийн синдикатад ажиллаж байлаа.

Цаг хугацаа хуучин шархыг эдгээн анагааж, Конни Корлеоне хэрүүл шуугиан дэгдээсэн тэр өдрөөс хойш дөнгөж долоо хоноод л буруугаа гэмшин ирж, уй гашууд зүрхээ зүсүүлсэндээ л дэмий юм донгоссон гэдгээ Кейд хэлээд ахтайгаа эвлэрсэн төдийгүй жил ч болоогүй байхад дахин эрд гарчээ.

Кей Адамс-Корлеоне католик шашныг шүтэх болж нөхрийнхөө төрөл төрөгсдийг ихэд баярлуулсан төдийгүй, ингэж энэ Невадад идээшин дасах юм гэж өөрөө ч бодоогүй аж. Эл нутгийн час улаан чулуурхаг энгэр бэл, гүн нарийн хавцал, уужим хөндий зуух шиг төөнөх элсэн цөл, гэнэт цээж сэрүүцүүлэх нуур цөөрөм бүгд түүнд таалагдаж, хоёр хүү нь өөр өөрийн одой морь унан, гэрт нь бие хамгаалагчид биш, энгийн зарц нар үйлчлэх болсон нь бүр ч их таатай байлаа. Майкл ч гэсэн энд ирээд жирийн хүн шиг аж төрж, барилгын компанийн эзний хувьд ажил хэрэгч хүмүүсийн клуб, олон нийтийн хороодын гишүүн болоод зогссонгүй, орон нутгийн улс төрийн бодлогод илээр оролцдоггүй ч сонирхох болов. Үүнээс илүү яаж жаргалтай амьдрах вэ? Кей Нью-Йоркийг бүрмөсөн орхиж, одооноос эхлэн Лас-Вегаст байнга суурьшина гэхээс хөл нь газар хүрэхгүй баярлан, эмнэлэгт удаан хэвтээд гарах өдрөө тэсэн ядан хүлээх лугаа адил эндээс бушуухан явахсан гэж яарна.

Сүүлчийн энэ өглөө Кей Адамс-Корлеонег үүрийн таван жингээр сэрэхэд гэрийн тавилга, эд хогшлыг нь зөөхөөр ирсэн хүнд ачааны чиргүүлтэй машины хөдөлгүүр хүржгэнэж байв. Орой гэхэд л тэд гэр бүлээрээ Корлеоне ээжийгээ аваад Лас-Вегас руу ниснэ дээ!

Кейг угаалгын өрөөнөөс гарч ирэхэд Майкл дэр тохойлдон хэвтээд янжуур баагиулж байснаа:

- Ингэж сүм дуганаас салахаа болино гэж бас байдаг аа, нохой долоо! Ням гаригт бол ч бас яая гэхсэн, гэтэл бүр өдөр болгон шүү! Хадам ээжээсээ хоцрохыг хүсэхгүй байна уу? гэсэнд Кей оймсоо өмсөхөөр орон дээр суулаа.

- Католик шашинд дагаар орсон хүн шиг хичээл зүтгэлтэй хүн үгүй гэдгийг чи мэднэ шүү дээ.

Майкл түүн рүү харснаа ёжтой инээмсэглэв.

- Католик шашинд ийм сүсэгтэй байж, хүүхдүүдээ сүм хийдээс байсхийгээд л зугтаахад нь дуугүй байх юм, хачин аа?!

- Амжина аа, гайгүй. Гэртээ харимагц гараас нь чирээд ч болсон аваачиж байна даа гээд Кейг гадаа гарваас зун цагийн дүгрэг улаавтар наран дорно зүгээс мандаж агаар хэдийн бүлээсжээ. Кей хаалга зүглэн машин руугаа очиход бэлэвсэн эхнэрийн журам сахин тас хар хувцас өмссөн Корлеоне ээж хүлээж байлаа. Ийнхүү өглөө болгон хамгийн түрүүчийн мөргөлд хамт явах нь тэдний хувьд заншил болсон аж.

Эл бяцхан сүм үүрийн туяанд сэтгэл эмтрэм ганцаардмал, эл хуль харагдах боловч халуун агаар цонхны хаалтанд саатах тул сүм дотор сэрүү татан сэтгэл тайвшрах бөлгөө. Кей цав цагаан чулуун шатаар өгсөхөд нь тусалж өөрөө араас нь ороход загалмайлан дүүжлүүлсэн Христос бурхны өмнөх лааны дөл сүүмэгнэн чичигнэнэ...

Зөвхөн энд бүүдгэр, сүмийн хүнхгэр тааз дор тэрээр эр нөхрийнхөө нууц амьдралын тухай тунгаан бясалгахыг өөртөө зөвшөөрдөг байлаа. Майкл тэдний харилцан итгэх, хайрлан хүндэтгэх нандин сэтгэлийг ашиглан түүнийг хуурч, төрсөн дүүгийнхээ хар хүнийг алаагүй гэж итгүүлсэн тэр бузар булай өдрийн маргааш нь Кей хэнд ч юу ч хэлэлгүй, цаашид яахаа ч бодож шийдсэн юмгүй, зүгээр л хүүхдүүдээ аваад Нью-Гемпшир рүү, эцэг эх хоёр луугаа явчхаж билээ.

Майкл дор нь бүгдийг ойлгоод эхний өдөр түүнд утастсанаа дараа нь тайван байлгаж, зөнд нь орхижээ. Зөвхөн долоо хоногийн дараа л Адамсынхны байшингийн өмнө Нью Йоркийн дугаартай лимузин хурдаа аажим саан зогссон нь Том Хейген ирсэн аж.

Үдэш орой болоход Кей амьдралдаа хамгийн шаналгаатай цагаа Том Хейгений хамт өнгөрүүлж, тэр хоёр төрсөн хотхоных нь захын ойгоор хэсүүчлэх зуур Хейген түүнийг өрөвдөж хайрлалгүй, бүх үнэнийг ярилаа.

Кей хөнгөн хийсвэр, хайхрамжгүй зан гаргах санаатай тааруухан жүжиглэнэ.

- Майкл намайг сүрдүүлэхээр чамайг явуулсан хэрэг үү? Би ч хувьдаа автомат мөрлөсөн «залуус» л машинаас үсрэн гарч ирэх ухааны юм бодлоо шүү гэхэд Хейген түүний л мэдэхээс анх удаа жинхэнээр уурлав.

- Балчир хүүхэд шиг балай юм донгосоод, яасан ичдэггүй юм бэ, Кей?

- За за, уучилж үз.

Анир чимээгүй дүнсийх ой дундуур үл мэдэг зурайсан хөдөөний зам дээр гарсан хойноо Хейген тайван дуугаар?

- Чи яагаад зугтаасан юм бэ? гэж асуулаа.

- Майкл надад худлаа хэлж, Коннигийн хүүд загалмай зүүлгэж өгөхдөө намайг хууран мэхэлсэн учраас л тэр. Би тийм хүнийг хайрлаж чадахгүй, ингэж амьдрахыг хүсэх ч үгүй. Хүүхдүүдэд минь тийм эцэг хэрэггүй.

- Юу яриад байгааг чинь ер ойлгохгүй юм гээч

Хейгенийг хэнэггүй царайлан цааш харахад Кейгийн дэлбэртлээ цухалдах ээлж нь болжээ.

- Тэр чинь төрсөн дүүгийнхээ нөхрийг алсан гээд байна шүү, чамд! Чи үүнийг ойлгож байна уу? Гэтэл надад худал хэлсэн!

Нэг хэсэгтээ чив чимээгүй гэлдэрч явснаа Хейген түрүүлж ам нээлээ.

- Үнэхээр ийм юм болсон эсэхийг чи мэдэхгүй, мэдэх ч аргагүй. Гэхдээ нээрээ тэгсэн гэж түрхэн зуур бодоод үзье. Зөвхөн ингэж төсөөлье гэснийг бүү мартаарай би нотлоогүй байна шүү. Хэрэв би ийм үйлдлийг цагаатгах, өөрөөр хэлбэл зөвтгөж болох учир шалтгааныг чамд хэлээд өгвөл чи яах вэ?

Кей түүнийг жигшин зэвүүцсэн харцаар тас шилбүүрдэв.

- Чамайг өмгөөлөгчийн дүрд тоглохыг анх удаа харж байна. Тийм ч сайхан харагдахгүй байна шүү, Том гэсэнд Хейген уруулаа үл мэдэг мушилзууллаа.

- Тэр ч бага хэрэг, ямар ч гэсэн сонс. Карло тэр удаад Конниг чухам санаандгүй биш, чухам Сонниг нуувчаас нь хуурч гаргахын тулд урьдаас бодож боловсруулсан төлөвлөгөө ёсоор зодож нүдсэн, Сонни заавал Жоуз-Бичээр дайрч өнгөрнө гэдгийг алуурчид андахгүй мэдэж байсан бол яах вэ? Сонниг хорлоход туслалцуулахаар Карлог худалдаад авчихсан байвал чи юу гэх вэ?

Кей дуугарсангүй тул Хейген цааш үгүүлрүүн:

- Талийгаач Их эцэг энэрэнгүй зөөлөн сэтгэлтэй хүн болохоороо төрсөн охиныхоо нөхрийг алж, хүүгийнхээ өшөөг авах чадал байгаагүй бол яах вэ? Тэгээд л туйлдаа хүртэл шаналж зовоходоо Майкл энэ хүнд дарамтаас өөрийг нь чөлөөлж хамаг гэм бурууг мөрөндөө үүрэхийг сайн мэдэхийн эрхээр өөрийн залгамжлагчаар түүнийг томилсон бол яах вэ?

Кей хоёр нүдээрээ дүүрэн нулимс мэлтэлзүүлж:

- Тэр бүхэн аль хэдийн ард хоцорч, түүнээс хойш хичнээн ч удав даа! Карлог уучлан хамаг юмыг мартаад хуучныг сөхөлгүй цааш амьдарч яагаад болдоггүй юм бэ? гээд нугын зөргөөр өнгөрч бургасны мөчир доогуур шурган шоржигнох горхины эрэг дээр очиход Хейген өтгөн өвс дотор шигдэн суугаад санаа алдав.

- Бидний энэ ертөнцөд яавч боломжгүй зүйл чинь тэр дээ, Кей минь.

- Майкл миний анх суусан хүн биш болчихжээ.

Хейген гунигтай ч гэх үү, доогтой ч гэх үү, хачин жуумагнаж:

- Тийм хэвээрээ байсан бол тэрээр одоо газарт булаастай хэвтэж, чи бэлэвсэн эхнэрийн хар гоёл өмсчихсөн, санаа зовох юмгүй сууж байх билээ л гэхэд Кей дүрсхийгээд явчихлаа.

- Энэ чинь юу гэсэн үг болохыг олигтойхон тайлбарлаад өгөөч, чөтгөр алгадмар! Амьд яваа насандаа ганц удаа ч болов ойлгомжтой ярьж чадах хүн үү, үгүй юу, чи? Майкл чадахгүй гэдгийг мэдэж байна. Харин чи сицили эр биш, Том оо, эмэгтэй хүнтэй илэн далангүй ярьж, өөрийнхөө зиндаанд тавин харьцаж чадахгүй гэж үү?

Дахиад л чив чимээгүй болж удтал сууснаа Хейген толгой сэгсрэн:

- Чи Майклыг буруу ойлгоод байх юм даа. За чи намайг хуурлаа гэж түүнд гомдоод л байна. Гэтэл тэрээр түүний ажил хэргийн талаар хэзээ ч бүү асууж шалгааж бай гэж чамд анхааруулаа биз дээ? Коннигийн хүүгийн эрийн цээнд хүрсний ёслол дээр загалмай зүүлгэсэн эцэг нь байлаа гэж чи түүнд уурлаад байх юм. Чухамдаа чи л түүнийг албадан шахалт шаардаагүй гэж үү? Гэтэл хэрэг явдлын учир шалтгаант холбоог үндэслэвэл чухам Майкл л хохирогчийнхоо хардлага, сөрдлэгийг замхруулж, сонор сэрэмжийг алдагдуулах зорилгоор ийм сонгодог арга мэхийг өөрөө хийх ёстой байсан бус уу? За сэтгэл ханав уу? Би ойлгогдохоор ярьж байна уу? гэхэд Кей толгойгоо улам тонгойн дув дуугүй суух тул цааш үгүүлрүүн: - За яахав, бүр тодорхой ярья. Их эцгийн өөд болсноос хойш сөрөг хүчнийхэн Майклыг цааш харуулахаар санаархсан. Хэн түүнийг худалдаалж урван тэрсэлсэн гэж чи бодож байна? Тессио. Тэгэхлээр Тессиог тонилгох хэрэгтэй болсон. Нэгэнт л урван биеэ худалдсан хүнийг яасан ч өршөөж болохгүй учир Карлог ч гэсэн цааш харуулах нь зүйн хэрэг байсан. Майкл тэднийг уучилж болох л байсан байх. Майкл, Тессиод үнэн голоосоо сайн байсан, охин дүүдээ ч хайртай нь үнэн. Харин Тессио, Карло хоёрыг амь хэлтрүүлсэн бол Майкл чиний, болон үр хүүхдүүдийнхээ өмнө, гэр бүлийнхээ өмнө, миний болон миний гэр бүлийн өмнө хүлээсэн журамт үүргээсээ няцсан хэрэг болохсон. Тэр хоёр новш хэзээ ямагт, өдөр болгон бидэнд аюул заналхийлж, гай тарьж болох байсан юм.

Кей нулимс дуслуулсан хэвээр:

- Тэгээд энэ бүхнийг надад хэл гэж Майкл чамайг явуулсан юм уу? гэхэд Хейген үнэн голоосоо гайхсан нүдээр түүнийг харлаа.

- Яалаа гэж дээ?! Чамайг хүүхдүүдээ олигтойхон харж халамжлах л юм бол хүссэн болгоноо авч, юу дуртайгаа хийж болно гэж хэлээрэй гэсэн.

Кей хоёр гараа Хейгений мөрөн дээр тавив.

- Тэгэхлээр тэрээр ингэж хэл гэж тушаагаагүй болж таарах нь ээ?

Хейген бүх үнэнийг уудлан ярих хэрэг байна уу, үгүй юу гэж өөрөөсөө асуух мэт түр тээнэгэлзэв.

- Чи чинь, ингэхэд юу ч ойлгосонгүй шив дээ? Хэрэв намайг энд ирээд юу ярьсныг Майкл мэдвэл би өнгөрлөө гэсэн үг. Тэрээр энэ хорвоо дээр зөвхөн гурван хүнд, тухайлан хэлэхэд чамд, гурван хүүхдэдээ л гай тарьж чадахгүй.

Эцэс төгсгөлгүй мэт санагдах таван минут арайхийн өнгөрч, Кей босоод зугуухан алхсаар буцах замдаа ороод бараг гэртээ тулж ирсэн хойноо зогтусан Хейген тийш эргэлээ.

- Чи оройн хоолны дараа намайг хоёр хүүтэй минь хамт машинаараа Нью-Йорк хүргэж чадах уу?

- Үүний тулд л би ирсэн юм шүү дээ.

Долоо хоногийн дараа Кей ламтай очиж уулзаад католик шашинтан болох хүсэлтэйгээ хэлжээ.

Ариун сүмийн бөмбөгөр орой дээрээс хонхны дуу тасалдан түгж гэмшил нарийвчлалд урин дуудлаа. Кей өөрийн тухай, үр хүүхдийнхээ тухай бүх бодол, бүхий л уур хилэн, дургүйцэл бухимдал, эргэлзэн тээнэгэлзсэн нийт асуудлаа таягдан хаяж цэвэршин ариусаад өчигдрийн шигээ, өдөр болгоных шигээ Майкл Корлеонегийн сүнсийг бурхандаа даатган аврал эрж сүсэглэн мөргөж билээ.